



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 06 дугаар сарын 19-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1-2
Хуралдааны товч тэмдэглэл:	3-111
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	112-362
Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх	114-115
1. Хуулийн төслийг эцэслэн батлах	116
2. Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх	117
3. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газраас 2026.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	118-119
4. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	120-122
5. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүн 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	122
6. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/	122-123
7. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/	123-155
8. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	155-178 290-305
9. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн 2026.06.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	178-182 305-306

10.Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2026.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	182-190 306-307
11.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	190-196 307-318
12.Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 18 гишүүн 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	196-213 318-319
13.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	213-290
14.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурын гишүүн Д.Ганмаа нарын 46 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	319-339
15.Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	339-348
16.Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	349-355
17.Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 18 гишүүн 2026.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	355-361
18.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулах	361-362

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 19-ний өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 50.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.¹

Томилолттой: Ч.Анар, Н.Номтойбаяр, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Ж.Баясгалан, Д.Бум-Очир, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан, Б.Заяабал, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, П.Мөнхтулга, Н.Наранбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Г.Тэмүүлэн, А.Ундраа, Р.Эрдэнэбүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга, Ж.Баярмаа, Х.Болормаа, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, С.Лүндэг;

Тасалсан: Д.Пүрэвдаваа;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-03 минут, С.Амарсайхан-5 цаг 50 минут, Х.Баасанжаргал-46 минут, М.Бадамсүрэн-41 минут, Д.Батбаяр-22 минут, Б.Батцэцэг-1 цаг 00 минут, П.Батчимэг-13 минут, Ж.Бат-Эрдэнэ-19 минут, Э.Болормаа-46 минут, Х.Булгантуяа-08 минут, Ж.Галбадрах-10 минут, Г.Ганбаатар-1 цаг 46 минут, Д.Ганбат-10 минут, Д.Ганмаа-04 минут, Л.Гантөмөр-2 цаг 29 минут, Х.Ганхуяг-09 минут, Г.Дамдинням-15 минут, Б.Жаргалан-13 минут, Д.Жаргалсайхан-3 цаг 45 минут, Ч.Лодойсамбуу-05 минут, Ц.Мөнхтуяа-43 минут, Ч.Номин-22 минут, Б.Пунсалмаа-18 минут, Ц.Сандаг-Очир-06 минут, Р.Сэддорж-9 цаг 24 минут, Ц.Туваан-29 минут, Б.Түвшин-2 цаг 33 минут, Ч.Ундррам-03 минут, Ж.Чинбүрэн-04 минут, Л.Энх-Амгалан-02 минут, Д.Энхтуяа-7 цаг 01 минут, С.Эрдэнэбат-01 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 72 гишүүнээс 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хойшлуулсан тул, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү нарын 35 гишүүнээс 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны явцад хэлэлцэхийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлын дарааллаас тус тус хасагдсан талаар мэдэгдэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 06 дугаар сарын 19-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл, Х.Ганхуяг нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

¹ Хуралдаан даргалагч ирцийг танилцуулах үед 2 гишүүн ирцэд нэмэгдсэн.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт дараах хууль, тогтоолын төслүүдийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар мэдээлэв. Үүнд:

1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал нарын 19 гишүүнээс 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

2.Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн Конвенц /Аж үйлдвэр болон худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 81 дүгээр конвенц/ соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

3.Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн Конвенц /Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 129 дүгээр конвенц/ соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

4.Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороонд;

5.Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд.

Нэг.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

С.Бямбацогт: 1.Монгол Улсын нисэхийн тухай /Шинэчилсэн найруулга/- хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 9

Бүгд: 81

88.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Улсын нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 10

Бүгд: 81

87.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 9

Бүгд: 81

88.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 10

Бүгд: 81

87.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 10

Бүгд: 81

87.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу Засгийн газар 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр *Улсын Их Хурлын чуулганаар* яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг танилцуулав. Үүнд:

1.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

2.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд.

С.Бямбацогт: 1.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг *Улсын Их Хурлын чуулганаар* яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 16
 Бүгд: 83
 80.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг *Улсын Их Хурлын чуулганаар* яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
 Татгалзсан: 14
 Бүгд: 83
 83.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг *Улсын Их Хурлын чуулганаар* яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороонд;

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд тус тус шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газраас 2026.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: 1.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
 Татгалзсан: 13
 Бүгд: 85
 84.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
 Татгалзсан: 12

Бүгд: 85
85.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 13
Бүгд: 85
84.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 13
Бүгд: 85
84.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 13
Бүгд: 85
84.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 12
Бүгд: 85
85.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 12
Бүгд: 85
85.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 13
Бүгд: 85
84.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 14
Бүгд: 85
83.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 15
Бүгд: 85
82.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 14
Бүгд: 85
83.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: 1.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 14
Бүгд: 85
83.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 16
Бүгд: 86
81.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 16
Бүгд: 86
81.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 13
Бүгд: 86
84.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 20
Бүгд: 86
76.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 12
Бүгд: 86
86.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 15
Бүгд: 86
82.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 13
Бүгд: 86
84.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 12
Бүгд: 86
86.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 10
Бүгд: 86
88.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 13
Бүгд: 86

84.9 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Хүн амын орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 14

Бүгд: 86

83.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 15

Бүгд: 86

82.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүн 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, **хэлэлцэх эсэх, үргэлжлэл**/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 17

Бүгд: 86

80.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “цэргийн” гэсний дараа “албаны офицер, ахлагч,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 12
Бүгд: 86
86.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 13
Бүгд: 86
84.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Б.Мажигсүрэн нар байлцав.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор үргэлжлүүлэн санал хураалт явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, А.Ариунзаяа, Л.Мөнхбаясгалан, О.Номинчимэг, Ж.Алдаржавхлан, Б.Баярбаатар, Д.Ганмаа, Б.Жаргалан, С.Одонтуяа, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, Л.Соронзонболд, Х.Тэмүүжин, Д.Үүрийнтуяа, Б.Хэрлэн, Х.Баасанжаргал, Г.Хосбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь хүүхэд, гэр бүлийн гишүүний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гэрлэлт, гэрлэлт дуусгавар болох, гэр бүлийн гишүүдийн хөрөнгийн эрх, үүрэг, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхэд үрчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	62
Татгалзсан:	26
Бүгд:	88

70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийн “, амар тайван,” гэснийг “бөгөөд” гэж, 3.6 дахь хэсгийн “хүүхэд,” гэснийг “хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах бөгөөд” гэж өөрчилж, 3.8 дахь хэсгийг хасаж, 3.2, 3.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.2.Гэр бүлийн гишүүд гэр бүлийн харилцаанд эрх тэгш байдлыг хангаж, гэрлэгчид гэр бүлийн гишүүдийн өмнө хамтын үүрэг, хариуцлага хүлээнэ.

3.3.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь гэр бүлийн харилцаанд хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	63
Татгалзсан:	25
Бүгд:	88

71.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“асран хамгаалах” гэж энэ хуулийн 54.1-д заасан хүүхдийн, эсхүл хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хэлбэрийг;

4.1.2.“бүтэн өнчин хүүхэд” гэж дараах хүүхдийг:

4.1.2.а.эцэг, эх нь тогтоогдоогүй;

4.1.2.б.эцэг, эх нь нас барсан;

4.1.2.в.эцэг, эхийг нь нас барсан гэж зарласан, эсхүл сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

4.1.2.г.эцэг, эхийг нь иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй гэж тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

4.1.2.д.эцэг, эхийнх нь эцэг, эх байх эрхийг хязгаарласан шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол тухайн шийдвэрт заасан хугацаанд;

4.1.2.е.эцэг, эхийнх нь эцэг, эх байх эрхийг хассан шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол уг шийдвэрийг хүчингүй болсонд тооцох хүртэл;

4.1.2.ё.эцэг, эхийн хэн нэг нь тодорхойгүйн улмаас эцэг, эсхүл эхтэйгээ амьдарч байгаад эцэг, эсхүл эх нь нас барсан, эсхүл энэ хуулийн 4.1.2.в, 4.1.2.г, 4.1.2.д, 4.1.2.е-д заасан шүүхийн шийдвэрээр эрх зүйн байдал нь өөрчлөгдсөн бол;

4.1.2.ж.гэрлэлт цуцалсны улмаас асрамждаа авсан эцэг, эсхүл эх нь нас барсан, эсхүл энэ хуулийн 4.1.2.в, 4.1.2.г, 4.1.2.д, 4.1.2.е-д заасан шүүхийн шийдвэрээр эрх зүйн байдал нь өөрчлөгдсөн бөгөөд тусдаа амьдарч байсан эцэг, эсхүл эх асрамждаа аваагүй бол.

4.1.3.“гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр хүний тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэн гэр бүл болох хүсэл зоригоо харилцан илэрхийлж, улсын бүртгэлд бүртгүүлэхийг;

4.1.4.“гэрлэгчид” гэж гэр бүлийн харилцаанд тэгш эрх эдэлж, хамтын үүрэг хүлээхээр гэрлэлтээ улсын бүртгэлд бүртгүүлсэн нөхөр, эхнэрийг;

4.1.5.“гэр бүл” гэж гэрлэлт, төрөлт, үрчлэлтийн үр дүнд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүргээр холбогдсон гэр бүлийн гишүүдийг;

4.1.6.“гэр бүлийн гишүүн” гэж дараах хүнийг:

4.1.6.а.гэрлэгчид;

4.1.6.б.гэрлэгчдийн хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд;

4.1.6.в. гэрлэгчдийн хамт амьдарч байгаа төрөл, садангийн хүн.

4.1.7.“нөхөн үржихүйн туслах аргыг ашиглаж хүүхэдтэй болох” гэж Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу бэлгийн эс ашиглаж, эсхүл тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болохыг;

4.1.8.“овог” гэж нэг өвөг дээдсээс гаралтай эцэг /эх/-ийн талын холбоо бүхий бүлэг хүмүүсийн дунд үе уламжлан хэрэглэгддэг нэрийг;

4.1.9.“садангийн хүн” гэж тухайн хүний төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг;

4.1.10.“сонирхогч тал” гэж 14 насанд хүрсэн хүүхэд, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, албан тушаалтныг;

4.1.11.“төрлийн хүн” гэж тухайн хүний эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач, зээ, эсхүл ач, зээгийн хүүхдийг;

4.1.12.“үрчлэлт” гэж шүүхийн шийдвэрийн дагуу хүүхдийг үрчлэн авсан эцэг, эх болон үрчлүүлсэн хүүхдийн хооронд төрсөн эцэг, эх, хүүхдийн нэгэн адил эрх, үүрэг, хариуцлага үүсгэхээр улсын бүртгэлд бүртгүүлснийг;

4.1.13.“харгалзан дэмжих” гэж энэ хуулийн 54.2-т заасан хүүхдийн, эсхүл хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хэлбэрийг;

4.1.14.“хүүхэд” гэж 18 насанд хүрээгүй хүнийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 30

Бүгд: 90

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.6, 5.7 дахь хэсгийг хасаж, 5.3, 5.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.3.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө бэлгийн замаар дамжих халдвар болон хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолын өвчтэй талаар харилцан мэдээлэлтэй байх зорилгоор эрүүл мэндийн шинжилгээ өгч, тодорхойлолт гаргуулан авна.

5.4.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө хоорондоо төрөл, садангийн холбоотой эсэхээ мэдэх зорилгоор дезоксирибонуклейн хүчил /ДНХ/-ийн удам зүйн шинжилгээнд хамрагдаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 32
 Бүгд: 90
 64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 8 дугаар зүйл болгох.

“8 дугаар зүйл.Гэрлэлтийн бүртгэл

8.1.Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангасан гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ 18 насанд хүрсэн гэрчийн этгээдийг байлцуулан бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

8.2.Гэрлэлтийг бүртгэсэн өдрөөс эхлэн гэрлэгчдийн хооронд энэ хуульд заасан эрх, үүрэг үүснэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
 Татгалзсан: 32
 Бүгд: 90
 64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Гэрлэхийг хүсэгчдэд өгөх зөвлөгөө, сургалт

6.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага анх удаа гэрлэхийг хүсэгчдэд гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө гэр бүлийн харилцаа, гэр бүлийн гишүүдийн эрх, үүрэг, хариуцлага, хүүхдийн эрх, хөгжил, хүмүүжил, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн маргааныг харилцан ойлголцол, зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэх чиглэлээр гэр бүлийн боловсрол олгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан гэр бүлийн боловсролын сургалтын агуулга, хэлбэр, зохион байгуулалт, хугацаа, сургалтад хамруулах журмыг боловсролын болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалзан Засгийн газар батална.

6.3.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага энэ хуулийн 6.1-д заасан сургалтыг иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
 Татгалзсан: 36
 Бүгд: 90
 60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
 Татгалзсан: 34

Бүгд: 90
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 7 дугаар зүйл болгох:

“7 дугаар зүйл.Гэрлэхэд харшлах шалтгаан

7.1.Гэрлэхэд дараах нөхцөл харшилна:

7.1.1.өмнөх гэрлэлт хүчинтэй;
7.1.2.гэрлэхийг хүсэгчид хоёулаа, эсхүл хэн нэг нь 18 насанд хүрээгүй;
7.1.3.гэрлэхийг хүсэгчид хоорондоо төрөл, садангийн холбоотой;
7.1.4.гэрлэхийг хүсэгчид хоорондоо үрчлэгч, үрчлүүлэгчийн харилцаатай;

7.1.5.гэрлэхийг хүсэгчид хоорондоо асран хамгаалагч, асран хамгаалуулагч, эсхүл харгалзан дэмжигч, харгалзан дэмжүүлэгчийн харилцаатай;

7.1.6.гэрлэхийг хүсэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон;

7.2.Иргэний хуульд заасны дагуу насанд хүрээгүй хүнийг иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцсон бол энэ хуулийн 7.1.2-т заасан харшлах нөхцөлд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 32
Бүгд: 90
64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.7 дахь заалтын “дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө” гэснийг “хамтран өмчлөх дундын хөрөнгөө” гэж, 9.1 дэх хэсэг, 9.2.8 дахь заалтын “эд” гэснийг тус тус хасаж, 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 9.2 дахь хэсэг болгох:

“9.2.Гэрлэгчид гэр бүлийн харилцаанд дараах үүрэг хүлээнэ:

9.2.1.бие биеэ тэжээн тэтгэх, асран халамжлах;
9.2.2.бие биеийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, зөрчихгүй байх;

9.2.3.гэр бүлийн угийн бичиг хөтлөх;
9.2.4.гэр бүлийн үнэт зүйл, үндэсний соёл, уламжлал, зан заншлыг эрхэмлэх;

9.2.5.хамтын үүрэг, хариуцлагаа ухамсарлан бие биедээ үнэнч байх, гэрлэлтээс гадуурх харилцаа үүсгэхгүй байх, гэр бүлийн хамтын амьдралаа тогтвортой байлгах, гэр бүлийн амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 9.3 дахь хэсэг болгох:

“9.3.Энэ хуулийн 9.2.3-т заасан угийн бичиг хөтлөх журмыг хууль зүй, соёлын болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалзан Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 40
Бүгд: 90
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Гэрлэлт дуусгавар болох

10.1.Гэрлэлтийг дараах тохиолдолд дуусгавар болсонд тооцно:

10.1.1.гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан;

10.1.2.гэрлэгчдийн хэн нэгнийг нас барсан гэж зарласан, эсхүл сураггүй алга болсон гэж тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

10.1.3.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн² 14 дүгээр зүйлд заасны дагуу гэрлэгчдийн хэн нэг нь хүйсийн өөрчлөлтөө улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн.

10.2.Гэрлэлт дараах тохиолдолд дуусгавар болно:

10.2.1.захиргааны, эсхүл шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулсан;

10.2.2.гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон.

10.3.Энэ зүйлийн 10.1.3-т заасан хүйсийн өөрчлөлт тухайн хүний хөрөнгийн эрх болон эцэг, эхийн эрхийг хязгаарлах, үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

² Иргэний улсын бүртгэлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

“12 дугаар зүйл.Гэрлэлтийг захиргааны журмаар цуцлах

12.1.Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, 18 хүртэлх насны хүүхэдгүй, хөрөнгийн маргаангүй бол Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1, 8.2-т заасны дагуу хүсэлтээ гаргаж, гэрлэлтээ захиргааны журмаар цуцлуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 33

Бүгд: 90

63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13 дугаар зүйл.Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах

13.1.Энэ хуулийн 12.1-д зааснаас бусад тохиолдолд гэрлэлт цуцлуулах асуудлыг гэрлэгчдийн хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ.

13.2.Энэ хуулийн 10.1.3-т заасны дагуу гэрлэгчдийн хэн нэг нь хүйсийн өөрчлөлтөө иргэний улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, гэрлэлт дуусгавар болсон бол гэрлэлт цуцлахаас бусад хүүхдийн асрамж, тэтгэлэг, дундын эд хөрөнгө хуваах асуудлыг нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх шийдвэрлэнэ.

13.3.Гэрлэгчид гэрлэлтийн гэрээнд хөрөнгийн эрх, үүргийг тусгасан эсэхээс үл хамаарч, гэрлэлт цуцлуулах үед хөрөнгийн эрх, үүргийн талаар харилцан тохиролцож болно.

13.4.Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдийн асрамж, хүүхэд эцэг, эхтэйгээ уулзах хуваарь, хүүхдийн тэтгэлэг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх асуудлыг бие даан, эсхүл эвлэрүүлэн зуучлалын журмаар харилцан тохиролцож болно.

13.5.Шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, хөдөлмөрийн чадваргүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзнэ.

13.6.Шүүх гэрлэлт цуцлахдаа нэхэмжлэлийн шаардлагаас үл хамааран дараах асуудлыг шийдвэрлэнэ:

13.6.1.хүүхдийн асрамж;

13.6.2.хүүхдээс тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах нөхцөл, хэлбэр, байршил, хугацаа;

13.6.3.тэтгэлгийн хэмжээ, нэмэлт зардал.

13.7.Шүүх энэ хуулийн 13.6.1, 13.6.2-т заасан асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хангаж, дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

13.7.1.хүүхдийн нас бие, бялдар, оюун ухаан, нийгэмшихүй, танин мэдэхүй, сэтгэхүй, хөгжил, сэтгэл зүйн онцлогт нийцсэн хэрэгцээг;

13.7.2.хүүхэд долоо, түүнээс дээш настай бол түүний саналыг;

13.7.3.хүүхдийн эцэг, эх, ах, эгч, дүү, эмээ, өвөө болон түүний амьдралд чухал нөлөө бүхий бусад хүнтэй тогтоосон харилцааг;

13.7.4.эцэг, эхийн хүүхдийг асран хамгаалж, хүмүүжүүлэхэд оролцож байсан оролцооны байдал, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, чадавхыг;

13.7.5.хүүхдийг асран хамгаалах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх төлөвлөгөө, хүүхэдтэй харилцах чадвар, эцэг, эхийн амьдралын хэв маяг, эрүүл мэнд, эрхэлсэн ажил, ажлын цагийг;

13.7.6.гэрлэгчид хүүхдийн асрамжийн асуудлаар тохиролцсон эсэхийг.

13.7.7.эцэг, эхийн зан суртахуун, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эсэх, хүүхдэд үзүүлэх нөлөөг;

13.8.Шүүх энэ хуулийн 13.6.3-т заасан тэтгэлгийн хэмжээ, нэмэлт зардлыг энэ хуулийн долоодугаар бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

13.9.Эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагаас мэргэжил, арга зүйн дэмжлэг авч, хамтран ажиллаж болно.

13.10.Эхнэр нь жирэмсэн, эсхүл хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсхүл гэрлэгчдийн хэн нэг нь хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүх гэр бүлийн хүчирхийллээс бусад тохиолдолд хүлээн авахаас татгалзана.

13.11.Энэ хуулийн 13.10-т заасан нөхцөл байдал арилсан бол гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.

13.12.Гэрлэлт цуцалсан тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш ажлын гурван өдрийн дотор тухайн шүүх уг шийдвэрийн хувийг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан болон улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.

Тайлбар:-Энэ хуулийн 13.10-т заасан “хүнд өвчтэй” гэж гэрлэгчдийн хэн нэг нь баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалтад заасан өвчтэй бөгөөд шүүхэд гэрлэлт цуцлуулах асуудлыг хэлэлцэх үед өвчин нь хүндэрсэн шатандаа орсны улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах боломжгүй болох нь эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон байхыг ойлгоно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “тохиолдолд” гэснийг “нөхцөлд” гэж, “цуцалж болно” гэснийг “цуцална” гэж, 14.1.1 дэх заалтын “гишүүдийн” гэснийг “гишүүний” гэж, 14.1.3 дахь заалтын “эд хөрөнгийн” гэснийг “хөрөнгийн” гэж тус тус өөрчилж, 14.1.1 дэх заалтын “байнгын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 33
Бүгд: 90
63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“15 дугаар зүйл.Шүүх гэр бүлийн нэг гишүүнд ногдох хөрөнгийг тодорхойлох

15.1.Гэрлэлт цуцалснаас гэр бүлийн дундаа хамтран өмчлөх хөрөнгөөс нэг гишүүнд ногдох хэсгийг тодорхойлоход гэрлэлтийн гэрээ, эсхүл гэрлэлтийн гэрээ байгуулаагүй бол Иргэний хуулийн 129, 130 дугаар зүйлд заасны дагуу шүүх шийдвэрлэнэ.

15.2.Гэрлэлтээс гадуурх харилцааны, эсхүл гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэрлэлт цуцалсан, эсхүл гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдал, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлын үүднээс гэрлэлт цуцалсан, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол Иргэний хуулийн 129.3-т заасны дагуу гэр бүлийн дундаа хамтран өмчлөх хөрөнгөөс нэг гишүүнд ногдох хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо шүүх өөрөөр тогтоож болно.

Тайлбар:-Энэ хуулийн 15.2-т “Гэрлэлтээс гадуурх харилцаа” гэж гэрлэгч нь гэр бүлийн үнэнч байдлын үүргийг зөрчин өөр хүнтэй гэрлэлтээс үүсэх эрх, үүргийн шинжтэй тогтвортой харилцаа тогтоосныг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “8 дугаар зүйлд” гэснийг “7 дугаар зүйлд” гэж өөрчилж, мөн зүйлийн “Тайлбар”-ыг хасаж, 16.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.Гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл гуравдагч этгээд гэрлэгчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл хууль бус бусад арга хэрэглэсний улмаас гэрлэлт бүртгүүлсэн нь тогтоогдсон бол шүүх гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 33
Бүгд: 90
63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “дахин” гэснийг, 17.1 дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 36
Бүгд: 91
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл.Гэрлэлт сэргээх

18.1.Гэрлэлт цуцлуулсан талууд эвлэрснээ хамтран илэрхийлж, хүсэлт гаргасан бөгөөд өөр хүнтэй гэрлэлт бүртгүүлээгүй, талууд өөрөөр тохиролцоогүй бол улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж сэргээх бөгөөд гэрлэлтийг сэргээсэн өдрөөс эхлэн тооцно.

18.2.Гэрлэгчид энэ хуулийн 18.1-д заасан гэрлэлт сэргээх хугацааны талаар харилцан тохиролцоонд хүрээгүй бол шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлж болно.

18.3.Шүүхийн шийдвэрээр нас барсан гэж зарлагдсан, эсхүл сураггүй алга болсон гэж тооцогдсон хүн эргэж ирэн нөхөр, эсхүл эхнэртэйгээ хамтран амьдрах хүсэлтээ гаргасан бөгөөд нөхөр, эсхүл эхнэр нь өөр хүнтэй гэрлэлтээ бүртгүүлээгүй бол талуудын зөвшөөрснөөр шүүх гэрлэлтийг сэргээх бөгөөд анх гэрлэлтээ бүртгүүлсэн өдрөөс эхлэн тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 34
Бүгд: 91
62.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “20.1-д” гэснийг “19.1-д” гэж “хуульд” гэснийг “хуулийн 129.8-д” гэж өөрчилж, 20.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“20.1.Энэ хуулийн 19.1-д заасан шүүхийн шийдвэрийг улсын бүртгэлийн байгууллага бүртгэснээр гэрлэлтийг анх гэрлэлтээ бүртгүүлсэн өдрөөс эхлэн тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 38
Бүгд: 91
58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“21 дүгээр зүйл.Гэрлэлтийн бүртгэлгүй хамтын амьдралаас үүсэх
хөрөнгийн харилцаа**

21.1.Дараах нөхцөл бүгд хангагдсан тохиолдолд гэрлэлтээ бүртгүүлээгүй хамтран амьдрагчдын хамтын амьдралын хугацаанд бий болсон эд хөрөнгийн эрхийн талаарх маргааныг Иргэний хуулийн 129, 130, 131-д заасны дагуу шүүх шийдвэрлэнэ:

21.1.1.хамтран амьдрагчид өөр хүнтэй гэрлэлт бүртгүүлээгүй байх;

21.1.2.таваас доошгүй жилийн хугацаанд тасралтгүй хамтран амьдарсан байх;

21.1.3.хөрөнгө хамтран өмчилж байгаа, хамтын амьдралын хугацаанд хөрөнгө бий болсон;

21.1.4.хамтран амьдрагчид нэг оршин суух хаягт бүртгэлтэй байх;

21.2.Хамтран амьдрагчдын хооронд өв залгамжлах эрх үүсэхгүй бөгөөд хамтын амьдрал дуусгавар болсон тохиолдолд бие биеэ тэжээн тэтгэх үүрэггүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 34

Бүгд: 91

62.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийн “бусад” гэснийг “бус гэж” өөрчилж, 23.1.1, 23.2.1, 23.2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.1.гэрлэгчдийн байнга оршин сууж амьдарч байгаа орон байрнаас бусад гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн эрх, үүргийг хуваарилах;

23.2.1.эд хөрөнгийн бус харилцаа, гэрлэгчдийн амины эрх;

23.2.6.гэрлэгчдийн байнга оршин сууж амьдарч байгаа орон байрны эзэмших, ашиглах, өмчлөх эрхийг хязгаарласан.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 40

Бүгд: 91

56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24 дүгээр зүйл.Хүүхдэд нэр, эцэг/эх/-ийн нэр, овог өгөх

24.1.Эцэг, эх харилцан зөвшилцсөний үндсэн дээр хүүхдэдээ нэр өгнө.

24.2.Хуульд өөрөөр заагаагүй бол хүүхэд эцгийн овог, нэрийг авна.

24.3.Хүүхдийн эцэг, эх нь гэрлэлтээ бүртгүүлээгүй бөгөөд харилцан тохиролцоогүй, эсхүл хүүхдийн эцгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогоогүй, эсхүл эцэг, эхийн хэн нэгний өмнөх гэрлэлт дуусгавар болоогүй бол эх нь хүүхдэд нэр өгөх бөгөөд хүүхэд эхийн овог, нэрийг авна.

24.4.Хүүхдийн эцэг, эх нь хэн болох нь тогтоогдоогүй бол улсын бүртгэлийн байгууллага хүүхдэд нэр, овог, эцэг /эх/-ийн нэр өгч болно.

24.5.Дараах тохиолдолд хүүхдийн эцэг, эсхүл эхийг тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн хүүхдэд овог, эцэг /эх/-ийн нэр өгнө:

24.5.1.хүүхдийн эцгийг тогтоосон бол эцгийн овог, нэрийг;

24.5.2.эцэг нь тодорхойгүй бөгөөд хүүхдийн эхийг тогтоосон бол эхийн овог, нэрийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.3, 27.4 дэх хэсгийн “үр хөврөлийн” гэснийг “бэлгийн эсийн” гэж, 27.4 дэх хэсгийн “тээгч эмэгтэй” гэснийг “тээгч эх” гэж, 27.5 дахь хэсгийн “Тээгч эмэгтэйн” гэснийг “Тээгч эх” гэж тус тус өөрчилж, 27.1, 27.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.1.Гэрлэгчид нөхөн үржихүйн туслах аргыг ашиглаж хүүхэдтэй болох талаар харилцан зөвшилцөж, хамтын шийдвэр гаргасан байна.

27.2.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн 15.7-д заасан гэрээ байгуулсны үндсэн дээр нөхөн үржихүйн туслах аргыг ашиглан хүүхэдтэй болсон гэрлэгчид гэрээний дагуу төрсөн хүүхдийн эцэг, эх байх бөгөөд тухайн хүүхдийг тэдгээрийн төрсөн хүүхэд гэж үзнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 41

Бүгд: 91

54.9 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28, 32, 35 дугаар зүйлийг нэгтгэж доор дурдсанаар өөрчлөн найруулж 28 дугаар зүйл болгох:

“28 дугаар зүйл.Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах

28.1.Эцэг, эх хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хүн, хуулийн этгээдийн өмнө итгэмжлэлгүйгээр төлөөлж, хамгаална.

28.2.Эцэг, эх, эсхүл хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч 14 насанд хүрээгүй хүүхдийнхээ өмнөөс хэлцэл хийх, 14-18 насны хүүхдэд насанд хүрээгүй иргэн хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцэл хийх тохиолдолд бичгээр зөвшөөрөл

олгох, хүүхдийг иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцогдох хүртэлх хугацаанд түүний хөрөнгийг хамгаалах үүрэгтэй.

28.3.Бүтэн өнчин, эсхүл эцэг, эх нь хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах боломжгүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн бол хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, албан тушаалтан, хүүхдийн суралцдаг сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага хамгаална.

28.4.Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн бол эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, албан тушаалтан хуульд заасны дагуу шүүхэд нэхэмжлэл гаргах үүрэгтэй.

28.5.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хоорондоо зөрчилдөж байгааг тогтоосон бол сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах эрх бүхий төлөөлөгчийг томилж болно.

28.6.Энэ хуулийн 28.5-д заасан хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах этгээдээр Хүүхэд хамгааллын тухай хуулийн 47.1-д заасан хүүхэд хамгааллын үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн хүн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдийг, эсхүл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 22.5-д заасан итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилно.

28.7.Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон, үүргээ биелүүлээгүй эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон гэр бүлийн бусад гишүүдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 42

Бүгд: 91

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29 дүгээр зүйл.Эцэг, эх, хүүхдийн хоорондын эрх, үүрэг

29.1.Хүүхэд гэр бүлийн дотор тэгш эрх эдэлнэ.

29.2.Хүүхэд гэр бүлийн орчинд амьдрах, эрүүл, аюулгүй өсөж, хүмүүжих, асран хамгаалуулах, тэжээн тэтгүүлэх, сурч боловсрох, хөгжих, эцэг, эхийн анхаарал халамжид байх, өөрт хамаарах асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх, эд хөрөнгө эзэмших, ашиглах, өмчлөх, өв залгамжлах эрхтэй.

29.3.Шүүхийн шийдвэрээр эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, эсхүл хасуулснаас бусад тохиолдолд хүүхэд эцэг, эхтэйгээ амьдрах, эцэг, эсхүл эх, эсхүл тэднээс тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх эрхтэй.

29.4.Хүүхэд төрснөөр, хүүхдийг үрчлэн авснаар эцэг, эх, хүүхдийн хооронд эрх, үүрэг, хариуцлага үүснэ.

29.5.Дагавар хүүхэд хойд эцэг, эхийн хооронд эцэг, эх, хүүхдийн эрх, үүрэг, хариуцлага үүснэ.

29.6.Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхийн дундаас төрсөн хүүхэд нь гэрлэлтээ бүртгүүлсэн гэрлэгчдээс төрсөн хүүхдийн адил эрх эдэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 39

Бүгд: 91

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “харгалзан дэмжигч” гэсний дараа “тухайн насанд хүрээгүй” гэж, 30.2 дахь хэсгийн “эцэг, эх хоёулаа” гэсний дараа “эцэг, эх,” гэж, “эцэг, эхийг” гэсний өмнө “тухайн насанд хүрээгүй” гэж, “томилно.” гэсний өмнө “харгалзан дэмжигч” гэж тус тус нэмж, 30.1 дэх хэсгийн “тэдний” гэснийг “тэдгээрийн” гэж, “эцэг, эхийн” гэснийг “эцэг, эх” гэж, 30.2 дахь хэсгийн “шалтгаанаар” гэснийг “шалтгааны улмаас” гэж, “хорооны” гэснийг “дүүргийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 43

Бүгд: 91

52.7 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.3.8 дахь заалтын “хүүхдээ” гэсний дараа “өөрийгөө болон бусдыг” гэж нэмж, 31.3 дахь хэсгийн “эх,” гэснийг “эх нь” гэж, 31.3.4 дэх заалтын “эд хөрөнгийг” гэснийг “хөрөнгийг” гэж тус тус өөрчилж, 31.2 дахь хэсгийг болон 31.3.12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.2.Эцэг, эх нь хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалж, энэ хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, эсхүл хасуулсан, эсхүл эцэг, эхийн хэн нэгэнд нь дангаар хэрэгжүүлэх хүүхдийн асрамж тогтоосноос бусад тохиолдолд хүүхэдтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн саналыг харгалзан хамтын шийдвэр гаргана.

31.3.12.хүүхдийг үе тэнгийн дээрэлхэлт үйлдэхээс болон түүнд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 35

Бүгд: 91

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 32 дугаар зүйл болгох:

“32 дугаар зүйл.Хүүхдийн асрамж, хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эхийн эрх, үүрэг

32.1.Хүүхдийн асрамж, хүүхдийн талаар шийдвэр гаргах болон хүүхэдтэй уулзах хуваарьтай холбоотой гаргасан шүүхийн шийдвэрийг эцэг, эх биелүүлэх үүрэгтэй.

32.2.Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцсэн байдлаар талууд өөрөөр тохиролцоогүй бол шүүх хүүхдийн асрамжийг авсан талд хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрхийг олгох бөгөөд тусдаа амьдрах эцэг, эсхүл эх хүүхдийн талаар мэдээлэл авах эрхтэй.

32.3.Хүүхдийн асрамжийг авсан тал хүүхдийн асуудлаар гаргасан аливаа шийдвэрийн талаар тусдаа амьдарч байгаа эцэг, эсхүл эхэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

32.4.Эцэг, эхийн хэн нэг нь, эсхүл 14 насанд хүрсэн хүүхэд тухайн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл хүүхдийн асрамж болон хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эхийн хүүхэдтэй уулзах эрх, үүргийн талаарх шүүхийн шийдвэрийг өөрчлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

32.5.Эцэг, эх харилцан тохиролцсоны үндсэн дээр хүүхдийг хэний асрамжид байгаагаас үл шалтгаалан хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хүүхэд гадаад улсад удаан хугацаагаар зорчих, шашин, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх дугуйланд сургах зэрэг хүүхдийн хөгжил, хүүхдийн хуваарьт хөрөнгийг хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиран зарцуулах талаар хамтын шийдвэр гаргаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 34 дүгээр зүйл болгох:

“34 дүгээр зүйл.Хүүхдийн хуваарьт хөрөнгийг захиран зарцуулахад эцэг, эхийн эрхийг хязгаарлах

34.1.Хүүхэд төрсөн цагаасаа эхлэн Иргэний хуулийн 127.1-д заасан хуваарьт хөрөнгөтэй болох бөгөөд түүний хуваарьт хөрөнгөд өв залгамжлал, бэлэглэл, тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг, нөхөн төлбөр, оюуны өмчийн үр шим, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон хуульд заасан бусад үндэслэлээр хүүхдийн өмчлөлд шилжсэн хөрөнгө, хөрөнгийн эрх хамаарна.

34.2.Хүүхдийн хуваарьт хөрөнгийн өмчлөгч нь хүүхэд байх бөгөөд эцэг, эх нь түүний хуваарьт хөрөнгийг хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцүүлэн түүний амьжиргаа, сурч боловсрох, хөгжих, авьяас чадварыг дэмжих, эрүүл мэндийн хэрэгцээнд зориулан захиран зарцуулна.

34.3.Эцэг, эх нь хүүхдийн хуваарьт хөрөнгийг өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглах, барьцаалах, шилжүүлэх, бэлэглэх, үрэгдүүлэхийг хориглоно.

34.4.Эцэг, эх нь энэ хуулийн 34.3-т заасан хүүхдийн ашиг сонирхолд харшлах үйл ажиллагаа явуулсны улмаас түүний хуваарьт хөрөнгөд хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

34.5.Хүүхэд 14 насанд хүрснээс хойш Иргэний хуулийн 75.1-д заасан хугацаанд өөрийн хуваарьт хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах эрхтэй.

34.6.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч өөрчлөгдсөн нь хүүхдийн хуваарьт хөрөнгийн өмчлөх эрхийг өөрчлөх, хязгаарлах, дуусгавар болгох үндэслэл болохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 40

Бүгд: 91

56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийг 35 дугаар зүйл болгож, 37.2 дахь хэсгийн “37.1-д” гэснийг “35.1-д” өөрчилж, 37.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 35.1 дэх хэсэг болгох:

“35.1.Хүүхэд төрөл, садантайгаа чөлөөтэй харилцах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 41

Бүгд: 91

54.9 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийг 36 дугаар зүйл болгож, 38.1.1 дэх хэсгийн “хангаагүй” гэсний өмнө “зориуд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 47

Бүгд: 91

48.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 41

Бүгд: 91

54.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Бямбацогт: 31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийг 36 дугаар зүйл болгож, 38.1.1 дэх хэсгийн “хангаагүй” гэсний өмнө “зориуд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 42

Бүгд: 91

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийг 37 дугаар зүйл болгож, 39.3 дахь хэсгийн “асран хамгаалах байгууллагын асран хамгаалалтад шилжүүлнэ” гэснийг “хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэж, 39.5 дахь хэсгийн “хязгаарлуулсан, эсхүл хасуулснаас” гэснийг “хязгаарлуулснаас” гэж өөрчилж, 39.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 37.4 дэх хэсэг болгох:

“37.4. Сонирхогч тал эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүнийг энэ хуулийн 36.1-д заасан нөхцөлөө арилгаагүй бөгөөд энэ хуулийн 39.1-д заасан нөхцөл бий болсон гэж үзвэл, түүний нэхэмжлэлийн үндсэн дээр тухайн хүний эцэг, эх байх эрхийг хасах эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 40

Бүгд: 91

56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийг 38 дугаар зүйл болгож, 40.1 дэх хэсгийн “38.1-д” гэснийг “36.1-д” гэж, “шүүх шийдвэрлэнэ” гэснийг “шийдвэрлэнэ” гэж, 40.2 дахь хэсгийн “38.1-д” гэснийг “36.1-д” гэж, “хууль ёсны” гэснийг “дээд” гэж, “бол” гэснийг “байвал” гэж, 40.3 дахь хэсгийн “саналыг” гэснийг “санал болон энэ хуулийн 41.1-д заасан сургалтад хамрагдсан эсэхийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 42

Бүгд: 91

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийг 39 дүгээр зүйл болгож, 41.1.1 дэх заалтын “, 4.1.4в, 4.1.4г” гэснийг, 41.1.4 дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 42

Бүгд: 91

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийг 40 дүгээр зүйл болгож, 42.2 дахь хэсгийн “асран хамгаалах байгууллагын асран хамгаалалтад

шилжүүлнэ” гэснийг “хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэж, 42.3 дахь хэсгийн “эд хөрөнгийн” гэснийг “хөрөнгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 39

Бүгд: 91

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 41 дүгээр зүйл болгох:

“41 дүгээр зүйл.Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, эсхүл хасуулсан хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах

41.1.Аймаг, дүүргийн боловсролын болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага эцэг, эх байх эрхийг нь хязгаарлуулсан, эсхүл хасуулсан хүнийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 35.1.10-т заасны дагуу эцэг, эх байх үүрэг, хариуцлагын талаар болон түүний зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах ажлыг хүртээмжтэй байдлаар зохион байгуулна.

41.2.Энэ хуулийн 41.1-д заасан сургалтын хөтөлбөрийг олон улсын жишиг, үндэсний онцлогийг харгалзан боловсролын болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 43

Бүгд: 91

52.7 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 42 дугаар зүйл болгох:

“42 дугаар зүйл.Эцэг, эх байх эрхийг сэргээх

42.1.Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүн энэ хуулийн 39.1.1, 39.1.2-т заасан нөхцөлийг арилгасан тохиолдолд эцэг, эх байх эрхийг сэргээх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

42.2.Шүүх дараах тохиолдолд эцэг, эх байх эрхийг сэргээхгүй:

42.2.1.энэ хуулийн 39.1-д заасан нөхцөл арилаагүй;

42.2.2.эцэг, эх байх эрхийг хассанаас хойш хүүхэд үрчлэгдсэн;

42.2.3.эцэг, эх байх эрхийг хассанаас хойш хүүхдийн эсрэг Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн;

42.2.4.эцэг, эх байх эрхийг сэргээх нь хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд харшлахаар байгаа нь тогтоогдсон.

42.3.Шүүх эцэг, эх байх эрхийг сэргээх эсэх асуудлыг шийдвэрлэхдээ долоо, түүнээс дээш настай хүүхдийн санал болон энэ хуулийн 41.1-д заасан сургалтад

хамрагдсан эсэхийг харгалзан үзнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 41
Бүгд: 91
54.9 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 45 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 43 дугаар зүйл болгох:

“43 дугаар зүйл.Тэжээн тэтгэх үүрэг, тэжээн тэтгүүлэх эрх

43.1.Гэрлэгчид бие биеэ, эцэг, эх нь хүүхдээ, хүүхэд нь эцэг, эхээ, төрөл, садангийн хүмүүс бие биеэ энэ хуульд заасны дагуу тэжээн тэтгэх үүрэгтэй.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд уг үүргээ биелүүлээгүй бол тэжээн тэтгүүлэх эрхтэй этгээд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 47
Бүгд: 91
48.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 46
Бүгд: 91
49.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 11 цаг 33 минутаас 13 цаг 33 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 44

Бүгд: 91
51.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 45 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 43 дугаар зүйл болгох:

“43 дугаар зүйл.Тэжээн тэтгэх үүрэг, тэжээн тэтгүүлэх эрх

43.1.Гэрлэгчид бие биеэ, эцэг, эх нь хүүхдээ, хүүхэд нь эцэг, эхээ, төрөл, садангийн хүмүүс бие биеэ энэ хуульд заасны дагуу тэжээн тэтгэх үүрэгтэй.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд уг үүргээ биелүүлээгүй бол тэжээн тэтгүүлэх эрхтэй этгээд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 47
Бүгд: 91
48.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 47
Бүгд: 91
48.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Ж.Бат-Эрдэнэ: 39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46, 47 дугаар зүйлийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулж 44 дүгээр зүйл болгох:

“44 дүгээр зүйл.Гэрлэгчдийн бие биеэ харилцан тэжээн тэтгэх үүрэг

44.1.Гэрлэгчид гэрлэлт хүчинтэй байх хугацаанд бие биеэ харилцан тэжээн тэтгэх үүрэгтэй.

44.2.Гэрлэлт дуусгавар болсны дараа гэрлэгчдийн хэн нэг нь дараах тохиолдолд тэтгэлэг гаргуулах эрхтэй:

44.2.1.гэрлэлт дуусгавар болохоос өмнө төрсөн, үрчлэн авсан гурав хүртэлх насны хүүхэдтэй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл хүнд өвчтэй хүүхдээ асарч байгаа бол;

44.2.2.гэрлэлт дуусгавар болохоос өмнө эхнэр нь жирэмсэн байсан бөгөөд хүүхэд төрсөн бол;

44.2.3.гэрлэлт дуусгавар болсноос хойш хоёр жилийн дотор хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн, эсхүл бүрэн алдсан нь гэр бүлийн хүчирхийлэл болон гэрлэлт цуцлуулахаас өмнө бий болсон нөхцөл байдалтай шууд холбоотойгоор үүссэн бол;

44.2.4.гэрлэлт дуусгавар болохоос өмнө өөрийн буруугүй үйлдлийн улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, эсхүл хүнд өвчтэй болсон бөгөөд энэ байдал нь гэрлэлт цуцлуулсны дараа арилаагүй бол.

44.3.Тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь уг үүргээ биелүүлээгүй бол тэтгэлэг гаргуулах тухай тэжээн тэтгүүлэх эрхтэй этгээдийн нэхэмжлэлийг шүүх шийдвэрлэнэ.

44.4.Энэ хуулийн 44.2-т заасан тэтгэлгийн хэмжээг хариуцагчийн хөрөнгө, орлого, бусад нөхцөл байдлыг харгалзан энэ хуулийн 46.1-д заасны дагуу тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 37

Бүгд: 91

59.3 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийг 45 дугаар зүйл болгож, 48.1 дэх хэсгийн “сургуульд” гэсний өмнө “эсхүл” гэж, “хөдөлмөрийн” гэсний өмнө “насанд хүрсэн боловч” гэж, “байнгын асаргаа” гэсний өмнө “насанд хүрсэн боловч” гэж нэмж, 48.2 дахь хэсгийн “48.1-д” гэснийг “45.1”-д гэж, “тэжээн тэтгэх үүргийн талаарх” гэснийг “хүүхдийн тэтгэлэг тогтоолгох тухай сонирхогч талын” гэж тус тус өөрчилж, 48.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 45.4 дэх хэсэг болгох:

“45.4.Энэ хуулийн 45 дугаар зүйлд заасан тэтгэлгийн хэмжээг хариуцагчийн хөрөнгө, орлого, бусад нөхцөл байдлыг харгалзан энэ хуулийн 46.1-д заасны дагуу тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 34

Бүгд: 91

62.6 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийг 46 дугаар зүйл болгож, 49.4 дэх хэсгийн “49.1-д” гэснийг “46.1-д” гэж, 49.5 дахь хэсгийн “49.4-т” гэснийг “46.3-т” гэж, 49.8 дахь хэсгийн “хүүхдийн” гэснийг “түүний” гэж тус тус өөрчилж, 49.3 дахь хэсгийг хасаж, 49.1, 49.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 46.1, 46.2 дахь хэсэг болгох:

“46.1.Талууд энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бол шүүх энэ хуулийн 46.2-т заасан тэтгэлэг тогтоох аргачлалын дагуу хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг харгалзан тэтгэлэг тогтооно.

46.2.Тэтгэлэг тогтоох аргачлалыг сар, улирал, хагас жил, эсхүл жилээр төлөх тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, тэтгэлэг авагчийн хэрэгцээ, шаардлага зэрэг нөхцөл байдлыг харгалзан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн

болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалзан Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийг 47 дугаар зүйл болгож, 50.4 дэх хэсгийн “50.2, 50.3-т” гэснийг “47.2-т” гэж өөрчилж, 50.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 37

Бүгд: 91

59.3 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 51 дүгээр зүйлийг 48 дугаар зүйл болгож, 51.3 дахь хэсгийн “51.1-д” гэснийг “48.1-д” гэж өөрчилж, гарчгийн “тэтгэлэг,” гэснийг, 51.1, 51.2, 51.3 дахь хэсгийн “тэтгэлэг, эсхүл” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 38

Бүгд: 91

58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 49 дүгээр зүйл нэмэх:

“49 дүгээр зүйл.Хүүхэд эцэг, эхээ тэжээн тэтгэх үүрэг

49.1.Насанд хүрсэн, хөдөлмөрийн чадвартай хүүхэд нь хөдөлмөрийн чадваргүй, эсхүл байнгын асаргаа шаардлагатай, эсхүл өндөр насны улмаас өөрийгөө тэжээн тэтгэх боломжгүй болсон нь тогтоогдсон эцэг, эхээ тэжээн тэтгэх үүрэгтэй.

49.2.Хоёр, түүнээс дээш хүүхэдтэй бол эцэг, эхээ тэжээн тэтгэх үүргийг тухайн хүүхдүүд харилцан тохиролцсоны үндсэн дээр хүүхэд тус бүрийн үүргийг тодорхойлон хэрэгжүүлж болно.

49.3.Энэ хуулийн 49.2-т заасны дагуу хүүхдүүд нь тохиролцож чадаагүй бол эцэг, эхийн, эсхүл хүүхдүүдийн хэн нэгний нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх хүүхэд тус бүрийн хөрөнгө, орлого, хөдөлмөрийн чадвар болон бусад нөхцөл байдлыг харгалзан тэжээн тэтгэх үүргийн оролцоог тодорхойлон шийдвэрлэж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 36

Бүгд: 91

60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 50 дугаар зүйл нэмэх:

“50 дугаар зүйл.Төрөл, садангийн хүмүүсийн тэжээн тэтгэх үүрэг

50.1.Насанд хүрээгүй бүтэн өнчин, эсхүл эцэг, эхээрээ тэжээн тэтгүүлэх боломжгүй хүүхдийг хөдөлмөрийн чадвартай төрсөн, үрчлэн авсан ах, эгч, дүү, өвөг эцэг, эмэг эх нь тэжээн тэтгэх үүрэгтэй.

50.2.Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээрээ тэжээн тэтгүүлэх боломжгүй, хөдөлмөрийн чадваргүй өвөг эцэг, эмэг эхээ хөдөлмөрийн чадвартай ач, зээ нь тэжээн тэтгэх үүрэгтэй.

50.3.Тэжээн тэтгэх үүрэгтэй төрөл, садангийн хүн хоёр, түүнээс дээш байвал тэжээн тэтгэх үүргийг харилцан тохиролцсоны үндсэн дээр хүн тус бүрийн үүргийг тодорхойлон хэрэгжүүлж болно.

50.4.Төрөл, садангийн хүмүүс тохиролцож чадаагүй бол тухайн хүний, эсхүл төрөл, садангийн хүний хэн нэгний нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх хүн тус бүрийн хөрөнгө, орлого, хөдөлмөрийн чадвар болон бусад нөхцөл байдлыг харгалзан тэжээн тэтгэх үүргийн оролцоог тодорхойлон шийдвэрлэж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 45

Бүгд: 92

51.1 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 52 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 51 дүгээр зүйл болгох:

“51 дүгээр зүйл.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах, хүчингүйд тооцох

51.1.Энэ хуулийн 44, 45 дугаар зүйлд заасан тэтгэлэг төлөгч болон тэтгэлэг авагч, эсхүл түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг төлөх нөхцөл, журмыг харилцан тохиролцож, тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулж болно.

51.2.Энэ хуулийн 49, 50 дугаар зүйлд заасан тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд болон тэжээн тэтгүүлэх эрхтэй этгээд, эсхүл түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь энэ хуулийн 51.1-д заасан гэрээг байгуулж болно.

51.3.Тэжээн тэтгэх тухай гэрээнд тэтгэлгийн хэмжээ, төлөх хугацаа, хэлбэрээс гадна тэжээн тэтгүүлэгчийн хэрэгцээ шаардлага, тэжээн тэтгэгчийн хөрөнгө, орлогын байдлыг харгалзан бусад нөхцөлийг тусгаж болно.

51.4.Тэжээн тэтгэх тухай гэрээг талууд харилцан тохиролцож бичгээр байгуулах бөгөөд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл цуцлахад гэрээ байгуулсан хэлбэрийг баримтална.

51.5.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах, хүчингүй болсонд тооцохтой холбогдсон харилцааг Иргэний хуульд заасан үндэслэл, журмын дагуу зохицуулна.

51.6.Тэжээн тэтгэх тухай гэрээтэй холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэхдээ хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой асуудлыг хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах бөгөөд бусад асуудалд талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 46

Бүгд: 92

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 54 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 53 дугаар зүйл болгох:

“53 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөх

53.1.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бөгөөд шүүхийн шийдвэрээр тэтгэлгийн хэмжээг тогтоосны дараа энэ хуулийн 44, 45 дугаар зүйлд заасан тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, бусад нөхцөл байдал өөрчлөгдсөн бол тэтгэлэг авагчийн, эсхүл тэтгэлэг төлөгчийн нэхэмжлэлийн үндсэн дээр тэтгэлгийн хэмжээг өөрчлөх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

53.2.Шүүх энэ хуулийн 53.1-д заасан асуудлыг шийдвэрлэхдээ энэ хуулийн 46.2-т заасан аргачлалын дагуу дахин тогтооно.

53.3.Эцэг, эх, эсхүл төрөл, садан хүн нь хүүхдийг тэжээн тэтгэх, өсгөн хүмүүжүүлэх үүргээ ноцтой зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон бол хүүхэд эцэг, эх, эсхүл төрөл, садангийн хүнээ тэжээн тэтгэх үүргээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөж болно.

53.4.Тэжээн тэтгүүлэгчийн тэжээн тэтгүүлэх эрхийн үндэслэл арилсан бол энэ хуулийн 43.1-д заасан этгээдийн тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болно.

53.5.Тэжээн тэтгүүлэгч нь тэжээн тэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, хүчирхийлсэн, дарамталсан, гэм хор учруулсан, эсхүл учруулахаар завдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол тэтгэлэг төлөгчийг тэжээн тэтгэх үүргээс шүүхийн шийдвэрээр чөлөөлнө.

53.6.Гэрлэлтээс гадуурх харилцаа, гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэрлэлт цуцалсан бол хүүхэд нь гэрлэлтээс гадуурх харилцааг үүсгэсэн буруутай эцэг, эсхүл эхээ тэжээн тэтгэхгүй байж болно.

53.7.Энэ хуулийн 53.4-т заасан тэжээн тэтгүүлэгчид 18 насанд хүрээгүй хүүхэд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 50

Бүгд: 92
45.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 41
Бүгд: 92
55.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Ж.Бат-Эрдэнэ: 48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 55 дугаар зүйлийг 54 дүгээр зүйл болгож, 55.4 дэх хэсгийн “хууль ёсны” гэснийг “дээд” гэж өөрчилж, 55.1 дэх хэсгийг хасаж, 55.2, 55.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 54.1, 54.2 дахь хэсэг болгох:

“54.1.Асран хамгаалалтад дараах хүнийг хамруулна:

54.1.1.бүтэн өнчин 14 насанд хүрээгүй хүүхэд;

54.1.2.эцэг, эх нь хоёулаа шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүний 14 насанд хүрээгүй хүүхэд;

54.1.3.эцэг, эх нь хоёулаа, эсхүл хүүхдийн байнга хамт амьдардаг эцэг, эсхүл эх нь хүнд өвчтэй, бусдын асрамжид байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүүхдээ биечлэн асран хамгаалах, хүмүүжүүлэх боломжгүй байгаа хүний 14 насанд хүрээгүй хүүхэд;

54.1.4.эцэг, эх нь хоёулаа, эсхүл хүүхдийн байнга хамт амьдардаг эцэг, эсхүл эх нь хорих ял эдэлж байгаа хүний 14 насанд хүрээгүй хүүхэд;

54.1.5.шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон хүн.

54.2.Харгалзан дэмжлэгт дараах хүнийг хамруулна:

54.2.1.бүтэн өнчин 14, түүнээс дээш насны хүүхэд;

54.2.2.эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүний 14, түүнээс дээш насны хүүхэд;

54.2.3.эцэг, эх нь хоёулаа, эсхүл тухайн хүүхдийн байнга хамт амьдардаг эцэг, эсхүл эх нь хүнд өвчтэй, бусдын асрамжид байдаг зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар биечлэн асран хүмүүжүүлэх боломжгүй байгаа хүний 14, түүнээс дээш насны хүүхэд;

54.2.4.эцэг, эх нь хоёулаа, эсхүл тухайн хүүхдийн байнга хамт амьдардаг эцэг, эсхүл эх нь хорих ял эдэлж байгаа хүний 14, түүнээс дээш насны хүүхэд;

54.2.5.ганц бие, төрлийн хүнгүй, бие даан амьдрах чадваргүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, эсхүл ахмад настан;

54.2.6.гэр бүлийн гишүүд бие биеэ асран хамгаалах боломжгүй, төрлийн хүнгүй, бие даан амьдрах чадваргүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, эсхүл ахмад настан.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 37

Бүгд: 92

59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 56 дугаар зүйлийг 55 дугаар зүйл болгож, 56.1 дэх хэсгийн “55.2, 55.3-т” гэснийг “54.1, 54.2-т” гэж, “баг, дүүрэг, хорооны” гэснийг “дүүргийн” гэж, 56.2 дахь хэсгийн “баг, дүүрэг, хорооны засаг захиргааны байгууллагад” гэснийг “дүүргийн Засаг дарга, орон нутгийн захиргааны байгууллагад” гэж тус тус өөрчилж, 56.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 55.3 дахь хэсэг болгох:

“55.3.Энэ хуулийн 55.2-т заасан хүний талаар мэдээлэл хүлээн авсан сум, дүүргийн Засаг дарга сум, хорооны хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн тухайн хүнийг асран хамгаалалт, харгалзан дэмжлэггүй болсон эсэхийг тогтоож, асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт хамруулах арга хэмжээ авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 35

Бүгд: 92

62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 57 дугаар зүйлийг 56 дугаар зүйл болгож, гарчгийн “дэмжлэгийн хэлбэр, түүнийг” гэснийг “дэмжигчийг” гэж, 57.4 дэх хэсгийн “баг, дүүрэг, хорооны” гэснийг “дүүргийн” гэж, “56.3-т” гэснийг “55.3-т” гэж, 57.4.1 дэх заалтын “хамгаалах” гэснийг “хамгаалж” гэж, 57.4.2 дахь заалтын “61 дүгээр” гэснийг “60 дугаар” гэж, “асран хүмүүжүүлэх” гэснийг “асруулахаар шилжүүлэх” гэж, 57.5 дахь хэсгийн “57.3, 57.4-т” гэснийг “55.2, 55.3-т” гэж, 57.6 дахь хэсгийн “баг, дүүрэг, хорооны” гэснийг “дүүргийн” гэж, 57.6.5 дахь заалтын “ажиллагаанаас” гэснийг “ажиллагааны улмаас” гэж, “эд хөрөнгөд” гэснийг “хөрөнгөд” гэж, 57.6.7 дахь заалтын “эд хөрөнгө” гэснийг “хөрөнгө” гэж тус тус өөрчилж, 57.1 дэх хэсэг, 57.4 дэх хэсгийн “зохих хэлбэрийн” гэснийг тус тус хасаж, 57.2, 57.3 дахь хэсэг, 57.4.3, 57.6.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 56.1, 56.2 дахь хэсэг, 56.3.3, 56.5.6 дахь заалт болгох:

“56.1.Сум, дүүргийн Засаг дарга асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох ажиллагааг шүүхийн шийдвэр болон сонирхогч талын хүсэлтэд үндэслэн,

эсхүл 54.1, 54.2-т заасан хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл өөрийн санаачилгаар явуулна.

56.2.Энэ хуулийн 54.1, 54.2-т заасан хүний талаарх нөхцөл байдлын үнэлгээг сум, хорооны хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан хийж, сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ.

56.3.3.асран хамгаалж, харгалзан дэмжвэл зохих хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад, хүнийг төрөлжсөн асрамжийн газарт шилжүүлэх.

56.5.6.хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад шилжүүлсэн хүүхэд болон төрөлжсөн асрамжийн газарт шилжүүлсэн хүнээс бусад асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн хөрөнгийг эрхлэн хамгаалагчийг тогтоож, гэрээ байгуулан биелэлтэд хяналт тавих;" гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 32

Бүгд: 92

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 58 дугаар зүйлийг 57 дугаар зүйл болгож, 58.1.3, 58.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 57.1.3, 57.1.4, 57.1.6 дахь заалт болгох:

“57.1.3.сүрьеэ, эсхүл хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдол, эсхүл сэтгэцийн өвчтэй;

57.1.4.согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хамааралтай;

57.1.5.хорих ял эдэлж байгаа, эсхүл Эрүүгийн хуульд заасан хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг санаатай хүнд гэмт хэрэг, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 33

Бүгд: 92

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 59 дүгээр зүйлийг 58 дугаар зүйл болгож, 59.1.1 дэх заалтын “гэр бүлд” гэснийг “гэр бүлтэй” гэж, 59.1.4 дэх заалтын “эд хөрөнгийн” гэснийг “хөрөнгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 32

Бүгд: 92

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 60 дугаар зүйлийг 59 дүгээр зүйл болгож, 60.1.1 дэх заалтын “сурч” гэсний өмнө “хөгжүүлэх,” гэж нэмж, 60.1.3 дахь заалтын “үл хөдлөх эд хөрөнгө, мал, банкинд хадгалуулсан мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг” гэснийг “хөрөнгийг” гэж, “тухайн сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг “харьяа сум, дүүргийн” гэж, 60.1.4 дэх заалтын “тухайн сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг “харьяа сум, дүүргийн” гэж, 60.2.3 дахь заалтын “асрамж,” гэснийг “асран хамгаалалт, харгалзан” гэж, 60.2.4 дэх заалтын “эд хөрөнгийг” гэснийг “хөрөнгийг” гэж, “баг, дүүрэг, хорооны” гэснийг “дүүргийн” гэж, 60.3 дахь хэсгийн “бага насны” гэснийг “долоон насанд хүрээгүй” гэж тус тус өөрчилж, 60.2.4 дэх заалтын “, дэнчин тавих” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 31

Бүгд: 92

66.3 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 61 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 60 дугаар зүйл болгох:

**“60 дугаар зүйл.Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх
үйл ажиллагаа**

60.1.Энэ хуулийн 54.1, 54.2-т заасан хүүхдийг иргэн гэр бүлдээ авч асран хүмүүжүүлж /цаашид “асралт гэр бүл” гэх/ болно.

60.2.Асралт гэр бүлийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, түүний эрх, үүрэг, үйл ажиллагаанд хяналт тавихад Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 37

Бүгд: 92

59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 62 дугаар зүйлийг 61 дүгээр зүйл болгож, 62.2, 62.3 дахь хэсгийн “хүүхдийн нэр дээрх” гэсний өмнө “тухайн” гэж нэмж, 62.1 дэх хэсгийн “хуульд заасны дагуу мөнгөн” гэснийг “хуулийн 13, 14, 15, 16 дугаар зүйлд заасны дагуу асаргааны” гэж, 62.4 дэх заалтын “62.1, 62.2-т” гэснийг “61.1, 61.2-т” гэж, “гэр бүлийн” гэснийг “хүүхэд, гэр бүлийн хөгжлийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 35

Бүгд: 92

62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 63 дугаар зүйлийг 62 дугаар зүйл болгож, 63.2 дахь хэсгийн “хүүхдийн нэр дээр” гэсний өмнө “тухайн” гэж нэмж, гарчгийн “эд хөрөнгийг” гэснийг “хөрөнгийг” гэж, 63.1 дэх хэсгийн “хууль ёсны”

гэснийг “дээд” гэж, 63.2 дахь хэсгийн “эд хөрөнгө” гэснийг “хөрөнгө” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 32
Бүгд: 92
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 64 дүгээр зүйлийг 63 дугаар зүйл болгож, 64.4 дэх хэсгийн “сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг “харьяа сум, дүүргийн” гэж өөрчилж, 64.2.5 дахь хэсгийн “асран хамгаалуулагч” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 63.2.10 дахь заалт нэмэх.

“63.2.10.хорих ялаар шийтгүүлсэн.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 34
Бүгд: 92
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 65 дугаар зүйлийг 64 дүгээр зүйл болгож, 65.3 дахь хэсэг, 65.2.1 дэх заалтын “хууль ёсны” гэснийг “дээд” гэж, 65.2.2 дахь заалтын “шалтгаангүйгээр” гэснийг “шалтгаантайгаас бусад тохиолдолд” гэж, 65.2.4 дэх заалтын “22-оос доошгүй” гэснийг “21, түүнээс дээш” гэж, 65.4 дэх хэсгийн “65.2.2-т” гэснийг “64.1.2-т” гэж өөрчилж, 65.1, 65.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 36
Бүгд: 92
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

59.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 66 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 65 дугаар зүйл болгох:

“65 дугаар зүйл.Үрчлэгчийн эрх, үүрэг, хориглох зүйл

65.1.Үрчлэгч нь эцэг, эхийн нэгэн адил энэ хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

65.2.Үрчлэгч нь насанд хүрсэн, иргэний эрх зүйн чадамжтай, эрүүл мэндийн болон эдийн засгийн бүрэн чадавхтай хүн байх бөгөөд ашиг олох зорилгоор хүүхэд үрчлэн авахыг хориглоно.

65.3.Хүүхдийг дараах хүнд үрчлүүлэхийг хориглоно:

65.3.1.бусдын асрамж, дэмжлэгт байгаа хүн;
65.3.2.65-аас дээш настай ганц бие хүн;
65.3.3.шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн чадамжгүй, эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тогтоогдсон хүн;

65.3.4.эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, эсхүл хасуулсан хүн;

65.3.5.үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн хүн;

65.3.6.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүн;

65.3.7.эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар эцэг, эх байх эрх, үүргийг биелүүлж чадахгүй болох нь тогтоогдсон хүн;

65.3.8.хорих ял эдэлж байгаа, эсхүл Эрүүгийн хуульд заасан хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан хүн;

65.3.9.бүртгэлтэй хаяг дээрээ амьдардаггүй, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй орчинд амьдардаг хүн.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

60.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 67 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 66 дугаар зүйл болгох:

“66 дугаар зүйл.Хүүхэд үрчлэх журам

66.1.Аймаг, дүүргийн Засаг даргын дэргэд хүүхдийг үрчлүүлэх эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

66.2.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага үрчлэгчийг гэр бүл, эцэг, эх, хүүхдийн харилцааны талаар зохих сургалт, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангана.

66.3.Хүүхэд үрчлүүлэх эцэг, эхийн зөвшөөрлийг хүүхэд төрсний дараа өгнө.

66.4.Сум, хорооны хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан үрчлүүлэх хүүхэд, үрчлэх гэр бүлд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан нөхцөл байдлын үнэлгээг хийж, Зөвлөлд хүргүүлнэ.

66.5.Зөвлөл энэ хуулийн 66.4-т заасан нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн хүүхэд үрчлүүлэх эсэх талаар санал, дүгнэлт гаргана.

66.6.Зөвлөл зайлшгүй шаардлагатай гэж үзвэл үрчлүүлэх хүүхэд, үрчлэгчийн нөхцөл байдлын талаар нэмэлт үнэлгээ хийлгэж, холбогдох байгууллага, албан тушаалтан, мэргэжилтнээс мэдээлэл, тайлбар гаргуулан авч болно.

66.7.Хүүхдийг үрчлэх асуудлыг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл болон Зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

66.8.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийг үрчлүүлэх тухай шүүхийн шийдвэр гарахаас өмнө хүүхдээ үрчлүүлэх зөвшөөрлөө цуцлах эрхтэй.

66.9.Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхдийг эцэг, эх байх эрх хассан шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сарын дараа үрчлүүлж болно.

66.10.Энэ хуулийн 66.9-д заасны дагуу эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхдийг үрчлүүлэх асуудлаар сум, хорооны хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан үрчлүүлэх хүүхэд, үрчлэх гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг хийж, Зөвлөлд хүргүүлэх бөгөөд хүүхдийн хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн зөвшөөрөл болон Зөвлөлийн дүгнэлтэд үндэслэн шүүх шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 37

Бүгд: 92

59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

61.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 68 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 67 дугаар зүйл болгох:

“67 дугаар зүйл.Хүүхэд үрчлэлтийн бүртгэл, хяналт

67.1.Хүүхэд үрчлүүлэх эсэх шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор шийдвэрийн хувийг улсын бүртгэлийн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

67.2.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь үрчлэлтийн мэдээллийн сан /хүүхэд үрчлэх хүсэлтэй иргэн, үрчлүүлэх хүүхдийн болон үрчлэгдсэн хүүхэд, үрчилж авсан иргэний мэдээлэл/ бүрдүүлнэ.

67.3.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага үрчлэгдсэн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд түүнийг 18 насанд хүртэл хяналт тавьж, хүүхдийн хөгжлийн тайланг хагас жил тутамд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

67.4.Энэ хуулийн 67.2-т заасан мэдээллийн сан бүрдүүлэх, 67.3-т заасан үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

67.5.Үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзвэл Сонирхогч тал үрчлэлтийг хүчингүйд тооцуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргах эрхтэй.

67.6.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсөн нөхцөл байдал бий болсныг тогтоовол хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны

байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

62.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 69 дүгээр зүйлийг 68 дугаар зүйл болгож, 69.4 дэх хэсгийн “үрчлэн” гэсний өмнө “хүүхдийг” гэж, “Хүүхдийг” гэснийг “Хүүхдээ” гэж өөрчилж, 69.6, 69.7 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 34

Бүгд: 92

63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

63.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 71 дүгээр зүйлийг 70 дугаар зүйл болгож, 71.2.6 дахь заалтын “эрхэлсэн” гэсний дараа “үйлдэл хийсэн нь тогтоогдсон” гэж нэмж, 71.1 дэх хэсгийн “хууль ёсны” гэснийг “дээд” гэж, 71.2.5 дахь заалтын “66.3-т” гэснийг “65.3-т” гэж, 71.2.6 дахь заалтын “65.7-д” гэснийг “64.4-т” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 38

Бүгд: 92

58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

64.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 72 дугаар зүйлийг 71 дүгээр зүйл болгож, 72.1 дэх хэсгийн “хүчингүйд” гэснийг “хүчингүй болсонд” гэж, 72.2, 72.3 дахь хэсгийн “хууль ёсны” гэснийг “дээд” гэж өөрчилж, 72.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 38

Бүгд: 92

58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 75 дугаар зүйлийг 74 дүгээр зүйл болгож, 75.1 дэх хэсгийн “хуулийн” гэснийг “хуульд” гэж, “хүчинтэйд” гэснийг “гэрлэлтийг хүчин төгөлдөр гэж үзэж, хүлээн зөвшөөрнө.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 37

Бүгд: 92

59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

66.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 76 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 75 дугаар зүйл болгох:

“75.1.Гадаад улсад бүртгэгдсэн гэрлэлт нь Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ хуульд нийцээгүй бол Монгол Улсад гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж үзэж, хүлээн зөвшөөрөхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 40

Бүгд: 92

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

67.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 77 дугаар зүйлийг 76 дугаар зүйл болгож, 77.4 дэх хэсгийн “хүчинтэйд тооцогдоно” гэснийг “гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр гэж тооцно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 40

Бүгд: 92

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

68.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 81 дүгээр зүйлийг 80 дугаар зүйл болгож, 81.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 80.4 дэх хэсэг болгох:

“80.4.Гадаад улсын хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын иргэн хүүхдийн эцэг, эхийг тогтоосон нь энэ хуульд харшлахгүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр гэж тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 38

Бүгд: 92

58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

69.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 82 дүгээр зүйлийг 81 дүгээр зүйл болгож, 82.2 дахь хэсгийн “тогтоосон нь энэ хуульд харшлаагүй бол хүчинтэйд” гэснийг “Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хуульд харшлаагүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр гэж тооцно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 35

Бүгд: 92

62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

70.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 83 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 82 дугаар зүйл болгох:

“82.1.Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэхэд Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

82.2.Монгол Улсын харьяат хүүхдийг Монгол Улсын иргэн үрчлэн авах хүсэлт гаргаагүй бол хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцүүлэн хүүхэд үрчлэн авахаар хүсэлт гаргасан гадаадын иргэн, гэр бүлд үрчлүүлнэ.

82.3.Монгол Улсын харьяат хүүхдийг Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад улсын иргэнд үрчлүүлэхэд энэ хуулийн 64, 65, 66 дугаар зүйлд заасныг баримтална.

82.4.Энэ хуулийн 65.3-т зааснаас гадна Монгол Улсаас албадан гаргасан, Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй байхаар тогтоосон хугацаа нь дуусаагүй байгаа гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно.

82.5.Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэхдээ гадаад улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй итгэмжлэгдсэн байгууллагыг сонгож, хамтран ажиллана.

82.6.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх талаар санал гаргах үүрэг бүхий гадаад үрчлэлтийн орон тооны бус зөвлөл ажиллана.

82.7.Гадаад үрчлэлтийн орон тооны бус зөвлөлийн саналыг үндэслэн хүүхэд үрчлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэх бөгөөд үрчлэгдсэн эсэх тухай шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш ажлын таван өдрийн дотор улсын бүртгэлийн болон гадаадын иргэний асуудал хариуцсан байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

82.8.Гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх тухай шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор үрчлэгчид мэдэгдэж, шийдвэрийн хувийг хүргүүлнэ.

82.9.Энэ хуулийн 82.6-д заасан гадаад үрчлэлтийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам болон Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн, хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

82.10.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх асуудлыг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ. Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг тухайн улсын хуулийн дагуу үрчлүүлсэн нь Монгол Улсын олон улсын гэрээ, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд харшлаагүй бол хүлээн зөвшөөрч болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

71.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 84 дүгээр зүйлийг 83 дугаар зүйл болгож, 84.5 дахь хэсгийн “хууль ёсны” гэснийг “дээд” гэж өөрчилж, 84.3, 84.4, 84.7, 84.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“83.3.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат үрчлэгдсэн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд 18 насанд хүртэл Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Дипломат

төлөөлөгчийн газар, гадаадын иргэний болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавьж, тайланг хагас жил тутамд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

83.4.Энэ хуулийн 83.3-т зааснаас бусад Монгол Улсын харьяат үрчлэгдсэн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хангагдаж байгаа эсэхэд 18 насанд хүртэл энэ хуулийн 67.3-т заасны дагуу аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага хяналт тавьж, хүүхдийн хөгжлийн тайланг хагас жил тутамд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

83.7.Гадаад улсад оршин суугаагаас бусад Монгол Улсын харьяат үрчлэгдсэн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн нөхцөл байдал тогтоогдвол даруй аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан болон эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

83.8.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдсөн байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдсон бол Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

72.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 86 дугаар зүйлийг 85 дугаар зүйл болгож, 86.2 дахь хэсгийн “5.4-т заасан зохицуулалтыг” гэснийг “6 дугаар зүйлд заасныг” гэж өөрчилж, 86.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“85.3.Энэ хуулийн 6.2, 9.3, 61.4, 66.1, 67.4, 82.9, 83.5-д заасан журам, энэ хуулийн 46.2-т заасан тэтгэлэг тогтоох аргачлалыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний дотор тус тус батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 45

Бүгд: 92

51.1 хувийн саналаар дэмжигдлээ.

73.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 87 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 86 дугаар зүйл болгох:

“86.1.Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 37

Бүгд: 92

59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

74.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн талаар:

Ж.Бат-Эрдэнэ: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 8¹ дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8¹.1.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.3.Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцалсан бол гэрлэлт цуцалсан тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Гэрлэлт сэргээсний бүртгэл

9.1.Гэр бүлийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу иргэн гэрлэлт сэргээсний бүртгэлд бүртгүүлэх бол дараах баримт бичгийг бүрдүүлж, өөрийн биеэр бүртгүүлнэ:

9.1.1.тус тусдаа гаргасан өргөдөл;

9.1.2.иргэний үнэмлэх, эсхүл иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, эсхүл паспортыг орлох баримт бичиг.

9.2.Гэр бүлийн тухай хуулийн 18.2-т заасны дагуу гэрлэлтийг сэргээсэн бол гэрлэлт сэргээсэн тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.

9.3.Иргэнийг нас барсан гэж зарласан, сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэрийг хүчингүй болсонд тооцох тухай шүүхийн шийдвэрийг энэ хуулийн 9.1-д заасан баримт бичигт хавсаргана.

9.4.Гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус тооцсон тухай шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүх иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд “Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн” гэсний дараа “7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “8 дугаар зүйлд” гэснийг “5.3-т” гэж, мөн зүйлийн 7.8 дахь заалтын “9 дүгээр” гэснийг “7 дугаар” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн ““нас барсны бүртгэлд” гэснийг “Гэр бүлийн тухай хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.4-т заасан тохиолдол бий болсон” гэж” гэснийг ““Гэрлэгч нас барсны бүртгэлд бүртгэгдсэн” гэснийг “Гэрлэгч нас барсны, эсхүл хүйс өөрчлөгдсөн бүртгэлд, эсхүл нас барсан гэж зарласан, эсхүл сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

3.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ж.Бат-Эрдэнэ: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 127 дугаар зүйлийн 127.4, 127.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 127 дугаар зүйлийн 127.7 дахь хэсгийг 127.5 дахь хэсэг болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 129 дүгээр зүйлийн 129.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“129.3.Гэрлэлт дуусгавар болсонтой холбоотойгоор гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийг тодорхойлохдоо хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал болон хуульд заасан бусад нөхцөлийг харгалзан шүүх өөрөөр тогтоож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 133 дугаар зүйлийн 133.2 дахь хэсгийн “энэ хууль болон” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 517 дугаар зүйлийн 517.1 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “”127.6”” гэснийг “”127.4”” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

4.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ж.Бат-Эрдэнэ: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт,” гэснийг “заалтын” гэж өөрчилж, “мөн зүйлийн 7, 9 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

5.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ж.Бат-Эрдэнэ: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн буюу Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн “торгох” гэснийг “торгох, эсхүл албадан сургалтад хамруулж, долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэснийг “торгоно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

6.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ж.Бат-Эрдэнэ: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “55.2.1-55.2.6, 55.3.1-55.3.6-д” гэснийг “54.1, 54.2-т” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

7.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ж.Бат-Эрдэнэ: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.7.“бүтэн өнчин хүүхэд” гэж Гэр бүлийн тухай хуулийн 4.1.2-т заасныг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга Д.Цолмон, мөн газрын ахлах референт Б.Төрбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Монгол Улсын Ерөнхий сайдын Засаглал, цахим бодлого хариуцсан зөвлөх С.Тэнгис, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболд, “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Мэргэжлийн нэгдсэн зөвлөлийн зохицуулагч Б.Гэрлээ, мөн компанийн Ерөнхий аудитор О.Баярмагнай, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор Г.Давааням, С.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нарангэрэл, референт М.Мандхай нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, Ц.Баатархүү, Б.Уянга, Да.Цогтбаатар, П.Батчимэг, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын Д.Үүрийнтуяа, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга Д.Цолмон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор Г.Давааням, С.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 13 цаг 33 минутаас 17 цаг 44 минутад хуралдааныг даргалав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:40/

Ес.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн 2026.06.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Н.Ариунболд, Б.Солонго нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:54/

Арав.Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2026.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, М.Ганхүлэг, О.Алтангэрэл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ санал хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:17/

Арван нэг.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг, мөн газрын ахлах шинжээч Ц.Мөнхбат, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч А.Нарангаравуу, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын газрын дарга Л.Чой-Иш, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Э.Баттулга, Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, судлаач Д.Дагвадорж, Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн шинжлэх ухааны зөвлөх З.Батжаргал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад нүүрстөрөгчийн зах зээлийн бэлэн байдлыг бэхжүүлэх нь” төслийн хуулийн зөвлөх Б.Номун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:36/

Арван хоёр.Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 18 гишүүн 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга Т.Балжинням, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн зөвлөх Я.Хишигт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Ц.Баатархүү, М.Ганхүлэг, Б.Хэрлэн нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн зөвлөх Я.Хишигт нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:25/

Арван гурав.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын

тогтоолын төсөл /Засгийн газар 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ж.Алдаржавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, Р.Ринчинбазар, А.Энхбат, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Шүүхийн сахилгын хорооны дарга С.Энхтөр, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваа-Очир, мөн хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Батцэцэг, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Чулуунбат, Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, мөн газрын Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга Х.Баярмаа, Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, мөн газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа, Гүйцэтгэлийн аудитын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Цэвэгдорж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Отгонцэцэг, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нямдагва, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батбямба, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Отгонбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чулуунчимэг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, мөн яамны Санхүү,

хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Уянга, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Ариунсанаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрчим хүний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Л.Мөнхцэцэг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Санхүүгийн хэлтсийн дарга Х.Отгонжаргал, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Х.Батжаргал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах, Батлан хамгаалах яамны Стратеги төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мөнх-Оргил, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Баянзул, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сумъяа, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, Гаалийн ерөнхий газрын дарга П.Дэлгэрнаран, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Санхүүгийн бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Амартүвшин, Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хорооны ажлын албаны дарга Н.Ганбаатар, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, Хүний эрхийн Үндэсний Комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Бадамсэрээжид, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Алтанцэцэг, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Дэд дарга Г.Эрдэнэбат, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Ж.Сайнхишиг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Эрдэнэсамбуу, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, А.Төрмөнх нар байлцав.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх илтгэлийг Сангийн сайд З.Мэндсайхан, Төрийн аудитын дээд байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан нар тус тус танилцуулав.

Тайлангийн илтгэл болон дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Г.Очирбат, Г.Лувсанжамц, Ө.Шижир, Б.Мөнхсоёл,

Д.Энхтүвшин, О.Саранчулуун, С.Эрдэнэбат, П.Сайнзориг, О.Цогтгэрэл, П.Наранбаяр, Г.Хосбаяр, У.Отгонбаяр, Да.Цогтбаатар, Г.Ганбаатар, О.Батнайрамдал, Д.Ганмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Сангийн сайд З.Мэндсайхан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд Т.Аубакир, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ц.Идэрбат, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Авлигатай тэмцэх газрын дарга Г.Азжаргал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн А.Энхбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Төрийн сангийн газрын дарга О.Хуягцогт, Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Цахим, хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Батцэцэг, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Н.Цэвэлмаа, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Батбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 17 цаг 44 минутаас 19 цаг 09 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 19 цаг 09 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл хоёр дахь хэлэлцүүлэгт бүлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Нэгдсэн хуралдаан 19 цаг 36 минутаас 20 цаг 11 минутад завсарлав.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, мөн газрын Дэд дарга Д.Цолмон, ахлах референт Б.Төрбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболд, Монгол Улсын Ерөнхий сайдын Засаглал, цахим бодлого хариуцсан зөвлөх С.Тэнгис, “Эрдэнэс Монгол”

хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Мэргэжлийн нэгдсэн зөвлөлийн зохицуулагч Б.Гэрлээ, мөн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Ерөнхий аудитор О.Баярмагнай, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, доктор Г.Давааням, С.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нарангэрэл, референт М.Мандхай нар байлцав.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, П.Сайнзориг, О.Номинчимэг, Ж.Алдаржавхлан, О.Алтангэрэл, Ч.Анар, Р.Батболд, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Ж.Галбадрах, А.Ганбаатар, Г.Ганбаатар, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Б.Жаргалан, Б.Заяабал, С.Зулпхар, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, З.Мэндсайхан, Н.Наранбаатар, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа, Ц.Сандаг-Очир, Б.Уянгахишиг, Б.Хэрлэн, Л.Энхнасан, Д.Энхтүвшин, С.Эрдэнэболд /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн нэрийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг хасаж, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хяналт, ил тод байдал, засаглалыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхтэй” гэснийг “хяналтыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангахтай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 2.1 дэх хэсгийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн “хуулийн дагуу байгуулагдсан” гэснийг “хуулиар зохицуулагдах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 37

Бүгд: 94

60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 1 дүгээр санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалтын “хяналт” гэснийг “хяналтын эрхийг” гэж өөрчилж, доор дурдсан агуулгатай 4.1.6 дахь заалт нэмэх:

“4.1.6.“хяналтын эрхийг хэрэгжүүлэх” гэж төр, орон нутаг, эсхүл тэдгээрийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдээр дамжуулан тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхыг томилох, эсхүл компанийн стратеги, санхүүгийн бодлого, үндсэн үйл ажиллагаанд заавал биелэгдэх шийдвэр гаргах эрхийг хууль, гэрээ, дүрмийн үндсэн дээр хэрэгжүүлэхийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 37

Бүгд: 94

60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалтын “энэ” гэснийг, 4.1.4 дэх заалтыг тус тус хасаж, 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.5.“нийтийн үйлчилгээ” гэж иргэдийн ая тухтай амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор дэд бүтэц, эрчим хүч, зам, тээвэр, эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт болон холбогдох бусад салбарт төрөөс иргэдэд тэгш, чанартай, үр ашигтай, хууль тогтоомж, стандартын дагуу үзүүлж байгаа олон нийтэд зориулсан үйлчилгээг,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 39

Бүгд: 94

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах Тайлбар хэсэг нэмэх:

“Тайлбар: -Энэ хуульд заасан “үр ашигтай байх” гэж арилжааны чиглэлийн төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд санхүүгийн капитал хөрөнгийн жигнэсэн дундаж өртгийн тодорхой хувиас доошгүй хэмжээний цэвэр ашигтай ажиллаж, эдийн засгийн өгөөж бий болгон компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийг ойлгоно. Харин нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд нийтийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, хамгийн боломжит бага зардлаар үзүүлэхийг ойлгоно.”

“Тайлбар: -Энэ хуульд заасан “зах зээлд шударга өрсөлдөх, аливаа хэлбэрээр давуу эрх эдлэхгүй байх” гэж хуульд зааснаас бусад тохиолдолд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, төрийн баталгаа, хөнгөлөлттэй зээл, санхүүжилт авах, газар, үл хөдлөх эд хөрөнгө, дэд бүтцийг зах зээлийн үнээс доогуур нөхцөлөөр ашиглах, зөвшөөрөл, эрх олгох ажиллагаанд давуу нөхцөл эдлэх, төрийн болон орон нутгийн худалдан авах ажиллагаанд давуу эрх эдлэх, дампуурал, төлбөрийн чадваргүйдлийн нийтлэг журмаас үндэслэлгүйгээр чөлөөлөгдөхгүй байхыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтын “мэргэжлийн” гэснийг “мэргэшсэн” гэж, 5.2.5 дахь заалтын “үр ашиггүй” гэснийг “үргүй” гэж өөрчилж, 5.2.8 дахь заалтын “тайлагнах” гэсний өмнө “бүрэн” гэж нэмж, 5.2.1, 5.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.1.компанийн удирдлагын эрх төрийн болон орон нутгийн эрх хэмжээнээс тусгаарлагдсан байх;”

“5.2.2.хувьцааны төрөл, тоонд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	52
Татгалзсан:	41
Бүгд:	93

55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийг үйл ажиллагааны зорилго, чиг үүргээс нь хамааруулан арилжааны, эсхүл нийтийн үйлчилгээний гэж ангилах бөгөөд энэ талаар тухайн компанийн дүрэмд тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн гарчгийн “үндсэн чиглэл” гэснийг “өмчлөлийн бодлого” гэж, 7.1 дэх хэсгийн “үндсэн чиглэлийг” гэснийг “өмчлөлийн бодлогыг” гэж, 7.2 дахь хэсгийн “энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн төслийг” гэснийг “төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг” гэж, 7.3, 7.4 дэх хэсгийн “Үндсэн чиглэлд” гэснийг “Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогод” гэж, 7.3.4 дэх заалтын “үндсэн чиглэлийн” гэснийг “төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогын” гэж, 7.3.1 дэх заалтын “хувьцаа эзэмших, хянах зорилго,” гэснийг “хувьцаа эзэмших зорилго, хяналтын эрхийг хэрэгжүүлэх” гэж, 7.3.6 дахь заалтын “биржээр олон нийтэд нээлттэй худалдах” гэснийг “худалдах, түүнийг хэрэгжүүлэх арга,” гэж тус тус өөрчилж, 7.3.5 дахь заалтын “бүтцийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	53
Татгалзсан:	40
Бүгд:	93

57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7.7 дахь хэсгийн “хуудсанд” гэсний дараа “06 дугаар сарын 30-ны өдрийн дотор” гэж нэмж, 7.5, 7.6 дахь хэсгийг доор

дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“7.5.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогын хэрэгжилтэд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг тухайн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газарт, Засгийн газар тайланг тухайн жилийн намрын чуулганы хугацаанд холбогдох Байнгын хороонд танилцуулна.

7.6.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогын хэрэгжилтийн тайланг Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаа дуусахаас хоёроос доошгүй сарын өмнө Улсын Их Хуралд танилцуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 9, 10 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн “үндсэн чиглэл” гэснийг “Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлого” гэж агуулгад нь тохируулан тухай бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“8.1.Төрийн өмчит компанийг дараах үндэслэлээр үүсгэн байгуулна:

8.1.1.Нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэх;

8.1.2.Үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор төрийн нийтийн өмчид хамаарах байгалийн баялгийг ашиглах;

8.1.3.Зүй ёсны монополь үйл ажиллагаа эрхлэх;

8.1.4.Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой батлан хамгаалах, хил хамгаалах, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг дэмжих, холбогдох аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;

8.1.5.Харилцаа холбоо, банк, санхүүгийн салбарт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг хасаж, 8.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 2 дахь өгүүлбэр нэмэх:

“Энэ хуулийн 8.1.2-т заасан үндэслэлээр орон нутгийн өмчит компанийг Улсын Их Хурлын зөвшөөрлөөр үүсгэн байгуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 46

Бүгд: 93

50.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн “мэдээлэлд” гэсний өмнө “судалгаа,” гэж, 9.4.1 дэх заалтад “шаардлага” гэсний дараа “буюу хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх гэсэн бодлоготой нийцэж байгаа эсэх” гэж тус тус нэмж, 9.4.5 дахь заалтын “хугацаа” гэснийг “хугацаатай байх эсэх” гэж, 9.5, 9.6 дахь хэсгийн “хувьцаа эзэмшигч” гэснийг “этгээд” гэж, 9.7 дахь хэсгийн “байгуулах” гэснийг “байгуулж болох” гэж, “заасны дагуу” гэснийг “заасан этгээд” гэж өөрчилж, доор дурдсан агуулгатай 9.8 дахь хэсэг нэмэх:

“9.8.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах эсэх асуудлыг тухайн хугацаа дуусах оны өмнөх санхүүгийн жилд багтаан шийдвэрлэх бөгөөд үйл ажиллагаа явуулах хугацааг сунгахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаатай холбоотой асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 43

Бүгд: 93

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.4 дэх хэсгийн “орон нутгийн” гэсний дараа “өмч давамгайлсан компани, төрийн болон орон нутгийн өмчийн” гэж нэмэх:

“10.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна компанийн үйл ажиллагааны зорилго, хүрэх үр дүн, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, ногдол ашгийн бодлого, эсхүл нийтийн үйлчилгээний үүргийн бодлогыг тодорхой тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 37

Бүгд: 93

60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.6 дахь хэсэг нэмэх:

“10.6.Алтан хувьцаа гаргах тохиолдолд компанийн дүрэмд алтан хувьцаа эзэмших этгээд, эрхийн агуулга, хугацааг тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
 Татгалзсан: 38
 Бүгд: 93
 59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.2, 11.3 дахь хэсэг нэмэх:

“11.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компани бусад этгээдтэй хамтран охин, хараат компани үүсгэн байгуулах асуудлыг энэ хуулийн 8.1-д заасан үндэслэлийн дагуу энэ хуулийн 9.4-т заасан судалгаа, шинжилгээ болон Засгийн газрын зөвшөөрлийн дагуу Компанийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

11.3.Энэ хуулийн 11.1, 11.2-т заасны дагуу үүсгэн байгуулсан охин, хараат компани дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг толгой компани эзэмшинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
 Татгалзсан: 36
 Бүгд: 93
 61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “худалдах” гэснийг “шилжүүлэх” гэж, 13.2 дахь хэсэг, 13.4 дэх хэсгийн “гүйцэтгэх захирлын” гэснийг “гүйцэтгэх удирдлагын” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, доор дурдсан агуулгатай 13.2.6, 13.2.7 дахь заалт тус тус нэмэх:

“13.2.2.алтан хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласан, хугацааг багасгасан өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулах;”

“13.2.6.компанийн хувьцааны хяналтын багцтай хэмжээгээрээ дүйцэхүйц хувьцаа болон хувьцаанд хамаарах бусад үнэт цаасыг нэг болон хэд хэдэн удаагийн дараалсан шийдвэрээр нэмж гаргах;

13.2.7.талууд харилцан тохиролцож, компанийн дүрэмд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
 Татгалзсан: 38
 Бүгд: 93
 59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 18 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн “гүйцэтгэх захирал” гэснийг “гүйцэтгэх удирдлага” гэж агуулгад нь тохируулан тухай бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
 Татгалзсан: 38
 Бүгд: 93
 59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “үндэслэлээ” гэснийг “үндэслэл, хоригийн хамрах хүрээг” гэж, 13.8 дахь хэсгийн “заасан” гэснийг “заасны дагуу компанийн дүрэмд тусгасан” гэж өөрчилж, “дахин” гэснийг, 13.6 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.9 дэх хэсэг нэмэх:

“13.9.Засгийн газар хориг тавих шийдвэр гаргахдаа зорилгодоо нийцсэн байх, компанийн үйл ажиллагаанд хамгийн бага хязгаарлалт тогтоох зарчмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 37

Бүгд: 93

60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “заасан журмын дагуу” гэснийг “өөрөөр заагаагүй бол” гэж, 14.7 дахь хэсгийн “34-өөс доош” гэснийг “34 хүртэлх” гэж өөрчилж, 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Энэ хуулийн 14.2-т заасны дагуу компанийн энгийн хувьцааны гуравны нэгээс доош хувийг олж авсан бол төр, эсхүл орон нутаг тухайн хувьцааны зах зээлийн үнэ болон бодит үнэ цэнийг тооцон, аль өндөр үнээр тухайн хувьцааг худалдана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 38

Бүгд: 93

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 15.1 дэх хэсгийн “үнэт цаас” гэснийг “өрийн хэрэгсэл” гэж, мөн зүйлийн 15.4 дэх хэсгийн “зөвлөлд” гэсний дараа “/байхгүй бол хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид/” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 15.5, 15.6, 15.7 дахь хэсэг нэмэх:

“15.5.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани зээл авах, өрийн хэрэгсэл гаргах, баталгаа гаргуулах, санхүүгийн түрээс болон түүнтэй адилтгах үүрэг хүлээхдээ өрийн тогтвортой байдлын дүгнэлтийг хараат бус, мэргэжлийн этгээдээр гаргуулсан байна.

15.6.Энэ хуулийн 15.5-д заасан дүгнэлтэд өрийн нийт хэмжээ, өр ба өөрийн хөрөнгийн харьцаа, мөнгөн урсгал, валютын эрсдэл, хүүгийн эрсдэл, төсвийн болзошгүй өр төлбөр, төрийн баталгааны нөлөөллийг тусгана.

15.7.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани бусад этгээдэд өрийн баталгаа гаргахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 37
 Бүгд: 93
 60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“16 дугаар зүйл.Ногдол ашгийн бодлого

16.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд зааснаас гадна дараах зарчим, шаардлагыг баримтална:

16.1.1.ногдол ашгийг өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайланд туссан татвар төлсний дараах хуваарилж болох цэвэр ашгаас тооцох;

16.1.2.компанийн төлбөрийн чадвар, мөнгөн урсгал, батлагдсан бизнес болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, их засварын хэрэгцээ, нөөц сан бүрдүүлэх шаардлага, санхүүгийн тогтвортой байдлыг харгалзан үзэх;

16.1.3.нийтийн үйлчилгээний үүрэг хүлээсэн бол тухайн үүргийн санхүүжилт, нөхөн төлбөр, татаас, тарифын зохицуулалтыг ногдол ашиг тооцох сууринаас тусад нь авч үзэх;

16.1.4.компанийн урт хугацааны үнэ цэн, хэвийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын чадавхыг дордуулахгүй байх.

16.2.Арилжааны зорилготой төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани нь тухайн санхүүгийн жилд хуваарилж болох цэвэр ашигтай ажилласан бол ногдол ашиг хуваарилах үүрэгтэй.

16.3.Энэ хуулийн 16.2-т заасан компанийн тухайн жилд хуваарилах ногдол ашгийн зорилтот хувь хэмжээг Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн төсвийн төсөл боловсруулах үе шатанд компанийн ангилал, салбарын онцлог, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, өр төлбөрийн түвшин, мөнгөн урсгал, өөрийн хөрөнгийн өгөөж, нөөц сангийн шаардлагыг харгалзан тогтооно.

16.4.Энэ хуулийн 16.3-т заасан зорилтот хувь хэмжээ нь арилжааны зорилготой компанийн хувьд хуваарилж болох цэвэр ашгийн 30 хувиас доошгүй байх зарчмыг баримтална. Харин компанийн санхүүгийн байдал, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, эсхүл энэ хуулийн 16.6-д заасан үндэслэл байгаа бол уг хувь хэмжээг бууруулж болно.

16.5.Нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчит компанид энэ хуулийн 16.4-т заасан доод хувь хэмжээ хамаарахгүй. Компани нь цэвэр ашигтай ажилласан тохиолдолд төлбөрийн чадвар, мөнгөн урсгал, нийтийн үйлчилгээний үүргийн санхүүжилт, үйлчилгээний хүртээмж, чанар, тасралтгүй байдлыг харгалзан ногдол ашиг хуваарилж болно.

16.6. Дараах үндэслэл байгаа бол энэ хуулийн 16.3, 16.4-т заасан зорилтот буюу доод хувь хэмжээнээс бага хэмжээгээр ногдол ашиг хуваарилж болно:

16.6.1.ногдол ашиг хуваарилснаар Компанийн тухай хуульд заасан төлбөрийн чадварын шаардлага хангагдахгүй болох;

16.6.2.компанийн мөнгөн урсгал, өр төлбөрийн үйлчилгээ, зээлийн гэрээний үүрэг, өрийн тогтвортой байдлын шалгуурт шууд эрсдэл үүсэх;

16.6.3.батлагдсан бизнес, хөрөнгө оруулалт, их засвар, техник технологийн шинэчлэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд цэвэр ашгийг дахин хөрөнгө оруулалтад ашиглах зайлшгүй шаардлага үүссэн;

16.6.4.энэ хуульд заасан нөөц сан, эсхүл тусгай зориулалтын нөөц бүрдүүлэх шаардлагатай;

16.6.5.нийтийн үйлчилгээний буюу арилжааны бус тусгай үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, эх үүсвэрийг хадгалах шаардлагатай;

16.6.6.тухайн компанид хуримтлагдсан алдагдал байгаа бөгөөд уг алдагдлыг нөхөх шаардлагатай;

16.6.7.онцгой нөхцөл байдал, давагдашгүй хүчин зүйл, зах зээлийн огцом өөрчлөлт, салбарын системийн эрсдэлийн улмаас компанийн санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үүсэхээр байгаа.

16.7.Энэ хуулийн 16.6-д заасан үндэслэлээр ногдол ашгийг зорилтот хувь хэмжээнээс бага тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Саналд дараах баримт бичгийг хавсаргана:

16.7.1.аудитлагдсан санхүүгийн тайлан;

16.7.2.төлбөрийн чадварын болон мөнгөн урсгалын дүгнэлт;

16.7.3.дараагийн гурваас доошгүй жилийн стратеги төлөвлөгөө;

16.7.4.хөрөнгө оруулалт, их засварын тооцоолол;

16.7.5.нийтийн үйлчилгээний үүрэг хүлээсэн бол уг үүргийн өртөг, санхүүжилт, нөхөн төлбөрийн тооцоо;

16.7.6.ногдол ашиг бууруулах үндэслэл, эрсдэлийн үнэлгээ.

16.8.Энэ хуулийн 16.7-д заасан саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хянаж, зөвшөөрөх, өөрчлөх, эсхүл татгалзах тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.

16.9.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд төр, орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь энэ зүйлд заасан ногдол ашгийн бодлого, зорилтот хувь хэмжээ, санхүүгийн тогтвортой байдлын шалгуурыг баримтлан хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлд санал өгөх чиглэл баримтална.

16.10.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн ногдол ашгийн бодлогын хэрэгжилт, хуваарилсан болон

хуваарилаагүй ашгийн хэмжээ, бууруулсан үндэслэл, дахин хөрөнгө оруулалтад ашигласан хөрөнгийн үр дүнгийн талаарх нэгдсэн тайланг жил бүр Засгийн газарт танилцуулж, олон нийтэд мэдээлнэ.” гэсэн **саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтын “компанийн” гэсний дараа “газар,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтын “санал гаргах” гэснийг “саналын эрхийг хэрэгжүүлэх” гэж өөрчилж, 20.1.5 дахь заалтын “тохиолдолд” гэсний дараа “компанийн дүрэм болон гэрээнд заасан” гэж нэмж, 20.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.1.4.төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд дүрэм болон гэрээнд заасан хариуцлага хүлээлгэх, компанид хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлөхийг шаардах, шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг энэ хуулийн 17.2, 17.5-д заасан этгээд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьд дангаараа, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан, эсхүл тэдгээрийн оролцоотой компанийн хувьд бусад этгээдтэй хамтран хэрэгжүүлнэ.

22.3.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчит компанийн нэгдлийн хараат, охин компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг толгой компанийн гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 41
Бүгд: 93
55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “авлигын,” гэсний дараа “нийтийн албаны ашиг сонирхлын,” гэж нэмж, 24.1.2 дахь заалтын “тухайн салбарт таваас доошгүй жил удирдах албан тушаалд” гэснийг “төрийн өмчит компанийн хувьд удирдах албан тушаалд таваас доошгүй, орон нутгийн өмчит компанийн хувьд удирдах албан тушаалд хоёроос доошгүй жил” гэж, “хууль” гэснийг “эрх зүй” гэж өөрчилж, 24.1.6.а. заалтын “өөрөө” гэснийг “дангаараа” гэж өөрчилж, “дангаараа болон” гэснийг хасаж, 24.6 дахь хэсгийн “гуравны нэгээс доошгүй” гэснийг “олонх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.4, 24.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.4.Арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь сондгой тооны таваас ес хүртэлх гишүүнтэй байна.

24.5.Энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний нэг гишүүн нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс томилсон этгээд байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “нийтийн зориулалттай дэд бүтэц,” гэснийг хасаж, “таваас илүүгүй сондгой тооны” гэснийг “таван” гэж, “хоёр хүртэлх гишүүн нь төрийн захиргааны албан хаагч, хоёроос доошгүй нь мэргэжлийн хараат бус гишүүн байж болно” гэснийг “гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна” гэж, 24.8 дахь хэсгийн “хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс томилсон этгээд байна.” гэснийг “энэ хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилогдсон этгээд байна.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн гарчгийн “гишүүнд нэр дэвшигчээс” гэснийг “сонгон шалгаруулалтад оролцогчоос” гэж, мөн зүйлийн 27.1 дэх хэсгийн “гишүүнд нэр дэвшигчийг” гэснийг “гишүүнийг” гэж, 27.2 дахь хэсгийн “нэр дэвших” гэснийг “сонгон шалгаруулалтад оролцох” гэж, 27.2.3 дахь заалтын “нэр дэвшигч” гэснийг “сонгон шалгаруулалтад оролцогч” гэж тус тус өөрчилж, 27.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “хувьд” гэсний дараа “хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь” гэж нэмж, 28.5 дахь хэсгийн “компани болон хувьцаа эзэмшигчид” гэснийг “компанид” гэж өөрчилж, 28.7 дахь хэсгийн “гурван” гэснийг “хоёр” гэж өөрчилж, “нэг удаа” гэсний дараа “хоёр жил хүртэл хугацаагаар” гэж нэмж, 28.8 дахь хэсгийн “тушаалаар” гэснийг “тушаалын байдлаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтын “заавал оролцож” гэснийг “биечлэн, эсхүл зайнаас оролцох” гэж, 29.1.6 дахь заалтын “түүний хамаарал бүхий этгээд” гэснийг “нэгдмэл сонирхолтой этгээд нь” гэж өөрчилж, 29.1.8 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын ирц гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчинтэй болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр нийт гишүүдийн олонхын саналаар хүчин төгөлдөр болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 38

Бүгд: 93

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “жагсаалт,” гэсний дараа “холбогдох материалыг” гэж нэмж, “доошгүй” гэснийг “дээшгүй” гэж өөрчилж, 29.4 дэх хэсгийн “дарга,” гэсний дараа “эсхүл гишүүн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.6.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний санал өгөх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд удирдамж, чиглэл өгөхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

36.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 35 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 29.7дахь хэсэг нэмэх:

“29.7.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь аливаа чиглэл, санал, зөвлөмжийг биелүүлсэн нь энэ хууль болон Компанийн тухай хуульд заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “урамшуулал авч болно” гэснийг “урамшуулалтай байна” гэж, 30.2 дахь хэсгийн “эзэмшигчдийн хурлаас” гэснийг “эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч” гэж, 30.8 дахь хэсгийн “өмчит” гэснийг “өмчийн” гэж, “гишүүний ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлж,” гэснийг “гишүүнд” гэж тус тус өөрчилж, 30.2.2 дахь заалтын “төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санал болон” гэснийг хасаж, “харгалзан” гэснийг “баримтлан” гэж өөрчилж, 30.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.2.1.нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын албан тушаалтны цалингийн жишгийг харгалзан төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналаар;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 39
Бүгд: 93
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтын “хууль” гэснийг “эрх зүй” гэж өөрчилж, мөн зүйлийн 32.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 41
Бүгд: 93
55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “нэг” гэснийг “гурав хүртэлх” гэж өөрчилж, “хугацаатай” гэсний дараа “даалгаврын” гэж нэмж, 33.3 дахь хэсгийн “Хөдөлмөрийн тухай хуулийн 72.1-д заасны дагуу”

гэснийг хасаж, “үүрэг” гэсний өмнө “нууц хадгалах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 39
Бүгд: 93
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтын “хувьцаа, өөрийн хөрөнгийг урт хугацаанд” гэснийг “ашигт ажиллагааг” гэж, 34.1.8 дахь заалтын “заасан үйл ажиллагаанд үл хамаарах зардлыг” гэснийг “зааснаас бусад үйл ажиллагааг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 42
Бүгд: 93
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.1, 36.1.2, 36.1.13 дахь заалтын “3” гэснийг “хоёр” гэж, 36.1.3 дахь заалтын “өргөдөл” гэснийг “хүсэлт” гэж тус тус өөрчилж, 36.1.4 дэх заалтын “ноцтой” гэсний өмнө “эсхүл” гэж нэмж, 36.5 дахь хэсгийн “нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээг хангах зайлшгүй шаардлагатай, эсхүл зүй ёсны монопол үйл ажиллагаа эрхэлдэг” гэснийг “нийтийн үйлчилгээний” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.4, 37.5 дахь хэсгийг хасаж, 37.6 дахь хэсгийн “өмчит” гэснийг “өмчийн” гэж, “жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно” гэснийг “жагсаалтыг Засгийн газар батална” гэж өөрчилж, мөн хэсгийн “этгээдээр” гэсний дараа “санхүүгийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.9 дэх хэсгийн “бүтцэд хамаарах тодорхой тооны” гэснийг “дотоод” гэж өөрчилж, 37.10 дахь хэсгийн “ээлжит бус” гэсний дараа “дотоод” гэж нэмж, 37.12 дахь хэсгийн “нэгжгүй байж болох бөгөөд” гэснийг “нэгж байгуулахгүйгээр” гэж, “ажиллана” гэснийг “ажиллуулна” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийн “гурван үзүүлэлтийн хоёроос доошгүйг” гэснийг “нөхцөлийг” гэж өөрчилж, 37.8 дахь хэсгийн “хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн зөвшөөрлөөр” гэснийг, 37.7.3 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 41
Бүгд: 93
55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.5 дахь заалтын “зөв,” гэсний дараа “, бүрэн” гэж нэмж, 38.1.7 дахь заалтын “гүйцэтгэлийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “хянуулахаар” гэснийг “батлуулахаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 39
Бүгд: 93
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсгийн “үнэлгээний” гэсний өмнө “арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийн” гэж, 40.4.2 дахь заалтын “байгуулалт,” гэсний дараа “засаглал, эрсдэлийн удирдлага” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 40.5 дахь хэсэг нэмэх:

“40.5.Энэ хуулийн 40.3-т заасан нийтийн үйлчилгээний компанийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурт дараах асуудлыг хамааруулна:

40.5.1.компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшин болон нийтийн үйлчилгээний үүргийн биелэлт;

40.5.2.компанийн бүтэц, зохион байгуулалт, засаглал, эрсдэлийн удирдлага, хүний нөөцийн зохистой менежмент;

40.5.3.санхүүгийн менежмент, төсвийн хэмнэлт, хэтрэлт, төсөв, татаасын ашиглалт, нэгж үйлчилгээний өртөг, зардлын үр ашиг;

40.5.4.үйлчилгээний чанар, хүртээмж;

40.5.5.ашиглаж байгаа үндсэн хөрөнгө, дэд бүтцийн найдвартай ажиллагаа;

40.5.6.мэдээллийн ил тод байдал.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.9 дэх хэсгийн “3 жил” гэснийг “2 жил” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 40.10, 40.11 дэх хэсэг, Тайлбар хэсэг нэмэх:

“40.10.Эрх бүхий байгууллагын шийдвэрээр нийтийн ашиг сонирхлын зорилгоор үнэ, тарифыг өртгөөс доогуур тогтоосон, эсхүл нийтийн үйлчилгээний үүргийн хүрээнд компанид нэмэлт санхүүгийн үүрэг хүлээлгэснээс үүссэн орлогын зөрүү, алдагдлыг компанийн үйл ажиллагааны үр ашиггүй байдалд тооцохгүй бөгөөд гүйцэтгэлийн үнэлгээнд нотлох баримтад үндэслэн залруулж тусгана.

40.11.Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 40.3-т заасан журамд нийцүүлэн компанийн тэнцвэржүүлсэн гүйцэтгэлийн үнэлгээний аргачлалыг баталж, хэрэгжилтэд хяналт тавина. Уг аргачлалд энэ хуулийн 40.4, 40.5-д заасан болон тухайн компанийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн бусад үзүүлэлтийг уялдуулан үнэлэх, тайлагнах, бизнес төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг тодорхойлох зохицуулалтыг тусгана.

Тайлбар: -Энэ хуулийн “Тэнцвэржүүлсэн гүйцэтгэлийн үнэлгээний аргачлал” гэж төрийн болон орон нутгийн өмчит компанийн стратеги, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг санхүүгийн үр дүн, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, хэрэглэгчийн сэтгэл ханамж, үйлчилгээний чанар, үйл ажиллагааны үр ашиг, байгууллагын чадавх, хүний нөөцийн хөгжлийн үзүүлэлтээр тэнцвэртэй хэмжиж, үнэлэх, тайлагнах арга зүйн зохицуулалтыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 36

Бүгд: 93

61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “ажлыг” гэснийг “ажил үүргийг” гэж, 41.4 дэх хэсгийн “03 дугаар сарын 01-ний” гэснийг “05 дугаар сарын 15-ны” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Наймдугаар бүлгийн гарчгийг “Нэмэлт хувьцаа гаргах, төрийн эзэмшлийн хувьцааг шилжүүлэх, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн дугаарыг 43 болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43 дугаар зүйл.Нэмэлт хувьцаа гаргах, төрийн эзэмшлийн хувьцааг шилжүүлэх, худалдах, үнэт цаасны зах зээлд санал болгох

43.1.Төрийн болон орон нутгийн өмчит компани энэ хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн дараах хэлбэрээр хувьцаа, үнэт цаасыг үнэт цаасны зах зээлд санал болгож болно:

43.1.1.нэмэлт хувьцаа гаргаж, анхдагч зах зээлд нийтэд санал болгох;

43.1.2.төр, орон нутгийн эзэмшлийн хувьцааг хоёрдогч зах зээлд санал болгох, эсхүл хуульд заасан бусад хэлбэрээр худалдах;

43.1.3.нэмэлт хувьцаа гаргах болон төр, орон нутгийн эзэмшлийн хувьцааг худалдах ажиллагааг хослуулан хэрэгжүүлэх;

43.1.4.дотоодын болон олон улсын үнэт цаасны зах зээлд давхар бүртгэл хийх, хадгаламжийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан шийдвэрийг төрийн өмчийн компанийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчийн компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана. Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит компанийн хувьцааг нийтэд нээлттэй, эсхүл хаалттай хүрээнд санал болгох, төрийн эзэмшлийн хувьцааг худалдах асуудлыг Засгийн газар Улсын Их Хуралд танилцуулж, хуульд заасан бол Улсын Их Хурлын зөвшөөрлийг авна.

43.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг санал болгох ажиллагааг дараах зорилгоор хэрэгжүүлнэ:

43.3.1.компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх, техник, технологийг шинэчлэл хийх, өрсөлдөх чадвар, санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэх;

43.3.2.компанийн засаглал, ил тод байдал, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх;

43.3.3.төрийн өмчийн оролцоог зохистой хэмжээнд бууруулах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх;

43.3.4.Монгол Улсын иргэн, Үндэсний баялгийн сан, тэтгэврийн сан болон дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчийн оролцоог нэмэгдүүлэх;

43.3.5.газрын хэвлийн баялгийн өгөөжийг нийт иргэнд хүртээмжтэй, ил тод, зах зээлийн зарчмаар хүргэх;

43.3.6.төрийн өмчит компанийн талаар баримтлах бодлого, компанийн дүрэмд заасан бусад.

43.4.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг санал болгох ажиллагааг дараах үе шатлалаар, эсхүл аль нэгийг сонгож, эсхүл хослуулан хэрэгжүүлж болно:

43.4.1.Монгол Улсын иргэн, Үндэсний баялгийн сан, тэтгэврийн сан, даатгалын сан, хөрөнгө оруулалтын сан болон дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчдад хаалттай захиалгын аргаар санал болгох;

43.4.2.дотоодын үнэт цаасны зах зээлд нийтэд нээлттэй хэлбэрээр санал болгох;

43.4.3.олон улсын үнэт цаасны зах зээлд давхар бүртгэл хийх замаар санал болгох.

43.5.Энэ хуулийн 43.4.1-д заасан хаалттай захиалгын аргаар санал болгох ажиллагаанд оролцох эрх бүхий этгээд, захиалгын доод болон дээд хэмжээ, нэг этгээдийн эзэмших дээд хязгаар, давуу эрх, төлбөр тооцоо, хуваарилалтын асуудлыг тухай бүр Засгийн газар хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

43.6.Энэ хуулийн 43.2-т заасан салбарын төрийн өмчит компанийн хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг хаалттай захиалгын аргаар санал болгоход дараах зарчмыг баримтална:

43.6.1.тэгш, шударга, ил тод оролцох боломж олгох;

43.6.2.нэг этгээдэд хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх;

43.6.3.хувьцааны үнэ, үнэлгээ, эрсдэл, ногдол ашиг, саналын эрх, хязгаарлалт, захиалгын нөхцөлийг нийтэд хүртээмжтэй мэдээлэх;

43.6.4.захиалга давсан тохиолдолд хувьцааг хувь тэнцүүлэн хуваарилах;

43.6.5.иргэдийн хувьцааг богино хугацаанд төвлөрүүлэн худалдан авах, дамжуулан худалдах, зах зээлийг урвуулан ашиглах эрсдэлээс сэргийлэх зохицуулалт тогтоох.

43.7.Энэ хуулийн 43.2-т заасан салбарын төрийн өмчит компанийн хувьцааг санал болгоход төрийн эзэмшлийн доод хэмжээ, саналын эрх, алтан хувьцаа,

мэргэжлийн хөрөнгө оруулагчийн оролцоо, гадаадын хөрөнгө оруулагчийн эзэмшлийн хязгаарыг тухайн компанийн онцлогт нийцүүлэн шийдвэрлэнэ.

43.8.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ур чадвартай ажилтныг тогтвортой ажиллуулах, дотоод хяналтыг сайжруулах зорилгоор ажилтнуудад эзэмшүүлэх давуу эрхийн хувьцаа, опционыг Компанийн тухай хуульд заасны дагуу гаргаж болно.

43.9.Энэ хуулийн 43.8-д заасан давуу эрхийн хувьцаа, опцион гаргахтай холбоотой журмыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

Тайлбар: -Энэ зүйлд заасан “хаалттай захиалга” гэж төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг хууль, Засгийн газрын шийдвэр, эсхүл эрх бүхий байгууллагын баталсан журмаар урьдчилан тодорхойлсон хөрөнгө оруулагчийн хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.2-т заасны дагуу санал болгох ажиллагааг.

Тайлбар: -Энэ зүйлд заасан “нээлттэй захиалга” гэж төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.1-д заасан журмын дагуу нийтэд санал болгох ажиллагааг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 45 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 45.3, 45.4 дэх хэсэг нэмэх:

“45.3.Төрийн өмчийн компанийн эд хөрөнгийн тооллого хийж, дуусгалтын тайлан, тэнцэл үйлдэн, эд хөрөнгийг хэсэгчлэн шилжүүлэх, эсхүл дуудлагаар худалдах ажлыг Засгийн газрын шийдвэрийг үндэслэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

45.4.Орон нутгийн өмчийн компанийн эд хөрөнгийн тооллого хийж, дуусгалтын тайлан, тэнцэл үйлдэн, эд хөрөнгийг хэсэгчлэн шилжүүлэх, эсхүл дуудлагаар худалдах ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн орон нутгийн өмчийн газар эрхлэн гүйцэтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 36

Бүгд: 93

61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 53 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 46 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн “байгуулахыг” гэснийг “байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг” гэж, “шийдвэрлэнэ” гэснийг “гаргана” гэж өөрчилж, 48.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.3.Энэ хуулийн 48.1-д заасан нөөц сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

48.3.1.компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх, технологийг шинэчлэх;

48.3.2.давагдашгүй хүчин зүйл, зах зээлийн гэнэтийн өөрчлөлт болон бусад урьдчилан таамаглах боломжгүй эрсдэлийн сөрөг нөлөөллийг бууруулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 38

Бүгд: 93

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 49.1.7 дахь заалтын “компанийн эсрэг, эсхүл” гэснийг хасаж, 49.1.14 дэх заалтын “дэмжлэг,” гэсний дараа “татаас,” гэж нэмэх:

“49.1.1.компанийн төсөв, бизнес төлөвлөгөө,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 37

Бүгд: 93

60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.3, 51.4 дэх хэсэг нэмэх:

“51.3.Энэ хуулийн 24.6-д заасан зохицуулалтыг 2028 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

51.4.Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн өмчит компанийг энэ хуулийн 8.3-т нийцүүлэх арга хэмжээг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

59.Ажлын хэсгийн гаргасан, Дагаж мөрдөх хугацааг “2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Ажлын хэсгийн гаргасан, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа хоёр жилээс хэтрэхгүй байх бөгөөд нэг удаа хоёр жил хүртэл хугацаагаар улируулан томилох тухай зохицуулалт дэмжигдсэнтэй холбогдуулан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг хүчингүй болгох тухай хуулийн төслийг боловсруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 38

Бүгд: 93

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

61.Ажлын хэсгийн гаргасан, Төрийн өмчийн компанийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр санхүүгийн аудит хийлгэх тохиолдолд тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх компанийн жагсаалтыг Засгийн газар батлах зохицуулалт дэмжигдсэнтэй холбогдуулан Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 38

Бүгд: 93

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

62.Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 17.2.1 дэх заалт нэмэх:

“17.2.1.Энэ хуулийн 6.1.2-д заасан төрийн өмчийн оролцоотой компанийн эрхийг хэрэгжүүлэгч нь бие даасан хараат бус санхүүгийн институт бүхий хөрөнгийн менежментийн байгууллага байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

63.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.1.4 дэх заалт нэмэх:

“18.1.4.энэ хуулийн 8.1.2-т заасан үндэслэлээр үүсгэн байгуулсан төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг Улсын Их Хурлын зөвшөөрлийн үндсэн дээр бусдад шилжүүлэх, барьцаалуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 36

Бүгд: 93

61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

64.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2.8 дахь заалтын “хувьцааны удирдлагын талаарх илтгэлийг” гэснийг, мөн төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн “төр болон орон нутгийн хувьцааны удирдлагын талаарх илтгэлийг” гэснийг “энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан өмчлөлийн бодлогын хэрэгжилтийн тайланг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 37

Бүгд: 93

60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн “03 дугаар сарын 01-ний” гэснийг “05 дугаар сарын 01-ний” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 37

Бүгд: 93

60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “байгуулах” гэсний өмнө, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “байгуулна” гэсний өмнө, “үүсгэн” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалтын “дүрэмд” гэсний өмнө “компанийн” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “зөвлөл” гэсний дараа “/байхгүй бол гүйцэтгэх удирдлага/”, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “комисс” гэсний өмнө “татан буулгах” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “шийдвэрлүүлэх үүрэгтэй” “шийдвэрлүүлнэ” гэж, 24 дүгээр зүйлийн гарчгийн “тавигдах” гэснийг “тавих” гэж, 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийн “хавсарган ирүүлнэ” гэснийг “хавсаргана” гэж өөрчлөх.

3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.4 дэх хэсгийн “зөвхөн” гэснийг, 8.5 дахь хэсгийн “Энэ” гэснийг, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “хурлаас” гэснийг, 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсгийн “төрийн өмчийн асуудал эрхэлсэн” гэснийг тус тус хасах.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 36

Бүгд: 93

61.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 8.1.3 дахь заалтыг хасах:

“8.1.1.хувийн хэвшил дангаараа гүйцэтгэхэд эдийн засаг, санхүүгийн хувьд үр өгөөжгүй нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулах;

8.1.2.үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулах:

“8.2.Энэ хуулийн 8.1.1-д заасан нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт компани үүсгэн байгуулахад хувийн хэвшил дангаараа гүйцэтгэхэд эдийн засаг, санхүүгийн хувьд үр өгөөжгүй байх нөхцөлийг хангасан байна.

8.3.Орон нутаг зөвхөн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн 8.1.1, 8.2-т заасан үндэслэлээр орон нутгийн өмчит компанийг үүсгэн байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

3.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“16 дугаар зүйл.Ногдол ашгийн бодлого

16.1.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч оролцоотой компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд зааснаас гадна дараах зарчим, шаардлагыг баримтлан ногдол ашгийн бодлогыг батална:

16.1.1.компанийн төлбөрийн чадвар, мөнгөн урсгал, батлагдсан бизнес болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, их засварын хэрэгцээ, нөөц сан бүрдүүлэх шаардлага, санхүүгийн тогтвортой байдлыг харгалзан үзэх;

16.1.2.нийтийн үйлчилгээний үүрэг хүлээсэн бол тухайн үүргийн санхүүжилт, нөхөн төлбөр, татаас, тарифын зохицуулалтыг ногдол ашиг тооцох сууринаас тусад нь авч үзэх;

16.1.3.компанийн урт хугацааны үнэ цэн, хэвийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын чадавхыг дордуулахгүй байх.

16.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани ногдол ашгийн бодлогыг тухайн компанийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын бүтцээс хамаарч дараах хэлбэрээр ногдол ашгийн бодлогод тодорхойлж тусгана:

16.2.1.өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайланд туссан татвар төлсний дараах хуваарилж болох цэвэр ашгаас тухай бүр, эсхүл урьдчилан тогтоосон хувиар;

16.2.2.цэвэр ашгийн хэмжээ үл хамаарч жил бүр тогтмол хэмжээ болон түүнээс тооцох өсөлтийн хувиар;

16.2.3.хүү, татвар, элэгдэл, хорогдол зэрэг санхүүгийн үзүүлэлтийн хамтад нь, эсхүл хэсэгчлэн тооцохоос өмнөх ашгаас урьдчилан тогтоосон тодорхой хувиар тооцож;

16.3.Арилжааны зорилготой төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани нь тухайн санхүүгийн жилд хуваарилж болох цэвэр ашигтай ажилласан бол ногдол ашиг хуваарилах үүрэгтэй.

16.4.Энэ хуулийн 16.3-т заасан компанийн тухайн жилд хуваарилах ногдол ашгийн зорилтот хувь хэмжээ, ногдол ашиг тооцох хэлбэрийг Засгийн газар, орон нутгийн өмчит компанийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн төсвийн төсөл боловсруулах үе шатанд компанийн ангилал, салбарын онцлог, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, өр төлбөрийн түвшин, мөнгөн урсгал, өөрийн хөрөнгийн өгөөж, нөөц сангийн шаардлагыг харгалзан тогтооно.

16.5.Энэ хуулийн 16.4-т заасан зорилтот хувь хэмжээ нь арилжааны зорилготой компанийн хувьд хуваарилж болох цэвэр ашгийн 30 хувиас доошгүй байх зарчмыг баримтална. Харин компанийн санхүүгийн байдал, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, эсхүл энэ хуулийн 16.7-д заасан үндэслэл байгаа бол уг хувь хэмжээг бууруулж болно.

16.6.Нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчит компанид энэ хуулийн 16.5-т заасан доод хувь хэмжээ хамаарахгүй. Компани нь цэвэр ашигтай ажилласан тохиолдолд төлбөрийн чадвар, мөнгөн урсгал, нийтийн үйлчилгээний үүргийн санхүүжилт, үйлчилгээний хүртээмж, чанар, тасралтгүй байдлыг харгалзан ногдол ашиг хуваарилж болно.

16.6.Дараах үндэслэл байгаа бол энэ хуулийн 16.4, 16.5-т заасан зорилтот буюу доод хувь хэмжээнээс бага хэмжээгээр ногдол ашиг хуваарилж болно.

16.7.Компанийн тухай хуульд заасан төлбөрийн чадварын шаардлага хангагдахгүй, эсхүл нийтийн үйлчилгээний буюу арилжааны бус тусгай үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, эх үүсвэрийг хадгалах шаардлагатай болсон тохиолдолд энэ хуулийн 16.4, 16.5-д заасан зорилтот буюу доод хэмжээнээс багаар хуваарилж болно.

16.8.Энэ хуулийн 16.7-д заасан үндэслэлээр ногдол ашгийг зорилтот хувь хэмжээнээс бага тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Саналд дараах баримт бичгийг хавсаргана:

16.7.1.аудитлагдсан санхүүгийн тайлан;
 16.7.2.төлбөрийн чадварын болон мөнгөн урсгалын дүгнэлт;
 16.7.3.дараагийн гурваас доошгүй жилийн стратеги төлөвлөгөө;
 16.7.4.хөрөнгө оруулалт, их засварын тооцоолол;
 16.7.5.нийтийн үйлчилгээний үүрэг хүлээсэн бол уг үүргийн өртөг, санхүүжилт, нөхөн төлбөрийн тооцоо;

16.7.6.ногдол ашиг бууруулах үндэслэл, эрсдэлийн үнэлгээ.

16.9.Энэ хуулийн 16.8-д заасан саналыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хянаж, зөвшөөрөх, өөрчлөх, эсхүл татгалзах тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.

16.10.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд төр, орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь энэ зүйлд заасан ногдол ашгийн бодлого, зорилтот хувь хэмжээ, санхүүгийн тогтвортой байдлын шалгуурыг баримтлан хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлд санал өгөх чиглэл баримтална.

16.11.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит компанийн ногдол ашгийн бодлогын хэрэгжилт, хуваарилсан болон хуваарилаагүй ашгийн хэмжээ, бууруулсан үндэслэл, дахин хөрөнгө оруулалтад ашигласан хөрөнгийн үр дүнгийн талаарх нэгдсэн тайланг жил бүр Засгийн газарт танилцуулж, олон нийтэд мэдээлнэ.

Тайлбар: Энэ зүйлд заасан “хүү, татвар, элэгдэл, хорогдол зэрэг санхүүгийн үзүүлэлтийн хамтад нь эсхүл хэсэгчлэн тооцохоос өмнөх ашиг” гэж олон улсын санхүүгийн харилцаанд түгээмэл ашигладаг “EBITDA буюу earnings before interests, tax, depreciation and amortization, EBI буюу earnings before interests, эсхүл EBIT буюу earnings before interests and tax” зэргийг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.2.Төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

5.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“20.1.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байна. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.1.1.төрийн болон орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, шилжүүлэх, алтан хувьцаа гаргах, төрийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх асуудлаар үндэслэл бүхий санал боловсруулж Засгийн газар, эсхүл иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал хүргүүлж, холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг Засгийн газарт тайлагнах;

20.1.2.төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хуульд заасан журмын дагуу нээлттэй, өрсөлдөөнт зарчмаар сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх ажлыг зохион байгуулах;

20.1.3.төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх талаар санал гаргах;

20.1.4.төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хууль зөрчсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон, компанийн дүрэмд заасан үүргээ биелүүлээгүй тухай үндэслэл бүхий дүгнэлт гарсан бол хариуцлага хүлээлгэх, компанид хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлөхийг шаардах, шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд уг асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал хүргүүлэх;

20.1.5.төрийн болон орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх захирал хууль болон дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх саналаа төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх;

20.1.6.төрийн болон орон нутгийн өмчийн компанийн бизнес төлөвлөгөө болон төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх;

20.1.7.төрийн болон орон нутгийн өмчийн компанийн эзэмшиж, ашигладаг улсын тусгай хамгаалалттай газар, дэд бүтцийн томоохон барилга, байгууламж, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тодорхой хувь болон тухайн компанийн үндсэн хөрөнгийн 20 хувиас дээш хэмжээний эд хөрөнгийг бусдад эзэмшүүлэх, худалдах, ашиглах эрхийг шилжүүлэх талаарх асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газарт хүргүүлэх;

20.1.8.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх захирлын бүрэн эрхийн хугацаа, цалин, урамшууллын хэмжээ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

20.1.9.энэ хуулийн 7.1-д заасан төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийг баримтлан төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлтэй 3 жил тутамд зорилт, үр дүнгийн гэрээг шинэчлэн байгуулна.

20.1.10.төрийн өмчийн компанийн үл хөдлөх эд хөрөнгө, газар эзэмших, ашиглах эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдах, солих, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үл хамаарах их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг бүртгэж, хуульд нийцэж байгаа эсэхийг хянах;

20.1.11.төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нээлттэй, өрсөлдөөнт зарчмаар сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх талаар санал гаргах;

20.1.12.төрийн болон орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх захирал хууль зөрчсөн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон болон энэ хуулийн 12.2-т заасан нөхцөл байдал үүссэн, тухайн компаний зээл, үнэт цаасны хэмжээ нь тогтоосон өрийн дээд хязгаарыг давсан, компаний үндсэн чиг үүргийг алдагдуулсан, дүрэмд заасан үүргээ биелүүлээгүй нь үндэслэл бүхий дүгнэлтээр тогтоогдсон бол хариуцлага хүлээлгэх саналаа төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх;

20.1.13.төрийн болон орон нутгийн өмчийн компанийн бизнес төлөвлөгөө болон төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг энэ хуулийн 12.2-т заасан шаардлага болон компаниас гаргасан зээл, үнэт цаасны хэмжээ нь өрийн дээд хязгаарт нийцсэн эсэх, компанийн үндсэн чиг үүргийн хэрэгжилт зэрэг үр дүнд суурилсан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу жил бүр тогтсон хугацаанд үнэлэх, төрийн өмчийн компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах талаар шаардлага, зөвлөмж өгч, хэрэгжилтийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах;

20.1.14.төрийн өмчийн компанийн төрийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавих;

20.1.15.төрийн өмчит компаниас төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг энэ хуульд заасан зарчмыг баримталж, тухайн жилийн төсвийн тухай хуульд заасны дагуу бүрэн төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

20.1.16.хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

6.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

7.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.4.Ижил төрлийн үйл ажиллагаа, чиг үүрэг хэрэгжүүлдэг төрийн болон орон нутгийн өмчит компаниуд нэг төлөөлөн удирдах зөвлөлтэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

8.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.4 дэх хэсэг нэмэх.

“23.4.Төлөөлөн удирдах зөвлөлгүй төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьд түүний бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

9.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.5.Төрийн албан хаагч нь энэ хуулийн 24.4-т заасан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшихийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

10.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.1.4.бусад аж ахуйн нэгж, төрийн байгууллагад давхар албан тушаал эрхэлдэггүй байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

11.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.5 дахь хэсгийн “компанид” гэснийг “компани болон толгой компанийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж байгаа төсөл хэрэгжүүлэгч компанид” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Татгалзсан: 37
 Бүгд: 93
 60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэсний өмнө “Төрийн байгууллага,” гэж нэмж, “албан газар, төрийн өмчийн компани” гэснийг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 5-д заасан төрийн өмчит хуулийн этгээд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
 Татгалзсан: 42
 Бүгд: 93
 54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
 Татгалзсан: 42
 Бүгд: 93
 54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын 9¹ дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “улсын ахлах” гэсний дараа “байцаагч” гэж нэмж, 7 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг хасах;

2.Мөн зүйлийн 2 дахь заалтын 13 дугаар зүйлийн 2 дахь заалтын “нийтийн үйлчилгээний” гэсний өмнө “төрийн өмчит” гэж нэмэх;

3.Мөн зүйлийн 3 дахь заалтын 15 дугаар зүйлийн гарчгийн, 6, 7 дахь хэсгийн “Нийтийн үйлчилгээний” гэсний өмнө “Төрийн болон орон нутгийн өмчит” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “холбоотой” гэсний дараа “асуудлыг” гэж, 7 дахь хэсгийн “нээлттэй” гэсний өмнө “олон нийтэд ил тод,” гэж, тус тус нэмж, мөн хэсгийн 1 дэх заалтын “удирдлагын” гэснийг “удирдлага, түүний цалин, хөлс, урамшууллын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
 Татгалзсан: 38

Бүгд: 93
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 14 дүгээр зүйлийн өмнө “мөн зүйлийн 3 дахь заалтын “өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн” гэснийг “өмчит компанийн” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 44
Бүгд: 93
52.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21¹ дүгээр зүйлийн дараах “12” гэснийг “13” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн нэг дэх заалтад доор дурдсан агуулгатай 3, 4 дэх дэд заалт нэмэх:

“3/Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль батлагдсантай холбогдуулан бусад хууль тогтоомж дахь төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит компанийн талаарх нэр томъёог хуульд нийцүүлж өөрчлөх талаарх саналаа Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;

4/Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүсгэн байгуулагдсан уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит компанид тус хуулийн 8.3-т заасан зөвшөөрөл хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 21 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн 2026.06.05-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Н.Ариунболд, Б.Солонго нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Галсанбат нар байлцав.

С.Бямбацогт: 1.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 39
Бүгд: 93
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 39
Бүгд: 93
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 39
Бүгд: 93
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 38
Бүгд: 93
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн

тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 21 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2026.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан/-ийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл нар байлцав.

С.Бямбацогт: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10-т “Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн бол хуулийн төслийг Байнгын хороонд буцаана.” гэж заасны дагуу Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд буцаах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	54
Татгалзсан:	39
Бүгд:	93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд буцаав./21:18/

Уг асуудлыг 21 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн/-ийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг, мөн газрын ахлах шинжээч Ц.Мөнхбат, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч А.Нарангаравуу, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын газрын дарга Л.Чой-Иш, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга С.Пүрэвсүрэн, Цаг уур, орчны шинжилгээний газрын

дарга Э.Баттулга, Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, судлаач Д.Дагвадорж, Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн шинжлэх ухааны зөвлөх З.Батжаргал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад нүүрстөрөгчийн зах зээлийн бэлэн байдлыг бэхжүүлэх нь” төслийн хуулийн зөвлөх Б.Номун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл нар байлцав.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, С.Ганбаатар, П.Наранбаяр, С.Одонтуяа, П.Сайнзориг, Ч.Ундрал, С.Эрдэнэбат /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “бодлого,” гэснийг, мөн хэсгийн “бүртгэл,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 42
Бүгд: 93
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Байгаль орчныг хамгаалах тухай хууль,” гэсний дараа “Агаарын тухай хууль,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 42
Бүгд: 93
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “төр,” гэсний дараа “иргэн,” гэж нэмж, мөн хэсгийн “эрх, үүрэг, тэдгээрийн уялдаа холбоог хангахтай холбогдсон” гэснийг “эрх, үүргийг зохицуулсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 39
Бүгд: 93
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг, 4.1.3 дахь заалтын “нэг ижил” гэснийг, 4.1.5 дахь заалтын “, болон сайн дурын

санаачилгыг хэрэгжүүлэх” гэснийг, 4.1.12 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн дагуу” гэснийг, 4.1.13 дахь заалтыг, 4.1.15 дахь заалтын “зорилгоор ашигладаг” гэснийг, 4.1.16 дахь заалтыг, 4.1.21 дэх заалтын “бодлого,” гэснийг, 4.1.25, 4.1.27 дахь заалтыг, 4.1.30 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээнд” гэснийг, мөн заалтын “тохируулга хийж” гэснийг, 4.1.40 дэх заалтыг тус тус хасаж, 4.1.3 дахь заалтын “шингээлт эсхүл” гэснийг “шингээх үйл ажиллагаанаас үүссэн” гэж, 4.1.4 дэх заалтын “тогтвортой” гэснийг “арга хэмжээ” гэж, 4.1.6 дахь заалтын “зах зээлийн тогтолцоог” гэснийг “зах зээлийг” гэж, 4.1.14 дэх заалтын “шингээсэн” гэснийг “хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлсэн” гэж, 4.1.15 дахь заалтын “шаардлагаас” гэснийг “үүргээс” гэж, 4.1.28 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж тус тус өөрчилж, 4.1.6 дахь заалтын “худалдах,” гэсний дараа “арилжих, дүйцүүлэх,” гэж, 4.1.9 дэх заалтын “үзүүлэлтэд” гэсний дараа “нийцсэн уур амьсгалын санхүүжилтийг хамарсан” гэж, 4.1.20 дахь заалтын “үйлдвэрлэл,” гэсний дараа “үйлчилгээ,” гэж, 4.1.28 дахь заалтын “зохицох” гэсний дараа “, даван туулах” гэж, 4.1.30 дахь заалтын “нэмж” гэсний дараа “, эсхүл хасаж” гэж, 4.1.32 дахь заалтын “бусад хийг” гэсний өмнө “олон улсын гэрээ, стандартаар хүлэмжийн хий гэж хүлээн зөвшөөрөгдсөн” гэж, 4.1.33 дахь заалтын “ой,” гэсний дараа “бэлчээр,” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 4.1.2, 4.1.7, 4.1.8, 4.1.10, 4.1.11, 4.1.18, 4.1.19, 4.1.22, 4.1.24, 4.1.26, 4.1.31, 4.1.36, 4.1.37, 4.1.38, 4.1.39 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“даван туулах” гэж уур амьсгалын өөрчлөлт, аюулт үзэгдэл тулгарахад байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтолцоо, үндсэн чиг үүрэг, өвөрмөц чанар, бүтцээ хадгалан хариу үйлдэл үзүүлэх, сэргээн зохион байгуулагдах, дасан зохицох чадавхыг;

4.1.7.“карбон кредит” гэж эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломжтойгоор баталгаажсан, бүртгэгдсэн карбон нэгжийг;

4.1.8.“карбон нэгж” гэж сааруулалтын үр дүнг нэг тонн нүүрстөрөгчийн давхар ислийн тэнцэлд дүйцэх байдлаар илэрхийлсэн тооцооллын нэгжийг;

4.1.10.“ногоон таксономи” гэж эдийн засгийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байдлаар нь ангилж, ногоон болон уур амьсгалын санхүүжилтэд хамрагдахыг тодорхойлсон шалгуур, ангиллыг;

4.1.11.“олон талт карбон зах зээл” гэж олон улсын гэрээ, шийдвэрийн хүрээнд төвлөрсөн зохицуулалтаар хэрэгжих, олон улсад шилжүүлэн тооцох, сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.18.“уур амьсгалын өөрчлөлт” гэж байгалийн хүчин зүйл, хүний үйл ажиллагааны улмаас дэлхийн агаар мандлын хийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөс үүдэн уур амьсгалд урт хугацаанд гарч буй өөрчлөлтийг;

4.1.19.“уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий хүн амын бүлэг” гэж уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэлтэй, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, газар зүйн байршлын улмаас түүнд дасан зохицох, даван туулах чадавх хязгаарлагдмал хүн амын бүлгийг;

4.1.22.“уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл” гэж уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг өөрчлөлтийг;

4.1.24.“уур амьсгалын санхүүжилт” гэж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн олон улсын, үндэсний болон орон нутгийн түвшинд төр, хувийн хэвшил, бусад эх үүсвэрээс бүрдсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг;

4.1.26.“үндэсний карбон зах зээл” гэж үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хангах хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгарахаас урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнд үүссэн карбон кредитийг бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах замаар зохицуулсан зах зээлийг;

4.1.31.“хоёр талт карбон зах зээл” гэж улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжих олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнг бий болгох, бүртгэх, шилжүүлэх, худалдах, арилжих, дүйцүүлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулсан зах зээлийг;

4.1.36.“хүлэмжийн хийн ялгарлаас урьдчилан сэргийлэх” гэж тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй тохиолдолд үүсэх байсан хүлэмжийн хийн ялгарлаас зайлсхийхэд чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.37.“хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах” гэж хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг;

4.1.38.“хүлэмжийн хийн ялгарлын тэнцэл” гэж тайлант хугацаанд үүссэн хүлэмжийн хийн нийт ялгарлаас бууруулалт, урьдчилан сэргийлсэн ялгарал болон шингээлтийг хасан гарах цэвэр дүнг;

4.1.39.“хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт” гэж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнг батлагдсан аргачлалын дагуу хэмжих, үр дүнг тайлагнах, тайлагнасан мэдээллийг хөндлөнгийн итгэмжлэгдсэн этгээдээр шалгуулан баталгаажуулах үйл ажиллагааг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа үг хэлж, хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “салбар,” гэсний дараа “хүн амын” гэж нэмж, 5.1.5 дахь заалтын “шинжлэх ухаанд үндэслэх” гэснийг “шинжлэх ухаан, инновацад суурилах” гэж, 5.1.9 дэх заалтын “мэдлэг, инновацад суурилсан дэвшилтэт технологийг” гэснийг “мэдлэгийг” гэж тус тус өөрчилж, 5.1.6 дахь заалтыг, 5.2 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5.1.1 дэх заалт нэмэх:

“5.1.1.эдийн засгийн үр ашигтай байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
 Татгалзсан: 42
 Бүгд: 93
 54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “олон улсын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд боловсруулах тайлан, илтгэлийг танилцах” гэснийг “тайлан, илтгэлийг сонсож, хэлэлцэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 6.1.4 дэх заалтын “бүрэн эрх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
 Татгалзсан: 42
 Бүгд: 93
 54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж, 7.1.5 дахь заалтын “хөтөлбөрийг тодорхойлсон” гэснийг “хөтөлбөрт зориулсан” гэж, 7.1.9 дэх заалтын “санхүүжилтийн орлогын урсгалыг” гэснийг “санхүүжилтийг” гэж, 7.1.10 дахь заалтын “ажиллагааг удирдах зохицуулах” гэснийг “ажиллагааны” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтын “энэ хуульд заасан асуудлаар” гэснийг, 7.1.6 дахь заалтыг, 7.1.8 дахь заалтын “хүлэмжийн хийн ялгарлын бууралт, шингээлтийн үр дүнг тооцох, баталгаажуулах, тайлагнахтай холбоотой” гэснийг, 7.1.9 дэх заалтын “ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн орлогын урсгал, үр ашиг, зарцуулалтыг бүртгэх, хянах, тайлагнах, цаашдын төлөвлөлтийг хангах, олон улсын тайлагнал болон ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбоотой” гэснийг, 7.1.10 дахь заалтын “энэ хуулийн 4.1.27-д заасан” гэснийг, 7.1.11 дэх заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа үг хэлж, хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “ногоон хөрөнгө оруулалтын бодлого,” гэснийг, 8.1.5 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.1.Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах асуудлыг уялдуулан боловсруулах;

8.1.3.ногоон санхүүжилтийн стратегийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
 Татгалзсан: 41
 Бүгд: 93
 55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтын “төлөвлөгөө,” гэснийг хасаж, 8.2.2 дахь заалтын “удирдах” гэснийг “зохицуулах, хяналт тавих” гэж өөрчилж, 8.1.4 дэх заалтыг 8.2.1 дэх заалт болгон шилжүүлж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8.2 дахь хэсэг нэмэх:

“8.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	53
Татгалзсан:	40
Бүгд:	93

57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.5, 8.2.6, 8.2.8 дахь заалтын “хөтөлбөрт” гэсний дараа “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн” гэж, 8.2.7 дахь заалтын “шилжүүлэгт” гэсний дараа “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн” гэж тус тус нэмж, 8.2.13 дахь заалтын “зарцуулалтыг хариуцан удирдаж,” гэснийг “зарцуулалтад” гэж, 8.2.15 дахь заалтын “, мэдээлэл цуглуулах, боловсруулах, тайлагнахтай холбоотой үйл ажиллагаа, аргачлал, зохицуулалтын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам” гэснийг “аргачлал, журам” гэж тус тус өөрчилж, 8.2.9 дэх заалтыг, 8.2.14 дэх заалтын “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн үр дүнг тооцох, мэдээлэл цуглуулах, нэгтгэх, тайлагнах, баталгаажуулах үйл ажиллагааны нэгдсэн аргачлал, зохион байгуулалтын” гэснийг, 8.2.18, 8.2.19 дэх заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 8.2.4, 8.2.16, 8.2.17, 8.3.1, 8.3.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.2.4.олон талт карбон зах зээлийн үйл ажиллагаанд зөвшөөрсөн тухай тодорхойлолт олгох, оролцогч этгээдийг бүртгэх, хяналт тавих;

8.2.16.энэ хуулийн 7.1.8-д заасан журмын төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, батлуулах;

8.2.17.энэ хуулийн 7.1.7, 7.1.9-д заасан журмын төслийг боловсруулж, батлуулах;

8.3.1.энэ хуулийн 6.1.1, 7.1.1-д заасны дагуу уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах арга хэмжээг салбарын хэмжээнд тодорхойлж, улсын төсөвт тусгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

8.3.5.салбарын хэмжээнд Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг хангах, хүлэмжийн хийн ялгарлын тооллоготой холбоотой өгөгдөл, мэдээллийг цуглуулах, тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	50
Татгалзсан:	43
Бүгд:	93

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.2.20 дахь заалт нэмэх:

“8.2.20.сааруулалтын үр дүнг тооцох аргачлал, стандарт, ялгарал болон шингээлтийн итгэлцүүрийг Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хорооны дэргэдэх техникийн хороогоор хэлэлцүүлж, түүний дүгнэлтэд үндэслэн батлах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	51
Татгалзсан:	42
Бүгд:	93

54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцсэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход чиглэсэн аймаг, нийслэлийн төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлан санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	54
Татгалзсан:	39
Бүгд:	93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “8.2-т заасан байгууллагаар” гэснийг “8.2.15-д заасан журмын дагуу” гэж өөрчилж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “6.1.1, 7.1.1, 10.1-д заасантай уялдуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөвлөгөөг” гэснийг “6.1.1, 7.1.1, 9.1-д заасантай уялдуулан тухайн нутаг дэвсгэрийн уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	52
Татгалзсан:	41
Бүгд:	93

55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтын “уур амьсгалын” гэсний дараа “өөрчлөлтийн” гэж нэмж, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийн “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийн хүрээнд” гэснийг “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн” гэж, 11.1.2 дахь заалтын “нэмэр” гэснийг “нэмрийн зорилт” гэж, мөн заалтын “хариуцсан зохих байгууллагад” гэснийг “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар” гэж, 11.1.3 дахь заалтын “удирдах” гэснийг “удирдлага, зохион байгуулалтаар хангах” гэж тус тус өөрчилж, 11.1.6 дахь заалтын “Парисын хэлэлцээрийн шаардлагад нийцүүлэн” гэснийг, 11.1.10 дахь заалтын “бүрэн эрх” гэснийг тус тус хасаж, 11.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.9.сааруулалтын үр дүнгийн урт хугацааны хадгалалт алдагдах, хэтрүүлэн тооцож шилжүүлэх, байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан буцаан алдагдах эрсдэлийг бууруулах зорилгоор төсөл, хөтөлбөрөөс үүссэн баталгаажсан сааруулалтын үр дүнг тооцож, карбон кредитийг байршуулж, буцаан олгох, удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа үг хэлж, хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн төлөв байдлын үнэлгээг жил тутам, уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн чиг хандлага, нөлөөллийн үнэлгээг таван жил тутам боловсруулж, үнэлгээний дүнг нэгтгэн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

12.2.Энэ хуулийн 8.2.15-д заасан журмын дагуу уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх бодит болон болзошгүй сөрөг нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн салбар, бүс нутаг тус бүрээр холбогдох төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутгийн байгууллага нь Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасан үнэлгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, шинжлэх ухаанд суурилсан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох арга хэмжээний бодлого, төлөвлөлтийг тодорхойлно.

12.4.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний үр дүнг үндэсний, бүс нутгийн, салбарын болон орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, Үндэсний дасан зохицох төлөвлөгөө боловсруулахад ашиглана.

12.5.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний үр дүнг уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний платформоор дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 40

Бүгд: 93

57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.6 дахь хэсэг нэмэх:

“12.6.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэн гарах эдийн засгийн болон эдийн засгийн бус гарз хохирлын үнэлгээг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20.3-т заасан журмын дагуу холбогдох төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 44

Бүгд: 93

52.7 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “баталгаажуулахаар” гэснийг “хянуулахаар” гэж, 13.3 дахь хэсгийн “коэффициентыг” гэснийг “итгэлцүүрийг” гэж, мөн зүйлийн 13.4 дэх хэсгийн “боловсруулж, тогтмол хугацаанд шинэчилнэ” гэснийг “боловсруулна” гэж, 13.5 дахь хэсгийн “аргачлалыг” гэснийг “аргачлал, ялгарал болон шингээлтийн итгэлцүүрийг” гэж, мөн хэсгийн “энэ хуулийн 8.2-т заасан байгууллага” гэснийг “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран” гэж, 13.8 дахь хэсгийн “хүргүүлж” гэснийг “гаргаж” гэж тус тус өөрчилж, 13.4 дэх хэсгийн “бодлого,” гэснийг, 13.8 дахь хэсгийн “хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн ил тод байдлын тайлангийн хамтаар” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 40

Бүгд: 93

57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгана.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа үг хэлж, хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “санхүүжүүлэлтийг тодорхойлон” гэснийг “санхүүжүүлэн” гэж өөрчилж, мөн зүйлийн 16.1, 16.4, 16.6 дахь хэсгийн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1.Үндэсний зохицуулагч байгууллага энэ хуулийн 12.1, 12.2-т заасан үнэлгээний үр дүнд үндэслэн Үндэсний дасан зохицох төлөвлөгөөг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

16.4.Холбогдох төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 4.1.19, 4.1.20-д заасан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий салбар, хүн амын бүлгийн дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

16.6.Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг бүх шатны боловсролын түвшинд эзэмшүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хандлага, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “дээд шатны байгууллагад танилцуулна” гэснийг “энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх бодлого, төлөвлөлт

18.1.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг таван жил тутам шинэчлэн батална.

18.2.Урт хугацааны хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн шилжилтийн стратегийг хүлэмжийн хийн үндэсний тооллого, хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн хэтийн төлөв, төсөөлөлд үндэслэн боловсруулна.

18.3.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх төлөвлөлтийг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тодорхойлно.

18.4.Энэ хуулийн 18.2-т заасан стратеги, төлөвлөгөөнд хүлэмжийн хийг ялгаруулагч болон шингээгч салбар тус бүрээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээний хүрээ, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тусгана.

18.5.Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 8.4-т заасан чиг үүрэг, 10, 11 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт тусгаж хэрэгжүүлнэ.

18.6.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг харгалзан үзнэ.

18.7.Хувийн хэвшлийн байгууллага өөрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийг тооцох, бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийг дэмжинэ.

18.8.Үндэсний зохицуулагч байгууллага байгууллагын болон төслийн түвшний хүлэмжийн хийн ялгарлын тооцоо, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалттай холбоотой заавар, аргачлалыг баталж, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

18.9.Үндэсний зохицуулагч байгууллага уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээний гүйцэтгэлийг жил бүр үнэлж, хэрэгжилтийн тайланг боловсруулж, энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

18.10.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд институтын болон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 45

Бүгд: 93

51.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.2.Үндэсний зохицуулагч байгууллага Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн ил тод байдлын тайланг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалын дагуу боловсруулж, энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 43

Бүгд: 93

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20 дугаар зүйл.Ногоон санхүүжилт

20.1.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх, нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг ногоон санхүүжилтээр дэмжинэ.

20.2.Ногоон санхүүжилтээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөв, мөнгөний бодлого, ногоон санхүүжилтийн стратегитай нийцсэн байна.

20.3.Энэ хуулийн 20.1-т заасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтөд зардал, үр ашгийн тооцоо, нийгэм, эдийн засгийн өгөөж, төсөвт үзүүлэх нөлөөлөлд үндэслэнэ.

20.4.Ногоон санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 20.4.1.улсын болон орон нутгийн төсөв;
- 20.4.2.төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилт;
- 20.4.3.гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүний санхүүжилт;
- 20.4.4.гадаадын зээл, буцалтгүй тусламж;
- 20.4.5.байгаль орчин, уур амьсгалын сан;
- 20.4.6.хууль тогтоомжид нийцсэн бусад эх үүсвэр.

20.5.Ногоон санхүүжилтийг дараах санхүүгийн хэрэгсэл, хөшүүргийг ашиглан хэрэгжүүлж болно:

- 20.5.1.улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт;
- 20.5.2.татварын хөнгөлөлт, чөлөөлөлт;
- 20.5.3.батлан даалт;
- 20.5.4.зорилтот бонд, зээл;
- 20.5.5.төр, хувийн хэвшлийн болон олон улсын эх үүсвэртэй холимог санхүүжилт;

20.5.6.хууль тогтоомжид заасан бусад.

20.6.Энэ хуулийн 20.5-д заасан ногоон санхүүжилтийн хөшүүрэг нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Өрийн удирдлагын тухай, Татварын ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

20.7.Ногоон санхүүжилтэд хамрагдах төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа нь ногоон санхүүжилтийн шалгуур, ногоон таксономи, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын шаардлагыг хангасан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 38
Бүгд: 93
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.5 дахь хэсгийг хасаж, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.3.Ногоон санхүүжилтэд хамрагдах төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны үр дүн нь бодит, хэмжигдэхүйц, баталгаажихуйц байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3, 22.5, 22.6 дахь хэсгийг хасаж, 22.1, 22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, доор дурдсан агуулгатай тайлбар нэмэх:

“22.1.Ногоон санхүүжилтийн мэдээлэл нь ил тод, нээлттэй, нийтэд хүртээмжтэй байна.

22.4.Уур амьсгалын санхүүжилтийн мэдээллийг энэ хуулийн 19 дугаар зүйлд заасны дагуу Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн ил тод байдлын тайланд тусган тайлагнана”

Тайлбар: -Энэ хуулийн 4.1.24-т заасан уур амьсгалын санхүүжилт нь 4.1.9-д заасан ногоон санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд энэ хуульд "ногоон болон уур амьсгалын санхүүжилт" гэж дурдсан тохиолдолд уур амьсгалын санхүүжилтийг ногоон санхүүжилтэд хамааруулан ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	50
Татгалзсан:	43
Бүгд:	93

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “хэлбэртэй” гэснийг “төрөлтэй” гэж, 23.3.8 дахь заалтын “иргэдтэй урьдчилан зөвлөлдөж” гэснийг “иргэдэд төсөл, хөтөлбөрийн танилцуулга хийж,” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 23.3.7, 23.5.11, 23.6 дахь хэсгийг хасаж, 23.5.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.5.5.сааруулалтын үр дүнг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод тооцох, олон улсад шилжүүлэх эсэхийг тодорхойлсон ашиглалтын зорилго;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	51
Татгалзсан:	42
Бүгд:	93

54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “санхүүжилтээр шууд санхүүжээгүй төслөөс” гэснийг “санхүүжилтээс бусад эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төслөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	50
Татгалзсан:	43
Бүгд:	93

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	50
Татгалзсан:	43

Бүгд: 93
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “баталгаажуулалтын журмыг энэ хуулийн 8.2-т заасан байгууллага батална” гэснийг “баталгаажуулалтыг энэ хуулийн 7.1.8-д заасан журмын дагуу хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Наймдугаар бүлгийн гарчгийн “ИЛ ТОД БАЙДАЛ” гэснийг “ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ” гэж өөрчилж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “Үндэсний” гэсний өмнө “Уур амьсгалын өөрчлөлтийн” гэж нэмж, 27.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.2.Үндэсний зохицуулагч байгууллага уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, төсөл, хөтөлбөрийн үр дүн, хүлэмжийн хийн үндэсний тооллогын мэдээллийг энэ хуулийн 27.1-д заасан үндэсний мэдээллийн системд бүртгэж, түүний ашиглалт, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг ханган ажиллана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн гарчгийн “, ил тод байдал” гэснийг хасаж, мөн зүйлийн 28.2 дахь хэсгийн “хуулийн” гэсний өмнө “хуулийн 28.1-д заасан байгууллага” гэж нэмж, 28.3 дахь хэсгийн “тогтоосон хугацаанд” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “зорилтыг хангах зохицуулалттай карбон кредитийг энэ хуулийн 8.2-т заасан” гэснийг “зорилтод тооцогдох карбон кредитийг энэ хуулийн 8.3-т заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 41
Бүгд: 93
55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 43
Бүгд: 93
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 32 дугаар зүйл нэмэх:

“32 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

“32.1.Энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 7.1.9, 7.1.10-т заасан журмыг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор баталж, мөрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 42
Бүгд: 93
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 44
Бүгд: 93
52.7 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “8.3” гэсний дараа “заасан чиг үүрэг” гэж, 24.1 дэх хэсгийн “бүртгэгдсэнээр” гэсний дараа “түүнийг” гэж тус тус нэмж, 4 дүгээр зүйлийн 4.1.6, 4.1.15 дэх заалтын “зах зээлийн тогтолцоог” гэснийг “зах зээлийг” гэж, 4.1.20 дахь заалтын “мэдрэг байдал өндөр” гэснийг “эрсдэлтэй, мэдрэг байдалтай” гэж, мөн заалтын “өндөр” гэснийг “бүхий” гэж, 4.1.32 дахь заалтын “нүүрсхүчлийн хий” гэснийг “нүүрстөрөгчийн давхар исэл,” гэж, 4.1.33 дахь заалтын “экосистемийн,” гэснийг “экосистемийг ашиглах” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “санхүү, төсвийн” гэснийг “эдийн засаг, хөгжлийн” гэж, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “тогтоосон” гэснийг “хуульд заасан” гэж тус тус өөрчилж, төслийн хуулийн нэрийн “ХУУЛЬ” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.2.20, 8.3.6 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтын “бүрэн эрх” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “Салбарын болон бусад” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

1.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “өөрчлөлтийг даван туулах” гэснийг “өөрчлөлтийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 38
Бүгд: 93
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 9 дэх хэсгийн “мэдээллийн нэгдсэн” гэснийг “уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн” гэж, 2 дугаар зүйлийн “өөрчлөлтийн мэдээллийн нэгдсэн сан” гэснийг “өөрчлөлт” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 41
Бүгд: 93
55.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Хуулийн төсөл буцаах тухай” тогтоол баталсанд тооцов./21:45/

Гурав.Найруулгын санал

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчилж, төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг,

найруулгын шинжтэй засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 38
Бүгд: 93
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 21 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 18 гишүүн 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн/-ийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очир, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга Т.Балжинням, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн зөвлөх Я.Хишигт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

С.Бямбацогт: 1.Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 37
Бүгд: 93
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ойн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ойн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 42

Бүгд: 93

54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.“Ойн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 39

Бүгд: 93

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 21 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Арван дөрөв.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа нарын 46 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Туяа, мөн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч С.Жаргалсайхан, Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал Ц.Төмөр-Очир, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал М.Одгэрэл, Монголын Өрхийн эмнэлгийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирал Ш.Хажидмаа, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны ахлах мэргэжилтэн, хүний их эмч Н.Болормаа, “Гурван гал” эмнэлгийн Ерөнхий захирал Г.Пүрэвсүрэн, Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийн захирал Х.Ганцэцэг, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Л.Баярцэцэг, Хүний их эмч Д.Энхмаа, хуульч, өмгөөлөгч Г.Баатарсүрэн, Эрх зүйч Ч.Адъяалхам нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, М.Нарантуяа-Нара, М.Ганхүлэг, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Л.Баярцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, О.Саранчулуун, Б.Бейсен, М.Нарантуяа-Нара нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу ирэх “Пүрэв” гарагийн 10.00 цагт санал хураалтыг явуулахаар хойшлуулав./22:56/

Арван тав.Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Я.Жавхлан, мөн газрын ахлах референт Ч.Эрдэнэчимэг, Б.Төрбат, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын дэд захирал Б.Мөнхбаатар, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч, хуулийн зөвлөх Г.Энхболд, Тагнуулын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга А.Бат-Эрдэнэ, мөн газрын хэлтсийн дарга Б.Батмөнх, Ч.Хүдэрбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон, референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Ө.Шижир нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9-д “Илтгэл, танилцуулга сонсох, асуулт, хариулт явуулах, санал, дүгнэлт танилцуулах, санал хураах цагийг тогтоох.” гэсэн хуралдаан даргалагчийн эрх, үүргийг танилцуулж, санал хураалтыг ирэх долоо хоногийн “Пүрэв” гарагийн 10.00 цагт явуулахаар тогтов./23:25/

Арван зургаа.Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Я.Жавхлан, мөн газрын ахлах референт Ч.Эрдэнэчимэг, Б.Төрбат, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын дэд захирал Б.Мөнхбаатар, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч, хуулийн зөвлөх Г.Энхболд, Тагнуулын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга А.Бат-Эрдэнэ, мөн газрын хэлтсийн дарга Б.Батмөнх, Ч.Хүдэрбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон, референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9-д “Илтгэл, танилцуулга сонсох, асуулт, хариулт явуулах, санал, дүгнэлт танилцуулах, санал хураах цагийг тогтоох.” гэсэн хуралдаан даргалагчийн эрх, үүргийг танилцуулж, санал хураалтыг ирэх долоо хоногийн “Пүрэв” гарагийн 10.00 цагт явуулахаар тогтов./23:45/

Арван долоо.Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын

гишүүн О.Цогтгэрэл нарын 18 гишүүн 2026.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Н.Ариунболд, Б.Солонго нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон, референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Н.Ариунболд нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9-д “Илтгэл, танилцуулга сонсох, асуулт, хариулт явуулах, санал, дүгнэлт танилцуулах, санал хураах цагийг тогтоох.” гэсэн хуралдаан даргалагчийн эрх, үүргийг танилцуулж, санал хураалтыг ирэх долоо хоногийн “Пүрэв” гарагийн 10.00 цагт явуулахаар тогтов./00:05/

Арван найм.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./00:05/

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./00:06/

Дагалдан гарсан:

3.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./00:06/

Холбогдуулан боловсруулсан:

4.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./00:06/

5.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./00:06/

Уг асуудлыг 00 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 18 асуудал хэлэлцэв.

Бусад.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Эрдэнэт хотын Монгол ажилчдын нэгдсэн захиргааны “Баатар” холбооны ахмадууд, Ховд аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1985 оны төгсөгчид, мөн аймгийн ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2006 оны төгсөгчид, 3 дугаар сургуулийн 2006 оны төгсөгчид, Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид, Манхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид, Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1989 оны төгсөгчид, Архангай аймгийн Ихтамир сумын ерөнхий боловсролын сургуулийн 2001 оны төгсөгчид, мөн аймгийн Цэнхэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2001 оны төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын 72 дугаар сургуулийн 1996 оны төгсөгчид, Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2001 оны төгсөгчид, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Б.Түвшин нарын урилгаар Байлдааны гавьяаны улаан тугийн одонт, Сүхбаатарын одонт Нийгмийг аюулаас хамгаалах яамны Цэргийн дээд сургуулийн 1986 оны төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын “Монгол Билиг Оюу” сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн урилгаар Увс аймгийн Өндөрхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид, мөн аймгийн Өмнөговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын урилгаар Ховд аймгийн Жаргалант сумын “Цаст-Алтай” цогцолбор сургуулийн 2006 оны төгсөгчид, Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2006 оны 10^г ангийн багш, төгсөгчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 13 цаг 29 минут үргэлжилж, 126 гишүүнээс 98 гишүүн хүрэлцэн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 00 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БЯМБАДУЛАМ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2026 оны 06 дугаар сарын 19-ний өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 03 минут*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Эхлээд зочин танилцуулчихъя. Гарах гээд байх шиг байна. Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар, түр байж байгаарай одоохон танилцуулаадахъя. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө 40 жилийн ойг тэмдэглэж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэе. Гишүүд суучих уу.

2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн “Баасан” гаргийн чуулганы нэгдсэн хуралдааны ирц ирвэл зохих 126-аас 64 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Чуулганы нэгдсэн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлуудын тухай мэдээлэл гишүүддээ өгье.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд энэ өдөр хэлэлцэх ёстойгоосоо хойшилж байна.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаас хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааныг хэлэлцэх асуудлаас хасагдсан.

Хоёрдугаарт, “Хянан шалгах түр хороо байгуулагдах” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 06 дугаар сарын 17-ны өдөр хуралдааны явцад тогтоолын төслийг хэлэлцэхийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдаанаас хасагдсан байна. Бусад товлогдсон асуудлууд хэлэлцэгдэнэ.

Төрсөн өдөр нь тохиож байгаа гишүүдийг танилцуулъя. 06 дугаар сарын 19-нд Улсын Их Хурлын гишүүн Хажекберийн Жангабыл, Хассуурийн Ганхуяг нар төржээ Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг нар төржээ Улсын Их Хурлын гишүүн Хажекберийн Жангабыль, Хассуурийн Ганхуяг нарт төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Лутаагийн Энхнасан, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Мягмардашийн Сарнай нарын гишүүд хамгийн эртэч гишүүд болж ирцдээ орсон байна. Та бүхэндээ бас баяр хүргэе.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайханы урилгаар Элчин сайдын яам, хөгжлийн түнш байгууллагуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Монгол Улсын Засгийн газар, Сангийн яамны хөгжлийн түнш байгууллагуудын төлөөлөл Монголд бас чуулсан байгаа. Энэхүү арга хэмжээг бас зохион байгуулсан манай Сангийн яамныхан, түүн дундаас Дэлгэржаргал даргадаа энд ир харагдаж байна. Та бүхэнд бас Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар дараах 18 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт нь хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийт 5 төсөл байгаа. Гишүүд танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хоёрдугаарт нь Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Гуравдугаарт нь Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Үргэлжлүүлнэ.

Дөрөвдүгээрт нь Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Тавдугаарт нь Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Зургаад нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Долоод нь Гэр бүлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Наймд нь Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Есдүгээрт нь Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Аравдугаарт нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Арван нэгд нь Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Арван хоёр.Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Арван гуравд нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна.

Арван дөрөвд нь Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Арван тавд нь Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар өргөн мэдүүлсэн.

Арван зургаад нь Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна Засгийн газар өргөн мэдүүлсэн.

Арван долоод нь Төрийн нууцын тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын 18 гишүүн өргөн мэдүүлсэн.

Арван наймд нь баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно гэсэн ийм асуудлуудыг өнөөдөр хэлэлцэх нь.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Үүний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал нарын 19 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд. Энэ аж үйлдвэр болон худалдаа дахь хөдөлмөрийн хяналтын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 81 дүгээр конвенц юм байна.

Гуравдугаарт нь Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд. Хөдөө аж ахуй дахь Хөдөлмөрийн хяналтын тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 129 дүгээр конвенц юм байна.

Дөрөвдүгээрт нь Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026 оны 06 дугаар сарын 18-ны өд өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд. Энэ нөгөө тамхины онцгой албан татвар тогтоох тухай асуудал байгаа.

Тавдугаарт нь Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд тус тус хуваариллаа. Та бүхэндээ мэдэгдэж байна. Хэлэлцэх асуудалдаа орёё.

Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд болон Хөдөө аж ахуйн тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Хуулийн төслүүдийн эцэслэн батлах хувилбарыг холбогдох Байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Ирц бүртгэлийн санал хураалт. Чуулганы танхимд хүрэлцэн ирж амжаагүй байгаа, орж ирээгүй байгаа гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Одоогоор ирц бүртгэлд, ирцэд бэлэн, санал хураалтад бэлэн болсон 57 гишүүн байна. Бид нар хуулийн төслүүдийг 64 гишүүнээс дээш эцэслэн батлах ёстой. Ирцэд орсон 74 гишүүн байгаа. Тийм болохоор ирцэд орчхоод өрөө рүүгээ явсан гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Зочин танилцуулъя. Ихтамираас мөн үү? Мөн юм шиг байна. Манай Архангайн гишүүд байна уу Мөнхтулга, Тэмүүлэн гишүүд? Зочин танилцуулъя. Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1989 оны төгсөгчид, Архангай аймгийн Ихтамир сумын ерөнхий боловсролын сургуулийн 2001 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа төгсөгч, төгсөлтийн баяраа тэмдэглэж та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Одоо ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Түр байж байгаарай. Жаргалан гишүүн суудлаа эзлээдэхье. Ирц бүртгэлийн санал хураалт. Ирц бүртгэл өглөө ирцдээ орчхоод танхимд орж ирээгүй гишүүд Алтанхуяг, Амгаланбаатар, Саранчулуун, Баатархүү, Тулга, Батсуурь, Цогтбаатар Да, Баярбаатар, Цогтгэрэл, Ганхуяг, Баярбаатар байна. Сая Баярбаатар гишүүн Улс төр судлалын доктор болсон шүү нээрээ. Дипломоо гардаж авсан. Баярбаатар гишүүндээ бас Монгол Улсын Их Сургуулийн улс төр судлалын докторын диплом дөнгөж сая гардаж авсан. Эрдэнэболд гишүүн алга байна. Ганхуяг, Отгонбаяр, манай Очирбат гишүүд байгаа мөртөө эсрэг гарсан байна сая яагаагүй юм шиг байна.

Хуулийн төслүүдийг эцэслэн батлах хувилбарыг холбогдох Байнгын хороонд бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Улсын нисэхийн тухай.

Санал хураалтад 81 гишүүн оролцсоноос 72 гишүүн буюу 88 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн

Улсын нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

81 гишүүн санал хураалтад оролцсоноос 71 гишүүн бол 87 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

81 гишүүнээс 72 буюу 88 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

81-ээс 71 буюу 87 хувийн саналаар энэ дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

81-ээс 71 буюу 87 хувийн саналаар эцэслэн батлагдлаа

Улсын нисэхийн тухай хууль болон Хөдөө аж ахуйн тухай хууль, Ерөнхийлөгчийн тухай хуулийн боловсруулсан, ажлын хэсэгт нь ажилласан хуулийн төслийг эцэслэн баталсан нийт гишүүддээ талархлаа илэрхийлье. Дараагийн асуудалд оръё

10.21 цаг.

Хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасан.

Үүний дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

2.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хурал тус тус өргөн мэдүүлсэн.

Одоо хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдье гишүүд ээ. Гишүүд ээ санал хураалт явуулъя.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 83 гишүүн оролцож, 67 гишүүн буюу 80 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ

2.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 83 гишүүн орсноос 69 гишүүн буюу 83 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул холбогдох Байнгын хороонд шилжүүлээ.

Зочин танилцуулъя. Архангай аймгийн Цэнхэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2001 оны төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын 72 дугаар сургуулийн 1996 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийн баяраа тэмдэглэж, Төрийн ордонтой танилцаж байгаа эрхэм зочдодоо Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Архангайнхан босоод байна уу гээд. Дараагийн асуудалдаа оръё.

10.23 цаг.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ. Үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагч илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Пунсалмаа гишүүн, Баатархүү гишүүн нарын бэлэн болоогүй байх шиг харагдаж байна. Шижир гишүүн, Эрдэнэболд гишүүн санал хураалт явуулъя.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

85 гишүүнээс 72 гишүүн буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн 10 хуулийн төсөл байгаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 73 гишүүн буюу 85 хувийн саналаар санал дэмжигдлээ

3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 72 буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ

4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 72 буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 72 буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 73 буюу 85 хувийн саналаар санал дэмжигдлээ

7.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 73 буюу 85 хувийн саналаар санал дэмжигдлээ

8.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 72 буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ

9.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээний хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 71 буюу 83.5 хувийн саналаар санал дэмжигдлээ

10.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 70 буюу 82 хувийн саналаар санал дэмжигдлээ

11.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 71 буюу 83 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болох хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

10.30 цаг.

Зочин танилцуулъя. Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа,

Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө 20 жилийн ойг тэмдэглэж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Өвөрхангайчууд босоод эхэллээ шүү. Манай Алтангэрэл гишүүн бол нисээд очих гээд байх шиг байна шүү дээ ер нь. Дараагийн асуудалдаа оръё.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт ,хууль санаачлагч илтгэл болон хуулийн төсөл үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт явуулъя.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

85-аас 71 буюу 83 хувийн саналаар санал санал дэмжигдлээ. Хамт өргөн мэдүүлсэн 12 хуулийн төсөл байгаа.

Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өр оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

86-аас дал буюу 81 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор. Санал хураалт явуулъя.

86-аас 70 буюу 81.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор. Санал хураалт явуулъя.

86-аас 73 буюу 84-ийн саналаар санал дэмжигдлээ

5.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлал хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 66 буюу 76-гийн саналаар санал дэмжигдлээ.

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 74 буюу 86-гийн саналаар санал дэмжигдлээ.

7.Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 71 буюу 82 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 73 буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 86-аас 74 гишүүн буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 76 буюу 88 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 73 буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 72 буюу 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

86-аас 71 буюу 82 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ. Дараагийн асуудалдаа оръё.

10.36 цаг.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлцлүүдийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалын холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлтгэсэн үү? Санал хураалт явуулъя.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

86 гишүүнээс 69 гишүүн буюу 80 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцогчдын олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ. Дараагийн асуудалд оръё.

10.37 цаг.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй.

Алтанхуяг гишүүн санал хураалтад бэлдсэн үү та.

Зочин танилцуулъя. Ховд аймгийн Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай сумынхан байна. Би Чандмань суманд 8 дугаар анги төгссөн. Харин тийм манай баруун бүсийнхэн бүгд ажлаа сайн хийж байгаа. Тэгээд тэн дундаа Ховдынхон гээд.

Санал хураалтдаа гишүүд бэлдсэн. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “цэргийн” гэсний дараа “албаны офицер, ахлагч,” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 74 гишүүн буюу 86 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг. Санал хураалт.

Санал хураалтад 86 гишүүн орсноос 73 гишүүн буюу 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

10.41 цаг.

Дараагийн асуудалдаа орёе. Нэг босоод сайхан суниачхаад суувал яаж байна гишүүд ээ. Бас овоо хэдэн санал хураалт. 60 санал хураалт байгаа шүү дээ. Гишүүд ээ гарч явахгүй шүү. 60 санал хураалт байгаа шүү. Бүгдээрээ сууцгаана шүү. Суниагаад сууя гэсэн болохоос гараад яв гээгүй шүү.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо Байнгын хорооноос санал хураахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Гишүүд хуруугаа уншуулаарай. Алтанхуяг гишүүн та ирцдээ ороогүй байна. Хуруугаа уншуулаагүй байна. Сайд нар бас байгаа биз? Засгийн газраас өргөн барьсан хууль. Манай Алтангэрэл нарын гишүүд маш олон хоног өдөр, шөнөгүй, хагас, бүтэн сайнгүй, нойр, хоолгүй ажилласан. Гэр бүлийн хууль олон жил, 16 оноос хойш Гэр бүлийн хуулийг шинэчлэх гэж үндсэндээ 10-аад жил шинэчилж чадаагүй явсан хууль байгаа. Тийм ээ Алтангэрэл гишүүн ээ? 2 эхнэртэй, 2 нөхөртэй байж гэж үү? Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Сайнзориг гишүүн ээ. Саналаа өгч амжаагүй дотор байгаа гишүүд Ерөнхий сайд байна. Сайнзориг гишүүн байна. Өшөө? Алтанхуяг гишүүн та бас дотор байгаа саналаа өгөөгүй байна. Бүгдийг нь хэлж байна. Сайд нар Батлут сайд, Мэндсайхан сайд өөр хэн байна? Аубакир сайд байна уу? Байна.

Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь хүүхэд, гэр бүлийн гишүүний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гэрлэлт, гэрлэлт дуусгавар болох, гэр бүлийн гишүүдийн хөрөнгийн эрх, үүрэг, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхэд үрчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл, Ариунзаяа, Мөнхбаясгалан, Номинчимэг, Алдаржавхлан, Баярбаатар, Ганмаа, Жаргалан, Одонтуяа, Отгонбаяр, Пүрэвдаваа, Сайнзориг, Соронзонболд, Тэмүүжин, Үүрийнтуяа, Хэрлэн, Баасанжаргал, Хосбаяр. Цаашид “Ажлын хэсэг” гэж нэрлэнэ. Ажлын хэсгийн гишүүдээс яг сая орж ирчхээд явсан гишүүд хэн байна? Жаргалан гишүүн алга байна. Пүрэвдаваа гишүүн алга байна. Бусад нь байна. Ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа. Олон хоног ажилласан шүү бас. Саяын нэр дурдсан гишүүд бол олон хоног, хагас, бүтэн сайнгүй, өдөр, шөнөгүй ажиллаж энэ хуулийг гаргаж байгаа. Тэгээд хэдүүлээ бас энэ хүний хөдөлмөрийг үнэлээд дэмжээд явчих нь зөв байх. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 88 гишүүн орсноос 62 гишүүн буюу 70 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийн “, амар тайван,” гэснийг “бөгөөд” гэж, 3.6 дахь хэсгийн “хүүхэд,” гэснийг “хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах бөгөөд” гэж өөрчилж, 3.8 дахь хэсгийг хасаж, 3.2, 3.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“3.2.Гэр бүлийн гишүүд гэр бүлийн харилцаанд эрх тэгш байдлыг хангаж, гэрлэгчид гэр бүлийн гишүүдийн өмнө хамтын үүрэг, хариуцлага хүлээнэ.

3.3.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь гэр бүлийн харилцаанд хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаална.”. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

88-аас 63 гишүүн буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“асран хамгаалах” гэж энэ хуулийн 54.1-д заасан хүүхдийн, эсхүл хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хэлбэрийг;

4.1.2.“бүтэн өнчин хүүхэд” гэж дараах хүүхдийг:

4.1.2.а.эцэг, эх нь тогтоогдоогүй;

4.1.2.б.эцэг, эх нь нас барсан;

4.1.2.в.эцэг, эхийг нь нас барсан гэж зарласан, эсхүл сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

4.1.2.г.эцэг, эхийг нь иргэний эрх зүйн чадамжгүй, бүрэн чадамжгүй гэж тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

4.1.2.д.эцэг, эхийнх нь эцэг, эх байх эрхийг хязгаарласан шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол тухайн шийдвэрт заасан хугацаанд;

4.1.2.е.эцэг, эхийнх нь эцэг, эх байх эрхийг хассан шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол уг шийдвэрийг хүчингүй болсонд тооцох хүртэл;

4.1.2.ё.эцэг, эхийн хэн нэг нь тодорхойгүйн улмаас эцэг, эсхүл эхтэйгээ амьдарч байгаад эцэг, эсхүл эх нь нас барсан, эсхүл энэ хуулийн 4.1.2.в, 4.1.2.г, 4.1.2.д, 4.1.2.е-д заасан шүүхийн шийдвэрээр эрх зүйн байдал нь өөрчлөгдсөн бол;

4.1.2.ж.гэрлэлт цуцалсны улмаас асрамждаа авсан эцэг, эсхүл эх нь нас барсан, эсхүл энэ хуулийн 4.1.2.в, 4.1.2.г, 4.1.2.д, 4.1.2.е-д заасан шүүхийн шийдвэрээр эрх зүйн байдал нь өөрчлөгдсөн бөгөөд тусдаа амьдарч байсан эцэг, эсхүл эх асрамждаа аваагүй бол.

4.1.3.“гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр хүний тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэн гэр бүл болох хүсэл зоригоо харилцан илэрхийлж, улсын бүртгэлд бүртгүүлэхийг;

4.1.4.“гэрлэгчид” гэж гэр бүлийн харилцаанд тэгш эрх эдэлж, хамтын үүрэг хүлээхээр гэрлэлтээ улсын бүртгэлд бүртгүүлсэн нөхөр, эхнэрийг;

Энхэр нь урд нь байлгахгүй нөхрийг нь урд нь тавьдаг юм уу?

4.1.5.“гэр бүл” гэж гэрлэлт, төрөлт, үрчлэлтийн үр дүнд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүргээр холбогдсон гэр бүлийн гишүүдийг;

4.1.6.“гэр бүлийн гишүүн” гэж дараах хүнийг:

4.1.6.а.гэрлэгчид;

4.1.6.б.гэрлэгчдийн хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд;

4.1.6.в. гэрлэгчдийн хамт амьдарч байгаа төрөл, садангийн хүн.

4.1.7.“нөхөн үржихүйн туслах аргыг ашиглаж хүүхэдтэй болох” гэж Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу бэлгийн эс ашиглаж, эсхүл тээгч эхээр дамжуулан хүүхэдтэй болохыг;

4.1.8.“овог” гэж нэг өвөг дээдсээс гаралтай эцэг /эх/-ийн талын холбоо бүхий бүлэг хүмүүсийн дунд үе уламжлан хэрэглэгддэг нэрийг;

4.1.9.“садангийн хүн” гэж тухайн хүний төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг;

4.1.10.“сонирхогч тал” гэж 14 насанд хүрсэн хүүхэд, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, албан тушаалтныг;

4.1.11.“төрлийн хүн” гэж тухайн хүний эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач, зээ, эсхүл ач, зээгийн хүүхдийг;

4.1.12.“үрчлэлт” гэж шүүхийн шийдвэрийн дагуу хүүхдийг үрчлэн авсан эцэг, эх болон үрчлүүлсэн хүүхдийн хооронд төрсөн эцэг, эх, хүүхдийн нэгэн адил эрх, үүрэг, хариуцлага үүсгэхээр улсын бүртгэлд бүртгүүлснийг;

4.1.13.“харгалзан дэмжих” гэж энэ хуулийн 54.2-т заасан хүүхдийн, эсхүл хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хэлбэрийг;

4.1.14.“хүүхэд” гэж 18 насанд хүрээгүй хүнийг. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Ховд аймгийн ерөнхий боловсролын 10 жилийн 1 дүгээр сургуулийн 1985 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Манай Ховдынхонд сая бид нар, гэр бүл, аав, ээж, авгай, нөхөр юу билээ. Их хамаатан садан гээд бүгдийг нь заачихлаа шүү бас. Гэр бүлийн тухай хуулийн нэр томьёоны тодорхойлолтыг.

4.Төслийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.6, 5.7 дахь хэсгийг хасаж, 5.3, 5.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.3.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө бэлгийн замаар дамжих халдвар болон хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолын өвчтэй талаар харилцан мэдээлэлтэй байх зорилгоор эрүүл мэндийн шинжилгээ өгч, тодорхойлолт гаргуулан авна.

5.4.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө хоорондоо төрөл, садангийн холбоотой эсэхээ мэдэх зорилгоор дезоксирибонуклейн хүчил /ДНХ/-ийн удам зүйн шинжилгээнд хамрагдаж болно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 90 гишүүн орсноос 58 гишүүн буюу 64 саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 8 дугаар зүйл болгох.

“8 дугаар зүйл.Гэрлэлтийн бүртгэл

8.1.Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангасан гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ 18 насанд хүрсэн гэрчийн этгээдийг байлцуулан бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

8.2.Гэрлэлтийг бүртгэсэн өдрөөс эхлэн гэрлэгчдийн хооронд энэ хуульд заасан эрх, үүрэг үүснэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

90-ээс 58 буюу 64-ийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төсөлд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмэх.

“6 дугаар зүйл.Гэрлэхийг хүсэгчдэд өгөх зөвлөгөө, сургалт

6.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага анх удаа гэрлэхийг хүсэгчдэд гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө гэр бүлийн харилцаа, гэр бүлийн гишүүдийн эрх, үүрэг, хариуцлага, хүүхдийн эрх, хөгжил, хүмүүжил, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн маргааныг харилцан ойлголцол, зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэх чиглэлээр гэр бүлийн боловсрол олгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан гэр бүлийн боловсролын сургалтын агуулга, хэлбэр, зохион байгуулалт, хугацаа, сургалтад хамруулах журмыг боловсролын болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалзан Засгийн газар батална.

6.3.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага энэ хуулийн 6.1-д заасан сургалтыг иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулж болно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

90-ээс 54 буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 7 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

90-ээс 56 буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 7 дугаар зүйл болгох:

“7 дугаар зүйл.Гэрлэхэд харшлах шалтгаан

7.1.Гэрлэхэд дараах нөхцөл харшилна:

7.1.1.өмнөх гэрлэлт хүчинтэй;
7.1.2.гэрлэхийг хүсэгчид хоёулаа, эсхүл хэн нэг нь 18 насанд хүрээгүй;

7.1.3.гэрлэхийг хүсэгчид хоорондоо төрөл, садангийн холбоотой;
7.1.4.гэрлэхийг хүсэгчид хоорондоо үрчлэгч, үрчлүүлэгчийн харилцаатай;

7.1.5.гэрлэхийг хүсэгчид хоорондоо асран хамгаалагч, асран хамгаалуулагч, эсхүл харгалзан дэмжигч, харгалзан дэмжүүлэгчийн харилцаатай;

7.1.6.гэрлэхийг хүсэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон;

7.2.Иргэний хуульд заасны дагуу насанд хүрээгүй хүнийг иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцсон бол энэ хуулийн 7.1.2-т заасан харшлах нөхцөлд хамаарахгүй.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 64 саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 9 дүгээр зүйлийн 9-ийн. Алтангэрэл ажлын хэсгийн ахлагч микрофон өгье.

О.Алтангэрэл: Энэ 9 дүгээр санал дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя. Тэгээд ер нь бас урьдчилаад хэлэхэд энэ Гэр бүлийн тухай хууль болон дагалдах хуулиудын төслүүд дээр нийт 30 орчим ийм санал дээр гүйцээн боловсруулах чиглэл авах юм. Энэ ямарваа алдаа гарсан гэсэн үг биш. Ер нь дахиж сайн хяная. Бас богино хугацаанд их шахуу ажилласан учраас дахиад бас 5 хоногийн хугацаатай харъя гээд ажлын хэсгээрээ хуралдахдаа тохироод тэгээд энэ 30 орчим саналыг гүйцээн боловсруулах чиглэл авъя гэдэг санал гаргаж байгаа юм.

Тэгээд энэ 9 дүгээр зүйлээс, 9 дүгээр саналаас эхэлж байна. Тэгээд гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү.

С.Бямбацогт: 9-өөс эхлээд хэд хүртэл юм? Тухай тухай бүрд нь яах юм уу тээ? За.

9 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн ахлагч Алтангэрэл гишүүн гүйцээн боловсрох чиглэл өгсөн учраас гүйцээн боловсрох чиглэл өглөө.

10.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 9.3 дахь хэсэг болгох.

“9.3.Энэ хуулийн 9.2.3-т заасан угийн бичиг хөтлөх журмыг хууль зүй, соёлын болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалзан Засгийн газар батална.”. Дэмжье гэсэн томъёолол санал хураалт.

Санал хураалтад 90 гишүүн орсноос 50 гишүүн буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Ховд аймгийн ерөнхий боловсролын 2 дугаар 10-н жилийн сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа, төгсөлтийн 20 жилийн ойгоо тэмдэглэж байгаа дүү нартаа Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Уучлаарай тэгээд бас манай гавьяат жүжигчин Гомбо-Очир нарын төгсөгчид байна. Манай сургуулийнхан байна шүү. 10 дугаар ангиа энэ сургууль төгсжээ. Дараад нь танилцуулна. 10 дугаар зүйл.

11.Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

10 дугаар зүйл.Гэрлэлт дуусгавар болох. Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Гүйцээн боловсруулах чиглэл авъя дарга.

С.Бямбацогт: 10 дугаар, 11 дэх санал хураалт гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

12.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Гэрлэлтийг захиргааны журмаар цуцлах

12.1.Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, 18 хүртэлх насны хүүхэдгүй, хөрөнгийн маргаангүй бол Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1, 8.2-т заасны дагуу хүсэлтээ гаргаж, гэрлэлтээ захиргааны журмаар цуцлуулна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Чехийн зочдод хүлээж байгаарай. Юу нь гарахгүй байна шүү дээ.

Санал хураалтад 90 гишүүнээс 57 гишүүн 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Танилцуулга нь хаа байна? Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд болон Чех улсаас хүрэлцэн ирсэн Үндэсний төв музейн захирал нар Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаа танилцаж байна. Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

13.Төслийн 13 дугаар зүйлийг доор тусад нь өөрчлөн найруулах:

13 дугаар зүйл. Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Гүйцээн боловсруулах чиглэл авъя дарга.

С.Бямбацогт: Гүйцээн боловсруулах чиглэл өглөө 13 дахь санал.

14.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “тохиолдолд” гэснийг “нөхцөлд” гэж, “цуцалж болно” гэснийг “цуцална” гэж, 14.1.1 дэх заалтын “гишүүдийн” гэснийг “гишүүний” гэж, 14.1.3 дахь заалтын “эд хөрөнгийн” гэснийг “хөрөнгийн” гэж тус тус өөрчилж, 14.1.1 дэх заалтын “байнгын” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 90 гишүүн орсны 57 гишүүн буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн. Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Гүйцээн боловсруулах чиглэл авъя.

С.Бямбацогт: 15 дугаар санал гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

16.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “8 дугаар зүйлд” гэснийг “7 дугаар зүйлд” гэж өөрчилж, мөн зүйлийн “Тайлбар”-ыг хасаж, 16.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.Гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл гуравдагч этгээд гэрлэгчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл хууль бус бусад арга хэрэглэсний улмаас гэрлэлт бүртгүүлсэн нь тогтоогдсон бол шүүх гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцно.”. Санал гарсан ажлын хэсэг. Санал хураалт.

90-ээс 57 буюу 63 санал санал дэмжигдлээ.

17.Төслийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “дахин” гэснийг 17.1 дэх хэсгийг тус тус хасах. Санал хураалт.

91-ээс 55 буюу 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18.Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл.Гэрлэлт сэргээх

18.1.Гэрлэлт цуцлуулсан талууд эвлэрснээ хамтран илэрхийлж, хүсэлт гаргасан бөгөөд өөр хүнтэй гэрлэлт бүртгүүлээгүй, талууд өөрөөр тохиролцоогүй бол улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж сэргээх бөгөөд гэрлэлтийг сэргээсэн өдрөөс эхлэн тооцно.

18.2.Гэрлэгчид энэ хуулийн 18.1-д заасан гэрлэлт сэргээх хугацааны талаар харилцан тохиролцоонд хүрээгүй бол шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлж болно.

18.3.Шүүхийн шийдвэрээр нас барсан гэж зарлагдсан, эсхүл сураггүй алга болсон гэж тооцогдсон хүн эргэж ирэн нөхөр, эсхүл эхнэртэйгээ хамтран амьдрах хүсэлтээ гаргасан бөгөөд нөхөр, эсхүл эхнэр нь өөр хүнтэй гэрлэлтээ бүртгүүлээгүй бол талуудын зөвшөөрснөөр шүүх гэрлэлтийг сэргээх бөгөөд анх гэрлэлтээ бүртгүүлсэн өдрөөс эхлэн тооцно.”. Санал хураалт.

91-ээс 57 гишүүн буюу 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “20.1-д” гэснийг “19.1-д” гэж “хуульд” гэснийг “хуулийн 129.8-д” гэж өөрчилж, 20.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“20.1.Энэ хуулийн 19.1-д заасан шүүхийн шийдвэрийг улсын бүртгэлийн байгууллага бүртгэснээр гэрлэлтийг анх гэрлэлтээ бүртгүүлсэн өдрөөс эхлэн тооцно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

91-ээс 53 буюу 58 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

20.Төслийн 21 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“21 дүгээр зүйл.Гэрлэлтийн бүртгэлгүй хамтын амьдралаас үүсэх хөрөнгийн харилцаа

21.1.Дараах нөхцөл бүгд хангагдсан тохиолдолд гэрлэлтээ бүртгүүлээгүй хамтран амьдрагчдын хамтын амьдралын хугацаанд бий болсон эд хөрөнгийн эрхийн талаарх маргааныг Иргэний хуулийн 129, 130, 131-д заасны дагуу шүүх шийдвэрлэнэ:

21.1.1.хамтран амьдрагчид өөр хүнтэй гэрлэлт бүртгүүлээгүй байх;

21.1.2.таваас доошгүй жилийн хугацаанд тасралтгүй хамтран амьдарсан байх;

21.1.3.хөрөнгө хамтран өмчилж байгаа, хамтын амьдралын хугацаанд хөрөнгө бий болсон;

21.1.4.хамтран амьдрагчид нэг оршин суух хаягт бүртгэлтэй байх;

21.2.Хамтран амьдрагчдын хооронд өв залгамжлах эрх үүсэхгүй бөгөөд хамтын амьдрал дуусгавар болсон тохиолдолд бие биеэ тэжээн тэтгэх үүрэггүй.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Зочин танилцуулъя. Манай Уянгахишиг гишүүн, Доржханд сайд 2 ойрхон явчхаад. Зочин танилцуулъя. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2001 оны төгсөгчид болон Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа, төгсөлтийн баяраа хийж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын Гэр бүлийн тухай хууль хэлэлцэж байгаа, их чухал хууль хэлэлцэж байгаа бид бүхэн.

91 гишүүнээс 57 гишүүн 62 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн байна.

22.Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах. 21 үү?

21.Төслийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийн “бусад” гэснийг “бус гэж” өөрчилж, 23.1.1, 23.2.1, 23.2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.1.гэрлэгчдийн байнга оршин сууж амьдарч байгаа орон байрнаас бусад гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн эрх, үүргийг хуваарилах;

23.2.1.эд хөрөнгийн бус харилцаа, гэрлэгчдийн амины эрх;

23.2.6.гэрлэгчдийн байнга оршин сууж амьдарч байгаа орон байрны эзэмших, ашиглах, өмчлөх эрхийг хязгаарласан.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

51 гишүүнээс, 91 гишүүнээс 51 буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Ажлын хэсгийн ахлагч Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: 22 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя.

С.Бямбацогт: 22-ыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

23.Төслийн 27 дугаар зүйлийн 27.3, 27.4 дэх хэсгийн “үр хөврөлийн” гэснийг “бэлгийн эсийн” гэж, 27.4 дэх хэсгийн “тээгч эмэгтэй” гэснийг “тээгч эх” гэж, 27.5 дахь хэсгийн “Тээгч эмэгтэйн” гэснийг “Тээгч эх” гэж тус тус өөрчилж, 27.1, 27.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.1.Гэрлэгчид нөхөн үржихүйн туслах аргыг ашиглаж хүүхэдтэй болох талаар харилцан зөвшилцөж, хамтын шийдвэр гаргасан байна.

27.2.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн 15.7-д заасан гэрээ байгуулсны үндсэн дээр нөхөн үржихүйн туслах аргыг ашиглан хүүхэдтэй болсон гэрлэгчид гэрээний дагуу төрсөн хүүхдийн эцэг, эх байх бөгөөд тухайн хүүхдийг тэдгээрийн төрсөн хүүхэд гэж үзнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн орсон 50 гишүүн буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ. Дэлгэрсайхан гишүүн ээ, сайд аа.

24.Төслийн 28, 32, 35 дугаар зүйлийг нэгтгэж доор дурдсанаар өөрчлөн найруулж 28 дугаар зүйл болгох:

**“28 дугаар зүйл.Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг
төлөөлөх, хамгаалах**

28.1.Эцэг, эх хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хүн, хуулийн этгээдийн өмнө итгэмжлэлгүйгээр төлөөлж, хамгаална.

28.2.Эцэг, эх, эсхүл хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч 14 насанд хүрээгүй хүүхдийнхээ өмнөөс хэлцэл хийх, 14-18 насны хүүхдэд насанд хүрээгүй иргэн хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцэл хийх тохиолдолд бичгээр зөвшөөрөл олгох, хүүхдийг иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцогдох хүртэлх хугацаанд түүний хөрөнгийг хамгаалах үүрэгтэй.

28.3. Булгаа. За ойлголоо. Бүтэн өнчин, эсхүл эцэг, эх нь хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах боломжгүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн бол хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, албан тушаалтан, хүүхдийн суралцдаг сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага хамгаална.

28.4.Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчигдсөн бол эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, албан тушаалтан хуульд заасны дагуу шүүхэд нэхэмжлэл гаргах үүрэгтэй.

28.5.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хоорондоо зөрчилдөж байгааг тогтоосон бол сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах эрх бүхий төлөөлөгчийг томилж болно.

28.6.Энэ хуулийн 28.5-д заасан хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах этгээдээр Хүүхэд хамгааллын тухай хуулийн 47.1-д заасан хүүхэд хамгааллын үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн хүн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдийг, эсхүл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 22.5-д заасан итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилно.

28.7.Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон, үүргээ биелүүлээгүй эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон гэр бүлийн бусад гишүүдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн орсон 49 гишүүн буюу 53 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Эрдэнэт хотын Монгол ажилчдын нэгдсэн захиргааны “Баатар” холбооны ахмадууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, амьдралын сайн сайхан бүхнийг Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

25.Төслийн 29 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29 дүгээр зүйл.Эцэг, эх, хүүхдийн хоорондын эрх, үүрэг

29.1.Хүүхэд гэр бүлийн дотор тэгш эрх эдэлнэ.

29.2.Хүүхэд гэр бүлийн орчинд амьдрах, эрүүл, аюулгүй өсөж, хүмүүжих, асран хамгаалуулах, тэжээн тэтгүүлэх, сурч боловсрох, хөгжих, эцэг, эхийн анхаарал халамжид байх, өөрт хамаарах асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх, эд хөрөнгө эзэмших, ашиглах, өмчлөх, өв залгамжлах эрхтэй.

29.3.Шүүхийн шийдвэрээр эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, эсхүл хасуулснаас бусад тохиолдолд хүүхэд эцэг, эхтэйгээ амьдрах, эцэг, эсхүл эх, эсхүл тэднээс тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх эрхтэй.

29.4.Хүүхэд төрснөөр, хүүхдийг үрчлэн авснаар эцэг, эх, хүүхдийн хооронд эрх, үүрэг, хариуцлага үүснэ.

29.5.Дагавар хүүхэд хойд эцэг, эхийн хооронд эцэг, эх, хүүхдийн эрх, үүрэг, хариуцлага үүснэ.

29.6.Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхийн дундаас төрсөн хүүхэд нь гэрлэлтээ бүртгүүлсэн гэрлэгчдээс төрсөн хүүхдийн адил эрх эдэлнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

91-ээс 52 гишүүний 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “харгалзан дэмжигч” гэсний дараа “тухайн насанд хүрээгүй” гэж, 30.2 дахь хэсгийн “эцэг, эх хоёулаа” гэсний дараа “эцэг, эх,” гэж, “эцэг, эхийг” гэсний өмнө “тухайн насанд хүрээгүй” гэж, “томилно.” гэсний өмнө “харгалзан дэмжигч” гэж тус тус нэмж, 30.1 дэх хэсгийн “тэдний” гэснийг “тэдгээрийн” гэж, “эцэг, эхийн” гэснийг “эцэг, эх” гэж, 30.2 дахь хэсгийн “шалтгаанаар” гэснийг “шалтгааны улмаас” гэж, “хорооны” гэснийг “дүүргийн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

91-ээс 48 буюу 52 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

27.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.3.8 дахь заалтын “хүүхдээ” гэсний дараа “өөрийгөө болон бусдыг” гэж нэмж, 31.3 дахь хэсгийн “эх,” гэснийг “эх нь” гэж,

31.3.4 дэх заалтын “эд хөрөнгийг” гэснийг “хөрөнгийг” гэж тус тус өөрчилж, 31.2 дахь хэсгийг болон 31.3.12.

Гишүүд ээ, ирц жаахан сулраад байна. Манайхан жахаан хариуцлагатай байж байгаад яачихъя тэгэх үү.

“эд хөрөнгийг” гэснийг “хөрөнгийг” гэж тус тус өөрчилж, 31.2 дахь хэсгийг болон 31.3.12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.2.Эцэг, эх нь хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалж, энэ хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, эсхүл хасуулсан, эсхүл эцэг, эхийн хэн нэгэнд нь дангаар хэрэгжүүлэх хүүхдийн асрамж тогтоосноос бусад тохиолдолд хүүхэдтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн саналыг харгалзан хамтын шийдвэр гаргана.

31.3.12.хүүхдийг үе тэнгийн дээрэлхэлт үйлдэхээс болон түүнд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах;”. Санал гаргасан ажлын хэсэг.

Одонтуяа гишүүн, ажлын хэсгийн гишүүн үг хэлье.

С.Одонтуяа: Энэ 31.3.12 дээр ийм тусгайлан бүр заалт оруулж өгч байгаа. Та бүхэн мэдэж байгаа сүүлийн үед нийгмийг сэртхийлгэсэн ийм хэргүүд ар араасаа гарсан. Ингээд Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гараад ажлын хэсгээс энэ бүр эцэг, эхийн үүрэг, хариуцлагад энэ заалтыг ингэж бүр оруулж өгч байгаа юм.

Мэдээж бусад хуулиудад бас оруулна. Тийм учраас энэ их чухал заалт оршиж байгаа шүү манай бас Их Хурлын гишүүд бүгд мэдээд аваарай гэж байгаа. Тэгэхээр цаашид үе тэнгийн дээрэлхэлтэй холбоотой асуудлыг эцэг, эх өөрөө урьдчилан сэргийлэх, хамгаалах үүргийг хүлээж байна гэсэн үг.

С.Бямбацогт: Ер нь их чухал хууль хэлэлцэж байгаа. Манай гишүүд бас хариуцлагатай, ухамсартай байгаад бас хуулиа баталчихвал энэ хаврын чуулганаар бидний баталсан, 10 жил батлагдаагүй хууль шүү дээ. 10 жил батлагдаагүй. Энийг бас онцлоод анхаарчхаасай гэж бас хүсье.

Одоо санал хураалт бил үү? Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн орсноос 56 гишүүн буюу 61 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

28.Төслийн 33 дугаар зүйлийг ажлын хэсгийн ахлагч Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: 28 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя.

С.Бямбацогт: Гүйцээн боловсруулах чиглэл өглөө 28.

29.Төслийн 36 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 34 дүгээр зүйл болгох:

“34 дүгээр зүйл.Хүүхдийн хуваарьт хөрөнгийг захиран зарцуулахад эцэг, эхийн эрхийг хязгаарлах

34.1.Хүүхэд төрсөн цагаасаа эхлэн Иргэний хуулийн 127.1-д заасан хуваарьт хөрөнгөтэй болох бөгөөд түүний хуваарьт хөрөнгөд өв залгамжлал, бэлэглэл, тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг, нөхөн төлбөр, оюуны өмчийн үр шим, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон хуульд заасан бусад үндэслэлээр хүүхдийн өмчлөлд шилжсэн хөрөнгө, хөрөнгийн эрх хамаарна. Маш чухал заалт байна.

34.2.Хүүхдийн хуваарьт хөрөнгийн өмчлөгч нь хүүхэд байх бөгөөд эцэг, эх нь түүний хуваарьт хөрөнгийг хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцүүлэн түүний амьжиргаа, сурч боловсрох, хөгжих, авьяас чадварыг дэмжих, эрүүл мэндийн хэрэгцээнд зориулан захиран зарцуулна.

34.3.Эцэг, эх нь хүүхдийн хуваарьт хөрөнгийг өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглах, барьцаалах, шилжүүлэх, бэлэглэх, үрэгдүүлэхийг хориглоно.

34.4.Эцэг, эх нь энэ хуулийн 34.3-т заасан хүүхдийн ашиг сонирхолд харшлах үйл ажиллагаа явуулсны улмаас түүний хуваарьт хөрөнгөд хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй. Хүүхдэдээ хохирол төлөх юм уу?

34.5.Хүүхэд 14 насанд хүрснээс хойш Иргэний хуулийн 75.1-д заасан хугацаанд өөрийн хуваарьт хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах эрхтэй. Аа яа яа.

34.6.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч өөрчлөгдсөн нь хүүхдийн хуваарьт хөрөнгийн өмчлөх эрхийг өөрчлөх, хязгаарлах, дуусгавар болгох үндэслэл болохгүй.”. Аймаар саналууд байна шүү. Санал хураалт.

Санал хураалтад 51 гишүүн, 91-ээс орсон 51 гишүүн буюу 56 саналаар энэ санал дэмжигдлээ.

Хүүхдийнхээ хөрөнгийг хамгаалах үүрэгтэй юм байна шүү эцэг, эхчүүд ээ. Хүүхдийнхээ хөрөнгийг хамаагүй үрэх юм бол өөрсдөө буцааж төлөх нь байна шүү айн. Аягүй чухал, хатуу заалт баталчихлаа шүү. Болгоомжтой байхгүй бол.

Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэгийн урилгаар Байлдааны гавьяаны Улаан тугийн тугийн одонт, Сүхбаатарын одонт Нийгмийг аюулаас хамгаалах яамны Цэргийн дээд сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төгсөлтийнхөө 40 жилийн ойг тэмдэглэж байгаа, Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Батчимэг гишүүний гэр бүлийн хүн Батсайхан хурандаа байх шиг байна тийм ээ. Гараараа даллаадхаач харагдана уу? Бас бусад нь мэдээд аваг. Гэр бүлийн хууль ярьж байна шүү. Та 2 хүүхдээ хөрөнгийг хамаагүй үрж болохгүй нь байна шүү. Тэгвэл буцааж төлөх нь байна шүү бас.

30.Төслийн 37 дугаар зүйлийг 35 дугаар зүйл болгож, 37.2 дахь хэсгийн “37.1-д” гэснийг “35.1-д” өөрчилж, 37.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 35.1 дэх хэсэг болгох:

“35.1.Хүүхэд төрөл, садантайгаа чөлөөтэй харилцах эрхтэй.”. Санал хураалт.

90 гишүүнээс 50 гишүүн буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Төслийн 38 дугаар зүйлийг 36 дугаар зүйл болгож, 38.1.1 дэх хэсгийн “хангаагүй” гэсний өмнө “зориуд” гэж нэмэх. Санал гарсан ажлын хэсэг. Санал хураалт.

Уянгахишиг гишүүн, ажлын хэсгийн гишүүн Уянгахишиг горимын санал гаргая.

Г.Уянгахишиг: Уучлаарай сая энэ төхөөрөмж ажилласангүй. Энэ саналыг хүчингүй болгож өгнө үү гээд горимын санал гаргаж байна.

С.Бямбацогт: Уянгахишиг гишүүний горимын саналаар хүчингүй болгох горимын саналаар санал хураалт явуулъя. Уянгахишиг гишүүн саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн.

Горимын санал дэмжигдсэн тул саяын 31 дүгээр саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 91 гишүүн явснаас 49 гишүүн буюу 53 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Төслийн 39 дүгээр зүйлийг 37 дугаар зүйл болгож, 39.3 дахь хэсгийн “асран хамгаалах байгууллагын асран хамгаалалтад шилжүүлнэ” гэснийг “хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэж, 39.5 дахь хэсгийн “хязгаарлуулсан, эсхүл хасуулснаас” гэснийг “хязгаарлуулснаас” гэж өөрчилж, 39.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 37.4 дэх хэсэг болгох:

“37.4.Сонирхогч тал эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүнийг энэ хуулийн 36.1-д заасан нөхцөлөө арилгаагүй бөгөөд энэ хуулийн 39.1-д заасан нөхцөл бий болсон гэж үзвэл, түүний нэхэмжлэлийн үндсэн дээр тухайн хүний эцэг, эх байх эрхийг хасах эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.”. Санал хураалт.

91-ээс 51 буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Төслийн 40 дүгээр зүйлийг 38 дугаар зүйл болгож, 40.1 дэх хэсгийн “38.1-д” гэснийг “36.1-д” гэж, “шүүх шийдвэрлэнэ” гэснийг “шийдвэрлэнэ” гэж, 40.2 дахь хэсгийн “38.1-д” гэснийг “36.1-д” гэж, “хууль ёсны” гэснийг “дээд” гэж, “бол” гэснийг “байвал” гэж, 40.3 дахь хэсгийн “саналыг” гэснийг “санал болон энэ хуулийн 41.1-д

заасан сургалтад хамрагдсан эсэхийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн орсон 49 гишүүн буюу 53 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

34.Төслийн 41 дүгээр зүйлийг 39 дүгээр зүйл болгож, 41.1.1 дэх заалтын “, 4.1.4в, 4.1.4г” гэснийг, 41.1.4 дэх хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн орсон 49 гишүүн 53-ын саналаар санал дэмжигдлээ.

35.Төслийн 42 дугаар зүйлийг 40 дүгээр зүйл болгож, 42.2 дахь хэсгийн “асран хамгаалах байгууллагын асран хамгаалалтад шилжүүлнэ” гэснийг “хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэж, 42.3 дахь хэсгийн “эд хөрөнгийн” гэснийг “хөрөнгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

91-ээс 52 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Төслийн 43 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 41 дүгээр зүйл болгох:

“41 дүгээр зүйл.Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, эсхүл хасуулсан хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах

41.1.Аймаг, дүүргийн боловсролын болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага эцэг, эх байх эрхийг нь хязгаарлуулсан, эсхүл хасуулсан хүнийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 35.1.10-т заасны дагуу эцэг, эх байх үүрэг, хариуцлагын талаар болон түүний зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах ажлыг хүртээмжтэй байдлаар зохион байгуулна.

41.2.Энэ хуулийн 41.1-д заасан сургалтын хөтөлбөрийг олон улсын жишиг, үндэсний онцлогийг харгалзан боловсролын болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн орсон 48 гишүүн буюу 52 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын “Монгол Билиг Оюу” сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид, Ховд аймгийн 3 дугаар 10-н жилийн сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Хонхны баяраа, төгсөлтийн баяраа сайхан тэмдэглээрэй бүгдээрээ.

37 юу? Төслийн 44 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 42 дугаар зүйл болгох:

“42 дугаар зүйл.Эцэг, эх байх эрхийг сэргээх

42.1.Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүн энэ хуулийн 39.1.1, 39.1.2-т заасан нөхцөлийг арилгасан тохиолдолд эцэг, эх байх эрхийг сэргээх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

42.2.Шүүх дараах тохиолдолд эцэг, эх байх эрхийг сэргээхгүй:

- 42.2.1.энэ хуулийн 39.1-д заасан нөхцөл арилаагүй;
- 42.2.2.эцэг, эх байх эрхийг хассанаас хойш хүүхэд үрчлэгдсэн;
- 42.2.3.эцэг, эх байх эрхийг хассанаас хойш хүүхдийн эсрэг Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн;
- 42.2.4.эцэг, эх байх эрхийг сэргээх нь хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд харшлахаар байгаа нь тогтоогдсон.

42.3.Шүүх эцэг, эх байх эрхийг сэргээх эсэх асуудлыг шийдвэрлэхдээ долоо, түүнээс дээш настай хүүхдийн санал болон энэ хуулийн 41.1-д заасан сургалтад хамрагдсан эсэхийг харгалзан үзнэ”. Ажлын хэсэг. Санал хураалт.

91 гишүүнээс 50 гишүүн буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

38.Төслийн 45 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 43 дугаар зүйл болгох:

“43 дугаар зүйл.Тэжээн тэтгэх үүрэг, тэжээн тэтгүүлэх эрх. Сайн анхааралтай сонсцгоогоорой гишүүд ээ,

43.1.Гэрлэгчид бие биеэ, эцэг, эх нь хүүхдээ, хүүхэд нь эцэг, эхээ, төрөл, садангийн хүмүүс бие биеэ энэ хуульд заасны дагуу тэжээн тэтгэх үүрэгтэй.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд уг үүргээ биелүүлээгүй бол тэжээн тэтгүүлэх эрхтэй этгээд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Уначихлаа шүү дээ. Ажлын хэсгийн гишүүн Хосбаяр горимын санал.

Г.Хосбаяр: Даргаа уучлаарай сая кноп дээрээ хүрч амжилгүй цаг нь дуусчихлаа. Тэгэхээр дахин санал хурааж өгөөч. Хүчингүй болгоод дахин санал хурааж өгөөч.

С.Бямбацогт: Гүйцээн боловсруулчихвал яасан юм? Тэгье 43 ядаж, тийм төрөл садны 43 дугаар санал ажлын хэсэг. Зочин танилцуулъя. Өө биш юм уу? Саяын Хосбаяр гишүүн горимын саналаар санал хураалт явуулъя. Саяын санал хураалтыг хүчингүй болгох ажлын хэсгийн гишүүн Хосбаярын горимын саналыг, хүчингүй болгох саналыг дэмжье гэсэн санал хураалт.

Ер нь уначихсан болохоор тэгээд саяын горимын санал дэмжигдсэнгүй шүү дээ. Ажлын хэсэг гүйцээн боловсруулах, ажлын хэсгийн ахлагч Алтангэрэл гишүүнд микрофон өгье.

О.Алтангэрэл: Энэ ерөөсөө манайх гэр бүлийн уламжлалт хууль, Гэр бүлийн хуучин хуулиараа, уламжлалаар хуучин ямар заалттай байсан бэ гэхлээр гэр бүлийн гишүүд, гэрлэгчид бие биеийгээ, дээрээс нь төрлийнхөө хүмүүсийг тэжээн тэтгэх үүрэгтэй байсан байхгүй юу. Эцэг, эх нь хүүхдээ, хүүхэд нь эцэг, эхээ гээд. Тэгэнгүүт энэ хүрээ хязгаарыг хумиад төрөл садангийн хүмүүс гэсэн тодорхойлолт байгаа юм. Төрлийн хүмүүс гээд тэгэхээр юу хэлж байна вэ гэхлээр эцэг, эхийг нь, эмээ өвөөг нь, ач, гучийг нь хэлж байгаа юм. Садан гэвэл төрсөн ах, дүүсийг нь хэлж байгаа юм. Тэгэнгүүт энд ингээд хүрээ хүрээ хязгаарыг нь хумиад нэр томъёоны хувьд оруулаад ирж байгаа байхгүй юу.

Өөрөөр хэлбэл, энэ дотор өргөжүүлсэн юм байхгүй. Нарийвчлаад өчнөөн хоног яриад яг мэргэжлийн хуульчид, мэргэжлийн яам, яг мэргэжлийн хүмүүс нь яриад гэр бүлийн харилцааг зохицуулж байгаа юм. Тэгэнгүүт төрлийнхнийгөө тэжээх гэж байгаа юм байна гэж ингээд. Хуучин бол бүр яг ямар үгтэй байсан бэ гэхлээр төрлийн хүмүүс бие биеэ тэжээн тэтгэх үүрэгтэй гэсэн үг байсан байхгүй юу. Одоо бид нар эмээ, өвөөгөө тэжээн тэтгэхгүй гээд яах юм. Больё гэх юм уу? Ач, зээгээ тэжээн тэтгэнэ. Төрсөн ах, дүүгээ харж хандах хүнгүй бол тэжээн тэтгэ л гэж байгаа байхгүй юу. Үгүй харин тийм. Тэгээд хэрвээ үүргийг нь оруулаад хэрвээ ингээд тэжээн тэтгэх үүргээ биелүүлэхгүй бол тэр хүмүүс чинь намайг өөр харж хандах хүн алга, миний хүүхэд ингээд байна. Намайг тэжээн тэтгээч гээд ингээд шүүхэд хандах эрхийг нь л нааж өгч байгаа юм. Ийм тохиолдол бараг гарахгүй байх.

Тэгэхдээ хуульд бид нар заавал заах ёстой байхгүй юу. Тийм учраас та бүхнийг бас ойлгоосой гэж хүсэж байгаа юм. Зүйл, заалт болгон дээр асар олон хэлэлцүүлэг, олон хоногийн ажил, мэргэжлийн байгууллагуудын санал, дүгнэлт, олон юм байгаа гэдгийг би бас та бүхнийг эрхэм гишүүдээс ойлгоосой гэж хүсэж байна. Тэгээд яг энэ зүйл, заалт дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя саяын. Тэгээд ингээд хуучнаараа орох юм бол, хуучнаараа явах юм бол төрлийнхөө бүх хүмүүсийг тэжээн тэтгэх үүрэг чинь үлдлээ шүү.

С.Бямбацогт: Алтангэрэл гишүүн ээ саяынх нөгөө санал хураалт уначихсан, горимын санал уначихсан. Тийм болохоор гүйцээн боловсруулах өгөх болохгүй юм байна. Тийм болохоор хэн сая горимын санал гаргачихъя. Ажлын хэсэг тэгээд тэрүүгээр санал хураачихъя. Энхбаяр гишүүн, Энхбаяр гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр гишүүний микрофон.

Б.Энхбаяр: Сая оршил энэ ажлын хэсэг их зөв санал гаргасан байна. Яг төслийн заалтын нөгөө гишүүд хараагүй учраас, төслийн заалтыг нь харьцуулбал та бүхэн энэ шууд ажлын хэсгийн саналыг шууд дэмжих юм байна бүгд ер нь бол. Тийм. Тийм учраас энэ, тийм учраас ч юу байх вэ би сая төхөөрөмж ажилласангүй. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалгаж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүнээс 47 гишүүн оролцож, 51.6 хувиар санал дэмжигдлээ.

Одоо 38 дээр санал хураалт явуулъя. 38 дугаар саналаа уншаад танилцуулчихсан. 38 дугаар саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Би ажлын хэсэгт. Ер нь байна шүү дээ. Ер нь 10 минут завсарлая. Энэ ердөөсөө маш замбараагүй явж байна. Гишүүд өөрсдөө танхимаа орхиж явж байна. Ийм чухал асуудал хэлэлцэж байхад танхимдаа суухгүй гарч явсан гишүүд өнөөдөр гэр бүл, хүүхдийн өмнө ямар хариуцлага хүлээж байгаа юм. Тэгээд ингээд будилуулаад хуулиа уншихгүй, ойлгохгүй, зарчмын зөрүүтэй санал гаргачхаад өөрсдөө саналаа өгөхгүй ингэж болдог юм уу? 5 минут юм уу, 10 минут завсарлуулаад ирцээ хангаад тэгээд санал хураалтаа явуулахыг хүсэж байна. Ингэж болохгүй. Одоо саяын энэ хүмүүс кнопуудаа тоол тэгвэл, дахиад хүмүүсээ дууд. Яаж ингэж болдог юм. Тэгвэл хүмүүсээ дууд. Ингэж болохгүй шүү дээ. Олон нийт харж байгаа, хүүхдүүд харж байгаа, зочид харж байгаа. Гэр бүлийн хууль ер нь эцсийн эцэст яагаад одоог хүртэл батлагдаагүй юм бэ гэдэг чинь ийм юмнаас болж байгаа байхгүй юу. Ийм арчаагүй байж болохгүй шүү дээ. Хуулиа уншицгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн гишүүн Баасанжаргал гишүүн. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Би сая саналаа өгөхөөс хоцроод кнопоо дарж чадсангүй. Тэгээд горимын санал гаргаад энэ саналыг хүчингүй болгож өгнө үү гэж санал гаргаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Мэдээж Улсын Их Хурлын гишүүд өөр өөрсдийн байр суурийг илэрхийлэх нь зөв. Энэ дээрээ хэдүүлээ нервтээд яах вэ. Харж байна, харж байна, харж байна. Ажлын хэсгийн гишүүн Баасанжаргал гишүүний гаргасан саналын томъёоллоор саяын явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Ингээд санал хураалт явуулъя гишүүд ээ.

Санал хураалтад 91 гишүүнээс 44 гишүүн оролцож, 48.4 хувиар санал дэмжигдсэнгүй.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурал гиш гишүүн О.Цогтгэрэлийн урилгаар Увс аймгийн Өндөрхаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Дамдинням гишүүний сумынхан байна.

Гишүүд энэ яачхав. Гишүүд чимээгүй аядаарай. Отгонбаяр гишүүн горимын санал гаргая гэж байна. Отгонбаяр гишүүний микрофоныг нээе.

У.Отгонбаяр: Уучлаарай саяын санал хураалт дээр тоног төхөөрөмж ажилласангүй. Тийм учраас энэ саналыг цуцалж өгөхийг, үнэн үнэн горимын санал гаргаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ингэе ер нь бол 38 дугаар саналыг эцсийн хэлэлцүүлэг дээр бас эргэж харахаар саналын томьёоллоор айн.

39.Төслийн 46, 47 дугаар зүйлийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулж 44 дүгээр зүйл болгох:

“44 дүгээр зүйл.Гэрлэгчдийн бие биеэ харилцан тэжээн тэтгэх үүрэг

44.1.Гэрлэгчид гэрлэлт хүчинтэй байх хугацаанд бие биеэ харилцан тэжээн тэтгэх үүрэгтэй.

44.2.Гэрлэлт дуусгавар болсны дараа гэрлэгчдийн хэн нэг нь дараах тохиолдолд тэтгэлэг гаргуулах эрхтэй:

44.2.1.гэрлэлт дуусгавар болохоос өмнө төрсөн, үрчлэн авсан гурав хүртэлх насны хүүхэдтэй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл хүнд өвчтэй хүүхдээ асарч байгаа бол;

44.2.2.гэрлэлт дуусгавар болохоос өмнө эхнэр нь жирэмсэн байсан бөгөөд хүүхэд төрсөн бол;

44.2.3.гэрлэлт дуусгавар болсноос хойш хоёр жилийн дотор хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн, эсхүл бүрэн алдсан нь гэр бүлийн хүчирхийлэл болон гэрлэлт цуцлуулахаас өмнө бий болсон нөхцөл байдалтай шууд холбоотойгоор үүссэн бол;

44.2.4.гэрлэлт дуусгавар болохоос өмнө өөрийн буруугүй үйлдлийн улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, эсхүл хүнд өвчтэй болсон бөгөөд энэ байдал нь гэрлэлт цуцлуулсны дараа арилаагүй бол.

44.3.Тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь уг үүргээ биелүүлээгүй бол тэтгэлэг гаргуулах тухай тэжээн тэтгүүлэх эрхтэй этгээдийн нэхэмжлэлийг шүүх шийдвэрлэнэ.

44.4.Энэ хуулийн 44.2-т заасан тэтгэлгийн хэмжээг хариуцагчийн хөрөнгө, орлого, бусад нөхцөл байдлыг харгалзан энэ хуулийн 46.1-д заасны дагуу тогтооно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүнээс 54 гишүүн оролцож, 59.3 хувиар санал дэмжигдлээ.

40.Төслийн 48 дугаар зүйлийг 45 дугаар зүйл болгож, 48.1 дэх хэсгийн “сургуульд” гэсний өмнө “эсхүл” гэж, “хөдөлмөрийн” гэсний өмнө “насанд хүрсэн боловч” гэж, “байнгын асаргаа” гэсний өмнө “насанд хүрсэн боловч” гэж нэмж, 48.2 дахь хэсгийн “48.1-д” гэснийг “45.1”-д гэж, “тэжээн тэтгэх үүргийн талаарх” гэснийг “хүүхдийн тэтгэлэг тогтоолгох тухай сонирхогч талын” гэж тус тус өөрчилж, 48.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 45.4 дэх хэсэг болгох:

“45.4.Энэ хуулийн 45 дугаар зүйлд заасан тэтгэлгийн хэмжээг хариуцагчийн хөрөнгө, орлого, бусад нөхцөл байдлыг харгалзан энэ хуулийн 46.1-д заасны дагуу тогтооно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүнээс 57 гишүүн оролцож, 62.2 хувиар санал дэмжигдлээ.

41.Төслийн 49 дүгээр зүйлийг 46 дугаар зүйл болгож, 49.4 дэх хэсгийн “49.1-д” гэснийг “46.1-д” гэж, 49.5 дахь хэсгийн “49.4-т” гэснийг “46.3-т” гэж, 49.8 дахь хэсгийн “хүүхдийн” гэснийг “түүний” гэж тус тус өөрчилж, 49.3 дахь хэсгийг хасаж, 49.1, 49.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 46.1, 46.2 дахь хэсэг болгох:

“46.1.Талууд энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бол шүүх энэ хуулийн 46.2-т заасан тэтгэлэг тогтоох аргачлалын дагуу хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг харгалзан тэтгэлэг тогтооно.

46.2.Тэтгэлэг тогтоох аргачлалыг сар, улирал, хагас жил, эсхүл жилээр тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, тэтгэлэг авагчийн хэрэгцээ, шаардлага зэрэг нөхцөл байдлыг харгалзан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг харгалзан Засгийн газар батална.”

Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Энэ санал дээр гүйцээн боловсруулах чиглэл.

Ж.Бат-Эрдэнэ: 40 дүгээр, 41 дүгээр санал дээр ажлын хэсгийн гаргасны дагуу гүйцээн боловсруулах саналыг дэмжлээ. Санал гаргаж байна.

42.Төслийн 50 дугаар зүйлийг 47 дугаар зүйл болгож, 50.4 дэх хэсгийн “50.2, 50.3-т” гэснийг “47.2-т” гэж өөрчилж, 50.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 91 гишүүнээс 54 гишүүн оролцож, 59.3 хувиар санал дэмжигдлээ.

43.Төслийн 51 дүгээр зүйлийг 48 дугаар зүйл болгож, 51.3 дахь хэсгийн “51.1-д” гэснийг “48.1-д” гэж өөрчилж, гарчгийн “тэтгэлэг,” гэснийг, 51.1, 51.2, 51.3 дахь хэсгийн “тэтгэлэг, эсхүл” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүнээс 53 гишүүн оролцож, 58.2 хувиар санал дэмжигдлээ.

44.Төсөлд доор дурдсан агуулгатай 49 дүгээр зүйл нэмэх:

“49 дүгээр зүйл.Хүүхэд эцэг, эхээ тэжээн тэтгэх үүрэг

49.1.Насанд хүрсэн, хөдөлмөрийн чадвартай хүүхэд нь хөдөлмөрийн чадваргүй, эсхүл байнгын асаргаа шаардлагатай, эсхүл өндөр насны улмаас

өөрийгөө тэжээн тэтгэх боломжгүй болсон нь тогтоогдсон эцэг, эхээ тэжээн тэтгэх үүрэгтэй.

49.2.Хоёр, түүнээс дээш хүүхэдтэй бол эцэг, эхээ тэжээн тэтгэх үүргийг тухайн хүүхдүүд харилцан тохиролцсоны үндсэн дээр хүүхэд тус бүрийн үүргийг тодорхойлон хэрэгжүүлж болно.

49.3.Энэ хуулийн 49.2-т заасны дагуу хүүхдүүд нь тохиролцож чадаагүй бол эцэг, эхийн, эсхүл хүүхдүүдийн хэн нэгний нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх хүүхэд тус бүрийн хөрөнгө, орлого, хөдөлмөрийн чадвар болон бусад нөхцөл байдлыг харгалзан тэжээн тэтгэх үүргийн оролцоог тодорхойлон шийдвэрлэж болно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүнээс 55 гишүүн оролцож, 60.4 хувиар санал дэмжигдлээ.

45.Төсөлд доор дурдсан агуулгатай 50 дугаар зүйл нэмэх:

“50 дугаар зүйл.Төрөл, садангийн хүмүүсийн тэжээн тэтгэх үүрэг

50.1.Насанд хүрээгүй бүтэн өнчин, эсхүл эцэг, эхээрээ тэжээн тэтгүүлэх боломжгүй хүүхдийг хөдөлмөрийн чадвартай төрсөн, үрчлэн авсан ах, эгч, дүү, өвөг эцэг, эмэг эх нь тэжээн тэтгэх үүрэгтэй.

50.2.Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээрээ тэжээн тэтгүүлэх боломжгүй, хөдөлмөрийн чадваргүй өвөг эцэг, эмэг эхээ хөдөлмөрийн чадвартай ач, зээ нь тэжээн тэтгэх үүрэгтэй.

50.3.Тэжээн тэтгэх үүрэгтэй төрөл, садангийн хүн хоёр, түүнээс дээш байвал тэжээн тэтгэх үүргийг харилцан тохиролцсоны үндсэн дээр хүн тус бүрийн үүргийг тодорхойлон хэрэгжүүлж болно.

50.4.Төрөл, садангийн хүмүүс тохиролцож чадаагүй бол тухайн хүний, эсхүл төрөл, садангийн хүний хэн нэгний нэхэмжлэлийн үндсэн дээр шүүх хүн тус бүрийн хөрөнгө, орлого, хөдөлмөрийн чадвар болон бусад нөхцөл байдлыг харгалзан тэжээн тэтгэх үүргийн оролцоог тодорхойлон шийдвэрлэж болно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 47 гишүүн оролцож, 51.1 хувиар санал дэмжигдлээ.

46.Төслийн 52 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 51 дүгээр зүйл болгох:

“51 дүгээр зүйл.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах, хүчингүйд тооцох

51.1.Энэ хуулийн 44, 45 дугаар зүйлд заасан тэтгэлэг төлөгч болон тэтгэлэг авагч, эсхүл түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тэтгэлгийн хэмжээ,

тэтгэлэг төлөх нөхцөл, журмыг харилцан тохиролцож, тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулж болно.

51.2.Энэ хуулийн 49, 50 дугаар зүйлд заасан тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд болон тэжээн тэтгүүлэх эрхтэй этгээд, эсхүл түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь энэ хуулийн 51.1-д заасан гэрээг байгуулж болно.

51.3.Тэжээн тэтгэх тухай гэрээнд тэтгэлгийн хэмжээ, төлөх хугацаа, хэлбэрээс гадна тэжээн тэтгүүлэгчийн хэрэгцээ шаардлага, тэжээн тэтгэгчийн хөрөнгө, орлогын байдлыг харгалзан бусад нөхцөлийг тусгаж болно.

51.4.Тэжээн тэтгэх тухай гэрээг талууд харилцан тохиролцож бичгээр байгуулах бөгөөд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл цуцлахад гэрээ байгуулсан хэлбэрийг баримтална.

51.5.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах, хүчингүй болсонд тооцохтой холбогдсон харилцааг Иргэний хуульд заасан үндэслэл, журмын дагуу зохицуулна.

51.6.Тэжээн тэтгэх тухай гэрээтэй холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэхдээ хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой асуудлыг хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах бөгөөд бусад асуудалд талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзнэ.". Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Улсын Их Хурал дахь намын бүлгийн дарга нар ирцийнхээ асуудал дээр анхаараарай. Санал хураалтад 92 гишүүнээс 46 гишүүн оролцож, 50 хувиар санал дэмжигдсэнгүй.

47. Алдаржавхлан гишүүн горимын санал гаргая гэж байна.

Ж.Алдаржавхлан: Үгүй би санал өгөх гэж байгаад амжсангүй. Тийм учраас та санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: 47.Санал хураалт явуулъя.

47.Төслийн 54 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 53 дугаар зүйл болгох:

“53 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөх

53.1.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бөгөөд шүүхийн шийдвэрээр тэтгэлгийн хэмжээг тогтоосны дараа энэ хуулийн 44, 45 дугаар зүйлд заасан тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, бусад нөхцөл байдал өөрчлөгдсөн бол тэтгэлэг авагчийн, эсхүл тэтгэлэг төлөгчийн нэхэмжлэлийн үндсэн дээр тэтгэлгийн хэмжээг өөрчлөх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

53.2.Шүүх энэ хуулийн 53.1-д заасан асуудлыг шийдвэрлэхдээ энэ хуулийн 46.2-т заасан аргачлалын дагуу дахин тогтооно.

53.3.Эцэг, эх, эсхүл төрөл, садан хүн нь хүүхдийг тэжээн тэтгэх, өсгөн хүмүүжүүлэх үүргээ ноцтой зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон бол хүүхэд эцэг, эх, эсхүл төрөл, садангийн хүнээ тэжээн тэтгэх үүргээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөж болно.

53.4.Тэжээн тэтгүүлэгчийн тэжээн тэтгүүлэх эрхийн үндэслэл арилсан бол энэ хуулийн 43.1-д заасан этгээдийн тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болно.

53.5.Тэжээн тэтгүүлэгч нь тэжээн тэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, хүчирхийлсэн, дарамталсан, гэм хор учруулсан, эсхүл учруулахаар завдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол тэтгэлэг төлөгчийг тэжээн тэтгэх үүргээс шүүхийн шийдвэрээр чөлөөлнө.

53.6.Гэрлэлтээс гадуурх харилцаа, гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэрлэлт цуцалсан бол хүүхэд нь гэрлэлтээс гадуурх харилцааг үүсгэсэн буруутай эцэг, эсхүл эхээ тэжээн тэтгэхгүй байж болно.

53.7.Энэ хуулийн 53.4-т заасан тэжээн тэтгүүлэгчид 18 насанд хүрээгүй хүүхэд хамаарахгүй.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад санал хураалтад 92 гишүүн оролцож, 92 гишүүнээс 42 гишүүн оролцож, 45.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Баасанжаргал гишүүн горимын санал гаргая гэж байна. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Горимын санал гаргая дарга. Би төхөөрөмждөө амжиж хүрч чадсангүй сая байж байгаад. Тэгээд санал хураалтыг бол хүчингүй болгож өгнө үү гэж хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Баасанжаргал гишүүний гаргасан саналын дагуу, горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 51 гишүүн оролцож, 55.4 хувиар санал дэмжигдэж саяын санал хураалт хүчингүйд тооцогдлоо.

Зочин танилцуулъя. Ховд аймгийн Манхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс эрүүл энх, аз жаргал, амьдралын сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Баасанжаргал гишүүн горимын санал гаргаж байна. Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Саяын 47 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя. Тэгээд би бас ташрамд нэг зүйл хэлмээр байна. Энд ерөөсөө ингээд хуучин хуулийн заалт хэвээр үлдэх, төслийн заалт хэвээр үлдэхэд нэлээн өөрчилсөн, ажилласан юмнууд нь хэвээр үлдчихээд байна. Одоо байхгүй байгаа гишүүд маань орж ирж саналаа өгөөч ээ. Энэ гэр бүлтэй холбоотой, эцэг, эх байх,

хүүхдийн дээд ашиг сонирхол маш чухал заалтууд байна. Заримдаа ирц хүрэхгүйн улмаас санал унаж байна.

Жишээлбэл, түрүүн унасан саналын улмаас хуучин Гэр бүлийн хуулиар төрлийн хүмүүсээ бүгдийг нь тэжээн тэтгэх үүрэгтэй байсан. Нэхэмжлэл гаргах эрхтэй нөгөөдүүл нь. Хумиад төрөл буюу садан, эцэг, эх, эмээ, өвөө, ач гуч, төрсөн ах, дүү гээд нөгөө хүрээг нь хумиад оруулаад ирэхэд унагаад хуучин заалт нь хэвээр үлдчих жишээний. Тэгээд гэр бүлээс гадуур харилцааны улмаас гээд тэр тэжээн тэтгэх үүрэг дээр бас нэлээн том заалт байсныг ажлын хэсэг ажиллаад хасангуут энд зүгээр л харьцуулж харлахгүй уншаад л тэжээн тэтгэх гэдэг үгийг нь хараад л эсэргүүцэнгүүт тэнд тэр заалт нь хэвээр үлдчих жишээний үр дагаврууд гараад байна. Гишүүд минь ээ хариуцлагатай хандаад өгөөч гэж ажлын хэсгийн даргын хувиар чин сэтгэлээсээ хүсье. Тэгээд энэ санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн ахлагч Алтангэрэлийн гаргасан саналын дагуу гүйцээн боловсруулах чиглэл өглөө. 47 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Гишүүд санал хураалтдаа идэвхтэй оролцоорой.

48.Төслийн 55 дугаар зүйлийг 54 дүгээр зүйл болгож, 55.4 дэх хэсгийн “хууль ёсны” гэснийг “дээд” гэж өөрчилж, 55.1 дэх хэсгийг хасаж, 55.2, 55.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 54.1, 54.2 дахь хэсэг болгох:

“54.1.Асран хамгаалалтад дараах хүнийг хамруулна:

54.1.1.бүтэн өнчин 14 насанд хүрээгүй хүүхэд;

54.1.2.эцэг, эх нь хоёулаа шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүний 14 насанд хүрээгүй хүүхэд;

54.1.3.эцэг, эх нь хоёулаа, эсхүл хүүхдийн байнга хамт амьдардаг эцэг, эсхүл эх нь хүнд өвчтэй, бусдын асрамжид байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүүхдээ биечлэн асран хамгаалах, хүмүүжүүлэх боломжгүй байгаа хүний 14 насанд хүрээгүй хүүхэд;

54.1.4.эцэг, эх нь хоёулаа, эсхүл хүүхдийн байнга хамт амьдардаг эцэг, эсхүл эх нь хорих ял эдэлж байгаа хүний 14 насанд хүрээгүй хүүхэд;

54.1.5.шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон хүн.

54.2.Харгалзан дэмжлэгт дараах хүнийг хамруулна:

54.2.1.бүтэн өнчин 14, түүнээс дээш насны хүүхэд;

54.2.2.эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүний 14, түүнээс дээш насны хүүхэд;

54.2.3.эцэг, эх нь хоёулаа, эсхүл тухайн хүүхдийн байнга хамт амьдардаг эцэг, эсхүл эх нь хүнд өвчтэй, бусдын асрамжид байдаг зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар биечлэн асран хүмүүжүүлэх боломжгүй байгаа хүний 14, түүнээс дээш насны хүүхэд;

54.2.4.эцэг, эх нь хоёулаа, эсхүл тухайн хүүхдийн байнга хамт амьдардаг эцэг, эсхүл эх нь хорих ял эдэлж байгаа хүний 14, түүнээс дээш насны хүүхэд;

54.2.5.ганц бие, төрлийн хүнгүй, бие даан амьдрах чадваргүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, эсхүл ахмад настан;

54.2.6.гэр бүлийн гишүүд бие биеэ асран хамгаалах боломжгүй, төрлийн хүнгүй, бие даан амьдрах чадваргүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, эсхүл ахмад настан.. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 55 гишүүн оролцож, 59.8 хувиар санал дэмжигдлээ. 59.

49.Төслийн 56 дугаар зүйлийг 55 дугаар зүйл болгож, 56.1 дэх хэсгийн “55.2, 55.3-т” гэснийг “54.1, 54.2-т” гэж, “баг, дүүрэг, хорооны” гэснийг “дүүргийн” гэж, 56.2 дахь хэсгийн “баг, дүүрэг, хорооны засаг захиргааны байгууллагад” гэснийг “дүүргийн Засаг дарга, орон нутгийн захиргааны байгууллагад” гэж тус тус өөрчилж, 56.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 55.3 дахь хэсэг болгох:

“55.3.Энэ хуулийн 55.2-т заасан хүний талаар мэдээлэл хүлээн авсан эсвэл дүүргийн Засаг дарга сум, хорооны хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн тухайн хүнийг асран хамгаалалт, харгалзан дэмжлэггүй болсон эсэхийг тогтоож, асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт хамруулах арга хэмжээ авна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 57 гишүүн оролцож, 60 хувиар санал дэмжигдлээ.

50.Төслийн 57 дугаар зүйлийг 56 дугаар зүйл болгож, гарчгийн “дэмжлэгийн хэлбэр, түүнийг” гэснийг “дэмжигчийг” гэж, 57.4 дэх хэсгийн “баг, дүүрэг, хорооны” гэснийг “дүүргийн” гэж, “56.3-т” гэснийг “55.3-т” гэж, 57.4.1 дэх заалтын “хамгаалах” гэснийг “хамгаалж” гэж, 57.4.2 дахь заалтын “61 дүгээр” гэснийг “60 дугаар” гэж, “асран хүмүүжүүлэх” гэснийг “асруулахаар шилжүүлэх” гэж, 57.5 дахь хэсгийн “57.3, 57.4-т” гэснийг “55.2, 55.3-т” гэж, 57.6 дахь хэсгийн “баг, дүүрэг, хорооны” гэснийг “дүүргийн” гэж, 57.6.5 дахь заалтын “ажиллагаанаас” гэснийг “ажиллагааны улмаас” гэж, “эд хөрөнгөд” гэснийг “хөрөнгөд” гэж, 57.6.7 дахь заалтын “эд хөрөнгө” гэснийг “хөрөнгө” гэж тус тус өөрчилж, 57.1 дэх хэсэг, 57.4 дэх хэсгийн “зохих хэлбэрийн” гэснийг тус тус хасаж, 57.2, 57.3 дахь хэсэг, 57.4.3, 57.6.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 56.1, 56.2 дахь хэсэг, 56.3.3, 56.5.6 дахь заалт болгох:

“56.1.Сум, дүүргийн Засаг дарга асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох ажиллагааг шүүхийн шийдвэр болон сонирхогч талын хүсэлтэд үндэслэн, эсхүл 54.1, 54.2-т заасан хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл өөрийн санаачилгаар явуулна.

56.2.Энэ хуулийн 54.1, 54.2-т заасан хүний талаарх нөхцөл байдлын үнэлгээг сум, хорооны хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан хийж, сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ.

56.3.3.асран хамгаалж, харгалзан дэмжвэл зохих хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад, хүнийг төрөлжсөн асрамжийн газарт шилжүүлэх.

56.5.6.хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад шилжүүлсэн хүүхэд болон төрөлжсөн асрамжийн газарт шилжүүлсэн хүнээс бусад асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн хөрөнгийг эрхлэн хамгаалагчийг тогтоож, гэрээ байгуулан биелэлтэд хяналт тавих;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92-оос 92 гишүүнээс 60 гишүүн оролцож, 65.2 хувиар санал дэмжигдлээ.

Энэ зарим үг, үсгээ харахгүй бол бас л л сонин л юм шиг санагдаад байгаа юм даа.

51.Төслийн 58 дугаар зүйлийг 57 дугаар зүйл болгож, 58.1.3, 58.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 57.1.3, 57.1.4, 57.1.6 дахь заалт болгох:

“57.1.3.сүрьеэ, эсхүл хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдол, эсхүл сэтгэцийн өвчтэй;

57.1.4.согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хамааралтай;

57.1.5.хорих ял эдэлж байгаа, эсхүл Эрүүгийн хуульд заасан хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг санаатай хүнд гэмт хэрэг, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 59 гишүүн оролцож, 64.1 хувиар санал дэмжигдлээ.

52.Төслийн 59 дүгээр зүйлийг 58 дугаар зүйл болгож, 59.1.1 дэх заалтын “гэр бүлд” гэснийг “гэр бүлтэй” гэж, 59.1.4 дэх заалтын “эд хөрөнгийн” гэснийг “хөрөнгийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 60 гишүүн оролцож, 65.2 хувиар санал дэмжигдлээ.

53.Төслийн 60 дугаар зүйлийг 59 дүгээр зүйл болгож, 60.1.1 дэх заалтын “сурч” гэсний өмнө “хөгжүүлэх,” гэж нэмж, 60.1.3 дахь заалтын “үл хөдлөх эд хөрөнгө, мал, банкинд хадгалуулсан мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг” гэснийг “хөрөнгийг” гэж, “тухайн сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг “харьяа сум, дүүргийн” гэж, 60.1.4 дэх заалтын “тухайн сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг

“харьяа сум, дүүргийн” гэж, 60.2.3 дахь заалтын “асрамж,” гэснийг “асран хамгаалалт, харгалзан” гэж, 60.2.4 дэх заалтын “эд хөрөнгийг” гэснийг “хөрөнгийг” гэж, “баг, дүүрэг, хорооны” гэснийг “дүүргийн” гэж, 60.3 дахь хэсгийн “бага насны” гэснийг “долоон насанд хүрээгүй” гэж тус тус өөрчилж, 60.2.4 дэх заалтын “, дэнчин тавих” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 61 гишүүн оролцож, 66.3 хувиар санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Ховд аймгийн Манхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

54.Төслийн 61 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 60 дугаар зүйл болгох:

**“60 дугаар зүйл.Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх
үйл ажиллагаа**

60.1.Энэ хуулийн 54.1, 54.2-т заасан хүүхдийг иргэн гэр бүлдээ авч асран хүмүүжүүлж /цаашид “асралт гэр бүл” гэх/ болно.

60.2.Асралт гэр бүлийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, түүний эрх, үүрэг, үйл ажиллагаанд хяналт тавихад Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмыг баримтална.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 55 гишүүн оролцож, 59.8 хувиар санал дэмжигдлээ.

55.Төслийн 62 дугаар зүйлийг 61 дүгээр зүйл болгож, 62.2, 62.3 дахь хэсгийн “хүүхдийн нэр дээрх” гэсний өмнө “тухайн” гэж нэмж, 62.1 дэх хэсгийн “хуульд заасны дагуу мөнгөн” гэснийг “хуулийн 13, 14, 15, 16 дугаар зүйлд заасны дагуу асаргааны” гэж, 62.4 дэх заалтын “62.1, 62.2-т” гэснийг “61.1, 61.2-т” гэж, “гэр бүлийн” гэснийг “хүүхэд, гэр бүлийн хөгжлийн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 57 гишүүн оролцож, 62 хувиар санал дэмжигдлээ.

56.Төслийн 63 дугаар зүйлийг 62 дугаар зүйл болгож, 63.2 дахь хэсгийн “хүүхдийн нэр дээр” гэсний өмнө “тухайн” гэж нэмж, гарчгийн “эд хөрөнгийг” гэснийг “хөрөнгийг” гэж, 63.1 дэх хэсгийн “хууль ёсны” гэснийг “дээд” гэж, 63.2 дахь хэсгийн “эд хөрөнгө” гэснийг “хөрөнгө” гэж тус тус өөрчлөх Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 60 гишүүн оролцож, 65.2 хувиар санал дэмжигдлээ.

57.Төслийн 64 дүгээр зүйлийг 63 дугаар зүйл болгож, 64.4 дэх хэсгийн “сум, баг, дүүрэг, хорооны” гэснийг “харьяа сум, дүүргийн” гэж өөрчилж, 64.2.5 дахь хэсгийн “асран хамгаалуулагч” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 63.2.10 дахь заалт нэмэх.

“63.2.10.хорих ялаар шийтгүүлсэн.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 58 гишүүн оролцож, 63 хувиар санал дэмжигдлээ.

58.Төслийн 65 дугаар зүйлийг 64 дүгээр зүйл болгож, 65.3 дахь хэсэг, 65.2.1 дэх заалтын “хууль ёсны” гэснийг “дээд” гэж, 65.2.2 дахь заалтын “шалтгаангүйгээр” гэснийг “шалтгаантайгаас бусад тохиолдолд” гэж, 65.2.4 дэх заалтын “22-оос доошгүй” гэснийг “21, түүнээс дээш” гэж, 65.4 дэх хэсгийн “65.2.2-т” гэснийг “64.1.2-т” гэж өөрчилж, 65.1, 65.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 56 гишүүн оролцож, 60.9 хувиар санал дэмжигдлээ.

59 дүгээр санал. Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: 59 дүгээр санал дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя.

Ж.Бат-Эрдэнэ: 59 дүгээр санал. Төслийн 66 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 65 дугаар зүйл болгох гэсэн дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

60.Төслийн 67 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 66 дугаар зүйл болгох:

“66 дугаар зүйл.Хүүхэд үрчлэх журам

66.1.Аймаг, дүүргийн Засаг даргын дэргэд хүүхдийг үрчлүүлэх эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

66.2.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага үрчлэгчийг гэр бүл, эцэг, эх, хүүхдийн харилцааны талаар зохих сургалт, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангана.

66.3.Хүүхэд үрчлүүлэх эцэг, эхийн зөвшөөрлийг хүүхэд төрсний дараа өгнө.

66.4.Сум, хорооны хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан үрчлүүлэх хүүхэд, үрчлэх гэр бүлд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан нөхцөл байдлын үнэлгээг хийж, Зөвлөлд хүргүүлнэ.

66.5.Зөвлөл энэ хуулийн 66.4-т заасан нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн хүүхэд үрчлүүлэх эсэх талаар санал, дүгнэлт гаргана.

66.6.Зөвлөл зайлшгүй шаардлагатай гэж үзвэл үрчлүүлэх хүүхэд, үрчлэгчийн нөхцөл байдлын талаар нэмэлт үнэлгээ хийлгэж, холбогдох байгууллага, албан тушаалтан, мэргэжилтнээс мэдээлэл, тайлбар гаргуулан авч болно.

66.7.Хүүхдийг үрчлэх асуудлыг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл болон Зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

66.8.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийг үрчлүүлэх тухай шүүхийн шийдвэр гарахаас өмнө хүүхдээ үрчлүүлэх зөвшөөрлөө цуцлах эрхтэй.

66.9.Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхдийг эцэг, эх байх эрх хассан шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сарын дараа үрчлүүлж болно.

66.10.Энэ хуулийн 66.9-д заасны дагуу эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхдийг үрчлүүлэх асуудлаар сум, хорооны хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан үрчлүүлэх хүүхэд, үрчлэх гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг хийж, Зөвлөлд хүргүүлэх бөгөөд хүүхдийн хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн зөвшөөрөл болон Зөвлөлийн дүгнэлтэд үндэслэн шүүх шийдвэрлэнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

92 гишүүнээс 55 гишүүн оролцож, 59.8 хувиар санал дэмжигдлээ.

Нэлээн нарийн заалтууд л орж байна даа.

61.Төслийн 68 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 66 дугаар зүйл болгох гэсэн 61 дүгээр санал. Алтангэрэл.

О.Алтангэрэл: 61 дүгээр санал дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя.

Ж.Бат-Эрдэнэ: Алтангэрэл хуулийн ажлын хэсгийн ахлагчийн гаргасан саналын дагуу 61 дүгээр санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

62.Төслийн 69 дүгээр зүйлийг 68 дугаар зүйл болгож, 69.4 дэх хэсгийн “үрчлэн” гэсний өмнө “хүүхдийг” гэж, “Хүүхдийг” гэснийг “Хүүхдээ” гэж өөрчилж, 69.6, 69.7 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 58 гишүүн оролцож, 63 хувиар санал дэмжигдлээ.

62 мөн байх аа?

63.Төслийн 71 дүгээр зүйлийг 70 дугаар зүйл болгож, 71.2.6 дахь заалтын “эрхэлсэн” гэсний дараа “үйлдэл хийсэн нь тогтоогдсон” гэж нэмж, 71.1 дэх хэсгийн

“хууль ёсны” гэснийг “дээд” гэж, 71.2.5 дахь заалтын “66-т” гэснийг “65-т” гэж, 71.2.6 дахь заалтын “65.7-д” гэснийг “64.4-т” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 54 гишүүн оролцож, 58.7 хувиар санал дэмжигдлээ.

64.Төслийн 72 дугаар зүйлийг 71 дүгээр зүйл болгож, 72.1 дэх хэсгийн “хүчингүйд” гэснийг “хүчингүй болсонд” гэж, 72.2, 72.3 дахь хэсгийн “хууль ёсны” гэснийг “дээд” гэж өөрчилж, 72.4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 54 гишүүн оролцож, 58.7 хувиар санал дэмжигдлээ.

64.Төслийн 72 дугаар зүйлийг 71 дүгээр зүйл болгож, 72.1 дэх хэсгийн “хүчингүйд” гэснийг “хүчингүй болсонд” гэж, 72.2, 72.3 дахь хэсгийн “хууль ёсны” гэснийг “дээд” гэж өөрчилж, 72.4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

92 гишүүнээс 53 гишүүн оролцож, 57.6 хувиар санал дэмжигдлээ.

65.Төслийн 75 дугаар зүйлийг 74 дүгээр зүйл болгож, 75.1 дэх хэсгийн “хуулийн” гэснийг “хуульд” гэж, “хүчинтэйд” гэснийг “гэрлэлтийг хүчин төгөлдөр гэж үзэж, хүлээн зөвшөөрнө.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 55 гишүүн оролцож, 59.8 хувиар санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Увс аймгийн Өмнөговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

66.Төслийн 76 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 75 дугаар зүйл болгох.

“75.1.Гадаад улсад бүртгэгдсэн гэрлэлт нь Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ хуульд нийцээгүй бол Монгол Улсад гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж үзэж, хүлээн зөвшөөрөхгүй.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 52 гишүүн оролцож, 56.5 хувиар санал дэмжигдлээ.

67.Төслийн 77 дугаар зүйлийг 76 дугаар зүйл болгож, 77.4 дэх хэсгийн “хүчинтэйд тооцогдоно” гэснийг “гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр гэж тооцно.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 52 гишүүн оролцож, 56.5 хувиар санал дэмжигдлээ.

68.Төслийн 81 дүгээр зүйлийг 80 дугаар зүйл болгож, 81.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 80.4 дэх хэсэг болгох:

“80.4.Гадаад улсын хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын иргэн хүүхдийн эцэг, эхийг тогтоосон нь энэ хуульд харшлахгүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр гэж тооцно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

92 гишүүнээс 54 гишүүн оролцож, 58.7 хувиар санал дэмжигдлээ.

69.Төслийн 82 дүгээр зүйлийг 81 дүгээр зүйл болгож, 82.2 дахь хэсгийн “тогтоосон нь энэ хуульд харшлаагүй бол хүчинтэйд” гэснийг “Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хуульд харшлаагүй бол Монгол Улсад хүчин төгөлдөр гэж тооцно.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 57 гишүүн оролцож, 62 хувиар санал дэмжигдлээ.

70. Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Энэ 70 болон 71 дүгээр санал дээр гүйцээн боловсруулах чиглэл хүсэлт гаргаж байгаа юм.

Ер нь энэ ямар учиртай вэ гэхлээр гадаад өөрчлөлттэй холбоотой асуудал нэлээн нарийн байна. Хууль зүйн байнгын хорооны гишүүд болон ажлын хэсгийнх нь санал зөрөлдөөн огт байхгүй. Энэ дээр ямар алдаа байхгүй боловч бид нар дахиад мэргэжлийн байгууллагуудыг нэлээд шахуу хугацаатай байсан учраас холбогдох яамд болоод мэргэжлийн байгууллагатай нь дахиж нэг уулзалдъя гэдэг үүднээс энэ саналуудыг гаргаж байгаа юм шүү гэдгээ тодотгож хэлье. 70 болоод 71 дүгээр санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Төсөл гишүүдэд бүгдэд нь тараагдсан байгаа. Бүгдээрээ харж байгаа учир 70 болоод 71 дүгээр зүйл дээр гүйцээн боловсруулах чиглэл олгож байна.

72.Төслийн 86 дугаар зүйлийг 85 дугаар зүйл болгож, 86.2 дахь хэсгийн “5.4-т заасан заалтыг” гэснийг “6 дугаар зүйлд заасныг” гэж өөрчилж, 86.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“85.3.Энэ хуулийн 6.2, 9.3, 61.4, 66.1, 67.4, 82.9, 83.5-д заасан журам, энэ хуулийн 46.2-т заасан тэтгэлэг тогтоох аргачлалыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний дотор тус тус батална.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүний гишүүнээс 47 гишүүн оролцож, 51.1 хувиар санал дэмжигдлээ .

73.Төслийн 87 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 86 дугаар зүйл болгох:

“86.1.Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүнээс 55 гишүүн оролцож, 59.8 хувиар санал дэмжигдлээ.

2.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Энэ дагах хуулиуд дээр ер нь ийм гүйцээн боловсруулах чиглэл хүсэлт гаргаж байна. Тухайлбал, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1-6 дахь саналууд дээр би ингээд хуулийн төсөл болгон дээр нь тус бүр дээр хэлээд.

Ж.Бат-Эрдэнэ: Бүгд дээр нь авах юм уу?

О.Алтангэрэл: Бүгд дээр нь. Ерөөсөө дагах хуулиуд дээр бүгдээрээ. Энд нэгмөсөн хэлэх үү, хууль тус болгон дээр нь санал гаргах уу гээд асуудал байна. Тийм.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн ахлагч Алтангэрэлийн гаргасан саналын дагуу дагалдах хуулиуд дээр бүхэлд нь гүйцээн боловсруулах чиглэл өгч, олгож байна.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Гэр бүлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ. Дараагийн асуудал.

12.26 цаг.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатарын урилгаар Ховд аймгийн Жаргалант сумын “Цаст-Алтай” цогцолбор сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Дараагийнхаа асуудалд орёе.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга танилцуулна. Болдын Уянга таныг индэрт урьж байна.

Б.Уянга: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 529 дүгээр захирамжаар дээрх хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагаар ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, О.Номинчимэг, Ж.Алдаржавхлан, О.Алтангэрэл, Ч.Анар, Р.Батболд, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Ж.Галбадрах, А.Ганбаатар, Г.Ганбаатар, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Б.Жаргалан, Б.Заяабал, С.Зулпхар, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, З.Мэндсайхан, Н.Наранбаатар, У.Отгонбаяр, Б.Пунсалмаа, Ц.Сандаг-Очир, Г.Уянгахишиг, Б.Хэрлэн, Л.Энхнасан, Д.Энхтүвшин, С.Эрдэнэболд нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажилласан.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэн болно.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс нийт 81 зарчмын зөрүүтэй санал, найруулгын санал 1 гаргасан бөгөөд Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураах үед 71 зарчмын зөрүүтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны зүгээс зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэж, анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Цэрэндаваагийн

Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, Нацагдоржийн Ганболд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Сүхээгийн Тэнгис Монгол Улсын Ерөнхий сайдын Засаглал, цахим бодлого хариуцсан зөвлөх, Ганхуягийн Давааням Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор, Сарангэрэлийн Батбаяр Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор, Бат-Эрдэмийн Төрбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” хувьцаат компанийн Мэргэжлийн нэгдсэн зөвлөлийн зохицуулагч, Очирсайханы Баярмагнай. “Эрдэнэс Монгол” хувьцаат компанийн Ерөнхий аудитор.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн, зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн, зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах болон Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.

21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ гэж тус тус заасныг та бүхэнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нэрсийг өгсөн байна. Наранцэцэгийн Алтаншагай.

Н.Алтаншагай: Хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа. Шинэчлэгдэх сайжрах цаг нь болсон. Хэдэн асуултууд байгаа юм. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, үр өгөөжтэй байхыг энэ нийгэм, иргэд маш ихээр хүсэж байгаа, шаардаж байгаа юм. Мэргэжлийн бус улс төрийн томилгоо хийж ялсан намын эсвэл улс төрчдийн шахааны хүмүүсээр дүүргэж байна гэсэн энэ ийм гажуу тогтолцоо ерөнхийдөө амь бөхтэй оршсоор байгаа юм. Энэ хууль батлагдсанаар энэ төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглал хэрхэн сайжрах вэ? Улс төрөөс яг хараат бус байж чадах уу? 1 дүгээрт.

Хоёрдугаарт нь энэ сонгон шалгаруулалтыг яг яаж хийж байгаа юм бэ? Яг энэ хууль, дүрэмжээ нээж чадаж байгаа юм уу? Би өмнө нь бас асууж байсан. Энэ орон нутгийн болон төрийн өмчид яригдахаар л ялсан намаас нөлөө бүхий этгээдүүд л хүн зүтгүүлээд байна гээд л дуулдаад байдаг. Тэр нь явсаар байгаад л тэгээд л батлагдаад л, томилогдоод л цаашаа яваад өгдөг.

Хоёрдугаарт, энэ төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн бүтэц орон тооны хувьд маш үрэлгэн байгаа. Энэ бол ер нь зах замбараагаа алдсан олон. Төрлийн бас энэ худалдан авалтыг төсвийн гадуур хийж байгаа, ашиг сонирхлын зөрчил үүсэж, авлигын гэмт хэрэг үйлдэх нөхцөлийг бүрдүүлж

байгаа. Төрөөс төрсөн тэрбумтнууд гэдэг чинь яг энэ орон нутгийн болон төрийн өмчитүүд дээр байгаад байгаа шүү дээ. Энэ дээр яг мерит зарчмаараа л байх ёстой. Хэн нэгнээс үл хамаарсан, улс төрөөс үл хамаарсан энэ мэргэжлийн, яг энэ тухайн энэ ажлын байран дээр яг шаардагдаж байгаа, ажлын шаардлага хангаж байгаа хүн л очих ёстой.

Гуравдугаарт, энэ төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлага, үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангаа олон нийтэд нээлттэй, ил тод тайлагнадаг болмоор байгаа юм. Яг төлөвлөгөөт бол энэ аудитаас яг шалгалтууд яг ямар хэмжээнд явж байгаа вэ? Цаг тухайд орж чадаж байгаа юу? Үнэн, зөвөөр энэ шалгалтын энэ аудитын дүгнэлтүүд гарч чадаж байгаа юу? Өөрөөр хэлбэл, энэ төрийн өмчит болон орон нутгийн өмчит компаниудын санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, олон нийтэд хяналт тавих, улс төрчдийн энэ хяналтад байлгах бас ангид байлгах энэ тал руугаа л явахгүй бол энэ хардлагыг улам дагуулсаар л байна. Төрөөс төрсөн тэрбумтан гэдэг энэ нэр хоч чинь энэ дээрээ улам их зүүгдсээр л байгаа. Төрийн өмчийн энэ аж ахуйн нэгж байгууллагууд дээр, өмчитүүд дээр яг хариуцлага гэдэг юм уу, ажлын сахилга хариуцлага алдсан дээр яг хариуцлага тооцсон ийм тоон мэдээллийг бас хэлж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг. 4 номерын индэр.

Д.Цолмон: Алтаншагай гишүүний асуултад хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Өөрийгөө танилцуулаарай.

Д.Цолмон: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Цолмон. Хуулийн төсөлд бол төрийн өмчит компанийн удирдлага, зохион байгуулалтын талаар, засаглалын талаар нэлээн нарийвчилсан зохицуулалтууд орсон. Ялангуяа бол нээлттэй компанид тавигддаг засаглалын нийтлэг ийм шаардлагуудыг бол төрийн өмчит компаниудад бол хуульчилж энэ шаардлагыг бол оруулж ирсэн байгаа. Та хэлж байна улс төрөөс хараат бус байх энэ шаардлага бол хамгийн түрүүнд бол тавигдаж байгаа. Гүйцэтгэх удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага бол хуулийн төсөлд дэлгэрэнгүй тавьсан байгаа. Та 21 дүгээр зүйл харах, 24 дүгээр зүйлээс та харах боломжтой. Ингээд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог заагаад, тавигдах шаардлагыг нь заагаад энэ гишүүдийг бол сонгон шалгаруулалтын, нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох энэ зохицуулалт орж ирж байгаа. 25 дугаар зүйл бол энэ тодорхой байгаа. Сонгон шалгаруулалтыг бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төр бодлого зохион байгуулах ийм зохицуулалттайгаар орж ирсэн байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Зочин танилцуулаадахъя. Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Оюунцэцэг багштай 10^г ангийн 2006 оны төгсгөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг нийт гишүүдийнхээ өмнөөс хүргэж байна.

Нэмж тодруулъя Алтаншагай гишүүн.

Н.Алтаншагай: Энэ би санхүүгийн шалгалтай холбоотой асуусан шүү дээ. Энэ дээр хариулт авмаар байна. Мөн хариуцлагын тогтолцоотой холбоотой асуулт асуусан байгаа. Дээр нь энэ саяхан өнгөрсөн долоо хоногийн 14 хоногийн байх Засгийн хуралдааны шийдвэрээр гарсан төрийн өмчийн 14 компанийг татан буулгасан гэсэн Ерөнхий сайдын мэдээлэл байгаа. Энэ дээр бас тодорхой тайлбар өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя. Хэн хариулах вэ? 4 номер.

Г.Давааням: Ажлын хэсгийн гишүүн Давааням МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш. Хариуцлагын тогтолцоо дээр хариулъя. Төрийн өмчит компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан дээр хариуцлагын асуудал нь Компанийн тухай хуулийн механизмаас гажсан шинжтэй явж байсан буюу төрийн байгууллагаас тодорхой удирдамж, чиглэл өгөөд ингээд яг нөгөө өөрсдөө шийдвэрээ гаргаад үр дагавраа өөрсдөө хариуцдаг энэ компанийн механизм өөрөө ажиллах боломжгүй болчихоод удирдлага чиглэлээр явчихаар өөрөөр хэлэх юм бол өөрийн шийдвэрээ гаргахгүй учраас үр дагавраа өөрөө хариуцахгүй гэдэг ийм механизм руу бол орчихсон байсан.

Энэ хуулиар бол яг Компанийн хуулийн механизмын дагуу ТУЗ, гүйцэтгэх удирдлага бол яг компанийн эрх ашгийн үүднээс шийдвэрээ гаргаад энэ хүрээндээ.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Нэмж хариулъя.

Г.Давааням: Хүлээнэ гэдэг ийм зарчим үйлчилж байгаа. Ингээд тодорхой хууль тогтоомж юм уу эсвэл компанид хохирол учруулсан тохиолдолд хувьцаа эзэмшигч болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Төрийн өмчийн хорооны зүгээс Компанийн хуульд заасан төлөөлөл, нэхэмжлэлийг гаргах замаар иргэний хариуцлага, хууль, гэрээнд заасан бас хариуцлагыг гэрээнд заасныхаа дагуу хүлээлгэх боломжтой байдлаар орж ирж байгаа. Санхүүгийн юун дээр нэмэлт хариулт өгөх.

Ж.Бат-Эрдэнэ: Үүрийнтуяа гишүүн нэмж хариулах юм уу? 4 номерын микрофон.

Д.Үүрийнтуяа: Энэ санхүүгийн тайланг нөгөө ил тод байдалтай холбоотой асуудал дээр би тодруулаад хэлчихье гэж бодож байна. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар ч гэсэн ер нь гүйцэтгэлээрээ ч гэсэн санхүүгийн тайлан бол ил тод байгаа шүү дээ. Үндэсний аудитын газар хуваарийнхаа хүрээнд санхүүгийн тайлагналын болон гүйцэтгэлийн нийцлийн аудитыг хийгээд бүгд шилэн дансанд болон ил тодын тайлангууд дээр бүгд гарч байгаа. Энийг бол харж болно.

Дээр нь нэмээд бид нар энэ хууль дээр нэмж оруулж байгаа хяналтын тогтолцооны өөрчлөлт нь бол одоо олон улсын аудит болон Үндэсний аудитын газар давхардуулан аудит хийж байгаа энэ нөхцөл байдлыг үр ашиггүй зардал гаргахгүй байх үүднээс олон улсын аудитын хүлээн зөвшөөрөх, үндэсний аудит энэ дүнг хүлээн зөвшөөрч, нэг аудитаар тооцдог байх зарчмын асуудлыг бас тусгаж оруулж өгч байгаа гэдгийг бас нэмж хэлэх нь зүйтэй байх. Тэгээд Төрийн

өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга бусад асуудлууд дээр нэмэлт тайлбарыг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын индэр.

Б.Цэнгэл: Гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Цэнгэл. Би Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зөвхөн хяналт шалгалтыг хийдэг ийм бие даасан хэлтэс ажилладаг. Энэ бол төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтуудыг хийдэг мөн манай төрийн өмч болон төрийн өмчийн оролцоотой компаниудын төлөөлөн удирдах ТУЗ-ийн дэргэд бол бие даасан бас аудитын хороод ажиллаж байгаа. Ер нь бол зөрчил, дутагдлууд бол бас ерөнхийдөө нийтлэг зөрчил, дутагдлууд бол бас их гарч байгаа. Нэн ялангуяа худалдан авалттай холбоотой зөрчил, дутагдал, зардлыг хэтрүүлэх ийм зөрчил, дутагдлууд бол гарч ирж байгаа.

Тэгэхлээр энэ бүгдээр нь бол бид бол бас арга хэмжээ авч холбогдох. хариуцлага тооцож, хурлаар оруулж байж тогтоол гаргаад энийг хэрэгжилтийг бас тодорхой хугацаа заагаад ингээд бас үр дүнг нь ингээд тооцож ажиллаж байгаа. Энэ дээр бас нэмж хэлэхэд бол гүйцэтгэх удирдлагууд болон захирлууддаа бол.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Б.Цэнгэл: Контрактыг гэрээ дээр нь бол бас энэ заалтуудыг бол нэлээд түлхүү оруулж өгч ажиллаж байгаа. Сая манай ажлын хэсгийн ахлагч дээр хэллээ бид бол энэ хуулийн төсөлд бол 6 дугаар бүлгийг бүүр бүхэл бүтэн бүлгийг энэ дээр бол оруулж өгч байгаа. 37 дугаар зүйл дээр бол компанийн аудитын тогтолцоо ямар байх вэ гэдэг бас ийм орж ирсэн. Тэгээд компанийн дотоод аудитын чиг үүрэг ямар байх юм бэ гээд бол нэлээн тодорхой энэ зүйлүүдийг оруулж өгсөн. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Түвшиний урилгаар Байлдааны гавьяаны гавьяаны Улаан тугийн одонт, Сүхбаатарын одонт Нийгмийн аюулаас хамгаалах яамны Цэргийн дээд сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс эрүүл энх, аз жаргал, амьдралын сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Алтаншагай гишүүн тодруулъя.

Н.Алтаншагай: Засгийн газрын хуралдаанаар 14 төрийн өмчийг татан буулгасантай холбоотой мэдээлэл авъя. Тэр дээр тодруулж өгөөч. Яг татан буугдсан юм уу, ямар шийдвэр гарсан юм бэ?

Ж.Бат-Эрдэнэ: 4 дугаарт индэр.

Д.Цолмон: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Цолмон. Алтаншагайн гишүүний асуултад тодруулъя. Засгийн газрын хуралдаанаар бол энэ төрийн өмчит компаниудын үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, засаглалыг сайжруулах энэ шинэчлэлийн бодлогын арга хэмжээнүүд бол явж байгаа. Энэ

хүрээндээ бол энэ “Эрдэнэс Монгол” нэгдлийн харьяа 14 компанийг татан буулгах бол шийдвэр гарсан. Энэ дээр бол зарим компаниуд нь бол охин компанийн чиг үүргийг толгой компанид нь нэгтгэх чиг үүргийг нь нэгтгэж татан буулгах. Зарим компаниудын хувьд бол энд гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан энэ компаниудын хувьд бол бас хувь эзэмшлээс гарах, татан буулгах энэ үндсэн даалгавраа чиг үүрэг бол авсан. Үүний дагуу бол “Эрдэнэс Монгол” компанийн төлөөлөн удирдах зөвлөл дээр хууль тогтоомжийн дагуу холбогдох шийдвэрүүд нь гараад явна.

Ж.Бат-Эрдэнэ: Отгоншарын Батнайрамдал гишүүн алга байна. Цэндийн Баатархүү гишүүн. Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Энэ өдрийн мэндийг хүргэе. 2 зүйлийг тодруулъя гэж бодож байна. Энэ маш чухал хууль ийм байгаа. Үнэхээр энэ төрийн өмчит компанийн ил тод байдлыг сайжруулахгүй бол нууцын гэрээ гэдэг зүйлийн дор маш том худалдан авалтууд хийгддэг. Татвар төлөгчдийн мөнгө яаж захиран зарцуулагдаж байгаа юм бэ гэдэг нь тодорхойгүй байдаг. Энэ нь бол маш олон хүмүүсийн хардлагыг дагуулдаг. Тэгэхээр энэ хууль дээр энэ төрийн болон орон нутагт өмчит үйлдвэрийн газрын худалдан авалтыг яг ямар шалгуураар ил тод болгож байгаа юм бэ? Ардчилсан намын бүлэг бол Төрийн нууцын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг өргөн бариад өнөөдөр хэлэлцүүлж байгаа. Төрийн нууц гэдэг тамга дараад ингээд худалдан авалтын гэрээгээ нууцалдаг. Энэ байдал зогсох уу гэдгийг нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт нь энэ төрийн өмчит компани чинь зарим нэг нь төрийн үйлчилгээг үзүүлж явдаг. Тухайлах юм бол нийслэлд нийтийн тээврийн компани яг зах зээлийн өртгөөрөө биш иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ гэдгээрээ явж байгаа энэ төрийн өмчит компанийн ангиллыг нийтийн үйлчилгээний компани гэдэг ангилалд оруулсан уу?

Гуравдугаарт нь төрийн өмчит компаниуд ашигтай ажиллахын тулд тодорхой хэсгийг нь хувьчилж, хувь нийлүүлэгчийг хувийн хэвшлээс татан оруулдаг. Энэ зөв байдаг. Гэтэл хувь нийлүүлж орж байгаа хувийн хэвшил бол хувиа өсгөө, үр ашгаа сайжруулъя, ашигтай ажиллая гэдэг зорилгоор ордог. Гэтэл нөгөө талынх нь хувьцаат хувьцаа нь төрийн өмч байдаг учраас давамгайл байдал үүсгэхгүй шүү, худалдан авах үйл ажиллагаанд орохгүй шүү гэдэг ийм хязгаарлалтууд гараад 34 хувиа хувьчилсан төрийн өмчит компаниуд 34 хувь нь ашигтай ажиллая гээд ордог. Нөгөө төрийн өмчийн хувьцаатай тал нь шударга өрсөлдөөний зарчмаар ажиллах ийм шаардлага үүсдэг. Энэ бол олон салбарт ийм зүйл гарч байгаа энийг бүгдээрээ мэдэж байгаа. Энийг яаж зохицуулж байгаа вэ гэдгийг тодруулмаар байна.

Ж.Бат-Эрдэнэ: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Манай Баатархүү гишүүн маш чухал чухал асуудлуудыг бас хөндлөө. Ер нь энэ ил тод байдлын асуудлуудыг бүхий л түвшинд ярьж байгаа юм. Зөвхөн худалдан авах ажиллагаа биш. Түрүүн Үүрийнтуяа дарга бас хэллээ. Ер нь компанийн тайлан, мэдээлэл нууцад хамрагдуулснаас бусад бүх мэдээллүүд ер нь ил тод байх ёстой. Энэ зөвхөн олон нийтээсээ гадна хувьцаа эзэмшигч, жижиг хувьцаа эзэмшигч, эргээд энэ ер нь бол төрийн үйл ажиллагаанд хяналт тавих

чиглэлийн бүхий л байгууллагууд энэ хүртээмжтэй ил тод байх ёстой гэдэг энэ зарчмын агуулгууд энд бол бүрэн тусаж байгаа. Нууцын асуудлыг бол мэдээж энэ Компанийн хуулиар зохицуулахгүй. Бас Цогтгэрэл нарын гишүүдийн болоод Засгийн газрын бас өргөн барьсан Нууцын тухай хууль энэ хуулиудын араас бас хэлэлцэгдэж байна. Энэ дээр цаашдаа энэ аж ахуйн үйл ажиллагаануудыг нууцалдаг юмнуудыг нууцалдаггүй байх энэ асуудлыг улам тодруулж өгөх байх. Ер нь бол цаашдаа буруу гэж санал нэг байна.

Хоёрдугаарт худалдан авах ажиллагааны асуудлыг би бас ирэх 7 хоногт шинэчилсэн найруулгыг өргөн барих гэж байна. Энэ чиглэлдээ бас энэ төрийн өмчит компаниудын худалдан авах ажиллагааг ил тод болгох, тайлан мэдээллийг шилэн дансанд гүйцэд оруулдаг байх энэ чиглэл дээрээ энэ хуультай уялдаад явчихна.

Мэдээж энэ компанийн засаглал бүх үйл ажиллагааг ил тод байлгах асуудал нь компанийг таны хэлж байгаа нөгөө хувьчлах гэхээсээ илүүтэйгээр олон нийтийн болгох, тодорхой түвшинд мэргэжлийн оролцогчдын хяналтыг бий болгох, ард иргэдийн хяналтыг бий болгох. Яагаад энэ төрийн өмчит компанийн бас ашигтай ажиллаж байгаа компаниудыг ашигтай ажиллаж болох компаниудыг бас ард иргэд хувьцааг нь эзэмшиж болохгүй байгаа вэ гэдэг зүйлийг бид хэд бас ярих ёстой.

Тийм учраас энэ хувьчлал гэдэг зүйлийг 90-ээд оны дундуур бас явсан алдааг давтахгүйгээр илүү их иргэд рүүгээ үр өгөөжийг нь хүртдэг тэр бололцоонуудыг бас энэ Төрийн болон орон нутгийн өмчит энэ компанийн тухай хуулиар бид нар бас тодруулж өгч байгаа. Уг асуудлууд цаашдаа энэ хуулийн 44 дүгээр зүйл дээр бид тусгаад явна нэлээн тодруулж өгнө. Эцсийн хэлэлцүүлэг дээр ч гэсэн энэ асуудлыг нэлээн ажлын хэсгээр сайтар ярилцъя гээд бодож байгаа.

Тэгэхээр ер нь бол аль болохоор компанийн ашигт ажиллагаа, үр өгөөжтэй байх энэ чиглэлд нь олон нийтийн хяналт, тэгээд ил тод байдлыг хангах чиглэлд оруулж ирнэ.

Хоёрдугаарт энэ орон нутгийн яг компани буюу нийтийн үйлчилгээний компани гэдэг энэ ангиллууд бол орж ирж байгаа гэдгийг танд хэлмээр байна. Энэ компаниуд ч гэсэн мөн улс төрөөс бас ангид байх энэ зүйлүүд нь тавигдаад ирнэ. Ийм учраас бас нийслэл гэлтгүй энэ орон нутаг, аймгууд дээр байгаа энэ улс төрөөс хамаарал бүхий томилгоо, ТУЗ-д нь улс төрчид орж удирдаж байгаа энэ бүх зүйлүүд бол энэ хуулиуд гараад үе шаттайгаар цэгцрээд явна гэдэг зүйлийг танд хэлмээр байна. Сүүлийн асуултад нь ажлын хэсгээс хариулчих. Хэн хариулах билээ? МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багшид дарга микрофон өгөөд.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг 4 дугаартай индэр.

С.Батбаяр: Гишүүний асуултад хариулъя. Сайнзориг гишүүний асуулт, хариулттай давхцуулахгүйгээр хуулийн төслийнхөө талаар маш товч аль заалт дээр байгаа вэ гэдгийг нь хэлье. Нууцын тухай асуудлаар гэрээг нууцалдаг гэсэн асуудал байгаа. Одоогийн хуулийн төсөл дээр 49 дүгээр зүйл дээр Шилэн дансны тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаас

гадна энэ хуулиар төрийн болон орон нутгийн өмчит компаниуд нийт 15 төрлийн мэдээллийг ил тод байлгахаар хуулийн төсөлд тусгасан байгаа.

Энд нөгөө бараа, ажил үйлчилгээ, худалдан авалт болон нийлүүлэгчийн талаарх мэдээлэл, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллүүд бол бүгд ил тод буюу цахим хаягаараа олон нийтэд ил байна гэсэн энэ заалтыг бол хуулийн төсөлд оруулсан байгаа.

Хоёр дахь асуулт нь болохоороо нийтийн үйлчилгээний ангилалд оруулсан уу гэдэг асуулт байгаа. Хуулийн төсөл дээр компанийг арилжааны болон нийтийн үйлчилгээний гэдэг 2 янзаар компани дүрэмдээ заах замаар ангилна гэдэг байдлаар оруулсан. Нийтийн үйлчилгээний гэдэг тайлбарыг бол хуулийн төсөлд оруулаад ямар ямар төрлийн компаниуд нийтийн үйлчилгээнийх байж болох вэ гэдэг дээр шалгуур үзүүлэлтүүдийг бол хуулийн төсөлд бол тусгасан байгаа. Нийтийн үйлчилгээний компани ямар ялгаатай вэ.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

С.Батбаяр: Нийтийн үйлчилгээний компани нь бол ажлын гүйцэтгэлээр бол цэвэр ногдол ашиг хуваарилах буюу ашгийн төлөөх гэдгээс илүүтэйгээр нийтийн үйлчилгээний үүргийг гүйцэтгэдэг байдлаар бол шалгуур үзүүлэлтүүдийг нь бас хуулийн төсөл дээр нарийвчлан тус тусад нь зохицуулсан байгаа.

Гурав дахь нь болохоороо төрийн өмчийн компанитай давамгай байдал үүсгэхгүй байх гэдэг дээр бол хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр төрийн өмчит компанийн үйл ажиллагааг баримтлах зарчим гэдэг дээр ямар нэгэн байдлаар төрийн өмчит компани гэдгээрээ хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй буюу ил тод, давамгай байдал эдлэхгүй гэдгийг бол зааж өгөөд, зах зээлд шударга өрсөлдөх гэдгийг болохоороо тусад нь тайлбар байдлаар татвар болон ямар нэгэн татаасны болон худалдан авах ажиллагаа зэрэг дээр бол давамгай байдал эдлэхгүй гэдгийг бол маш нарийн тодорхойлоод 5 дугаар зүйл дээр бол заасан байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирын урилгаар Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1995 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс эрүүл энх, аз жаргал, амьдралын хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Цэндийн Баатархүү гишүүн тодруулъя.

Ц.Баатархүү: 3 жил дараалан ашиггүй ажилласан бол хувьчлах тал руугаа явж байгаа. Тэгэхээр энд ямар хардлага яваад байна вэ гэхээр нийтийн баялаг буюу олон жил Монголын ард түмний хуримтлуулсан, бий болгосон энэ нийтийн баялгийг зориуд ашиггүй ажиллуулаад хэн нэгэн этгээд хувьчлаад авчих вий гэдэг энэ болгоомжлол байна. Тийм учраас энэ хууль дээр тодорхой заамаар байгаа юм. Аль болохоор энэ нийт иргэддээ баялгийн хувь, энэ компанийн хувьцаа эзэмшүүлэх, олон нийтэд эзэмшүүлэх энэ тал руугаа явуулъя гэсэн энэ саналтай бол би санал нэг байгаа гэдгээ хэлье.

Хоёрдугаарт нь жил болгон хувийн хэвшилтэй л хувийн хэвшил өрсөлдөх ёстой. Одоо бол хувийн хэвшил бол төрийн өмчийн компанитай өрсөлдөж ялагдаж байна л даа. Тэгэхээр хувийн хэвшлийн хийх боломжтой зүйл гэдгийг ямар байгууллага жил болгон гаргах юм бэ энэ шалгуурыг?

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Төрийн өмчит компаниудыг үр ашигтай байлгах тухай асуудал дээр зарчмын хувьд тантай санал нэг. 3 жил дараалан ашиггүй ажиллуулахаар хувьчилдаг гэдэг энэ, ашиггүй ажиллахаар хувьд очдог гэдэг ойлголтыг бол байж болохгүй. Одоо менежментийн хувьд гүйцэтгэх удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлтэй нь хариуцлагын тогтолцоог нь тодорхой болгож өгөх гэж байгаа юм. Орон тооны байх асуудлыг нь ярьж байгаа юм. Үүрэг, даалгаврын гэрээ хийдэг. Тэр даалгаврын гэрээг дүгнэдэг.

Хэрвээ үр ашигтай ажиллуулах үүргээ хэрэгжүүлээгүй бол гүйцэтгэх удирдлагатай нь хариуцлага тооцдог, ажлаас нь чөлөөлдөг, сонгон шалгаруулалтыг нь зарладаг. Энэ сонгон шалгаруулалт нь нээлттэйгээр зарлагдаж менежментийн баг нь үр ашигтай ажиллуулсныхаа төлөө тодорхой урамшууллаа авч ажилладаг энэ механизм руу оруулах гол бодлогын концепцууд энэ хуулиар хийгдэж байгаа гэдгийг танд хэлэх нь зүйтэй байх.

Хоёр дахь асуулт дээр ажлын хэсгээс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Цэнгэл дарга хариулъя 4 номероос.

Ж.Бат-Эрдэнэ: Цэнгэл дарга 4 номерын индэр.

Б.Цэнгэл: Гишүүдийн асуултад хариулъя. Тэгэхээр бид нар бодлого буюу үндсэн чиглэлийг Их Хурлаар оруулж батлуулахаар энэ хуульд бол нэлээн тодорхой туссан байж байгаа. Тэгэхлээр энэ бодлого буюу үндсэн чиглэл дотор бол ерөөсөө компани тус бүрээрээ бид нар оруулах юм. Ямар компаниудыг нийтийн үйлчилгээний чиглэлийнхээр явуулах юм, ямар компаниудыг стратегийн гэдэг чиглэлээр нь авч үзэх юм, ямар компаниудыг яг зүй ёсны монопол гэж авч үзэх юм бэ гэдгийг бол ерөөсөө компани компаниар нь бүр тус тусад нь бүр маш нарийн шалгуур үзүүлэлт л гаргаж ирж байгаад Их Хуралд өргөн барьж байгаад Их Хурлаараа энийгээ батлуулаад явна.

Энэ нь хуучин бол салбарын сайд орж ирээд л компани байгуулдаг байсан явдлыг таслан зогсоож байгаа энэ хуулиар. Тэгэхээр энэ бол маш их өндөр шалгууртай бол явна гэж бол ойлгож болно. Түрүүний таны асуултад бол 49 дээр бол одоо 3 жил дараалан санхүүгийн зорилт үр дүнд хүрээгүй бол өөрчлөн байгуулахад татан буул.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Баатархүү гишүүн ямар үйл ажиллагааг хувийн компаниар эрхлүүлж болох вэ гэдгийг яаж тодорхойлоо вэ гэсэн тийм үү? Энэ дээр хариулаадхаач. Энэ бол маш чухал шүү дээ. Маш чухал. Сайнзориг гишүүн ямар үйл ажиллагааг хувийн компани эрхэлнэ гэж тодорхойлох юм?

П.Сайнзориг: Энэ дээр бол төрийн өмчит компанийг бол юу гэдэг юм нэг өдөр зүүдэлж сэрээд байгуулах энэ боломжийг л хязгаарлаж өгч байгаа. Үүгээрээ

бид хэд энэ зах зээл рүү шууд мэдэгдэл хийхгүйгээр хувийн хэвшлийн хийж байгаа бизнес дээр давхцуулж бизнес рүү орох энэ нөхцөл байдлуудыг хязгаарлана. Компани байгуулах асуудал дээр зах зээл болон ажиллах хүч, эргээд энэ бараа, үйлчилгээг худалдан авах байдал, дээрээс нь энэ бараа материал үйлдвэрлэхэд орох тэр, бараа материалын татан авалт ч гэдэг юм уу бүх зүйлүүдийн судалгааг хийгээд энэ дээр төр орох уу үгүй юү гэдэг энэ эцсийн дүгнэлтийг мэргэжлийн этгээдүүдээр гаргаад эцсийн байдлаараа улс, Засгийн газар, эсвэл тодорхой түвшинд иргэдийн хурал нь шийдээд явах юм байгаа.

Түрүүн бас Цэнгэл дарга хэлж байна. Энэ бүх төрийн өмчит компаниудын нэг бүрчлэн бодлогын асуудлуудыг Улсын Их Хурлын хяналтаас бол гадуур тавихгүй. Энэ бодлогоо жил бүр Улсын Их Хуралдаа намрын чуулганд тайлагнаад тодорхой авах арга хэмжээнүүдийг төлөвлөөд явж байж энэ зах зээлийг.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Та хэд арай ерөнхий хариулаад байна л даа. Энэ салбарын энэ үйл ажиллагааг хувийн хэвшил хийх боломжтой гэдэг шалгуурыг Төрийн өмчийн хороо магадгүй жил болгон энэ тэр гаргах энэ нарийн заалтыг оруулахгүй бол болохгүй байгаа байхгүй юу. Одоо ажиллаж байгаа төрийн болон орон нутгийн өмчит компаниудын үйл ажиллагаа явуулж байгаа салбар болгоноор нь энийг хувийн хэвшил хийх боломжтой юм байна. Энэ дээр бол төрийн өмчит компани, орон нутгийн өмчит компани байх шаардлагагүй юм байна гэдэг үүднээсээ зарим компанийг бол иргэдийн хувьцаатай болгох, зарим компанийг татан буулгах, нэгтгэх энэ ажил энэ хууль батлагдсаны дараа хийгдэх ёстой байхгүй юу. Тэгэхээр энийг хэн хариуцаж хийх юм бэ? Төрийн өмчийн хороо юм уу, Засгийн газар юм уу, Улсын Их Хурал юм уу, иргэдийн хурал юм уу? Та нар ингээд бүх субъектийг хэлчихлээ шүү дээ. Субъект хэрэгтэй байна. Төрийн өмчийн хороо бол ер нь ажлаа илүү хариуцлагатай хийх ёстой шүү л гэж би хэлмээр байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ Баатархүү гишүүний асуулгаад байгаа асуулт чинь маш чухал асуулт шүү дээ. Жишээ нь АЗЗА компанийг бид нар хувийн хэвшлээр хийлгүүлэх боломж бололцоо байгаа шүү дээ. Тэгэхээр энийг тод яаж тодорхойлох юм бэ, хэн тодорхойлох юм бэ? Тэгээд энэний тодорхойлолтын үндсэн дээр зарим нэгийг нь татан буулгаад хувийн хэвшлээр хийлгүүлэх ийм боломж бололцоог нь нээж байж л бид нар хувийн хэвшлээ дэмжинэ шүү дээ. Хэн хариулах юм? Хууль санаачлагч. Хууль санаачлагч Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Баатархүү гишүүний асууж байгаа асуултын хариулт бол намрын чуулганаар Засгийн газрын оруулж ирэх асуудал байгаа. энэ хууль дээр, энэ хууль дээр юу орж ирж байгаа вэ гэхээр одоо баталчихвал намрын чуулганаар бид төрийн өмчийн компанийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг Улсын Их Хуралд оруулж ирнэ. Энэ баримт бичгийн дагуу аль аль компаниудыг татан буулгах, аль аль компаниудыг хувьд шилжүүлэх гэдэг тодорхой санал оруулж ирнэ.

Ер нь бол Ерөнхий сайд бас нэмж хариулах байх л гэж юу хариулбал Ерөнхий сайд бол бодлогоо зарлачихсан байгаа. Төрийн өмчийн компаниудын талаар баримтлах бодлогоо Засгийн газар дээр бол ярьчихсан байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: 13 цаг болсон тул чуулганы хуралдааныг цааш нь үргэлжлүүлэхээр шийдвэрлэлээ. Ерөнхий сайд хариулах юм уу? Ажлын хэсэг нэмье. Энэ тодорхой хариулчихмаар байна саяынх дээр. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Яг аж ахуйн нэгжүүдийг тухайлах юм бол төрийн өмчийг ашиглаад үйл ажиллагаа явуулж байгаа бүх аж ахуйн нэгжүүдийг бүрчлэн жагсаагаад энэ нь төрийн өмчийн өмчийг ашиглаж байгаа, энэ нь зах зээл дээр хувийн хэвшилд өгч болно, энэ нь зөвхөн төр хийх ёстой гэдэг ангиллыг энэ хуулиар гаргахгүй. Хуулийн үндсэн концепц дотор төрийн өмчийн энэ үндсэнд хэрхэн, яаж ашиглах вэ, цаашдаа яаж авч явах юм бэ гэдэг, энэ төрийн өмчит компаниудыг яаж ангилж явах юм бэ гэдэг Үндсэн чиглэлийг боловсруулах тухай хуулийн зохицуулалтыг энэ үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар баталж явах тухай зохицуулалтыг оруулж өгсөн байгаа. Тэгэхээр энэ үндсэн чиглэлийн хүрээнд Засгийн газар өөрөө энэ бодлогоо тодорхойлж, тухайн байгаа компаниудынхаа нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, судалгаа шинжилгээнд үндэслэсэн энэ үндэслэл дээрээ бодлогоо оруулж ирнэ. Энийг Улсын Их Хурал батална. Энэ харилцааг энэ хуулиар зохицуулж өгч байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ер нь бол чухал асуудал байлаа шүү. Болдын Уянга гишүүн.

Б.Уянга: Хэд хэдэн зүйлийг тодруулъя. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод, засаглалыг сайжруулах тухай хууль гээд нэрээсээ авхуулаад л дэмжих л ёстой хууль. Дэмжиж байгаа. Гэхдээ дандаа тоо баримтууд нь 2023 оны жилийн эцсийн байдлаар гэсэн байсан юм. Тэгэхээр нэгэнт 2026 онд эхний хэлэлцүүлэг нь явж байгаа юм чинь 2025 оны байдлаар ер нь хамгийн сүүлийн байдлаар төрийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын нийт орлого нь хэд байсан юм? Нийт зардал нь хэд байгаа юм? Хэдэн төгрөгийн ашигтай ажилласан юм бэ гэдгийг нь хэлээд өгөөч. 23 оны жилийн эцсийн байдлаар бол 23.6 их наяд төгрөгийн орлоготой, 16.9 их наяд төгрөгийн зардалтай тэгээд 4, 5 их наяд төгрөгийн ашигтай байсных нь ихэнх нь “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэт” үйлдвэр 2 байсан байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэнээс яг өөрчлөгдсөн юмнууд нь юу байна вэ? Энэ тоон мэдээллийг ажлын хэсгээс авна.

Өөр нөгөө асуулт нь болохоор орон нутгийн өмчит компаниуд дээр байгаа юм. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийг аягүй ихээр байгуулаад байгаа юм. Тэгээд хэмнэлтийн тухай хуультай холбоотойгоор орон нутгийн өмчит компаниудыг байгуулахыг болилоо гэж байтал байгуулагдаад байгаа шиг ажиглагдаад байгаа юм. Тэгээд бас энэ танай 2023 оны дата дээр орон нутгийн өмчит 275 хуулийн этгээд нийт 87.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан гээд байгаа юм. Энэ өнөөдөр 2025 оны эцсээр нэмэгдэв үү, багасав уу? 275 гэсэн байгаа энэ орон нутгийн өмчит компанийн тоо нь өсөх үү? Өссөн байгааг нь бол мэдээд байгаа шүү. Яг тоог нь тэгэхдээ хэлээд өгөөрэй. Энэ нь болохоор ажлын хэсгээсээ эдгээр мэдээллүүдээ авчихъя.

Эхний хэлэлцүүлэг яваад тэгээд өөрөө Эдийн засгийн байнгын хороон дээр байж байхдаа зарчмын зөрүүтэй саналууд дээр нь байсан. Гэхдээ мэдээж ажлын хэсэг ажиллаж байхдаа санхүүгийн сахилга бат дээр нь ямар нэгэн ажил мэдээллийг сонсов уу? Хуулийн аль заалтууд нь энэнтэй холбогдолтой

боловсруулагдав уу? Тэгээд алдагдалтай хэрвээ компаниуд ажиллаж байх юм бол хяналтдаа тавиад арга хэмжээгээ яг яаж авах юм бэ? Ашиггүй компаниудыг татан буулгаад эсвэл хувийн хэвшилд шилжүүлэх тал дээр ажлын хэсэг дээр ямар саналууд хэлэлцэгдээд, өнөөдөр ямар саналууд нь нэгдсэн чуулганаар хураагдахаар бэлтгэгдсэн байгаа вэ? Ийм 2 асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Энэ төрийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль бол Оюун-Эрдэнийн Засгийн газрын үед өргөн мэдүүлсэн хууль. Ингээд 2 жил болж байна Их Хурал дээр. Тэгээд энэ хуулийг батлан гаргах зайлшгүй шаардлага нь юу вэ гэхээр яг төрийн өмчит компани дээр шинэчлэл хийе гэхээр яг үнэндээ бол бид нар бол улс төрөө дийлэхгүй юм байна лээ. Энэ төрийн өмчит компанийн чинь захирлууд бүгдээрээ хамгаалалттай.

Тэгээд одоо сая энэ Эрдэнэс Монголыг Чингис хаан баялгийн сан гээд хуулийнх нь дагуу ажиллуулаад 14 төрийн өмчит компани татан буугдаж, 67 тэрбум төгрөг хэмнэсний дараа бол утасны дуудлага бол тасрахаа больсон. Тэгээд яг үнэндээ нөгөө олон бүтээмжийн алдарт менежерүүд чинь ардаа хамгаалалттай учраас зовлон болж байна. Тэгэхээр энэ хуулийг гаргаж өгөөч л гэж би Их Хурлаас хүсээд байгаа юм. Хэрвээ тэгэх юм бол төлөөлөн удирдах зөвлөл гээд байгаа энэ ТУЗ чинь өөрөө хараат бус болно. Яагаад гэвэл энэ босго шаардлагыг бол давах тийм улс төрөөс хамаарал бүхий хүмүүс бараг олдохгүй болно.

Яагаад гэхээр төрийн өмчит компани ашигтай ажиллахын тулд мэргэжлийн удирдлагаар хангахгүй бол хэдүүлээ ингээд ийм төрийн өмчит компанийг цэгцэлнэ гээд байдаг. Тэгээд нэг улс төрчийн хүнийг нөгөө улс төрчийн хүнээр солиод юу ч өөрчлөгдөхгүй. Тийм учраас бол энэ хуулиа ажлын хэсэг бол яг анх орж ирснээр нь энэ бол хатуу зохицуулалтуудтай тэрүүгээр нь гаргаад өгчих нь зүйтэй юм байна лээ. 101 төрийн өмчит компани өнөөдөр энэ орон нутагт энэ орон нутагт болоод энэ салбарын яамнуудын дэргэд энэ олон төрийн өмчит компани, дээрээс нь төрийн өмчит үйлдвэрийн газар гээд янз бүрийн статустай ашиг, орлого олдоггүй тэгээд ерөөсөө хараат бус байх нөхцөл ерөөсөө бүрддэггүй. Тэгээд энэ компаниудыг чинь хэрвээ удирдлагыг яг мэргэжлийн удирдлагаар соливол үнэхээр бодитой өөрчлөлт гарна. 14 компани татан буулгалаа гэж юу өөрчлөгдөж байгаа юм. Бүх юм хэвийн үргэлжилж байгаа шүү дээ одоо.

Тэгэхээр энэ хууль гарснаараа орон нутагт ч гэсэн тийм дур дураараа орон нутгийн өмчит компани байгуулаад байх нь багасна, боломжгүй. Их Хурлаас зөвшөөрөл авна хэрвээ шаардлагатай гэж үзвэл. Ингээд бид нар намар энэ хуулийн дагуу төрийн өмчит компани дээр баримтлах Засгийн газрын үндсэн чиглэлийг өргөн барихтай зэрэгцүүлээд бид нар яг хэдэн хувийг нь нээлттэй болгох юм, IPO гаргах юм, хэдэн хувийг нь иргэдэд нь эзэмших юм, орон нутагт нь эзэмшүүлэх юм уу, үгүй юм уу, хувьцаагаа арилжаалж болох юм уу үгүй юм уу гэдгийг нь бүгдийг нь нээнэ. Тэгээд Чингис хаан Баялгийн сан нэгдэл бол тун удахгүй бол бид нар олон улсын хөрөнгө оруулалтын менежментийн компанид менежментийг нь өгнө. Тэгээд тэр менежментийн компани үнэлгээ, аудитаа хийсний дараа намар төсөвтэй зэрэгцүүлээд IPO гаргах эрхээ Их Хурлаас авна.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг нэмж хариулъя 4 номер.

Ц.Баяр-Эрдэнэ: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Баяр-Эрдэнэ. Уянга гишүүний асуултад хариулъя. Бид яг энэ хуулийг өргөн барьж байх үед бол 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг бол тусгаж, холбогдох материалыг хавсаргасан байгаа. Тэгээд бол 2025 оны энэ төрийн өмчит компаниуд эдийн засгийн үндсэн зорилтот түвшний тайланг бол аудитаар баталгаажсаны дараагаар нэгтгээд гаргачихсан байгаа. Тэгээд энэ мэдээллүүдийг өгье.

Тухайлбал, 2023 онд 99 хуулийн этгээд байсан. 2025 онд бол 69 толгой компани буюу хуулийн этгээд 101 компани байгаа. Ажиллагсад бол 2025 онд 54.5 мянган ажиллагсад байна. 2023 онд бол 58 мянган ажиллагсад байсан. Нийт зардал 2023 онд 17 их наяд орчим төгрөг байсан бол 2025 оны гүйцэтгэлээр 22.6 их наяд. Цэвэр ашиг 2023 онд 5 их наяд.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Ц.Баяр-Эрдэнэ: 2025 онд 1.8 их наяд болсон. Энэ бол бас цэвэр ашгийн үзүүлэлт бол буурсан байгаа. Борлуулалтын орлого үндсэндээ 2023 онд 24 их наяд байсан. 25 онд 25.3 их наяд болсон байгаа. Ер нь бол 25 онд 23 оны үзүүлэлттэй харьцуулах юм бол төрийн өмчит компаниудын маань ашигт ажиллагаа нэлээд буурсан ийм үзүүлэлт байгаа. Энэ бол бас нэлээд олон хүчин зүйлээс хамаарсан гэдгийг онцолж хэлье. Бид 25 оны үзүүлэлтүүдийг саяхан энэ аудитын тайлан нэгтгэж гарсан учраас үзүүлэлт бүрээр нь нэгтгэчихсэн байгаа.

Орон нутгийн өмчит компаниудын хувьд бол үндсэндээ 390 орчим компани байгаа. Эдгээрээс бол 120 орчим нь бол Улаанбаатар хотын харьяаны орон нутгийн өмчит компаниуд байгаа. Орон нутгийн өмчит энэ 390 орчим компани.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Ц.Баяр-Эрдэнэ: Орон нутгийн өмчит компаниудын хувьд бол ашиг, алдагдлын хувьд бол ерөнхийдөө 50 хувь нь алдагдалтай, 50 орчим хувь нь бол ашигтай ажилласан байгаа. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд маань бол нэгжийн хуулиар ер нь орон нутгийн иргэдэд үйлчилсэн нийтийн үйлчилгээний өөрөөр хэлбэл нийгмийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг иймэрхүү чиг үүргийн компаниуд байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Сайнзориг гишүүн. Ажлын хэсгийн ахлагч.

П.Сайнзориг: Нийтийн үйлчилгээ буюу энэ орон нутгийн өмчит компани зөв байгаа. 283 орон нутгийн өмчит компани байна. 25 оны байдлаар бол 3.4 их наяд төгрөгийн орлоготой, нийт зардал 3.1 их наяд, цэвэр ашиг 222 тэрбум төгрөг байсан. Нийт авлага 214 тэрбум байгаа. Иймэрхүү байдалтай ажиллагсдын тоо 22 мянга 47 он байна. Цалингийн сан нь 668 тэрбум төгрөг хүрчхээд байгаа. Тэгэхээр энэ бас зарим асуудал дээр бол орон нутаг дээр энэ нийтлэг үйлчилгээ буюу хүргэхээс өөр аргагүй байгаа. Тэрийг бол хувийн хэвшил сонирхох бол боломжгүй. Хүн ам багатай, дээрээс нь ер нь эхний хөрөнгө оруулалтууд маш өндөртэй үйл

ажиллагаанууд дээр бас хувийн хэвшил ордоггүй. Дээрээс нь яах вэ тарифын зохицуулалт гэж асар юм байна. Төвлөрөл ихтэй Улаанбаатар хот дээр жишээ нь эрчим хүчний станц, дулааны станц барилаа гэхэд тодорхой хэмжээнд ашигтай ажиллах магадлал боломж байгаа бол яг хүн ам багатай ч гэдэг юм уу энэ дээр энэ бол үндсэндээ л одоо бас орон нутагтайгаа хам

Ж.Бат-Эрдэнэ: Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Тоонуудаа зөрүүтэй л аваад байна даа тээ? Сая тэр манай боссон дарга орон нутгийн өмчид 390 компанийн 120 нь Улаанбаатар хотод гэлээ. Сайнзориг гишүүн маань 283 байна гээд тэгэх юм. 2025 оных нь жилийн эцсийн байдлаар аудитлагдсан гээд тэгэхээр иймэрхүү зөрүүтэй байдлууд дээрээ л анхаарах хэрэгтэй л байна даа. Өөр юу гэх вэ дээ тээ. Сая хэлсэн тоо бол 390 байсан шүү дээ. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр гишүүн хариулъя. Хууль санаачлагч.

Б.Энхбаяр: Төрийн болон орон нутгийн өмчийн нийт хэчнээн компани яг тоо бүтэн зураглалаар нь ярих юм бол энэ маш зөрүүтэй байгаа. Төрийн өмчийн хороо, Сангийн яам, нийслэл гээд энэ ажил тоолох, хянах ажил яагаад ийм эмх замбараагүй, хяналтгүй хүрээнээс гарчхав гэхээр орон нутгийн өмчийн компаниудыг бол хурлууд, аймаг, нийслэл, сум, дүүргийн хурлууд өөрсдөө байгуулаад явж байгаа. Гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд ярих юм бол Засгийн газар өөрөө байгуулаад явж байгаа. Тэгэхээр энэ хууль гарах юм бол орон нутгийн өмчийн компаниудыг байгуулахыг Улсын Их Хурал шийднэ. Энэ хууль гарч байж энэ бүх компаниудыг цэгцлэх гээд байгаа. Одоо зөвхөн сая Төрийн өмчийн хорооноос хэлж байгаа энэ төрийн өмчийн 69 компани дээр зөвхөн хөрөнгийг нь аваад үзэх юм бол 60 их наяд төгрөг гэж байгаа. Энэ тэгэхдээ балансын хөрөнгө. Балансын хөрөнгө шүү. Энэ балансын хөрөнгийн.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Төрийн өмчийн энэ том гэж байгаа 69 компанийн 60 их наяд төгрөгийн хөрөнгийн тал нь авлага, өр төлбөр байгаа. Төрийн өмчийн компанийн энэ өр төлбөр нь ДНБ/дотоодын нийт бүтээгдэхүүн/-ний төрийн өмчийн компаниудын энэ зардал бол улсын төсвийн нийт зардлын 72 хувийг эзэлж байгаа.

Өөрөөр бол улсын төсвөөс бид Их Хуралд орж ирж батлагддаг төсвөөс гадна Их Хурлаар ордоггүй улсын төсвийн дөрөвний гуравтай дүйх зардал төрийн өмчийн компаниуд дээр явж байгаа. Тийм учраас энийг парламентын буюу ард түмний хяналтад энэ батлагдах гэж байгаа хуулиар оруулж ирэх гээд байгаа юм. Жил болгон тайлан, санхүүгийн тайлан, гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг Улсын Их Хуралд яг гүйцэтгэлийн тайлан сонсдог шиг сонсдог болгох гэж байгаа юм. Тийм учраас 2, 3 төсөвтэй байна.

Ж.Бат-Эрдэнэ: Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ маш чухал хууль орж ирж байгаа. Энийг бол аль болох өнөөдөр ч хамаагүй баталчихмаар байгаа. Өмнө нь наад Их Хурлын дарга Бямбацогт дарга Хэрэг эрхлэхийн газрын дарга

байхдаа улаан намын цагаан байрныхаа дээрэмчдийг ерөөсөө танихгүй, мэдэхгүй гэж яриад байсан. Ерөнхий сайд, Учрал Ерөнхий сайд бол таньж мэдэж байгаа, бүгдийг нь цэвэрлэнэ л гэсэн юм. Цэвэрлэх ажлаа яаралтай хиймээр байгаа юм. 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ 2024 оны дүнгээрээ 34.3 их наяд төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ гээд тайлан дээр нь тусчихсан байгаа юм. Энэ юуг харуулж байгаа тоо вэ гэхээр 24 онд нөгөө улаан намын цагаан байрныхан чинь сонгуулийнхаа зардлыг төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээсээ авч явуулсан гэсэн үг. Энэ нэгтгэсэн тайлангаар шүү. Энэ дүн нь 2025 онд өсөх ёстой.

Гэтэл өсөж чадаагүй буюу 19.1 их наяд болоод зөрүү нь 15.2 их наяд төгрөг. Зөрүү нь. 15.2 их наяд төгрөг чинь энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүд дээрээ хууль бусаар бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гээд юу гэдэг юм хэвлэл мэдээллийн зардал гэдэг юм уу, үндэслэлгүй халсан хүмүүстээ тэтгэмж өгч явуулдаг юм уу гэх мэтчилнээр явсаар байгаад 15.2 их наяд төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ гаргаад явуулчихсан байгааг Ерөнхий сайд, шинэ Ерөнхий сайд бас анхаараарай. Улсын төсвөөр бид нар 33 их наядыг баталж явуулж байгаа. Нийтдээ бол 133 их наяд төгрөгийн асуудал явж байгаа. Сая энд бусад гишүүдийн асуулт дээр ч гэсэн гарч байна энэ тайлан баланст бол маш багаар дүгнэгдэж байгаа асуудлууд байгаа.

Тайлан баланс дээр яг үнэлгээг нь зөв хийгээд явах юм бол энэ 133 их наяд төгрөг хэд ч хүрэх магадлалтайг нь Цэнгэл дарга маш сайн мэдэж байгаа байх. Тэгэхээр юу гэдэг юм энэ Эрдэнэс Монгол ч гэдэг юм уу, Төрийн банк ч гэдэг юм уу энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүд сая Эрдэнэс Монголыг нэрийг нь өөрчилчих шиг боллоо. Тэгээд хэл ам дагуулаад байсан, давхардаад байсан хэдэн дарга нарыг нь бас цөөлчих шиг боллоо. Тэгээд 67, 8 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргалаа л гэж ярьж байгаа. Бодит байдал дээр энэ чинь зөвхөн танайхан өөрсдөө хийж байсан ажлуудынхаа алдаа, дутагдлыг зах зухаас нь олоод хараад залруулах гэж байгаагийн л илэрхийлэл.

Жишээлэхэд төрөөс тэрбумтан төрдгийн жишээ Төрийн банкин дээр байгаа. Танай намын нэг даргынх нь үеэл тэнд захирал хийдэг. 4 жилийнх нь цалин нийлээд 1 тэрбум төгрөг болчихдог. Төрөөс тэрбумтан төрж болдгийн жишээ. Гэтэл Төрийн банк, Хаан банк 2 гараанаас ижил нөхцөлөөр гарсан. Өнөөдөр Хаан банк 2 их наядын буюу Монголын хамгийн том компани болчихсон явж байна. Төрийн банк хамгийн жижиг хэвээрээ байгаа. Өнгөрсөн чуулган дээр уг нь Төрийн банкны жишээлэхэд хувьчлалыг оруулж ирье гэж байсан сая хаврын чуулганд орж ирээгүй бүүр хойш нь татчихсан гэж ойлгосон.

Тэгэхээр та бүгд маш хариуцлагатай байж байгаад энэ мэт үргүй зардал гаргаад байгаа, төрд ашиг авчирч өгдөггүй, төр өөрөө хувийн хэвшилтэй өрсөлдөх шаардлагагүй энэ мэт Төрийн банк гэх мэт энэ байгууллагуудаа хувьчлахгүй бол төр данхар тэр чигээрээ 103, 33 байтугай их наяд төгрөгийг Монгол Улсын Ерөнхий сайд удирдаж байгаа буюу төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 90 их наядын Цэнгэл дарга удирдаж байна. Үлдсэнийг нь улсын төсвөөр Ерөнхий сайд танхимынхаа сайд нартай буюу төсвийн ерөнхийлөн захирагч нартайгаа нийлж байгаад удирдаж байна. Энийгээ талд нь гаргаж дараагийнх юугаа ажиллаарай гэж хэлэх гэсэн юм.

Тэгээд сая нийслэлийн бас төсөв санхүүтэй холбоотой сонсгол болсон. Энэ Ерөнхий сайд бас чиглэл өгдөг, нэгдмэл улсын хувьд анхаарахгүй бол тэнд нэг хурган дарга нь 15 туслахтай, 3 компанид ТУЗ-ийн мөнгө гээд 200 орчим сая төгрөг жилд авдаг. Тэгээд тэрийгээ бүүр мэддэггүй. Би 200 орчим сая төгрөг авчихсан юм уу би мэдэхгүй байна гэж байгаа юм. Тэгээд нийслэлийн босгосон бонд, нийслэлээс баталсан татвараар орж ирж байгаа төсөв нийлж явсаар байгаад нийслэл дээр 7.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тийм төрийн өмчит компани Төсвийн орлого ер нь эдийн засаг дахь харьцаа бол бараг 61 хувьд хүрчихсэн. Энэ Төрийн өмчит компанийн хуулийг тухайн үед боловсруулж байхад намайг Хэрэг эрхлэхийн дарга байхад ажлын хэсгийг байгуулж бид ажиллаж байсан. Энэ ажил дээр бол EBRD оролцсон. Энэ ажил дээр бол тэр Тони Билерийн институтээс зөвлөгөө авсан. Тэгээд энэ хуулийг боловсруулж батлуулахад хүн бодохгүйгээр хийх ёстой юм байна лээ. Тэгээд өнгөрсөн хугацаанд бол төрийн өмчит компанийн шинэчлэл хийхээр яг ингээд зоригтой шийдвэр гаргая гэхээр очоод хана мөргөчихдөг. Тэгээд нөгөө эрхтэн дархтнууд, улс төрчид нь залгаад, зовоогоод ингээд эхэлдэг. Тэгэхээр энэ хамтын хүч хэрэгтэй шүү. Аль аль намын. Маш олон хүний уур бухимдлыг хүргэнэ. Сая би эхний 14 компани дээрээ бол олон улс төрчдийн уур бухимдлыг хүргэсэн.

Тэгэхээр цаашаа зөв явахын тулд хууль гаргах хэрэгтэй. Энэ хуулиар бол хараат бус ТУЗ-ийн гишүүдийн тоо олон болж байгаа. Шаардлагууд нь асар өндөр болж байгаа. Асар өндөр болж байгаа. Энд бол тэнцэх хүн төдийлөн бас олдохгүй болно. Өмнө нь би төсвийн хуулийн үеэр хэлж байсныг та бүхэн санаж байгаа байх. Ерөөсөө энэ олон улсын аудит оруулах ёстой юм. Тэр заалт унагаачихсан шүү дээ. Олон улсын аудит энэ компаниудад оруулж өгөхгүй бол энэ тайлан, баланс дээр цэвэрлэгээ хийхгүй бол энэ явахаа больсон. Юун IPO гаргах. IPO гаргана гэдэг чинь үнэлгээ хийнэ, аудит хийнэ, олон улсын аудит хийнэ.

Тэгээд тэр андрайтер энэ тэр авах тэр хөлс мөнгө хэрэгтэй шүү дээ. Төсөв мөнгө. Тэгж байж явахгүй бол үнэлгээ ч хийгээгүй, аудит ч хийгээгүй нөгөө Их Хурал нийгэм шахангуут ийм тогтоол гээд хэдэн компани татан буулгах гэж байгаа юм уу, нэгтгэж байгаа юм уу гээд хүчээр бариад ороод ирдэг. Тэр төрийн өмчит компани дээр баримтлах чиглэлийг Засгийн газар татаад авчихсан. Яагаад гэвэл тэр худлаа. Тэгж хүмүүс хуураад яах вэ. Үнэлгээ хийгээгүй бол, аудит хийгээгүй бол байхгүй.

Тэгэхээр хамгийн зөв зарчим юу гэж үзсэн бэ гэхээр энэ хуулиа гаргачихъя. Тэгээд энэ статусаа маш тодорхой болгочихъё. Тэгээд намар IPO гаргахын тулд бол хамгийн зөв зам бол яг Узбекистан энэ тэрийн хийж байгаа жишиг юм байна лээ. Юу гэхээр ийм портфоли маягаар ингээд ашигтай компаниудынхаа хувьцаануудыг нийлүүлээд, хөрөнгө оруулалтын сан дээрээ байршуулаад, хуулийнх нь дагуу хөрөнгө оруулалт, менежментийн компанид asset management хийлгээд тэрнийхээ эрхийг Их Хурлаасаа авчих юм байна лээ.

Тийм учраас энэ Чингис хаан баялгийн сан нэгдэл бол өөрөө ...-оор удирдуулна цаашдаа. Тэгээд Хөрөнгө оруулалтын сан дээр нь хувьцаануудаараа

нийлүүлж байгаад Их Хуралд намар энэ энэ компани дээр IPO гаргах гэсэн юм гээд зөвшөөрлөө авчих юм бол бирж дээр гаргана. Хөрөнгө босгоно. Энэ бол эргэлзээ байхгүй. Тэгэхээр энд Их хурлын гишүүдийг л гол нь дэмжиж.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Нийслэлийнхэн маань бол сая хуралдаад үндсэндээ 7 их наяд төгрөгийн алдагдал үйлдвэрлэхихсэн гэдгээ хүлээн зөвшөөрч чадахгүй байгаа. Энийг бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гаргаж ирсэн юм. Тэгэхээр Улсын Их Хурлын хуралдаан даргалагч Бат-Эрдэнэ дарга үүргийг нь өгч байгаад Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 7 их наяд төгрөгийн алдагдал гэдгээ баталж оруулж ир. Яг нийслэлд алдагдал үйлдвэрлэхихсэн юм уу үйлдвэрлээгүй юм уу? Энийг талд нь гаргах шаардлагатай байгаа юм.

Хоёрдугаарт нь Ерөнхий сайд ер нь бол их зоригтой ажиллана гээд байгаа юм. Одоо танд намар хүртэл хугацаа байна. Өөрийн намаасаа эхэлнэ гэсэн. Сүүлийн 10 жилд танайх дангаараа засаг барьсан. Намар гэхэд танайх ямар ямар хүмүүстэй хариуцлага тооцоод, ямар хулгайчуудаасаа салаад, ямар төрийн өмчийг нийтийн болгох гэж байгаа юм? Та сая яриандаа өөрөө бас хэлсэн шүү дээ. Намар гэхэд бид нар энэ энэ компаниудыг IPO хийе гээд гаргаад ирнэ гээд. Энэ дээр маш хурдтай, маш зоригтой ажиллаарай гэдгийг танд захиж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ерөнхий сайд. Учрал Ерөнхий сайд тодруулъя.

Н.Учрал: Тэгээд манай Засгийн газар бол дуусдаггүй яриаг дуусгана л гэсэн. Тийм учраас дуусдаггүй татварын реформыг бид хамтдаа баталлаа. Одоо энэ тэтгэврийн шударга тогтолцооны реформ хийх гэж байна. Та бүхэн баталж өгвөл намрын төсөв дээр бодит өөрчлөлтийг хийнэ. Явахгүй байсан олон төслүүдийг компаниуд нь сонгон шалгаруулаад ингээд гараанаас гарчихлаа. Төрийн өмчит компанийн реформыг хийнэ гэж олон үеийн Засгийн газар хичээж байсан. Одоо бодитой ажил хэрэг болж байгаа манай Засгийн газрын үед. Ерөөсөө олон улсын хамгийн зөв чиг хандлага ерөөсөө энэ төр, төрийн өмчит компанийн тодорхой хувиудыг нь багцлаад л хөрөнгийн багц үүсгээд нээлттэй арилжаална.

Тэгээд тэр банкин дээр байгаа гадаадын банк оруулж ирэх гээд байгаа энэ бизнесийн эрх чөлөөг дагасан нөгөө 20 хувийг, 1 хувьцаа эзэмшигч 20 хувь гэдэг босгыг гадаад банкин дээр тооцохгүй энэ тэр гээд өөрсдийгөө чөдөрлөчихсөн заалтууд байна. Энийг аваад хаячихмаар. Ингээд намар хүртэл.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Намар Банкны тухай хуульд өөрчлөлт оруулсан хуулийн төсөл орж ирнэ. Чинбатын Ундрам гишүүн алга байна. Пүрэвийн Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Манай Их Хурал ч ингээд сүүлийн үед бол танхимд хамгийн чухал ингээд хуулиуд орж ирээд яг хэлэлцэх үед бол 5, 10 гишүүн л суудаг болж дээ. Тэгээд хууль батлуулах гэж байгаа Засгийн газар, төлөөлөл, хуульд ажилласан ажлын хэсэг, Ерөнхий сайд Учрал мөн энэ

танхимд бас орж ирж хууль батлуулахын тулд, дэмжүүлэхийн тулд бас та нэлээн их нөлөөлөлтэй үг хэлж сууж байх шиг байна.

Миний их гайхсан зүйл саяын өнгөрсөн Эдийн засгийн байнгын хороон дээр манай Их Хурлын дарга бас орж ирж Эрчим хүчний яамны 13 сайд буюу түүний холбогдох ажилтнуудын 13 хүний бүрэлдэхүүнтэй ирсэн мэдээлэл хийж байгаа мэдээлэл дээр шууд орж ирж бас их тэр Эрчим хүчний яамны өнөөгийн нөхцөл байдал, санхүүгийн хүндрэл, тэд бүүр бүгдийн толгойг илэх маягийн тэр зовлон бэрхшээлийг сонсох аядсан тэгээд Их Хурлын тогтоол гаргах өвөлжилттэй холбоотой ийм асуудлыг хөндлөнгөөс оруулж ирж ингэж сууж байгаа харагдсан юм. Тэгэхээр ер нь ажиглаад байхад бол ер нь ингээд хуулиа батлуулах гэсэн, ач холбогдол өгсөн ийм юман дээр бол акцент өгч Ерөнхий сайд ингэж сууж байна гэж би харж байна.

Энэ Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах энэ хууль бол өнөөдөр үнэхээр чухал хууль уу гэвэл маш чухал хууль. Гэхдээ орж ирж байгаа орон зайны, цаг хугацааны хувьд, боловсруулагдсан байдал, ажлын хэсгийн ажилласан байдлыг Эдийн засгийн байнгын хороон дээр сая хараад голсон.

Яагаад гэвэл тэнд зөрчил харагдсан ашиг сонирхлын зөрчил. Ер нь бол энэ ажлын хэсэгт, хуулийн ажлын хэсэгт орж ажилласан гишүүд маань өөрөө нөлөөлөх маягтай тэгээд Эдийн засгийн байнгын хорооны хурлыг Их Хурлын гишүүн Үүрийнтуяа гишүүн бол бас удирдаж байсан. Ингэж болж байгаа юм уу? Тийм яг энэ хуулийг хэлэлцэх үед та бол тэр хурлыг даргалахаас татгалзаад дараагийн хүнд шилжүүлээд явах боломж байсан. Энийг бол би бас боломжгүй юм явчихлаа даа л гэж харлаа л даа. Зөрчөөд явчихлаа даа л гэж харж байсан. Ажлын хэсэг бол анхнаасаа ер нь бол ингээд жил гаран яваад ирчихсэн хуулийг шахаж боловсруулж ирэх тал дээр маш тааруухан ажилласан нь харагдсан. 62 билүү зарчмын зөрүүтэй саналыг хураахад тэнд шинээр ингээд заалт оруулж ирчхээд Эдийн засгийн байнгын хороон дээр санал хураалгах гээд байсан шүү дээ. Ийм байж болох юм уу?

Өнөөдөр төрийн өмчит компани, орон нутгийн өмчит компанийн энэ дампуурал, энэ алдагдалтай ажилладаг ийм нөхцөл байдалд 472 тэр компани байна гэж байгаа юм. Энэ ТУЗ, тэрний ачаалал, энэ Монгол, энэ эдийн засгийн, тэр төсөвт өгч байгаа ачааллаа тооцож бодоход үнэхээр аймшигтай тийм хүндрэлтэй байгаа шүү дээ. Тэгээд энд ингээд орж ирээд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ-ийн гишүүн нь төрийн захиргааны албан хаагч байхаар хуульчилсан явдал нь төрийн өмчит компаниудын засаглалыг мэргэжлийн бус болгож, компанийн сайн засаглалын тогтолцоо бүрдэх нөхцөлийг хааж байна гээд ийм заалт оруулж ирсэн мөртөө энэ хуулийн төслийнхөө 24-ийн 5 дахь хэсэг дээрээ төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны нэгээс дээшгүй нь төрийн захиргааны алба хаагч байна гээд ингээд тусгаад өгчихсөн.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тийм Батчимэг гишүүн бас чухал асуудлуудыг хөндөж байна. Би 16 онд намайг Их Хуралд сонгогдоод Их Хурлын гишүүн болоод орж ирсэн байх

үед төрийн өмчит компанийн шинэчлэлийг ярьж байсан. Ажлын хэсэг ажиллаж байсан. Анхааралтай ажиглаж байсан 10 жил шүү. Тухайн үед бол энэ Хэрэг эрхлэхийн дарга Энхбаяр дэд сайд, манай Сайнзориг гишүүн бол Хууль зүйн яамны газрын дарга тээ? 10 жилийн өмнө шүү дээ. Яг энийг ярьж байсан. Протоколыг нь гаргаад үзвэл яг энэ яригдаж л байсан. Тэрнээс хойш бол бид нар ажлын хэсэг ажилласан, анхааралтай ажигласан, үе үеийн Засгийн газар ярьдаг. Яг барьж аваад хийе гэхээр улс төртэйгөө очоод хана мөргөдөг. Яг үнэн. Тийм учраас одоо бол жоохон зоригтой байх ёстой. Намайг Хэрэг эрхлэхийн дарга байхад яг энэ хуульд байсан. Тухайн үед барьсан. Ингэхээр одоо бол энд бол аль нам, эвслээс үл хамаараад зоригтой шийдчих хэрэгтэй энэ төрийн өмчит компанийн асуудлыг.

Тийм учраас би эхлэл болгоод тэр “Эрдэнэс Монгол” бол уул уурхайн компани болчихсон байсан. Майнинг компани. Тийм учраас тэр майнинг компанийг Чингис хаан баялгийн сан буюу хөрөнгийн менежмент хийдэг, хөрөнгө удирддаг, иргэдийн хуримтлалын санг нэмэгдүүлэхэд ажилладаг тийм үү хөрөнгийн удирдлагын тал руу нь ажиллуулъя гэдэг ийм шийдвэрийг гаргачихсан. Тэгээд одоо хамгийн зөв жишгээр нөгөө хөрөнгийн багцууд гаргаж байгаад бирж дээр гаргая.

Тийм учраас энэ хуулийг гаргаад өгвөл намар төсөвтэйгөө оруулаад ирье гэж ингэж зорьж байгаа юм. Харин энэ удаа бол яг энэ хуулийн үе үеийн түүхийг мэдэх бүх хүмүүс энд ингээд нэгдэж байх шиг байна. Манай Үүрийнтуяа гишүүн бол бас энэ төрийн өмчит манай “Эрдэнэт” үйлдвэрийн бас хариуцлагатай алба хашиж байсан. Зовлон, жаргал, саад бэрхшээлийг мэддэг хүмүүс хамт цуглалаа. Одоо хийх хэрэгтэй. Сая 14 компани буулгахад яах вэ дээ хэдэн улс төрчид сандарч л байна. Тэгээд хүний өөрийгүй л сандарч байгаа. Бүтээмжийн менежерүүдийн эзэд нь зовж байх шиг байна. Тэр бол ер нь их тийм сонин юм уу. Ингээд 14-өө буулгасан шиг намар бол энэ хуулийг гаргавал сюрприз барина гэж л би бодоод байгаа юм. Тэгж байж энэ төрийн оролцоог бууруулахгүй бол наадах чинь бол арай хэтэрлээ. Тэгээд одоо наад хараат бус гишүүдийн тоог анх удаа түүхэндээ анх удаа олон болгож байна шүү дээ хараат бусыг. Өмнө нь энэ чинь дандаа бага байхгүй юу.

Төрийн албан хаагч нар дээр бол нөгөө Засгийн газар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлдэг учраас тодорхой төлөөлөл тэр нөгөө хувьцаа эзэмших эрхээрээ ордог. Тэгэхдээ энэ удаа бол хараат бусыг олон болгох шийдвэрийг гаргаж байгаа нь маш сайн хэрэг. Тэгэхээр яг таны, бидний хүсэж байгаа нийгмийг бүтээхэд энэ төрийн өмчит компаниудыг цэгцлэхээс өөр зам байхгүй. Засаглал нь тодорхой болно. Тэгээд дараа нь хэн ч ярьж хөөрөх, нөлөөлөх бололцоо байхгүй болно.

С.Бямбацогт: Нэмж хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Үүрийнтуяа.

Д.Үүрийнтуяа: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн гишүүдийн хувьд Эдийн засгийн байнгын хороонд байгаа гишүүд ч бий. Миний хувьд ажлын хэсгийг ахалж байгаа. Би Эдийн засгийн байнгын хорооны гишүүн Эдийн засгийн байнгын хорооны даргыг эзгүйд Улсын Их Хурлын даргын шийдвэрээр түр орлон гүйцэтгэж байх энэ цаг хугацаанд энэ хуулийн төсөл орж ирсэн. Хуралдаан даргалагчийн хувьд 1 саналын эрхтэй, хурал даргалах л

үүрэгтэй. Эцсийн шийдвэр, санал хураалтын дүнд нөлөөлөх ямар нэгэн боломж байхгүй, ашиг сонирхлын зөрчил гаргаагүй гэдгээ чуулганы индэр дээр бас албан ёсоор гишүүнд уламжилъя.

Чухал хуулийн төсөл гэж хүлээж авч байгаа эрхэм гишүүддээ талархлаа илэрхийлж байна. Дээр нь бид бас ойлголтын зөрүүг арилгах үүднээс ялангуяа төрийн өмчит компанийн энэ бусдаар гүйцэтгүүлж байгаа ажил, үүрэг гэдэг сонгуулийн зардалд явчихлаа гэж хэлж байгаатай би гишүүдийн энэ хэлж байгаатай санал нийлж болохгүй байгаа юм.

Би өөрөө бас энэ төрийн өмчийн компанид санхүүгийн асуудлыг хариуцаад ажиллаж байсан хүний хувьд хэдэн үг нэмээд хэлчихмээр байна дарга. Хариулт нэмж гүйцээх боломж олгож өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Хариултаа гүйцээе. Минут нэмье.

Д.Үүрийнтуяа: Энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гэдэг зардалд ямар ямар зардал ордог юм бэ гэхээр нэгдүгээрт ажилчдын эрүүл мэндийн үзлэг, оношилгооны зардал ордог. Мөн сервис, үйлчилгээний зардал ордог. Аудитын бүх төрлийн үйлчилгээний зардал ордог. Хяналт шалгалтын үйл ажиллагааны зардал ордог. Хуулийн зөвлөгөө авах ажлууд ордог. Дээр нь химийн анализ урвалж, урьдчилан сэргийлэх үзлэг, ХАБ-ын зардлууд энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээнд ордог юм.

Тэгэхээр хэдүүлээ ойлголтоо бас зөвтгөөд явах нь зүйтэй байх. Яах вэ улс төрийн нөхцөл байдлын үүднээс дүгнэхээс илүү байгаа нөхцөл байдлаа бид боломжоо гаргаад явах нь зүйтэй гэж харж байгаа. Өнгөрсөн цаг хугацаанд хамтарсан Засаг байх үед төрийн өмчийн компанид оруулсан олон төрлийн бүтээмж, хяналт гээд янз бүрийн нэртэй менежерүүд маань өнөөдрийг хүртэл л төрийн өмчит компанийн бүтцэд өөр нэртэй сууж л байгаа. Энэ зүйлийг л засаж залруулах эрх зүйн орчин нь энэ хуулиар гарах юм байгаа юм л гэдгийг тодотгож хэлье.

С.Бямбацогт: Пүрэвийн Батчимэг гишүүн тодруулж асууя.

П.Батчимэг: Өнгөрсөн Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр өөрийнхөө ажигласан зүйлийг бол би сая хэллээ л дээ. 62 зарчмын зөрүүтэй санал орж ирэхэд тэр олон саналыг хурааж байх явцад асуудал үүсээд байсан байхгүй юу. Тэрийгээ л би сая хэлсэн юм. Тэгээд шинэ санал орж ирчхээд, заалт оруулж ирчхээд тэрийгээ батлуулах гээд санал хураалт хураалгах гээд байсан шүү дээ. Энэ зарчмын хувьд болох юм уу гэж асууж байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт ер нь бол зөвхөн энэ төрийн өмчит компани энэ хуультай холбоотойгоор би ганц яриагүй байна л даа. Сая жишээ нь Гэр бүлийн тухай хуулийг хэлэлцэхэд энэ олон саналын зарчмын зөрүүтэй саналыг хураалгахад бас л ажлын хэсэг яаж ажиллаж энэ хуулийн боловсруулалт энэ боловсруулах ажлыг яаж шахаж ажиллаж ирсэн л.../минут дуусав./

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Сайнзориг хариулъя.

П.Сайнзориг: Батчимэг гишүүн таны ярьж байгаа энэ зүйлүүдийг жишээ нь саналын 27 дахь саналаар хараат бус гишүүн жишээ нь олонх болгоно энэ тэр гээд засагдаж байна. Төрийн албан хаагчид бол аль болохоор юу гэдэг юм маш цөөн тоо буюу хязгаартай байж байгаа. Энэ ч өөрөө сонгон шалгаруулалттай.

Хоёрдугаарт та бас зарчмыг андуураад байх шиг байна. Ажлын хэсгийн саналаасаа гадна хувь гишүүдийн санал хажуугаар нь орж ирсэн. Зэрэгцэж уншаад байсан нь л буруу байсан. Эхлээд ажлын хэсгийн саналаа хураачхаад ажлын хэсгийн санал дэмжигдээгүй бол гишүүний саналыг зүгээр уншаад танилцуулчихдаг байхгүй юу.

Тэгсэн чинь Байнгын хорооны ажлын албан дээр жоохон зохион байгуулалтын ажил гарсан. Цэнгүүн ч санал гаргаж байгаа, би ч гаргаж байгаа. Та миний гаргаж байгаа саналуудыг бол мэдэж байгаа. Асуудлуудыг зарим гишүүдээс гаргаж ирж байгаа асуудлуудыг ярилцах боломж болохыг нь бол гаргасан. Орон нутгийн өмчит уул уурхайн компаниудын асуудлуудыг зөв зохицуулалттай дагаж мөрдөх журмын зохицуулалт орохын тулд би гаргаж байгаа байхгүй юу. Тэрнээс биш зэрэгцүүлээд ч юм уу ажлын хэсгээс шинэ санал оруулж ирээд байгаа зүйл биш. Би зүгээр хувь гишүүнийхээ хувьд гаргасан Цэнгүүн, Пунсалмаа.../минут дуусав./

С.Бямбацогт: Хуулийн шинэчилсэн найруулга бол тодорхой саналууд гарч болдог. Хуулийн нэмэлт, өөрчлөлт бол зөвхөн тэр хөндөгдсөн нэмэлт, өөрчлөлт, зүйл, заалттай холбоотой саналууд дээр л зарчмын зөрүүтэй саналууд гардаг ийм дэгийн хуультай. Энэний дагуу бас явсан байх гэж бодож байна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуултаа асууя.

М.Бадамсүрэн: Хуулийн шинэчлэлийг бол дэмжиж байгаа. Тэгээд надад хэдэн асуулт байна. нэгдүгээрт ингээд нөхцөл байдал нийслэлд буюу үндэсний хэмжээнд нэг өөр, аймаг, сум, тэр дундаа яг хөдөөгийн сумдад нөхцөл байдалд бол нэлээн өөр байдаг. Тэгэхээр өөрөөр хэлбэл нөгөө орон нутагт буюу сумдад яг эдийн засгийн зах зээлийн зарчмаараа үйл ажиллагаа явуулж чадахгүй ийм орон нутгийн өмчит газрууд л байна л даа.

Тэгэхдээ зайлшгүй нөгөө иргэдэд нийтлэг үйлчилгээ хүргэх ёстой учраас тэгээд энэ дээр сумдад бол ийм нийтлэг үйлчилгээний газар гэж байгуулаад л тэр нь ингээд л төрийнхөө мэдэлд, орон нутгийнхаа захиргааны мэдэлд тэгээд л энэ л болохгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энийг ер нь яаж энэ дээр гол өөрчлөхөөр ингэж шийдэл байгаа бол? Зүй нь бол аль болох ийм зайлшгүй энэ хэрэгцээтэй үйлчилгээг буюу сумдад бол ингээд тохижилтын ажил байна зам талбайн, халаалт, цэвэр, бохир ус, дамжуулах уурын зуух гээд энэ дэд бүтцүүдтэй холбоотой зүйлийг хувийн хэвшил рүү шилжүүлэх энэ зарчмыг илүү баримталбал зөв байх гэж бодож байна.

Өөрөөр хэлбэл, тийм нэгдсэн удирдлагаар, арга зүйгээр, ийм бодлогоор хангаж өгөхгүй бол тэгээд сум болгонд л ийм өөр тэгээд тэр нь л орон нутгийн өмч учраас энэ дээр нь янз бүрийн ашиглалт гарах ийм эрсдэл бол маш өндөртэй. Ер нь ийм зүйлүүд зөндөө гарч байгаа. Тэгээд энэ орон нутгийн өмчийн компанийн мэдлийн трактор, техник хэрэгслийг хувийнхаа хадлан тэжээл, тариалахад ашигладаг энэ нь хууль, хяналтын байгууллагаар тогтоогддог. Тэгээд ийм орон

нутагт бол ийм асуудлууд бас нэлээн байгаа. Төрийн өмчийн компанитай ч гэсэн байгаа гэж үзэж байгаа байх. Тийм учраас энийг цэгцлэх гэж ингэж зорьж байгаа.

Тэгэхээр миний хэлэх гээд байгаа зүйл нь энэ орон нутаг цаашдаа бол энэ малын тэжээл тариалах, малын үржүүлэг, технологийн ажил, мал эмнэлгийн ажил, энэ халаалт, дулаантай холбоотой гээд энэ ажлуудыг нэгдүгээрт төрөөс дэд бүтцээр дэмжиж, Хоёрдугаарт нь түрээсийн техникээр, гуравд нь ийм хөнгөлөлттэй зээлийн бодлогоор ингээд цогцоор нь дэмжвэл төр яг энэнээсээ ангижрах л бодлого болох юм.

Тэгэхээр энэ нөгөө орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах холбоотой зүйл учраас энийг ийм орон нутагт нь зах зээлийн зарчмаар нь явуулах, гэхдээ төр ингээд тодорхой дэмждэг нь тодорхой. Ийм ийм зүйлээр бид нар дэмжинэ, энийг нь харин хувийн хэвшил ингэж авч явна гэхгүй бол аж ахуйн тооцоо дээр орон нутгийн өмчит компани ажиллана гэхээр яг бодит байдал дээр бол ерөөсөө болохгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энийг сайжруулах талаар хууль дээр ер нь яаж зохицуулахаар тусгасан байгаа бол, цаашид анхаарах зүйлийн талаар ямар бодлого байгаа бол гэдгийг л асууя.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон индэр.

Г.Давааням: Гишүүний асуултад хариулъя. Давааням МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш. Хуулийн төсөл дээр 2 үндсэн агуулга явж байгаа.

Нэгдүгээрт нийтийн үйлчилгээний үүрэг гэдэг агуулга дотор адилхан орон нутагт эрүүл мэнд, боловсрол, зам, тээвэр ч гэдэг юм уу ийм салбарууд дээр бол нэгжийн хуулийнхаа чиг үүргийн дагуу компани байгуулаад явж болно. Тэгээд компани байгуулахдаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ерөнхийдөө шийдэхээр энэ хүрээнд яг хувийн хэвшил хийх боломжтой ийм зүйлүүд байх юм бол тэрэнд нийцэж байгаа эсэх тэр өмчийн бодлоготойгоо үндэслэлүүдээ тодорхой болгоод оруулахаар өөрөөр хэлэх юм бол орон нутагт хувийн хэвшил хийх боломжтой зүйлүүд байх юм бол орон нутгийн өмчит компани байгуулахгүй.

Хувийн хэвшил хийх боломжтой зүйлүүд дээр бол хувийн хэвшилд нь яагаад одоо байгаанууд нь өөрөө хувийн хэвшилд шилжих боломжтой бол тэр нь тухайн иргэдийн төлөөлөгчийн хуулийн өмчийн бодлогоороо ингээд нээлттэй явах байдлаар зохицуулсан байх.

С.Бямбацогт: Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Энэ ийм л би бол их хариулт хангалтгүй байна л гэж үзэж байгаа. Энэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар яг энэ орон нутгийн иргэдийн хурлуудад ингээд мэргэжил, арга зүйн зөвлөмж, зөвлөгөө өгдөг. Үр ашгийг нь тооцдог. Тэгээд яг энэ үйлчилгээ дээр нь ингээд энэ нь зөв юм байна. Энэ үйлчилгээ дээр нь энэ нь үнэхээр гарцаагүй юм байна гэх мэтээр ийм судалгаа, анализ хийсэн зүйлүүд ер нь байдаг болов уу? Яг энийг улс орны хэмжээнд бүхэлд нь 330 сум, 21 аймаг, нийслэлийн дүүргүүд дээр яг юу гэж үзэж байгаа юм бол? Би бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг бараг яамнаас том ийм байгууллага гэж ойлгодог.

Тэгээд ингэхгүй бол яг үнэндээ ингээд тийм л учраа олохгүй байдалтай л орон нутагт бол байгаад байгаа нь бол үнэн шүү. Тэгээд асар их энэ дээр өмч хөрөнгийн алдаа, зөрчил гардаг. Одоо нийслэлийн дүүргүүд дээр ч гэсэн адилхан. Тэгээд яг.../минут дуусав./

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Яах вэ орон нутагт энэ төрийн өмчийн компани, төрийн энэ орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоот газруудыг чинь ингээд иргэдийн хурал нь өөрөө шийдээд л байна. Өдөр ирэх тусам тоо нь нэмэгдээд байна л даа. Тийм учраас энэ хууль батлагдсанаараа уул уурхайн салбарт хэрэв үйл ажиллагаа явуулах гэж байгаа орон нутгийн өмчит компани байх юм бол энэ газрын хэвлийн баялаг гэдэг утгаараа Их Хурлаас зөвшөөрөл авах, бусад тэр нийтлэг үйлчилгээний үйл ажиллагаа явуулах гэж байгаа компаниудыг бол тэр орон нутагт нь компаниа байгуулах эрхийг нь өөрсдөд нь өгөөд ингээд явна.

Тэгэхдээ тэр салбарын асуудал дээр бол заавал салбарынхаа сайд нараас тэр тэр чиглэлийн үйл ажиллагаа явуулах дээрээ зөвшөөрөл авах гээд ингээд нэлээн хатуу шаардлагуудыг бол тавьж өгч байна. Таны хэлснээр зарим үйлчилгээг бол хувийн хэвшилд шилжүүлэх нь бүрэн нээлттэй. Та бидний батлах энэ Бизнесийн эрх чөлөөний хуулиар ч гэсэн энийг бүгдийг нь нээж байна. Тэгээд зарим чиг үүргээ хувийн хэвшил шууд шилжүүлж болно.

С.Бямбацогт: Хуулийн төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос хураалгахаар бэлдсэн зарчмын зөрүүтэй 83 санал байна. Санал хураалтыг 16 цагаас нэгтгэж явуулна. Дараагийн асуудалдаа оръё.

13.40 цаг.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл танилцуулна. Таныг индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан эдийн засгийн эрх, эрх чөлөөний үзэл санааг бодит амьдралд хэрэгжүүлэх иргэн, аж ахуйн нэгжийн эдийн засгийн суурь эрхийг бодитоор хамгаалж, эдийн засаг дахь төрийн оролцооны зорилго, хэлбэр, хүрээ хязгаарыг тодорхой болгохоор Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг боловсруулсан.

Бид ардчилсан Үндсэн хуулиараа зах зээлийн эдийн засгийг төлөвшүүлж, хувийн хэвшилд тулгуурласан хөгжлийн загварыг бий болгохоор зорьж ирсэн. Энэ хугацаанд Монгол Улсын эдийн засаг өсөж, 1 хүнд ногдох орлого нэмэгдэж, шинэ бизнесүүд бий болсон нь үнэн ч өсөлтийн хурд, хүртээмж хангалтгүй байна.

Манай эдийн засгийн өсөлт, уул уурхайн салбарт хэт төвлөрсөн хэвээр байна. Уул уурхайн салбарын орлого нэмэгдэхийн хэрээр бусад салбарын өрсөлдөх чадвар сулрах, төрийн зардал тэлэх, бүтээмжээс илүү түүхий эдийн мөчлөгөөс хамаарах үзэгдэл хүчтэй болж, Голланд өвчний шинж тэмдэг мэдрэгдсээр байна.

Энэхүү нөхцөл байдлаас гарахын тулд эдийн засгаа төрөлжүүлэх, хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг сэргээх, иргэдийн бүтээлч санаачилгыг хамгаалах хөгжлийн бодлого зайлшгүй шаардлагатай болсон.

Өнгөрсөн он жилүүдэд эдийн засаг дахь төрийн оролцоо тасралтгүй өссөөр төр зөвхөн зохицуулагч биш зах зээлийн голлох тоглогч оролцогч нь боллоо. Эрх зүйн орчин урьдчилан таамаглах боломжгүй, тогтворгүй хэвээр үүнийг дагаад дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл сул байсаар байна. Энэ бүхэн Монголд бизнесийн зохицуулалтын зардал маш өндөр байх нөхцөлийг бүрдүүлжээ.

Америкийн Нэгдсэн Улсын “Heritage” фондын 2025 оны эдийн засгийн эрх чөлөөний индексээр Монгол Улс 62.6 оноо авч, 184 орноос 74 дүгээр байрт эрэмбэлэгдэж байна. Өмчийн эрхийн хамгаалалт, эрх зүйн орчны чанар төрийн зохицуулалтын үр нөлөө зэрэг үзүүлэлтүүд сул үнэлэгдсэн хэвээр байна.

2016 оноос хойших 10 жилийн хугацаанд Монгол Улс дунд зэргийн эрх чөлөөтэй ангиллаас гарч чадаагүй эдийн засгийн эрх чөлөөний институцийн чанарын ахиц хязгаарлагдмал хэвээр байна. Дэлхийн банкнаас эрхлэн гаргадаг бизнес эрхлэлтийн индексээр манай улс 190 орноос 81 дүгээр байрт, дотоод, гадаадын бизнес орчны үнэлгээний бусад судалгаанууд ч тэр Монгол Улсын бизнесийн орчин нь хүнд суртал ихтэй, зохицуулалт өндөртөйд тооцогдож байна. Энэ нь хөрөнгө оруулалт татах чадвар, бизнес эрхлэх таатай орчин, эдийн засгийн тогтвортой өсөлтөд шууд нөлөөлж байна.

Өөрөөр хэлбэл, Монгол Улс эдийн засгийн эрх чөлөөний суурь зарчмуудыг Үндсэн хуульдаа тунхагласан боловч тэдгээрийг хэрэгжүүлэх эрх зүйн баталгаа нь хангалтгүй хэвээр байна. Эдийн засгийн эрх эрхийг ямар нөхцөлд хязгаарлаж болох, төр ямар зарчим баримтлах, иргэн бизнес эрхээ хамгаалуулах талаар нэгдсэн зохицуулалт өнөөдөр байхгүй байгаа тул, байхгүй байгаа нь бүх хуулийг санаачлан боловсруулах үндэслэл болж байна.

Энэ хууль батлагдсанаар Монгол Улс иргэн төвтэй, хувийн санаачилгыг дэмжсэн хөгжлийн загварыг сонгож буйгаа илэрхийлж баялаг бүтээгчдийн эрх чөлөө, бүтээлч санаачилга, хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн үр шим, эдийн засгийн өсөлтийн жинхэнэ эх үүсвэр мөн гэдгийг төрийн бодлогын түвшинд бас тунхаглах болно.

Хуулийн төсөл эдийн засгийн эрх чөлөөг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Өмчийн халдашгүй байдал, хөдөлмөр, хөрөнгө оруулалтын үр шимээ хүртэх эрх, гэрээний эрх чөлөө, аж ахуй эрхлэх эрх, санхүүгийн эрх чөлөө, мэдээллийн

халдашгүй байдал, шударга өрсөлдөөн зэрэг багтана. Эдгээр бол төрөөс олгодог боломж биш харин иргэдийн суурь эрх мөн юм.

Хувийн өмчийг нийтийн зайлшгүй хэрэгцээнд үндэслэн зах зээлийн бодит үнэлгээнд тулгуурласан нөхөн төлбөрийг бүрэн олгосны үндсэн дээр дайчлах зарчмыг бас тогтооно. Татвар тогтоох зарчмын хүрээнд иргэн, аж ахуйн нэгжээс хуульд заагаагүй төлбөр, хураамж шаардахыг хориглоно.

Татварын тогтолцоо нь ил тод, хуульд үндэслэн байх зарчмыг баталгаажуулна. Төрийн өмчит этгээдэд хуульд заагаагүй давуу эрх, давуу байдал бий олгохгүй. Хөрөнгө оруулалт, бизнесийн харилцаа нь гэрээнд итгэх итгэл дээр тогтдог. Төрийн үүрэг бол гэрээ байгуулахыг заах бус харин байгуулсан гэрээний хэрэгжилтийг хамгаалах явдал.

Тиймээс гэрээний эрх чөлөөний зарчмуудыг баталгаажуулна. Ингэснээр хөрөнгө оруулалтын эрсдэл буурна.

Энэ хуулийн төслөөр хориглоогүй бол зөвшөөрнө гэсэн зарчмыг хуульчилна. Зөвшөөрлийн тогтолцоо хамгийн бага хязгаарлалттай байх, төр хуульд заасан хугацаанд шийдвэр гаргах, шаардлагагүй бичиг баримтыг шаардахгүй байх, хуульд заагаагүй шалгалт хийхгүй байх зарчмыг тогтоож өгнө.

Төрийн үүрэг бол ялагчийг сонгох биш харин оролцогч бүр ижил дүрмээр өрсөлдөх эрх зүйн орчныг бүрдүүлэх явдал юм. Төр ялгаварлан гадуурхахгүй, төр зах зээлд оролцохгүй, төрийн худалдан авалт ил тод байх, эдийн засаг нээлттэй байх зарчмыг баталгаажуулна.

Санхүүгийн эрх чөлөөг хангах зорилгоор иргэн, аж ахуйн нэгж хууль ёсны хөрөнгө мөнгөө чөлөөтэй эзэмших, ашиглах, шилжүүлэх эрхийг тодорхой зааж өгнө.

Төр үнэ, ханш, санхүүгийн харилцаанд захиргааны аргаар үндэслэлгүй хязгаарлалт тогтоохоос зайлсхийх зарчмыг баримтална. Ингэснээр санхүүгийн орчны тогтвортой байдал бэхэжнэ.

Мөн хуулийн төслөөр зохицуулалтын хүрээ хязгаарыг тодорхой зааж өгсөн. Эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлах шаардлага тодорхой тохиолдолд гарч бас болно. Гэхдээ хязгаарлалт нь хуульд үндэслэсэн, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай, зорилгодоо нийцсэн хамгийн бага хязгаарлалтын хязгаар шаардлагатай байх ёстой.

Түүнээс гадна парламентын хяналт хамгаас чухал гэж үзсэн. Хуулийн хэрэгжилтийг тогтмол үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ. Засгийн газар Эдийн засгийн эрх чөлөөний тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулах зохицуулалтыг тусгасан. Ингэснээр эдийн засгийн эрх чөлөөний байдлыг парламентын түвшинд тогтмол хянах шинэ тогтолцоо бий болно. Энэхүү хууль батлагдсанаар аж ахуй эрхлэгчдийн хувьд бизнес эрхлэхэд илүү хялбар, эрх зүйн орчин илүү ойлгомжтой, тогтвортой болон шударга өрсөлдөөн бэхжиж, хөрөнгө оруулагчдын хувьд өмчийн хамгаалалт сайжирч, эрсдэл буурч итгэл нэмэгдэх учиртай.

Улсын хэмжээнд хөрөнгө оруулалт, ажлын байр, бүтээмж, орлого өсөх урт хугацааны суурь нөхцөл бүрдэнэ.

Эрхэм гишүүд ээ,

Бид төр төвтэй эдийн засгийн загварыг сонгох уу, иргэн төвтэй хувийн хэвшлийг дэмжсэн эдийн засгийн тогтолцоогоо бэхжүүлэх үү гэсэн нэн хариуцлагатай цаг үед явж байна. Эдийн засгийн эрх чөлөө бол хөгжлийн зорилго төдийгүй хөгжилд хүрэх арга зам юм.

Иймээс Үндсэн хуулийн баталгааг бодит болгож, эдийн засгийн эрх чөлөөтэй Монгол Улсаа бүтээхийн төлөө бас энэ хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд. Баярлалаа.

С.Бямбацогт: Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадамдоржийн Пунсалмаа танилцуулна. Индэрт урьж байна таныг.

Б.Пунсалмаа: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Б.Жаргалан, Г.Очирбат нараас 2026 оны 06 сарын 05-ны өдрийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 сарын 16-наас 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч эдийн засгийн суурь, эрх чөлөөг хамгаалах, төрөөс эдийн засгийг зохицуулах үйл ажиллагааны зорилго, хэлбэр, хязгаарыг тодорхой болгох, эдийн засгийн харилцаанд эрх зүйг тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой орчныг бүрдүүлэн, төр болон хувийн хэвшлийн харилцаанд хариуцлага, ил тод байдлыг бэхжүүлэх зорилгоор Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслүүд батлагдсанаар иргэн, хуулийн этгээд холбогдох төрийн байгууллагад нэмэлт зардал гаргахгүй, улсын төсөвт ачаалал үүсгэхгүй байхаар тооцсон байгаа.

Хуулийн төслийг d.parliament цахим хуудаст байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг баримтлан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, дэмжих, эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон

гишүүдийн олонх нь дэмжиж, чуулганд нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэд хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа. Хуралдаан даргалагч Д.Үүрийнтуяа.

С.Бямбацогт: Пунсалмаа гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Аюушсүрэнгийн Батпүрэв Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх, Намсрайн Ариунболд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх, Баттулгын Солонго Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх.

Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-нд Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүд үнэн зөв, бодитой, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх, ёстой. Худлаа мэдээлэх, Улсын Их Хуралд хүндэтгэлгүй хандахыг хориглодог. Улсын Их Хурлын тухай хууль болон бусад хуулиудыг бас та бүхэн сануулж байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдах гишүүдээс урьдчилан ирсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Болдын Уянга гишүүн алга байна. Бадарчийн Хэрлэн гишүүн алга байна. Чинбатын Ундрэм гишүүн алга байна. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн болилоо. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаарх Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ.

Дашцэрэнгийн. Энхтүвшин гишүүн алга байна Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалтыг 16 цагаас нэгтгээд явуулна. Санал хураалтыг хойшлууллаа. Дараагийн асуудалдаа оръё.

13.54 цаг.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл анхны хэлэлцүүлэг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболдын урилгаар Хэнтий аймгийн Баянхутаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 1998 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Бат-Эрдэнэ гишүүнийг индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Мандухай нарын 10 гишүүнээс 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл, хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байх асуудал туссан.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 06 дугаар сарын 06, 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны хуралдаанаар явуулах үед Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Иймээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн хэсэгт заасныг баримтлан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт хөдөө аж ахуйн зорилтот хөтөлбөр гэсэн заалт нэмэх хуулийн төсөл боловсруулсныг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-д заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Бат-Эрдэнэ даргад баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Хуулийн төсөлтэй холбогдуулж 2 асуулт байна. нэгдүгээрт энэ хуулийн санаачлагч нь хэн бэ? Хоёрдугаарт энэ хуультай холбогдуулж Улсын Их Хурлын тухай хууль дээр энэ хуулийн харьяалагдах Байнгын хороо нь болохоор Эдийн засгийн байнгын хороо байгаа. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг авсан уу гэсэн ийм 2 асуулт байна.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Хөдөө аж ахуйн тухай хуулийн ажлын хэсгийн хүрээнд бид нар ярилцаж байгаад ер нь бол ажлын хэсгээс бол ийм санал гаргах нь зүйтэй гэж гарсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд үндсэндээ бол хөдөө аж ахуйн тухай асуудал нэг бол дэд бүтэц рүүгээ орчхоод нэг бол байгаль орчин руугаа орчхоод ингээд дунд нь бас хаягдчихаад яг тодорхой хөдөө аж ахуйн бодлогын асуудал гэсэн зүйл, заалт бол бас байхгүй байгаа юм.

Тийм болохоор Хөдөө аж ахуйн тухай хууль боловсруулах ажлын хэсэг дээр бид нар ажлын хэсгийнхэн ярьж байгаад үндсэндээ бол гаргаж ирсэн. Өөрөөр хэлбэл, хууль санаачлагч нь ажлын хэсэг болж байгаа юм.

Байнгын хороон дээр хэлэлцэх явцад бас бусад Байнгын хороотой ярилцъя гэдэг гэсэн тийм саналууд бол яригдаагүй. Үндсэндээ бол Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээрээ бол ярилцаад ингээд цаашаагаа чуулганы хуралдаан руу оруулъя гэсэн ийм саналаар ингээд явж байгаа. Тэгээд Эдийн засгийн байнгын хороотой бол зөвшилцөж ярьсан зүйл байхгүй.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Тэгээд энэ яах вэ маш богинохон хууль боловч энэ хууль дээдлэх зарчим гэдэг юмыг зөрчөөд байгаа харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хуулийн төслийг хэн санаачилсан юм бэ? Санаачлагч нь байхгүй. Дээр нь энэ 42.5 дээр хамтад нь хэлэлцүүлнэ гээд хуулийн төслийн санаачлагч байхгүй юм гэхэд санаачлах 3-хан субъект байгаа. Байнгын хороо гэсэн субъект байхгүй. Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар, Ерөнхийлөгч гэсэн 3 субъект байгаа.

Тэгэхээр энэний аль нь ч биш. Яг ямар хууль өргөн барьсан нь ерөөсөө бид нарт ч ил тод биш, ажлын хэсэг дээр ч гэсэн жишээлбэл зарчмын зөрүүтэй санал гаргах ямар ч бололцоогүйгээр уржигдар хэлэлцээд ингээд баталчихсан. Тэгээд юу хэлэлцэж байгаа нь тодорхойгүй. Цэг, таслал ч байсан энэ чинь хууль учраас яг энэ процессоо дагах ёстой. Тэгэхээр энэ юмнуудаа хангаагүй байна.

Дээр нь хуулийн төслийг боловсруулсан төслийг хамтад нь хэлэлцэх ёстой байтал яг үндсэн гол хууль нь хэлэлцэгдээд батлагдчихсан сая. Энэ анхны

хэлэлцүүлэг. Тэгэхээр энэ чинь өөрөө хууль тогтоомжийнхоо энэ юунууд зөрч.../минут дуусав./

С.Бямбацогт: Асуултаа дуусгаад асуучихъя.

Д.Энхтүвшин: Тэгээд энэ Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудал гээд Улсын Их Хурлын тухай хуулийн 23.11 дээр хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал гээд өөрөөр хэлбэл энэ хөндөж байгаа хууль чинь энэ хуулийн асуудлыг Эдийн засгийн байнгын хороо хариуцахаар ингээд заачихсан байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ 42.6 дээр чинь энэ заасан төсөл нь бусад Байнгын хорооны эрхлэх асуудал хамааралтай бол тэр Байнгын хорооныхоо санал, дүгнэлтийг Байнгын хороогоороо хэлэлцэж тэр санал, дүгнэлтийг нь харьяалагдах Байнгын хороондоо хүргүүлэхээр ийм заачихсан.

Тэгэхээр энэ өөрөө ингээд тусдаа хууль явуулахад гайхаад байсан чинь Хууль тогтоомжийнхоо энэ хуулиудаа зөрчөөд ийм хууль ас орж ирсэн байна. Тэгээд энэ талаар тайлбар өгөөч болж байгаа юм уу?

С.Бямбацогт: Энэ дээр манай Тамгын газраас хариулна. Ер нь бас хууль тогтоомжууд хоорондоо зөрчилдөхгүй байх ёстой. Нэг хууль баталж байна гээд нөгөө хуульд нь дахиад ингээд өөрчлөлт ороод байгаа нь зөв үү? Бас энэ дэгтэй яаж нийцэж байгаа юм? Тэгээд тэрнээсээ болоод нэг хууль санаачлаад нөгөө хуулиа эвдээд, тэр нь хоорондоо зөрчилдөөд ийм асуудал гарах уу, гарахгүй юу? Байнгын хорооны эх барьсан зөвлөх хэн бэ? Тамгын газрын бас ажилтнууд энэ дээр бас анхаарах ёстой. Хуулийг чинь бас Тамгын газар чинь эх барьж байгаа шүү дээ. Хэн хариулах вэ? Хатантуул дарга.

Б.Хатантуул: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.5-д анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль тогтоомжийн хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болно.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Яах вэ би бас мэргэжлийн хуульч биш л дээ. Зүгээр хуульд энэ бид нарын хэрэглэж байгаа тарааж өгсөн хууль дээр маш тодорхой байгаад байгаа байхгүй юу. Төсөл боловсруулж болно энэ хууль дээр заачихсан байгаа. Тэгэхдээ хууль санаачлагч гэж байдаг. Хууль санаачлагч нь тийм боловсруулж байгаа нь яах вэ ажлын хэсэг, энэ Байнгын хороон дээр боловсруулж байгаа юм. Хамтад нь хэлэлцүүлнэ гээд заачихсан байна. Тэгэхэд чинь тусдаа, бусад бид нар хуулийг чинь ингээд хамтад нь хэлэлцэж байгаа хуулиудыг тус тусад нь уншаад ингэж асуудал болгож оруулж ирдэггүй хамтад нь хэлэлцээд явдаг байтал энэ тусдаа хууль орж ирж байна.

Тэгээд холбогдох Байнгын хорооноос нь санал, дүгнэлт авна. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг Эдийн засгийн байнгын хороо хариуцна гээд хууль дээр

заачихсан байхад энэ Байнгын хороогоор хэлэлцээгүй, эндээс санал, дүгнэлт аваагүйгээр орж ирж байна л даа. Тэгээд цэг, таслал байсан гэсэн хууль учраас бид нар бас яг энэ процессоо дагахгүй бол ерөнхийдөө харахад хялбар юм чинь, ойлгомжтой юм чинь гэдэг агуулгаар бас энэ хууль тогтоомжоо зөрчөөд баймааргүй байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Процесстой холбогдолтой асуудлыг нь бас нягталчих нь зөв байх. Хөдөө аж ахуйн тухай хуулийг бас өргөн барьсан гишүүдийн нэг учраас бас энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа.

Ажлын хэсэг дээр бас ярилцаад хэд хэдэн өөрчлөлт оруулсны сайн болон бас сөрөг зүйлүүд бас байгаа. Сайн зүйл нь бол үндсэндээ хөдөө аж ахуйн бодлого үйл ажиллагаа Хөгжлийн бодлого, төлөвлөлтийнхөө тухай хуулиараа урт болон дунд богино хугацааны гэдэг энэ 3 ангиллынхаа хүрээндээ бол нэлээн нарийвчлан зохицуулдаг болох ийм агуулга бол орж ирж байна.

Тэгэхээр хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, байгаль орчны зорилтот хөтөлбөр, засаглалын зорилтот хөтөлбөр, бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр, ингээд шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөр гээд ингээд 6.5.9 дээр хөдөө аж ахуйн чиглэлийн зорилтот хөтөлбөрийг бид нар 10 жилээр тооцоолдог, төлөвлөдөг, түүнийхээ хэрэгжилтийг ингэж хангаад, хянаад явдаг ийм агуулга руу бол орж байна. Энэ бол зөв.

Монгол Улсын гол салбар бол хөдөө аж ахуйн салбар. Түүний бодлого, үйл ажиллагаа тодорхой, хүрэх зорилтууд нь тодорхой, хэмжих энэ байдлууд нь бас зөв ингээд явах учиртай. Энэ бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдолтой асуудлууд дээр бас алдаанууд байна.

Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хуулиараа Монгол Улсын энэ бодлого, үйл ажиллагаа аль нэгэн сайд шинээр гарч ирээд өөрчлөөд явдаг ийм байдлаасаа бид бүхэн салъя аа, уялдаа холбоотой байна, залгамж чанартай байна гэдгийг хуульчилж өгөөд ингээд зохицуулсан. Үндсэндээ яг салбар дээр энэ хэрэгжилтийн байдал дээр бас зайлшгүй анхаарах шаардлагууд бас байна. Сайдууд бас гарч ирээд өөр өөрсдийн шинэ концепцуудыг гаргаж ирээд өмнөх явж байсан ажлуудаа бас үндсэндээ бас үргэлжлүүлэхгүй байх ийм нөхцөл байдлууд бас ажиглагдах вий дээ гэдэг ийм эмзэглэл бас байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг бас хэлэлцэж байгаатай холбогдолтой хөдөө аж ахуйн салбар төдийгүй ер нь Монгол Улсын энэ хөгжлийн салбарын энэ чиглэлүүд үргэлжлэх, уялдаа холбоог нь хангах чиглэл дээр бас нэлээн анхаарал хандуулаарай. Энэ бас заалт орж ирснээрээ энэ асуудлыг бас нэлээн бас цэгцлэх болов уу гэж бол харж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр Алсын хараа-2050-ийг бид бүхэн баталсан байгаа. 30 жилээр үндсэндээ Монгол Улс ямар түвшинд байх вэ гэдгийг бол харж байгаа.

Үүн дотор зорилтуудыг ингээд харах юм бол бид нар хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн шинэ паркийн тоо эхлэхэд бол тэг байсан бол 2025 онд 10 болно гэсэн байгаа юм. Энэ хаана байгаа вэ? 2030 онд 20 болно. 2050 онд 84 үйлдвэр, технологийн парктай болно гэдэг ийм зорилтуудыг тавьсан. Тэгэхээр яах вэ энд энэ жишээгээр дамжуулаад энэ хуулийн 9 энэ зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хэрхэн яаж бид нар дүгнэж байна вэ, яаж хэмжиж байна? Үүнтэй холбогдолтой агуулгуудыг бас багцлаад бас бид би би тайлбар, мэдээлэл авчихъя гэж бодож байна.

Хоёр дахь нь Малчны сонсгол бас болох гэж байна. Баталсан хуулиудаа бид бүхэн бас дагаж мөрдөхгүй бас байгаа асуудлууд байгаа. Улсын төсвийн тодорхой бас санхүүжилттэй холбогдолтой Малчны тухай хуулиар үндсэнд хэрэгжүүлэх ёстой энэ заалтууд журмаа батлахгүй, нийгмийн даатгалын нөхөн төлөлттэй холбогдолтой асуудлууд үүн дээр гарч ирж байна.

Тэгэхээр бид тодорхой төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг баталдаг. Хууль баталдаг. Үүний хэрэгжилт бол үндсэндээ бас асуудалтай байна гэдгийг би бас давтаж бас хэлье.

Хуулийн төслийн бас нэг чухал анхаарах цаашдаа хэрэгжүүлэхтэй холбогдолтой чухал асуудал нь бол өргөн барьсан хувилбараасаа нэлээн өөрчлөгдсөн. Өргөн барьсан хувилбар дээрээ бид бүхэн өртгийн сүлжээг голчилж явъя гэдэг ийм агуулгатай байсан бол үйлдвэрлэлийн сүлжээ болгож яг одоо хуучин үндсэн концепц руугаа бол орсон. Тэгэхээр энийг бас хэрэгжилт дээрээ гол бас анхаарал хандуулаарай. Салбар дундын хоорондын үндсэндээ зохицуулалтуудыг, тэр мөшгөх системийг, хүйтэн системийг үндсэндээ төр хариуцах зайлшгүй шаардлагууд бас тулгарч байгаа. Үүнтэй.../минут дуусав./

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Хэрэгжилтийг. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийг би 20 онд санаачилсан л даа. Тэгээд урт хугацааны бодлого гээд Алсын хараа-2050 гээд бид 30 жилийн хөтөлбөрөө, зорилтот хөтөлбөр, Алсын хараа бодлогын бичиг баримтаа баталсан. Төрийн бодлогын бичиг баримт. 10 жилийнхээ бид нар дунд хугацааны зорилт хөтөлбөр гээд 7 зорилт, хөтөлбөртэй баталж байсан. Богино хугацааг бид 5 жилийн үндсэн чиглэл, 4 жилийн Засгийн газрын хөгжлийн хөтөлбөр, жилийнх нь төлөвлөгөө гэж баталдаг. Төлөвлөгөөндөө уялдаж төсвөө баталдаг ийм л хуультай болсон.

Тэгээд зорилтот хөтөлбөрүүдийг тухайн үед баталж байхад хэтэрхий олон салбар болгон өөрийн зорилтот хөтөлбөртэй болчих юм бол Их Хурлаар батлагддаг, хэрэгждэггүй баахан бодлогын бичиг баримттай болох гээд байна. Тийм болохоор л түрүүн ярьсан тэр 7 байж байгаад сүүлд 1 нэмэгдээд 8 болсон. Энэ яг 8 зорилтот хөтөлбөрөө л баталдаг байя. Үүнийг задлаад, салгаад, салаалаад олон зорилтот хөтөлбөртэй болчих юм бол ингээд гоожоод эхэлнэ гэж бид бол хийж байсан юм.

Одоо ингээд л юу гэдэг юм хөдөө аж ахуйн зорилтот хөтөлбөр рүү явчих юм бол араас нь залгаад хөдөө аж ахуйтай чухал адилхан эрчим хүч чухал эрчим хүчний зорилтот хөтөлбөр, байгаль орчин чухал байгаль орчны зорилтот хөтөлбөр, авто тээвэр чухал, тээвэр чухал тээврийн зорилтот хөтөлбөр гэдэг юм

уу, агаарын тээвэр чухал агаарын тээврийн зорилтот хөтөлбөр гэдэг юм уу ингээд ингээд бүх юмнууд чинь салаад явчих гээд байна гэдэг агуулгаар уул нь нэлээн цэгцэлсэн юм байгаа юм.

Тэгээд одоо хэрэгжилт нь бол бас нөгөө хангалтгүй байгаа. Яг үнэндээ зорилтот хөтөлбөрөөс бид нар ганцхан зорилтот хөтөлбөр баталсан. Бүсчилсэн хөгжлийн зорилтот хөтөлбөрөө 2024 онд баталсан. Бусад 7 зорилтот хөтөлбөрийг Засгийн газар Улсын Их Хуралд оруулж ирэх ёстой. Одоо болтол оруулж ирээгүй байгаа. Нэгэнтээ зорилтот хөтөлбөр байхгүй юм чинь өнөөдөр тэрийг хэмжээд, хянаад, үнэлээд, дүгнэх боломжгүй болчихоод байгаа юм.

Тийм болохоор өнөөдөр танд, таны асуултад хариулахад зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилт гэдэг юм ерөөсөө нойл, юу ч байхгүй. Бүсчилсэн хөгжлийн зорилт бид нар бүсчилсэн хөгжлийг хийхдээ бол бүсчилсэн тойргууд яахын тулд Бүсчилсэн хөгжлийн зорилт хөтөлбөр баталсан. Энэ маань бас өнөөдөр бас амьдрал дээр хэр зэрэг байгаа бол? Үнэлж, дүгнэсэн зүйл байхгүй байгаа гэдгийг танд хариулчихъя.

Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

М.Ганхүлэг: Тийм яг зөв өө. Тодорхой салбарын энэ зорилт хөтөлбөртэй байх нь зөв байгаад байгаа юм. Гэхдээ хэрэгжилтийн асуудал дээр бас асуудлууд байна гээд. Жишээ нь гэх юм бол бид нар 2030 он, 2050 он гэхэд бол хөдөө аж ахуйн парк 84 парктай болно гэдэг зорилтыг бүүр маш тодорхой заагаад өгчихсөн байгаа. 2025 онд бид нар 10 энэ хөдөө аж ахуйн парктай байна гээд.

Тэгээд өнөөдөр энийг үндсэндээ бид нар ярьж байгаа юм алга. Хойноос нь бас хэрэгжилтийг нь үндсэндээ хянаж байгаа ийм процесс алга. Тэгэхээр энэ чиглэл дээр бас анхаараасай гэдэг талаас нь бас хэлж байгаа юм.

Хоёрт нь энэ хэрэгжилтийн хөдөө аж ахуйн чиглэлийн зорилт хөтөлбөрийг гаргахдаа энэ хуулийн үндсэн тэр санааг бас аль болох тусгах чиглэлд нь анхаарч хийгээсэй гэж хүсээд байгаа юм. Одоо бид нар үйлдвэрлэл талаас нь хараад байгаа юм. Тэр мал аж ахуйн бүтээгдэхүүн бий болоод тэрийг тээвэрлэх, мөшгөх, тэрийг үндсэндээ тэр логиستيкийн систем энэ тэр гээд тэр нарийн зохицуулалтуудыг илүү дэмжих төрийн бодлогуудыг үндсэндээ гаргаж ирсэн ийм зорилт хөтөлбөр байх ёстой юм гэдгийг энэ бас.../минут дуусав./

С.Бямбацогт: Ганхүлэг гишүүн үг хэлчихлээ.

Зочин танилцуулъя. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө 30 жилийн ойг тэмдэглэж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуултаа асууя.

О.Алтангэрэл: Байз энэ хууль санаачлагч нь хаана байна дарга? Одоо бид нар ингээд энэ төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа гээд та алах цохиул Үндсэн

хууль зөрчих гээд байна. Одоо хуралдаж хуралдаж байгаад үхрийн сүүлэн дээр хутга гэж хаврын чуулган дуусахын алдад ийм зөрчилтэй юм хэдүүлээ хийж болохгүй. Хамтад нь батлах ёстой зүйл, заалтыг бариад санаачилга ч байхгүй, ажлын хэсэг ч байхгүй. Асуултад нь ингээд л Их Хурлын дарга өөрөө хариулаад л би тэдэн онд баталж байсан ингээд сууж болохгүй.

Энэ чинь Булгантуяагийн хурал даргалснаас хамаагүй ноцтой үйл явдал. Булгантуяа гишүүнийг хурал даргалсан энэ тэр гээд л Үндсэн хуулийн цэц энэ тэр гэж байгаа. Энэнээс чинь ноцтой үйл явдал болох гээд байна. Хууль зөрчигдөх гээд байна шүү дээ. Хэдүүлээ хуулиа барья л даа. Энхтүвшин гишүүн зөв яриад байна шүү дээ. Би бас ингээд гайхаж энийг асуух гэж ингэж орж ирсэн. Энэ чинь хууль санаачлагчид нь суугаад юмаа тайлбарлаад, бид нар асуугаад ингээд зорилго, чиглэлийг нь ойлгоод Улсын Их Хурлын чуулганы дэг, дэс дараалал юмны чинь зорилго энэ юм байгаа биз дээ.

Тэгэхээр ингэж хууль зөрчмөөргүй байна. Энийгээ больё. Та түр энийгээ зогсоогооч гэж ийм хүсэлт байна. Асуулт байхгүй.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Бат-Эрдэнэ гишүүн горимын санал.

Ж.Бат-Эрдэнэ: Санаачлагчийн хувьд Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлах эрхтэй. Ажлын хэсэг боловсруулах явцад, ажлын хэсэг ажиллах явцад Улсын Их Хурлын гишүүд өөрөөр хэлбэл ажлын хэсэгт байгаа гишүүд санаачилж өөрсдөө энд ажлын хэсгээсээ гаргасан шийдвэр шүү дээ. Тэр утгаараа бол энэ санаачлагчид нь бол ажлын хэсэг дээр очно. Гишүүд дээр. Одоо горимын санал энэ дээр гаргачихъя. Тэр хамтад нь хэлэлцүүлнэ гэх явцад жоохон процедур алдагдаад тэгээд арагшийгаа үлдээд сугараад үлдчихсэн юм. Тэгээд дангаараа түүнээс биш хамтдаа явж байгаад тэр нөгөө хэлэлцэх асуудлын дэг дотор, юун дотор ороогүй нэрсийн жагсаалт дотор оруулж чадаагүй. Тэгээд энэ нь үлдчихээд процедурын жоохон алдаа гарсан юм.

Тийм болохоор горимын санал гаргаж байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороонд нь буцаая гэсэн ийм горимын санал гаргаж байна.

С.Бямбацогт: Тэгэхээр бид нар бас яг Улсын Их Хурлын гишүүдэд мэргэжил арга зүй, техникийн зөвлөгөө үзүүлдэг Их Хурлын Тамгын газрынхаа ажилтнууд, зөвлөхүүдийнхээ хэлж байгаа, ярьж байгаа хууль хоорондын зөрчил гарчих вий, дэгийн хууль болон бусад хууль зөрчилдчих вий гэж хэлж байгаа зүйлүүдийг бас нэлээн хүндэтгэлтэй сонсож анхаардаг баймаар байгаа юм.

Тэгэхгүй би хууль санаачлах эрхтэй, миний санаачилсан хуулийг батлах, та нар туслах л үүрэгтэй гээд хууль баталчихдаг. Одоо энэ дээр бол тийм л юм болчихсон байгаа юм л даа. Тэгээд үндсэндээ энэ чинь Хүнсний тухай хууль билүү? Хөдөө аж ахуйн тухай хууль. Хөдөө аж ахуйн тухай хууль батлахдаа нэг гишүүн санал гаргаад л ийм зорилтот хөтөлбөр байх ёстой гээд Хөдөө аж ахуйн тухай хуульд оруулчихсан. Оруулаад тэр хуулиа бид баталчихсан. Тэгэнгүүтээ тэр хуулийг хэрэгжүүлэхийн тулд энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт заавал явах ёстой гээд л Байнгын хороонд санал гаргаад л энэ хуулийг араас нь оруулж ирж байгаа юм байна лээ.

Тухайн үед би бас Тамгын газрынхан бол энэ болно, болохгүй гэдэг талаар бас тодорхой зөвлөмж өгч байсан байх гэж ойлгож байна. Гишүүд маань өөрсдөө үгүй ээ наадхаа болго наадхаа гээд л ингэчихдэг. Тэгэнгүүт айн тийм тэгээд тиймэрхүү юм болчихсон байх вий дээ. Тийм болохоор эргээд ярьцгаая. Мэргэжлийн Байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, дээрээс нь Эдийн засгийн байнгын хороо бас энийгээ эргэж харъя. Сая бас манай Бат-Эрдэнэ гишүүн бас санал гаргаж байна.

Тэгээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41.10-д нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн бол хуулийн төслийг Байнгын хороонд буцаана гэсэн ийм заалт байдаг юм.

Гэхдээ энийг бол санал хураалтаар шийдэх юм байна. Тэгээд санал хураагаад гишүүд маань олонхоороо энийг буцаагаад яая. Үнэхээр хуулийн зөрчил гарах гээд байна шүү гэдгээ ойлгоод гишүүд маань үзэх юм бол энэ санал хураагаад буцаагаад Байнгын хороонд шилжүүлээд гаргалгаа гаргая. Тэр болтол энийг горимын саналаар энэ асуудлыг хойшлуулъя.

Үндсэндээ энэ асуудлыг гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооны гаргасан горимын саналаас санал хураалт явуулах ёстой. Энэ саналыг тэгэхээр хураалгахгүй хойшлуулъя. Саяын агуулгаар гэхдээ бас яах нь байна шүү Тамгын газраас энэ дээр гаргалгааг нь бэлдээрэй бас. Санал хураалтыг 16 цагаас явуулна. Дараагийн асуудалдаа орьё.

14.17 цаг.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Э.Болормаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Зуны дунд сарын шинийн 5-ны цастай, хуртай өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их

Хурлын даргын 2026 оны 263 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, С.Ганбаатар, П.Наранбаяр, С.Одонтуяа, П.Сайнзориг, Ч.Ундрэм, С.Эрдэнэбат нарын гишүүд ажиллалаа.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хуулийн төсөл Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийг тусгасан нь цаашид тус хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах эсэх, карбон зах зээлийн бодлогыг хэн гаргах, бүртгэл, тооллогыг ямар байгууллага хийх талаар, үндэсний платформын зохицуулалт нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн мэдээллийн сангийн зохицуулалттай нийцэж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан хүлэмжийн хийн тэг ялгаралд хүрэх бодлогын зорилтдоо манай улс хэрхэн хүрэх, цаашид ногоон санхүүжилтийн хүрээнд урт, дунд хугацааны бодлогод туссан усны нөхцөлүүдийг хэрэгжүүлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат энэ хуулийг хэлэлцэн баталснаараа үүсэж байгаа давуу тал, уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг бүс нутаг, хүн амын бүлэгт чиглэсэн дэмжлэг үзүүлэх эсэх, экологийн төслүүдийг хэрэгжүүлэх талаар зохицуулалт туссан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр Техникийн хороо, мэргэжлийн байгууллага болон шинээр Засгийн газрын агентлаг байгуулагдах эсэх, шинээр үүсэж байгаа харилцаанд үндэслэн гаалийн болон хув хүний орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Ажлын хэсгээс уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох болон даван туулах бодлогыг байгаль орчны салбарын суурь болгон хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, салбар дундын уялдааг хангах, уур амьсгалын өөрчлөлтийн талаар цогц судалгаа, мэдээллийн санг бүрдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг бүх шатын боловсролын түвшинд эзэмшүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хандлага, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авах, ногоон санхүүжилт карбон зах зээлийн зохицуулалтын хамрах хүрээг тодорхойлон нэмж тусгах, төслийн нэр томьёог жигдлэх, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тогтоолын заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөн бүтэц, найруулга, холбогдох хууль зүйн техникийн засварыг хийх зэрэг зарчмын зөрүүтэй 40 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Болормаа гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга, Лхамсүрэнгийн Чой-Иш Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын газрын дарга, Саруулын Пүрэвсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга. Энэ хүмүүс байгаа юм уу? Тэгээд суудлаасаа өндийж чадахгүй юу? Хүрэлхүүгийн Номин Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны газрын ахлах шинжээч. Алга байна тийм үү? Цэндээхүүгийн Мөнхбат Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын ахлах шинжээч, Алтангэрэлийн Нарангаравуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Цэвэгмэдийн Мөнхнасан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч бас алга байна тийм үү? Эрхэмбаярын Баттулга Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга, Дамдины Дагвадорж Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, судлаач, Замбын Батжаргал Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн шинжлэх ухааны зөвлөх, Баатарын Номун Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Нүүрстөрөгчийн зах зээлийн бэлэн байдлыг бэхжүүлэх нь” төслийн хуулийн зөвлөх.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орчихоод ирээгүй ажлын хэсгийн гишүүдийг дуудъя. Сангийн яам, Хөдөө аж ахуйн яам. Бусад нь ирсэн байх шиг байна тиймээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн, зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн, зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.

Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг болохыг та бүхэнд сануулъя. Тийм болохоор Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандаж, гишүүдийн асуусан асуултад үнэн, зөв, бодитой мэдээлэл өгнө шүү гэдгийг сануулъя.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаярын урилгаар Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийн баяраа тэмдэглэж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ганбатын Очирбат гишүүн асуултаа асууя. Алга байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг дэмжиж байгаа. Төсөлтэй холбогдолтой бас 2 асуултыг асууя. COP17 бас олон улсын томоохон бас хурал болох гэж байгаатай холбогдолтой байгаль орчны бас хэд хэдэн хуулиуд бас өнөөдөр орж ирж байна. Тодорхой бас асуудлуудыг бид бүхэн бас хууль, эрх зүйн орчноо сайжруулаад хурал уулзалтуудаа бас амжилттай хийгээд явахад бас нэмэр болох болов уу гэж бас харж байна. Энэ удаагийн хуулийн төсөл дээр карбон кредиттэй холбогдолтой, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахтай холбогдолтой хэд хэдэн асуудлууд бас нэлээн хөндөж бас орж ирсэн байна.

Гэхдээ бас нарийвчлан зохицуулах бас шаардлагууд байна гэж харж байна. Ерөнхий асуулт нь бол ер нь энэ карбон кредитийн тодорхой энэ үр ашгийг малчдад бэлчээрээ сэлгэх, хамгаалах энэ чиглэлээр өөрийн туршлагаа нэмэгдүүлж, үр өгөөжийг нь хүртэх чиглэлээр бас ямаршуу гол гол зохицуулалтууд байна вэ, энэ чиглэлийг яг бодитойгоор дэмжих асуудлууд нь юу байна вэ гэдэг ийм ерөнхий асуулт байгаа.

Илүү тодруулах хүрээндээ бол 2 асуулт байгаа юм. 2 дугаар бүлгийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг дээр яг энэ карбон энэ зах зээлтэй холбогдолтой асуудал дээр малчдын хүртэх үр өгөөжийг бас нэлээн ийм тодорхой заах хэрэгтэй байна. Хуулийн төслийн гол агуулга нь бол гэрээгээр шийднэ гэсэн ийм агуулга орж ирсэн байна. Тэгэхээр энэ гэрээг ямар байдлаар яаж шийдэх вэ? Талуудын хэлцэл хийх чадварыг бас та бүхэн маань бас яаж судалсан бэ? Мөн яг энэ малчид энэ алс нутагт байгаа, мэдээллээс бас жоохон алслагдмал байгаа энэ нөхцөл байдлуудыг бас яаж харгалзах вэ? Тэгэхээр энийг илүү нарийвчлан зохицуулах ийм боломж байх уу? Карбон кредитийн олгохтой холбогдолтой зохицуулалт дотроо бол бэлчээр бол нэлээн дийлэнх хэсгийг нь бол үндсэндээ бол авна. Тэгэхээр бэлчээрээ ашигласнаараа бүүр илүү тодорхой тэчнээн хувь байдаг юм уу, тэчнээн хэмжээний үр ашгийг нь бол авах боломжтой гэдгийг нь бид нар заавал Засгийн газар тодорхой энэ гэрээ гэж ингэж орхилгүйгээр нарийвчлаад өгвөл энэ бас хуулийн хэрэгжилтэд бас илүү хэрэгтэй болов уу гэж бас хараад байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан төр захиргааны байгууллага үүнтэй холбогдолтой асуудлыг ерөнхийд нь зохицуулахыг бол дэмжиж байна. Яг гэхдээ бэлчээртэй холбогдолтой асуудал дээр хэрэгжүүлж

эхлүүлэх зөвшөөрөл, түүнтэй холбогдолтой асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яам бол олгох гээд байгаа юм. Тэгэхээр яг энэ дээр бас тухайн асуудлыг эрхэлсэн яамыг бас оруулж ирэх, холбогдох төрийн захиргааны байгууллагыг нь оруулж ирэх, эс үгүй бол тусад нь салах байдлаар ингэж нарийвчлан зохицуулах нь зөв болов уу гэж бодож байна.

Тэгэхээр үндсэндээ энэ Засгийн газрын тухай хуулиараа энэ бэлчээр, эдэлбэр газартай холбогдолтой асуудлыг Хүнс, хөдөө аж ахуйн яам бас хариуцаж байгаа. Тэгэхээр энэ бас хуультай зөрчилдөх үү? Ийм бас зохицуулалтууд бас байна гэдгийг асууя.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Болормаа гишүүн хариулъя.

Э.Болормаа: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Ганхүлэг гишүүн нэлээд хамгийн гол чухал зохицуулалт буюу карбон зах зээл, тэр дундаа бид ихэнхдээ мод тарих эдгээр бусад төслүүдийг эрчим хүчний төслүүдийг боддог бол бэлчээр бол энэ уур амьсгалын өөрчлөлтийн салшгүй маш том бүрэлдэхүүн хэсэг байгаа. Тэгэхээр бид нар асуудлыг ярьж байгаа бол шийдлийг ч гэсэн мөн бэлчээртэй салшгүй холбож, ойлгож энэ асуудлыг ажлын хэсгийн хүрээнд нэлээн ярьсан байгаа.

Эхний таны асуулт буюу энэ карбон кредит энэ санхүүжилт хөрөнгө оруулалтаас малчид, иргэд яаж бодь орлого олох вэ гэдэг дээр тодорхой хариулт өгье. Хуулийг хэлэлцэх эсэх дээр энийг бас бид нар яг тодорхой ойлголтыг олон нийтэд өгч чадаагүй харагдсан. Ажлын хэсгийн хүрээнд энийг маш олон гишүүд хөндсөн. Шууд малчид хэрхэн өгөөж авах юм бэ? Байгалиа хамгаалсан, байгалиа нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд эерэг үр дүн үзүүлэх гэдэг. Өнөөдөр карбон зах зээл буюу энэ зах зээлийн эрэлт нь тэр чигээрээ Монгол Улсаас гадуур байгаа олон улсад.

Тэгэхээр бид энэ нийлүүлэх энэ зах зээлд үүд, хаалгыг нь нээх зохицуулалтыг энэ хуулиар оруулж ирж байгаа. Тэгэхээр эрэлтийг нь буюу энэний төлөө мөнгөө зарцуулъя гэсэн тэр зах зээл юу гэж хүсдэг вэ гэхээр иргэдтэй шууд харьцахаас илүүтэйгээр дандаа төсөл хөгжүүлэгчтэй, этгээдтэй харилцдаг. Харин тэдгээр этгээд нь малчид, иргэдтэйгээ маш нарийн ойлголцсон байх ёстой гэдгийг бол шаарддаг байгаа.

Тэгэхээр бид бид нар одоогоор оруулсан байдлаар юу гэж байгаа вэ гэхээр яг тэр олон улсын стандартын дагуу энэ тэгш хүртээмжтэй шилжилт гэж ярьдаг энэ уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий бүлэг, хүн амын бүлэг, салбараа бол нэн тэргүүнд авч үзнэ. Тэдгээрийн саналыг заавал тусгасан байх. Гэрээгээр бүүр цаашлаад юу гэж зохицуулагддаг вэ гэхээр энэ орлогоо тодорхой хэмжээг нь ашиг гэх нь юу юм тэгэхдээ орлогоо тодорхой хэмжээг нь хуваалцдаг, яг тодорхой хувийг нь иргэддээ өгдөг байх.

Шууд иргэд яагаад бас оролцоход хүндрэлтэй байдаг вэ гэхээр нөгөө бид нарын энэ хэмжилт, баталгаажуулалт хийдэг олон улсын итгэмжлэгдсэн байгууллагуудын зардал нь аягүй өндөр. Тэгэхээр хувь хүн, иргэн, малчин ийм төсөл хэрэгжүүлж явах нь яг бодитойгоор хүндрэлтэй учир би бас буруу хүлээлт

үзүүлмээргүй байна. Яг бодитоор бол энэ төслүүдийг хэрэгжүүлэх этгээдүүдтэй бид нар иргэдийг холбох, харин тэдгээр нь үр ашгийнхаа тодорхой хувийг тэр иргэдтэйгээ ойлцсон байх ёстой шүү гэдэг шаардлагыг бол оруулсан байгаа.

Таны хоёр дахь асуулт буюу бэлчээртэй холбоотой энэ Эдийн засгийн хөгжлийн яам зөвшөөрөл олгох гэдэг нь Засгийн газраас өргөн барьсан төсөл дээр Хүнс, хөдөө аж ахуйн яам саналгүй гэсэн. Тэгэхээр одоогоор Хүнс, хөдөө аж ахуйн яам энэ ороогүй байгаа нь яам бол өөрөө энэ саналгүй гэж саналаа хүргүүлсэн. Гэхдээ бид юу гэж оруулсан бэ гэхээр энэ зөвхөн нэг яамны эрх мэдэл нэг газар төвлөрчихвөл Засгийн газрын чөлөөлье гэдэг агуулгаас өөр тал руу яв.../минут дуусав./

С.Бямбацогт: Тодруулж асууя Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Тийм яах вэ гэрээтэй холбогдолтой асуудал дээр ингээд 2 тал болчхож байгаа. Тэгэхээр тэр мэдээлэл авах чадамж, аягүй олон ийм ялгаатай бас байдлууд, кэйсүүд үүсчих вий дээ гэж бодоод байгаа юм. Тэгэхээр малчдыг төлөөлж байдаг юм уу тэр талаас үндсэндээ хандах ийм бас төлөөллийн зохицуулалтыг нь илүү сайжруулж өгөхгүй бол 2 тал гэрээ хийж байхад өөр ялгамжтай хувиуд аваад эхэлбэл яах вэ ч гэдэг юм уу. Тийм ийм бас ийм асуудлууд руу бас орох эрсдэлүүд бас байна.

Нөгөө талаасаа шинэ тутам зохицуулалт учраас энэ дээр бас яг яаж гэрээ хийх вэ, ямар санал гаргах вэ гэдгийг бол үндсэндээ бараг бид нар өөрсдөө ч мэдэхгүй байна шүү дээ. Тэгэхээр яг ингээд малчдад бид нар ингээд үндсэндээ энэ дээр гэрээ хийгээд ингээд явъя гэдэг дээр тодорхой зайлшгүй ийм зохицуулалт хийх яг энэ төрийн захиргааны төв байгууллага нь байдаг юм уу энэ дээр тусдаа яг ийм бас нэгж зайлшгүй шаардлагатай бас байх ийм эрсдэл байна гэдэг талаас нь бас юу асуугаад байгаа юм аа.

Хоёр дахь асуудал дээр дотор нь ангилчихъя гэж байгаа юм. Бэлчээртэй холбогдолтой асуудал дээр яамны саналыг тусгаад явахгүй бол Засгийн газрын хуулийг зөрчих юм байна лээ.

С.Бямбацогт: Асуулт Болормаа гишүүн хариулчихъя. Дараад нь зочин танилцуулъя. Ажлын хэсэг Болормаа гишүүн хариулъя.

Э.Болормаа: Тэгэхээр саяын зөвшөөрөлтэй холбоотой зүйл дээр бид яг энийг ажлын хэсэг дээр ярьсны дагуу өнөөдөр оруулж ирж байгаа зарчмын зөрүүтэй саналуудын нэг нь орон нутгийнхаа иргэдийн саналыг авна гэж онцгойлон тусгаж байгаа. Тэгэхээр бид оруулж ирсэн төслөөсөө энийг бол энэ агуулгаар нь сайжруулсан гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ дээр өнөөдөр санал хураах, зарчмын зөрүүтэй саналуудын нэг нь юм байгаа юм.

Цаашид тэгэхдээ журам энийг мэдээж хуулийн түвшинд ямар зүйл байх вэ, журмын түвшинд ямар зүйл байх вэ гэдэг нь ялгаж салгагдана. Тэгэхээр журамтай холбоотой зохицуулалт дээр энийг бас онцгойлон тусгах талаар бол анхаарч ажиллая. Энэ хууль бол 6 сарын дотор холбогдох журмуудыг бол батлах үүрэгтэй байгаа. Хэрвээ батлагдвал энэ хууль маань.

Дараагийн тантай холбоотой асуудал дээр бэлчээртэй холбоотой асуудал яг бид нар энийг албан ёсоор тийм хууль зөрчинө гэхээс илүүтэйгээр Засгийн газрын бүрэн эрх дотор байгаа асуудал нэг яам биш. Энэ зөвшөөрөл өгч байгаа гэдэг нь энэ газрын ашиглалтын зөвшөөрөл гэхээсээ илүүтэйгээр төсөл нь энэ үндэсний.../минут дуусав./

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Минут сунгая Болормаа гишүүнд.

Э.Болормаа: Карбон зах зээлийн гадна талаасаа энэ зах зээлд хүсээд байгаа 3 тодорхойлолт байгаа. Эхнийх нь болохоор татгалзахгүй гэдэг энэ төслийн санаачилга нь өөрөө тухайн улсын уур амьсгалын өөрчлөлтийн зорилт, энэ зорилготой бол ямар нэгэн харшлах зүйлгүй гэдэг тодорхойлолт.

Хоёр дахь нь ямар тодорхойлолт вэ гэхээр энэ өөрөө яг технологийн дагуу тэр баталгаажуулалт нь зөв байсан. Дээрээс нь энэ нэлээн нарийн зохицуулалттай олон улсад учир Монгол Улс энэ эерэг төслөө хэрэгжүүлэх нь нөгөө улсынхаасаа багасгаж байгаа болохоос манай улсынхыг бас ихэсгэж байгаа хүлэмжийн ялгарлын тооллыг. Тэгэхээр тэр засгийн оролцоо байна.

Тиймээс төвлөрсөн энэ бодлогоо хариуцаж байгаа Эдийн засгийн хөгжлийн яам байна. Бид нар салбар бүр дээр салбар бүрийн яамыг оруулах юм бол энд нугалаа үүсээд энэ зөвшөөрлүүд нь гацдаг биш тухай бүрдээ энэ Засгийн газрын хэмжээний энэ процессын журам нь батлагддаг Засгийн газрын хэмжээний эрх байгаа учир энэ дээр бол бид асуудалгүй гэж үзсэн байгаа.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаярын урилгаар Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа, төгсөлтийн баяраа хийж байгаа Отгонбаяр гишүүний төгсөлтийнхөндөө бас улсын Улсын Их Хурал дахь нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Отгонбаяр гишүүн найзуудтайгаа нийлчихсэн байна шүү дээ төгсөлтийнхөнтэйгөө.

Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуултаа асууя. Алга байна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн. Алга байна Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя. Алга байна.

Зарчмын зөрүүтэй 41 санал байгаа. Нэгдсэн журмаар санал хураалт явуулна. Санал хураалтыг хойшлууллаа. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. Хүрэлцэн ирсэн ажлын хэсэгт баярлалаа. Ажлын хэсэгт ирээгүй нөхдүүд бас анхаарах ёстой шүү Тамгын газар. Их хуралд хүндэтгэлгүй хандаад хуралдаанд ирэхгүй байгаа нөхдүүдэд. Дараагийн асуудалдаа оръё .

14.36 цаг.

Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Бат-Эрдэнэ: Эрхэм Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

2012 оны 05 сарын 17-ны өдөр шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш 14 жилийн дараа Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хийхээр ажиллаж орж ирлээ. Тогтвортой хөгжлийг нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн 3 хүрээнд хангаж, хүрээлэн буй орчин, экосистемийг хамгаалснаар хүн бүр эрхээ бүрэн дүүрэн эдэлж сайн сайхан амьдрах боломж нөхцөлийг өнөөгийн болон хойч үедээ бүрдүүлнэ. Хүн төрөлхтөнд тулгараад байгаа уур амьсгалын өөрчлөлт, орчны бохирдол, биологийн олон янз байдлын хомсдол нь олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан хүний үндсэн эрхийг хангаж, амьдралын чанарыг сайжруулахад тулгарч байгаа сорилт бэрхшээлүүдийн нэг хэсэг болоод байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, ус, усны нөөц, ан амьтан, төрийн нийтийн өмч байна гэж мөн тус тус заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2-т хүн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг тунхаглаж, байгаль орчныг хамгаалах болон хүний үндсэн эрхийн хамаарлыг хүлээн зөвшөөрсөн билээ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хөрс дэлхийн унаган байгалиа хайрлан хамгаалж хөгжих эрхэм зорилгыг тодорхойлж, байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн, эко системийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэлх нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх, хүлэмжийн хийн ялгарал багатай байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах зорилтуудыг дэвшүүлсэн.

Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 86-д Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг боловсруулахаар тусгасан.

Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг хангуулахын тулд ойн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ойн нүүрстөрөгчийн хийн шингээлтийг тооцох, түүнийг үнэлэх, тайлагнах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Ийнхүү дээр дурдсан урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого чиглэлд нийцүүлэн Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хийх зайлшгүй шаардлага бий болсон.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний 2.10-т модлог ургамлын үр, тарьц суулгац бэлдэх, импортлох, хадгалах, худалдан борлуулах, тээвэрлэх, ашиглах, үрийн нөөцийн усан сан бүрдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор заажээ.

Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг хангуулахын тулд ойн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ойн нүүрстөрөгчийн хийн шингээлтийг тооцох, түүнийг үнэлэх, тайлагнах эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлага бий болсон.

Ойн тухай хуулийг 2012 онд шинэчлэн баталснаас хойш 13 удаа нэмэлт өөрчлөлт орсон. Үүний 8 нь бусад хуулийг дагалдан орсон редакцын шинжтэй нэмэлт өөрчлөлт байна.

2022 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр улсын хэмжээнд ойн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг байгуулсан нь дэвшил болсон. Үүнээс өөрөөр ойн салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх ойг эко системийн хувьд нь хадгалах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, ойн эко системийн үйлчилгээнд бүрэн чиглэсэн ойн тогтвортой менежментийн бодлогыг урт хугацаанд хэрэгжүүлэхэд чиглэсэн агуулгын өөрчлөлт, шинэчлэлт хийгдээгүй байна.

Улсын хэмжээнд 2014-2016 онд явуулсан олон зорилтот ойн тооллогын тайланд ойн нөөцийн 76 хувь нь болц гүйцсэн буюу хөгширсөн, унанги, ойн хөнөөлт шавж, өвчинд өртсөн талбай ихээр нэмэгдсэн, байгалийн жамаар нөхөн сэргэх чадамж буурсан, Монгол Улсын ойн үнэт чанар алдагдаж байна гэж дүгнэсэн.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Засгийн газраас ойн хомсдол, доройтлыг бууруулан ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх зорилгоор нийт 1.5 тэрбум мод, сөөг тарьж, ойг нөхөн сэргээх болон таримал ойн талбайг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Энэ нь ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэхэд шинээр ой бий болгох, мод сөөгийг тарималжуулах, ойн санд бүртгэх, өмчийн харилцааг тодорхой болгох зохицуулалтуудыг бий болгох хэрэгцээ байгааг харуулж байгаа билээ.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг тусгасан.

Нэгдүгээрт, Ойг эко системийн түвшинд тодорхойлж, ойн сан бүхий газарт байгалийн болон таримал, заган, татмын ой мод, сөөг, заган болон заг бүхий газар, ойн цоорхой, цагаан энгэр, ой тэлэн ургахад шаардлагатай газар болон хамгаалалтын зурвас хамааруулан ойн сангийн ангиллыг өргөтгөж хамгаалалтын болон ашиглалтын бүсэд хувааж байсныг 3 болгож, тусгай зориулалтын ойн ангиллыг нэмэх ба тэдгээрийн дэглэм, хориглох үйл ажиллагааг тодорхойлно.

Хоёрдугаарт, улсын, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөө нь стратегийн шинжтэй байх тул сумын ойн менежментийн төлөвлөгөө нь тухайн газар, нутаг дэвсгэрийн ойд хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээг тусгаж хэрэгжүүлэх ба 10 жилийн хугацаатай байх. Үүнээс хугацаанаас өмнө байгалийн аюулт үзэгдлийн улмаас ойн төлөв байдалд ихээхэн хэмжээний өөрчлөлт орсон нь ой зохион байгуулалт, ойн тооллогоор тогтоогдсон, эсхүл газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ойн сан бүхий газрын ангилалд өөрчлөлт орсон үндэслэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах тайланг тухайн жилд багтаан цахим системд илгээж байхаар хуульчлах ба хушин ойн менежментийг тусгайлан заана.

3.Ойн баялгийн модны нөөц болон дагалт баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, нэмэгдсэн өртөг шингээх, тогтвортой ашиглах, ойн эко системийн үйлчилгээний эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх. Ингэхдээ тухайн ойн бүсийн ангилал дэглэмд нийцсэн ойн менежментийн төлөвлөгөөнд үндэслэсэн дэвшилтэт ногоон технологи ашигласан ойн баялгийн нөөцийг хаягдалгүй, үр ашигтай, тогтвортой ашиглах, хаягдлыг бууруулах, үлдэгдэл био массыг био эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг нээнэ.

4.Ойн санг хот айл, нөхөрлөлд гэрээгээр 10 жилийн давтамжтайгаар 60 хүртэл жилийн хугацаагаар гэрээгээр хариуцуулан хамгаалах. Тухайн ойгоосоо ахуйн зориулалтаар түлээний мод болон дагалт баялаг түүж ашиглах, түүнчлэн ойн сангийн нүүрстөрөгчийн кредитийг ашиглан зах зээлд оролцох нөхцөлийг бүрдүүлнэ.

5.Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх ойн мэргэжлийн үйл ажиллагааны төрөл, шаардлага, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд тавих шаардлага үүргийг тусгана.

Зургаадугаарт, Ойн мэдээллийн цахим санг хөгжүүлж, салбарын үйл ажиллагаанд оролцогчдын мэдээлэл солилцох, ойн сантай холбоотой бүртгэл, зөвшөөрөл, хяналт, мэдээлэл, гарал үүсэл, эрхийн бичиг, цахимжуулах, мод бэлтгэл боловсруулах үйлдвэрлэлийн үйл явцыг ойн тогтвортой менежментийн стандартыг хангаж байгааг баталгаажуулах харилцааг хуульчлахаар.

Долоодугаарт, Ойн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих зорилго бүхий ойжуулалтын сан, мөн ойн нүүрстөрөгчийн шингээлт, ялгаралтай холбоотой төсөл, бэлтгэл, бүртгэл, баталгаажуулалт, зах зээлийн оролцоог дэмжих зорилго бүхий ойн нүүрстөрөгчийн худалдааны орлогоос бүрдсэн ойн нүүрстөрөгчийн санг байгуулах, ажиллуулах эрх бүхий зохих зохицуулалтыг бүрдүүлэхээр тусгалаа.

Ойн бүсийн ангиллыг шинэчилж, тэдгээрт тохирсон дэглэмийн зохицуулалтыг бид нар нарийвчлах нэн шаардлага тулгараад байна. Ойн тогтвортой менежментийн зарчмыг тусгаж, бүх шатны ойн менежментийн нийтлэг болон тусгайлсан тухайлах юм бол хушны самрыг биологийн нөөц болон ашиглалтын нөөцөд тулгуурлан тусгайлсан менежментийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих зохицуулалтыг шинээр оруулах шаардлага бий болсон.

Өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан таримал ойг эзэмшиж, ашиглах, үр шимийг хүртэх болон таримал ойг хүлээн авах, ойн мэдээллийн цахим системд бүртгэх, таримал ойгоор бүртгэснийг баталгаажуулахтай холбогдолтой харилцааг нарийвчлан зохицуулах шаардлага байна.

Ойн нөөцийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх био эдийн засгийг хөгжүүлж, ойгоос үлдэгдэлгүй байх буюу ойн бүхий л түүхий эдийг ашиглах зохицуулалтыг бид нар эдийн засгийн хувьд дэмжихтэй холбогдолтой харилцаа, зохицуулалтыг шинээр нэмсэн.

Ойжуулалтын санг байгуулж, тус салбарын тогтвортой хөгжлийг дэмжих, түүнчлэн ойн нүүрстөрөгчийн шингээлтийг тооцох, ялгарлыг бууруулах, олон улсын нүүрстөрөгчийн зах зээлд оролцох боломжийг нээж, түүнтэй холбогдсон харилцааг Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар оруулж өглөө.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулсан болно.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд та бүхнийг Ойн хуулийн хэлэлцээд шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Төслүүдийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гомбын Ганбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Ганбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 18 гишүүнээс 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол улсын ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтол зэрэг тулгамдсан асуудлуудыг бууруулах, ойн экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг нэмэгдүүлэх, иргэд, аж ахуйн нэгж, орон нутгийн байгууллагын оролцоог сайжруулах, ойн нөөцийн бүртгэл, хяналт, менежментийг нь боловсронгуй болгох, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх замаар ирээдүй хойч үедээ эрүүл, баялаг ойн сан бүхий байгаль орчныг өвлүүлэн үлдээх эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор уг хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийн зардлын тооцооны тайланд дурдсанаар хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллага болон улсын төсөвт нийт 3.1 тэрбум төгрөгийн нэмэлт зардлыг үүсгэхээр байгаа боловч шинэчилсэн найруулгын энэхүү төсөл нь ойн нөөцийн хамгаалалт, тогтвортой ашиглалт, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж хууль санаачилж үзжээ.

Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодруулж, ойн цэвэрлэгээний ажлыг хийж байгаа эрх бүхий мэргэжлийн байгууллага гэрээний хугацаанд ойг бүрэн цэвэрлэж чадаагүй тохиолдолд үүсэх үр дагаврын талаар, ойн сан, дагалдах баялгийг сүйтгэсэн иргэдэд хариуцлага тооцох зохицуулалт туссан эсэх, Монгол Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан хуулийн төслийн 35 дугаар зүйлд ойн дагалт баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх агуулгын зохицуулалтад экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр хөрс, ус, давхаргыг гэмтээхгүй байх зохицуулалт тусгагдсан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад Монгол орны хуурай бүсийн экологийн тэнцвэрийг хадгалахад чухал үүрэгтэй говийн ойн сангийн талаарх зохицуулалтыг тусгах асуудалд анхаарах талаар хэлсэн болно.

Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 68.8 хувь нь дэмжсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ойн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, “Ойн хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ганбаатар гишүүнд баярлалаа.

Зочин танилцуулъя. Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө 20 жилийн ойг тэмдэглэж байгаа та бүхэндээ Улсын Их Хурал нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал хүсье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн танилцуулъя. Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бямбасүрэнгийн Оюунсанаа Ойн газрын дарга, Түвдэндоржийн Балжинням Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга, Дамдинжамцын Жагдаг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлогын зохистой

ашиглалтын газрын Ойн бодлого, хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч. Балганы Алтанцэцэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Стрийм” төслийн хуулийн бодлогын мэргэжилтэн. Ядамын Хишигт Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн зөвлөх.

Их Хуралд хүндэтгэлтэй хандаж, Их Хурлын гишүүдийн асуусан асуултад бүрэн гүйцэт, үнэн, зөв мэдээлэл өгөхийг та бүхэнд сануулж байна. Худал мэдээлэл өгөх, асуултад хариулахаас татгалзах, чуулганы хуралдаанд хүрэлцэн ирээгүй бол холбогдох хуулийн дагуу бас хариуцлага тооцохыг сануулъя.

Одоо төслийн үзэл баримтлал болон Байнгын хорооны санал, дүгнэлт хууль, санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Салдангийн Одонтуяа гишүүн асуултаа асууя.

С.Одонтуяа: Би бас энэ яамны сайдаар ажиллаж байхад нийт 16 хуулийн төслийг бас бид бэлдэж байсан. Тэрний нь бол энэ Ойн тухай хууль байгаа. Ер нь үзэл баримтлалын хувьд бол дэмжиж байгаа. Гэхдээ ажлын хэсэг байгуулаад энэ дээр бас хэд хэдэн зүйлийг засаж, залруулахгүй бол энэ сошиалаар бас иргэдийн болон мэргэжлийн байгууллагуудаас нэлээдгүй асуудлууд бас маргаан дагуулахаар ийм асуудал байгаа.

Энэ нэгдүгээрт энэ Ойн тухай хуулийн төсөлд анх энэ d.parliament дээр санал авч байхад энэ 6 төрөл байсан. Гэтэл энэ яг өргөн барихад үйлдвэр төрлийн зориулалтаар мод бэлтгэх, мөн ойн дагалт баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх гэснийг хассан байгаа юм. Тэгэхээр энэ ямар байгууллагаас энэ санал ирээд энийг хасчав гэдгийг та хэлж өгөөч. Мөн Зөвшөөрлийн тухай хуульд бүгд заасан гээд тэгж байгаа байх. Гэхдээ Зөвшөөрлийн тухай хуульд бол ямар ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгохоор зааснаас биш дотор нь нөгөө ямар ямар төрөл байхаар тусгаагүй байгаа юм. Тэгэхээр энэ 6 төрлийгөө оруулаад явсан бол маргаангүй байсан юм биш үү? Сүүлд би зүгээр энэ хуульчидтай зөвлөлөө л дөө. Энэ талаар маргаан гарахад Зөвшөөрлийн хууль, Ойн тухай хуулиар маргаан гарахад шийдэхэд жаахан хүндрэлтэй асуудлууд бол гарах гээд байгаа юм.

Нэг чухал зүйл юу вэ гэхлээр энэ энэ тусгай зөвшөөрлийг нь авахдаа Зөвшөөрлийн хуулиар заавал ойн дагалт баялгийг ашиглах ойн мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөл шаардаж байгаа юм. Тэгэхээр ийм төрлийн мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөлгүй болчихоор ойн баялгаа хамгаалах тогтолцоо нэг алхам ухарч байгаа юм биш үү?

Хоёр дахь асуудал юу вэ гэхээр энэ хушны самрын идээний гарц хаягдлыг тодорхой заалт ер нь оруулахгүй юм уу? Бидний үед баахан журмуудад Бат-Эрдэнэ гишүүн гаргаж байсан. Би гаргаж байсан. Тэгээд бүгдийг нь Засгийн газраас хүчингүй болгосон. Яагаад гэхээр хууль давсан журам гээд. Тэгэхээр энийгээ энэ хуульдаа оруулж, тодорхой болгож энэ чиглэлээр ажилладаг хүмүүсээ бас ингээд янз бүрийн эдийн засгийн энэ асуудалд оруулаад баймааргүй байна.

Гурав дахь асуудал юу вэ гэхээр хушин ойн нөхөн сэргээлтийг зөвхөн хушны тарьц суулгацаар хийдэг байхыг бас хуульчлах хэрэгтэй. Яагаад гэхээр одоо бол энэ хушин ой чинь хөгшрөөд 80 хувь нь хөгширчихсөн байхгүй юу. Гэтэл нөхөн сэргээлтийг нь зүгээр л арын хаалгаар ингээд дүйцүүлээд байгаа байхгүй юу. Энэ чинь болохгүй.

Тийм учраас энэ заалт ерөөсөө журамд хэрэгждэггүй учраас энийг хуульчлаад энэ самраа түүх гээд, хушин ойгоо яах гээд байгаа бол нөхөн сэргээлтийг нь заавал хушин тарьцаар хий гэдгийг хуульчилж өгөх ёстой байна. Энэ хэдэн асуултуудыг асуугаад тэгээд тодруулъя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа Одонтуяа гишүүнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар ажиллаж байсан. Ийм хэд хэдэн харилцаа байгаа юм. Өнөөгийн Ойн хууль, Зөвшөөрлийн хууль хоёр өөрсдөө нийцэл нь хангагдаагүй байгаа. Өөрөөр хэлбэл, таны дурдсан мэргэжлийн байгууллага гэдэг томъёоллоор аливаа үйл нэг ажиллагааны чиглэлийг тодорхой болгож өгөөгүй байгаа юм. Нэгдүгээрт. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 буюу байгаль орчны салбарт олгож байгаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцаа зохицуулагдаж байгаа. Сошиалд гэж хэлсэн. Сошиалд бол өнөөдөр бүүр зөвшөөрөлгүй болгох гээд байна гэж явуулаад байгаа тийм зүйл бол албан ёсоор байхгүй гэдгийг мэдэгдье.

Хоёрдугаарт өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ойн тухай хууль 7.1-ээр ойн тооллого, ой зохион байгуулалтын ажлыг ойн мэргэжлийн байгууллага гүйцэтгэхээр, 17.3.5-аар ой хээрийн түймрийн гаралт, хөнөөлт шавж, өвчний тархалт болон ойн баялгийн судалгааг хийхийг ойн мэргэжлийн байгууллагаар 17.3.5-аар, арчилгаа болон цэвэрлэгээг 28.1-ээр ойн мэргэжлийн байгууллага хийхээр, 32.4-өөр ойг нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг хийхээр ойн мэргэжлийн байгууллага хийхээр хуульчилж өгсөн.

Өөрөөр хэлбэл, 1.11 буюу Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1-ийн тусгай зөвшөөрлийн 1.11 дээр ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа хэлбэр дээр явж байгаа. Зөвшөөрөл энд авагдаж байгаа. Энийг бид нар шинэчилсэн найруулга дээр ойлгомжтой болгож өгөхийн тулд түрүүний миний хэлсэнчлэн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг тодорхойлоогүй алдааг засаж, 49.2 буюу ойн мэргэжлийн үйл ажиллагаа дараах төрөлтэй байна.

49.2.1.Ой зохион байгуулалт, ой тооллого хийх, 49.2.2.Ойжуулах, ойг нөхөн сэргээх.

49.2.3.Ойн хөнөөлт организмын судалгаа хийх, тэдгээртэй тэмцэх.

49.2.4.Ойн төлөв байдлыг сайжруулах гэж оруулж өгсөн. Энийг 6 болгох буюу таны хэлсэн нөгөө саяын ойн дагалт баялгийн нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, мод бэлтгэхтэй холбоотой харилцааг оруулж байгаа. Энэ өөрөө хуулийн зөрчил.

Өөрөөр хэлбэл, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1-ээр олгогдож байгаа зөвшөөрлийн 1.29 дээр ойн дагалт баялгийн нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, 1.30 дээр ойгоос мод бэлтгэх эрхийг заавал тусгай зөвшөөрөлтэй харилцаанд зоож өгсөн.

Тэгэхээр мэргэжлийн байгууллагын эрхээ 1.11-ээр авч байгаа боловч заавал хэрвээ ойн дагалдах баялгийн нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах юм бол дахиад заавал тусгай зөвшөөрөл авах ёстой. Мод бэлтгэх эрхээ авахын тулд заавал дахиад тусгай зөвшөөрөл авах ёстой. Гэтэл энийг журамласан харилцаагаар буюу саяын таны хэлсэн 4 дээр нэмэх нь 6 болгоод нэг харилцаанд оруулаад мэргэжлийн байгууллага гээд өгчихөөр энэ өөрөө маш том хэмжээний зөрчил үүсгэж байгаа юм.

Мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа гэдэг бол ерөөсөө өгөх буюу ойгоо яаж нөхөн сэргээх юм, яаж үржүүлэх юм, яаж ойжуул.../минут дуусав./

С.Бямбацогт: Тодруулъя. Одонтуюа гишүүн.

С.Одонтуюа: Тэгэхээр би таны саяын хэлсэн тайлбарыг нэг нэгэнгүй сонсоод эндээс бол бас ойлгохгүй юм зөндөө байгаа байхгүй юу. Тэгэхээр иргэд энийг ойлгох уу? Тэгэхээр хууль өөрөө иргэдэд маш ойлгомжтой байх ёстой байхгүй юу. Тэрнээс яг энэ Ойн тухай хуульдаа бүүр нэг бүрчлэн заагаад дараа нь дагалдах хууль чинь Зөвшөөрлийн, Зөрчлийн хууль гэж би ойлгож байгаа байхгүй юу. Ойн тухай хууль дээрээ л ойлгомжтой бүгдийг нь заачихмаар байна.

Тэгэхгүй ингээд байх, тэрэнд байгаа, энэнд байгаа гээд байхаар чинь иргэдэд хууль ойлгомжгүй болохоор л нөгөө маргаан гарна.

Хоёрдугаарт би энэ уулийн үзэл баримтлалыг бас нэлээд танилцлаа. Бас тэр гаднын хуулиудыг судлаад ашиглалт тал руугаа маш их зүйл ингээд оруулж өгч байгаа байхгүй юу. Гэтэл манай улсын бид зүгээр хүмүүсээ яаж байгаа юм биш ер нь ухамсар, бид нар энэ ойгоо ингээд ашиглах, тэр мод тайрах ингээд л янз янзын юман дээр бас хэт ингээд задгай тавиад хэтэрхий ашиглалт тал.../минут дуусав./

С.Бямбацогт: Бат-Эрдэнэ гишүүн хариулъя. Ашиглалт их тавьж байгаа чинь зөв үү, цаг нь болсон уу гэж байна.

Б.Бат-Эрдэнэ: Одонтуюа сайд өөрөө өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиа их сайн харах хэрэгтэй. Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Зөвшөөрлийн хууль дээр тусгасан харилцаа буюу энэ мэргэжлийн байгууллага миний хэлээд байгаа мод бэлтгэх, энэ байгалийн ойн дагалт баялгийн нөөцийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах харилцааг тусад нь хуульчилж өгсөн. 3 өөр зөвшөөрөл. Энэ 3 өөр тусгай зөвшөөрлийг зөвхөн мэргэжлийн байгууллагад олгох буюу нэг субъектив байдлаар нэг хэсэг рүү олгох харилцааг хуульд оруулж болохгүй.

Хоёрдугаарт Ойн тухай хууль бол ойтой холбоотой харилцааг зохицуулах ёстой хууль болохоос биш зөвшөөрлийн, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зөвшөөрлийн харилцаа бүгдээрээ Зөвшөөрлийн тухай хуулиар

зохицуулагдаж байгаа. Энэ зөвшөөрлийн хуулиас нэг хэсэг зөвшөөрлийг нь Ойн тухай хуулиар зохицуулчихаар хэлбэр рүү шилжүүлчихвэл энэ өөрөө бас болохгүй. Бид нар энд гол оруулж өгсөн асуудал бол замбараагүй байсныг нь энд тэнд оруулж өгсөн.

С.Бямбацогт: Баярлалаа. Зочин танилцуулъя. Өвөрхангай аймгийн Уянга сумын 1 дүгээр сургуулийн 96 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ төгсөлтийнхөө баярыг сайхан тэмдэглээрэй гэж хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл гишүүн Өвөрхангай гэсэн гүйгээд ороод ирж байна шүү. Мэндчилэхэд их дургүй хүн шүү дээ уул нь.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн алга байна. Чинбатын Ундрам гишүүн алга байна. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя.

Ц.Баатархүү: Монгол улсын энэ цөлжилтийг буцаах, бэлчээрийн доройтлыг бууруулах, нийт нутаг дэвсгэрийг ингээд ногоон болгох бүхий л үйл ажиллагааг Улсын Их Хурал бол дэмждэг. Дэмжих ёстой. Гэхдээ энэ хууль дээр нэг зүйл ойлгомжгүй байна. Ойгоо хамгаалъя, ойн баялгаа ашиглая гээд бүх зүйлийг Зөвшөөрлийн хууль руу оруулж байгаа чинь Ойн хууль гэсэн малгай хууль дээр чинь маш буруу ойлгомжгүй ийм харилцаа үүсэх юм биш үү? Одонтуяа гишүүний хэлээд байгаа болгоомжлолтой би санал нэг байна. Учир юу юм бэ гэхээр энэ дээр чинь ямар асуудал үүсэх вэ гэхээр хуш модны самрыг ямар ч зөвшөөрөлгүй дур дураараа ингээд ашиглаад хэрэглээд байх боломж бололцоо нээчихсэн юм шиг харагдаж байна. Тэгэхээр малгайн хууль дээрээ хариуцлагын ойг хамгаалах энэ заалтуудаа оруулж өгөхгүй бол зөвхөн ойг баялаг гэж үзээд ашиглах тухай эрхүүдийг нь нээж өгсөн ийм хууль болчихоод байна.

Тэгэхээр Монгол Улсад өдрөөс өдөрт, хоногоос хоногт багасаж байгаа ой модоо, түүний баялгийг зөв эргэлтэд оруулж ашиглах бол туйлын чухал байна. Энэ дээр маш тодорхой хариулт өгөөч ээ.

Хоёрдугаарт нь нэг зүйл энд дутуу байна. Ойн энэ сав газар амьдарч байгаа амьтан, энэ амьтны нүүх, шилжих, ус уух энэ цэгүүдийн экологийн коридорыг гаргаж өгөх тухай заалт энд бас байхгүй байна. Мэдээж энэ Мал, амьтны хууль бусад хуулиуд дээр тусаж байгаа байх. Гэхдээ малгайн хууль дээр ч энэ байхгүй байна. Улаанбаатар хотыг тойрсон, хот суурин газрыг тойрсон ойн амтай, энэ бүх амнуудыг хашдаг. Мал, амьтан ус уухдаа ингээд энэ хашаанд нь шорлогдож янз бүрийн байдлаар эрсэддэг. Бид нар байгаль дэлхийгээ хайрлая гэвэл энэ заалт чинь байхгүй байна гэдгийг дахин хэлье.

Гуравдугаар асуух асуулт бол иргэд, иргэдийн оролцоотойгоор мод тарьж ургуулбал тэрийг ямар баялаг хөрөнгө гэж үзэх юм бэ? Мод тарьж ургуулаад байгаа иргэд олон түмнээ яаж дэмжиж энэ оролцоог нь хангах юм бэ гэдэг ийм 3 асуултад хариулж өгөөч.

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Хууль дээр ямар ч заалт тэгж чөлөөтэй орхисон заалт байхгүй. Сошиал мэдээллээр яваад байна гэдгийг би дахиад хэлье. Зөвшөөрлийн тухай хуультай харилцааг огт хөндөөгүй. Өөрөөр хэлбэл, өнөөдөр Зөвшөөрлийн тухай хууль дээр байгаа 1.11, 1.29, 1.30 гэдэг заалт огт хөндөгдөөгүй. Тэр утга агуулгаараа хуш модны самар ч гэсэн бүгдээрээ тусгай зөвшөөрөлтэй хэлбэр дээрээ байгаа. Хэлбэр дээрээ байгаа. Зөвшөөрлийнхөө харилцаагаар шийдэгдэнэ.

Харин дагалт баялгийн дунд, урт ургацын, дунд ургацын жилд зөвхөн ахуйн зориулалтаар их ургацын жилд нь аль ч зориулалтаар ашиглахыг зөвшөөрнө гэдэг ч юм уу ийм тодорхой дэглэм, зохицуулалтын харилцааг л бид нар оруулж өгч байгаа юм. Өөр юм бол байхгүй. Яг зөвшөөрөлтэй харилцаа зөвшөөрөлтэйгөөрөө явж байгаа гэдгийг би хэлье.

Иргэдэд бид нар нээж өгч байгаа. Нэг ёсондоо нээж ч юу байх вэ илүү хялбар болгож өгч байгаа. Өөрөөр хэлбэл, гоожин гээд аваад байдаг сум руу давхидаг зүйлийг болиулж цахимжуулж байгаа. Тээвэрлэлт хийж явж байгаад гэмт хэрэгт холбогддог байсан бол цахим систем дээр нь тээвэрлэлтийг нь бүтэн оруулж өгдөг чеклэчихдэг харилцааг нь бид нар хийж өгч байгаа.

Дээрээс нь бид нар ойжуулалтын санг бий болгож өгч байгаа. Ойжуулалтын сан буюу таны саяын хэлдэг дэмжлэг гэдэг зүйл маш хэрэгтэй байгаа. Тэгвэл бид нар ойн баялаг, нөөц ашигласны төлбөр, олон улсын хөтөлбөр, төсөл, буцалтгүй тусламж, хандив, экологийн үйлчилгээний орлого, ойн дагалд учирсан хохирлын нөхөн төлбөр, хуульд заасан бусад эх үүсвэрүүдээс оруулаад эндээсээ тодорхой хэмжээний дэмжлэгийг иргэд болон аж ахуйн нэгж таримал ой бий болгох асуудал дээр хийж өгч байгаа юм.

Дээрээс нь хүлэмжийн зах зээл. Дөнгөж сая бид нар Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг хэлэлцсэн. Тэгвэл бид нар таримал ой бий болгож байгаа иргэн, аж ахуйн нэгж хэн ч бай тухайн ой дээр нь орж ирэх хүлэмжийн энэ зах зээлээс орж ирэх мөнгөн дүнг нь бид нар баталгаажуулж оруулж өгөх бүх боломжийг бол хуулиар нь бүрэн дүүрэн нээж өгч байгаа гэдгийг би хэлмээр байна.

Амьтан болон экологийн коридортой холбоотой асуудал дээр бол ойн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль гэх мэтчилнээр хуулийн зохицуулалтууд бол хангалттай яг өнөөдрийн түвшин дээр бол нээлттэй байгаа. Тусгай хамгаалалтын хууль дээр бол бид нар тусгайлсан зүйлийг бол оруулж өгч байгаа, заалтыг бол оруулж өгч байгаа.

Ойн хууль дээр бол аливаа хаалт байхгүй. Харин хамгаалалтын, ашиглалтын, тусгай зориулалтын ойн гэж ангилал үүсгээд энэ дотроо тодорхой хэмжээний ялангуяа хамгаалалтын буюу таны хэлдэг зэрлэг амьтан өөрөө амьдардаг хэсэг дээр бид нар илүү хамгаалалтын зарчмыг барьж, тэнд хүний гар хүрэхээргүй байдалтайгаар зөвхөн ойн анги очиж мэргэжлийн үйл ажиллагаа явуулах түвшинд нь л тодорхой зөвшөөрлүүдийг олгох харилцааг бол бид нар оруулж өгч байгаа юм.

Тэгэхээр амьтан, зэрлэг амьтан маань бол ойдоо ямар ч асуудалгүй бол амьдарч экологийн коридор гэж таны нэрлэсэн буюу аливаа асуудал бол үүсэхээргүй түвшиндээ бол.../минут дуусав./

С.Бямбацогт: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Өдрийн мэнд хүргэе. Хамгаалалтаас зохистой ашиглалт, эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлийн агуулгыг бол дэмжиж байгаа. Бид нар ерөнхий агуулгынхаа хүрээнд бол нэлээн нээе, хуучин бол ойгоо хамгаалах тухай концепцтой байсан бол одоо бол илүү бас зүй зохистойгоор ашиглая гэдэг ийм агуулга руу орж байна гэж бас анх ойлгож байгаа.

Гэхдээ бас бид нар нээж байгаа бол хяналтаа хэрхэн тавих вэ, яаж эндээс урьдчилан сэргийлэх вэ гэдэг талын юмнууд дээрээ бас нэлээн анхаарал хандуулах ёстой агуулгууд бас гишүүд маань бас хэлээд байна. Энэ үүднээсээ бас хэд хэдэн зүйлүүдийг бас дахиад нэмээд тодруулъя.

Ойн дагалдах баялгийг ашиглах, хамгаалахтай холбогдолтой асуудал дээр тэр яг мэргэжлийн бус байгууллагад л тийм боломжийг л өгөх гээд байгаа юм шиг зохицуулалт 49.2 энэ тэр гээд хэд хэдэн заалтуудыг харахаар бас байгаад л байна л даа. Тэгээд энийг бол их тийм ойлгомжтойгоор бас жоохон томьёолж өгөхгүй бол бас болохгүй асуудлууд бас байна.

Хоёрт нь энэ дуудлага худалдаатай холбогдолтой зохицуулалт байгаа. Тийм дагалдах баялгийг дуулдаг худалдаагаар бас байгаль орчны сайдын баталсан журмын дагуу дуудлага худалдааг зохион байгуулаад нээлттэй ил тод явуулдаг байсныг энэ болиулж байгаа агуулга бас харагдаад байх шиг байна. Тэгэхээр энэ дээр та хэд маань бас энэ бол бас жоохон ухарсан алхам бас болох эрсдэлтэй шүү гэдгийг хэлье.

Үйлдвэрийн зориулалтаар бэлтгэхээс бусад дээр ер нь тусгай зөвшөөрөлгүй болох гээд байна л гээд байна шүү дээ тээ. Энийг бас нэлээн дэлгэрүүлээд бас та хэд маань дахиад хариулаач ээ. Энгийн ойгоос мод болон дагалдах, бэлтгэх хамгаалалтын бүс, хамгаалалтын бүс дотроо бас тодорхой дэглэмүүд байгаа. Тэр дэглэмүүд дээр нь хэрхэн бас тийм ялгамжтай байдлаар зохицуулалтууд хийж байгаа вэ гэдгийг бас тодруулъя. Бас хэтэрхий бас хамгаалалтын бүс рүүгээ бас орох, чөлөөлөх ийм зохицуулалтууд бас яваад байх вий гэдэг ийм бас асуултууд байна.

Хяналт дээр хуучин бол Засгийн газар болон Байгаль орчны яам үндсэндээ хяналт хийдэг байсан бол нэмээд ер нь 4 төрлийн хяналт руу орж ирж байх шиг байна. Нэг талдаа бол энэ бол зөв гэж харж байгаа.

Нөгөө талаасаа нөгөө дундаа хийх вий энийг яаж ер нь нарийвчлан зохицуулах вэ гэдэг дээр бас тодорхой заалтууд нь ямар байгаа вэ гэдгийг бас тодолдоо тодруулъя. Ингээд бид нар ашиглалтыг нэлээн нэмээд өгнө. Орлогууд бас нэлээн орж ирнэ. Орлогыг нөхөн сэргээлт болон зүй зохистой ашиглах тал дээр бас тодорхой зохицуулалтууд яаж орж байгаа вэ гэдгийг бас нэлээн дэлгэрэнгүй хэлээд өгөх нь зөв байх.

Сая жишээ нь гэх юм бол хуш модны самрыг авсан орлогыг хуш мод тариалахад зориулъя энэ тэр гээд бас ийм зөв, тодорхой бас ийм шийдлүүд бас байна. Тэгэхээр энийг ерөнхийдөө дотор нь задлаад энэ ямар хэмжээний орлого юмнууд бас нэмэгдэх вэ, түүнийг өөр зүйлд бас зарцуулахгүй байх талаас нь буцаад яг байгальд нь зориулах талаас нь бас ямар зохицуулалтууд байна вэ гээд асуултуудыг асууя.

С.Бямбацогт: Бат-Эрдэнэ гишүүн хариулъя хууль санаачлагч.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Зөвшөөрлийн хуультай холбоотой харилцааг бид нар ерөөсөө хөндөөгүй. Зөвшөөрлийн хуулиараа л байгаа. Тэнд дуудлага худалдаа байвал тэнд дуудлага худалдаагаараа л байгаа гэсэн үг. Бид нар харин хуулийн 31.5-аараа ойн баялгийн ашиглах нөөцийг тогтоохтой холбоотой журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж байгаа.

Нөгөөдөх нь нөгөө миний түрүүний хэлдэг ургацын жилээсээ хамаараад тодорхой хэмжээний ахуйн хэрэглээндээ ашиглах уу, эсвэл ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах уу гэдэг хэлбэрийг тухайн үед нь шийдвэрлэх, тэр нь өөрөө Байгаль орчны яам буюу сайдын бүрэн эрх мэдэл дээр байгаа. Тийм учраас ерөөсөө энэ ой дээр тийм айхтар нээгээд байгаа бодлого байхгүй. Зөвшөөрлийн хуультай холбоотой харилцаа тэр чигээрээ бүрэн дүүрэн хадгалагдаж байгаа гэдгийг би дахиад хэлье. Ашиглалтын бүсийн ойтой холбоотой асуудал байгаа. Ашиглалтын бүсийн ойд ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэж байгаа.

Бид нар сумын ойн менежментийн төлөвлөгөө, аймгийн ойн менежментийн төлөвлөгөө, улсын ойн менежментийн төлөвлөгөөтэй болоод ойн менежментийн төлөвлөгөө дээр тухайлбал аль хэсэг нь ойжуулах ёстой юм, аль нь залуу юм, аль нь насжилттай юм, аль нь ой хөнөөлт организм болон ой хээрийн түймэрт өртчихсөн, болсон мөртөө хатсан юм, аль нь унаа ихтэй юм, аль нь ахуйн хэрэглээнд авч болох юм гэдгийг ойн менежментийн төлөвлөгөө дээр нь тулгуурлаад бид нар гаргачхаж байгаа юм. Тэр бүрэн эрх нь бол хүчин төгөлдөр хууль дээрээ мөрдөгдөөд явж байгаа.

Ашиглалтын бүсийн ой гэдэг хэлбэр дээр бол бид нар ашиглалтын бүсийн ой дээр бол мод бэлтгэх, ойн дагалт баялаг, түүх, бэлтгэх, экологийн боловсрол олгох, байгалийн аялал жуулчлал явуулах, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх, ялгарлыг бууруулах, төсөл хэрэгжүүлэх, ойн зам, дэд бүтцийг төлөвлөх, байгуулах, ашиглах, био эдийн засгийн үйл ажиллагааг эрхлэх, хуульд заасан бусад гэж оруулж ирж байгаа. Хуулийн төслийн 10.2 дээр.

Өнөөдөр бид нар хожуулууд байна, унаанганууд байна. Ойн хөнөөлт организм болон ойрын төмөрт өртчихсөн мөртөө ашиглаж чадахгүй хэсгүүд байгаа. Тэгвэл энийг аваад тэр модон эдлэл, бүтээгдэхүүнээ хийдэг болъё гэж байгаа юм. Хөвсгөл аймгийн Жаргалант сум гэхэд хогийн цэгийнх нь бараг 60 хувь нь модны үртэс байгаа. Хаягдаж байгаа юм. Тэр хогийн цэгийнх нь 60 хувь нь модны үртэснээс бүрдэж байгаа юм. Тэгвэл энийг аваад бид нар эдийн засгийн эргэлтэд оруулах ёстой. Энийг хийж чадвал бид нар энэ хуулиар явж байгаа харилцааг бид нар өнөөдөр батлаад явуулж чадах юм бол ойн салбар маань

жилдээ 1 их наяд орчим төгрөгийн орлого олдог ийм эдийн засгийн эргэлттэй болдог, болох боломжтой ийм салбар байгаа юм гэдгийг би хэлэх гэж байгаа юм.

Иргэдтэй холбоотой харилцаа буюу хэтэрхий нээж байна гэдэг нь иргэд дээр яригдаад байх шиг байна. Бид нар хот айл болон нөхөрлөлтэй холбоотой асуудлуудыг хөндөж байгаа юм. Яг өнөөдөр ний нуугүй хэлэхэд иргэд маань өөрөө арынхаа ойг очоод сүйтгээд байдаг харилцаа маш бага. Харин ч бүүр байгаль хамгаалал буюу нөгөө хэн ой руу орж байна, юу хийж байна, ойн хээрийн түймэр тавьчих вий, яагаад удаад байна гэдэг ч юм уу энэ харилцаан дээр иргэд маань илүү их хяналтыг тавьж бараг байгаль хамгаалагчийн чиг үүргийг гүйцэтгэдэг. Нөгөө талдаа иргэд дээр бид нар.../минут дуусав./

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Хэнтий аймгийн Дархан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө ойг тэмдэглэж байгаа, Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа гишүүдийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Бадарчийн Хэрлэн гишүүн асуултаа асууя. Ганхүлэг гишүүн тодруулъя гэнэ.

М.Ганхүлэг: Тийм ерөнхий асуулт нь ер нь ил тод болгох, цахимжуулах, хяналт тавих гэдэг дээр та бас дахиад нэлээд дэлгэрэнгүй хэлчихсэн нь дээр байх. Энэ чиглэлийн харилцаа юмнууд бас нэлээн цаашдаа нөгөө нарийн зохицуулахгүй бол маргаанууд бас үргэлжилсээр байна. Иргэдийн бас мод бэлтгэхтэй холбогдолтой асуудал дээр нэлээн уян хатан зохицуулалт орж ирж байна гэж ойлгож байгаа. Нэлээн олон бас манай бүсээр ярихад бол бас Хэнтий аймгийн Дорнод аймгийн бас хойд бүсийн иргэд бол самар янз янзын чиглэлээр бас нэлээн бизнес эрхлээд ингээд явдаг. Маш олон иргэд бас эрүүгийн гэмт хэрэгт бас холбогдчихсон ийм асуудлууд бас байгаа.

Тэгэхээр энэнтэй холбогдолтой бас илүү уян хатан болгох, иргэдийн бас эдийн засгийн тэр боломжийг нь бас аль түвшинд харах вэ гэдэг дээр бид нар анхаарал хандуулах ёстой.

Нөгөө талаасаа ил тод болгох нөгөө тэр дуудлага худалдаа энэ тэр юмнууд бол байгаа гэж ойлголоо. Мөн энэ дуудлага худалдаатай адилхан нээлттэйгээр олгох хэн нэгэн хүнээс хамааралгүй байх энэ зөвшөөрөл юмнуудыг бас олгох чиглэлийн зохицуулалтаа бас илүү дэлгэрүүл.../минут дуусав./

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дуудлага худалдаатай холбоотой харилцаа бол Зөвшөөрлийн тухай хууль дээрээ байгаа. Зөвшөөрлийн тухай хуулиар тус дуудлага худалдаатай холбоотой харилцааг зохицуулсан учраас бид нар хөндөөгүй хяналт тавихтай холбоотой харилцаан дээр ойн ашиглалт, нөхөн сэргээлт, ойн төлөв байдлыг сайжруулах ойжуулалтын үйл ажиллагаанд хяналтыг байнга тавьж байгаа.

Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэлэлцэх, санал өгөх, хэрэгжилт дээр нь бид нар хяналтыг тавихаар хуульчилж өгсөн. Ойн модны

нөөцийг ашиглах, талбайн зураглал гаргах, ашиглалтад хяналт тавих арга хэмжээг хэрэгжүүлэх бодит зардлуудтай холбоотой харилцааг оруулж өгсөн. Ойжуулалтын сангийн зохион байгуулалт, сангийн хөрөнгийг зохицуулах, түүнд хяналт тавих журамтай холбоотой харилцааг зохицуулж өгсөн гэх мэтчилэн тухайн холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэгч нарт тодорхой хэмжээний хяналтын чиг үүргүүдийн хариуцуулж өгсөн.

Цахимжсан хэлбэр дээр аль болох цахижуулж байгаа. Ил тод нээлттэй болгож байгаа. Иргэд цахим хэлбэрээр гоожингоо авдаг болж байгаа гэсэн үг. Тэр дотор нь тодорхой харилцааг нь зоогоод ор.../минут дуусав./

С.Бямбацогт: Бадарчийн Хэрлэн гишүүн асуултаа асууя.

Б.Хэрлэн: Тэгэхээр Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулаад 4 чиглэлийн асуулт байна.

Нэгдүгээрх нь 12 дугаар зүйл буюу ойн сан бүхий газрыг хариуцан хамгаалах тухай. Энэтэй холбогдуулж асууя.

Баг, хорооны иргэдийн нийтийн хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга гэрээний дагуу хот айл, нөхөрлөлд 10-н жилээр хариуцуулж болно гэж байгаа. Энэ хот айл, нөхөрлөл нь босоо, хатсан модыг цэвэрлэх, дагалт баялгийг түүх, ахуйн зориулалтаар мод бэлтгэх ийм ажлуудыг хийнэ. Тэгээд дээр нь ойн сангийн нүүрстөрөгчийн кредитийг ашиглан зах зээлд оролцож болно. Бүүр цаашилбал 48.4-т нь аялал жуулчлал эрхлэх, нэмэгдсэн өртөг шингээсэн, боловсруулах, үйлдвэр эрхлэхийг энд эрх олгосон байгаа юм.

Энэ дээрээ миний асуулт юу гэхээр Үндсэн хуулийн 6.1-д иргэдэд өмчлүүлснээс бусад газрын ой, усны нөөц энэ бол төрийн нийтийн өмч байх ийм үндсэн заалт байдаг. Тэгэхээр энэ заалтыг арай зөрчиж байгаа биш байгаа даа? Энэ хот айл, нөхөрлөл чинь тухайн ойн сан баялгийг, дагах баялгийг ашиглах давуу эрх эдлээд явчхаж байна уу үгүй юу? Энэ дээр тодруулаад өгөхгүй юу.

Хоёрдугаарх нь энэ хот айл, нөхөрлөл гэдэг маань ойн менежментэд ер нь яг ямар үүрэг, оролцоотой оролцож байгаа юм бэ? Сумын ойн менежменттэй хэрхэн, яаж холбогдож байгаа юм бэ? Энийг хоёрдугаарт нь.

Гуравт нь ер нь энэ хот айл, нөхөрлөл үүргээ биелүүлээгүй бол хэн, ямар хариуцлага хүлээлгэх юм? Эд нар яг ямар үүрэг хүлээх юм? Ерөнхийдөө энэ 12 дугаар зүйл бол ойн сан бүхий газрыг хариуцан хамгаалах гэхээсээ илүүтэйгээр ашиглах тухай зохицуулалт ороод ирчихсэн байгаа байхгүй юу.

Хоёр дахь чиглэл нь юу вэ гэхлээр энэ хамгаалалтын бүсийн ойд Архангай аймгийн Жаргалант сумын ой хамаардаг гэсэн. Тэгэхээр энэ хуулийн төслийн 9.4-д хамгаалалтын бүсийн ойд үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэхийг хориглоно гэсэн байна. Тэгэхээр өнөөдөр Жаргалант сумын 2 хөрөө рамыг буулгана гэсэн үг үү энэ хэрвээ энэ батлагдчих юм бол энийг тодруулъя.

Гурав дахь нь Архангай аймгийн Жаргалант сумын иргэдийн санал, хүсэлтийг бол би дамжуулж байгаа юм. Тэгэхээр Жаргалант сумын иргэд ер нь бол эмээл, гэрийн мод, тавилга хийдгээрээ бол улс орондоо нэртэй ийм хүмүүс байдаг. Ер нь төл модыг бол ер нь түлээнд хэрэглэхээс гадна бас үйлдвэрлэлийн түүхий эд болгож хэрэглэдэг ийм хүмүүс. Тэгээд тэд нар тэгж байна л даа. Нэг өрх жилдээ ахуйн хэрэглээнд зориулна 24 куб метр мод бэлтгэх эрхтэй байдаг. Тэгэхээр энэ 24 кубийн ядаж тал хувийг нь хуурай босоо мод, унанги болгож өөрчлөх ийм боломж байгаа юу? Тэндээс бас яг үйлдвэрлэлд хэрэглээд ингээд явчихаар мод байх юм бол тэрүүгээрээ нөгөө эмээлээ хийх гэж байх шиг байна л даа. Тэгэхээр ийм зүйлийг асуусан энийг дамжуулъя.

Дөрөв дэх чиглэлийн асуулт. Таримал ой, ой сангийн байгалиараа байгаа ойг нөхөн сэргээх, доройтлоос хамгаалах энэ үүргийг жаахан ялгаатайгаар энэ хуульд зохицуулаад оруулаад ирсэн байна. Тэгэхээр 24.3-д нь таримал ойг өмчлөгч өөрийн хөрөнгөөр энэ нөхөн сэргээх, доройтлоос хамгаалах үйл ажиллагааг эрхэлнэ гээд. 20.8-д нь болохоор сумын ойн санд хамаарах ойг орон нутгийн төсвийн хөрөнгөөр энийг нөхөн сэргээх, доройтлоос хамгаалах ажлыг зохицуулна гээд. Ингээд ийм хоёр ялгаатайгаар зохицуулалт ороод ирсэн байна л даа.

Тэгэхээр энэ дөрөв дэх чиглэлийн асуулт маань ялангуяа энэ таримал мод таримал ойг сэргээх, хамгаалах тухай асуудал энэ Тэрбум модны хүрээнд энэ чинь төрийн болоод түмний олон хүний хүч, хөдөлмөрөөр ийм таримал ойнууд бий болж байгаа. Тэгэхээр энийг хамгаалах, энийг тэтгэх тухай асуудал зөвхөн эзэмшигчийнх нь хариуцах үүрэг, өмч хөрөнгөөрөө хариуцах үүрэг болгоод ингээд зохицуулчхаж байгаа нь бас ямар учиртай юм бол гэдгийг тодруулъя. Би энэ 4 чиглэлийн асуулт нийтдээ бол би 7 асуултдаа хариулт авъя.

С.Бямбацогт: Ажлын хэсгээс хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Я.Хишигт: Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Хот айл гэрээгээр ойн санг хариуцах асуудал Үндсэн хууль зөрчиж байгаа юм уу гэдэг энэ асуултад хариулъя. Тэгэхээр Үндсэн хууль дээр бол Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад бүх газар бүгд төрийн өмч. Тэгэхээр төр өөрийнхөө өмчлөгчийнхөө хувьд өөрөө хэнд гэрээгээр юуг ашиглуулах вэ, ямар хугацаатай ашиглуулах вэ гэдэг асуудлаа өөрөө шийдэж байгаа. Тэгэхээр гэрээгээр ашиглана гэдэг бол өөрийн эзэмшилдээ байгаад харж хамгаална гэдэг энэ утгаараа байгаа. Энэ бол өмчлөлд шилжиж байгаа асуудал биш. Харин эзэнтэй болж, тэрийг харж хамгаалж, хэн, хаана, яаж ойг сүйтгэх гэж байна. Тэрийг харж хамгаалж байгаа. Тэр нь тэр харж хамгаалсан учраас тодорхой ойн ангидаа цахимаар мэдэгдээд тэр ойн дагалт баялгийг ашиглах ийм боломжийг нээж өгч байгаа юм.

Хоёр дахь асуудал бол таримал ойн асуудал ярьж байна. Таримал ойг бол нэгдүгээрт Монгол улсын иргэн өөрийн өмчлөлийн газар дээрээ таримал ой тарьж болно. Ингэх юм бол өөрийнхөө өмчөөр өөрийнхөө өмчийн газар дээр тарьсан модоо өөрөө арчилна гэсэн үг.

Хоёр дахь асуудал бол эзэмшлийн асуудал. Одоо Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль дээр ч байгаа. Ер нь бол төрийн өмчийн бүх газрыг мэдээж Улсын Их Хурал энд байгаа бүх газар нутаг дээр очиж чадахгүй.

Тэгэхээр байгаа тэр засаг захиргааны нэгж, тэр байгууллага өөрийн эзэмшилдээ эзэн нь болоод тэрийгээ хэндээ, яаж, хэзээ гэрээгээр эзэмшүүлэх бэ гэдэг асуудлаа шийднэ. Ийм учраас энэ бол төрийн өмчийг яг захиран, төрийн нийтийн зориулалттай өмч ой бол. Тэгэхээр энийг яаж, хэнд, яаж өгч хамгаалуулж, эзэмшүүлж, хараа хяналтад нь байлгах бэ гэдэг ийм асуудал байгаа юм. Нөгөө асуудал нь манай мэргэжлийн байгууллагынхан хариулах байх.

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулъя. Хэн хариулах бэ? Ажлын хэсэг 4.

Б.Оюунсанаа: Оюунсанаа Ойн газрын дарга. Хэрлэн гишүүний асуултад нэмж хариулъя. Архангайн Жаргаланттай холбоотой тусгай зориулалтын уламжлалт бүтээгдэхүүн хийдэг аймаг, бүс, сумууд байгаа. Эдгээрт бол мөн адилхан хуулийн үйлчлэл, хөрөө рамтай холбоотой энэ зохицуулалтууд бол мэдээж ашиглалттай холбоотой ороод явж байгаа. Ойн анги болоод ойн ангиас тухайн түлээ, түлшийг бэлтгэх тохиолдолд, эсвэл өвөлжөө, хаваржааны зориулалттай шургааг бэлтгэх тохиолдолд тодорхой газрыг заана. Хэдийн хэмжээний, хэдэн ширхэг, хэдэн шоо метр бэлтгэх бүх заалтууд бол тодорхой тусгагдсан байгаа. Тэгж байж бэлдэнэ. Түүнээс биш тийшээгээ зөвшөөрөл авангуутаа шууд ороод их хэмжээгээр авах тийм зүйл байхгүй. Тэдгээрийг хэрхэн авах тухай нарийн зохицуулалтуудыг нь оруулсан байгаа.

С.Бямбацогт: Тодруулъя.

Б.Хэрлэн: 4 асуулт дутуу байна.

С.Бямбацогт: Тодруулъя. Хариултаа мэдэхгүй байх шиг байна шүү дээ.Тодруулаад асуучих та.

Б.Хэрлэн: Би асуултаа давтаж хэлж өгөх үү.

С.Бямбацогт: 4.

Б.Оюунсанаа: Ойн менежментийн төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэх тал дээр хариулъя.

Сумын, аймгийн, улсын ойн менежментийн төлөвлөгөө гэсэн гурван түвшний ойн менежментийн төлөвлөгөө байгаа. Сумын ойн менежментийн төлөвлөгөөндөө болохоор тухайн бүс нутагт байгаа бүхий л модны нөөцийг зүйлээр нь нарийвчлан гаргасан байдаг. Үүнтэй бол уялдаж байгаа гэж ойлгож болно. Дөрөвдүгээр асуулт.

С.Бямбацогт: Хэн билээ өөрөө?

Б.Оюунсанаа: Оюунсанаа Ойн газрын дарга.

С.Бямбацогт: Оюунсанаа Ойн газрын дарга. Хариулт хангалттай юу? Хангалтгүй байна гээд байна шүү дээ та.

Б.Оюунсанаа: Би гол нь юу яачихлаа.

С.Бямбацогт: Бичгээр гүйцээгээд хариулчхаарай. Бичгээр авчихъя. Хэрлэн гишүүн тодруулаад хэлчих асуултаа. Хэрлэн гишүүнд микрофон өгье.

Б.Хэрлэн: Би 4 чиглэлийн 7-н асуулт асуулт асууснаас 2 асуултдаа тойм дөхүүлсэн хариулт авлаа. Тэгэхээр энэ асуултуудыг би бичгээр та бүхэнд хүргүүлье. Хариултыг бас би бичгээр авъя.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүдийн асуусан асуулт бүх зүйл та бүхэнд хангалттай сайн мэдээлэл өгөх ёстой шүү. Тэр үүрэгтэйгээ бас ойлгож ажиллаарай. Тэгээд бичгээр хариулт авахаар боллоо.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хууль төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай гишүүд үг хэлнэ.

Ирүүлсэн нэрс байхгүй. Үг байхгүй дууслаа. Үг хэлж дууслаа. Санал хураалтыг нэгтгээд 16 цагийн санал хураалтуудтай хамт явуулна. Дараагийн асуудалдаа оръё.

15.25 цаг.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

3.Мэндсайхан: Монгол Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ,

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэн боловсруулж, “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг төслийн хамт та бүхэнд танилцуулж байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсөв, орон нутгийн төсөв, Үндэсний баялгийн сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийг хамрууллаа.

Монгол улсын эдийн засаг 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ 89.9 их наяд төгрөгт хүрч, эдийн засгийн өсөлт 6.8 хувьтай, инфляцын түвшин оны эцэст 7.5 хувь, гадаад худалдааны нийт эргэлт 27.1 тэрбум ам.долларт хүрсэн бол гадаад худалдааны тэнцэл 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 30 их наяд 303.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 33.7 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31 их наяд 331 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 34.8 хувь тус тус хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 27.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь ДНБ-ний 1.1 хувьтай тэнцэж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан төсвийн тусгай шаардлагыг нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл дараах байдлаар хангаж байна. Үүнд:

1.Нэгдсэн төсвийн орлого 33 их наяд 179.2 тэрбум төгрөг. Үүнээс гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг тэнцвэржүүлсэн жураар тооцож, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого нийт 30 их наяд 303.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, Ирээдүйн өв санд 1 их наяд 710.6 тэрбум төгрөг, хуримтлалын сан 603 тэрбум төгрөг, тогтворжилтын сан 562.5 тэрбум төгрөг тус тус хуваарилсан нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.1-д заасан нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх төсвийн тусгай шаардлагыг хангасан.

2.Нэгдсэн төсвийн урсгал зардал 2025 онд 24 их наяд 237.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 26.9 хувьд хүрсэн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-д заасан урсгал зардал нь ДНБ-ний 30 хувиас хэтрэхгүй байх тусгай шаардлагыг хангасан.

3.Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 35 их наяд 407.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 39.4 хувьд хүрсэн нь Төсвийн тогтвортой байдлын хуулийн 6.1.4-т заасан Засгийн өөрийн үлдэгдэл нь ДНБ-ний 60 хувиар хэтрэхгүй байх тусгай шаардлагыг хангасан.

4.Нэгдсэн төсвийн 2022 онын суурь тэнцэл 1 их наяд 113.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 1.2 хувьтай тэнцэх ашигтай гарсан нь 2025 онын төсвийн жилээс шинээр хэрэгжүүлж буй Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухай жилийн ДНБ-ний 2 буюу түүнээс дээш хувийн ашигтай байх тусгай шаардлагатай нийцээгүй.

Төсвийн тухай хуулийн 57.2 дахь хэсэгт орон нутгийн төсвийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн Төсвийн хуульд нийцүүлэн алдагдалгүй төлөвлөн баталж хэрэгжүүлнэ гэж зохицуулсан боловч мөн хуулийн 57.3 дахь хэсэгт орон нутгийн төсвийн урд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна гэсэн одоогийн хууль, эрх зүйн зохицуулалт нь төсвийн суурь тэнцлийн тусгай шаардлагыг хангахад сөргөөр нөлөөлж байна.

Тайлант онд улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 18 их наяд 988 тэрбум төгрөгт хүрч, 95.9 хувийн биелэлттэй өмнөх оныхоо гүйцэтгэлээс 1 их наяд 180.2 тэрбум төгрөгөөр буюу 5.5 хувиар буурсан бол нийт зарлага, цэвэр зээлийн дүн 20 их наяд 414.3 тэрбум төгрөг буюу 90.5 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оныд 613 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд 2 их наяд 135.4 тэрбум төгрөгийн буюу 73 хувийн санхүүжилтийг,

гадаадын зээл, тусламжийн хүрээнд 116 төсөл, арга хэмжээнд 1 их наяд 874.9 тэрбум төгрөг буюу 96 хувийн санхүүжилтийг нийт 729 төсөл, арга хэмжээнд 4 их наяд 10.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, энэ хүрээнд 1800 орчим аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж ажилласнаар 110 мянган ажлын байрыг хэвээр хадгалж, улсын хэмжээнд 490 төсөл, барилга байгууламж ашиглалтад орууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд гүйцэтгэлээр бүрэн санхүүжүүлэх зарчим баримталсан. Харин 2025 онд ажил хийгдсэн боловч төсвийн орлогын биелэлттэй уялдуулж санхүүжилтийг нь бүрэн олгоогүй нийт 286 тэрбум төгрөгийн гүйцэтгүүлэх бүхий он дамжин үргэлжлэх төсөл, арга хэмжээг 2026 оны батлагдсан санхүүжилтээс олгоод байна.

Тайлант онд Монгол улсын зээлжих зэрэглэл нэмэгдэж, S&P агентлагаас B plus эерэг байсанг B ... тогтвортой түвшинд Moody's агентлагаас B2 байсанг B1 тогтвортой түвшинд хүргэж, Fitch агентлагаас B plus тогтвортой түвшинд хэвээр хадгалж, зээлийн эрсдэлийн үнэлгээг 1 шат ахиулсан байна. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.1, 8.10.2 дахь заалтад тус тус заасны дагуу нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг төрийн аудитын төв байгууллага хүргүүлж, аудит хийлгэн улсын төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын хэмжээг баталгаажуулсан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Мэндсайхан сайдад баярлалаа. Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар төрийн аудитын дээд байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн талаар хураангуйлан танилцуулъя.

1.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хуулийн дагуу аудитыг гүйцэтгэж, Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 30 их наяд 303.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 31 их наяд 331 тэрбум төгрөгөөр баталгаажууллаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 5.5 хувиар өссөн, тайлант онд төлөвлөснөөс 937.6 тэрбум төгрөгөөр

тасарсан боловч, Үндэсний баялгийн санд 2 их наяд 313.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөснөөс 357.4 тэрбум төгрөгөөр давуулсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31 их наяд 331 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 2.4 хувиар өссөн нь улсын төсвийн урсгал зардал 4.6 хувиар, орон нутгийн төсвийн урсгал зардал 12.7 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1 их наяд 27 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ/дотоодын нийт бүтгэгдэхүүн/-ний 1.1 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаарт багтаж байгаа боловч төсвийн суурь тэнцэл 1 их наяд 113.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.2 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасан тусгай шаардлагыг хангахгүй байна.

Засгийн газрын өрийн нэрлэсэн үнээр илэрхийлсэн үлдэгдэл 35 их наяд 407.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 39.4 хувьтай тэнцэж байгаа нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан хязгаарт багтаж байгаа боловч нийт өрийн үлдэгдлийн 95.7 хувийг гадаад валютаар илэрхийлсэн өр эзэлж байгаа нь стратегийн баримт бичигт тогтоосон 80 хувийн зорилтот түвшнээс давсан үзүүлэлттэй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хүрээнд зарим төрлийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг үнэлэх зорилгоор төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоо хуульд оролцоотой хуулийн этгээдүүдээс түүврийн аргаар тоон болон чанарын мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийхэд салбарын бодлогын хэрэгжилтэд оруулах гүйцэтгэлийн гол үзүүлэлт тодорхойлогдоогүй, хүрсэн түвшин, гаргасан зардлын үр өгөөж, гүйцэтгэсэн ажлын өртөг тооцох тогтолцоо байхгүйгээс төсвийг зарцуулахдаа арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах соёл төлөвшихгүй төсөв тэлэх байдал ажиглагдаж байна.

Төсөв захирагчдын шилэн дансны хөтлөлт 94.2 хувь Харин улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллагын төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа хуулийн этгээдүүд мэдээллийг ил тод, бүрэн байршуулаагүй, гүйцэтгэл хангалтгүй байна.

Улс төрийн намуудад олгосон төрийн санхүүжилтийн зарцуулалтын зардлын ангилал, шалгуур үзүүлэлт тодорхойгүй, хууль, журмын заалт уялдаагүй хяналт шалгалт хийх чиг үүрэг давхардаж байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах нэгдсэн дүгнэлтийг хийлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлсэн 611 төсөл, арга хэмжээний 80 хувь буюу 6 их наяд 981.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 415 төсөл нь боловсрол, зам тээвэр, хот байгуулалт, эрүүл мэнд, эрчим хүч гэсэн тэргүүлэх 5 чиглэлд төвлөрсөн нь суурь дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэжээ.

2.Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын тухайн жилийн санхүүжилтийн гүйцэтгэлд 72.9 хувь, тухайн онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт 75.1 хувьтай байгаа бөгөөд барилга байгууламжийн 2 ажил тутмын 1 нь ТЭЗҮ/техник, эдийн засгийн үндэслэл/ зураг төсөл боловсруулах 5 ажил тутмын 4 нь тухайн онд хэрэгжиж дуусаагүй дараагийн онд шилжсэн байна.

3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт өртгийн 80 хувийг эзэлж байгаа голлох 5 салбарын төсвийн ерөнхийлөн захирагчдын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зорилт арга хэмжээг төлөвлөсөн шалгуур үзүүлэлтээр авч үзэхэд дунджаар 77.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

4.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд 23 сургууль ашиглалтад орж, суралцагчийн суудлын тоо 10.6 мянгаар, 20 цэцэрлэг ашиглалтад орж хамрагдах хүүхдийн тоо 3 мянгаар, 2 дотуур байр ашиглалтад орж, орны тоо 280-аар, соёлын төв, театрын 8 барилга баригдаж, суудлын тоо 2.3 мянгаар, 10 эмнэлгийн барилга ашиглалтад орсноор эмчлүүлэгчдийн орны тоо 154-өөр тус тус нэмэгдсэн байна.

Мөн инженерийн дэд бүтцийн 36, дэд станц болон цахилгаан хангамжийг сайжруулах 30 байгууламж ашиглалтад орж хатуу хучилттай авто зам 330.3км-ээр, гүүрний хүчин чадал 282 урт метрээр тус тус нэмэгдсэн зэрэг нийгмийн үйлчилгээ болон суурь дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэл тодорхой ахиц гарчээ.

Аудитаар дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай байна гэж үзлээ.

1.Барилга байгууламжид ашигласан материалаас ялгарах хорт бодисын агууламж хүлцэх хэмжээнд байгаа эсэхийг хянах, бүртгэх, баталгаажуулах тогтолцоо бүрдээгүй, 2025 онд ашиглалтад хүлээн авсан 13 сургууль, цэцэрлэгийг түүвэрлэн дотоод орчны агаарт шинжилгээ хийхэд 8 барилгад формальдегид болон бензолийн агууламж хүлцэх хэмжээнээс өндөр байгаа нь суралцагчдын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.

Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж байгаа хүн ам, нийгмийн барилга, байгууламжийн чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартыг чанд мөрдүүлэх, энэхүү асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

2.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, ашиглалтад хүлээн авах, хөрөнгөд бүртгэх үе шат бүрд захиалагч, хяналт хэрэгжүүлэгч, хэлээн авах комисс зэрэг холбогдох байгууллага, албан тушаалтны хяналт, хариуцлага сул байгаагаас шалтгаалан зураг төсөл, техникийн тодорхойлолт ажлын даалгаврын дагуу хэрэгжихгүй байх, хугацаа хоцрох, дутуу гээгдэх, чанар, стандартын шаардлагад нийцээгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх, байнгын ашиглалтад хүлээн авах, бүртгэл хийхгүй байх зэрэг алдаа, дутагдал буурахгүй байгааг таслан зогсоох, арилгахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг төрийн байгууллагын шат шатад авч хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж үзлээ.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн тайлангийн аудитаар Улсын Их Хуралд 3-н асуудлыг толилуулж, Ерөнхий сайдад 5, Шадар сайдад 1, Сангийн сайдад 9, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 4, Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайдад 1, Зам, тээврийн сайдад 1, бусад ерөнхийлөн захирагчид 4 зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

Эдгээр зөвлөмжүүд нь төсвийн үр ашгийг дээшлүүлэх, гадаад зээлийн ашиглалт, үр нөлөөг сайжруулах, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн шаардлагыг хангуулж, эдийн засгийн ангиллыг мөрдөх, худалдан авах ажиллагааг хууль журамд нь нийцүүлж, барилга байгууламжийн чанар, ашиглагдаж буй материалд эрүүл ахуйн стандартын шаардлага тавих хяналтын тогтолцоог сайжруулах зэрэг асуудал чиглэгдлээ.

2. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын талаар.

Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Нийгмийн болон Эрүүл мэндийн даатгалын сан, төсвийн ерөнхийлөн захирагчдын 60 санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэдгээрийн харьяа байгууллагуудын нийт 6792 санхүүгийн тайланг аудитад хамрууллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар өөрчлөлтгүй 32, хязгаарлалттай 28 дүгнэлт өгсөн бөгөөд Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Тус аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 6, Сангийн сайдад 2, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад 1, бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарт 2 зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагаас өмнөх жилүүдэд Засгийн газар бүх шатын төсвийн захирагч нарт өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтагдан гарч байгаа тул Улсын Их Хурлаас аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд дараах асуудлаар Засгийн газарт чиглэл хүргүүлж, төсвийн сахилга батыг дээшлүүлэх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төсвийн хүрээний мэдэгдэл дагуулан өөрчлөлт оруулдаг зөрчил давтагдан гарсан нь төсвийн бодлого тогтвортой хэрэгжихгүй байх эрсдэл үүсгэж, төсвийн гүйцэтгэл, хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бүрэн чиглээгүй, нийгэм эдийн засагт үзүүлэх ач холбогдлыг бууруулж байна.

2. Түүхий эдийн мөчлөг сөрсөн төсвийн тэлэлтийг хязгаарласан орлогын бүтцийг тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлэхгүйгээр экспортын биет хэмжээнд найдсан төсвийн төлөлт хийсээр байгаа нь нийлүүлэлтээс шалтгаалсан түүхий эдийн үнэ буурах, төсвийн орлого хуваарийн дагуу бүрдэхгүй байх эрсдэлтэй байна.

3.Ирээдүйн өв сангийн корпорац байгуулах, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх олгосон мандатыг боловсруулж, түүхий эдийн мөчлөгийн үед бий болсон орлогыг хуримтлуулах замаар төсвийн тэлэлтийг хязгаарлах бодлого хэрэгжүүлэх орон зайг бий болгох, гадаад валютын нөөцийг тогтворжуулах бодлого баримтлах.

4.Төсвийн орлого тасарсан, тайлант онд хэрэгжсэн зарим хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгоогүйгээс дараа оны төсөвт ачаалал үүсгэж, төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

5.Орон нутгийн төсвийн орлого өмнөх оноос 7.2 хувиар, зарлага 12.6 хувиар нэмэгдсэн нь орлогын өсөлтөөс давсан зарлагыг хязгаарлаж, санхүүгийн сахилга батыг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

6.Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт төсвийн төлөвлөлтийг үр дүнд чиглүүлэхээр зохицуулсан боловч, тухайн жилийн Төсвийн тухай хуулиар хөтөлбөр, арга хэмжээг зардалтай уялдуулан батлаагүй, суурь түвшин, шалгуур үзүүлэлт, хүрэх дүнг оновчтой тодорхойлоогүй, хэмжигдэхүйц бус төлөвлөснөөс хэрэгжилтийг үнэлэх үр дүнд суурилсан төлөвлөлтөд шилжих боломжийг хязгаарлаж байна.

7.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, бүртгэх үр дүн.../минут дуусав./

С.Бямбацогт: Индрийн микрофон цаг сунгая.

С.Магнайсүрэн: Үе шат бүр төсвийн Ерөнхийлөн захирагч болон оролцогч байгууллага, албан тушаалтнуудын хяналт, хариуцлага сул, хамтын ажиллагаа хангалтгүй байгаа нь үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

8.Гадаад дамжуулан зээлээс олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй, тооцоо нийлж баталгаажаагүй авлагын асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу үе шаттай шийдвэрлэх шаардлагатай байна.

Дээрх дүгнэлтээс үзвэл төсвийн хөрөнгө, төрийн өмчийн санхүүгийн удирдлагыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэхэд аудитын зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, хариуцлага тооцох тогтолцоонд дүн шинжилгээ хийж, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлангийн талаар товчлон танилцууллаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Магнайсүрэн даргад баярлалаа. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлтийн талаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Жамсрандоржийн Дэлгэрсайхан танилцуулан. Таныг индэрт урьж байна.

Ж.Дэлгэрсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16^{1.5.3}-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн 20205 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн дүгнэлтийг танилцуулж байна.

Юуны өмнө 25 он дахь эдийн засаг болон төсвийн хүрээнд гарсан эерэг өөрчлөлтүүдийг дурдъя. 2025 онд Монгол Улсын Макро эдийн засгийн үзүүлэлт эерэг гарсан. Эдийн засгийн бодит өсөлт оны гүйцэтгэлээр 6.8 хувьд хүрч, төлөвлөсөн 5.5 хувиас 1.3 хувиар давсан байна. Гадаад секторт ахиц гарч, гадаад худалдааны тэнцэлд 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарч, гадаа валютын нөөц 7 тэрбум ам.долларт хүрлээ.

Эдгээр үзүүлэлтүүдийг үндэслэн S&P агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг В, В- түвшинд хүргэж, төлбөрийг тогтвортой болгож ахиулсан төсөв, санхүүгийн тогтвортой байдлын эерэг нөлөөллийг харуулж байгаа үзүүлэлт юм.

Мөн баялгийн сангуудын орлого төлөвлөгдсөнөөс давсан нь бодлогын зарим арга хэмжээг оновчтой хэрэгжүүлсэнтэй холбоотой байна гэж Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс үзлээ.

Энэ нь 2025 оны төсвийн хүрээнд гарсан томоохон эерэг өөрчлөлт юм. Үндэсний баялгийн сангийн тухай, Ирээдүйн өв санд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 1 их наяд 394.1 тэрбум, гүйцэтгэл 1 их наяд 710.6 тэрбум, хуримтлалын сангийн орлогын төлөвлөгөө 562.1 тэрбум төгрөг байсан бол гүйцэтгэл 603 тэрбум төгрөг буюу 118 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь эрдэс баялгийн арилжааг уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нээлттэй хийдэг болсноор далд эдийн засаг хумигдаж, борлуулалтын үнэлгээ өссөн. Төрийн өмчит компаниудын зарим үр ашиггүй зардлыг танаж, засаглалыг сайжруулсантай холбоотой гэж үзэж байна.

Гэсэн хэдий ч эдгээр эдийн засгийн эерэг үзүүлэлт, баялгийн сангийн эерэг өөрчлөлт байгаа боловч төсвийн гүйцэтгэлийн хувьд эдгээр нь тусгалаа олж чадаагүй бөгөөд анхаарах олон асуудлууд байгааг Төсвийн зөвлөлийн зүгээс онцолж байна. Үүнд:

Нэгдүгээрт төсвийн төлөвлөлт гүйцэтгэлийн зөрүү нэмэгдэж байна. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр орлого 97.3 хувь, татварын орлого 93.1 хувь, нийт зарлага 88.6 хувь, урсгал зарлага 93.3 хувь, хөрөнгийн зарлага 72.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь зардлын үзүүлэлтүүдийн хувьд сүүлийн 11 жилийн дээд үзүүлэлт болж байна.

Ялангуяа хөрөнгийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүү нэмэгдэж байгааг анхаарах шаардлагатай. Төсвийн зардал тэлэхийн хэрээр төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүү хувь нэмэгдэж байгаа байдал, үүнд орон нутгийн төсвийн үзүүлэх нөлөөлөл нэмэгдэж байгаа нь төсвийн гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой бөгөөд цаашид сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Төсвийн төлөвлөлтийн алдаанд төсвийн тодотгол хийх нөхцөл болж байна. 2025 онд төсвийн тодотгол хийж 1.8 их наяд төгрөгийн зарлага, 3.1 их наяд

төгрөгийн орлогыг бууруулж төлөвлөсөн боловч төсөв алдагдалтай гарч, төсвийн зарим тусгай шаардлагыг хангахгүй байгаа нь төсвийн тодотгол хийсэн ч төсвийн үр дүн эерэг гарахгүй байгаа нөхцөл байдлыг илэрхийлж байна. 3.Баялгийн сангууд.

3.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.4-д заасан 4 тусгай шаардлагаас 1 нь биелэгдээгүй байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасан төсвийн тусгай шаардлага хангагдахгүй байна. Уг заалтад төсвийн тэнцвэржүүлсэн суурь тэнцэл 1 их наяд 113.9 тэрбум төгрөгийн ашигтай байгаа нь ДНБ-ний 1.2 хувийг эзэлж байгаа бөгөөд 2 хувь байх ёстой гэсэн тусгай шаардлагад хүрэхгүй байгаа юм.

4.Макро эдийн засгийн өсөлттэй холбоотой сорилт байсаар байна. Эдийн засгийн өсөлт, татварын орлого нэг салбараас хамраалтай байгаа нь төсвийн орлогын тасалдалд хүргэж, төсвийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байна.

5.Төсвийн мөчлөг дагасан бодлого, төсвийн гүйцэтгэл дэх макро эдийн засгийн эрсдэлд нөлөөлөхийг нэмэгдүүлж байна. Төсвийн мөчлөг дагасан бодлого нь макро эдийн засгийн өсөлт хүртээмжтэй бус нэг салбараас хамаарал өндөртэй үед төсвийн гүйцэтгэлийн чанарыг сулруулах нэг үндсэн хүчин зүйл болж байна. Үүнээс шалтгаалж төсвийн орлого тасалдах, төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл буурах зэрэг сөрөг үр дагаврууд гарах эрсдэлтэй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтэд онцгой анхаарах шаардлагатай байна. Хөрөнгө оруулалтын зардал нь төсвийн хэмнэлт, алдагдал бууруулах, тусгай шаардлагыг хангах, удирдлагын гол хэрэгсэл болон өөрчлөгдөж байгааг төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцад анхаарах шаардлагатай байна.

Төсвийн төлөвлөлт муу, орлогын тасалдал өндөртэй үед хөрөнгө оруулалтыг хойшлуулах, хэмнэлт үүсэх байдлаар төсвийн тусгай шаардлага тэнцлийн үзүүлэлтүүдийг сайжруулах хандлага гарч байгааг өөрчилж сайжруулах шаардлагатай байна.

7.Орон нутгийн төсөв, төсвийн нэгдсэн төсөвт үзүүлэх нөлөөлөл нэмэгдэж байгаад холбогдох талууд дүгнэлт хийх шаардлагатай байна. Орон нутгийн төсвийн зарлага, хөрөнгө оруулалт, төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүү, алдагдал гэсэн үзүүлэлтийн зарим нь улсын төсвөөс давж, нэгдсэн төсөвт бодлогын томоохон нөлөөтэй болсон тул тухайн төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулахад анхаарах шаардлага нэгэнт бий болжээ.

8.Нэгдсэн төсвийн хүрээнд гүйцэтгэлийн үнэлгээний чанарыг сайжруулах, нийгэм эдийн засгийн үр нөлөөг, үр дүнг тооцох гарцаагүй шаардлага бий болсон байна. Төсвийн гүйцэтгэлийг ерөнхийлөн захирагчид төсөл, арга хэмжээний үр дүнгээр хэмжиж байгаа боловч, аргачлал, хэмжүүр, гүйцэтгэл нь тодорхой бус, нийгэм эдийн засагт гаргасан эерэг нөлөөлөл ойлгомжгүй байна.

Мөн нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Монгол улсын нийгэм эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллийн нэгдсэн хэмжүүр байхгүй байгааг анхаарч, энэ хэмжээний мөнгийг зарцуулсны үр дүн нийгэм эдийн засагт хэрхэн гарч байгааг тодорхой болгох шаардлага зайлшгүй байна.

9.Тайлагналын хангалтгүй байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт сул, санхүүжилтийн болон үр дүнгийн уялдаа хангалтгүй, ахиц дэвшил болон бодит үр дүнг тайланд тодорхой тусгадаггүй, байгууллагын мэдээлэл, зөрүүтэй байдал нь олон нийтийн хяналт, оролцооны боломжийг хязгаарлаж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дээрх анхаарах асуудал байгааг дурдахын зэрэгцээ цаашид төсвийн гүйцэтгэлийг сайжруулахтай холбоотой макро эдийн засгийн зөв бодлого баримталж, төрийн зардлыг бууруулж, төрийн оролцоог бууруулах чиглэлд тууштай ажиллах, төсвийн мөчлөг сөрсөн бодлогыг тууштай хэрэгжүүлж, төсвийн эрсдэлийг бууруулах, мөн Улсын Их Хурлаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмжүүдийг хүргүүлсэн бөгөөд төсвийн гүйцэтгэлтийг сайжруулахтай холбоотой бодлогын томоохон өөрчлөлтийг хийх шаардлагатай гэж үзэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан даргад баярлалаа. Одоо ажлын хэсгийн бүрэлдэхүүн танилцуулна. Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын шадар сайд, Баттөмөрийн Энхбаяр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга. Энэ байхгүй сайд нарыг Энхбаяр сайд дуудаарай. Хоёр Энхбаяр сайд аа. Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Дамбын Батлут Батлан хамгаалахын сайд, Цэндийн Сандаг-Очир Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Боловсролын сайд, Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Жуковын Алдаржавхлан Соёл, спорт, аялал жуулчлалын сайд, Энхтайваны Бат-Амгалан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Цагаанхүүгийн Идэрбат Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Чинбатын Номин Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Бадрахын Найдалаа Эрчим хүчний сайд, Энхбаярын Батшугар Эрүүл мэндийн сайд, Лхагвын Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, Сономдовчингийн Энхтөр Шүүхийн сахилгын хорооны дарга, Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Даваанямын Даваа-Очир Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Батмөнхийн Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Дугарын Сүнжид Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Гаваасүрэнгийн Азжаргал Авлигатай тэмцэх газрын дэд дарга алга байна. Дуудаарай. Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд бас алга байна. Батаагийн Батцэцэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Ганбаатарын Билгүүн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Содномцэрэнгийн Заяадэлгэр Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга, Батдэмбэрэлийн Эрдэнэтулга Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Цэрэнжавын Одхүү Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга, Равсалын Ринчинбазар Төсвийн

тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн.

Дотор багтахгүй аль зааланд байгаа юм? Зааланд байгаа юм уу? Аль танхимд байгаа юм? Энэ Үндсэн хууль танхимд, Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд багтахгүй учраас Үндсэн хууль танхимд бас зарим ажлын хэсэг байгаа юм байна шүү.

Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Дамдины Чулуунбат Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Даваажавын Гантуяа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Буянтогтохын Бундхорол Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, тэргүүлэх аудитор, Хоржавын Баярмаа Үндэсний аудитын газрын Бодлого төлөвлөлт, инновацын газрын дарга, Найдангийн Цэвэлмаа Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Буяндэлгэрийн Баттуяа Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Даваасамбуугийн Баярсайхан Үндэсний аудитын газрын Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Чимэдцэрэнгийн Цэвэгдорж Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газрын захирал, тэргүүлэх аудитор, Ганболдын Нандинжаргал Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лханаажавын Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бат-Ирээдүйн Анар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Баттулгын Батбямба Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Балдангомбын Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөрхуягийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бавуужавын Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Намжилын Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хөхөөгийн Отгонжаргал Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Санхүүгийн хэлтсийн дарга, Бэгзсүрэнгийн Мөнх-Оргил Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, Гомбожавын Ариунбуян Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Ханджавын Батжаргал Стандарт, хэмжил зүйн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Огнонгийн Хуягцогт Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Нарангийн Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Лхагвадоржийн Эрдэнэбадрах Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга.

Ингээд болчхож байгаа билүү? Их засаг танхимд бас биш ээ Үндсэн хууль билүү? Их засаг танхимд Бадарчийн Отгонцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны

Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга босоод байгаарай. Сонсогдож байна уу? Харагдаж байх шиг байна. Баярсайханы Нямдагва Гадаад харилцааны яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч. Гараа өргөөд байгаарай. Нямдагва байна уу? Мөнхтүшиг дарга байна уу? Танайхан хаа байна? Сайд чинь хааччихсан юм? Наад газрын дарга чинь хааччихсан юм? Насангийн Отгонбаяр Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Эрхэмбаярын Гансүх Батлан хамгаалахын яамны Стратеги төлөвлөлтийн газрын дарга, Чамбасүрэнгийн Чулуунчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Аюурзанын Мөнх-Оргил Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Жамбалын Энхтөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсандонхойгийн Баянзул Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Төмөрбаатарын Сумьяа Зам, тээврийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цэен-Ойдовын Ариунсанаа Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батцэцэгийн Уянга Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Содномцэрэнгийн Должинсүрэн Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лхагважавын Мөнхцэцэг Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Цэдэнбалын Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Батжаргалын Цогтнаран Татварын ерөнхий газрын дарга, Пүрэвээгийн Дэлгэрнаран Гаалийн ерөнхий газрын дарга, Басангийн Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Цэвээнжавын Батбаатар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Төмөрбаатарын Амартүвшин Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Намдагийн Ганбаатар Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хорооны дарга, Доржсүрэнгийн Мөнхзориг Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга, Сүхбаатарын Цогтгэрэл Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батсүхийн Бадамсэрээжид Хүний эрхийн Үндэсний Комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Чойжоогийн Гантөмөр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, Басангийн Алтанцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга, Цэнд-Аюушийн Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлого хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга. Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Ирээгүй сайд нарыг дуудаж ирүүлье Энхбаяр сайд аа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн танилцуулсан. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн, зөв, бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй.

Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн, зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.

Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд худал мэдээлэл өгсөн, мөн чуулганы хуралдааны дэгийн бусад заалтыг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг болохыг бас ажлын хэсгийн нийт гишүүдэд сануулъя. Тийм болохоор Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандаж, Улсын Их Хурлын гишүүдийн асуултад үнэн, зөв, бүрэн гүйцэд хариулахыг та бүхэнд бас анхааруулъя. Зочин танилцуулъя.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх илтгэл болон дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, төсвийн ерөнхий захирагч нар болон Монгол Улсын Ерөнхий аудитораас асуулт асууж, үг хэлэх Их Хурлын гишүүд нэрээ өгнө үүб

Хаана байна? Наранбаяр гишүүнээр тасалж байна уу? Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн тасаллаа.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургуулийн 12^б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордондоо танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа удахгүй сургуулиа төгсөж байгаа хүүхдүүддээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсье.

Отгонбаяр гишүүнийг нэмье. Эрдэнэбат гишүүнийг нэмье. Тасаллаа. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Энэ аудитын тайлангаа харахаар, энэ санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар харахаар төрийн өмчийн компаниудын үр дүн 2024 онтойгоо харьцуулахад 55 хувиар буурч, 3.7 их наяд төгрөг болсон байгаа юм. Бараг 2 дахин буурсан гэсэн үг тиймээ. Тэгээд энэ ингэж буурах болсон шалтгаан юу вэ? Бид нар одоо 2025 оны төлөвлөгөө төсвийг ярьж байхад төрийн өмчийн компаниудын ашиг хэд байна гэж төсөл төлөвлөсөн бэ, яагаад ингэж буурах болсон бэ гэдэг 1 дүгээр асуулт байгаад байгаа юм.

Дээрээс нь бид их сүүлийн үед их ярьж байгаа энэ манай төсөв бол ингээд 2, 3 хуваагдаад байна. Төрийн өмчийн компаниуд гээд тусдаа төсөвтэй. Монгол Улсын төсөв гээд бид Их Хурлаар батлаад байдаг орон нутгууд маань бас төсөв тодорхой хэмжээнд өмнөх жилүүдийнхээ гүйцэтгэлээр үндэслээд бас төсвийг хэтрүүлдэг ийм асуудал гараад төсөв маань ингээд 2, 3 хуваагдаад байгаа. Энэ дээр аудитын дүгнэлтээр бол 49 дүгээр хуудсан дээр төрийн өмчийн компаниудын яг үндсэн чиг үүрэгтэй нь хамааралгүй, нийгмийн шинжтэй үйл ажиллагаанд 1.1 их наяд төгрөг зарцуулсан байна гэж байгаа байхгүй юу. 1.1 их наяд төгрөг. Энэ одоо юу болж байна вэ гээд энэ дээр хариулт авмаар байна. Бид энэ төсвийг хэзээ нэгдсэн болгох юм бэ гэдэг асуулт.

Дараагаар нь бол энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн энэ дүгнэлт, зөвлөмж дээр орсон байна. Нэгдсэн төсөвт орон нутгийн төсвийн үзүүлэх нөлөөлөл нэмэгдэж байна. Энэ дээр ер нь цаашдаа анхаарахгүй бол болохоо болилоо гэдэг ийм утгатай. Тэгээд энэ талаар ер нь ямар арга хэмжээ авах шаардлагатай байгаа юм? Улсын Их Хурлаас ямар хууль дээр өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа юм бэ гэж асуултыг бол Сангийн сайдаас асуумаар байна.

Мөн энэ тайлан дээрээс харахаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 2025 онд 131.7 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлээгүй байна гэж байгаа юм. Яахаараа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Ирээдүйн өв санд төвлөрүүлдэггүй юм бэ? Яагаад ийм байдалд хүрч байна вэ гэдэг асуулт.

Дараагаар нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энэ Нийгмийн даатгалын сангийн арилжааны банкны харилцах дансанд байршиж байгаа мөнгө нь 1.1 их наяд төгрөг байгаад байгаа юм. Харилцах данс дээр. Харилцах данс дээр байршиж байгаа мөнгө бол маш бага хүүгийн орлого олж байгаа байх. Тэгээд яагаад ийм их хэмжээний мөнгө ингээд өндөр хүү олдог орлоготой байршихгүй харилцах данс дээр байршиж байна вэ? Эсвэл яг зөвхөн тухайн өдрийн байдлаар ингэж таарсан юм гээд нэг ийм асуулт байна.

Дээрээс нь энэ төрийн өмчийн компаниудын авлага, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн урьдчилж төлсөн авлага гэж байгаа юм. Бараг 470 тэрбум төгрөг байгаа. Энэ ингээд авлага байгаад байгаа юм. Урьдчилаад татвар нийгмийн даатгалаа төлсөн гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энийг нөгөө талдаа төсвийн орлого дээр яаж бүртгээд байна вэ гээд. Энийг Сангийн яамнаас асуумаар байна. Энд ийм асуултуудад хариу авъя.

С.Бямбацогт: Сангийн сайд Мэндсайхан хариулъя.

3.Мэндсайхан: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл алдагдахад нөлөөлж байгаа хүчин зүйлс ялт ч үгүй орон нутгийн төсөв байгаа. Тэгээд энэ бол Төсвийн тухай хууль дээр 2, 57.2, 57.3 2 дээр 2 ойлгомжгүй заалт байгаад байгаа юм. Юу вэ гэхээр зэрэг би жишээ болгоод ярихад өнгөрсөн оны Улсын Их Хурлаар баталсан улсын нэгдсэн төсөв дээр орон нутгийн орлогыг 6.9 их наядаар батлаад, зарлагын 6.9 их наяд буюу алдагдалгүй төсөв баталж хэрэгжүүлэх энэ төсвийн хязгаарыг нь тавиад өгчхөж байгаа юм. Иргэдийн хурал бол орлого талын 1.5 их наядаар нэмэгдүүлээд зардал талын 3.7 их наяд дээр. Ингээд энэ хоёрын алдагдал 2.2 буюу энэ улсын нэгдсэн төсөв дээр шууд алдагдал болж орж ирж байгаа. Энд гол юу нөлөөлөөд байна вэ гэхээр Төсвийн тухай хууль дээр орон нутгийн төсвийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээ тухайн жилийн хуульд нийцүүлэн алдагдалгүй төлөвлөж баталж хэрэгжүүлнэ гэдэг заалт нь байж байгаа юм.

Нөгөө талдаа юу гээд заагаад өгчихсөн гэхээр орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагын төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага санхүүжүүлэх эх үүсвэрээс хэтрэхгүй байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ өнгөрсөн онд санхүүжүүлээгүй үлдсэн тусгай дансанд авсан энэ хөрөнгө оруулалт нь ингээд цаашаагаа үргэлжлээд явчхаж байгаа юм. Энэ 2 заалтаас болоод төсвийн тэнцвэр алдагдахад нөлөөлж байгаа, одоо орон нутгийг Иргэдийн Хурлыг

буруутгах арга байхгүй өөрсдөө төсвийнхөө хязгаараар нэмэгдүүлээд явахад энэ 57.3-ыг үндэслээд явчхаад байгаа юм. Энэ төсвийн нэгдсэн төсвийн суурь тэнцэлд нөлөөлөөд байгаа юм.

Тэгэхээр энийг бол бид нар юу гэж байна гэхээр намар Улсын Их Хурал руу төсвийн, 27 оны төсвөө өргөн барихдаа энэ хуулийг өөрчлөлтийг хийж орж ирэхгүй бол энэ цаашдаа бид нар орон нутгийн төсвүүд дээрээ энэ төсвийн тогтвортой байдал, сахилга бат дээр бол өөрчлөлт хийж чадахгүй ийм орон нутгийн төсвөө хянахгүй байдал руу орох ийм асуудал үүсээд явж байна гэдэг нь эндээс харагдаж байгаа.

Татвар дээр бол урьдчилж авсан татварын орлогыг тухайн тайлант хугацаандаа аваад гүйцэтгэхлээрээ ногдлоос ногдлоо тооцоод суутгаад явж байгаа. Тийм учраас энэ дээр ямар урьдчилж аваад тэрийг дараа оны орлогоос урьдчилж авч байгаа ийм асуудал байхгүй.

Төрийн өмчит компаниудын асуудлаар Цэнгэл дарга хариулах уу?

С.Бямбацогт: Индрийн 3 дугаар микрофон Цэнгэл дарга хариулъя.

Б.Цэнгэл: 2025 онд бол төрийн өмчит компаниудын зардал, өр төлбөр бол өссөн ийм үзүүлэлттэй гарсан. 24 онд бол төрийн өмчийн 101 компани дээр бол 59 мянган хүн, 59678 хүн ажиллаж байсан бол 25 онд бол 54571 болж буурсан. Энэ бууралт нь бол төсвийн хэмнэлтийн бодлоготой холбогдуулаад 10 хүртэлх хувийн орон тоог бууруул гэдэг чиглэл өгсөнтэй холбоотой бол энэ бууралт бол гарч ирсэн.

Орлого бол 24 онтой бол харьцуулахад бол 24 онд бол 22.9 их наяд байсан бол 25 онд бол 25.3 их наядын орлого олж, нийт зардал бол өмнөх жил бол 18.2 их наяд байсан бол 25 онд бол 22.6 их наяд болж өссөн байж байгаа. Төсвийн өр төлбөрт бол.../минут дуусав./

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя.

Б.Цэнгэл: Төсвийн төлбөрт бол 5.5 их наядыг төвлөрүүлсэн. Ногдол ашиг бол багассан.Цэвэр ашиг бол 1.7 их наяд байж байгаа. Авлага 5.2 их наяд. Өр төлбөр бол 24.5 их наяд байна. Нийт төрийн өмчит компаниудын хөрөнгө бол 60 их наядад давж байна.

Хөрөнгийн өгөөжөө өмнөх жилээсээ буурсан үзүүлэлт гарсан. Ойролцоогоор 3 хувийн хөрөнгийн өгөөжтэй байж байна. Энэ дээр бол мэдээж гадаад, дотоод хүчин зүйлүүд бол их нөлөөлсөн. Зүгээр зөвхөн “МИАТ” компани дээр жишээ аваад ярихад бол 25 онд бол “МИАТ” компани 32 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан. Энэ бол дэлхий нийтэд үүсээд байгаа энэ нөхцөл байдлууд бол нөлөөлсөн. 26 он нөлөөлсөн байх жишээтэй. Баярлалаа.

С.Бямбацогт: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Тэгээд чөлөөт үлдэгдлээр манай салбар дээр зарим сангуудын чөлөөт үлдэгдэл заавал үлддэг. Манайхаас бол ашигтай байдаг салбар нь

аюулгүй ослоос авсан шимтгэл ашигтай гардаг. Үйлдвэрлэлийн ослын тэтгэмжээс бол заавал ашигтай гардаг. Урсгал тэтгэвэр буюу тэтгэмжийг санхүүжүүлэх эх үүсвэр заавал байх ёстой Соронзонболд гишүүн ээ. Ингэж байж нөгөө урсгал зардлуудаа бид нар авч үлдэж байж тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь асуудалгүй тавих бэлэн байдлыг хангах үүднээс 2-3 сарын нөөцийг бид нар заавал авч үлддэг.

Нэгдүгээрт саяын 700 орчим тэрбум төгрөгийг бид нар арилжааны 4 банкин дээр бодлогын хүүгээс доошгүйгээр байршуулах журамтай. Энэ 700 тэрбум төгрөгийн үлдэгдэл нь саяын үйлдвэрлэлийн ослын сангаас ашигтай ажилладаг учраас, ашигтай гардаг учраас энэ сан дээр үлдэгдэл байдаг. Үүнийгээ бид нар арилжааны банкууд дээр үлдэгдлийг нь бодлогын хүүгээс доошгүй байршуулаад 200 орчим тэрбум төгрөгийн хүүгийн орлогыг олдог гэсэн.

С.Бямбацогт: Соронзонболд гишүүн тодруулж асууя.

Л.Соронзонболд: Тэр юу гээд байна шүү дээ төрийн өмчийн компаниудын чиг үүрэгт хамаарахгүй 1.1 их наяд төгрөгийн нийгмийн шинж чанартай ажлуудад зарцуулсан байна гээд. Энэ чинь юу болж байна л гэж суугаад байгаа шүү дээ. Энэ дээр ямар арга хэмжээ авах гээд байгаа юм? Төрийн өмчийн компани бол 1.1 их наяд төгрөг.

С.Бямбацогт: Индрийн 3 дугаар микрофон Цэнгэл дарга.

Б.Цэнгэл: Бид энэ асуудлыг шийдэх зорилгоор бол Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн тухай хуулийг бол Их Хурал бол сая бас хэлэлцээд анхны хэлэлцүүлэг нь бол явж байна. Одоо санал хураалтад орох гэж байна. Тэгэхээр та бүхэн мэдэж байгаа.

Тухайлбал, Эрдэнэт хотын хотын амьдралыг бол тэр чигт нь үндсэндээ бол “Эрдэнэт” үйлдвэр бол нуруун дээрээ үүрч явж байгаа. Тэгэхээр энэ бол бас яг үндсэн чиг үүргүүд нь хамаарахгүй нийгмийн шинжтэй бол маш том ачаа орж ирдэг. Манай “МонРосцветмет” ч гэсэн бас бүхэл бүтэн суурин буюу тосгон хотыг бас авч явж байна. Хөтөлтийн цемент шохой бол Хөтөлтийн цементийн Хөтөлийн 10 мянга гаруй оршин суугчдын дулааны станцыг аваад явдаг. Энэ дээр жил бүхэн тухайлбал 3 гаруй тэрбум төгрөгийн алдагдал хүлээгээд явж байх жишээтэй. Дарханы төмөрлөг дээр ч гэсэн энэ бас үйл ажиллагаа бол бас давтагддаг. Энэ асуудлыг шийдэх асуудлыг бол удаа дараа тавьдаг боловч тухайн.../минут дуусав./

С.Бямбацогт: Гүйцээгээд асуултаа тодруулга хийе Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Тийм тэгэхээр харин “Эрдэнэт” үйлдвэр, “Эрдэнэс Тавантолгой” ч гэдэг юм уу олон компани төрийн өмчийн компаниудаар ингээд нийгмийн шатны ажлыг хийж байна. Тэгээд тэр нь болохоор бол тухайн орон нутгийнхаа төсөв дээр ороод тэгээд их хурлаар батлагдаад явах ёстой байхгүй юу. Тэгэхгүй 1.1 их наядыг тухайн төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл юм уу гүйцэтгэх удирдлагууд шууд шийдээд байна шүү дээ гээд байхгүй юу. Энэ чинь өөрөө болохгүй байна гээд 1 дүгээр асуудал.

Хоёрт болохоор бол Дамдинням сайдад хариулах юм уу хэн хариулах юм? Тэр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 130 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлээгүй байна өглөгтэй байна гээд байгаа шүү дээ. Энэ ямар учиртай юм бэ? Энийг тайлбарлаач.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Сангийн яам Хуягцогт 4 дүгээр микрофон индрийн.

О.Хуягцогт: Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Хуягцогт Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Ирээдүйн өв санд АМНАТ-ын орлогын биелэлттэй холбоотойгоор 12 сарын хуваарилалт нь бол дараа ондоо сар дамжин хуваарилагддагтай холбоотойгоор ийм өглөг үүссэн. 2025 оны оны эцсээр бол 243.5 тэрбум төгрөгийн өглөг үүссэн. Ингээд энэ дараа сардаа ингээд тооцоо нийлээд шилжих ийм зохицуулалттай байгаа.

С.Бямбацогт: Жоохон тодорхой хариулна шүү нөхөд өө. Тэгээд тодорхойгүй аман дотроо их хариулахгүй шүү. Ганбатын Очирбат гишүүн асуултаа асууя.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Ингээд 2025 оны төсвийн гүйцэтгэл 30 гаруй их наяд төгрөгийн асуудал яригдаж байна. Тэгээд Засгийн газар 2026 оны 06 сарын 17-ны өдөр буюу би бол энэ материалыг өчигдөр авсан. 1000 гаруй хуудас материал. Тэгээд хаашаа юм өчигдөр Их Хурал нэлээн орой тарсан. Бид нарыг 10 цаг уншаад өнөөдөр асуулт асуу гэж байгаа юм шиг ийм зохион байгуулалттай цаашаа ажилламааргүй байна Их Хурлын даргаа. Нэг.

Хоёрдугаарт 10 хэдхэн цагийн дотор энийг уншиж 4 асуулт бэлдлээ. Эхнийхийг нь асууя даа 4 асуулт. Энэ жил болгон ингээд энэ жилийн төсөв болон энэ төсвийн тодотгол яригддаг. Тэгээд энэ Төсвийн хүрээний тухай хуулиа байнга зөрчдөг. Засгийн газар энэ байдлаа юу гэж харж байгаа юм? Цаашдаа ер нь бид нар энэ дунд хугацааны төсвийн төлөвлөлтөө ер нь яах юм? Ингээд зүгээр ийм иргэдээ хуурсан маягтай тэгээд л хууль нь тийм гээд яваад байх юм уу энийгээ засаад залруулах юм уу? Нэг дэх асуулт энийг асуучихъя.

Хоёрдугаарт энэ нэгдсэн төсвийн суурь тэнцлийн тухайн жилийн ДНБ-ий 2 буюу түүнээс дээш хувийн ашигтай байх Төсвийн тусгай шаардлагын тухай хуультай. Засгийн газар шаардлага хангасан гээд байдаг. Үндэсний аудитын газрын шаардлага хангаагүй байна гэдэг. Энд ямар зөрчил гарчхав? Энийгээ Засгийн газар Үндэсний аудитын газар хоёр нь хариулчхаарай.

Гуравдугаарт их сонин тоо харчихлаа харин энэ 10 хэдэн цагийн дотор. Засгийн газар 2025 онд татвар төлөгч нараас төлөгчдөөс 1.2 их наяд төгрөгийн татварыг урьдчилан төлүүлсэн байх юм. Энэ ямар учиртай юм? Тодотгол 1 удаа орж ирсэн. Орж ирээгүй байж байж татвар төлөгч нараас яагаад 1.2 их наяд төгрөг урьдчилаад авчхав? Энэ дээр тодорхой хариулт авчихъя.

Тэгээд төрийн өмчит компани түрүүлээд татвараа төлчихсөн юм уу? Хувийн хэвшил нь төлчихсөн юм уу? Хэнд ямар компани төлсөн юм? Ямар хуулийн дагуу энийг түрүүлж авсан юм? Тэгээд 2026 оны төсөв тасалдвал яах юм? Энэ дээр маш тодорхой хариулт авна шүү.

Дараагийнх нь Засгийн газар энэ 2025 онд 9.1 их наяд төгрөгийн энэ ашиглаагүй зээлийн үлдэгдэлд 37.6 тэрбум төгрөгийн шимтгэл төлж байгаа юм. Тэгээд энэ ашиглаагүй зээлийг ер нь хэн хэзээ аваад ямар зориулалтаар авсан болоод одоо ингээд зүгээр ингээд хүүгийн төлбөрт 37.6 тэрбум төгрөг төлөөд байдаг юм бэ? Энэ хэнтэй ямар хариуцлага тооцох вэ? Хэн нь авсан юм? Хэний Засгийн газрын үед авсан юм, тэр сайд, дарга нар нь, гишүүд нь байгаа юм уу? Байвал хариулаад өгчих. Тэгээд тодруулъя. Д

С.Бямбацогт: Сангийн сайд хариулъя Мэндсайхан. Өөр хэн хариулах вэ? Бас бэлдэж байгаарай.

З.Мэндсайхан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Татвар төлөгчдөөс 1.2 их наяд тэрбум төгрөгийн татварын хураамжийг урьдчилан төвлөрүүлсэн байна гээд. Татварын хууль тогтоомжид заасны дагуу татвар төлөгч тайлант хугацааны ногдлоо урьдчилан төлөхөөр хуульчилсан. Энэ урьдчилсан төлөлт, тайлангаа татварын албанд ирүүлсний дараа хаагдаад явдаг.

Аудитын тайланд дурдагдсан байгаа тэр 1.2-ыг бол урьдчилгаа төлөлт гэдэг нь 25 оны жилийн эцсийн тайлангийн ногдлоо 25 онд нь төлсөн төлөлт. Түүнээс биш 26 оны тайлангаас урьдчилж авсан асуудал огт биш ээ. Аж ахуй нэгжийн орлогын албан татварын хуулийн 25 дугаар зүйлд албан татварыг өөрөө тодорхойлон ногдуулаад төсөв төлөх харилцааг зохицуулсан. Энэ хуулийг үндэслээд 25.2-т заасан сар бүр төлөх татвараа сар бүрийн 25-ны дотор, улирлын эцэст хийсэн тооцооны дагуу эхний улирал, сарын 20-ны дотор жилийн эцэст хийсэн тооцооны дагуу татвараа дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор төсөвт төлнө гэж заасан байдаг. Энийгээ үндэслээд энэ нөгөө урьдчилж орж ирсэн татвар байгаа.

Таны асууж байгаа тэр 1 аравны, төсвийн 2 хувийн ашигтай байх нь төсвийн шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна гэж ярьж байна. Тусгай шаардлагын гурван үзүүлэлтээс нэгийг нь хангахгүй байгаа. Тэр нь 1.2 хувь байх ёстой буюу 1.1 их наядын алдагдалтай. 1.3 их наядын алдагдалтай гарчихсан байгаа. Энэ түрүүн би хэлсэн орон нутгийн төсөв алдагдалгүй байна гэдэг төсвийн нэг хуулийн заалт байгаа. Үүгээр бол орлого, зарлага нь тэнцээд орон нутгийн төсөв батлагдаж байх ёстой.

Гэтэл урьд оны санхүүжилтийн дүнгээр дараа оны зарлага руу нь санхүүжүүлнэ гэсэн Төсвийн хууль дээр бас ийм салаа утгатай заалт байгаа. Энийг нь үндэслээд та бидний баталсан нэгдсэн төсвийг төсвийн хязгаарыг давуулаад орон нутгийн иргэдийн хурал батлаад байгаа юм. Төсвийг давуулж батлаад байгаа юм. Орлого, зарлагыг. Энэний чинь алдагдал нь улсын нэгдсэн төсөв дээр бид нарын яриад нөгөө хязгаарыг чинь давж явчхаад байгаа юм. Тийм учраас одоо улсын төсөв өргөхдөө энэ 2 хуулийн ойлголтыг, зөрүүтэй ойлголтыг өөрчлөх ёстой. Нэг ёсондоо орон нутгийн төсөв гол алдагдалгүй батлагдах буюу орлого, зардлыг тэнцсэн тэр зарчмыг барих тэх заалтыг л бид нар барьж явах ёстой.

С.Бямбацогт: Хариулт хангалттай юу? Эхний асуулт хариулт авлаа гэж байна. Гүйцээгээд хариулчихъя Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Манай төсөв бол нэгдсэн төсөв. Улсын төсөв дотор чинь Эрүүл мэндийн даатгалын төсөв, Нийгмийн даатгалын сангийн, нөгөө Ирээдүйн өв сан гээд Их Хурлаар баталдаг. Эд нар дээр бол ямар нэгэн зөрчил байхгүй байна. Төсвийн бүрэлдэхүүнд байж байгаа. Орон нутгийн төсөв гэж байгаа. Энэ дээр л асуудал байгаа. Би сая тайлбарыг нь өгчихлөө. Бусад төсөв дээр бол дагалдаад явж байгаа төсөв дээр ямар нэгэн зөрчил байхгүй.

С.Бямбацогт: Очирбат гишүүн тодруулъя.

Г.Очирбат: Одоо ийм үгээр ам хаахгүй ээ. Тэгээд хэнд хариуцлага тооцох юм хууль зөрчиж байгаа нөхдүүд ээ? Салаа утгатай хууль гэж юу яриад байна? Аль нь Хууль тогтоомжийн хууль зөрчөөд байгаа юм? Харин тийм. Тэгэхээр одоо хэнд хариуцлага тооцох юм? Яагаад ийм асуудал бий болчихсон юм? Тэгээд энэ аудитын тайлан дээр чинь энэ түрүүлээд 1.2 их наяд төгрөг авчихсан гээд энэ бүүр гаргаад тавьчихсан байна шүү дээ. Анхаарах зүйл дээр. Тэгээд энэ бол түрүүлээд бараг та хэд харин тэгээд аваад төлөвлөчихсөн юм бол би түрүүн асуултад хариулт авч чадахгүй байна шүү дээ. ТӨК/төрийн өмчит компани/-удаас авчихсан юм уу, хувийн хэвшилд юм уу? Аль компаниас нь хэдийг авсан юм бэ гэдэг тоогоо хэлээд өг гэхэд та яг тодорхой хариулт өгөхгүй байна шүү дээ. Ерөнхийдөө бөөрөнхийлсөн маягтай байна.

Дараа нь энэ юугаа ер нь яах юм, төсвийн хүрээгээ ер нь яах юм? Дунд хугацааны төлөвлөлтөө яах юм гээд асуухад хариулт авч чадсангүй. Тэгээд энэ 2 дээрээ бас хариулт авчихъя. Тэр 4 дэх асуулт байсан тэр зээлийн хүүд 37.6-г төлөөд байгаа.

С.Бямбацогт: Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Тэр төсвийн урьдчилж авсан хуулийн заалт юу вэ гэсэн би танд хуулийн заалтыг нь уншаад өгчихсөн. 25 он онд аж ахуйн нэгжүүд өөрөө төлөвлөөд ногдол ашгаа урьдчилж төлнө. Үүгээрээ ороод ирчихсэн 25 дараа оныхоо 2 дугаар улиралд 1 дүгээр улиралдаа багтаагаад энэнийхээ ногдол ашгийг тогтвортой суутгаад явж байгаа. Энэ дээр ямар нэгэн тийм урьдчилаад аж ахуйн нэгжүүдээр авчихсан юм байхгүй. Тэр аж ахуйн улсын төсөвт үйлдвэрүүд өөрсдөө ногдол ашгаа түрүүлээд өгсөн ийм л асуудал нь аудитаар гарсан байна.

Салаа утгатай хууль гэж би салаа утгатай хуулийн чинь заалтыг хэлээд өгчихье. Төсвийн тухай хуулийн 57.2 дээр орон нутгийн төсвийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тухайн жилийн төсөвт нийцүүлэн алдагдалгүй батална гээд заачихсан байгаа юм. 57-гийнх нь 3 дээр орон нутгийн төсөв урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээс хэтрэхгүй байна гэж байгаа юм. Энийг үндэслээд ямар жишээ гарч байна гэхээр өнгөрсөн онд улсын төсвөөр бид нар Их Хурлаар.../минут дуусав./

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя. Гүйцээчихье.

3.Мэндсайхан: 25 онд бид нар 6.9-ийн их наядаар орон нутгийн төсвийн орлого, зарлагыг батлаад өгсөн. Аймаг, сумын иргэд, аймаг, орон нутгийн,

нийслэлийн Иргэдийн Хурал батлахдаа орлогыг нь 1.5-аар, зарлагыг нь 3.7-гоор нэмэгдүүлээд баталж байгаа юм. Энэ хуулийн 2 дахь 57.3-ыг үндэслээд аймаг орон нутгийн Иргэдийн Хурал ийм юм хийчхээд байна. Тэгэхээр одоо бид нар 57.2-ыг авч үлдэх буюу 57.3-ыг өөрчлөхгүй бол энэ асуудал аймаг, орон нутгийн Иргэдийн Хурлын асуудлыг бид нар яаж хариуцлага тооцох вэ дээ. Ийм зөрчилтэй хууль яваад байна гэдгийг л би хэлж байна. Энэ дээр үндэслээд би энэ дээр төсвийн хязгаарыг нь бариад ярихаар 57.3-аа барьж урдаас ийм тайлбартай байна. Сая нийслэлийн сонсголыг та анзаарсан бол яг энэ асуудлыг хөндөж ярьсан байгаа.

С.Бямбацогт: Нэг байгаа билүү? Очирбат гишүүн тодруулъя.

Г.Очирбат: Ингээд харин сүүлийн 10 жил ингэж явж татвар төлөгч нарын мөнгийг хуулиар ойлгомжгүй байдал үүсгэж гувчуулсан байна л даа. Мэндсайхан сайд харин ёстой шударга сайд болохоор ингээд хэлээд тавьж байх шиг байна шүү дээ. Тэгээд цаашдаа яаж явах вэ? Энэ хуулиа өөрчлөх хэрэгтэй. Монгол Ардын намынхан 10 жил эрх барьсан. Татвар төлөгч нарын мөнгийг 2 утгатай хуулиар, салаа утгатай хуулиар ингэж үргүйдүүлж байсан байна шүү гэдгийг нотолчихлоо.

Хоёрт гэх юм бол энэ хаана хамаагүй сайд дарга болохоороо очиж дураараа очиж зээл авдаг. Тэгээд тэр зээлийнхээ хүүгийн төлбөрт жил болгон 37.6 тэрбум төгрөг татвар төлөгч нарын мөнгөөр төлж байгаа. Энэ байдлыг таслан зогсоох хэрэгтэй шүү. Асуултдаа хариулт авч чадсангүй. Тэгээд манай энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн дүгнэлтдээ байр суурь дээрээ байгаарай. Үндэсний аудитын газрынх нь байр суурь дээрээ байгаарай. Энэ Их Хурлын гишүүд ялангуяа энэ зас.../минут дуусав./

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон Сангийн яам.

С.Тулга: Сангийн яам Тулгаа. Гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Ашиглагдаагүй зээлийн үлдэгдэл одоо 13.8 их наяд төгрөг байгаа. Энэ зээлийн үлдэгдэл юунаас шалтгаалж байна гэхээр гадаад зээлийн ашиглалт маань өөрөө төсвийн бүрэлдэхүүн хэсэг учраас жил болгон ерөнхийдөө 1.5-аас өнгөрсөн жилийн хувьд, энэ жилийн хувьд 1.2 их наяд төгрөгийн гадаад зээлийн ашиглалт батлагдсан байгаа. Гадаад зээлийн ашиглалт ашиглагдаагүй, ашигласан дүн дээр хүү төлдөг. Ашиглагдаагүй үлдэгдэл дээр commitment рөө 37.6 их тэрбум төгрөг төлсөн байгаа. Энэ болохоороо 45 төслийн 9.1 их наяд төгрөгийн гадаад зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл дээр төслөн төлбөр байна. Энэ зээлүүдийг 2012 оноос 24 онд соёрхон баталсан 45 зээлийн төсөл дээр төслөн байна.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын Даваагийн Цогтбаатарын урилгаар Баянхонгор аймгийн Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2001 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа, төгсөлтийнхөө 25 жилийн ойг тэмдэглэж байгаа та бүхэндээ нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсье.

Лувсанжамц гишүүн асуултаа асууя.

Г.Лувсанжамц: Сайн байцгаана уу? Хууль, тогтоол дундаас та бидний хамгийн өндөр ач холбогдол өгөх ёстой зүйл бол өнөөдөр хэлэлцэж байгаа энэ төсвийн гүйцэтгэл. 2025 онд нийт төрийн бүх байгууллагууд 31 их наяд төгрөгийг зарцуулсан. Ажил, хөдөлмөр эрхэлдэг, татвар төлдөг иргэн, аж ахуйн нэгжүүд байгаа учраас энэ их мөнгийг зарцуулах боломж, нөхцөл бүрдсэн гэдгийг өнөөдөр бид энд мартаж болохгүй. Зарцуулсан төсвийн үр дүнгээ шалгаж асуух, сайжруулах, өндөр ач холбогдол өгөх ийм ажил дээр Их Хурлын гишүүд та бүхэн маань үүргээ сайн биелүүлээсэй гэж сануулж хэлье.

Нэгдүгээр асуулт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аудитын газар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өнгөрсөн оны 113 дугаар Улсын Их Хурлын тогтоол, 7 дугаар зүйл төсвийн жил бүрийн гүйцэтгэлд Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд заасан зорилтот түвшинд хүрсэн эсэх, тухайн онд хүрсэн түвшин, төсвийн гүйцэтгэлээр хүрсэн түвшнийг тус тус тусгаж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байх гэж заалтад тусгасан. Ийм санал гаргаж оруулсан энэ Их Хурлын тогтоол дээр. Энэ 1000 гаруй хуудастай тайлангаас харахад энэ 7 дугаар заалтыг хэрэгжүүлээгүй байна. Хүрсэн үр дүнгээ 36 төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр гаргах энэ ажлыг хэзээ хийх вэ? Ирэх жил энэ орж ирэх үү?

Үргэлжлүүлээд Хэрэг эрхлэх газраас 82 тэрбум төгрөгийг өнгөрсөн жил зарцуулсан байна Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар бас хамт хариулаасай гэж бодож байна. Таван жилийн үндсэн чиглэлийн 7.3.5.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ гэж байгаа. Хөрөнгийн өгөөжийг төрийн өмчит компани болон ОНӨААТҮГ/орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар/-аар гаргаж байгаа. 2025 оны байдлаар хэдэн хувьтай байгаа вэ? Эдийн засаг, хөгжлийн яам 134 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

4.1.4.Өрхийн бодит орлогыг нэмэгдүүлнэ гэсэн зорилт тавьсан. Жил бүр 5 хувиар. 2025 онд хэдэн хувиар нэмэгдүүлсэн бэ?

4.1.5.Үндэсний баялгийн сангийн иргэдэд хүрэх өгөөжийг нэмэгдүүлнэ гэсэн. Өнгөрсөн оны байдлаар хэдий хэмжээний төсвийг та бүхэн энд бүрдүүлсэн байна вэ?

Боловсролын яам 3.9 их наяд төгрөг зарцуулсан.

1.1.2.2.Мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын тоог нэмэгдүүлнэ. Хувийг нь нэмэгдүүлнэ гэсэн байгаа. 25 оны гүйцэтгэлээр хэдэн хувьд хүрсэн байна вэ?

Авлигатай тэмцэх газар 51 тэрбум төгрөг зарцуулсан.

7.1.1.Авлигын төсөөллийн индексийг 33 байгааг өсгөнө гэсэн тоо тавьсан. Энэ жилийн хувьд 34 болгоно гэсэн. 2025 оны гүйцэтгэлээр хэд байгаа вэ?

Байгаль орчны яам 222 тэрбум төгрөг зарцуулсан.

6.2.1.1. Улаанбаатар хотын агаар дахь $\text{pm}_{2.5}$ тоосонцрын хэмжээг буулгана гэсэн зорилт тавьсан. Өнгөрсөн жилийн байдлаар ямар үр.../минут дуусав./

С.Бямбацогт: Энхбаяр сайд. Дараад нь хэн байсан бэ? Аудит, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хариулъя.

Б.Энхбаяр: Төрийн өмчийн компаниуд үндсэндээ “Эрдэнэт”, “Эрдэнэс Тавантолгой”, “Монрос” гэсэн компаниудаас бусад нь бол их ашиг муутай ихэнх нь алдагдалтай байна гэж байна. Тоо, зарим тоонууд хэлье. Нийтдээ 2025 оны санхүүгийн тайлангаар бол 69 төрийн өмчит компанийн 32 нь алдагдалтай, 37 нь ашигтай ажилласан. Эндээс Эрдэнэс Монголын нэгдлийн харьяа компаниудыг оролцуулж тооцох юм бол 49 нь ашигтай, 49 нь бол алдагдалтай компаниуд байна. Хамгийн их алдагдалтай 20 компанийг Хөгжлийн банк, “Тавантолгой түлш” тэргүүлж байна. Хамгийн их өндөр ашигтай компанийг “Эрдэнэс Монгол”, “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэт” үйлдвэр эзэлж байна.

Энэ дотор их олон үзүүлэлтүүд яригдана. Юун түрүүн эрх зүйн асуудлыг дөнгөж сая энэний өмнө Төрийн өмчийн компанийн ил тод байдлын тухай анхдагч бие даасан хуулийг гаргах асуудлыг ярьж байна. Манай улс энэ төрийн өмчийн компаниудын эдийн засаг дахь оролцооны асуудлыг олон жилийн турш ярьж байгаа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сайдын тушаалаар энэ асуудлыг ер нь цогцоор нь нэг судалж үзье гэдэг ажлын хэсэг гараад одоогийн байдлаар 1 сар ажиллаж байна. Энэ бол нэлээн удаан үе шаттай олон рефеорм хийдэх юм байна гэж ойлгож байгаа. Хууль гарсны дараа намар ямар ч байсан төрийн өмчийн компаниудын талаар барих бодлогоо оруулж ирнэ. Урьдчилсан байдлаар би хэлье. Урьдчилсан байдлаараа 1 сар ажилласан ажлын хэсгийн хүрээнд авч үзэхэд Боловсролын салбар дахь төрийн оролцоо 80 орчим хувьтай байна. Эрчим хүчний салбарт 70 хувьтай байна. Тээврийн салбарт 37 хувьтай байна. Уул уурхайн салбарт энэ саяын хэлж байгаа 4 чиглэлд төрийн хамгийн их оролцоо байна гэсэн ийм чиглэл гарч байна.

Төсвийн ногдол ашгийн талаас нь авч үзэх юм бол үндсэндээ “Эрдэнэс Тавантолгой” компаниас бараг төсөв бүрэн хамааралтай байна. Сарын өмнө би яг Лувсанжамц гишүүний асуултад хариулахдаа төрийн өмчийн компаниуд энэ төр бол жилдээ 55 орчим тэрбум төгрөгийн түрээсийн зардал гаргаж байна. 5 орчим тэрбум төгрөгийн орлого олж байна гэдэг ийм дүнг танилцуулж байсан. Энэнээс хойшоо дахиж сая хэлсэнчлэн төрийн өмчийн компаниуд, дээр нь нэмэх нь орон нутгийн өмчийн компанид орох юм бол энэ 600 гараад явчихна.

Ингээд бүгдийг нь ер нь рүү нь орох нүсэр ажил хийгдэж байгаа. Танд сарын өмнө хэлж байсан тооноос дахиад тоо маань өөрчлөгдсөн. Одоогийн байдлаар. Одоогийн байдлаар ингээд дахиад гарсан чинь энэ түрээс төлж байгаа дүн нэмэгдэж байна. 2026 оны энэ төсөв дээр орон байр, түрээсийн зардал төрийн өмчийн компаниуд дээр гарч үзэхэд одоогийн байдлаар 105.3 тэрбум төгрөг зарцуулсан ийм байдал гарч ирж байна. Сарын өмнө бол би танд 55 тэрбум гэж хэлж байсан. Шалгаад яваад байгаа юм. Одоо сарын хугацаанд шалгаад үзэхэд дахиад энэ дүн 2 дахин нэмэгдсэн ийм байдалтай байна.

Энийг байгууллага болгоноор нь авч үзэж байна. Хамгийн түрээс болон түрээсийн орлого, түрээсийн зардлыг нь авч үзэхэд.../минут дуусав./

С.Бямбацогт: Зочин танилцуулчихъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэгийн урилгаар Сүхбаатар аймгийн Онгон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө 20 жилийн ойг тэмдэглэж байгаа та бүхэндээ Их Хурлынхаа гишүүдийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсье.

Аудит Магнайсүрэн дарга 3 дугаар микрофон. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бэлдэж байгаарай.

С.Магнайсүрэн: Асуултад хариулъя. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн батлагдсан боловч хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхой бус, зарим хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд тодорхой бус байгаа. Оновчгүй, хэмжих нэгж уялдаагүй, суурь түвшин алдаатай, хэмжигдэхүйц бус байгаа зэргээс болоод үр дүнг тооцох боломжгүй байна гэж манайх дүгнэсэн байгаа.

Ингээд бид нар аудитын шийдлээ юу гэж гаргасан бэ гэхээр зэрэг Тэргүүн шадар сайдад бид нар зөвлөмж өгсөн байгаа. Энэ зөвлөмжийн 2 дээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг барих барилга, байгууламжийн тоо, зам гүүр, инженерийн шугам сүлжээний ажлын урт, хөрөнгө оруулалтын ажлын явц, гүйцэтгэлийн хувиар бус салбарын онцлогт тохирсон бодлогын зорилт, үр дүнд чиглэсэн оновчтой шалгуур үзүүлэлтээр тодорхойлж, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хяналт шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтэд тусгах гээд ингээд зөвлөж.../минут дуусав./

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

С.Магнайсүрэн: Хариулаад болчихсон.

С.Бямбацогт: Болчихсон уу? Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. 4 дүгээр микрофон.

А.Энхбат: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат. Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Хөгжлийн бодлого, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай хууль хооронд үндсэндээ хэрэгжилт сул байгаа. Бид нар та бүхэн мэдэж байгаа саяхан 1 сарын өмнө 2025 оны хөгжлийн гүйцэтгэлийг бид нар дүгнэсэн. Ер нь бид нарын байр суурь бол энэ Засгийн газрын Санхүүгийн нэгдсэн тайлан, Улсын төсвийн гүйцэтгэл хоёрыг хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлтэйгээ хамтад нь хэлэлцэхгүй бол нэг тал нь бид нар өөрөөр хэлбэл төсвийн байгууллагын зардлыг бид нар яриад байгаа болохоос биш яг гишүүний асуултад асуугаад байгаа тэр зүйл бодлого, үр дүнд хүрсэн зүйлтэйгээ холбож өгч чадахгүй яваад байгаа. Тийм болохоор цаашдаа энэ улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг үнэлэхдээ улсын хөгжлийн бодлогын хэрэгжилттэй уялдуулж дүгнэх зайлшгүй шаардлагууд харагдаж байна. Угаасаа энэ.../минут дуусав./

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя 4.

А.Энхбат: Төсвийн тухай хуулийн 27.1.5 болон мөн хуулийн 54.5.4-д заасан хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнг бол тооцоход хүндрэлтэй байгаа. Цаашдаа хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг эргээд бид нар бодитой үнэлэх, төсвийн хөрөнгө зарцуулалттайгаа уяж, үр дүнг тооцох асуудал бол орхигдож явж байгаа гэдэг нь үнэн. Баярлалаа.

С.Бямбацогт: Эдийн засаг, хөгжлийн яам хэн хариулах вэ? Энхбаяр сайд. Шадар сайд Энхбаяр.

Ж.Энхбаяр: Энэ Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл маань өөрөө өнөөгийн бид нарын хэрэгжүүлж байгаа үндсэн чиглэлээс энэ боловсруулсан аргачлал нь их өөр байсан. Энэ аргачлал жоохон учир дутагдал ихтэйб Тэгээд бид нэлээн энийг тойрч байж шинэ хууль, эрх зүйн орчин бүрдүүлээд энэ үр дүнд суурилсан хэмжигдэхүйц ийм аргачлалаар 26-аас 30 оноо боловсруулж, үүнд тэр суурилсан аргачлалаар нь үр дүнг нь дүгнэдэг хэмжигдэхүйц хэлбэрээр ингэж өргөн бариад хэлэлцээд явж байгаа. Энэ 25 он бол яг өмнө Эдийн засаг, хөгжлийн яам гэж байгуулагдаагүй байсан үеийн өргөн барьсан ийм бодлого байгаа. Тухайн үед Засгийн газрын Хэрэг эрхлэх газар боловсруулж өргөн барьж байсан байгаа юм.

Энэ дээр өрхийн бодит орлогын асуудлыг байгаа юм. 2024 оны гүйцэтгэлээр өрхийн бодит орлого 11 хувь гарсан. Энийг цаашид жил бүрд.../минут дуусав./

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя.

Ж.Энхбаяр: 24 оны гүйцэтгэлээр өрхийн орлого 11 хувиар өссөн. Цаашид бол 5 хувиар буулгахгүйгээр өрхийн орлогыг авч явахаар ингэж төлөвлөгөөнд тусаж байгаа. Өрхийн орлогыг 2024 оны гүйцэтгэл нь 8.9 хувиар, 2025 онд 5 хувиар өсөж зорилгоо бол хангасан байна.

Өрхийн бодит орлого гэдгийг нийт орлогоос нь энэ инфляцыг хасаад тооцсон бодит яг өсөлт юм шүү. Улсууд инфляцаасаа багагүй байна гэж яриад байдаг. Энэ бол инфляцаа хасаад бодитоор өссөн өсөлт. Өрхийн орлого бол ингээд тавьсан зорилтоо 25 оны хувьд бол хангасан байна л гэдэг ийм мэдээ байна.

С.Бямбацогт: Болсон уу? Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя. Хэн бэ? Боловсролын яам. Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Яг одоо мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан сургуулийн тоо хэд байна вэ гээд байх шиг байна. Тэгэхээр яах вэ 25 он, 26 оны гүйцэтгэл, 25 оны гүйцэтгэл ярьж байгаа учраас бол нийт төрийн өмчийн сургуулийн 717 сургуулийн 40 хувь нь өнөөдөр мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан гэсэн ийм тоо гарсан байна. Гэхдээ энэ тооны цаана бусад сургуулиуд нь мэргэжлийн багшгүй болчихсон юм шиг бас буруу ойлголт бас нийгэмд төрүүлж болохгүй гэж бодож байна. Нийт системийн хувьд бол манайх мэргэжлийн багшийн хангалт бол 97, 98 хувьтай байж байгаа. Ер нь өөрөө боловсролын салбарын онцлог бол залуу багш нар их байдаг учраас бол декрет, жирэмсний амралтаас болж 2000 багш нарын хөдөлгөөн гардаг. Ингээд 400, 500 багш нарын тэтгэвэрт гардаг учраас бол 2500-аас 600 багшийн

хөдөлгөөн гардаг учраас энийг багш ч мэргэжлээр сурч байгаа хүмүүсийн төгсөлтөөр зохицуулдаг бас ийм онцлогтой салбар байгаа юм.

С.Бямбацогт: Авлигатай тэмцэх газар. Нөгөө зааланд сууж байгаа гэсэн үү дэд дарга? Бэлдэж байгаарай одоо хэн хариулна? Байгаль орчны яам хариулж байя тэр хооронд. Сандаг-Очир сайд.

Ц.Сандаг-Очир: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн 2025-аас 26 оны агаарын бохирдол ер нь хэдий хэмжээгээр буурсан бэ? Тэр дундаа нарийн ширхэгтэй тоосонцор $\text{pm } 2.5$ яаж буурсан бэ гэж асууж байна. Өнгөрсөн 25-26 оны өвөл Улаанбаатар хот агаарын бохирдолтой тэмцэх чиглэлээр нэлээн олон ажлууд хийсэн. Зарим айл өрхүүдийг нарны панелаар хангах, цахилгаан халаагуураар хангах, 20 орчим айл өрхүүдийг орон сууцанд оруулах, нөгөө талаар өвлийн түлшний хэрэгцээг бас сайжруулсан түлш түлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Энэний хүрээнд нийтдээ 2025-аас 26 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд түлшний хэрэглээнд сайжруулсан түлш хэрэглэснээр өмнөх 24 онтой харьцуулахад $\text{pm } 2.5$ -ын тоосонцрын хэмжээ бол 30.4 хувиар буурсан гэсэн ийм статистик тоо баримт гарсан байгаа гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Авлигатай тэмцэх газар. Нөгөө зааланд байгаа тийм үү Их Засаг танхимд. Холбогддог л баймаар юм. Тэр хооронд зочин танилцуулж байя. Тамгын газар. Зочныхоо танилцуулгыг гаргачих уу.

Архангай аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа, төгсөлтийн 20 жилээ тэмдэглэж байгаа та бүхэндээ Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Энэ жил ер нь энэ өдөр 2006 оноор л нөгөө яасан өдөр хэд билээ? Харин тийм байна.

Бэлэн болсон уу нөгөө заал? Лувсанжамц гишүүн асуултаа асуучихъя тодруулж.

Г.Лувсанжамц: Тийм энэ хүрэх үр дүн нь тодорхойгүй, хэмжих арга зам нь байхгүй гэсэн тийм шалтгаан байсан учраас таван жилийн үндсэн чиглэл дээр бүгдийг нь засаж өгөөд 516 шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж өгсөн. Заримыг нь тооцох гэж оруулж өгсөн. Тэгээд энэндээ бэлдэх ёстой бид нар. 26 ондоо бид нар бас хэмжиж чадсангүй гээд суухгүйн тулд 25 оныхоо гүйцэтгэлийн энэ дээрээ хэмжиж орж ирье гээд батлахад нь ч хэлсэн, дараа нь ч хэлсэн. Ингээд болсонгүй гээд бүгдээрээ яриад сууж байж болохгүй. Эдийн засаг, хөгжлийн сайд эхний зорилтоо бол биелүүлсэн байна. Баяр хүргэе.

Хоёрдугаарх нь Үндэсний баялгийн сан дээр 25 онд хэдэн төгрөг төвлөрүүлсэн бэ гэдгийг тодруулга авъя. Боловсролын яам бол 40 хувь бүрэн хангагдсан гэж байна. Та бүхэн 27 онд хүрэх байсан төвшнөө давуулан биелүүлсэн байна гэж ойлголоо. Баяр хүргэе. Авлигатай тэмцэх газар заавал энэ дээр хариултаа авмаар байна.

Хамгийн сүүлд нь Хэрэг эрхлэхийн Б.Энхбаяр сайдаас асууя. Энэ бусад яамнууд төсвийн ерөнхийлөн захирагч нарын энэ үр дүнг нь танай дээр уг нь

хэмжиж шалгаад гаргах ёстой. Хөрөнгийн өгөөжийг төрийн өмч, орон нутгийн өмчөөр нь л тодорхой хэлээд өг.

С.Бямбацогт: Авлигатай тэмцэх газар Азжаргал дарга. 4 дүгээр микрофон.

Г.Азжаргал: Гишүүний асуултад хариулъя. Авлигатай тэмцэх газар Азжаргал. 2024 онд гишүүн авлигын төсөөллийн индекс ярьж байна гэж ойлгосон. 33-аас 31 оноотой байгаа. Энэ индекс бол 13 үзүүлэлтээр дүгнэгдээд энэ жил 2025 он бол 9 үзүүлэлтээр нь дүгнэгдсэн байж байгаа. Монгол улс тэгээд энэ дээр өргөн хүрээнд улс төрийн намын санхүүжилт, төрийн өмчийн компаниудын засаглал, тэгээд нөгөө төрийн шийдвэр гаргахад иргэдийн дуу хоолой, хэвлэлийн эрх чөлөө гэсэн энэ өргөн хүрээнүүдийг хамарч байгаа. 2023-2030 онд хэрэгжүүлэх авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг Улсын Их Хурлаар батлуулаад ингээд ажиллаж байгаа.

С.Бямбацогт: Энхбаяр сайд тэр төрийн өмчит компаниудын хөрөнгийн өгөөж. Хэрэг эрхлэхийн сайд Энхбаяр.

Б.Энхбаяр: Юу л даа Засгийн газрын Хяналт үнэлгээний шинжилгээ бол Тэргүүн шадар сайдаар эхлэх асуудал байгаа юм Засгийн газрын хуулиараа. Гэхдээ яах вэ нэг Засаг учраас тэрний сайд энэний сайд гээд юу яах вэ. Ер нь энэ хяналт шинжилгээ, үнэлгээний чиг үүрэг хэрэглэхийн сайдаар эхлэх асуудал л байх ёстой юм байна лээ. Төсвийн тодотгол хийгээд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний асуудал яривал энэ бодлогын салангид байдлыг засъя гэсэн ийм би бол ийм бодол, саналтай байгаа. Хуулиар засах юм.

С.Бямбацогт: Тэгээд хөрөнгийн өгөөжийн хувьд бол нэг хэсэг компаниудын тариф барьчихсан эрчим хүчний компаниудын. Тэрнээсээ болоод эрчим хүчний компаниуд алдагдалтай ажилладаг. Нэг хэсэг компаниудыг нийгмийн хариуцлагын хүрээнд алдагдалтай ч хамаагүй ард иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог нь бүрдүүл гээд АЗЗА компаниуд мэтийн компаниуд дээр маш бага төсөв өгдөг. Тэрүүгээрээ замаа зас, цасаа цэвэрлэ гээд ингээд иймэрхүү олон компаниуд АЗЗА гэхэд 20, 30-н компани, эрчим хүчний компани 40-өөд компани. Тоогоор олон боловч алдагдлын хэмжээ нь харьцангуй бага. Цөөхөн уул уурхайн компаниуд нь ашигтай ажилладаг, харьцангуй өндөр ашигтай ажилладаг. Яг бизнестэй өрсөлддөг хэдэн компани байдаг юм байна лээ. Хувийн хэвшилтэй өрсөлддөг. Төрийн банк, мэдээлэл сүлжээ, холбоо зэрэг шаардлагатай юу шаардлагагүй юу эдгээрийг л уул нь ангилаад л янзалчих хэрэгтэй л юм байна лээ л дээ. Ер нь бол орлого ордоггүй, өгөөж өгдөггүй компани бидэнд байх хэрэггүй л дээ.

Гэтэл нөгөө талд нийгмийн хариуцлага төр заавал ард түмнийхээ өмнө ачаа үүрэх ёстой асуудлууд байгаад байгаа. Ийм л хэдэн ялгаатай юм байна лээ.

Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя. Одоо болсон.

Ө.Шижир: Асуулт бол зөндөө байна. Гэхдээ энэ олон юмыг чинь товчлоод асуучихъя. Ер нь бол нэгдүгээрт энэ батлагдсан хууль тогтоомжийн хүрээнд Засгийн газар үйл ажиллагаа явуулах ёстой юм уг нь бол. Тэгэхгүй өөрсдөдөө зориулаад, үйл ажиллагаандаа зориулаад хууль тогтоомжийг өөрчилдөг байдал

хэрээс хэтэрлээ. 2025 оны улсын төсөв оруулж ирэхдээ 14, 5-н хуулийг өөрчлөхөд дагуулж оруулж ирсэн. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь 22 дахь удаагаа өөрчлөгдсөн. Энэ өөрөө юу вэ гэхээр үйл ажиллагаандаа зориулж хууль тогтоомжийг өөрчлөөд байна гэсэн үг Засгийн газар нь. Нэг үгээр хэлбэл батлагдсан хууль тогтоомждоо үйл ажиллагаа явуулж чадахгүй өөрсдийнхөө үйл ажиллагаанд тохируулаад байна гэсэн үг.

Үндэсний аудитын газар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд би дахиад хоёр дахиа хэлье зүгээр шүдгүй арслан. Би энэ хоёр байгууллагаас хоёулангаас нь асууя. Сүүлийн 3 жилээр Үндэсний аудитын газраас гаргасан зөвлөмжүүд хэдэн хувийн хэрэгжилттэй хэдээс хэд нь хэрэгжсэн юм сүүлийн 3 жилээр?

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс сүүлийн 3 жилийн төсөв, төсвийн тодотголоор өгсөн зөвлөмжүүд чинь тэдэн зөвлөмжөөс хэд нь хэрэгжсэн юм, хэрэгжилт нь хэдэн хувьтай байсан юм? Энэ тоонуудыг бодитоор харахгүй бол бид нар жил бүр ийм хоосон цаасны араас хоосон тоо ярьдаг, үр дүн, гүйцэтгэл муутай. Тэгээд баахан зөрчил ярьсан ийм л юм болох гээд байна л даа. Нэг.

Хоёрдугаарх нь энэ 75 дугаар хуудсан дээр ингэж байгаа юм. Урсгал зардалд хийсэн түүвэр судалгаагаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх 24 хороо, зөвлөл, ажлын албаны гүйцэтгэлийн зардал 17.5 тэрбум төгрөг. Энэ бол татвар төлөгчдийн мөнгө салхинд хийссэн гэсэн үг. Хоол, унааны зардал нь 698.8 тэрбум төгрөг. 4367 гадаад томилолт нь 74.3 тэрбум төгрөг. 16206 сургалтад 61 тэрбум төгрөг зарцуулсан гэж байгаа юм. 16206 сургалт жишээ нь.

Тэгэхээр ийм байдлаар бид нар төсвийн хөрөнгийг үрэн таран хийдэг байдал хэзээ болих юм бэ? Манай аудитын дүгнэлт байгууллагын зөвлөмжүүд хэзээ хэрэгждэг болох юм бэ. 22.3 тэрбумаар хэвлэл мэдээллийн зардал гарсан байна гэж байгаа юм. Үүний үр дүн юу юм бэ? Хууль тогтоомж болон Засгийн газрын үйл ажиллагаа хэр юм бэ? Энийг асуумаар байна.

Дараа нь энэ 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил, арга хэмжээ 34.3 их наяд гэж байгаа юм. 2024 бол сонгуулийн жил. 34.3 их наядаар ямар ямар төсөл арга, хэмжээ хийсэн юм? Түүний хамгийн том дүнтэй 10 дүнг нь та надаа нэрлээд өгөөч. Яагаад ингэж асуугаад байна энэ чинь 2025 онд 19 тэрбум буюу 15, 6-н тэрбумаар буураад ороод ирж байгаа байхгүй юу. Сонгуулийн жилдээ ингээд 15, 34, 5-н их наяд болоод ороод ирдэг ийм байдал чинь хэдий болтол давтагдах юм бэ? Ийм юмнуудаар эхлээд асуултаа асууж тодруулъя.

С.Бямбацогт: Аудитынх. Ерөнхий аудитор Магнайсүрэн дарга 3 дугаар микрофон.

С.Магнайсүрэн: Шижир гишүүний асуултад хариулъя. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн асуудлаар бас олон тоо мэдээ дурдаж болж байгаа. Жишээлбэл, энэ 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлангаар гэхэд бид нар нийтдээ бид нар 6792 энэ аудитын тайлан баталгаажуулалт хийсэн. 13400 гаруй зөрчил ер нь нэгтгэгдсэн байгаа. Ингээд 11.8 их наяд. Энэний 8.1 их наяд нь төрийн өмчит

болон өмчийн оролцоотой компаниуд дээр ногдож байгаа юм. Бусад нь бол бусад төсвийн захирагч нар дээр ингээд ногдоод явж байгаа юм.

Хэрэгжилтийн байдал дээр бол бид нар онцгойлон анхаарч ажиллаж байгаа. Өнгөрсөн жилийн хэрэгжилтийн байдлыг бид нар төсөв захирагч бүрээр нь өнгөр.../минут дуусав./

С.Бямбацогт: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Хариултаа гүйцээчихье. 3 минутаар хариулах ёстой доо. 1 минут болчихлоо сая.

С.Магнайсүрэн: Төсөв захирагч болгоноор нь бид нар өнгөрсөн жилийн акт, албан шаардлага, зөвлөмж, холбогдох шийдлүүдийнхээ биелэлтийн хувийг төсөв захирагч болгоноор гаргасан байгаа. Ирэх долоо хоногт бол Байнгын хороод дээр бид нар ингээд төсвийн ерөнхийлөн захирагч болгоноор ингээд бас давтаад энэ нарийвчилж тоонууд ярина. Бүх төсөв захирагч нар дээр тийм ийм ийм биелэлттэй гэж хэлэхэд бол цаг хугацааны хувьд хангалтгүй байгаа учраас ийм ерөнхий хэлье.

Ер нь бол бид нар аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангах талаар бол бүх талаар Их Хурлын гишүүдээс өгсөн чиглэл, Байнгын хорооноос гаргасан чиглэлийн дагуу ажиллаж байгаа. Холбогдох бүтцийн нэгж байгуулагдсан. Бүх дата мэдээгээ нэгтгэж авсан. Хууль хяналтын байгууллагатай бас биелүүлэх талаар хамтарч ажиллаж байна.

Тухайлбал, бид нар Улсын ерөнхий прокурортой энэ прокурорын газартай энэ талаар хамтарч ажиллаад төрд учруулсан хохирол, төрийн албан хаагчдын буруутай үйл ажиллагааны улмаас төрд учруулсан хохирлын асуудлыг барагдуулахаар хамтарч санал солилцож хамтран ажиллаж эхэлсэн.

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя 3 дугаар микрофон.

С.Магнайсүрэн: Тухайлбал, төрийн албан хаагчдын буруутай үйл ажиллагааны улмаас төрд учруулсан хохирол 7.2 тэрбум төгрөгийн зөрчил одоо бидэн дээр яг бэлэн байгаа. Энэ асуудлыг төрийг төлөөлөх, шүүхэд төлөөлөгчийн хувьд Улсын прокурор бол энэ тал дээр манайтай хамтарч ингэж хөөцөлдөхөөр болоод одоогийн байдлаар бараг хагас дээр нь шүүхэд нэхэмжлэл бичсэн явж байгаа юм. Манай бичсэн төлбөрийн актыг бас гүйцэтгэх шугам ажиллагаа дээр бидэн дээр бас гарц, гаргалгаа олж өгсөн байж байгаа. Бид нар заавал хууль дээр өөрчлөлт оруулахгүйгээр энэ тал дээр бас хамтарч ажиллах боломж байгаа гэдэг ийм зохицуулалтуудыг бид нар бас судалж, ярилцаж байна.

Дээр нь бид нарын ингээд шүүхэд хандаад гэмт хэрэг гээд хуулийн байгууллагад хандаад зарим хаагдчихсан, хэрэг үүсэхээс татгалзсан асуудал дээр бид нар гомдол гаргах тэр бололцоог бас Улсын прокурортой хамтарч гаргасан байж байгаа.

Ингээд бид нар бол аудитын шийдвэрийн хэрэгжилтийн тал дээр онцгойлон анхаарч байна. Ер нь бол хэрэгжилт өмнөх жилээс бол илүү сайжирч яваа. Ирэх жил бол бид нар илүү ил үр дүнд нь хүрчих байх гэсэн ийм тооцоолол байгаа.

Яагаад гэвэл ийм хууль, эрх зүйн боломж бас бидэнд байна гэж ингэж харж байгаа.

Дээр нь бол Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлээр албан тушаалаас чөлөөлөх болон хариуцлага хүлээлгэхээр нэлээн ийм хатуу заалтууд орсон учраас харьцангуй ийм хөшүүрэг, хууль, эрх зүйн хөшүүргүүд бий болсон. Эрх зүйн хувьд бол боломж бүрдсэн гэж ингэж үзэж байгаа. Үр дүн гарна гэж тооцож байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл.

Ж.Дэлгэрсайхан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулъя. Манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хуулийн чиг үүргийнхээ дагуу төсвийн төсөл, төсвийн тодотгол, хөгжлийн төлөвлөгөө, төсвийн төлөвлөгөөнд дүгнэлт өгдөг. Мөн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой эдийн засгийн таамаглал гаргадаг. Түүний хэрэгжилтэд бас дүгнэлт өгдөг ийм байгууллага.

Манай дүгнэлт, зөвлөмжийн хувьд бол бид нар 24 оноос хойш яг хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн 39 дүгнэлт, зөвлөмжийг өгсөн байдаг. Хэрэгжилтийн үнэлгээ дээр бас бид нарын хувьд харьцангуй өөрөөр ханддаг.

Учир нь бид нар манай дүгнэлт, зөвлөмжийн зөвхөн Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж байгаа дунд хугацааны төсвийн дунд хүрээний мэдэгдэлтэй холбоотой эдийн засгийн таамаглалаас бусад дүгнэлт, зөвлөмж бол Улсын Их Хуралд, Төсвийн байнгын хороонд хүргэгддэг. Манай дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн хувьд бол Улсын Их Хурал тэрхүү дүгнэлт, зөвлөмжийг хэрхэн хүлээж авснаас бол хамаардаг.

Хэрэгжилтийн үнэлгээг бол бид нар Улсын Их Хурал дээр очиж байгаа учраас шууд тэд.../минут дуусав./

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя 4 дүгээр микрофон.

Ж.Дэлгэрсайхан: Шууд тэдийг нь хэрэгжүүлсэн тэдийг нь хэрэгжүүлээгүй гэж бол дүгнэдэггүй. Ерөнхийд нь бол бид нар үнэлэхдээ манай дүгнэлт, зөвлөмж бол дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл дээр бид нар харьцангуй нийцтэй сүүлийн үед бол таамаглал, тооцооллууд харьцангуй ойртож, бидний гаргасан таамаглалын дагуу явж байгаа гэж үздэг.

Төсвийн төсөл, төсөв боловсруулах, төсвийн гүйцэтгэлийн хувьд бол бидний дүгнэлт, зөвлөмж яг бодитойгоор хэрэгжилт бол хангалтгүй байна гэж үздэг. Энэ ч гэсэн дөнгөж сая бидний уншин танилцуулсан төсвийн гүйцэтгэлтэй холбоотой мэдэгдэлд дүгнэлт, зөвлөмж дээр бол бид маш олон төсвийн гүйцэтгэлтэй холбоотой сул талуудыг илрүүлж, энэ сул талууд байсаар байгаа нь бол бидний дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт хангалттай бус байна гэж үзэх ийм үндэслэл болж байна гэж харж байгаа юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Сая бас зарим асуултууд гүйцэд гарахгүй байна гээд гишүүд тэгж байгаа. 24 дэд хороо 690 тэрбумын зардал гарсан гэнэ. Улсын Их Хурлын

Тамгын газрын Хяналт шалгалтын газар Энхбат дарга байна уу? Энхбат даргыг дууд. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх газрын дарга Сайнхишиг дарга байна уу? Дууд. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Эрдэнэсамбуу байна уу? Дууд. Төсвийн гүйцэтгэл хэлэлцэж байна. Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүрэг онцгой бүрэн эрхээр хэнтэй ч хуваалцдаггүй. Энд энэ хариуцсан дарга нар сууж байх ёстой шүү дээ. Энэ гишүүдийн асуусан асуултад дутуу хариулж байгаа, буруу хариулж байгаа энэ бүгдийг бүртгэж аваад холбогдох албан тушаалтанд гүйцэд хариултыг өгүүлэх. Хэрвээ хариулахгүй байгаа бол, дутуу хариулаад байгаа бол, хариулт ирүүлэхгүй байгаа бол хариуцлага тооцох ажлыг нь хяналт тавиад сууж байх ёстой шүү дээ. Ажлаа хийцгээ л дээ. Хааччихсан юм тэр хүмүүс чинь? Тэгээд хариултаа өгөхгүй байна шүү дээ гишүүд чинь, гишүүдийн асуултад гүйцэд хариулт өгөхгүй. Тэгээд хэн бүртгэх ёстой юм, хэн хяналт тавих ёстой юм энд?

Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: 3 асуултад хариулт авсангүй тэрийг нь бичгээр авна гэж ойлголоо. Би өмнө нь яг чуулган дээр ингэж суусан надад албан бичиг ирсэн. Маш тодорхойгүй албан бичиг Улсын Их Хурлын Тамгын газраас ирсэн шүү. Би тэрийг тухайн үед нь яг хэлж байсан.

Одоо дахиад энэ ТӨК-удтай холбоотой асуудлууд байна. Бид нар нөгөө зөвхөн улсын төсвөө тойроод л яриад байдаг болохоос төрийн өмчит компаниудыг тойрсон 100 орчим их наядын асуудал ерөөсөө ярьдаггүй. Үүнд явж байгаа асуудал ерөөсөө ярьдаггүй. Гэтэл энэ аудитын өгсөн тайлан, дүгнэлт дээр чинь 1 их наяд 158 тэрбум төгрөгийг нийгмийн чанартай төсөл, арга хэмжээнд зарцуулсан гэж байна шүү дээ. 1 их наяд 151 тэрбум төгрөг. Нөгөө ахмадын тэтгэврээс харамлаад байдаг мөнгө чинь энд байна. Харамлаад байдаг нөгөө мөнгөнүүд чинь бүгд энд байгаад байна. 1 их наяд 151 тэрбум төгрөгийн хамгийн их үнийн дүнтэй 10 төслийг хэлээд өгөөч. Сая би дахиад 10 юу хэл бас хэлэхгүй юм. Энэ дээр тодруулчхаад дахиад тодруулъя.

С.Бямбацогт: Цэнгэл дарга хариулъя Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар .

Б.Цэнгэл: Төрийн өмчит компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд бол тодорхой оршин байж байгаа сум, орон нутаг, аймгийнхаа тодорхой бас зардлуудыг бол хариуцаад явдаг. Энэ бол бас тухайн байгууллагууд бол бас нэлээд зардал өсгөх ийм алдагдал хүлээх ийм нөхцөл байдал бол үргэлжилсээр байгаа. Энийг бид бол энэ батлагдах Төрийн өмчит компанийн тухай хуулиар бол нэг мөр бас цэгцлэхийг бол зорьж байна. Тухайн орон нутаг бол энийг бас авч явах боломжгүй гэдэг ийм тайлбар хэлж, энийг бол тухайн орон нутгийн төсөв, улсын төсөвт суулгахгүй бол өдий хүрсэн ийм зовлон бол байгаа. Ер нь бол төрийн өмчит компаниуд бол “Тэрбум мод”-ны .../минут дуусав./

С.Бямбацогт: Тодруулъя Шижир гишүүн.

Ө.Шижир: Түрүүн асуултад хариулдаг нь 24 хороо, зөвлөл ажлын албаны зардалд нь 17.5 тэрбум төгрөг, хоол, унааны зардалд нь 698.8 тэрбум төгрөг,

16206 сургалт семинарт 61 тэрбум төгрөг. Ингээд энэ чинь юм яг тодорхой тайлан, дүгнэлтүүд нь яаж явагддаг юм гэж л асуугаад байгаа юм.

Хоёрдугаарт энэ аудитын газар жишээ нь энэ дүгнэлт дээр Үндэсний аудитын газар ингэсэн байгаа юм. Өмнөх оны аудитаар 29 зөвлөмж өгснөөс 68 хувийн гүйцэтгэлтэй байна. Ерөнхий сайдад 11 зөвлөмж өгсний 50.5 хувь гэх мэт. ингээд үндсэндээ зарим нь хэрэгжээд зарим нь хэрэгждэггүй юм байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр хариуцлагын асуудал яригддаг юм уу, эсвэл зүгээр дүгнэлт өгөөд орхичихдог юм уу? Хэрвээ ямар нэгэн хариуцлага яригддаг бол хэдүүлээ дүгнэлт өгөөд яах юм, ийм цаас үйлдвэрлээд яах юм, энд хэлэлцээд яах юм, энийг уншсан болоод яах юм бас яг бодитойгоор. Энэ чинь цаана нь үр дүн гарах ёстой шүү дээ.

Нөгөө талд нь энэ нийслэлийн тэр 500 сая долларын бонд дээр чинь дүгнэлт дээр нь банканд хадгалаад зориулалтын дагуу ашиглаагүй гэчихсэн байна. Энэ дээр хариулт авъя.

С.Бямбацогт: Магнайсүрэн дарга аудит хариулъя. 19 онд бид нар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Улсын Их Хурлын хяналт шалгалтын чиг үүргийг энэ онцгой бүрэн эрхийг нэмэгдүүлсэн, аудитын байгууллагыг Үндсэн хуулийн байгууллага болгосон. 20 онд Аудитын тухай хууль баталсан. Үүгээр аудитыг шүдгүй арслан биш шүдтэй арслан болгосон шүү дээ уул нь. Тэгээд шүдэт ямар шүдтэй болсныг хариулчих даа.

С.Магнайсүрэн: Шижир гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Магнайсүрэн. Бид ер нь хууль, эрх зүйн орчны хүрээнд бүх арга хэмжээг авах ийм бололцоо байгаа. Ажлаас халах хүртэл ийм арга хэмжээ авч байгаа. Гэмт хэргийн чанартай бол бид нар хууль хяналтын байгууллагад хандаад шалгуулж байгаа. Бүхий л арга хэмжээг авч байгаа. Манай шийдвэрүүд бол эхлээд зөвлөмж, зөвлөмжийн хэлбэртэй гарч байгаа. Зөрчлийн шинж байдлаасаа хамаараад зөвлөмж, эсвэл албан шаардлага, эсвэл төлбөрийн акт, тэгээд бусад хууль хяналтын байгууллагад шалгуулах, эсвэл сахилгын хариуцлага тооцуулах ийм 5 хэлбэрээр гарч байгаа.

Зөвлөмж хэрэгжээгүй бол бид нар дараагийн шатад завсрын аудитораар шалгаад дараагийн шатад бид нар албан шаардлага болгоод тэгээд үгүй тохиолдолд бол дараагийн шатдаа шилжинэ гээд дараа дараагийн шатдаа хүндрээд явдаг. Ингээд албан шаардлага давтаж хэрэгжүүлэхгүй тохиолдолд шууд сахилгын буюу хариуцлага тооцох арга хэмжээ рүү ордог ийм хуультай. Энэ дагуугаа л явж байгаа

С.Бямбацогт: Ингээд олон гишүүд асуух гэж байгаа. Өнөөдөр бас нэлээн олон асуудал байгаа. Тийм болохоор энэ гишүүдийн асуултад дутуу хариулж байгаа хариултуудыг гүйцээж хариулуулах ажлыг манай Улсын Их Хурлын Тамгын газар зохион байгуулъя, бүртгэе. Одоо дарга нар ирчихсэн сууж байна. Энхбат дарга, Сайнхишиг дарга та нар ажлаа хийцгээнэ шүү. Дэгийн хуулиа барихаас өөр, дэгээ барихаас өөр арга алга. Дутуу хариулж байгааг бид яах юм? Үгүй энэ байж байгаа хүмүүс нь хариулж байна шүү дээ. Сайд нараа ирүүл. Сайд нар ирүүлээрэй. Ирж байгаа, ирж байгаа. Би ирж байгаа бичгүүдийг, бас өгсөн үүрэг чиглэлийг биелсэн биелэлтийг та бүхэнд танилцуулж болно шүү бас. Байхгүй сайд

нарыг дуудъя. Ямар ч байсан одоогоор л лав тэр сайдаас асуух гэсэн алга гэж тохиолдол гарсангүй. Тэгээд л зүгээр л худлаа чанга хашхирдаг нь чанга хашхирч Цогтбаатар аа чи биш шүү бас тийм. Би дэг сахиулж байна. Би дэг сахиулж байна энд. Тийм би дэг сахиулж байна аа. Харин дутуу асуух. 3 минутад асуулт асуух ёстой. Тодруулж 2 удаа асуух ёстой. Тодруулж 2 асуух асуулгаж байна. 3 минут асуултаа хариулж байна. 3 минутын асуулт болон нэмэлт 2 минутдаа багтаж хариулж багтахгүй учраас бичгээр өг гэж байна. Би яах юм 5 минут асуулгах юм уу? 5 минут асуулгах юм бол чи хууль зөрчлөө чи хэлнэ шүү дээ Цогтбаатар аа чи. Тэгээд л худлаа чанга хашхирдаг юм шиг бодох юм чи. Чи дэгийн хуулиа унш чи. 2 удаа асуучихлаа. 2 удаа хариулчихлаа. Тийм, 2 удаа асуучихлаа. 2 удаа хариулчихлаа. Би гишүүдийн эрх ашиг хамгаалаад асуултад гүйцэд хариулж чадахгүй байна. Бүртгээд ав гэж Тамгын газар нь дуудлаа. Дуудаж оруулж байна, бүртгүүлж байна, дутуу хариулах юм бол дутууг бичгээр гүйцээлгэж өг гэж хэлж байна. Буруу хариулах юм бол хариуцлага тооц гэж хэлж байна. Энэнээс илүү би яах ёстой юм чи? Би дэг сахиулж байна. Ганцхан чанга дуутай нь чи биш шүү чи зүгээр.

Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуултаа асууя.

Б.Мөнхсоёл: Өдрийн мэнд хүргэе. Маш олон асуултууд байгаа шүү. Тэгэхдээ товчхон яах вэ минутаа шинээр авах уу зүгээр үү? Товчхон асууя аа маш олон асуултууд байна.

С.Бямбацогт: Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Би асуултаа асууя. Өдрийн мэнд хүргэе. Маш олон асуултууд байгаа мэдээж.

Нэгдүгээрт нь төлөвлөлтийн асуулт. Хоёрдугаарт нь хэрэгжилт дээр буюу худалдан авах ажиллагаатай бас холбоотой. Гуравдугаарт нь мэдээж гүйцэтгэлийн хяналт, үр дүнтэй холбоотой ийм 3 багц бүлгээр асуултууд байгаа юм надаа. Би зүгээр товчхон эхнээс нь уншихад жишээлбэл төлөвлөлтийн талаар шинэ төсөл, арга хэмжээний 38.7 хувь нь хөгжлийн бодлогын зорилттой уялдаагүй байна.

Хоёрдугаарт нь барилга, их засварын шинэ төсөл, арга хэмжээний 50 хувь нь зураг төсөвгүй батлагдсан.

Гуравд нь эдийн засгийн үр ашгийн тооцоолол 37.8 хувь нь огт хийгдээгүй гэх мэт ингээд тоо баримтыг жишээтэй нь би дурдаж болж байна.

Хоёрдугаар бүлэг асуулт болохоор худалдан авах ажиллагаатай холбоотой. Тендерийн 52 хувь нь 4 сараас хойш зарлагдсан учраас 2-оос 3 сарын хугацаа алдаад байна. Мэдээж тодорхой кэйсүүд байгаа. Жишээлбэл, тендерт гомдол гаргасан нь гаргахаар тэр тохиолдолд 5 сарын 31-ний дотор гэрээ байгуулах боломжгүй болдог, санхүүжилт хэмнэлтэд тооцох эрсдэлтэй байдаг. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа өнгөрсөн онд 5 сарын 31-нээс өмнө тендер зарлагдаагүй төсвийн хөрөнгө оруулалтуудыг царцаасан гэх мэт.

Хяналт дээр болохоор эрүүл мэндтэй хүртэл холбоотой асуудлууд байгаа. Барилгын чанартай холбоотой гэсэн үг. Тэгэхээр гишүүд бас дурдаад байна энэ Үндэсний аудитын газар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маш их ийм мэдээлэл бүхий дүгнэлт, зөвлөмжийг гаргаад байдаг. Энэний үр дүн хэзээ яаж хэрэгжих вэ? Энэ маань үр дүнгүй цаас болоод хувирчхаад байгаад бас гишүүд бухимдаад байгаа юм. Тэгэхээр хариуцлага яаж тооцох вэ л гэдэг асуудлууд яригдаад байна. Сая энэ долоо хоногийн нийслэлийн төсвийн сонсгол 1 дэх 2 дахь өдөр энэ долоо хоногт зохион байгуулагдсан. Тэр дээр улсын төсвөөс гадуур хүртэл хариуцлагагүй байдал яригдсан.

Улсын төсвийн алдагдал бүгдээрээ 1.4 их наяд гээд санаа зовж байтал гадуур нь нийслэл дээр төсвийн алдагдал 2.4 их наяд төгрөг хүртэл яригдах нь гээд ингээд энэ юуг илэрхийлээд байна вэ гэхээр гишүүдийн хэлээд байгаа манай улс ер нь ийм нэг төлөвлөлт, гүйцэтгэл үр ашгийн ийм алдаа, дутагдал, орон зай, хий орон зай маш их болчихжээ. Энийг бүгдээрээ багцалж шинэчилж, реформын шинжтэй ажил хийхгүй бол болохгүй байна гэдэг ийм ерөнхий дүгнэлт хэлээд асуулт бол жишээлбэл Үндэсний аудитын газар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагчдаас одоо бүгдээрээ хаа сайгүй мэдэж байгаа энэ асуудлуудаа яг яавал шийдэж болохоор байна вэ гэдэг дээр 1-3 саналаа хэлээч ээ л гээд асуулт асууя. Тэгээд хариултын дараа тодруулгаа хийе. Баярлалаа сая их саадтай нөхцөлд асуултаа асуулаа шүү.

С.Бямбацогт: Үндэсний Аудитын газар хариулъя. Яг дэг сахиулна 3 минутдаа багтааж хариулна. Тодруулж асуувал 1 минутад багтааж хариулна. Би боломж олгоод хариулуулаад байсан чинь ингээд 3 дугаар, индрийн 3.

С.Магнайсүрэн: Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Бид нарын хувьд бол ингээд 2 сарын 20-доос эхлээд ингээд 15-наас эхлээд 6 сарын 10 хүртэл ажиллаад ингээд тайлангаа тавьдаг. Бид нар нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, шилэн дансны гүйцэтгэл тэгээд нэмээд улс төрийн намын санхүүжилт гэсэн ийм дэд тайлан бүхий 2 том тайланг тавьдаг.

Бүх тайлангийн эцэст бол бид нар дүгнэлтээ хийгээд ингээд холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт нь зөвлөмж өгөөд тэгээд шаардлагатай асуудлыг Улсын Их Хуралд толилуулж байгаа юм. Түрүүн Шижир гишүүн бас асуусан. Энэ Ерөнхий сайдтай холбоотой асуудлыг хэрвээ Ерөнхий сайдаас ингээд зөвлөмжийн биелэлтээр тайлбар, сануулга бүх юмыг нь авч үнэлж дүгнээд Ерөнхий сайдаас үл шалтгаалсан тохиолдолд бид нар ингээд дээш нь Улсын Их Хуралдаа бас ингээд толилуулаад ингээд ороод ирдэг. Энэ удаад гэхэд бүх асуудал дээр нь бас ингээд Улсын Их Хуралд толилуулсан 2,3-н, 2,3-н асуудал байгаа. Түрүүн энийг би танилцуулга дээр дурдсан байгаа.

Хамгийн гол нь энэ багагүй хөрөнгө хүч цаг зав гаргаад ингээд бий болсон тайлан, тэрний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй ингэж ажиллах ийм зайлшгүй шаардлага байгаа. Бид бол зөвлөмж, нөгөө 13 мянган шийдвэрийнхээ араас шийдвэрийн хэрэгжилтийн газраараа дамжуулаад болоод энэ дээрээ төлөвлөгөө гаргаад ингээд араас нь хөөцөлдөөд ажилладаг. Зарим нь бол жилдээ багтаж хэрэгжих ажлууд байна. Зарим нь бол богино хугацаанд хэрэгжүүлчих ийм ажлууд байдаг учраас энэнийхээ дагуу төлөвлөлтөө гаргаад

араас нь хөөцөлдөөд ажилладаг. Тэрнийхээ үр дүнг тайлангаараа тавиад явдаг ийм л механизм байгаа.

С.Бямбацогт: Хариулт хангалттай юу? Бүгд гэж хэнээс асуусан юм бэ? Төсвийн тогтвортой байдал хариулъя.

Ж.Дэлгэрсайхан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Мөнхсоёл гишүүний асуултын хувьд өнөөдрийн энэ тулчихсан байгаа нөхцөл байдлыг бид яаж шийдэх юм бэ гээд. Энэ дээр түрүүн бид дурдсан бид бол байнга яг төсвийн болон хөгжлийн төлөвлөгөө, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой яавал сайжруулах вэ гэдэг зөвлөмжүүдийг байнга өгч байгаа.

Эндээс гол зүйлээ, гол 3 зүйлийг дурд гэсэн учраас 3 зүйлийг дурдъя. Нэгдүгээрт Монгол Улсын төсөвт хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт хангалтгүй байгаа үндсэн шалтгаан бол нэгдүгээрт хуулийн тогтвортой байдал гэж бид үзэж байгаа. Түрүүн Шижир гишүүн дурдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг байнга өөрчилж, тухайн үеийн бодлогод нийцүүлэн хуулийг өөрчилдөг энэ байдлыг бол бид нар бай зогсоох ёстой гэж үзэж байгаа. Төсвийн тусгай шаардлагуудыг буцаан сэргээх ёстой бөгөөд хуулийн зөрчил дээр бид нар хариуцлага тооцож чадахгүй бол энэ нөхцөл байдал цаашаа үргэлжилсээр байна гэж үзэж байгаа.

Хоёрдугаарт нь яг өнөөдөр хэлэлцэж байгаа энэ төсвийн гүйцэтгэл, хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлүүдийг маш анхааралтай байж.../минут дуусав./

С.Бямбацогт: Би одоо ингээд минут нэмээд өгөхөөр Цогтбаатар гишүүний хэлж байгаа дэг зөрчих гээд байх юм. Тэгээд хариултыг нь өгүүлэх гээд тэгэхээр 40, 50-н төсвийн ерөнхий захирагчаас ингээд 40, 50-н минут, 1 минутад бүгд хариулна гэхээр яаж хариулах юм. Мөнхсоёл гишүүн тодруулъя.

Б.Мөнхсоёл: Ерөнхийдөө Үндэсний аудитын газар бол хэлж байна шүү дээ. Хариуцлага тооцох, яг хариуцлага тооцох эзэд нь хариуцлагыг нь үүрүүлдэг байя гэж хэлж байна. Энийг сонсмоор байсан.

Хоёрдугаарт Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Дэлгэрсайхан хэллээ энэ Төсвийн тогтвортой байдлынхаа тухай хуулийн төсвийн дүрмүүдээ яг хэрэгжүүлдэг байг. Энэ хоёрыг л хэлүүлмээр байсан хэлчихлээ. Төсвийн ерөнхийлөн захирагчдыг төлөөлөөд Сангийн сайд Мэндсайхан, Хэрэг эрхлэхийн сайд Энхбаяр хоёрыг хариулчхаасай гэж хүссэн боловч цаггүй юм байна. Би өөрөө хэлчихье.

Тухайлбал, гадаадын зээлийн тухайд валютын ханшны эрсдэлийн удирдлагыг шинэчлэхэд би энэнтэй санал нэгдэж нийлж байгаа байхгүй юу Засгийн газрын хэн нь хариуцахыг зохицуулах хяналтын механизмыг бий болгох хэрэгтэй.

Хоёрдугаарт төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийг хангахтай холбоотой Их Хурлаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн хамт тайлагнаж байх үүрэгтэй гээд ингээд маш чухал саналууд,

зөвлөмжүүд байгаа шүү. Дараагийн удаа бүгдээрээ энийг амьдралд бодитойгоор хэрэгжүүлэхийн төлөө.../минут дуусав./

С.Бямбацогт: Тэр түрүүчийн асуултад бас манай төсвийн ерөнхийлөн захирагч нар бичгээр бас хариулчхаарай. Цаашдаа бас их чухал хэрэгтэй зарчим ярьж байх шиг байна тийм ээ. Энхбаяр сайд. Шадар сайд Энхбаяр.

Ж.Энхбаяр: Гүйцэтгэл яагаад дутуу гараад байна, муу гараад байна? Саяхан бид нар төсвийн хүрээ баталсан. Юу боллоо өргөн барьснаас гадуур зураг төсөлгүй, санхүүгийн эх үүсвэргүй, тооцоо судалгаагүй, ажлын даалгаваргүй 206 санал гарсан шүү дээ. Яг л энэ байхгүй юу. Энэ чинь төсөв дээр хэрэгжилтээр очоод худалдан авалт дээр унана, хэрэгжилт дээр унана, аудит дээр унана.

Ингээд хэрэгжилт эцсийн гүйцэтгэл ярихаар гүйцэтгэл чинь дутуу гараад байна. Тэгээд энийгээ бид эргээд бид нар өөр өөрөөсөө асуугаад байгаа байхгүй юу. Би харин Улсын Их Хурлын гишүүдэд зураг төсөлгүй, санхүүгийн эх үүсвэргүй ийм төсөл, хөтөлбөрийг оруулж ирж батлах гэдгээ ч больчхооч ээ. Тэгвэл Засгийн газартай Их Хурал хариуцлага тооцох бололцоо ч нээгдэнэ. Яг 2 тал хяналт тавина. Батлагдсан хүрээнд гүйцэтгэлээ хий, аль, сал.../минут дуусав./

С.Бямбацогт: Одоо ингээд хариулаад байхад Цогтбаатар гишүүн та яасан олон хариулуулдаг юм гээд дэг зөрчинө больё. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя. Тэгэхдээ дутуу хариулуулахаар дутуу хариуллаа гэж, гүйцэд хариулуулахаар гүйцэд хариулууллаа гэнэ. Яах ёстой юм?

Д.Энхтүвшин: Дарга аа та микрофоноо хаачих уу. Тайлан хэлэлцэж байгаа нь ер нь бол бас ололт, амжилтаа дүгнээд болоогүй бол бас хариуцлагын тухай асуудал яригддаг. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар Засгийн газрын хувьд бол тусгай шаардлагаа ингээд зөрчихсөн байна. Тэгэхээр энэ хуулиар 18.3-аар Засгийн газрыг огцруулах ийм үндэслэл болохоор ийм хариуцлагын тухай асуудал яригдаж байна.

Тэгэхээр энэ дээр би зүгээр нэг санаа, энэ хууль дээр яг хариуцлага тооцъё гээд хуулийн заалтыг нь үзсэн чинь Үндсэн хуулийн 43.4 буюу Үндсэн хууль дээр байхгүй заалтыг эшилчихсэн ийм хуультай юм байна. Тэгэхээр Их Хурлын Тамгын газрынхан бас тэрийг анхаараад энэ хуулийг бас өөрчлөхгүй бол хариуцлага тооцуулахгүй гэж байгаа юм шиг хариуцлага тооцох заалт нь Үндсэн хууль дээр байхгүй зүйл, заалтыг эшлээд ийм алдаатай хууль байдаг юм байна энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр. Тэгэхээр энийг цаашдаа бас анхаарах хэрэгтэй юм байна.

Тэгэхээр энэ төсвийн тусгай шаардлагыг зөрчинө гэдэг бол Засгийн газрыг огцруулах хэмжээний үндэслэл болно. Тэгэхээр энэ өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудлаар бол Засгийн газар огцруулах хэмжээний ийм үр дүн гарсан байна аа гэдгийг бас тодотгож хэлье.

Дараагийн нэг асуудал нь болохоор энэ ТӨК-удтай холбоотой асуудлуудыг энэ Засгийн газрын тайлан дээрээс ч гэсэн харахаар ер нь бол яг л өөр тусдаа төсөв шиг өөрт нь хамааралгүй нийгмийн шинжтэй үйл ажиллагаанд 1.1 их наяд наядыг зарцуулчихсан байна. Бусад газруудад зээл өгчихсөн юм байна. Бараг 1 их

наядын Эрдэнэс, ТӨК-уд хоорондоо ингээд асар их хэмжээний зээлүүд шилжүүлдэг. “Эрдэнэс Тавантолгой” Жишээлбэл Багануур, Шивээ-Овоо зэрэг компаниудад зэрэг компаниудад бараг 1 их наяд төгрөгийн ийм зээл, урт хугацаатай зээл олгочихсон байна. “Эрдэнэс Тавантолгой” нь Богдхан төмөр зам, газрын тос боловсруулах, дамжуулах хоолойн гээд 1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын ингээд санхүүжилтийг ингээд хийчихсэн байгаад байна.

Тэгэхээр энийг сайжруулахгүй бол бид нар ингээд төсөв энд яриад хянаж байгаа юм шиг ийм дүр эсгээд нөгөө талд нь ийм цоорхой байгаа учраас энэ нь өөрөө жоохон утга учир муутай байгаад байна.

Тэгэхээр энэнтэй холбогдуулж бас нэг асуулт байгаад байна. Орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дээр 1 хувийн хөнгөлөлт байгаа. Энийг энэ ТӨК-уд эдлэхгүй биз дээ? Энэ талаар нэмэлт тодруулга өгөөч. Дараачийн асуух зүйл нь болохоор татварын орлого өнгөрсөн онд төлөвлөснөөс 2 их наядаар буурсан байна. 27.2 их наяд болж, 2 их наядаар буурсан байна. Тэгэхээр энэ яагаад төлөвлөснөөс буучхав, эдийн засгийн идэвхжил муу байна уу энэ талаар Татварын ерөнхий газраас бас тайлбарлаж өгөөч.

Дараагийн асуулт нь болохоор зарим аймгуудын гүйцэтгэл дээр энэ минут дуусаж байх шиг байна. Даргаа нь нэмээд асуучихъя.

С.Бямбацогт: Хэрэг эрхлэхийн сайд Энхбаяр хариулъя.

Б.Энхбаяр: Энхтүвшин гишүүний эхний асуултад хариулъя. 2025 оны төсвийн санхүүгийн жилийн тайланг бид сонсож байгаа. Энэтэй холбоотой бас Засгийн газрын хариуцлагын асуудал ярьж байх шиг байна. 25 оны санхүүгийн жилд ажилласан 2 Засгийн газар солигдчихоод хариуцлагаа үүрчхээд байгаа юм. 25 оны санхүүгийн жилийн тал нь Оюун-Эрдэнийн Засгийн газар, Монгол Ардын нам, Ардчилсан намын хамтарсан Засгийн газар энэ санхүүгийн тайлан ярьж байгаа. Тэр нь болохоор өнгөрсөн оны тэр хүн нь хариуцлагаа үүрээд огцорчихсон. Их Хурал итгэл үзүүлээгүй.

Тэгэхээр нөгөө Оюун-Эрдэнийн болон Занданшатарын Засгийн газрын төсвийн гүйцэтгэлийг Учралын Засгийн газар юу гэж сонсож байгаа л гэж ингэж бас ойлголцвол их зүгээр байна.

С.Бямбацогт: Хэн хариулах нь вэ нэмж? Болчихсон уу? Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ Төрийн өмчтэй холбоотой, ялангуяа эрчим хүчний салбартай холбоотой асуудлууд ингээд ужгираад улам хуримтлагдаад байгаа. Нүүрс олборлолт нь үнийн зохицуулалттай. Нүүрс тээвэр нь тээврийн хатуу үнийн зохицуулалттай. Цахилгаан үйлдвэрлэл, цахилгаан түгээх, дамжуулах нь хатуу үнийн зохицуулалттай. Ингээд энэ эрчим хүчний салбар эдийн засгийн хувьд өгөөжтэй ажиллах бололцоогүй. Уурхайн шинэчлэл, хөрөнгө оруулалт, техникийн асуудлыг нь толгой “Эрдэс Монгол” компаниас бусад компанийн олсон ашгаас тэнд хөрөнгө оруулалт хийж, зээл олгож ингэж авчирч аваад. Тэгэхээр бидэнд юу хэрэгтэй гэвэл эрчим хүчний салбарыг либералчлах, чөлөөлөх энэ бодлогын суурь

асуудлыг л Их Хурал шийдээд өгөх хэрэгтэй. Ингээд төрийн өмчийн компаниуд хоорондоо зээл, өр, авлага үүсгэхийг хорьчих хэрэгтэй.

Нөгөө талаас нийгмийн үүрэг хүлээхийг хязгаарлах хэрэгтэй. Тэгээд тэр хууль, эрх зүйн орчнуудаа хийгээд өгөөч л гэж бас. Их Хурлын.../минут дуусав./

С.Бямбацогт: Отгоны. Татварын Ерөнхий газар Цогтнаран дарга хариулъя. Сангийн сайд хариулъя Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Тэр ТӨК-удыг бас юун дээрээс чөлөөлөх асуудлыг асуусан та. Татварын орлого буурсан бол татвартай болоогүй. Энэ гаалийн татвар өнгөрсөн жил импортын таслал үүссэнтэй холбоотойгоор гаалийн татвар болсон. Татварын аж ахуйн нэгжийн орлогын татвар бол давж биелсэн байгаа.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Яг асуусан асуултуудын хариулт бас авч чадсангүй ээ. Би 1 хувийн талаар асуусан. Тэрийг бас хариулж хариулсангүй. 2 их наядаар буурсан нь бас яг Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар чинь хоёулаа буучихсан байна л даа. Хүн амын орлогын албан татвар бүгдээрээ буучихсан байна лээ л дээ. Тэгэхээр юутай зөрөөд байна л даа. Тоотой дээр нь тодруулж асуух зүйл байна. Энэ нөгөө 5 сарын 31 өмнөөс төсвийн худалдан авах үйл ажиллагааны газрын төсвүүд татагддаг. Тэгэхээр энэ жилүүдэд 25 он болон 26 онд хэчнээн хэмжээний төслүүд татагдав, энэ юу юунаас болов гэдэг талаар хариуцсан сайдаас нь асууя.

Дээр нь энэ орон нутгийн төсвүүдээс жишээлбэл, Говь-Алтай аймаг унаа энэ хоолны хөнгөлөлт дээр 387 хувь, Увс аймаг тавилга авах 150 хувь, Хэнтий байрны түрээс 180 хувь гээд юу батлагдсан төсвүүдээ ингээд зарим аймгууд нь хэтрүүлчихсэн байна л даа. Тэгэхээр энэ нь ямар шалтгаанаар цөөн энэ аймгууд нь хэтрүүлээд, бусад нь яг 100 хувь дотроо батлагдсан зардлынхаа хэмжээндээ зарцуулалтаа хийгээд байгаа юм? Энэ талаар тайлбар хийж өгөөч.

С.Бямбацогт: Сангийн сайд хариулах у? Худалдан авах уу? Доржханд сайд. Батзул дарга. Доржханд сайд. Шадар сайд Доржханд.

Т.Доржханд: 2025 онд 535.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 129 төсөл, арга хэмжээ хийгдсэн. Үүнээс бол 221 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 69 төсөл, арга хэмжээ бол хэмнэлтэд бол тооцогдсон байгаа. Яагаад хэмнэгдэж байна вэ гээд тэгэхлээр түрүүн бас тайлбарлаж байгаа 5 сарын 31-нээр Төрийн хэмнэлтийн хуулийн 13.1.1-д заасны дагуу батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 5 сарын 31-нд бүрэн дуусгана аа гээд.

Тэгэхлээр зураг төсөл, ажлын даалгавар байхгүй. Тэгээд эх үүсвэр нь бас тодорхойгүй. Зохион байгуулалт нь хийгдэж амжаагүй ийм төслүүдэд бол 5 сарын 31-нд Хэмнэлтийн хуулиар бол хэмнэгдэж байгаа.

С.Бямбацогт: Татварынхан аймгуудын зардал нэмэгдсэн талаар гэж. Тэгээд зардалтай холбоотой асуудал төсвийн Санжаадорж дарга хариулах уу? Төсвийн бодлогын газрын дарга Сангийн яам. Яг ингээд л гишүүдийн асуултад

гүйцэд хариулт өгдөггүй, дутуу хариулт дээр бичгээр өгөх шаардлага гарч байгаа юм. Худлаа хариулт гэх юм бол худлаа хариулт дээр бид нар хариуцлага тооцох гэж Улсын Их Хурлын Тамгын газрынхан сууж байгаа юм. Амьхандаа л дэг сахиулах гээд л ингээд л үзээд л байгаа юм л даа. Санжаа дарга.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Аймгуудын хувьд бол Төсвийн тухай хуульд бол заасны дагуу урьд оны үлдэгдлээс бол зардлаа нэмүүлээд бол батлаад ингээд хэрэгжүүлэх боломжтой байгаад байдаг. Үүнийх нь дагуу бол зардлаа нэмэгдүүлж батлуулсан бол аймгууд бол байгаа. Ер нь бол бүх аймаг бол нэмэгдүүлж байгаа. Тэр дундаа бол нийслэл бол хамгийн өндрөөр нэмэгдүүлсэн байгаа.

Түрүүн бас асуултад гарч байсан 2026 онд энэ нөлөөлөх үү гээд. Нийслэлийн хувьд бол төсвийн хүрээний мэдэгдэл дээр Улсын Их Хурлаас баталсан зарлагын хязгаар 3 их наяд тогтоол энэ жил бол 7.8 гээд баталчихсан байгаа. Тэгэхлээр тэр хэмжээгээрээ зарлагаа нэмэгдүүлэх ийм асуудал үүсэж байгаа.

Түүнчлэн бол яг гүйцэтгэлийн хувьд бол бас зарлага бол хэтэрч гарсан ийм тохиолдлууд бол аймгуудын хувьд гарч байгаа. Энэ дээр бол бас аймгийн хувьд бол яг Сангийн яамнаас шууд энэ дээр бол хяналт тавихад бол бас одоогийн хуулиар бол боломжгүй болчихоод байгаа. Тэндээ бол бас .../минут дуусав./

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Би түрүүн хэлсэн санаагаа давтаад бас хэлчихье. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бол яг энэ төсвийн хэлэлцүүлгийн хамгийн чухал хариуцлага тооцдог энэ сахилга батыг хангуулдаг ийм зүйл, заалт байгаа. Тэгэхээр энэ зүйл, заалтын хариуцлага тооцдог хэсэг маань хуульд нийцэхгүй, хуульд байхгүй зүйл, заалтыг эшилчихсэн байна.

Тэгэхээр энийг өөрчлөхгүй бол энэ хариуцлага тооцох бололцоо, боломжгүй ийм зүйл, заалт байна. Тэгэхээр энийг Засгийн газар байна уу өөр газар санаачилж явахгүй бол. Үндсэн хуулийн 43.4 гэдэг заалт байхгүй. 43 дугаар зүйлд хоёрхон зүйл, заалттай зүйл дээр энийг бол зүгээр хөндлөнгөөс харвал хариуцлага тооцуулахгүй гэсэн жишээлбэл Засгийн газрыг огцруулах үндэслэл болохоор ийм том хариуцлага байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг ийм хариуцлагагүй байж болохгүй. Энэ хууль тогтоомжийн нийцлүүдийг хангах үүднээс Засгийн газар байна уу энэ өөрчлөлтийг оруулж ирэх хэрэгтэй гэж тодотгож хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Хууль хоорондын нийцлийн асуудал ярьж байна. Тийм болохоор бас хуулийг хооронд нийцүүлэх ёстой. Сая Цогтбаатар гишүүний маргаан ч гэсэн бол бидний баталсан хууль хэрэгжүүлж байгаа хууль маань амьдрал дээр яг бодитой сайн хэрэгжиж чадахгүй, үр дүнтэй хэрэгжиж чадахгүй байгаа учраас тэнд нэг нь асуусан болдог нөгөөдөх нь хариулсан болдог. Ингээд үр дүнгүй, чанаргүй хэлэлцүүлэг яваад байгаа болохоор бухимдаж байна. Үүнийгээ шийдэх гээд хуулийн төсөл санаачилчихсан байж байгаа. Одоо асуултыг ганцхан 4 минутаар 1 удаа асуугаад 4 минутад нэг хариулаад нэмэлтээр 2-хон

удаа 1, 1 минутаар хариулна гээд ингэдэг. Мөнхсоёл гишүүн энэ дээр сая бүх сайд нараас асуучихлаа. Хариулах боломж байхгүй хариулуулах.

Гэтэл нөгөө талд нь асуудал байгаад байна. Хууль зөрчсөн, маргаантай, хэл ам дагуулсан. Энийгээ бид нар шийдэж чадахгүй болохоор л бухимдаж байна шүү дээ. Сая ч гэсэн бас ингээд ярьж байхад Улсын Их Хурал дээр бичгээр хариулт өгчхөөрэй гээд хэлэхээр бичгээр хариулт өг гэсэн байгууллагууд нь өгдөггүй. Манай бас Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газар Энхбат дарга аа Монголбанкныханд бичгээр хариулт өгье өө гэж Цогтбаатар гишүүнээс Монголбанкны төлөөллөөс Монгол төгрөг бусад валютын, бусад улс орны валютын хэзээ чангарч эхлэх талаар, ипотекийн зээлийн хүртээмж хэзээ нэмэх талаар ямар бодлого барих талаар асуулт тодорхой хариулт авъя аа гэсэн. Өгч чадахгүй байсан. Энд бичгээр хариулт өгөөрэй гэж хэлсэн. Одоо болтол Монголбанк хариулт өгөөгүй байж байна. Энд хариуцлага тооцох ёстой бас.

Иймэрхүү байдлаар ингээд бичгээр хариулт өгчих гэж хэлдэг. Хэн ч өгөхгүй байна шүү дээ гэж Цогтбаатар гишүүн бухимдаж байна бас. Иймэрхүү бидний хууль маань бас амьдрал дээр бас сайн нийцэхгүй байгаа, хуулиа зөв сайн хэрэгжүүлж чадахгүй байгаагаас болж ингээд Их Хурлын гишүүд хоорондоо асуудалд ордог. Энд хэлэлцүүлгийн чанаргүй, хэлэлцсэн болдог, асуусан болж хариулсан болдог ийм чанаргүй л хэлэлцүүлэг болоод байна шүү дээ. Энийг чанартай болгох талаар бас манай Тамгын газрынхан энэ чуулган завсарлагааны хугацаанд хуулийн төсөл бас боловсруулъя. Анхааръя.

Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу? Тогтвортой байдлын зөвлөлөөс ийм дүгнэлт өгсөн байна. Үр дүнд чиглэсэн тогтолцоонд шилжих шаардлагатай байна. Засгийн газраас дараа жилийн төсвийн төлөвлөлт, төслийг боловсруулан өргөн мэдүүлэхдээ тухайн жилд хэрэгжүүлэх төсвийн бодлого, зорилт, зорилгыг нарийвчлан тодорхойлж, үнэлэх үнэлгээ, шалгуур үзүүлэлтийг гардаггүйгээс шалтгаалан тухайн жилд авч хэрэгжүүлсэн төсвийн бодлогыг үнэлэх боломж хязгаарлагдмал байна гэнэ ээ. Тэгэхээр энэ төсөв ер нь үнэлэгдээгүй юм биш үү? Одоо ингээд яг энэ дүгнэлтийг харах юм бол тийм байгаа байхгүй юу.

Хамгийн нарийн тэр шалгуур шалгууртай холбоотой юмыг асууя л даа. Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн дэмжих сангаас асууя. 2025 онд Эрүүл мэндийн дэмжих сангаас хамгийн олон тоогоор санхүүжилт авсан оношны хамааралтай бүлгийг нэрлэе. Эхний 10-ыг ч юм уу нэрлэе. Нэрлээд тэн дээр аль аймаг хамгийн олон санхүүжилтийг авсныг нь нэрлэнэ ээ. Нэрлээд оношны хамааралтай бүлгээ нэрлэлээ, аймаг орон нутгаа нэрлэлээ. 2 дугаар алхам.

Гуравдугаар алхам яах вэ гэхээр тэр оношны хамааралтай бүлгийн өвчнүүд дотор аль нь нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шугамаар сэргийлэгдэх боломжтой өвчнүүд гэдгийн жагсаалтаас гаргаад л хэлээдэх дээ. Та нарт байгаа угаасаа.

Хоёрдугаар асуудал нь манай энэ Гэр бүлийн яамнаас ирсэн энэ нөгөө гүйцэтгэл дээр яг ийм муу сурдаг хүүхдийн амийг ингээд би бараг 2, 3-н жил дараалж ер нь дандаа харах юм. Яагаад муу сурдаг гэхлээр хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүсийг иргэний төрөлхийн болон алдагдсан чадамжийг боломжит дээд хэмжээнд сэргээнэ гэсэн байгаа. 2025 онд хүмүүсийг сэргээсэн юм гэнэ ээ. Яаж сэргээсэн гэсэн чинь хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэнээс биеийн үйлдэл, үйл ажиллагааны олон улсын стандарт ангиллын дагуу үнэлгээ хийлгээд тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэд гээд 5 хувь гэж зорилтот түвшин 9.3 хувь болсон гэнэ ээ.

Яаж тийм болсон юм бол гэсэн чинь зүгээр судалгаа авсан байгаа юм. 48 мянган иргэдээс судалгаа авсан гэнэ. Тэр судалгаанд судалгаа авч байна аа. Ер нь тэгээд авч байна аа гээд дүгнэчихсэн байх юм. Энэ чинь тэгээд улсын төсөв төлөвлөгөө ийм байж болдог юм уу?

Хоёрдугаарт нь төрөлхийн болон алдагдсан чадварыг сэргээсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэнэ. 2025 онд 16 хувь байсан чинь 14 хувь болж багассан гэнэ. Тэгээд яаж багассан юм бол гээд харсан чинь 25 онд 2000 хүн 18-аас дээш насны 2000 хүн 0-18 насны 572 хүүхэд хөгжлийн бэрхшээлээ цуцлуулсан гэнэ ээ. Би хөгжлийн бэрхшээлтэй байхаа болилоо намайг хасаад өг гэсэн юм уу? Эсвэл та нар ингээд сэргээн засах үйлчилгээ хийгээд энэ хүмүүст бэрхшээлтэй байхаа больчихсон юм уу? Энэ юу болоод энэ 3000 орчим хүн ингээд хөгжлийн бэрхшээлтэй байхаа больчихсон юм? Энийг тодруулъя. Тэгээд энийгээ та нар төрөлхийн болон алдагдсан чадварыг нь сэргээсэн гэж нэрлэх юм уу, яаж сэргээсэн юм? Энэ дээр тодорхой хариулаадах даа 2 яам 2-уулаа тус тусдаа.

Аубакир сайд. Бакир сайд байхгүй нь. Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам Төрийн нарийн байна уу? Аубакир сайдыг дуудаарай. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Аубакир. Төрийн нарийн хариулж байж болох уу? Төрийн нарийн бичгийн дарга нь байна уу? Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга сайд алга, Төрийн нарийн алга яах вэ? Үгүй энэ чинь энд илүү чухал ажил явж байгаа биз дээ? Тийм тэр бол хүндэтгэн үзэх шалтгаан огт биш. Энхбаяр сайд хариулах уу? Тэгээд яах юм тэгээд? Эс үгүй бол чуулганаа зогсоох уу? Орж ирэхээр нь хариулчхаж болох уу Саранчулуун гишүүн дуудуулаад? Тэгье тэгье тэгвэл орж ирэхээр нь хариулъя. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя. Бакир сайдыг дуудаарай. Орж ирэхээр нь хариулъя.

С.Эрдэнэбат: Зарим Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалалтай холбоотой асуудал байдаг. Холбоогүй хэсгийг нь асуучихъя тэгвэл бусад яамдаас нь.

Нэгдүгээрт энэ Ахмадын сан гээд хуульд байдаг нийт цалингийнх сангийнхаа 3 хувийг тавих ёстой төр, хувийн хэвшилгүй. Гэсэн чинь манай төрийн байгууллагууд чинь ерөөсөө энийгээ байгуулдаггүй юм байна. Өөрөөр хэлбэл, тэр ахмадууддаа зориулаад Ахмадын тухай хуулийн дагуу нийт цалингийн сангийнхаа 3 хувийг бол тавьж зарцуулах ёстой гээд. Сая нэг чуулган хийх гэсэн хөөрхий ахмадууд бараг өөрсдөөсөө зарим нь мөнгөө гаргалаа шүү дээ. Тэгээд сая ингээд харсан чинь хурал зөвлөгөөнийг чинь харсан чинь 163 тэрбум төгрөг зарцуулсан гээд байж байдаг. Одоо яг сонсоход бол жоохон ичмээр л юм харагдаж байна л даа. Уул нь бол тэр сан нь байгаад яавал юу яадаг юм гэж. Тийм учраас тэр Ахмадын санг байгуулах тал дээр яг хэн нь хариуцаж байна аа? Засгийн газрын Хэрэг эрхлэх хариуцаж байна уу яаж байна вэ? Энэ тал дээр аудитын дүгнэлт гарсан. Энэ тал дээр тодорхой бас ямар хариу авсан бэ, хийсэн бэ гэдгийг нь асууя.

9 хувийн цомхотгол гээд хийсэн түрүү жил. Энд яг ямар хүмүүс чөлөөлөгдсөн бэ? Хөдөө гадаа сураг сонссон чинь хөөрхий энэ муу сумын төвийн 27 ажилтны харуул, манаач, жижүүр нь тэд нар л голцуу л тайрагдсан юм шиг байна лээ. Тийм учраас энэ 9 хувийн цомхотголоос хэчнээн хүн нь халагдсан яасан бэ? Би бол ер нь бол энэ цомхотголыг бас тэгшитгэж бүгдийг нь аваад шийдчих нь буруу гэж үзэж байгаа. Одоо тэгээд цаашдаа яг яаж байгаа вэ гэдгийг нь асууя.

Гуравдугаарт ажлаас халагдсан хүмүүсийн зардлын асуудал байдаг. Манай Ажилгүйдлийн даатгалын сан хүрэхээ байсан. Нэг хүн хүрч ирээд л баахан тэр оптоор нь сольдог. Энэ дээр хэдэн төгрөг гаргаж байгаа вэ? Нийгмийн даатгалын сангаас төрийн байгууллагуудаас халагдсан хэчнээн төгрөг гарсан бэ, хэн төлсөн төлөх вэ?

Гуравдугаарт манай төрийн өмчит энд хэчнээн машин байна вэ? Тэрийг тодорхой хэлж өгөөч гэж. Тендерийн асуудал дээр буцаан таталт нэлээн олон асуудал гарсан байна. Арайхийж юм төсөв дээр жижиг сажиг юм оруулаад өгсөн. Тэгээд сумынх нь төсвийг ч буцаан татчих юм. Тендерт тавьсан юмыг ч буцааж татчих юм. Зарим нь бүр албаар тэгдэг гэж байгаа. Албаар компани өрсөлдөж гомдол гаргуулж байгаад буцаан татуулах ажиллагааг хийдэг. Эс үгүй бол буцаан татах нь хүртэл нөгөө талдаа гомдол гаргасан хүмүүс нь ханштай байдаг ч гэнэ үү ийм зүйлийг битүү ярьж байна. Тэгээд энэ тал дээр хариулт өгөөч. Энэ дээр цэгцлэх юм юу байгаа юм бэ гэж. Ийм зүйлийг бол асуумаар байна.

Хөдөө орон нутаг дээр бас зарим газрууд дээр явчихаар ашиглалтын зардал гээд хасаад хаячихсан бөөн өрөнд байх юм. Тэгээд сүүлд нь энийг асуухаар яасан бэ гэхээр багш, эмч нарын цалин нэмэгдэхээр нь сургуулийнх нь халаалтын зардал тэр уурын зуухных нь зардлуудыг хасчихсан гээд байдаг. Энэ дээр энэ тал дээр хариулт өгөөч ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Аубакир сайд хариулъя. Ард дээр нь Доржханд сайд хариулчихъя.

Т.Аубакир: Тийм Саранчулуун гишүүний асуултаас эхлээд хариулъя. Бид нар 2020 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ зориулсан үйлчилгээ, тэтгэвэр, тэтгэмжийг үргэлж нэмсээр ирсэн. Улсын Их Хуралд Баясгалан гишүүн, Саранчулуун гишүүн нар орж ирснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг илүүтэй төр засгийн ажилд ойртуулах, ойлгуулах ажлыг хийгээд явж байгаа.

Бид нар энэ оны 11 сар гэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ агентлаг дээр үндсэндээ дахин инженерчлэл хийж байгаа. Яг одоо энэ зорилтот бүлэгтээ хүрч байна уу, чанартай үйлчилгээнүүд түгээж чадаж байна уу? Аймаг сумууд, аймгууд дээр болон дүүргүүд дээр байгуулагдаж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэмжих төв гэж бид нар ярьдаг сэргээх энэ үйлчилгээнүүдээ бид нар маш чанартай түвшинд хийж байгаа. Гэхдээ л бас л чамлалттай.

Тийм учраас Саранчулуун гишүүний асуудаг, үргэлж анхааруулж байдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ үйлчилгээг чанартай байлгах, тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг бид нар сайжруулах хүрээнд бид нар олон улсын та бид хоёр

бол байнга ярьж байгаа олон улсын стандарт Ай Си Эф-ийг Монгол Улсад нэвтрүүлэх ажлыг гардан гүйцэтгэж байгаа. Бид нар энэ Ай Си Эф гэдэг энэхүү үнэлгээг бид нар Монгол Улсад нэвтрүүлэх ёстой.

Яг өнөөдрийн байдлаар Монгол Улсад үндсэндээ хөдөлмөрийн чадвар алдалтыг л үнэлж байгаа болохоос биш хэдэн хувийн хөдөлмөрийн чадвартай байгаа юм бэ гэдгийг нь бид нар төдийлөн ярьдаггүй. Тийм учраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал бас энэхүү төрийн үзүүлэх ёстой үйлчилгээнээс хоцрохгүй явж байгаа.

Эрдэнэбат гишүүн асуулаа. Ажилгүйдлийн сан дээр бид нар энэ өнгөрсөн оноос гаргаад төрийн албаны энэ цомхотголын асуудлыг ярьсан. 9 хувь буюу нийтдээ 14400 иргэний 9 хувьдаа хүргэх юм бол цомхотголд оруулах ёстой байсан. 7800 орчим төрийн албан хаагч цомхотгогдсон байх ёстой. Бид нарын Ажилгүйдлийн энэ тэтгэмжийн энэ сан маань дутагдлын бас нэг үзүүлэлт нь бол энэ бид нар 2025 онд 90 орчим тэрбум төгрөг төвлөрсөн. Хүрээгүй 11 сараас тасалдалтай байсан. 2026 оны улсын төсөв дээр бид нар 192 тэрбум төгрөгийг Ажилгүйдлийн сан дээрээ тавьж өгсөн. Гэхдээ бид нар үүнийгээ дагуулаад ажилгүйдлийн энэ сангаас зүй бусаар байдаг юм уу, зохиомлоор ажилгүйдлийн тэтгэмж авдаг байдал дээр бид нар журмыг өөрчилж байгаа.

Өмнө бол ажилгүйдлийн сангаас тэтгэмж авах эрх нь үүсэхдээ 9 хүртэл сар ажилласан байх ёстой. 76 хоногийн хоногтоо тэнцэх өдрийн цалинг авсан байх ёстой гэдгийг жоохон чангаруулж өгч байгаа. Яагаад гэвэл төрийн албанаас халагдсан иргэд аргагүй. Нөгөө талдаа хувийн хэвшил дээр байдаг ч юм уу, бусад салбарууд дээр зохиомлоор хоног хугацаагаа гүйцэтгэдэг. Тэтгэмжээ авсан мөртөө тухайн байгууллагадаа хэвээрээ ажиллаад байдаг маш олон тохиолдол бүртгэгдсэн. 192 тэрбум төгрөгийг зөвхөн ажилгүйдлийн тэтгэмжийг өгч байна гээд та бод доо. Бид нар энэ дээр тодорхой хэмжээний арга хэмжээ авах хэрэгтэй. Энэ хүрээнд бид нар 9 сар гэдгийг 12 сар, 76 хоног гэдгийг бид нар 55 хоног дээр авчирч байгаа.

Хэрвээ өөрийнхөө хүсэлтээр ажлаас халагдсан бол арай өөр нөхцөлд бас үйлчилнэ. Өөрийнхөө хүсэлтээр халагдчихаад бид нар энэ ажилгүй байх хугацааны л тэтгэмжийг өгч байгаа болохоос биш өөрийнхөө хүсэлтийг бичиж шидчихээд л тэтгэмж энэ чинь бас багагүй мөнгө байдаг 55 орчим, 76 орчим хоногтой тэнцэх цалин шүү дээ. Тийм учраас бид нар энэ Ажилгүйдлийн сангийнхаа алдагдлыг бууруулах хүрээнд бид нар журмаа хүртэл өөрчилж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Би яах вэ нийт Ажилгүйдлийн сан сангаас илүүтэй төрийн албанаас хэчнээн хүн халагдав? Энэнээс бас энэ чинь нэг талаасаа хүн халахад амархан. Нөгөө талд нь тэр чинь санд очиж ачаалал үзүүлнэ. Тэгээд энэ төрийн байгууллагуудаас аль яамдаас хэчнээн хүн яаж халагдсан бэ? Энэ чинь ингээд ажилгүйдлийн даатгалд чинь хамгийн том үүрэг гүйцэтгээд байгаа байхгүй юу. Энийг би тодруулж асуумаар байгаа юм. Тэр Ахмадын сантай холбоотой юмыг бас хариулаад өгчхөөрэй.

Нэмээд асуухад Аубакир сайдаас асуухад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн даатгалын сан бол их үлдэгдэлтэй мөнгө байгаад байна гээд. Энэ бол хадгалдаг сан биш шүү дээ. Маш их осол аваарууд гараад байгаа. Энийг хадгалж зарцуулахгүй авч үлдсэний чинь төлөө хэчнээн хүн амь насаа, эрүүл мэндээр хохиров оо? Тэгээд одоо орж ирж байгаа хууль дээрээ болохоор тэр том том уул уурхайн компаниудын төлдөг тэр шимтгэлийг нь бууруулчихъя гээд ингээд аваад ороод ирдэг. Тийм учраас энэ даатгалын сантай холбоотой хэдэн төгрөг зарцуулсан бэ юунд зарцуулсан бэ гэж би асуумаар байна Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн юман дээр.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг 4 номерын микрофон.

Б.Анар: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Анар. 2024 онтой харьцуулаад үзэхэд төрийн албан хаагчдын тоо нийт 226.8 мянга байснаас 213.6 мянга болж нийтдээ 13.2 мянгаар яг төрийн албан хаагчдын тоо бол буурсан байна. Энэ бол яг манай Төрийн сан дээр явдаг цалингийн сангаар цалин авч байгаа ажил, албан хаагчдын тоо байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Түрүүн Доржханд гишүүнээс асуулт асуусан. Доржханд гишүүн.

Т.Доржханд: Зөв зөв одоо ингээд худалдан авах ажиллагаанд оролцлоо гэхэд 20 компани орлоо гэхэд 1 нь шалгардаг 19 нь гомддог. Гэхдээ гомдол их гардаг үнэн. Тэгээд гомдлын хугацаа нь болохлоороо ажлын 10 хоногт шийдвэрлэдэг. Ингээд ирэхлээрээ тэгээд гэрээ байгуулах үе шат гээд ингээд явахлаар дор хаяж 45 хоног бол хэрэгтэй болдог. Тендер шалгаруулалт нь бол нээлттэй явдаг 30 хоногоор гээд.

Тэгэхээр энэ дээр бол ингээд асуудал бол үүсдэг. Гэхдээ үр дүн бол гарч байгаа шүү Эрдэнэбат гишүүн юу вэ гээд тэгэхлээр 2025 оноос өмнө бол 2 тендерийн 1 нь бүтэлгүй болдог байсан юм. 50 хувь нь. Гэтэл одоо бол 85 хувь нь бүтэлтэй болж байгаа юм. Тэгээд 25 онд бол 535.9 тэрбум төгрөгийн 129 төсөл, арга хэмжээ нь бүтэлгүй болж байсан бол 26 онд 221-ээс 69 л нь гээд үр дүн ингээд гараад л яваад байгаа юм. Аль болох л бид.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Т.Доржханд: Тэгэхээр улсын төсөв батлагдсан л бол батлагдсан даруйд нь яамнууд руу тэгээд холбогдох төсвийн эрх захирагч нар руу албан бичиг явуулаад тэгээд холбогдох ажлын даалгавар болон зураг төслийг нь яаралтай ирүүл гэсэн арга хэмжээ аваад тэгээд худалдан авах ажиллагааг ерөөсөө л 01 сарын 01-нээс эхлээд явуулчхаж байгаа шүү дээ. Тэгээд маш зохион байгуулалт шуурхай явуулдаг. Худалдан авах ажиллагааг бид нар бол 100 хувь явуулж байгаа юм.

Харин гэрээ байгуулах процесс нь 10-аас 15 хувьтай хийгдэхгүй явж байгаа нь бол энэ гомдол дээрээ байдаг. Тэгээд энэ хуулийн төсөл бас өргөн барихад бэлэн болчихсон байгаа. Манай Сайнзориг гишүүн бүхий нэр бүхий эрх бишүүд энэ хуулийн төсөл дээр бол та бүгд бас саналаа өгөөд явах нь зөв байх. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Аубакир гишүүн нэмж хариулъя.

Т.Аубакир: Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс мэргэжлээс шалтгаалсан хөгжлийн даатгалын сангийн зориулалтыг хуулиар заагаад өгчихсөн байгаа. 9 төрлийн зориулалтаар бид нар гаргах ёстой.

Нэгдүгээрт хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр олгох, тэжээгч алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, 1 удаагийн болон сар бүрийн нөхөн төлбөр, Даатгалын сангийн хуульд заасан удирдлага, үйл ажиллагааны зардлын санхүүжилт гэх зэрэг 9 зориулалт байгаа юм. Бид нар Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулиа боловсруулаад Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа. Энэ нь энэхүү хуулиар бид нар осол гарчихсаны дараа биш гарахаас өмнө урьдчилан сэргийлэх тал руугаа чиглэсэн үйл ажиллагаануудыг илүүтэй цуг тусгаж өгсөн.

Үйлдвэрлэлийн ослын тоо бол төдийлөн айхтар буурч өгөхгүй байгаа. Янз бүрийн хэлбэрээр бусад салбарын хариуцах ёстой асуудал хүртэл үйлдвэрлэлийн осол мэт харагддаг тохиолдлууд их бий. Тийм учраас маш тодорхой болгоод энэ сангийн зориулалтыг бид нар илүүтэй урьдчилан сэргийлэх рүү чиглүүлнэ. Хамгийн үлдэгдэлтэй үлддэг сангийн энэ.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Хуулийн тийм зүйлүүд бол бий. Гэхдээ яг ний нуугүй хэлэхэд энэ дээр хуулийнх нь манай төсөв дээр 0.5, нийт зардлынхаа 0.5-ыг аюулгүй байдалд зарцуулна гэж байгаа байхгүй юу. Сая тэр нүхэнд 1 хүүхэд унаад л үхлээ. Улс орон даяараа л тэрний буруу энэний буруу гээд л ингээд явж байгаа юм. Уул уурхайгаас асар их мөнгө орж ирдэг. Энд эргээд хүнийх нь аюулгүй байдал, орчин тойрных нь аюулгүй байдалд бид нар хөрөнгө зарахгүй байгаад байгаа байхгүй юу. Байгаа мөнгө нь түгжигдчихсэн. Хадгалахаас өөр байдаггүй. Хуульд нь байх гацчихсан. Одоо яах вэ оруулж ирж байгаа нь бол сайн. Тэр Нийгмийн даатгалын хуульд зарим юмыг нь нээж өгч байна лээ гээд.

Нөгөө талдаа энэ уул уурхайгаас орж ирж байгаа энэ өндөр өгөөжтэй байж байгаа алт, зэс, өндөр үнэтэй байгаа үед нь буцаагаад төлдөг юмыг нь бууруулъя гэдэг чинь би бол зарчмын хувьд Нийгмийн даатгалын санд хангалттай мөнгө байгаад байгаа юм уу гэдэг ийм зүйлийг хараад байгаа учраас тодруулж асуугаад байгаа юм л даа.

Ж.Бат-Эрдэнэ: Аубакир сайд.

Т.Аубакир: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас жил бүрийн 4 сараас эхлээд улс даяар бид нар хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдэд дээр очиж энэхүү арга хэмжээгээ танилцуулдаг. Энэ жилийн хувьд 21 аймаг 40 гаруй сум дээр бид нар хөдөлмөрийн аюулгүй байдлын хангаж ажиллах чиглэлийн хөгжил саяхан өнөө хагас, бүтэн сайн өдөр, амралтын өдрүүдээр манай яамны үндсэндээ Хөдөлмөрийн аюулгүй байдлын алба тэр чигтээ бүрэн очиж ажиллалаа. Өмнөговь аймаг дээр.

Яг таны хэлж байгаа зөв. Аж ахуйн нэгжүүдэд зөвхөн зөвхөн энэ ослын сан гэхээсээ илүү өөрсдөө хөдөлмөрийн аюулгүй байдлаа хангаж ажиллах ёстой. Сая та хэллээ 3 настай хүүхэд өөд болсон. Тийм хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой л асуудал Яг олборлолтын талбай дээр 3 настай хүүхдийг жишээлбэл энэ чинь насанд хүрсэн хүн хүртэл хамгаалах хэрэгсэлтэй л явдаг л шүү дээ. Энэ маань нөгөө хуваарьт шалгалтуудыг хориглосон бид нар шалгахгүй, бид нар ингэхгүй боломж өгч байна гэдэг маань энэ.

Гэхдээ зайлшгүй шалгаж, сануулж байх үйл ажиллагаа манай төрд бас хэрэгтэй шүү дээ. Үйлдвэрлэлийн ослын зарим сангууд сангууд дээр байдаг зарим зориулалтуудыг бид нар яг энэ урьдчилан сэргий.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Энэ жил жилийн төсвийн гүйцэтгэлийг харахаар нөгөө л хэв асуудлууд хэвээрээ. Хуучин асуудлууд. Ялгаагүй л нөгөө өгдөг зөвлөмжүүд. Магадгүй сүүлийн хэдэн жилийн энэ төсвийн гүйцэтгэлийн тайланг өгч байгаа зөвлөмж энэ тэрийг нэгтгээд харвал ялгаа байхгүй ээ. Тэгээд бид хэд үндсэндээ ажлаа хийхгүй, асуудлуудаа мэдээд байгаа мөртөө шийдвэрлэх гэдэг юм уу яг бодит алхам хийхгүй байна аа л гэдэг нь харагдаад байгаа юм шиг санагдаад байна.

Тэгэхээр ер нь энэ төсвийн төлөвлөлт, төсвийн хуваарилалт, төсвийн мөнгийг үр ашигтай зарцуулах энэ асуудал дээр засаг захиргаа нэгжийн энэ өнөөгийн байдал ер нь хэрхэн, яаж нөлөөлж байна аа? Энэ дээр хийсэн дүгнэлт байна уу? Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн бас хариулж өгөөч. Яг энэ засаг захиргааны нэгжийн энэ өөрчлөлтийн асуудал дээр Засгийн газар ямар байр суурьтай байгаа юм бэ? Энэ олон сумууд чинь ингээд байгаад байх нь зөв юм уу, эсвэл ер нь бид хэд чинь ямар салж нийлэх гээд байгаа биш дээ. Энэ нэг Монгол Улс. Энэ цахимжаад явж байхад олон л төрийн үйлчилгээг бас нэгтгээд аль ч засаг захиргааны нэгжээс авчих бололцоотой л байна. Энэ дээр юу хариулт хэлээч?

Хоёрдугаарт ер нь зүгээр маш энгийнээр яривал гадаад худалдаа бол 27 тэрбумд хүрсэн юм байна. Үүнээсээ бол үндсэндээ экспортын 1 15.8 тэрбум долларыг бол зөвхөн нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрээс орж ирж байгаа юм байна. Тэгээд энэ орж ирж байгаа валют бол маш цөөхөн салбараасаа байна. Хөдөө аж ахуй жоохон дэмтэй байж байна. Буцаагаад яг юунд зараад байна аа? Нефть бүтээгдэхүүнд байгаа байх, хүнсний бүтээгдэхүүнд байгаа байх, барилгын материал байгаа байх, аялал жуулчлалд зориулж байгаа байх. Архи, тамхи, машиндаа зарцуулж байгаа байх. Дээрээс нь энэ тээврийг бас зарцуулаад байх шиг байна. Нүүрс тээвэрт алддаг болчихсон. Яагаад гэхээр нүүрс тээврийн компаниудыг бүгдийг нь Хятадууд авсан.

Тэгэхээр энэ гадагшаа урсцуудад яг төлбөрийн тэнцэл дээр ямар чиглэлийн юмнууд нь яг топ 10 үзүүлэлт байна? Энийг яг жагсаагаад Эдийн засаг, хөгжлийн яам хэлье гээд. Ард иргэд маань мэдэг. Бид хэд энэ уул уурхайгаас орж ирсэн баялгийг ийм зүйлд зарцуулаад байгаа юм аа гээд. Тэгээд энэнээс юу хэлэх гээд байна гэхээр хөрөнгө оруулалтууд ерөөсөө байхгүй. Ажлын байр бүтээн байгуулалтад ерөөсөө бид хэд хөрөнгө оруулалт хийж чадахаа ч байлаа. Тэгээд

хийж байгаа бүх юмнуудыг зогсоож, харлуулдаг л ийм байдал руугаа орж байна шүү дээ. Тэгэхээр энийг тодорхой хариулт авъя.

Дээрээс нь энэ эдийн засгийн суурь капитал газрын асуудал байна. Газраа зөв төлөвлөж чадвал, газраа зөв менежмент хийж чадвал хаанаа уул уурхайгаа, хаанаа аялал жуулчлалаа, хаанаа бэлчээрийн мал аж ахуйгаа хийхээ бид хэд ярина. Энэ газрын шинэтгэл хэзээ орж ирэх вэ? Энэ газрын шинэтгэлүүд чинь явахгүй байж байтал энэ ойн тухай ч гэдэг юм уу ингээд салбар салбарын нийтийн өмчийн хуулиуд чинь орж ирээд байна. Энэ газрын асуудлаа шийдэхгүй бол хөрөнгө оруулалтыг татаж чадахгүй ээ. Уул уурхайгаа явуулж чадахгүй ээ. Ийм зүйлүүд байх юм. Энэ дээр ямар ч байсан нэг хариулт авъя.

Ж.Бат-Эрдэнэ: Сайнзориг гишүүний хариултад Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Эдийн засаг, хөгжлийн яам 4 номер.

А.Энхбат: Гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат. Тэгэхлээр бид нар энэ Төсвийн тухай хууль маань Засгийн газар улсын төсөв, орон нутгийн төсвийн хоорондын харилцаатай засаг захиргаатай холбоотой асуудлын хувьд төсвийнх нь хувьд бид нар хуучин тогтолцоо маань хэвээрээ явж байгаа.

Цаашдаа бол энэ төв болон орон нутгийн төсвийн хоорондын харилцааг шинэчлэх зайлшгүй шаардлагууд тулгарч байгаа. Өөрөөр хэлбэл үндсэндээ 5 аймаг улсын төсөвт төвлөрүүлдэг бусад аймагт татаас авдаг энэ байдал маань орон нутгийн төсвийн өөрийн эрх мэдлийг нь сайжруулах асуудалдаа бол хүндрэл учруулж байгаа.

Тийм учраас энэ бусад улс орнуудын орон нутгийн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл гэсэн энэ арга зүйг нэвтрүүлэх хуулийн өөрчлөлтийг хийх зайлшгүй шаардлага бол тулгарчхаад байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Эдийн засгийн яам хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам. Эдийн засаг, хөгжлийн яамнаас байхгүй юм уу? Газрын шинэтгэлтэй холбоотой хэн хариулах вэ? Хэрэг эрхлэхийн дарга Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Ер нь манай улс хөгжье гэвэл газрын шинэтгэл хийхгүйгээр хөрөнгө оруулагч татагдахгүй, эдийн засагчид тэлэхгүй. Ард иргэд ч гэсэн бодитой өмчтэй байх асуудал бол шийдэгдэхгүй. Өнгөрсөн парламентын үед бол Засгийн газраас газрын багц хууль, 5 хууль Улсын Их Хуралд өргөн бариад тэгээд сонгуулийн хэл амнаас жоохон айж зугтдаг сайд нар эргүүлж татаад ингээд явчихсан. Энэ Газрын хуулийн багц хуулийн ажлын хэсэг бол Сайнзориг гишүүн бид хоёр Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, газрын дарга гээд байж байхдаа ажлын хэсгийг нь анх ахалж 10 жилийн өмнө эхлүүлж байсан юм. Суурь судалгаа. Өнгөрсөн парламентын үед үед бол.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя товчхон бөгөөд хурдан хариулъя.

Б.Энхбаяр: Товч хариулъя. Нийтийн өмчийн хууль бол парламент дээр явж байгаа. Номинчимэг гишүүн ахалж байгаа. Нийтийн өмчийн хууль дотор Үндсэн хуулийн 6.2-т заасан газар, газрын хэвлий, байгалийн баялаг, ой, ус гээд ард

түмний мэдэлд байдаг өмчүүдийг бүгдийг нь суурь асуудлыг энэ Нийтийн өмчийн хууль дээр зохицуулж байгаа. Энэ хуулийг Улсын Их Хурал батлаад өгөх юм бол энэ хуулийн хүрээнд газрын багц хуулийг Засгийн газар Улсын Их Хуралд өргөн барина. Ерөнхий сайдын захирамжаар өнгөрсөн долоо хоногт миний бие өөрөө ахлаад газрын багц хуулийг боловсруулах Засгийн газар дээр ажлын хэсгийг ахалсан. Өнөөдөр ажлын дэд хэсгийг ахалж байгаа.

Бид бол нийтийн өмчийн хуулийн үзэл баримтлалтай цуг уялдуулж газрын багц хуулийг өргөн барина. Ингэхгүй бол Сайнзориг гишүүний хэлээд байгаа ойг нь сугалж аваад газар дотор тусгай хамгаалалттай газрыг нь сугалж аваад, газрын дотор ашигт малтмалыг нь сугалж аваад гэдэг юм.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Эдийн засаг, хөгжлийн яам хүн байгаа юм уу? Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Бид мөнгөө яаж зараад байна вэ гэж. Төсөв нийт төсвүүд нийт олж байгаа орлогынхоо үндсэндээ ингээд 80 хувь болж байх шиг байна. Нийгмийн даатгал, халамж, тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн мөнгө, цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал буюу энэ урсгал зардалд нийт олсон орлогынхоо 80 гаруй хувийг өгч байна. Ирэх онуудад 90 хувь руу дөхнө.

Үндсэндээ олсон орлогоо бид нар урсгал зардалдаа ингээд зарцуулаад байдаг ийм төсөвтэй болчихоод байгаа. Энийгээ энэ юунаас бүрдүүлж байна вэ гэвэл гол урсгал, нүүрс нэгдүгээрт.

Хоёрдугаарт.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя. Яг эдийн засагч юунд зараад байна гээд байна шүү дээ.

Ж.Энхбаяр: Аягүй олон юм гарна. Би тэгээд эсвэл бичгээр өгчихье дөө. Энийг 1 минутад яагаад ч амжихгүй байна шүү дээ одоо. Жишээлбэл, импорттой холбоотой юм бол хүнс, авто бензин, дизель түлш, эрчим хүч, барилгын материал манай гол импортыг дүүргэж байна.

Дараагийн ангилалд нь суудлын автомашин, ачааны тээвэр, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж гэсэн энэ зүйлд л бид нар үндсэндээ гол импорт буюу жилдээ 11.3 тэрбум долларын импорт авч дотоод хэрэглээгээ хангасан байгаа. Мөн аялал жуулчлал, тээвэр, боловсрол зэрэгт 3.1 тэрбум долларыг бид.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Энэ ажлын хэсгийнх нь түрүүн Бямбацогт даргад дурдсан 2 бүтэн хуудас хүмүүсийн нэрс дуудсан шүү дээ. Тэгээд энэ дотор яг бүтэн статистик мэдээлэл өгчих энэ хүмүүс нь, мэргэжилтнүүд нь яачихсан юм? Сайд бас дуудахгүй бол энэ олон хүмүүс дотроос яг саяын мэдээллийг бүрэн гүйцэд уг нь өгөх ёстой шүү дээ. Зайлшгүй шаардлагатай хүмүүсээ дагуулж орж ирэхгүй тэгээд л дүүрэн баахан хүмүүсээ ингээд дуудчихсан 2 талд, 3 талд, 4 талд ингээд битүү л байна шүү дээ.

Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: 3-хан минутад асуух юм. Тэгээд энэ бараг танхимдаа багтахгүй дарга нарыг бид хэд дуудчихсан байна. Зарим нь Үндсэн хууль танхимд байж байна. Би бараг ард иргэдээсээ жоохон ичээд байна аа. Ингээд төсвийн гүйцэтгэлээр ерөөсөө л нөгөө хуучин асуудлуудаа л яриад байдаг. Энд л болохгүй байгаа гээд шийдэж байгаа юм нэг ширхэг ч байхгүй. Тэгээд ер нь энэ төрийн албаны реформыг энэ намар хийвэл яадаг юм бэ? Одоо би Ардчилсан нам байдаг юм уу энэ ер нь манай бас намын хуучнууд ч гэсэн туршлагатай хүмүүс маань зөвлөөд зүйлээ хийе. Яг үнэндээ хэлэхэд ингээд дарга сэтэртэй хүмүүс ихтэй. Нэр томьёоноос нь эхлээд ядаж менежер болгодог юм уу энийгээ дагаад асуудлуудыг шийдэх, ёстой зохицуулах, ёстой ажлын араас явах ёстой гэдэг ойлголтыг нь өгөх ёстой байдаг юм уу яадаг юм бүү мэд. Энд мэдээлэлтэй хүн 1 ширхэг ч суухгүй байна шүү дээ. Бүгд унтаж байх шиг байна. Тэгэхээр одоо ер нь ийм зоригтой жоохон юмнууд л байгаа ормоор байна. Тэгээд энэ засаг захиргааны шинэчлэлийг хийх юм уу?

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр сайд Хэрэг эрхлэхийн дарга Энхбаяр.

Б.Энхбаяр: Сайнаа энд дотор унтаад байгаа төрийн албан хаагч байхгүй байгаа шүү. Энэ хүмүүсийг бас тэгж хэлж болохгүй. Үгүй. битгий энэ өөрөө 20 жил төрийн албанд байсан байж төрийн жинхэнэ албан хаагчдаа битгий ингээд гэнэт тэнгэрээс буучихсан юм шиг. Энд ажлаа хийж байгаа, хариуцаж байгаа л хүмүүс байгаа шүү дээ. Нэр цохоод яг тэр албан хаагчаас ийм асуулт асууж байна аа гэвэл энэ чинь босоод л хариулна шүү дээ. Нийтийн өмчийн хуулийг бол Хэрэг эрхлэхийн Тэргүүн дэд даргаар ахлуулаад юу Нийтийн албаны тухай хуулийн боловсруулах ажлын хэсэг бол гарсан. Ер нь ийм цогц шинэчлэл хийе гээд байгаа юм. Нийтийн өмчийн асуудлаа баталчихъя. Ингээд Нийтийн албаны тухай хуулийг баталчихъя Хоёрдугаарт нь. Засгийн газар бол Нийтийн албаны хуулийг боловсруулах ажлын хэсгээ гаргаад ажиллаж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр сайд аа энэ хоёр Энхбаяр хоёулаа л байна. Төрийн албыг бид бас гадарлана шүү дээ. Энд ирж байгаа мэргэжилтнүүд, газрын дарга нар компьютероо бариад сууж байдаг шүү дээ энэ чинь. Тэгээд пад асуусан асуултад пад дараад л зүгээр бүх мэдээллүүдийг гаргаад гаргаад л ингээд л өгчихдөг шүү дээ энэ чинь. Сая хэн хариулах вэ гээд зөндөө олон асуулаа шүү дээ. Нэг нь ч гэсэн би пад гээд босоод ирэхгүй л байна шүү дээ. Энийг л хэлээд байх шиг байна. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Би Энхбаяр сайд аа төрийн албаны яг үнэнчээр зүтгэж байгаа хүмүүстээ хайртай. Эд нарынхаа эрх ашгийг хамгаалж явна. Би нэр заагаад Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуулаа. Тэнд сууж байна хүн нь. Босож ирээд Монгол Улсад цугларсан валют юунд урсаад байгааг ард түмэнд хэлээд өгөөч гэхээр хэлж өгч чадахгүй байгаа биз дээ дүнгээр нь. 1.8 их наяд чинь бензин, туслах материалд гарч байна. 7, 800-н сая доллар чинь аялал жуулчлалд өгөөд байна. 600 сая доллар нь машинд гараад байна. Автомашин авч унаж байна. Дээрээс нь нүүрс тээвэр дээр дахиад 600-аад сая долларыг жил болгон алддаг боллоо. Энийг хэлээд өгөөч л гэсэн шүү дээ. Тэгээд бид хэд олж байгаа орлого нь зэс, нүүрс, төмрийн баяжмал мөртөө уул уурхайгаа дэмжихгүй байна. Энэ дээр яаж сэтгэлгээ олон нийтэд хандлагыг нь өөрчлөх юм бэ? Зөв мэдээлэл өгөөч л гэж би хүсэж байгаа юм.

Ер нь эдийн засгаа либералчлах энэ салбарууд буюу энэ тарифын зохицуулалттай салбаруудаа жагсааж байгаад энэ энэ дээр ийм цаг хугацаанд тарифыг нь тэгж сулруулна гээд эсвэл Улсын Их Хурал бодлогоо оруулж ирээд энэ явж болох уу? Ер нь ийм хувилбар байж болох уу Эдийн засаг, хөгжлийн сайд Энхбаяр?

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр сайд Эдийн засаг, хөгжлийн сайд.

Ж.Энхбаяр: Энэ бүх тоонууд энд байж л байна л даа. Энэ чинь их дэндүү их материал тоо надад ногдож байгаа 1 минутад багтахгүй байна шүү дээ. Богинохондоо бол нийт олж байгаа орлого чинь урсгал зардлаа санхүүжүүлээд дуусчхаад байна. Эдийн засгаа тэлэх хэрэгтэй байна. Шинэ Оюу толгой, шинэ Тавантолгой, шинэ төмөр зам, шинэ эрчим хүчийг барьж байгуулах хэрэгтэй байна.

Гэтэл төсвийн маань бодит чадавх маань хүрэхээ больчихлоо. Урсгал зардлын хэт нэмэгдэл ийм төсвийн хөрөнгө оруулалт хийх чадавхыг нэлээн муутгачихлаа. Иймд эдийн засгаа либералчлах, бизнесийн эрх чөлөөг тэлэх, шууд хөрөнгө оруулалтыг татах, дэмжих, бизнесийн орчныг сайжруулах ийм хууль, эрх зүйн орчин бодлогуудыг оруулж ирээд байна. Гадаад зээлийнхээ ашиглалтыг сайжруулж байна. Хоёр том төслөө төсвийн үр гадна гаргаж байж бид нар гадаад зээлийн ашиглалтаа сая гишүүдийн шүүмжлээд байгаа тэр эх үүсвэрийн хүү төлөөд байгаа зээлүүдийн ашиглалтыг сайжруулъя гэж оруулж ирлээ.

Ж.Бат-Эрдэнэ: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Манайх чинь зах зээлийн нэртэй. Ингээд социалист шахам эдийн засагтай орон болчихсон. Тэрнийх нь гуравны нэгээс дээших нь зөвхөн төсөвт хамаардаг. Тэгээд төсвийн гүйцэтгэлийг ярьж байна. Өчигдөр төсвийн гүйцэтгэлийн материал энэ хэдэн хуудас чинь ийм цаас ирээд өнөөдөр хэлэлцээд. Ер нь жилийн жилд ингэдэг учраас бид нар энэндээ дүгнэлт хийдэггүй, гүйцэтгэл дээрээ ярьдаггүй учраас, ярьдаггүй учраас бид нарын төлөвлөлт ийм сул. Жилдээ энэ парламент 2 жилийн хугацаанд 5 удаа ч билүү төсөв тодотгочихсон.

Яагаад гэвэл энэ гүйцэтгэл дээрээ хэн ч ач холбогдол өгч ярьдаггүй. Улсын Их Хурал нь хэдэн цагийн дотор хэдэн мянган хуудас материал өгөөд энийг хуульд хэлчихсэн болгож ингэж өнгөрдөг. Энэ бол үнэхээр бид нарын хувьд бүгд цааш цаашдаа дүгнэлт хийх ёстой ийм л зүйл болчихоод байна.

Төсвийн хувьд мэдээж энэ чинь орлогоо юу гэж төлөвлөсөн тэр маань яаж биелсэн юм, зардал, зарлагыг яаж төлөвлөсөн юм, тэр нь яаж биелж явж байгаа юм, энд гарч байгаа зөрчил, дутагдал нь юу болсон юм, аудит нь юу гэж байгаа юм? Энэ 3 зүйлээс бүрдэж таарах байх. Төсвийн орлого ярихад бол 25 онд 937 тэрбум төгрөгөөр төсвийн орлого тасарч, дээр нь энэ тасарсан орлогыг дээр нь нэмээд 270 байна уу тэрбум төгрөгийг ТӨК-удаас 20-н, дараа оных нь татвараас суутгаад ингээд урьдчилаад авчихсан. Орлого талд иймэрхүү бүтэлгүй тоонуудтай.

Зардал талд ярихлаар 200, 300 төсөвт суучихсан хөрөнгө оруулалтын ажил нь 5, 600-н тэрбумаар одоо гэрээ нь хийгдээгүй. Нөгөө лаг лаг төсөв дээр юм ярьж

суулгаж жилд хэт тодотгож хийсэн төсөв маань ийм байдалтай. Тендер авсан компаниудын гүйцэтгэлээр ажлын хөлс мөнгө нь өгөгдөөгүй иймэрхүү байдлууд ингээд бүтнээр нь яривал ийм л бүтэлгүй л орлого, зарлага, зөрчил ийм л юм байна.

Эндээс би аудитаас 2 зүйл асуух гээд байна л даа. Энэ аудитын өгсөн дүгнэлт дээр өмнөх онд нь өгсөн 29 зөрчил дээр зөрчлийн 65 хувь нь биелээгүй. Шилэн дансанд бичигдсэн байх ёстой гүйлгээний 55 хувь нь шилэн дансанд бичигдээгүй гээд биччихсэн байна л даа. Тэгэхээр ер нь яах ёстой юм бэ? Энэ гарч байгаа хэдэн их наядын төсвийн зарлага гүйлгээний чинь 55 хувийг шилэн дансанд ерөөсөө бүртгээгүй. Одоо энд хариуцлага гэж байх уу? Үндсэндээ нөгөө ил тод нээлттэй засаглалд чинь 55 хувь нь хаалттай. 30 хэдэн их наядын чинь 55 хувь нь хаалттай гээд ийм л нөхцөл байдалтай төсвийн зарлага энд.

Дахиад нэмээд сангийн сайдаас энэ 1.7 их наядын ханшийн зөрүү, ханшийн ханшийн зөрүүгээс 1.7 их наядын алдагдал хүлээсэн гэсэн. Энэ цаг .../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Хэнээс асуулаа аудитаас асуусан тээ? Аудитын газрын дарга 3 номерын индэр.

С.Магнайсүрэн: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Үндэсний Аудитын газар Магнайсүрэн. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг өнгөрсөн жилийн аудитор тавьсан зөвлөмж, акт, албан шаардлага ийм үндсэн 3 төрөл, бусад 2 ингээд 5 төрлийнхөө аудитын шийдвэрийн хэрэгжилтийг жилийн эцсийн саяын аудитор жилийн дараа үзэж байгаа юм.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтээр 2 ийм асуудлууд зайлшгүй авч үзэх ёстой болж байгаа. Нэгдүгээрт бол зарим зөвлөмж бол 1 жилд багтаагаад хэрэгжихээргүй тийм том хэмжээний асуудал хөндсөн ийм зөвлөмжүүд бас байгаа юм. Тийм зөвлөмжүүдийг бол бид нар хэрэгжих шатдаа гэж үнэлээд ингээд дараагийн завсрын буюу дараагийн шатын аудитаар үзэхээр ингэж цаашаа явж байгаа.

Шилэн данстай холбоотой асуудлыг бол энэ жил бид нар дэд тайлангаар тусад нь оруулсан. Шилэн дансны харьцангуй зөрчил бол төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч, шууд захирагчдын түвшинд бол харьцангуй багассан. Ер нь бол маш сайжирсан үр дүн бол.

Төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын түвшинд бол сул байгаа гэдгийг бол бид нар энэ жил бол дүгнэлт дээрээ гаргаж ирсэн. Тэгээд энэ тал дээр бид нар мөн аудитын шийдвэрээ гаргаад ингээд араас нь хөөцөлдөж үр дүнг тооцож ажиллана.

Бүх аудитын шийдвэр дээр бол тодорхой хугацаанд хэрэгжүүлэх энэ зөвлөмж дээр, бүх зөвлөмж дээр бол тодорхой хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөө аваад тэр төлөвлөгөөг нь бид нар нэгтгээд шийдвэрийн хэрэгжилтийн газар дээрээ хяналтад аваад ингээд араас нь хөөцөлдөөд дараа дараагийн шатаараа үр дүнг нь тооцож ажиллана.

Албан шаардлага, акт бол тодорхой хугацаатай тавигддаг учраас тэр хугацаагаар нь бид нар ногоон гэрэл, улаан гэрэл асаагаад ингээд нөгөө акт нь биелэгдсэн, биелэгдээгүйгээр нь ингээд шууд ингээд тооцоод явдаг ийм механизмаар ингэж ажиллаж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Энхбаяр сайд хариулъя. Хэрэг эрхлэхийн сайд.

Б.Энхбаяр: Шилэн дансанд ер нь мэдээллүүд бол аягүй сайн орж байгаа. Хамгийн гол нь энэ шилэн дансанд орж байгаа мэдээллүүдийг нөгөө иргэд, олон нийт бүх талаас нь үзэх боломжтой. Ийм мэдээллийн санг бол хөгжүүлж байгаа. Засгийн газрын түвшинд бол ямар ч байсан туршилтын байдлаар бол үзэж байгаа. Би шилэн данс ажиллахгүй байгаа юм болов уу гээд сая таныг хэлэхээр нь зүгээр яг энэ туршилтын программыг хийгээд таны нэрээр үзэхэд бол жишээлбэл таны хамаарал бүхий 3 компани 2018-2025 оны хооронд 54 тендерт шалгарсан байна аа гэсэн ийм шилэн дансны мэдээлэл гарч ирж байгаа юм. Тэгээд ийм шуурхай болж байгаа юм. Хүний нэрийг нь энд тавиад л компанийг нь тавихад л шууд гараад ирэх ийм боломжтой болж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Би сайн муу гэдэг ийм ерөнхий тоогоор асуугаагүй л дээ. Сая аудитын дүгнэлт дээр шилэн дансанд орвол зохих, бүртгэвэл зохих мэдээллийн 55.1 хувь нь шилэн дансанд бүртгэгдээгүй байна аа л гэж байна. Тэгэхээр чинь энэ их тоо юу, бага тоо юу гэдгийг бүгдээрээ харж байгаа байх. 55 орвол зохих мэдээллийн 55 хувь нь бүртгэгдээгүй гэдэг. Тэгэхээр энэ бол өөрөө бас асуудал дагуулсан тоо байх гээд.

Түрүүн би тэр Сангийн сайдаас асууж байсныгаа гүйцээгээд асуучихъя. Цаг бага байгаа ч гэсэн. Нийт зээлийн 97 хувь нь валютаараа гэж байна. Уг нь энэ 80-аас дээшгүй байх ёстой гэж байна. Гэтэл энэнээс болоод ханшийн зөрөөнд 1.7 их наядыг бид нар 1.7 их наядыг ханшийн зөрүү төгрөгөөр алдчихсан байна аа гэдэг. Тэгэхээр энэ дээр цаашид ямар бодлого барьж ажиллах ёстой вэ? Ер нь энэ үнэ ханш, инфляц гэдэг зүйл дээр Засгийн газарт хамаатай юу, хамаагүй.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Мэндсайхан сайд хариулах уу?

З.Мэндсайхан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын нийт өр 38.5 их наяд байгаа. Энэ бол Өрийн удирдлагын хуулиараа ДНБ-ий 60 хувиас доошоо байна аа гэдэг энэ заалтаа хангаад явж байгаа. Таны асууж байгаа нийт ханшийн зөрүүгээс шалтгаалж 1.7 их наядаар гадаад зээлийн өр өссөн байгаа. 24-25 оны, 24 оны сүүлээс 25 оны төсөл бүр хооронд ам.долларын ханш 136 төгрөгөөр өссөн байна. Тэгэхээр энэ зээлийнхээ энэ өсөлт, валютынхаа өсөлтөө дагаад гадаад зээл дээр ханшийн зөрүүний ийм нэмэлт асуудал үүссэн байгаа. Энэ дээр бол би задаргааг нь тан руу явуулъя. Цаашдаа бид нар яах вэ гол асуудал бол мэдээж ханшийн асуудал мөн. Засгийн газрын асуудал инфляцын асуудал байна.

Гэхдээ бидэнд дотоодын инфляцаас илүүтэй манай эдийн засгийн бүтэц өөрөө импортоос бүрэн хамааралтай байна. Одоо өнөөдрийн байдлаар гэхэд

гадаад зах зээл дээр эрчим хүч, нефть, шатах, тослох материалын үнэ.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Түрүүн Энхбаяр сайд таны хамаарал бүхий компанид хэчнээн компани тендерт орсон орсон байна гээд би сайн мэдэхгүй тийм мэдээллийг хэлж байна. Яг миний шууд хамаарал бүхий компаниас төртэй холбоотой төсөл, тендерт орсон нь орох бодлого барьж байгаа орсон нь би бол 1 ч компани байхгүй гэж үзэж байна, бодож байна. Та хэрвээ тийм мэдээлэл байвал олон нийтэд Цогтгэрэл гишүүний шууд хамааралтай компани ийм ийм төсөл тендерт оржээ гэдгийг тавьж өгвөл сайн байна шүү. Би бол өөрөө мэдээлэлгүй болохоор тодруулж тийм ийм гэж хэлэх юм алга. Та бол сая тийм тодорхой нэр бүхий бараг 20, 30 тендер ч гэнэ үү 40, 50 ч гэнэ үү тоо хэлчих шиг боллоо.

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуулт асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр надад 3 сайдаас асуулт байна. Нэг нь бол Эрчим хүчний сайд Найдалаагаас, нөгөөх нь бол Доржханд Шадар сайдаас, дээр нь Мэндсайхан сайдаас.

Тэгэхээр энэ 2025 онд бид бас хүнд хэцүү үйлийг давсан. Эрчим хүчний дутагдалд орсон. Хязгаарлалтад орсон. Энэ нөхцөл байдал дунд өнөөдөр ингээд бид бас нэг зүйлийг олон жил бараг 30 гаран жил яриад ирсэн нь ерөөсөө сэргээгдэх эрчим хүч, салхи, нар тэгээд усан цахилгаан станцыг энд оруулдаг. Гэхдээ салхин цахилгаан станц, усан цахилгаан станцаас биш ээ, нарны цахилгаан станцаас авч байгаа энэ эрчим хүч бол төвийн эрчим хүчийг савлуулдаг, үнэтэй байдаг гэсэн юм яриад ингээд нэвтрүүлэх дээр бол энэ мэргэжлийнхэн их хойрго хандаж ирснийг хэлэх ёстой.

Гэтэл өнөөдөр 5 төсөл хэрэгжээд анх удаа нээлттэйгээр энэ дуудлага худалдааг зохион байгуулаад, сэргээгдэх эрчим хүч дээр нарны эх үүсгэвэрт энэ сэргээгдэх эрчим хүч дээр сонин ийм гайхалтай үзэгдэл үүсээд байна. Бид Бөөрөлжүүтээс 8.9 центээр авч байсан энэ цахилгаан чинь нүүрсний эхтэй энэ цахилгаан өнөөдрийн энэ тендерээр бол 6.65 цент болсон гэж байгаа юм. Тэгэхээр энэ асуудал бол цаашдаа энэ бодлогоо үргэлжлүүлэх юм уу энэ бодлогыг? Хоёрдугаарт ер нь цаашдаа ямар төлөвлөлттэй байна? Энэ нь өөрөө сэргээгдэх эрчим хүч Монгол Улсын хэдэн хувь хүртэл эрчим хүчийг хангах вэ гэдгийг Найдалаа сайдаас асууя.

Хоёрдугаарт үүнтэй холбоотойгоор энэ чинь нээлттэй явчихсан тендер. Олны өмнө шууд гараад ирсэн. Тэгээд түүхэндээ байгаагүй сэргээгдэх эрчим хүч бол ийм хямд болоод ороод ирсэн. Тэгэхээр энэ дээр би яг худалдан авалтыг, төрийн худалдан авалтыг хариуцаж байгаа энэ Доржханд сайдаас асууя энэ ер нь төрийн бүх худалдан авалтыг ийм байдлаар нээлттэйгээр, тендерээр, шууд ингээд тендерүүдийг бүгдийг нь нээлттэйгээр дуудлага худалдаа маягаар ингээд явуулчхаж болдоггүй юм уу? Нээлттэйгээр хамгийн гол нь ийм байдлаар явуулж болдоггүй юм уу гэсэн ийм асуулт байна.

Гуравд нь бол Сангийн яамнаас асууя. Энэ торгуулийн орлогын асуудал их аймаар байна. Өнөөдөр бид ингээд харахаар нийт төсвийн орлого, татварын бус орлого бол 9.3 хувийг эзэлж байгаа байхгүй юу. Тэгээд үүн дотроо торгууль яг хэдэн хувьтай байна аа? Ингээд иргэдтэй уулзаад явлаа, Сүхбаатар аймгаар явлаа, Дорнодоор явлаа, мөн Баянзүрх дүүргийнхээ сонгогчидтой уулзаад явлаа. Торгуулж үзээгүй хүн байхгүй байна. Хэд торгуулсан бэ гэдгийг л асуу гэж. Дээр үед бол Өгөөдэй хаан, Гүег хааныг загнахдаа 1 ч цэргийн ер нь ташуурдуулж үзээгүй цэрэг алга гэж ингэж загнаж байсан гэсэн. Ийм байдлаар л өнөөдөр энэ торгуулийн орлогын төлөө энэ төр чинь ажиллаад байна аа.

Тэгэхээрээ зэрэг энэ аж ахуйн нэгжүүдэд энэ төсвийн орлого бүрдэхгүй болохоор ачаа үүрүүлээд байгаа юм биш биз дээ? Энэ тал дээр та бүхэн од ямар бодлого бариад, яагаад яваад байгаа юм? Энэ торгуулийг яагаад ингээд нэмээд байгаа юм бэ гэдгийг л асууя.

Энэ торгуулийн орлогод байна шүү дээ 127.9 тэрбум төгрөгийг ингээд анхнаас нь төлөвлөөд хаячихсан байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл анхнаасаа торгоно шүү гэдэг ийм.

Ж.Бат-Эрдэнэ: Найдалаа гишүүн. Найдалаа, сайд хариулъя.

Б.Найдалаа: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Одоогийн байдлаар Монгол Улсад суурилагдсан хүчин чадлын 17.7 хувь нь сэргээгдэх эрчим хүчнээс авдаг юм. Тэрний бодит хэрэглээ 8 орчим, 8.2 хувь нь хэрэглээний 8 хувь нь сэргээгдэхээс байдаг. Сэргээгдэхийн тариф яах вэ өмнө нь дээр үед хийсэн гэрээнүүдээс болоод өндөр байсан. Дээр нь бас буруу ойлголт иргэдэд өгснөөс болоод үнэтэй, ашиггүй, тохиромжгүй, боломжгүй гэсэн нийтэд ойлголт төрсөн нь үнэн.

Харин зүгээр сая тэр 5 аймгийн нээлттэй сонгон шалгаруулалт хийсний үр дүнд, авагдсан хийсний үр дүнд хамгийн бага нь 1квт цаг нь 4.85 цент болсон. Хамгийн өндөр бага чадалтай Хэрлэнд 7 цент, 7.8 цент болсон. Тэгээд энэ бол ямар ч нүүрсний станцаас ялангуяа сүүлийн үед баригдсан бүх станцуудаас бараг 2 дахин бага юм байгаа юм.

Тэгэхээр цаашдаа бол сэргээгдэх эрчим хүчийг Монгол Улс асар их нөөцөө ашиглаад хөгжүүлэх ёстой. Энэ бол Монгол улсын эрчим хүчний хөгжлийн стратегид баталгаатай орсон. Тэгээд олон улсад хүлээсэн үүргээрээ 2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчийг суурилагдсан хүчин чадлаа 30 хувьд хүргэх үүрэгтэй Монгол Улс. Дээр нь төсөл нь явж байгаа удахгүй батлагдаж байгаа эрчим хүчний шилжилтийн стратегид 2050 он гэхэд 50 хувиас багагүй байхаар бид нар тусгаад хэлэлцэж байгаа. Энийг бол сүүлийн үед технологи гараад батарей байна уу бусад тохируулгын системүүд бий болсон.

Тийм болохоор Монгол Улс эрчим хүчнийхээ сэргээгдэх эрчим хүчнийхээ энэ асар их нөөцийг ямар ч асуудалгүйгээр хөгжүүлээд илүү үр дүнтэй ашиглах бололцоотой. Саяын тэр ер нь үнэ өртөг нь ч гэсэндээ бага байна гэдгийг, боломжтой гэдгийг харуулсан байгаа. Зүгээр цаашдаа манай эрчим хүчний салбар сая энэ төсвийн гүйцэтгэлтэй ч холбоотой энэ дамжуулах зээлдүүлэх зээлүүд нэлээн хуримтлагдсан байгаад байгаа юм.

Тухайлбал, 61.2 тэрбум төгрөг компаниуд дээр байгаа юм. Энэ юунаас болж үүсэж байна вэ гэхээр компаниуд нь үнэ, тарифын зохисгүй байдал болон үр ашгаасаа болоод энэ урт хугацаат өр төлбөр буюу ер нь хөрөнгө оруулалтаа нөхөх боломжгүй байгаад байгаа юм. Ингэх юм бол эрчим хүчний дэд бүтэц болон эх үүсвэрийг барихад ялангуяа компаниудаар дамжуулж бүтээн байгуулалт хийхэд саадтай байгаа юм.

Тэгэхээр бид нарын хувьд энэ эрчим хүчний салбарын санхүү хөрөнгө оруулалтын менежментийг өөрчлөх, шинэчлэх шаардлага байгаа юм. Борлуулалтынх нь орлогод тэр зээл төлөх эх үүсвэрийг нь тусгаж өгөх, тусгаж өгөхүйц, тэр зээлээ даахуйц, хөрөнгө оруулалтаа даахуйц орлого, үнэ, тарифыг тогтоох, нөгөө талаасаа түрүүн тэр сэргээгдэхийн тариф яригддагтай адилхан ер нь зүгээр Монгол Улсад явж байгаа эх үүсвэрүүдийн дамжуулахын, түгээхийн зардлуудыг нь өөрөөр хэлбэл эрчим хүчний өртгийг бууруулах чиглэлээр бас чухал бодлогын ажил хийх ёстой байгаа. Энэ талаар ажлууд тодорхой хийгдээд явж байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: 18 цаг өнгөрчхөж ээ. Чуулганы хуралдааныг үргэлжлүүлье. Доржханд сайд Шадар сайд хариулъя.

Т.Доржханд: Бас Наранбаяр гишүүнтэй санал нэг байна. Ялт ч байхгүй ил тод, нээлттэй, олны өмнө ийм дуудлага худалдаа хийсний үр дүнд бол энэ өчигдөр бүтэн 10 цаг гаруй 5 компани шалгарлаа. Үр дүнд нь бол үнэн бодит үнэ бол ингээд 4.8 центээр байсан. Гэтэл хамгийн сүүлд баригдсан нүүрсний уурхайн тариф бол 8.8 шүү. Тэгээд энэ чуулган дээр би санадаг юм маш олон хүмүүс бол сэргээгдэхийн үнэ бүтэхгүй маш үнэтэй 15-аас дээш гарна аа нүүрс л маш чухал нүүрс л хямдхан гэдэг ийм тархи угаалтыг хийдэг хүмүүс их байсан шүү.

Гэтэл өнөөдөр бодит байдал дээр зах зээлийн үнэ тогтож байна. Нийлүүлэлтийг ингээд өсгөөд, үнийн либералчлалыг ингээд хийгээд ирэхлээр зах зээл чинь аяндаа ингээд үнээ доошоо авчирч байгаа байхгүй юу. Энэ бол ингээд өчигдрийн бодит үр дүн байлаа. Харин худалдан авах ажиллагааны хувьд бол.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя Доржханд сайд.

Т.Доржханд: Төрийн худалдан авах ажиллагааны хувьд бол процесс нь жаахан өөр байдаг. Бид 100 хувь нээлттэй зарладаг. Бүх үйл ажиллагаа шилэн нээлттэй байдаг. Харин чанарын шаардлага хангасан тохиолдолд хамгийн бага үнэтэйг нь шууд сонгодог. Энэ бол олон улсын худалдан авах ажиллагааны процесс, журам.

Дуудлага худалдаа гэдэг бол чанарын шаардлага хангасан компаниудыг суулгаж байгаад үнэ хэлэлцүүлдэг. Хамгийн бага үнэ, эсвэл хамгийн их үнэ. Тэрийг нь ингээд шалгаруулж явдаг. Энэ бол ингээд дуудлага худалдаа. Засгийн газрын худалдан авах ажиллагааны хувьд бол бид нар өнөөдөр хамгийн ил тод байхаар, Хоёрдугаарт хиймэл оюун ухаан дээр суурилсан байхаар, хүний оролцоо байхгүй байхаар үйл ажиллагаагаа ингээд зохион байгуулаад явж байгаа. Үр дүнд нь ердөө сая 2025 оны гүйцэтгэлээр гэхэд өмнөх жилээсээ 30 хувиар илүү үр дүн

гарсан байхгүй юу гэрээ байгуулахад. Одоо эд нарыгаа бид нар 100 хувь болгохын төлөө явж байгаа. Авлигагүй, хээл хахуульгүй, шууд гэрээгүй нээлт.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Сангийн сайд Мэндсайхан сайд хариулъя.

З.Мэндсайхан: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Хүү, торгуулийн орлого нийт энэ нийт орлогын 0.7 хувь буюу 1 хувь хүрэхгүй хувийг эзэлж байгаа. Тэгэхдээ энэ орлого бол орон нутгийн орлого байгаа. Засгийн газар энэний яг орлогыг татаж авдаггүй. Төлөвлөөд, торгоод байна аа гэдэг ер нь төлөвлөөд торгоно ч гэж юу байх вэ дээ. Тэгээд урд аймаг, орон нутгууд төсвөө хийхдээ өнгөрсөн оны дундаж үзүүлэлтээрээ суурилад л хийсэн байх. Ер нь гол шалтгаан бол тэгээд л хууль зөрчсөн иргэнийг л торгож байгаа шүү дээ. Түүнээс биш Засгийн газар торгоод бай гээд байдаг ойлголт байхгүй шүү дээ. Зөрчлийн хуулиар зөндөө зөрчлүүдийг ангилаад өгчихсөн бид нар. Тэр дээр нь ямар ямар торгууль байх нь тодорхой байгаа. Энэнийхээ дагуу хууль зөрчсөн иргэнээ л хуулийн байгууллага дээр арга хэмжээгээ авч байгаа байх гэж ойлгож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Наранбаяр гишүүн асууя.

П.Наранбаяр: Тэгэхээрээ бас энэ яах вэ энэ хариулж байгааг ойлгож байна. Энэ орон нутгийн төсөвт шууд ордог. Тийм учраас орон нутаг дээр энэ торгууль чинь гараад яваад байна. Нийслэл дээр бол хэсэг бүр 70 тэрбумыг торгуулийн орлого гээд бүр төсөвлөчихсөн байсныг би санаж байна. Манайд бол яг энэ юуны хэмжээнд бол ер нь нийт төсвийн хэмжээнд бол нийтдээ 127.9 тэрбум төгрөгийг торгууль төлүүлсэн байна. Ингэж төлөвлөөд байна аа гэдэг чинь цаана нь торгууль авах, ийм торгуулах, торгох ийм юуг хүсэл төрүүлээд байна гэсэн үг.

Тэгэхээр зэрэг энэ дээр бол анхаарахгүй бол болохгүй нь ээ. Зүгээр албан бичгийн хариу өгсөнгүй гээд торгочихсон байна лээ шүү дээ Сүхбаатар аймагт. Жишээлбэл Баруун-Урт суманд. Бизнес эрхлэгчид бүгд ярьж байна шүү дээ. Ингээд ирээд шууд хууль зөрчсөн гэдгийг бүүр өөг нь хайсаар байгаад олоод торгож байна. Ийм нөхцөл байдалтай байгааг энд суугаа энэ Улсын Их Хурлын.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Ганбатын Хосбаяр гишүүн.

Г.Хосбаяр: Өнгөрсөн 2025 онд бид нар 30 их наядын орлого олоод 31 их наядыг зарцуулчихсан. Бид нар өөрсдөө баталсан л даа төсөв. Тэгээд энийгээ зарцуулалт энэ тайланг сонсоод сууж байна. Эндээс энэ хөрөнгө оруулалтын зардал байгаа. Улсын төсвөөс бид нар 9 их наядын үнийн дүнтэй 3 их наяд төгрөгийг нь санхүүжүүлэх ийм төсөл, хөрөнгө оруулалт энэ Монгол Улсын газар нутаг дээр хийжээ. Энэ бол чамлалттай тоо. Бид нар 800 энэ өргөн уудам нутагт 800 сая долларын л яг төсвийн хөрөнгө оруулалтаар 1 жилд хөрөнгө оруулалт хийж байгаа юм.

Тэгээд өнгөрсөн жилийн энэ хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг харахад 3 их наядын санхүүжилтээс 2 их наяд 135 тэрбум төгрөгийн санхүүжилтийг яг хийгээд, олгоод 886 тэрбум төгрөгийг нь олгоогүй байна л даа. Тэгээд энийгээ хэмнэсэн гэж яриад байх шиг байна. Энийг бол хэмнэлт гэж үзэхгүй байгаа. Өнөөдөр татвар

төлөгчдийн 1 төгрөг ч үнэ цэнтэй, буцаагаад энэ бид нарын өчнөөн юм болж намаржингаа ярилцаж баталдаг төсвийн 1 төгрөг болгож буцаад хөрөнгө оруулалт яг энэ үр ашигтай байж, энэ улс орны хөгжил, дэвшил ард иргэдийн амьдралд ач тусаа өгөх ёстой.

Тэгэхэд өнгөрсөн жил 25 онд гэхэд 886 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг ингээд хийгээгүй байгаа. Тэгээд олон асуудал байгаа л даа. Тэгэхдээ ихэнх асуудал нь энэ төрийнхөн бид нарт байгаа байх. Энэ төрийн бүх шатанд. Түүнээс биш хувийн хэвшилд мэдээж буруутай тодорхой хэсэг байгаа байх. Гэхдээ Монголын жишээ нь барилгын салбар барилгачид гэхэд өнгөрсөн онд 19600 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулсан байгаа. Барилга барьж чадаж байна гэсэн үг. Энэ хэдэн сургууль, цэцэрлэг, эмнэлгийг өлхөн барьчихна. Дахиад авто замчид байна. Бараг жилд 1000-аад километр автозамыг бүрэн барьж ашиглалтад оруулах ийм хүчин чадалтай болчихсон.

Өнөөдөр Монголын хувийн хэвшилд бол ажиллах хүчин, хөрөнгө санхүү, машин, техник, тоног төхөөрөмж гээд энэ хөрөнгө оруулалтын ажлыг хийх бүрэн боломжууд байгаа. Тэгээд бид нар болохтойгоо зэрэг ингээд тендер ч гэдэг юм уу эсвэл энэ бичиг цаас янз бүрийн зүйл ярьсаар байгаад ингээд энэ ажлуудыг хийхгүй байна л даа. Тэгээд цаашдаа ер нь энэ хөрөнгө оруулалтын ажлыг энэ тавьсан хөрөнгө оруулалтуудаа 100 хувь хэрэгжүүлэх 1 төгрөг ч үлдээхгүй хэрэгжүүлэх тал дээр энэ Сангийн яам ер нь ямар бодлогоо өөрчилж болохгүй юу?

Жишээлбэл, энэ бүх л дүнгээр нь буюу 3 их наядаар нь тавьчхаад түрүүлж ажлаа хийж байгаа компаниудыг санхүүжүүлээд ч юм уу, эсвэл энэ бүр цаашлаад энэ санхүүгийн жилээ өөрчилж болохгүй юу? Яагаад заавал 01 сарын 01-нээс дараагийн жилийн санхүүжилт эхлээд тендер зарлана гээд ингээд явж байтал 5, 6 сар болоод 7, 8 сар болоод хамаг энэ барилга бүтээн байгуулалт хийх сезон дуусчихдаг энэ байдлыг өөрчлөх ийм төсөл санаачилж ийм зүйл хийж болохгүй юу?

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Сангийн сайд хариулъя.

З.Мэндсайхан: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яам яах вэ бид нар улсын төсөв дээрээ 8.5 их наядын хөрөнгийн зардал баталж байгаа. Тэрний чинь 3.4 л улсын төсөв дээр, орон нутаг дээр 3.9 нь явчхаж байгаа юм. Тэгээд нөгөө үлдсэн 1.2 нь гадаад зээлийн ашиглалтаар явж байгаа байхгүй юу задаргаа нь. Тэгээд бид нар дээр байгаа орон зай бол өнгөрсөн он дээр гээд л харахад бид нар дээр 3.4-ийн орон зай байгаа.

Өнгөрсөн жилийн төсвийн энэ хөрөнгө оруулалтыг оновчтой болгох үүднээс тэр Хэмнэлтийн хуулиар 5 сарын 31 гэдгийг чинь яагаад тавьж өгсөн гэхээр бид нар өмнө нь яадаг байсан гэхээр тендерийг бол он дуустал зарладаг байсан юм. Тэгээд ажлаа хийхгүй бид нар зуны угаасаа бүтээн байгуулалтын улирал дээр тендерээ зарлаад, хэрүүл хийгээд дуусдаг байсан байхгүй юу. 11 сарын 10-ны 5-нд бид нар төсөв, улсын төсвөө батлаад дуусаж байгаа. Ингээд он гартал бид нар тендерийн бэлтгэл ажлаа хангах хангалттай хугацаа байгаа. Цаана нь зарлаад явах боломжийн хугацаанууд байгаа. Өнгөрсөн жил 500 хэдэн тэрбум төгрөг татагдаж байсан бол энэ жил 247 татагдаж байгаа юм. Энэ төсөл, хөтөлбөрүүд бол ингээд шууд төсвөөс хасагдаад явчхаж байгаа юм хэмнэлт болоод.

Харин өнгөрсөн оны чинь дүнгээ санхүүжүүлж чадаагүй 286 тэрбум төгрөг гэхэд энэ оны эхний улирал санхүүжигдээд л шилжээд санхүүжигдээд дуусаад явж байгаа гэсэн үг байхгүй юу. Дараа он руугаа дамжиж санхүүжигдээд. Тэгэхээр Хэмнэлтийн хуулиар бид нар тэр 5 сарын 31-нээр хязгаарлалт тавьж өгч байна гэдэг чинь тендерийг бид нар эндээс зогсоогоод цаашаа бүтээн байгуулалтын энэ улирлаа ашиглахгүй бол харин эсрэгээрээ энэ цаг хугацаандаа орохгүй бид нар бүтэн жилжингээ л тендертээ хөөцөлддөг ийм л улс байсан шүү дээ.

Тэгэхээр бид нар энэ дээрээ одоо цаашдаа төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой болгохын тулд Сангийн яаман дээр Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг санаачилж, бэлтгэл ажлыг нь хангаад явж байгаа. Энийг намрын чуулганаар өргөн барина. Ер нь одоо бид нарын асуудал бол бид өөрсдөө бас ярих ёстой. Бид нар чуулган дээр төсөв хэлэлцэх үеэр ярьж байгаад л баахан зураг, төсвөө ажлууд суулгачихдаг. Тэр ажлууд чинь л ингээд л хугацаа нь шахагдаад л гоожоод үлдэж байгаа шүү дээ.

Тэгэхээр энийгээ бид нар Төсвийн тухай хуулиас гадна Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зайлшгүй зохицуулж өгөх ёстой юм байна гэдэг учраа шалтгаанаар бид нар энэ хуулийг Сангийн яаман дээр бэлдээд дуусаж байгаа юм. Одоо энэ намрын чуулганаар өргөн барина гэсэн төлөвлөгөөтэй байна.

Ж.Бат-Эрдэнэ: Хосбаяр гишүүн тодруулъя.

Г.Хосбаяр: Энэ зарим өндөр хөгжилтэй орны энэ төсвийн хөрөнгө оруулалтын тэр юмнуудыг бас харж байсан л даа. Тэгэхэд ингээд бүх л том дүнгээр нь батлаад түрүүлж хийсэн газрууд нь энэ санхүүжилт юмаа дуусгаад боломжоороо авдаг ч юм уу ингээд ер нь бид нар яаж энэ хөрөнгө оруулалтыг үр ашигтай байлгах вэ гэдгээ л ярихгүй бол өнгөрсөн жил гэхэд дөнгөж 70 хувийн л гүйцэтгэлтэй 70 хувийн л хэрэгжилттэй байна шүү дээ. Тэгээд энэ жил энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт дээр ч байгаа. Сүүлийн 5 жилд ингээд улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл тогтмол буурч байна гэж байна.

Дахиад энэ 26 оныхыг гүйцэтгэлийг хойтон өдийд бид нар ярихдаа өө ноднин 25 он уржнангийнхаас буурчихсан байна аа гээд л яриад сууж байх байх л даа гэх жишээний. Тэгэхээр энэ дээр ер нь ийм бодлогын дорвитой өөрчлөлт хийж болохгүй юм уу? Ямар хууль, дүрэм, журамд баригдаад энийгээ хийж чаддаггүй юм бэ? Түүнээс биш хувийн хэвшилд бол өчнөөн боломж байна шүү дээ. Хувийн хэвшлийнхэн ажил хийгээд байхад төрд бид нарын энэ дүрэм, журмыг бид нарт л асуудал байна шүү дээ. Тэрнээс биш 3 байтугай л их наядын ажил хийчих боломж хувийн хэвшилд байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Сангийн сайд хариулах уу? Хэн хариулах вэ? Хэн хариулах вэ? 4 номерын микрофон.

Ж.Дэлгэржаргал: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Тэгэхээр төсвийн хөрөнгө оруулалтын хувьд бол яг бүтэн манай төсвийн жилийн цаглавар болон барилгын улирлын салбараасаа хамаараад бас энэ богино хугацаатай байдаг. Тэгэхээр энэ 5 сарын 31 бол яг гүйцэтгэлээ илүү сайжруулах, төлөвлөлтөө сайжруулах зохицуулалттай. Одоо яг Төсвийн тухай

хуулийн 11.14 дээр бол сайн явж байгаа төслүүдээ бид нар гүйцэтгэлээр нь бүрэн санхүүжүүлэх бол боломжтой байдаг.

Өөрөөр хэлбэл, яг санхүүжих дүн дотор нь зохицуулалт хийгээд төслүүдээ ашиглалтад оруулах боломж бол байгаа. Өнгөрсөн оны хувьд бол 73 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Нийт улсын төсөвтөө буцаагаад төвлөрсөн нь бол 779 тэрбум 286-г нь бол бид нар 26 оны батлагдсан санхүүжилтээс нь бол бүрэн олгосон. 493 тэр тэрбум бол хэдийгээр гэрээтэй байсан ч гэсэн гүйцэтгэл гарч, ирээгүй учраас санхүүжилт олгоогүй. Тэгэхээр энэ төслүүд маань гэрээтэй энэ онд үргэлжлээд явж байгаа учраас энэ үлдэгдэл ажлуудыг бид нар 27 оныхоо төсвийн төсөлд тусгаад төслүүдээ бүрэн дуус.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ухнаагийн Отгонбаяр гишүүн.

У.Отгонбаяр: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Өнөөдөр Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл хэлэлцэж байна. Сая ерөнхий аудиторын дүгнэлтэд төсөв тэлсэн мэдээллийн ил тод байдал байхгүй, давхардсан хяналт шалгалт гээд энэ бол жилийн жилд дандаа л энэ асуудлуудыг байнга л энэ дүгнэлтэд ордог. Энэ дээр цаашдаа бид бүхэн ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой юм бэ? Тэгэхгүй бол жилийн жилд л энэ төсвийн гүйцэтгэл хэлэлцэхэд төрийн аудитын дүгнэлтэд сая миний дурдсан 3 зүйлийг ном юм шиг оруулж ирдэг, энэ танилцуулгад орж байдаг энэ байдал маань хэзээ ер нь цэгцрэх юм бэ гэж нэгдүгээрх.

Хоёр дахь асуудал энэ Шинэ хоршоо хөтөлбөрийн талаар тодруулах гэж байгаа юм. Орон нутагт, тэр тусмаа зүүн бүс нутаг Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймагт бид бүхэн бизнес эрхлэгч нартаа, малчдадаа, хоршоологчидтой байнга уулзаж учирдаг. Сүүлийн жил энэ 2025 онд бол хоршооны зээл төдийлөн гарахгүй байна. Гарсан ч хүссэн ч хүссэн энэ зээл яг бүтнээрээ олгогдохгүй байна хүрэлцээ, ил тод байдал улам хумигдаж байна гэдэг асуудлыг байнга ярьж байдаг. Энэ дээр яг энэ 25 оны гүйцэтгэл дээр тодорхой дүн мэдээ энэ хоршооны зээлийн талаар бас өгөөч ээ.

Гурав дахь асуудал энэ боловсролын салбарын талаар бас тодруулах гэж байна. Бидэнд тараагдсан боловсролын салбар 2025 онд төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 184 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, 341.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, нийт 93 сургууль, цэцэрлэг, дотуур байр ашиглалтад орсон гэж байна. Энэний цаана олон жил царцсан цаашаа үргэлжлэх боломжгүй болсон, төсөвт өртөг нь нэмэгдсэн маш олон барилга байгууламж байгаа. Энэний тоон мэдээг та бүхэн маань бас хэлж бас мэдээлэл өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Отгонбаяр гишүүний асуултад Идэрбат сайд хариулъя.

Ц.Идэрбат: Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Монгол улсад хоршооны хөдөлгөөн бол үүсээд энд бас нэлээдгүй хугацаа өнгөрч байна. Тэр дундаа 2024 онд бол бас хоршоо хөгжүүлэх Шинэ хоршоо, Чинээлэг малчин үндэсний хөтөлбөр бас хэрэгжсэн. Ингээд үүний үр дүнд бол Монгол Улсад 15106 хоршоо байна. Энэ хоршоог Хөдөө аж ахуйн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газар дээр хоршоо хариуцсан 1 нэгж, Шадар сайдын ажлын албан дээр хоршоо хариуцсан бас 1 нэгж байгаа. Засгийн газар дээр бол энэ нэгжүүдийг нийлүүлж хоршоог бол ер нь Хөдөө аж ахуйн яам хариуцуулна гэсэн ийм чигтэй

байгаа. Энийг ч гэсэн миний хувьд бол бас дэмжиж байгаа. Шинэ, хуучин хоршоо гэж биш Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа энэ хоршоо гэдэг нэг л малгайн доор бид байх ёстой гэж ингэж харж байгаа.

Энэ хугацаанд бол нийт 840 гаруй тэрбум төгрөгийг энэ хоршоонуудад олгосон байдаг. Тэгэхээр ер нь бол бид шинээр дахиад хоршоо нээнэ гэхээсээ илүүтэйгээр энэ байгуулагдсан хоршоогоо яг хоршооны хөгжүүлэх тэр үзэл баримтлалын хүрээнд хоршиж, нэгдэж бүтээгдэхүүн юмаа гаргадаг энэ кластер үйлдвэрлэл рүүгээ шилжүүлэх нь зүйтэй. Бид тэр алхам руугаа ер нь явъяаа гэсэн ийм бодолтой байгаа.

Их Хуралд жилийн өмнө өргөн барьсан Хөдөө аж ахуйн хууль Мандухай нарын гишүүд Хосбаяр, Бейсен, Үүрийнтуяа, Бат-Эрдэнэ гишүүд бид өргөн барьсан хууль маань ингээд өчигдөр батлагдлаа. Энэ бол бас нэлээдгүй олон боломжийг энэ Монголын малчдад олгож байгаа. Тэр дундаа бид бол маргаашаас эхлээд энэ 10 хэдэн жил хаягдаж байгаа Монгол Улсын мал аж ахуйн бас том баялаг болсон энэ арьс ширийг үнэтэй болгох, анхан шатад нь ялгах, боловсруулах улмаар дараагийн шатны боловсруулалтад оруулах энэ “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа, энэ олноороо байгуулагдаж байгаа энэ үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнүүдийг бэлтгэх энэ ажлыг хангайн бүс, Хөвсгөл, хойд бүсээсээ бол Хөвсгөл аймаг, хангайн бүсээс бол Архангай аймаг, зүүн бүсээс бол үхрийн арьс шир, мөн хонины нэхий гэсэн ийм байдлаар эхний ээлжид туршилтууд 5, 6 сарын хугацаанд хийгээд хэрвээ энэ маань ингээд амжилттай болоод малчидтайгаа, хоршоотойгоо, үйлдвэрлэлүүдтэйгээ малын, махны үйлдвэрүүд, бойнуудтайгаа хамтраад ажиллаж байгаа энэ формат маань амжилттай болох юм бол улс орон даяараа энэ хоршоогоо цааш нь хөгжүүлээд удирдаад явах ийм бололцоог бас бүрдүүлэхээр эхний ээлжид бол туршилтыг хийхээр маргааш бид хэд гарах гэж байна.

Энэ нь бол хоршооны цаашдын хөгжилд бол бас үнэтэй хувь нэмэр оруулна. Нөгөө талдаа энэ манай хөдөө аж ахуйн салбар дээр тулгамдаж байгаа энэ махны асуудлууд, өнөөдөр үнэ нь өсөж байгаа гэж ярьж байгаа энэ ногооны асуудлууд гээд энэ олон асуудлуудыг шийдвэрлэхэд бид энэ хоршоон дээр суурилсан энэ кластер бүтээгдэхүүнээ бэлтгэх, нийлүүлэх, энэ сүлжээгээ явуулах нь зүйтэй юм аа гэж ингэж үзэж байгаа гэдгийг бас товчхон хариулъя. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Энх-Амгалан сайд 3 номер.

Л.Энх-Амгалан: 3 минут өгчих үү?

Ж.Бат-Эрдэнэ: 3 минут Энх-Амгалан сайд өгчихье дөө.

Л.Энх-Амгалан: Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Манай энэ боловсролын салбарт хийгдэж байгаа энэ хөрөнгө оруулалтын асуудлууд энэ цэцэрлэг, сургууль, дотуур байрууд бол бас нэлээн удааширч байгаа ийм объектууд бас их байна аа Отгонбаяр сайд. Яг таны Отгонбаяр гишүүн таны хэлж байгаагаар. Тэгэхээр энэ ажил авснаас хойш 2 сар орчим болж байна.

Тэгээд энэ жилийн хөрөнгө оруулалт дээр бол нийт 300 орчим объектууд он дамнасан болоод шинээр эхэлж байгаа, хөрөнгөгүй болчихсон гээд ийм

объектуудыг ингээд ангилаад сууж байна. 1.9 их наядын төсөвт өртөгтэй энэ жил санхүүждэг нь бол 500 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтээр ингээд объектууд нь явна. Тэгээд төсөвгүй гээд ийм хэсэг объектуудыг аваад үлдчихсэн юм байна лээ.

Тэгэхээр энийг бол би их сайн ойлгохгүй байгаад байгаа юм. Яг одоо улсын комисст өгөхөд бэлэн болчихсон байгаа жаахан 200, 300 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаа, 400 сая төгрөгийн санхүүжилт байгаа ийм 163 объектуудыг яг ингээд тодорхойгүй яг төслийн нэрээр нь нөгөө жагсаалт нь хасагдахгүйн тулд төслийн нэрээр нь оруулчихсан. Тэгсэн мөртөө л энэ санхүүжих дүн нь тэг гээд ингээд тавьчихсан ийм ойлгомжгүй нөхцөл байдал энэ манай салбарт үүссэн юм байна лээ. Тэгээд энийг цэгцлэх ийм зайлшгүй шаардлага бас байгаа.

Тэгээд Сангийн сайдтай бид хоёр бас ярилцаад Сангийн сайд, Боловсролын сайд хоёрын хамтарсан энэ боловсролын салбарт олон жил болж байгаа энэ санхүүжилтүүдийг, энэ объект, төсөл, арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх ийм ажлын хэсэг бас гаргаж ажиллуулж байна. Одоогийн байдлаар бол 10 жил хүрч байгаа 58 объект байгаа юм байна лээ. Энийгээ бид нар эхний ээлжид яг яаж оруулах вэ гэдэг асуудлуудыг ярилцсан.

Давхар ер нь энэ сургууль, цэцэрлэг, дотуур барьж бай барь барь барьж байгаа энэ компаниудтай бид нар хариуцлагын асуудал ярих цаг болсон байна. Энэ олон зуун мянган хүүхдүүдийн эрх ашиг хөндөгдөж байгаад. Тендерт маш бага дүнгээр орчхоод тэгээд жил бүхэн магадлан хийлгээд ингээд тендерийнхээ дүнг нэмээд байдаг ийм цэцэрлэг, сургуулиуд бол их олон болсон байна. Энэ чинь бараг үндсэндээ технологи шахуу болчихсон болж байгаад байна шүү дээ. Барилгын хөгжлийн төвтэйгөө, зарим нь бүр энэ зураг төсөл хийж байгаа компаниуд нь зураг төслүүдээ дутуу хийгээд дутуу тендер зарлаад тэгээд дараа нь тэр дутуу зураг төсөлтэй тендерүүдээ дахиж гүйцээж байна гэдэг үнээ нэмчихдэг ийм гаршсан хэдэн компаниуд бас байгаад байгаа юм. Тэгээд удахгүй бол манай салбар удахгүй хар жагсаалтаа зарлана. Боловсролын салбарт олон жил объект, сургууль, цэцэрлэгүүд авчхаад барьж дуусаагүй байгаа 16, 17 орчим компанийн нэр гарч байгаа. Энийгээ бид нар бас Сангийн яамтай хамтарч Засгийн газар дээр энэ хар жагсаалтыг зарлахаас өөр арга байхгүй гэж би бодож байгаа.

Тэгэхээр бид нар бол цаашдаа энэ үүсчихсэн байгаа 53 сургууль, цэцэрлэг, дотуур байрны ард гарч чадах юм бол цаашдаа бол ёстой жинхэнэ зарчмаар нь тэр газартай, зурагтай энэ объектуудаа л тавьдаг, эрэмбэлдэг ийм чиглэл рүү л явах нь зүйтэй болов уу л гэсэн бодолтой байна.

Л.Энх-Амгалан: Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Энэ цэцэрлэг, сургууль энэ боловсролын салбарын хөрөнгө оруулалт дээр арай жоохон өөр тогтолцоо зайлшгүй шаардлагатай байгаа юм. Хувийн хэвшил олон гишүүд хэлж байна шүү дээ хувийн хэвшлийг бол хувийн хэвшлийнхэн бол 16 давхар блокуудыг жилийн дотор л бариад л ашиглалтад оруулаад байдаг. Төр болохоор 2, 2-хан давхар сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгыг 3, 4 жил дамнаад явчихдаг. Тэгээд нөгөөх нь төсөвт өртөг нь өдөр хоног ирэх тусам нэмэгдээд явдаг. Энэ дутуу барилгуудаа бөөгнүүлээд тодорхой шийдэл гаргаад үнэхээрийн цаашаа явахуудыг нь явуулаад явуулахгүйг нь бүр хаагаад ингээд дуусах зайлшгүй бас ийм шаардлага байгаа юм билээ.

Тийм учраас энэ дээр бол бүүр онцгой анхаараад тэгээд цаашдаа бол эрүүл мэнд, боловсролын салбарын хөрөнгө оруулалтын тогтолцоог нь нөгөө хөрөнгө оруулалтаасаа болохгүй бол арай өөр хэлбэр рүү оруулж маш богино хугацаанд ашиглалтад орвол

Ж.Бат-Эрдэнэ: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Би бол Отгонбаяр гишүүнтэй санал нэг байна. Одоо цаашдаа ер нь Төсвийн хуулиар бол аливаа төсвийн энэ сургууль, цэцэрлэг, энэ объектыг чинь 3 жилийн дотор бол дуусгах ёстой ийм хуультай шүү дээ. Хуваагаад тавиад 3 жилийн дотор дуусгах.

Тэгэхдээ энэ ч гэсэн яг энэ сургууль цэцэрлэг, эмнэлгүүдийн хувьд, дотуур байруудын хувьд бол бас чамлалттай хугацаа 3 байтугай 5 жил рүү ингээд явчихдаг. Цаашдаа бол энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр одоо бид нар яг нийслэлд туршиж үзэж байгаа энэ хотхоны бага сургууль, төрөлжсөн ахлах сургуулиудыг хийж бид нар өөрсдөө төр сургууль, цэцэрлэгүүд барихгүй, хувийн компаниудаар бариулаад 5 жил, 10 жил, 15 жил санхүүгийн түрээс хэлбэрээр оруулах ийм сайн хэлбэрүүд бас байна.

Тийм учраас бол энэ хэлбэрүүдийг бол бид нар илүү цаашдаа энэ боловсрол магадгүй энэ эрүүл мэндийн салбарт ч гэсэн энэ хөрөнгө оруулалтын шинэ санхүүжилтийн хэлбэрийг оруулах зайлшгүй цаг хугацааны болоод нийгмийн ийм шаардлага үүссэн байна гэдэгтэй бол би тантай санал нэг байна.

Ж.Бат-Эрдэнэ: Отгонбаяр гишүүн

У.Отгонбаяр: “Шинэ хоршоо”, “Чинээлэг малчин” хөтөлбөрийн хүрээнд бас зүйл тодруулъя. Энэ хөтөлбөр эхэлснээс хойш үндсэндээ жилийн 18 хувийн хүүтэй зээлийг 12 хувийг нь Засгийн газар хариуцаж байгаа. Зээл авч байгаа хоршоологчид бол 6 хувийн хүү төлж байгаа. Тэгээд энэ 12 хувийн хүү засаг дээр өр болоод бичигдээд яваад байгаа. Энэ өнөөдөр яг ямар түвшинд хэчнээн төсөл, арга хэмжээнд Засгийн газар дээр хэчнээн төгрөгийн өр яг өнөөдрийн байдлаар энэ 2025 оны эцсээр бий болсныг бас тэр тоог хэлж өгөөч. Цаашдаа яг энэ өр ингээд зүгээр бичигдээд яваад байх юм уу? Ямар арга хэлбэрээр энийг бас зохицуулалтыг нь хийж явах талаар бас мэдээлэл өгөөч гэж хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Идэрбат сайд.

Ц.Идэрбат: “Шинэ хоршоо” хөдөлгөөнтэй холбогдуулаад 844 мянга тэрбум төгрөгийг 24.9 мянган зээлдэгчид олгосон. Үүний зээлийн татаасанд 25 оны дүгнэлт хэдүүлээ ярьж байгаа учраас 25 онд бол 59.4 тэрбум төгрөг хүүгийн татаасанд өгсөн. 26 оны хуваарь дээр бол 57 тэрбум гээд ингээд хүүгийн татааснууд нь өгөгдөөд ингээд явж байгаа.

Энэ зээлийн зарцуулалт дээр бол янз янзын л дүгнэлтүүд байгаа. Гэхдээ зээлийн эргэн төлөлтийн хувьд бол бас сайн ангилалтай явж байгаа гэсэн ийм мэдээллийг холбогдох энэ Шадар сайдын ажлын алба энэ хоршоо хариуцсан нэгжээс бол бидэнд өгч байгаа. Тэгэхээр энэ дээр бол ямар нэгэн хүндрэл юмнууд

бол гараагүй. Харин би түрүүнд хэлсэн нэгэнт ингээд урьд нь олддоггүй байсан 6 хувийн хүүтэй зээл малчдад очсон. Үүнийгээ ашиглаж байгаа малчдаа хоршуулах, нэгдүүлэх энэ ажиллагаагаа нэгдсэн удирдлага дээр хангуу.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Улсын Их Хурал бол Улсын Их Хурал шиг байх ёстой гэж би бол бодож байгаа юм. Монголбанк, Төрийн албаны зөвлөл өмнө нь асуултад хариулж чадаагүй. Асуултын хариултыг бичгээр ирүүлбэ гээд энэ танхимаас гарсан. Хариу нь одоо болтол ирээгүй таг мартчихсан юм. Тэгээд биелэхгүй юм бол Улсын Их Хурлын дарга тэр индэр суугаад л их уран гоё яриад л ухаантай царайлаад байх хэрэг байхгүй. Нөгөө 20 гаруй сайдтай энэ Засгийн газраас чинь энд бол яг 7 сайд л сууж байна шүү дээ. Төсвийн ерөнхийлөн захирагч нар бүгд сууна гээд Дэгийн тухай хууль дээр байгаа. Тэгээд энэ хариуцлагыг бид нар Улсын Их Хурал ярихгүй юм бол хэзээ ярих юм бэ? Энэ чинь 133 их наяд төгрөгийн асуудлыг ярьж байгаа энд.

Уг нь бол би энэ Дэгийн тухай хуулийг өөрчлөөд 1 гишүүнд 10 минут, 15 минут, хариулт нь 6 минут байдаг байдлаар хууль санаачлаад явсан. Монгол Ардын нам хэлэлцэхгүй хойш нь татсаар байгаад одоо ингээд гишүүд нь Их Хурлын даргаасаа минут гуйдаг энэ байдлаар явж байна. Энэ бол жаахан харамсалтай байна. Тэгээд энэ Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын дарга болонгуутаа чам шиг юм гэнэ Улсын Их Хурлын гишүүн болчихоод томроод байгаа юм уу гэнэ, дарамтлаад байгаа юм уу? Энэ Улсын Их Хурлын даргын хувийн компани биш энэ бол Улсын Их Хурлын гишүүд. Иргэд нэхээд энийг яриадах гээд байгаа байхгүй юу. Тэрийг өөрт нь бас хэлчихье дээ.

Тэгээд энэ яг тодорхой 6 асуулт байгаа юм. 25 оны төсвийг Улсын Их Хурал батлахдаа 1 их наядын алдагдалтай баталж байхад Ерөнхийлөгч хориг тавьсан юм. Яагаад гэсэн чинь мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлбэ, урсгал зардлаа танаа гээд. Гэтэл сая нийслэлийн сонсгол дээр яригдсан асуудал нийслэл дээр 3 жилийн хугацаанд 7 их наяд төгрөгийн алдагдал үйлдвэрлэчихсэн байна. Энийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Сангийн яамнаас тодруулга авъя

Хоёрт нь төсвийн сахилга бат тэг байна гээд байна. Одоо муу байна гээд байгаа юм. Аудит энэ дээр 4 минутад багтаагаад бас тайлбар өгөөдхөөрэй. Энэ бол аудитын энэ дүгнэлттэй холбоотой байгаа мэдээлэл.

Гуравдугаарт нь энэ 24-өөс 25 онд энэ бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ гээд энэ 15.2 их наяд төгрөг байгаа. Энэ дээр бас аудитаас тайлбар авъя. Яг энэ юуны зардлууд гараад явчихсан болоод 24 онд 25 оноосоо 15.2 их наядаар илүү байсан бэ гээд. Тэгээд дөрөвдүгээрт нь замбараагүй төлөвлөлтгүй учраас одоо дахиад тодотгол хийх юм уу? Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуух гээд байгаа юм. Энэ нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нэгдсэн төсвийн нийт зарлага, нэгдсэн төсвийн суурь зарлага гээд энэ бүгдээрээ ингээд учир нь алдагдчихсан.

Жишээлэхэд энэ Цахим хөгжлийн яаман дээр 88 тэрбум төгрөгөөр программ хангамж авсан энийгээ тайлан дээрээ 21 тэрбумаар дутуу тайлагнаад биччихсэн 66.7 тэрбум гээд. Энэ дээр тайлбар өгөөч гэж байгаа юм.

Тэгээд 5-д нь энэ аудит өмнөх жилийг яг энэ төсөв ярьж байхад бид нар дотроо ингээд ийм хариуцлага ярьдаг нэгжтэй болчихсон ингээд хариуцлага яриад үр дүнд хүрээд явна гэсэн жилийн өмнө. Одоо ямар үр дүнд хүрсэн, хэн ямар хариуцлага хүлээсэн бэ гэдэг дээр тайлбар авъя. Тэгээд 6-д нь энэ 1 минутаа нэмээд авчих уу дарга аа?

Ж.Бат-Эрдэнэ: 1 минут сунгая. Цогтбаатар гишүүний минутыг сунгая.

Да.Цогтбаатар: “Эрдэнэс Тавантолгой”-н ногдол ашгаас төрд ногдох 3.3 их наяд төгрөгийг урт хугацаат өр төлбөр дээр бүртгээгүй байна гэж байгаа юм Засгийн газрын Хэрэг эрхлэх. Өмнө нь бол “Эрдэнэс Тавантолгой” Уул уурхайн яамныхаа харьяа байсан дараад нь Хэрэг эрхлэх газар руу шилжсэн. 33.3 их наяд төгрөг хаачсан бэ? Ахмадын тэтгэвэр нэмье гэхээр 1 их наяд билүү 4 их наяд билүү төгрөг яригддаг. Багш, эмч нарын цалин нэмье гэхээр бас 3, 4 их наяд төгрөг яригддаг. Энд чинь мөнгө байгаад байна. Хариуцлага алга. Үрж байгаа хүмүүс нь хүний юманд хүүтэй ханддаг гэдэг шиг л хандаад байгаа учраас Монголд хариуцлага байхгүй, төсөв дээр хариуцлага байхгүй ийм салан задгай явж байгаа гэдгийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хүртэл хэлээд байна. Энэ дээр бас хариулт авъя. Яг тодорхой 6 асуулт.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтбаатар гишүүний хариултад аудит, дараа нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. 3 номерын микрофон. Сангийн яам, эхлээд Сангийн яам Мэндсайхан сайд. Мэндсайхан сайдын микрофон.

3.Мэндсайхан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ Төсвийн тухай хууль дээр. Өмнө нь энэ юу байсан юм байна лээ Цогтбаатар аа Төсвийн хуулийн бол тогтвортой байдал алдагдаад байгаа талаар та хөндөгдөөд байна шүү дээ. Тэгэхээр гол асуудал юун дээр байна вэ гэхээр өмнө нь бол Төсвийн хуульдаа бид нар орлого, зарлагын орон нутгийн энэ орлого зарлагыг тусгаад өгчихсөн тэр харилцаагаараа зохицуулаад явдаг байсан. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль батлахдаа эндээс бүх зарлагын асуудлаа улсын төсвөөс аваад явчихсан. Зөвхөн орлогын асуудлыг нь үлдээчихсэн.

Тэгээд Төсвийн тухай хууль дээр юу байна вэ гэхээр гол асуудал бол аймаг, орон нутгийн төсөв алдагдалгүй батлагдах ёстой. Тэгэнгүүтээ та бид хоёр бас сууж байгаад энд хамт сууж байгаад нийслэлд бонд гаргана аа гээд 500 сая долларын бонд гаргах эрхийг нь өгчихсөн. Энэ чинь ингээд бонд гаргаад ирнэ гэдэг чинь нөгөө өр үүснэ гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр нөгөө Төсвийн хуулийн чинь хэмжээгээр энэ бондын хэмжээгээр өр нь өсөөд явчхаж байгаа юм. Энэ чинь нэгдсэн нэгдсэн төсөв дээр ирээд өр үүсээд орон нутгийн, нийслэлийн зардал өсөөд явчхаж байгаа юм. Төсвийн хязгаарыг бид нар хуулиараа Их Хурал түрүүлж баталж байгаа. Орон нутагт 6.9 их наядын орлого, зарлагын гүйлгээ хийнэ ээ. Ирэх онд төсөв нь ийм багцаанд байна аа гэдэг хийгээд өгөхөөр зэрэг нөхдүүд аваачаад иргэдийн хурал нь орлогоо 1.5 хийх дээр ба нэмэгдүүлээд зарлагаа 3.7 болгоод нэмэгдүүлчхаж байгаа байхгүй юу.

Энэ гол нөлөөлж байгаа юм нь юу байна гэхээр зэрэг Төсвийн хууль хууль дээр урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлнэ гэдэг энэ заалтыг үндэслээд урьд оны үлдэгдлээс 2.2 их наядын зардал жишээ нь нийслэл дээр ороод ирж байгаа юм. Бонд нь нэмэгдээд ороод ирж байгаа юм. Ингэнгүүт бид нарын ба одоо Төсвийн хуулиар баталж өгсөн хязгаараас 3.9-өөр даваад явчихна, 7-гоор даваад явчхаж байгаа юм. Энэ хоёр ийм ойлгомжгүй заалт чинь эргээд бид нарыг аваачаад улсын нэгдсэн төсөв дээр алдагдал болгож хувиргаад байна аа. Нийслэлд орон нутгийн гаргаж байгаа.

Тэгэхээр бид нар энэ эрх зүйн хувьд энэ асуудлыг энэ намрын төсөв өргөн барихтай зэрэгцүүлээд нийслэлийн энэ асуудлыг шийдэхгүй бол цаашдаа бид нар улсын төсөв, орон нутгийн төсвийг хянаж чадахгүй зардлын тэлэлтийг бид нар дийлэхгүй болно. Энэ чинь аймаг, орон нутгийн Иргэдийн Хурлын төлөөлөгч нар сууж байгаад шийдчихэж байгаа асуудал шүү дээ.

Бид нар энд 126-уулаа хуралдаж байгаад хязгаарыг нь, төсөв батлаад хязгаарыг нь гаргаад өгөөд батлаад өгч байгаа. Тэгэнгүүт тэр Төсвийн хуулийн 57.3 дээр байгаа заалтыг үндэслээд л төсвөө нэмээд явуулчхаж байгаа юм.

Бас нэг асуудал нь тэр бондыг бол бид нар гаргаад өгчихсөн. Тэгэхээр ер нь цаашдаа бол энэ аймаг, орон нутагт бонд гаргахыг бид нар эргэж харах ёстой юм байна лээ. Одоо орон нутаг дээр бол Өмнөговь орсон. Эднийх болохоор зэрэг орлогынхоо 3 жил дараад 5 жил дараад татаас аваагүй орлогын тэд 70 хувиас доошгүй байна ч гэдэг юм уу энэ нөхцөлөө хангаад явж байгаа.

Гэхдээ Өмнөговь шиг аймаг бол манайд олон биш шүү дээ. Гол асуудал бол нийслэл дээр байна. Тэгэхээр энэ орон нутгийн төсөв, энэ хоёр төсвийн хоорондын харилцааг зохицуулах энэ заалтуудаа бид нар намрын чуулган дээр төсөв өргөн барихдаа зайлшгүй анхаарч шийдэх ёстой юм байна аа гэдгийг танд хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: 3 дугаартай индэр дээр Аудитын газар.

С.Магнайсүрэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Магнайсүрэн. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангах асуудал дээр бид бол онцгойлон анхаарч ажиллаж байгаа. Энэ талаар холбогдох байнгын хороо гишүүдээс гарсан санал, чиглэлүүдийг бид нар бодлого үйл ажиллагаандаа тусгаж дүрэм, журмаа баталсан.

Өнөөдрийн байдлаар 2025 оны санхүүгийн зөрчлийн нэгтгэлээс харах юм бол өнгөрсөн жилтэй харьцуулахад харьцангуй буурсан дүн, мэдээтэй байгаа боловч одоогийн байдлаар жишээлбэл 13442 зөрчил нэгтгэлд бид нар авсан. 11.8 их наядын дүнтэй. Энэ дотор гол эзэлж байгаа 8.1 их наядын зөрчил нь болохоор төрийн болон орон нутгийн өмчийн болоод орон нутгийн өмчийн оролцоотой энэ аж ахуйн нэгжүүдэд дээр голлож байна аа гээд. Түрүүн бас Цогтгэрэл гишүүн асууж байсан шилэн данстай холбоотой зөрчлийн ихэнх нь бас.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

С.Магнайсүрэн: Ихэнх нь энэ төрийн болон орон нутгийн өмчит компани болоод төртэй гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа ийм ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа компаниуд дээр энэ зөрчлүүд бол гарсан байдаг.

Өнөөдрийн байдлаар бид нар 25 оны аудитын дүнгээр 29 асуудлыг хууль хяналтын байгууллагад, 7.6 тэрбум төгрөгийн дүнтэй 29 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. 252 албан актаар, албан шаардлагаар 278 хүн хүнд ногдох 280.8 тэрбумын дүнтэй асуудал дээр хариуцлага тооцуулахаар холбогдох байгууллагуудад хандсан байгаа.

Мөн Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан зарим хариуцлага хүлээлгэх үндэслэл болон албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно гэсэн 4, 5-н заалттай холбоотой асуудлуудыг томилох эрх бүхий этгээд буюу эрх бүхий байгууллагуудад нь бид нар хуулийг үндэслээд жагсаалтаар харьяа байгууллагуудад.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 4 дугаартай индэр дээр.

Ж.Дэлгэрсайхан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл. Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн төсөвтэй холбоотой асуулт асуулаа. Нийслэлийн төсөв 2024 онд 2 их наяд 158 тэрбум төгрөг, 2025 онд 2 их наяд 781 тэрбум төгрөг, 2026 онд 2 их наяд 52.7 тэрбум төгрөгийн алдагдалтай баталсан. Энэ нийт алдагдлын хэмжээ нь 6 их наяд 999 тэрбум төгрөг болоод байгаа юм. Тэгэхээр энэ алдагдлыг баталж байгаа байдал нь 2 зүйл дээр хуулийн зөрчил үүсэж байгаа гэж манай зөвлөлөөс үзээд байгаа.

Хуулийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 57.2-т орон нутгийн төсвийг алдагдалгүй батлахаар заасан байдаг. Мөн 2026 онд нийслэлийн алдагдал нь Улсын Их Хурлаас баталсан төсвийн нийт алдагдлын хязгаарыг 1.4 их наяд төгрөгөөр давж төлөвлөгдсөн ийм байдлаар хуулийн зөрчил бол байна гэж үзэж байгаа. Гүйцэтгэлээр нь харвал 2024 онд нийслэлд 920 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан нэгдсэн.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Ж.Дэлгэрсайхан: Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн алдагдлын хэмжээтэй тэнцүү байгаа бол 2025 онд алдагдал нь нэгдсэн төсвийн нийт алдагдлын 75 хувьтай тэнцүү. 2026 онд төлөвлөсөн алдагдал нь бол нэгдсэн төсвийн алдагдлын хэмжээнээс 1 их наяд төгрөгөөр давчихсан ийм алдагдал байгаа. Ийм алдагдлыг бий болгоод байгаа шалтгаан нь бол удаа дараагийн төсвийн тодотголууд тэгээд үндэслэл болж байгаа зүйл нь бол урд оны үлдэгдлээр зарлагаа тэлээд байгаа ийм практик байна. Мөн үнэт цаас, бонд гаргах, давтамжтай тодотголууд орлогоос давсан гээд зардлын тэлэлтүүд нь ийм зөрчлүүдийг гаргаад байгаа гэсэн ийм мэдээлэлтэй байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтбаатар гишүүн. Цахим яам 4 дугаартай индэр.

Б.Мягмарнаран: Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Мягмарнаран. Цахим

хөгжил, инновац, харилцаа холбооны яамны харьяа Үндэсний дата төв болон И-Монгол Академи ажилладаг. Үндэсний дата төв нь болохоор төрийн цахим шилжилтийн үндсэн суурь, дэд бүтэц бүгдийг хариуцаж явдаг байгаа. Тэгээд үүнтэй холбоотой маш олон системүүд буюу төрийн мэдээлэл солилцооны “Хур систем” төрийн үйлчилгээний цахим машин, танил нэвтрэлтийн систем E-Mongolia платформ гээд энэ олон системүүдийг бүртгэж явдаг. Үүнтэй холбоотой нөгөө лицензийн бүртгэлүүд орж ирдэг. Тэгээд лицензийн бүртгэлүүдээс нөгөө лицензийн хугацаа дууссантай холбоотой бүртгэл нь тэгж орж бүртгэгдсэн байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Цогтбаатар гишүүнд 1 минут.

Да.Цогтбаатар: Сангийн яам бас энэ Ерөнхий сайд хоёрт хоёуланд нь хандаж хэлэхэд нийслэлийнхээ асуудлыг энэ нэгдсэн улс гэж ярьж байгаа бол онцгой анхаарч явахгүй бол өмнөх оныхоо зардлаа дараагийнхаа он руугаа шилжүүлж аваад байна аа гээд, энэ хуулийн зөрчил гараад байна аа гэдгийг энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнээд байгаа. Энийг онцгой анхаарч ажиллахгүй бол 3 компаниас 200 сая төгрөгийн тэтгэмж авдаг 15 туслахтай Засгийн газраар ярих юм бол Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд, Шадар сайдуудыг нийлүүлснээс том эрх мэдэлтэй нэг дарга жишээлэхэд нийслэл дээр байгаад байгаа. Энэ дээр онцгой анхаарал хандуулж ажиллахгүй бол улсын төсвийн алдагдлаас их хэмжээний алдагдлыг нийслэл дээр үйлдвэрлэлчхээд байна аа гэдгийг бас онцгой анх анхаараарай.

Энэ Цахим хөгжлийн яам бол яах вэ 20 их наяд үгүй ээ 20 тэрбум төгрөгийг бас ингэж нөгөө хугацаа хоцруулж бүртгэнэ энэ тэр гэдэг дээр бас жоохон онцгой анхаарч ажиллахгүй бол би хэлээд байгаа биш энэ аудитын тайлан дээр байгаа тоо. Аудитын тайлан дээрээс л асууж байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Сангийн сайдаас нэг зүйл асуучихъя санасан дээрээ. Энэ компаниудын гүйцэтгэлийг ноднин, урьд жилийн компанийн хийсэн гүйцэтгэлийг энэ жилийн төсөвт тавьсан хөрөнгөөс нь хасаад байна гээд тэгэх юм. Энэ ямар учиртай юм? Сангийн сайд

3.Мэндсайхан: Өнгөрсөн оны санхүүжилтээс 286 тэрбум төгрөгийн санхүүжилт шилжиж орж ирсэн. Үлдэгдэл байсан тэр нь оны эхэн дээр санхүүжүүлээд дууссан. Энэ оны шилжээд явж байгаа хөрөнгө оруулалт нь суусан энэ чигээрээ л явж байгаа. Түүнээс биш ямар нэгэн тийм аж ахуйн нэгжийн тухайн Төсвийн хууль дээр заасан санхүүжилтээс нь асуу тийм ойлголт бол байхгүй.

Ж.Бат-Эрдэнэ: Төсвийн тухай хуулиараа л явж байгаа юм.

3.Мэндсайхан: Төсвийн хуулиараа л явна.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэс Тавантолгойн 33 их наядтай холбоотой асуудал хэн хариулах юм? Хариулах хүн байна уу? Дэгийн тухай хуулиараа энэ төсвийн захирагч нар, сайд нар. Ер нь бол сууж байгаа л даа. Бид нар чинь давхар дээл гэгчээр Засгийн газрын Улсын Их Хурал, Засгийн газар бол хамтдаа ч давхар дээлтэй ч яваад байгаа. Тэгээд аль алийг нь бас бодолцох юм харагдаад байгаа юм. Ер нь бол суух хэрэгтэй шүү. Бид нар бол шаардлага тавьж байгаа. Номин сайд алийг хариулах юм? 4 номер.

Б.Батцэцэг: Засгийн газрын Хэрэг эрхлэх Тэргүүн дэд дарга. Батцэцэг Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. “Эрдэнэс Тавантолгой” компанийн эрх бүхий байгууллага ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гаргасан тохиолдолд төрийн өмчид ногдох ногдол ашгаас “Эрдэнэс Тавантолгой” компани болон “Эрдэнэс Монгол” компани, түүний нэгдэлд хамаарах төрийн өмчийн оролцоотой бусад аж ахуйн нэгжүүдийн хооронд үүссэн өр авлагыг суутган тооцохоор зохицуулсан.

Гэвч энэхүү зохицуулалт бол бодитоор хэрэгжээгүй 2022-оос 23 онд бол төрд ногдох ногдол ашгийн 3.4 их, 4 орчим их наяд төгрөгийн урт хугацаат өр төлбөр санхүүгийн тайланд тусгасан байгаа. “Эрдэнэс Монгол” нэгдлийн дотоод үүссэн өр, дотор нь хоорондоо үүссэн өрийг тооцоо нийлж суутган тооцох ажлыг бол 26 онд эхний ээлжид 1.9 их наядыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Оройн мэнд. Бид нар ер нь энэ Улсын Их Хуралд бид өөрсдөөсөө л алдаагаа хайх нь зөв юм шиг байна даа. Сайхан хууль батална. Тэгээд тэрнийхээ хэрэгжилтийг хянаж байгаа, үр дүнг нь хянаж байгаа ч юм алга. Төсөв батална, гүйцэтгэлд нь хяналт тавьж байгаа байдал нь өнөөдрийнх шүү дээ яг үнэндээ.

Ер нь 2025 оны төсвийнхөө гүйцэтгэл энэ бүгдээр хяналт тавьж байгаа байдлаа бид нар өөрсдөө харахгүй юу даа. Өчигдөр ирсэн байгаа байхгүй юу энэ зузаан ном. Ийм 3 хуудас зузаан ном. Яаж 24 цагт ийм зузаан номыг уншиж үзэх юм. Энэ чинь ядаж 10 хоногийн өмнө бид нарт урьдчилаад тараачхаж болно шүү дээ. Тэгээд хэдэн ерөнхий асуулт л асуухаас. Цаашдаа анхаарахгүй бол энэ чинь ерөөсөө болохгүй л дээ. Баталсан төсвөө ч аятайхан гүйцэтгэл дээр хяналт тавьж чадахгүй.

Сангийн сайдаас төсвийн урсгал зардал 25 онд нийт зарлагын 74, 73.4 хувийг эзлэхээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээрээ 77.4 хувьтай гарсан байна. 4 хувь ямар их зөрүү гараа вэ? Энэ ямар учиртай юм? Ер нь энэ чинь Аубакир сайд байна уу? Манай энэ нийтийн санхүү чинь дампуурчихсан юм биш үү? Аубакир сайд анхааралтай сонсож байгаарай. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал гээд баахан сангуудын чинь авлагын үлдэгдэл нь 1.7 их наяд болсон байна. Өнгөрсөн жил 25 оны эцсээр 242.5 тэрбумаар өссөн байна авлага чинь. Авлага нь ийм байгаа юм чинь нөгөө өр шир нь юу болж байгаа юм? Олон жилийн энэ насжилттай авлагуудаа яах гэж байгаа юм? Ямар бодлого, чиглэл баримталж байгаа юм? Авлага, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын сангийн өрийг надад тодорхой хэлээд өгнө үү.

Гурав дахь асуудал нь энэ улсын нийт өр эзэлж байгаа гадаад Засгийн газрын өр 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар манай улсын нийт гадаад өр 23.4 тэрбум ам.доллар байжээ. Та бүхэн тэр үед улс орон хэцүүдлээ 1 хүнд 20 сая төгрөг ногдох өртэй болчихлоо гээд ярьж байсан 10 жилийн өмнө. Тэр 10 жилийн өмнөх өр бол 90 оноос хойш өр байсан. Сүүлийн 30-аад жилийн. Сүүлийн 10 жилийн дотор одоо энэ өр чинь 1 хүнд ногдох өр чинь 41 аравны, 41 сая 140 мянган төгрөг болчихсон байна. Хамгийн анхаарууштай зүйл маань бид нар

Засгийн газрын нийт өр 25 оны гүйцэтгэлээр 8 тэрбум доллар буюу 35.4 их наяд, 21 онтой харьцуулахад 32 хувиар өсчихсөн байна шүү дээ. Нийт гадаад өрийг чинь.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 1 минут нэмж өгье Ганбаатар гишүүнд.

Г.Ганбаатар: Нийт гадаад өрийн чинь 22 хувь нь Засгийн газрын өр болчихоод байна. Энэ гадаад өрийн эзлэх хувь чинь жил ирэх тусам өсөөд байгаа Засгийн газрын өрийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх тал дээр Сангийн сайд юу бодож сууна вэ? Эдийн засгийн сайд байна уу? Хэн нь хариулах вэ? Тэгээд ийм 3 ерөнхий асуулт асуучхаад дараа нь тодруулж хэлье ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Сангийн сайд эхлээд хариулъя. Дараа нь Аубакир сайд хариулъя. Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын өргөсөн та сайн мэдэж байгаа Дорноговь аймгийн Алтанширээ дээр бид нар газрын тосны үйлдвэр энэ өөрөө дангаараа 1.7 их тэрбум доллар. Энэ дээр Эрдэнэбүрэний усан цахилгаан станц гээд энэ хоёр өөрөө 2 тэрбум долларын 7 их наядаар өссөн.

Тэгэхээр энийг бид нар богино хугацаанд нь гаргах энэ өрийн удирдлагыг, менежментийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх ашигтай байлгах үүднээс л сая хавар бид нар Гадаад зээл ашиглах тухай хуулийг бид нар баталлаа шүү дээ. Тэгээд энэ их зээлүүд чинь авчхаад нөгөө цаг хугацаандаа гарч чадахгүй бид нар төсвийн хязгаараараа ямар хэмжээтэй гараад байгааг та мэдэж байгаа 1.2. Голлож нөлөөлсөн 2 төсөл бол энэ 2 байгаа.

Нийт өрийн хувьд бол бид нар төсвийн гадаад, Өрийн удирдлагын тухай хуулийнхаа шаардлагыг хангаад явж байгаа. Өнөөдөр 38.5 их наядын өртэй байна. Гадаад зээл, Засгийн газрын өр. Энэ чинь бол ДНБ-ий 40 хүрэхгүй хувьтай байгаа. Өрийн удирдлагын хуулиараа 60 хүртэлх хувь байж болно оо гэж байгаа. Тэгэхээр бид нар бол энэ дээрээ бол үе шаттай бууруулаад ашиглалтыг нь сайжруулаад явж байгаа.

Цаашдаа харин бид нар ер нь эрх зүйн орчиндоо ч гэсэн өөрчлөлтүүдийг хийх ёстой. Одоо бид нар дундаас дээш орлоготой орон болсон гэдэг энэ олон улсын байгууллагуудын донор орнуудын чинь ард бид нар өөрсдөө арилжааны банкны, арилжааны хүүтэй зээл л олох ийм боломж руу орж ирж байгаа юм. Нэг ёсондоо хөнгөлөлттэй зээл Монгол Улсаас ер нь холдож байна гэсэн үг. Тэгэхээр энэ дээр бид нар харин Засгийн газар дээрээ аваад явах уу? Цаашдаа Хөгжлийн банкаараа явах уу? Тэгвэл Хөгжлийн банкаа энэ олон улсын “Эксим” банкны шаардлагад нийцүүлэх, нөгөө талдаа тэр өөрийнх нь засаглал талд нь авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээ шат дараатай авч энэ асуудлыг цааш нь сайжруулж явах ёстой гэж үзэж байгаа юм. Түүнээс биш нэгэнт тэртээ тэргүй харин Хөгжлийн банкаар явлаа гэхэд Засгийн газрынхан баталгаагаа гаргаад гаргана.

Урсгал зардлыг 70 хувьтай санхүүжүүлсэн байна гэххэв үү та хэд гэсэн билээ? Тэн дээр 74 хувьтай гээд тэгж байсан. Нийт зардлын өөрөө 100 хувь гэж

үзэх юм бол 74 хувь нь урсгал зардал байгаа юм. Тэгэхээр энэ урсгал зардал дээр та мэдэж байгаа хуульчлагдсан зардлууд л явж байгаа шүү дээ. Эрүүл мэндийн салбарын зардал явж байна. Боловсролын салбарын зардал 2 нийлээд тэр ер нийт урсгал зардлыг чинь бараг 75 хувийг нь эзэлж байгаа. Цаана нь төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр гарч байгаа зардлууд эзлээд л явж байгаа. Тэгэхээр нь бид нар нийт зардлаа 100 хувь гэж үзэх юм бол ер нь 10 хүрэхгүй орчим хувь нь л хөрөнгийн зардал гараад явж байгаа шүү дээ. Үлдсэн зардал нь бол хуульчлагдсан урсгал зардлуудаа л бид нар санхүүжүүлээд явж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Аубакир гишүүн хариулъя.

Т.Аубакир: Тийм. Сая энэ Учралын Засгийн газрын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хүрээнд чөлөөлтийн арга хэмжээний хүрээнд 160 орчим аж ахуйн нэгжийн барилттай байсан буюу данс хаасан арга хэмжээг нээхэд 2.1 их наяд, 2,1 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байгаа юм. “Капитал” банк болон “Чингис хаан” банкин дээр өр авлага үүссэн байсан. Хэн сайдын үед билээ дээ Нийгэм даатгалын сангийн мөнгийг энэ банкнууд руу хийчхээд жоохон асуудал үүссэн. Бид нар өр барагдуулах арга хэмжээг аваад явж байгаа.

Нийтдээ 230 орчим тэрбум төгрөг байснаас одоо яг үлдэгдэл 110 тэрбум төгрөг байгаа. Саяхан бид нар энэ долоо хоногийн эхээр бас хэлцлүүд хийж эхэлсэн. Тэр өртэй банкнуудын санал болгож байгаа 20 орчим тэрбум төгрөгийн яг Норвегийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон хүнсний зоорины асуудлыг өр, авлагадаа аваад нийслэлд юм уу, эсвэл худалдаад авъя гэсэн аж ахуйн нэгжүүдэд байгаа юм. Гэх маягаар бид нар.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя Аубакир.

Т.Аубакир: Капитал Чингис Хаан банкин дээр үүссэн өр, авлагыг бол Авлигатай тэмцэх газар, Сангийн яам, манай яам гэдэг ч юм уу ингээд нэгдсэн ажлын хэсэг гараад өр барагдуулах ажил сүүлийн үед маш сайн явж байгаа шүү дээ. Энэ 2 энэ банканд хэн сайдын үед билээ дээ ийм өр, авлага үүсчихсэн байгаад байдаг юм. Одоо бол энэ асуудал хуулиараа хаагдчихсан. Одоо хэрвээ чөлөөт үлдэгдэл байх юм бол системийн чадалтай банкнуудад бид нар санал болгоод 100 тэрбум төгрөг байна. Хэн өндөр хүү амлах вэ гэдгээр шилэнгээр ингээд өрсөлдүүлээд бид нар хадгалуулаад явж байгаа.

Үлдэгдэлтэй яагаад үлдчихээд байдаг юм бэ гэж. Манай Үйлдвэрлэлийн ослын сан бол ашигтай гардаг ганцхан сан. Энийг бол бид нар бодлогын хүүгээс доошгүйгээр өсгөх үүрэг хүлээсэн байдаг. Үүгээрээ бид нар 15.11 хувийн хүүтэй 700 тэрбум төгрөгийг системийн 4 банканд хадгалуулаад явж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулъя. Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Мэндсайхан сайд аа асуулт анхааралтай сонсоорой. Энэ төсвийн Тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт дээр 25 оны нийт зарлага 73.4 хувиар төлөвлөгдсөн боловч гүйцэтгэлээрээ 77.4 хувиар зарлага 4 хувиар өссөн байна аа гэсэн дүгнэлт байна л даа. Би тэрийг асуусан байхгүй юу.

Хоёр дахь нь яах вэ тэр гадаад зээлийн өсөлт Засгийн газрын өр эд нар нэмэгдээд байгаа гээд энэ Алтанширээгийн газрын тосны үйлдвэртэй холбогдуулаад яриад байна. Та бүгдийн энэ тараасан материал дээр чинь энэ нийтдээ гадаад зээл, тусламж 25 оны яах вэ санхүүжих дүн нь 2 их наяд боловч нийт хэлэлцээрийн дүн чинь 21.1 их наяд гэж байгаа. Төгрөг гэж байгаа байхгүй юу. Энэ чинь асар их мөнгө шүү дээ. 21.1 их наяд. Тэгээд энэ дээр хэнд хяналт тавьж байгаа юм? Яг үнэндээ наад Алтанширээгийн газрын тос.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээгээд асуучихъя.

Г.Ганбаатар: Яг үнэндээ 2 тэрбум доллароор манай улсын ялангуяа Засгийн газрын гадаад өрийг нэмж байгаа наад Алтанширээгийн газрын тос боловсруулах үйлдвэр чинь бол эдийн засгийн хувьд ямар ч үр ашиггүй төсөл шүү дээ. Ирээдүй нь бүрхэг төсөл шүү. Түүхий эдийн нөөцгүй, эдийн засгийн өгөөжгүй. Тэгээд ийм юман дээр ингээд гадаад зээлийн ялангуяа Засгийн газрын гадаад өр чинь нэмэгдээд байна аа л гээд байгаа юм.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя Шадар сайд.

Ж.Энхбаяр: Эдийн засгаас илүү улс орны аюулгүй байдлын асуудал, гадаад орчинд гарч байгаа асуудалтай холбоотой нефть, шатахууны хангалт яаж хүндэрч байгааг. Тэгэхээр Монгол Улс дотооддоо нефть боловсруулах ёстой. Нөөц байна, боломж байна, үйлдвэр баригдаж байна, 27 онд дуусна. Нефть дамжуулах хоолой баригдаж дуусаж байна. Одоо бид нефтийн газрын тосныхоо олборлолт, геологи хайгуулалт, тэнд гарсан бодлогын алдаагаа засах ийм хууль, эрх зүйн орчныг өнөөдөр Их Хурал хэлэлцэхээр шийдсэн. Энэ хүрээнд бүгдээрээ дэлгэрүүлж ярих байх.

Ер нь Засгийн газрын өр зохистой хэмжээнд байгаа. Нийт ДНБ 60 гэсэн дээд босго байгаа. Өнөөдөр 39 хувьтай байна. Гол нь гадаад зээлийн ашиглалтаа бид нар нэмж эдийн засгийн хөгжлийн суурь салбарууддаа нэлээн анхаарна. Эрчим хүчин дээр, дэд бүтэц дээр, сэргээгдэх дээр энэ зээлийн ашиглалтыг нэмэгдүүлнэ. Учир нь юу вэ гэвэл.../минут дуусав./

С.Бямбацогт: Энхбаяр сайд гүйцээгээд хариулчихъя.

Ж.Энхбаяр: Гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлж бид нар төсөв маань өнөөдөр урсгал зардлын хэт нэмэгдэл, цалин тэтгэврийн их өсөлттэй холбоотойгоор төсвөөр дамжуулж хөгжлийн дэд бүтцүүдийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх бололцоо хязгаарлагдмал болж байгаа юм.

Иймд гадаад зээлийн ашиглалтыг жоохон нэмье. Монгол Улсын Засгийн газрын олон улсад гаргасан бүх зээлийн төлбөрүүд, бондуудын төлбөрүүд бүрэн цаг хугацаандаа бүрэн төлөгдсөн. Ямар нэгэн зээл хугацаа хоцроосон зүйлгүй. Монгол Улсын зээлжих зэрэглэл тогтвортой өсөж байна. Дандаа тогтвортой сайн гэсэн ийм үнэлгээтэй байгаа. Валютын нөөц ч хамгийн өндөр 7.7 тэрбум долларт хүрсэн. Тэгээд энэ үед эдийн засгаа эрчимжүүлэхэд бид нар гадаад зээлийн ашиглалт, гадаад зах зээлээс санхүү хямд эх үүсвэр татах нь л гол бодлогын тэргүүлэх чиглэл. Тэгэхээр энэ гадаад зээл дээр бол бид нар гол нь үр өгөөжтэй төслүүдээ л нэн тэргүүнд санхүүжүү.../минут дуусав./

С.Бямбацогт: Мэндсайхан сайд нэмж хариулъя.

3.Мэндсайхан: Ганбаатар гишүүн тэр 21 их наяд гэж байна. 22 их наяд гэж байна. Одоо бид нарын чинь гадаад зээлийн ашиглаагүй баталгаажсан үлдэгдэл чинь 13.8 их наяд байгаа шүү дээ. Тэгэхээр тэр хэмжээгээр хасагдаад төсөл рүүгээ гараад явчихсан гэсэн үг. Бид нар зээлийг өр гэж харахаасаа илүүтэй Дорноговь дээр хийгдэж байгаа нефтийн үйлдвэрийг та өнөөдөр ашиггүй гэж дүгнэх бол та бид хоёрын хувьд эрт байна шүү дээ. Эсрэгээрээ бид нар энэ стратегийн үйлдвэрийг барихад энэ гадаад зээл чинь хөрөнгө оруулалт болж орж ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид нар өр гэхээсээ илүүтэй энийг хөрөнгө оруулалт гэж харах ёстой. Бид нар харин цаг хугацаандаа ашиглалтад оруулаад таны хэлж байгаа эрсдэлээс харин хамтдаа энийг урьдчилан сэргийлэх ёстой.

Хоёрдугаарт Засгийн газрын өр өсөөд байна гэж ярьж байна. Энэ Засгийн газрын хэрэгжүүлж байгаа бүх төсөл, хөтөлбөрийг чинь зээл авахыг чинь бас Улсын Их Хурал батлаад тэрийг Засгийн газар хэрэгжүүлж байгаа шүү дээ. Тэгээд бид нар Өрийн удирдлагаа хуулиа бариад л Их Хурал орж ирж байгаа зээл, хөтөлбөрүүдийг авах, эс үгүйг нь шийдээд, Их Хурал баталсан тохиолдолд бид нар Засгийн газар аваад энэ төсөл, хөтөлбөрүүдийг чинь зориулалтынх нь дагуу хэрэгжүүлээд.../минут дуусав./

С.Бямбацогт: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуултаа асууя.

О.Батнайрамдал: Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Надад маш ойлгомжтой ганцхан багц асуулт байгаа. Тэгэхээр Монголын татварын алба, Сангийн яам, ялангуяа орлого хариуцсан дарга, Үндэсний аудитын газар бэлдэж байгаарай. Оюутолгойтой холбоотой татвартай холбоно оо. Оюу толгой яг том зургаар аваад үзэх юм бол 13 оноос хойш орлого олж эхэлсэн. Тэгэхээр 13 оноос 2026 оны 3 сар хүртэл бол нийт 23.8 тэрбум долларын орлого олсон байдаг юм. Үүнээсээ Монгол Улсад Засгийн газар төлсөн АМНАТ, татвар хураамж, ногдол ашиг угаасаа байхгүй. Энэ бол бүгд энэ хугацаанд энэ 14 жилийн хугацаанд нийлээд 3.2 тэрбум доллар. Тэгэхээр нийт олсон орлогынхоо 13.4 хувийг Монголд, Монголын талд бэлэн мөнгөөр өгсөн гэсэн үг.

13 оноос 22 он хүртэл Оюу толгой дээр татварын багц актууд яваа. 2013-аас 20 он хүртэл нийтдээ 1.3 их наяд буюу 365 сая долларын акт тавигдсан. Арбитр дээр маргаантай яваа. 21-ээс 22 онд дөнгөж саяхан Монголын татварын албанаас 1.6 их наяд төгрөг буюу 450 сая долларын акт тавигдсан байгаа. Татварын акт тавигдсан гэсэн үг. Энэ бодвол буцаад л арбитр дээр явах байлгүй. Одоохондоо гомдол гаргах хуулийн хугацаа нь дуусаагүй юм байна лээ.

Тэгэхээр миний асуух гээд байгаа асуулт 2013-аас 20 оны хооронд тэр 365 сая доллар Оюу толгойгоос Монголын татварын алба буюу Төрийн сан руу бол шилжчихсэн мөнгө тийм үү? Тэгэхээр энэ “contingent liability” буюу болзошгүй буцаан төлөгдөх үүрэгтэй мөнгө гэсэн үг байхгүй юу. Хэрвээ арбитр дээр бид нар ялагдчих юм бол энэ мөнгийг бид буцааж тэр чигээр нь Оюу толгойд өгөх ёстой гэсэн үг. Арбитрын шийдвэрээс эцэслэн шийдэгдэнэ. Тэгэхээр энэ мөнгө Сангийн

яаман дээр яг яаж бүртгэгдсэн бэ? Энэ мөнгө байна уу үгүй юу? Энэ дээр Үндэсний аудитын газар бас ямар дүгнэлт гаргасан бэ?

Хоёрдугаарт дөнгөж 4-хөн сарын өмнө 2026 оны 2 сард Оюу толгойгоос Төрийн сан руу 21-ээс 22 оны татварын акт буюу нийтдээ 1.6 их наяд төгрөгийг Төрийн сан руу шилжүүлсэн. Энэ бол шууд орлого бол биш, буцаад арбитрын шийдвэрээс, эсвэл гомдол гаргахаас шалтгаалж эргэн төлөгдөж болзошгүй “contingent liability” буюу буцаан төлөгдөж магадгүй үүрэг хүлээж байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэ мөнгө өнөөдөр Төрийн сан дээр бас ямар бүртгэлтэй яваа вэ? Ямар бүртгэлтэй байх ёстой вэ? Энэ үрэгдчихээгүй биз дээ? Энэ асуултуудыг Сангийн яам, Монголын татварын алба, Үндэсний аудитын газраас асуугаад нэмж тодруулъя.

С.Бямбацогт: Сангийн яам эхлээд хариулъя. Дараа нь Үндэсний аудит хариулъя. Мэндсайхан сайд. Анар дарга хариулъя. 4 дүгээр микрофон индрийн.

Б.Анар: Татварын хуулиар бол маргаж болно. Гэхдээ бол актын төлбөрийг бол эргэж төлөх ёстой байдаг. Энэ оны эхэнд орж ирсэн Оюу толгойгоос орж ирсэн төлбөр бол Төрийн сан дээр орж ирсэн 1.6 орчим их наядын бол өглөг гэдгээр бүртгэлтэй бол байгаа Сангийн яаман дээр. Зарагдаагүй байна тийм.

С.Бямбацогт: Гишүүдийн асуултад тодорхой хариулчихмаар байгаа шүү дээ. Тодорхой хариулчихмаар байна. 4 дүгээр микрофон бэлдээд хариулъя. Тэр хооронд аудит хариулж байя. 3 дугаар микрофон.

Н.Цэвэлмаа: Гишүүний асуултад хариулъя Засгийн газрын нэгдсэн санхүүгийн тайлан дээр бол өглөгөөр бүртгэгдэж явж байгаа үлдэгдэл нь. Үлдэгдэл нь. Манайх бол сая 2025 оны Засгийн газрын нэгдсэн санхүүгийн тайланд аудит хийсэн байгаа. Энэ аудитын явцад бол Оюу толгойгоос үлдсэн үлдэгдэл төлбөр нь өглөгөөр бүртгэгдэж явж байгаа. Жилийн эцсийн байдлаар 12 сарын 31-нээр. Тэгэхээр о 13-аас 20 оныхыг он дамжаад ингээд үлдсэн нь 25 оны 12 сарын 31-нээр үлдэгдлээрээ бүртгэгдэнэ л гэсэн үг.

С.Бямбацогт: Сангийн яам хариулъя. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон. Татвар татварын ерөнхий газар 3 дугаар микрофон.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар, Цогтнаран. Оюу толгой компанийн үйл ажиллагаанд татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд татварын хяналт шалгалтын актуудыг 2013-аас 22 оны дуустал хугацаанд нийт 4 удаагийн хяналт шалгалт хийгдээд байгаа.

Энэ оны хувьд бол 1.6 орчим их наяд төгрөг Оюу толгой компанид төлсөн. Тэрний өмнө бол 3 удаагийн акт таны хэлж байгаа Арбитрын шүүх дээр явж байгаа. 1.2 их наяд төгрөгийн төлбөртэй энэ акт бол Оюу толгой компани Төрийн санд төвлөрүүлсэн. Төрийн сан дээр дээрх төлбөр яаж, хэрхэн бүртгэгдсэн талаар бол манай Сангийн яам хариулах байх.

С.Бямбацогт: Сангийн яам. Иймэрхүү л юм болоод байгаа шүү дээ бид нар чинь ерөөсөө. Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

О.Батнайрамдал: Энийгээ тодорхой хариулмаар байна. 1, 2-хон өгүүлбэрээр яг юу хэлж байгаа нь ойлгомжгүй ийм юм хэлж болохгүй шүү дээ. Энэ чинь нийтдээ 3 их наядын мөнгө ярьж байна шүү дээ Төрийн сан руу орсон. Тэгэхээр нягтлан бодох талаасаа ч гэсэн олон талаасаа энэ чинь “contingent liability” буюу буцаад эргээд төлөгдөж болзошгүй эрсдэлтэй төлөх үүрэгтэй мөнгөний хэмжээ байхгүй юу. Тэгэхээр энэ нь ингээд зарцуулагдчихсан юм уу үгүй юу л гэж асуугаад байгаа юм. Зарцуулагдчихсан бол зарцуулагдсан гээд шууд хэлчихмээр байна.

Сая 1.6 их наяд сая 2 сард орж ирсэн тийм үү? Тэр ингээд бас зарцуулагдсан уу? Одоо энэ арбитрын шийдвэр намар гарч магадгүй гэсэн хүлээлттэй байгаа тийм үү? Тэгэхээр арбитрын шийдвэр хэрвээ нөгөө талд гарчих юм бол бид нар дахиад 1.3 их наяд төгрөгийн Монгол Улсад төлөх үүрэгтэй болно шүү дээ. Хэрвээ зарцуулчихсан бол энэ мөнгийг хаанаас авах юм? Энэ дээр тодорхой хариулт авмаар байна. Сангийн яам.

С.Бямбацогт: Сангийн яам хариулъя. Хэрвээ одоо хариулах боломжгүй бол бичгээр хариулъя гэж байгаа шүү дээ. 4 дүгээр микрофон.

Б.Анар: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Ер нь бол таны хэлж байгаа зөв “contingent liability” гэдэг талдаа бүртгэх ёстой. Татварын маргаан яваад эцэслэж дуусаагүй. Арбитр дээр энэ маргаанууд үргэлжлээд явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бол болзошгүй өр талбар талдаа бүртгэх нь бол бүртгэлийн болон “Жи Эф Эс”-ийн стандартаар бол зөв. Зарцуулагдахгүй байх ёстой гэсэн үг болзошгүй өр төлбөр талдаа. Энэ яг энэ оны эхэнд орж ирсэн 1.6 их наядын хөрөнгө бол Төрийн сан дээр яг өглөг гэдэг бүртгэлээрээ байж байгаа.

Би тэр өмнө өмнөх онуудад тавигдсан татварын актын талаар бас Засгийн газрын тогтоолууд бас гарчихсан байгаад байгаа юм байна. Тэгэхээр энэ тогтоолуудыг нэгтгээд танд бас албан бичгээр хариуг нь хүргүүлье гэж бодож байна.

С.Бямбацогт: Батнайрамдал гишүүн сүүлийн тодруулж асууя нэмэлт асуулт.

О.Батнайрамдал: Яах вэ нэг зүйл хэлчихье. Монголын Татварын алба 13 оноос хойш 22 он хүртэл бол Оюу толгой дээр томоохон татварын акт тавьж ирсэн. Энэ бол олон улсад сайн жишигт тооцогддог юм байна лээ шүү. Би Оксфордын их сургууль дээр сурч байхад Монголын татвар хэрхэн үндэстэн дамнасан корпорацууд дээр маргаан үүсгээд явдаг гэдэг сайн жишигт ордог юм байна лээ. Энийг хэлье.

Хоёрдугаарт, гэхдээ энэ татвар маргаантай мөнгө эргэн төлөгдөх эрсдэлтэй байдаг учраас энэний бүртгэлийг зөв хийж, тэр мөнгийг болж өгвөл зарцуулахгүй байхгүй бол бид нар дараа нь арбитрын шийдвэрээсээ шалтгаалаад том өрөнд унадаг юм шүү дээ. Тийм учраас одоо энэ 1.6 их наяд төлөгдсөн тэн дээр Засгийн газар маш болгоомжтой харьцах ёстой шүү. Тэр урдах бодвол 1.3 их наяд хэлэхгүй байх шиг байна. Зарцуулагдсан л байх л даа. Одоо арбитрын шийдвэр яаж гарах юм бүү мэд.

С.Бямбацогт: Яг л ийм л асуудал болчихоод байгаа юм л даа саяын кейс. Гишүүдийн асуултад үнэн, зөв, бүрэн гүйцэд хариулт өгөх ёстой. Үнэн, зөв хариулж чаддаггүй. Гүйцэд хариулт өгдөггүй учраас бичгээр хариулт өг гэж бичиг явуулдаг. Бичгээр хариултаа бас заримдаа ирдэг, заримдаа ирдэггүй.

Тухайлах юм бол түрүүн Цогтбаатар гишүүний яриад байгаа асуудал дээр Монголбанкнаас 2026 оны 05 сарын 18-ны өдөр бичгээр хариулт ирсэн байгаа юм 4 хуудас. Монгол төгрөг бусад улс орны валютын эсрэг хэзээ чангарч эхлэх вэ, ямар бодлого баримталж байна вэ? Хариулт хангалттай биш байсан учраас бичгээр хариулт өгсөн. Бичгээр хариултаа 05 сарын 18-нд ирүүлсэн.

Хоёр дахь асуулт. Ипотекийн зээлийн хүртээмж хэзээ нэмэгдэх вэ? Ямар бодлого баримталж байна вэ? Бас 2 хуудас хариулт ирсэн. Иймэрхүү байдлаар л хариултаа ирүүлээд байдаг баймаар байгаа юм. Гэхдээ хариулт ирснийг нь гишүүд бас ирсэн бол ирсэн, ирээгүй бол ирээгүй гэдэг нь бас тодорхой үнэн, зөв бас ярьдаг баймаар байна. Хариулт 05 сарын 18-нд өгчихсөн байхад өгөөгүй гээд ярьж байгаа байхгүй юу.

Нэг талдаа бид нар бас эрхээ эдэлнэ. Нөгөө талдаа бас өөрсдөө үүргээ биелүүлнэ. Аль аль нь үнэн, зөв, бодитой мэдээллийг өгдөг байх ёстой. Тэгээд энэ бас гишүүдэд ч бас хамаатай шүү. Тэгэхээр саяын Батнайрамдал гишүүний асуултад Сангийн яам бичгээр бүрэн гүйцэт хариулт өгье. Тамгын газар бүртгэж аваад нэхнэ шүү. Эргэж танилцуулна шүү бас.

Даваахүүгийн Ганмаа гишүүн асуултаа асууя. Даваасамбуу уучлаарай, уучлаарай.

Д.Ганмаа: Оройн мэнд хүргэе. Эрүүл мэндийн сан өргүй болсон байгаа гээд маш сайн мэдээтэй байгаа бид нар. Нөгөө талд Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн байгууллагуудад олгох санхүүжилтийн хэдэн төгрөгийн өглөг яг өнөөдрийн байдлаар үүсээд байгаа вэ гэдэг асуулт байна. Өглөг үүссэн бол ямар хүчин зүйлс голлон нөлөөлсөн бэ? Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогоо төлөвлөсөн хэмжээнд нь төвлөрүүлж чадахгүй байна уу, эсвэл тусламж, үйлчилгээний эрэлт нь нөгөө зардал төлөвлөснөөсөө даваад байна уу?

Гуравдугаарт Эрүүл мэндийн даатгалын санхүүгийн тогтвортой байдлыг хангах сангийн тэнцлийг бий болгох, өглөгийг барагдуулах, цаашид алдагдал үүсгэхгүй байх чиглэлээр энэ манай гүйцэтгэл дээр ямар бодлого арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тэр нь болж байгаа эсэх дээр бас хариулт авбал их сайн байна.

Би сая энд бас энэ хавсралт 8-ыг хараад сууж байлаа л даа. Энд эрүүл мэндийн сайдын яг ерөнхий зохицуулагч дотор эрүүл мэндийн хөгжлийн төвийн төлөвлөгөө, гүйцэтгэл гээд 32.7 тэрбум төгрөгтэй. Одоо 31.1 тэрбумын гүйцэтгэлтэй явж байгаа байгууллага байгаа тээ. Энэ Эрүүл мэндийн яамны жишээлбэл төлөвлөгөө бол 8.7 тэрбум байдаг юм байна. Тэгэхлээр энэ эрүүл мэндийн хөгжлийн төвийн энэ 32.7 тэрбумд чинь цалин хөлс байдаг уу? Өшөө нэмэлт өөр ямар ямар зарлага байдаг вэ? Ямар бүтэцтэй тэр нь яаж санхүүжилтэд явдаг вэ гэдэг дээр хариулт авчихмаар байна. Ер нь сангийн тэнцлийн алдагдал болон эмнэлгүүдэд үүссэн өглөг нь иргэдэд үзүүлж байгаа нөгөө эмнэлгийн

тусламж хүртээмж, чанар, санхүүгийн үйл ажиллагаанд ямар сөрөг нөлөө үзүүлж байгаа вэ?

Жишээлбэл, хувийн эмнэлгүүдэд санхүүжилт өгөхгүй байгаа, гэрээлэх хугацаа нь болчихсон учраас болсон ч гэсэн гэрээлэхгүй байгаа, цөөн орон тоотой хувийн эмнэлгүүдэд бол ерөөсөө ингээд хаахаас өөр аргагүй байна гэдэг асуудлууд маш их яригдаж байгаа шүү дээ эрүүл мэндийн байгууллагуудаар явахаар. Энэ тал дээр хариулт авъя. Баярлалаа.

С.Бямбацогт: Эрүүл мэндийн яам хариулъя Төрийн нарийн бичгийн дарга. Хэн бэ? Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар Батбаатар дарга хариулъя. 3 дугаар микрофон.

Ц.Батбаатар: Гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн даатгалын сан 2025 оны төсвийн зарлага бол нийт 2 их наяд 242.4 тэрбум төгрөгөөр батлагдаж, даатгалын сан 2025 оны жилийн эцэст бол нийт 198.4 тэрбум төгрөгийн өр төлбөртэй бол гарсан. Эдгээр өр, төлбөрийг үүсэхэд бол 2026, 2024 оноос 316.8 тэрбум төгрөгийн өр, төлбөр он дамжин шилжсэнтэй холбоотойгоор бол энэ 25 оны зарлага талд бол ачааллыг бол үүсгэсэн үүссэн байгаа. Голлох нөлөөг үзүүлсэн.

Даатгалын сангаас 2025 оны жилийн эцэст бол үүссэн нийт 198.4 тэрбум төгрөгийн өр, төлбөрийг 26 оны эхний хагас жилд бол бүрэн барагдуулсан. 2026 оны 04 сарын 31-ний өдрийн байдлаар бол энэ 26 оны 01 дүгээр сараас хойш эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн гэрээний дүнгээс давсан гүйцэтгэл дээр бол нийт 89.2 тэрбум төгрөгийн гэрээний дүнгээс давсан нэхэмжлэлийг бол ирүүлсэн байна. Эдгээр давсан гүйцэтгэлийн өглөгийг бол Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2026 оны 04 дүгээр тогтоолын 4.10-д заасны дагуу давсан гүйцэтгэлийг хагас жилээр болон жилийн эцэст санхүүжилтийг олгоно оо гэж заасны дагуу өглөгийг бол 04 дүгээр сарын 31-ний байдлаар үүссэн 89.2 тэрбум төгрөгийн өглөгийг бол бүрэн барагдуулсан.

2025 оны 05 дугаар сарын гүйцэтгэлийн нэхэмжлэл бол хараахан хянагдаж дуусаагүй байгаа. Энэ дээр бол урьдчилсан тооцооллоор нийт 18 орчим тэрбум төгрөгийн давсан гүйцэтгэлийн нэхэмжлэлийг эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн байна.

Эрүүл мэндийн эмнэлгүүдийн хувьд бол 2026, 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бол эрүүл мэндийн байгууллагууд нь нийгмийн даатгалын шимтгэл болон эмийн өр, төлбөрт нийт 214 тэрбум төгрөгийн өр, төлбөртэй байсан. 05 дугаар сарын 31-ний байдлаар тооцоолон аваад үзэхэд бол нийгмийн даатгалын шимтгэлд 81.1 тэрбум, эмийн өр төлбөрт 121, бусад өр, төлбөрт 24.6 тэрбум төгрөгийн өр төлбөр байгаа.

Тэгэхээр энэ хагас жилээр Эрүүл мэндийн даатгалын сангаас өгөх гаргасан нийт өглөгийг шилжүүлсэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн яаманд энэ өр төлбөрийг эмнэлгүүдийн байгууллага эмийн өр төлбөр болон нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг энэ өглөгөөр авсан санхүүжилтээр бол зарцуулахаар бол албан бичиг хүргүүлсэн байгаа.

С.Бямбацогт: Нэмээд Эрүүл мэндийн яам хариулъя. Индэрийн 4 дүгээр микрофон.

Н.Эрдэнэбаяр: Ганмаа гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бас энэ бүтцийг аваад үзвэл ер нь бид нар 22 оноос хойш резидент эмч нарын цалинг бас олгодог болсон байгаа. Тэгээд энэ дээр одоогийн байдлаар 1002 резидент эмчид 28 тэрбум төгрөгийн ийм санхүүжилт гарч байгаа. Өөрөөр хэлбэл, ер нь түрүүний асуугаад байгаа энэ 32.7 тэрбум төгрөгийн үндсэн гол 28 тэрбум төгрөг ер нь бол энэ төгсөлтийн дараах сургалт буюу резидент эмч нарт ингэж бас олгож байгаа. Бусад зардал нь бол хөгжлийн төвийн өөрийнх нь урсгал зардал, цалин, нийгмийн даатгал гэх мэт яг ийм тогтмол зардлууд, тэдэнтэй холбоотой гол зардлууд ингэж эзэлж байгаа.

С.Бямбацогт: Ганмаа гишүүн тодруулж асууя.

Д.Ганмаа: Яг эрүүл мэндийн байгууллагаас гарч байгаа гэж асуусан. Тэгээд Даатгалын газрын дарга маань яг дуусахдаа, яриагаа дуусахдаа л асуусан асуултад маань хариуллаа. Тэр дээр би гараад байгаа энэ өглөг дээр нийгмийн даатгалын шимтгэл дээр ч бай, эмийн өглөг дээр ч бай гараад байгаа энэ санхүүгийн эрүүл мэндийн байгууллагуудад өгөх ёстой санхүүжилтээр өр, өглөг үүсгэхэд ямар хүчин зүйлс гол нөлөөлөөд байгаа вэ гэдэг нь саяынх гэж би ойлголоо. Тэгэхлээр зэрэг энийг ингээд тогтворжуулах, даатгалын сан зүгээр байгаа ч гэсэн эрүүл мэндийн байгууллагуудыг тогтвортой үйл ажиллагаагаа хувийн ч бай хувьсгалынх ч бай явуулахад мөн энэ өглөг тэнцлийг иргэдэд тусламж, үйлчилгээ, чанарыг нь муудахгүйгээр хүргэх тал дээр ямар арга хэмжээ авч төлөвлөж байгаа вэ гэдгийг хариулаад өгнө үү тэрийг л сонирхоод байгаа юм ер нь эцсийн эцэст.

С.Бямбацогт: Индэрийн 4 дүгээр микрофон хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Ганмаа гишүүний асуултад бас нэмэлтээр хариулъя. Ер нь бол бид нар бас энэ үнэхээр Эрүүл мэндийн даатгалын энэ асуудлууд дээр ингээд аваад үзэхэд бол эрүүл мэндийн байгууллагуудын бас удирдлага, менежменттэй холбоотой энэ өр, авлагын асуудлууд бас нэлээн их байгаад байгаа юм.

Өөрөөр хэлбэл, ижил түвшний жишээ нь лавлагаа түвшний тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмнэлгүүд байхад зарим эмнэлэг бол орлого, зарлага нь ингээд тэнцээд яваад байхад зарим эмнэлгүүд дээр бас энэ менежментийн асуудалтай холбоотойгоор гэж бид нар бол бас нэлээн хэдэн хэлэлцүүлгүүд хийгээд ингээд үзэхээр бол үнэхээр ийм асуудлууд бас байна. Тэгээд энэ дээр бол бид нар тодорхой ийм хяналт шалгалтууд, дотоод хяналт, үнэлгээнүүдийг хийж байгаа.

Тэрнээс гадна эрүүл мэндийн байгууллагуудын менежментийг сайжруулах чиглэл дээр бид бүхэн бас энд нэлээн хэд хэдэн арга хэмжээнүүдийг авч, өөрөөр хэлбэл энэ дээр бид нар бас энэ менежерүүдийн ур чадварыг сайжруулах чиглэлээр нь бас нэлээн анхаарч ажиллаж байгаа. Ер нь зүгээр энэ сангийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр хэд хэдэн асуудлууд байгаа. Ялангуяа энэ төр даах энэ бас энэ.../минут дуусав./

С.Бямбацогт: Хариултаа гүйцээчихье 4 дүгээр микрофон.

Н.Эрдэнэбаяр: Төр даах зардлыг бид нар зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай байгаад байгаа. Ер нь бол ингээд даатгалаас гарч байгаа ингээд нийт зардлуудаа ингээд аваад үзэхээр төрөөс даагдаж байгаа энэ хүүхдүүд, жирэмсэн гэдэг юм уу, ахмад настнууд гээд ингээд маш олон энэ бүлгүүд дээр бол үнэхээр төрөөс өгч байгаа санхүүжилт нь бага хэр нь яг зарлага талдаа бол маш өндөр байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг ер нь дараа дараагийн жилүүд дээр бид нар засаж сайжруулж байж ер нь өр, авлагын асуудлууд цэгцлэх бас боломжтой гэж үзэж байгаа.

25 оны гүйцэтгэлээр аваад үзвэл ер нь ДНБ-д нийт зардлын 269 хувь ногдоод байгаа юм. Бид нар бол ирэх жил дээр бол тухайлбал энэ дээр бас санал өгсөн байгаа. 4.5 хувь дээр хүргэе гэдэг ийм саналыг төсвийн хүрээний мэдэгдэл дээр ингэж гаргаж өгсөн байгаа. Тэгэхээр энэ байдлаараа батлагдаад явбал бас үйл ажиллагаанууд нэлээн сайжраад явна. Өөрөөр хэлбэл орлого талаа нэмэх тал дээр бас нэлээн арга хэмжээ авах шаардлагууд байгаа.

С.Бямбацогт: Ганмаа гишүүн дахиад тодруулъя.

Д.Ганмаа: Яах аргагүй яах вэ эрүүл мэндийн тогтолцоо салбарт тохиолдож байгаа асуудал бололтой энэ. Яг энэ ДНБ-д хүргэх ёстой зардал, орлогыг нэмэгдүүлэх, эдгээр асуудлуудыг шийдтэл эмнэлгийн тусламж, үйлчилгээгээ чанартай, хүртээмжтэй, аюулгүй хүргэхэд гарч болохуйц сөрөг нөлөөллүүдийг тооцож үзээд тэрүүндээ хэрэгжүүлсэн тийм арга хэмжээнүүд байгаа юу та хэдэд? Төлөвлөгөө, тооцоо, бодлого тээ? Энэ чинь бас цаг хугацаа нэлээн орох асуудал л даа. Би ойлгож байгаа. Тэгэхдээ бас яг тодорхой мэдээлэлтэй, мэдлэгтэй бусад хүмүүстээ, бусад эмнэлгийнхэндээ, ялангуяа иргэддээ энэ аюулгүй асуудлыг хүргэхэд тодорхой төлөвлөгөө гаргаад ажиллаж байхгүй бол бид нар асуудал гараад асуудлын араас нь хөөцөлдөж яваад тэгээд тэрнээсээ болж нас баралтууд, хүндрэлүүд, эмнэлгүүд бие бие рүүгээ түлхэх энэ тэр асуудлууд гараад байгааг надаар хэлүүлэхгүй та бүхэн мэдэж байгаа.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Тийм гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүллээ.

Одоо 20 цаг хүртэл гишүүд түр завсарлаад өнөөдрийн хэлэлцэх асуудлаа 20 цагаас үргэлжлүүлж хуралдаад дуусгана. Хэлэлцэх асуудал нэлээн үлдсэн байгаа. Санал хураалтууд нэлээн байгаа. 20 цагаас санал хураалтаар чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилнэ шүү гишүүд ээ. Санал хураалтдаа бэлэн байхыг хүсье. Бүлгүүдийн ажлын алба, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газар, гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдийг 20 цагт санал хураалтад бэлэн байлгана уу. Түр завсарлалаа.

19.36 цаг.

Баасан гараг 19 Зургаадугаар сар 2026

Төрийн ордон “Их хуралдай” танхим 20 цаг 11 минут

С.Бямбацогт: Гишүүдийг чуулганы танхимдаа урьж байна. Гишүүд ээ чуулганы танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Гишүүд, үүдэнд байгаа гишүүдийг танхимдаа урьж байна. Танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Өрөөндөө байгаа гишүүд бас танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Сайд нар бас танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Гишүүд танхимдаа хүрэлцэн ирье. Гишүүдийн зөвлөх, туслахууд, ажлын алба. Гишүүд суудлаа эзэлнэ үү. Ирц бүртгэлийн санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд хуруугаа уншуулчхаарай. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ татгалзсанд гарч байгаа гишүүд чуулгын танхимд хүрэлцэн ирнэ үү. Нара гишүүн бол байна. 37 гишүүн. Ганхүлэг гишүүн байна. Үүрийнтуяа гишүүн байна. 35 гишүүн танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Татгалзсанд гарч байгаа. Нэрсээ харж байгаа байх. Нэрс бол ил тод, нээлттэй явж байгаа. Хуралдаан зохион байгуулах газар, бүлгүүдийн ажлын алба, бүлэг, зөвлөлийн гишүүдийн зөвлөх, туслахууд энэ татгалзсанд гарч байгаа 35 гишүүнийг чуулганы хуралдаандаа ирүүлнэ үү. Зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулна.

Төрийн өмчит компанийн засаглал, ил тод байдал, бүтээмжийг нэмэгдүүлэх тухай хууль байгаа. Төрийн өмчит компаниудыг маш их шүүмжилдэг. Шүүмжилж байгаа асуудлыг цэгцлэх хууль байгаа. Тэгээд ажлын хэсэг маань бас Сайнзориг, Үүрийнтуяа нарын гишүүдээр ахлуулсан. Олон гишүүдэд орж ажилласан ажлын хэсэг. Зарчмын зөрүүтэй 83 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн нэрийн “бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах” гэснийг хасаж, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хяналт, ил тод байдал, засаглалыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхтэй” гэснийг “хяналтыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангахтай” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсгийн гишүүн Үүрийнтуяа, Сайнзориг, Номинчимэг, Алдаржавхлан, Алтангэрэл, Анар, Батболд, Б.Бат-Эрдэнэ, Баярбаатар, Галбадрах, Ганбаатар, А.Ганбаатар, Г.Ганбаатар, Ж.Ганбаатар, Даваасүрэн, Жаргалан, Заяабал, Зулпхар, Мөнхбат, Мөнхсоёл, Мэндсайхан, Наранбаатар, Отгонбаяр, Пунсалмаа, Сандаг-Очир, Уянгахишиг, Хэрлэн, Энхнасан, Энхтүвшин, Эрдэнэболд. Эдгээр гишүүд маань энэ төрийн өмчийн компаниудыг цэгцлэх хуулийн ажлын хэсэгт орж ажилласан байгаа. Маш сайн ажилласан. Цаашид энэ гишүүдийг “Ажлын хэсэг” гэж нэрлэж явна.

Тэгээд энэ санал дээр ажлын хэсгийн ахлагч Үүрийнтуяа гишүүнд микрофон өгье.

Д.Үүрийнтуяа: Хуультай холбоотой, хуулийн төсөлтэй холбоотой нийтдээ 83 зарчмын зөрүүтэй санал байгаагаас гүйцээн боловсруулах чиглэл авах бас 15

санал байгаа. Тэгээд эхний 1, 2 дахь саналаас эхэлж байгаа юм. Тэгээд энэ бол ажлын хэсгийн гишүүд ямар нэгэн байдлаар саналын зөрүүтэй, зөрчилтэй зүйл бол байхгүй. Эргэж ярилцах, сайжруулах асуудлаа дахиж ярьж гэсэн. Бас бусад гишүүдийнхээ саналыг харгалзаад 15 санал оруулж байгаа. 1, 2 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл авахыг хүсэж байна.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагчийн саналын дагуу 1, 2 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Эдийн засгийн байнгын хороонд.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн “хуулийн дагуу байгуулагдсан” гэснийг “хуулиар зохицуулагдах” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Дээрх 1 дүгээр санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалтын “хяналт” гэснийг “хяналтын эрхийг” гэж өөрчилж, доор дурдсан агуулгатай 4.1.6 дахь заалт нэмэх:

“4.1.6.“хяналтын эрхийг хэрэгжүүлэх” гэж төр, орон нутаг, эсхүл тэдгээрийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдээр дамжуулан тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхыг томилох, эсхүл компанийн стратеги, санхүүгийн бодлого, үндсэн үйл ажиллагаанд заавал биелэгдэх шийдвэр гаргах эрхийг хууль, гэрээ, дүрмийн үндсэн дээр хэрэгжүүлэхийг.” . Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Одбаяр гишүүнээ. Гишүүд сая саналын томъёоллыг танилцуулсан. Санал хураалт.

Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалтын “энэ” гэснийг, 4.1.4 дэх заалтыг тус тус хасаж, 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.5.“нийтийн үйлчилгээ” гэж иргэдийн ая тухтай амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор дэд бүтэц, эрчим хүч, зам, тээвэр, эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт болон холбогдох бусад салбарт төрөөс иргэдэд тэгш, чанартай, үр ашигтай, хууль тогтоомж, стандартын дагуу үзүүлж байгаа олон нийтэд зориулсан үйлчилгээг;”. Санал гаргасан ажлыг. Санал хураалт.

94 гишүүнээс 55 гишүүн буюу 58 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 5 дугаар зүйлд. Ажлын хэсгийн ахлагч Үүрийнтуяа.

Д.Үүрийнтуяа: Хуулийн төслийн энэ 6 дээр, тайлбар дээр бас дахин тодруулах шаардлага байгаа учраас гүйцээн боловсруулах чиглэл өгөхийг хүсэж.

С.Бямбацогт: 6 дугаар саналыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

7.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтын “мэргэжлийн” гэснийг “мэргэшсэн” гэж, 5.2.5 дахь заалтын “үр ашиггүй” гэснийг “үргүй” гэж өөрчилж, 5.2.8 дахь заалтын “тайлагнах” гэсний өмнө “бүрэн” гэж нэмж, 5.2.1, 5.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.1.компанийн удирдлагын эрх төрийн болон орон нутгийн эрх хэмжээнээс тусгаарлагдсан байх;”

“5.2.2.хувьцааны төрөл, тоонд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93 гишүүнээс 52 гишүүн буюу 55 хувийн саналалаар санал дэмжигдлээ.

8.Төслийн. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: 8 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл хүсэж байна.

С.Бямбацогт: 8 дугаар саналыг гүйцээн болгох чиглэл өглөө.

9.Төслийн 7 дугаар зүйлийн гарчгийн “үндсэн чиглэл” гэснийг “өмчлөлийн бодлого” гэж, 7.1 дэх хэсгийн “үндсэн чиглэлийг” гэснийг “өмчлөлийн бодлогыг” гэж, 7.2 дахь хэсгийн “энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиглэлийн төслийг” гэснийг “төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг” гэж, 7.3, 7.4 дэх хэсгийн “Үндсэн чиглэлд” гэснийг “Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогод” гэж, 7.3.4 дэх заалтын “үндсэн чиглэлийн” гэснийг “төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогын” гэж, 7.3.1 дэх заалтын “хувьцаа эзэмших, хянах зорилго,” гэснийг “хувьцаа эзэмших зорилго, хяналтын эрхийг хэрэгжүүлэх” гэж, 7.3.6 дахь заалтын “биржээр олон нийтэд нээлттэй худалдах” гэснийг “худалдах, түүнийг хэрэгжүүлэх арга,” гэж тус тус өөрчилж, 7.3.5 дахь заалтын “бүтцийн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93 гишүүнээс 53 гишүүн буюу 57 санал санал дэмжигдлээ.

10.Төслийн 7.7 дахь хэсгийн “хуудсанд” гэсний дараа “06 дугаар сарын 30-ны өдрийн дотор” гэж нэмж, 7.5, 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“7.5.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогын хэрэгжилтэд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг тухайн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газарт, Засгийн газар тайланг тухайн жилийн намрын чуулганы хугацаанд холбогдох Байнгын хороонд танилцуулна.

7.6.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогын хэрэгжилтийн тайланг Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаа дуусахаас хоёроос доошгүй сарын өмнө Улсын Их Хуралд танилцуулна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 54 буюу 58 саналаар санал дэмжигдлээ.

11.Дээрх 9, 10 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн “үндсэн чиглэл” гэснийг “Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлого” гэж агуулгад нь тохируулан тухай бүрд өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 8 дугаар зүйлийн Сайнзориг гишүүн. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: 12 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл авах хүсэлтэй байна.

С.Бямбацогт: 12 дугаар саналыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

13.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг хасаж, 8.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 2 дахь өгүүлбэр нэмэх:

“Энэ хуулийн 8.1.2-т заасан үндэслэлээр орон нутгийн өмчит компанийг Улсын Их Хурлын зөвшөөрлөөр үүсгэн байгуулж болно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 47 буюу 50.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

14.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн “мэдээлэлд” гэсний өмнө “судалгаа,” гэж, 9.4.1 дэх заалтад “шаардлага” гэсний дараа “буюу хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх гэсэн бодлоготой нийцэж байгаа эсэх” гэж тус тус нэмж, 9.4.5 дахь заалтын “хугацаа” гэснийг “хугацаатай байх эсэх” гэж, 9.5, 9.6 дахь хэсгийн “хувьцаа эзэмшигч” гэснийг “этгээд” гэж, 9.7 дахь хэсгийн “байгуулах” гэснийг “байгуулж болох” гэж, “заасны дагуу” гэснийг “заасан этгээд” гэж өөрчилж, доор дурдсан агуулгатай 9.8 дахь хэсэг нэмэх:

“9.8.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах эсэх асуудлыг тухайн хугацаа дуусах оны өмнөх санхүүгийн жилд багтаан шийдвэрлэх бөгөөд үйл ажиллагаа явуулах хугацааг сунгахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцаатай холбоотой асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.”. Санал хураалт.

Санал хураалтад 93 гишүүн орсноос 50 гишүүн буюу 53 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.4 дэх хэсгийн “орон нутгийн” гэсний дараа “өмч давамгайлсан компани, төрийн болон орон нутгийн өмчийн” гэж нэмэх:

“10.3.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна компанийн үйл ажиллагааны зорилго, хүрэх үр дүн,

хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, ногдол ашгийн бодлого, эсхүл нийтийн үйлчилгээний үүргийн бодлогыг тодорхой тусгана.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 56 буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.6 дахь хэсэг нэмэх:

“10.6.Алтан хувьцаа гаргах тохиолдолд компанийн дүрэмд алтан хувьцаа эзэмших этгээд, эрхийн агуулга, хугацааг тусгана.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 55 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.2, 11.3 дахь хэсэг нэмэх:

“11.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компани бусад этгээдтэй хамтран охин, хараат компани үүсгэн байгуулах асуудлыг энэ хуулийн 8.1-д заасан үндэслэлийн дагуу энэ хуулийн 9.4-т заасан судалгаа, шинжилгээ болон Засгийн газрын зөвшөөрлийн дагуу Компанийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

11.3.Энэ хуулийн 11.1, 11.2-т заасны дагуу үүсгэн байгуулсан охин, хараат компани дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг толгой компани эзэмшинэ.”. Санал хураалт.

93-аас 57 буюу 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “худалдах” гэснийг “шилжүүлэх” гэж, 13.2 дахь хэсэг, 13.4 дэх хэсгийн “гүйцэтгэх захирлын” гэснийг “гүйцэтгэх удирдлагын” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, доор дурдсан агуулгатай 13.2.6, 13.2.7 дахь заалт тус тус нэмэх:

“13.2.2.алтан хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласан, хугацааг багасгасан өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулах;”

“13.2.6.компанийн хувьцааны хяналтын багцтай хэмжээгээрээ дүйцэхүйц хувьцаа болон хувьцаанд хамаарах бусад үнэт цаасыг нэг болон хэд хэдэн удаагийн дараалсан шийдвэрээр нэмж гаргах;

13.2.7.талууд харилцан тохиролцож, компанийн дүрэмд заасан бусад.”. Санал хураалт.

93-аас 55 буюу 59-ийн саналаар санал дэмжигдлээ.

19.Дээрх 18 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн “гүйцэтгэх захирал” гэснийг “гүйцэтгэх удирдлага” гэж агуулгад нь тохируулан тухай бүрд өөрчлөх. Санал хураалт.

93-аас 55 буюу 59-ийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “үндэслэлээ” гэснийг “үндэслэл, хоригийн хамрах хүрээг” гэж, 13.8 дахь хэсгийн “заасан” гэснийг “заасны дагуу компанийн дүрэмд тусгасан” гэж өөрчилж, “дахин” гэснийг, 13.6 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.9 дэх хэсэг нэмэх:

“13.9.Засгийн газар хориг тавих шийдвэр гаргахдаа зорилгодоо нийцсэн байх, компанийн үйл ажиллагаанд хамгийн бага хязгаарлалт тогтоох зарчмыг баримтална.”. Санал хураалт.

93-аас 56 буюу 60 хувийн санал санал дэмжигдлээ.

21.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “заасан журмын дагуу” гэснийг “өөрөөр заагаагүй бол” гэж, 14.7 дахь хэсгийн “34-өөс доош” гэснийг “34 хүртэлх” гэж өөрчилж, 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Энэ хуулийн 14.2-т заасны дагуу компанийн энгийн хувьцааны гуравны нэгээс доош хувийг олж авсан бол төр, эсхүл орон нутаг тухайн хувьцааны зах зээлийн үнэ болон бодит үнэ цэнийг тооцон, аль өндөр үнээр тухайн хувьцааг худалдана.”. Санал хураалт.

93-аас 55 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 15.1 дэх хэсгийн “үнэт цаас” гэснийг “өрийн хэрэгсэл” гэж, мөн зүйлийн 15.4 дэх хэсгийн “зөвлөлд” гэсний дараа “/байхгүй бол хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид/” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 15.5, 15.6, 15.7 дахь хэсэг нэмэх:

“15.5.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани зээл авах, өрийн хэрэгсэл гаргах, баталгаа гаргуулах, санхүүгийн түрээс болон түүнтэй адилтгах үүрэг хүлээхдээ өрийн тогтвортой байдлын дүгнэлтийг хараат бус, мэргэжлийн этгээдээр гаргуулсан байна.

15.6.Энэ хуулийн 15.5-д заасан дүгнэлтэд өрийн нийт хэмжээ, өр ба өөрийн хөрөнгийн харьцаа, мөнгөн урсгал, валютын эрсдэл, хүүгийн эрсдэл, төсвийн болзошгүй өр төлбөр, төрийн баталгааны нөлөөллийг тусгана.

15.7.Төрийн болон орон нутгийн өмчийн компани, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан компани бусад этгээдэд өрийн баталгаа гаргахыг хориглоно.”. Санал хураалт.

93-аас 56 хувийн 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

16 дугаар зүйл. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: 23 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү.

С.Бямбацогт: 23 дугаар саналыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

24.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтын “компанийн” гэсний дараа “газар,” гэж нэмэх. Санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Төслийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтын “санал гаргах” гэснийг “саналын эрхийг хэрэгжүүлэх” гэж өөрчилж, 20.1.5 дахь заалтын “тохиолдолд” гэсний дараа “компанийн дүрэм болон гэрээнд заасан” гэж нэмж, 20.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.1.4.төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага хууль болон компанийн дүрэмд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд дүрэм болон гэрээнд заасан хариуцлага хүлээлгэх, компанид хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлөхийг шаардах, шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах;”. Санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төслийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг энэ хуулийн 17.2, 17.5-д заасан этгээд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьд дангаараа, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан, эсхүл тэдгээрийн оролцоотой компанийн хувьд бусад этгээдтэй хамтран хэрэгжүүлнэ.

22.3.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчит компанийн нэгдлийн хараат, охин компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг толгой компанийн гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.”. Санал хураалт.

93-аас 52 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Төслийн. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: 27, 28, 29 дүгээр саналууд дээр гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү.

С.Бямбацогт: 27, 28, 29 дүгээр саналууд дээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

30.Төслийн 27 дугаар зүйлийн гарчгийн “гишүүнд нэр дэвшигчээс” гэснийг “сонгон шалгаруулалтад оролцогчоос” гэж, мөн зүйлийн 27.1 дэх хэсгийн “гишүүнд нэр дэвшигчийг” гэснийг “гишүүнийг” гэж, 27.2 дахь хэсгийн “нэр дэвших” гэснийг “сонгон шалгаруулалтад оролцох” гэж, 27.2.3 дахь заалтын “нэр дэвшигч” гэснийг “сонгон шалгаруулалтад оролцогч” гэж тус тус өөрчилж, 27.3 дахь хэсгийг хасах. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “хувьд” гэсний дараа “хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь” гэж нэмж, 28.5 дахь хэсгийн “компани болон хувьцаа эзэмшигчид” гэснийг “компанид” гэж өөрчилж, 28.7 дахь хэсгийн “гурван” гэснийг “хоёр” гэж өөрчилж, “нэг удаа” гэсний дараа “хоёр жил хүртэл хугацаагаар” гэж нэмж, 28.8 дахь хэсгийн “тушаалаар” гэснийг “тушаалын байдлаар” гэж өөрчлөх. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал хураалт дэмжигдлээ.

32.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтын “заавал оролцож” гэснийг “биечлэн, эсхүл зайнаас оролцох” гэж, 29.1.6 дахь заалтын “түүний хамаарал бүхий этгээд” гэснийг “нэгдмэл сонирхолтой этгээд нь” гэж өөрчилж, 29.1.8 дахь заалтыг хасах. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.2.Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын ирц гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчинтэй болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр нийт гишүүдийн олонхын саналаар хүчин төгөлдөр болно.”. Санал хураалт.

93-аас 55 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “жагсаалт,” гэсний дараа “холбогдох материалыг” гэж нэмж, “доошгүй” гэснийг “дээшгүй” гэж өөрчилж, 29.4 дэх хэсгийн “дарга,” гэсний дараа “эсхүл гишүүн” гэж нэмэх. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: 35, 36 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү.

С.Бямбацогт: 35, 36 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

37.Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “урамшуулал авч болно” гэснийг “урамшуулалтай байна” гэж, 30.2 дахь хэсгийн “эзэмшигчдийн хурлаас” гэснийг “эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч” гэж, 30.8 дахь хэсгийн “өмчит” гэснийг “өмчийн” гэж, “гишүүний ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлж,” гэснийг “гишүүнд” гэж тус тус өөрчилж, 30.2.2 дахь заалтын “төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санал болон” гэснийг хасаж, “харгалзан” гэснийг “баримтлан” гэж өөрчилж, 30.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.2.1.нийтийн үйлчилгээний төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээг тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын албан тушаалтны цалингийн жишгийг харгалзан төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналаар;”. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

38.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтын “хууль” гэснийг “эрх зүй” гэж өөрчилж, мөн зүйлийн 32.4 дэх хэсгийг хасах. Санал хураалт.

93-аас 52 буюу 55 хувийн санал санал дэмжигдлээ.

39.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “нэг” гэснийг “гурав хүртэлх” гэж өөрчилж, “хугацаатай” гэсний дараа “даалгаврын” гэж нэмж, 33.3 дахь хэсгийн “Хөдөлмөрийн тухай хуулийн 72.1-д заасны дагуу” гэснийг хасаж, “үүрэг” гэсний өмнө “нууц хадгалах” гэж нэмэх. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

40.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтын “хувьцаа, өөрийн хөрөнгийг урт хугацаанд” гэснийг “ашигт ажиллагааг” гэж, 34.1.8 дахь заалтын “заасан үйл ажиллагаанд үл хамаарах зардлыг” гэснийг “зааснаас бусад үйл ажиллагааг” гэж тус тус өөрчлөх.Санал хураалт.

93-аас 51 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

41.Төслийн 36 дугаар зүйлийн. Уучлаарай. Үүрийнтуяа гишүүн

Д.Үүрийнтуяа: 41, 42 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү.

С.Бямбацогт: 42, 43 уу?

Д.Үүрийнтуяа: 41, 42.

С.Бямбацогт: 41, 42 гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

43.Төслийн 37 дугаар зүйлийн 37.9 дэх хэсгийн “бүтцэд хамаарах тодорхой тооны” гэснийг “дотоод” гэж өөрчилж, 37.10 дахь хэсгийн “ээлжит бус” гэсний дараа “дотоод” гэж нэмж, 37.12 дахь хэсгийн “нэгжгүй байж болох бөгөөд” гэснийг “нэгж байгуулахгүйгээр” гэж, “ажиллана” гэснийг “ажиллуулна” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

44.Төслийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийн “гурван үзүүлэлтийн хоёроос доошгүй” гэснийг “нөхцөлийг” гэж өөрчилж, 37.8 дахь хэсгийн “хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн зөвшөөрлөөр” гэснийг, 37.7.3 дахь заалтыг тус тус хасах. Санал хураалт.

93-аас 52 буюу 55 саналаар санал дэмжигдлээ.

44.Төслийн 37 дугаар зүйлийн 30.

45 тийм ээ. Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.5 дахь заалтын “зөв,” гэсний дараа “, бүрэн” гэж нэмж, 38.1.7 дахь заалтын “гүйцэтгэлийн” гэснийг хасах. Санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

46.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “хянуулахаар” гэснийг “батлуулахаар” гэж өөрчлөх. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

47.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсгийн “үнэлгээний” гэсний өмнө “арилжааны зорилго бүхий төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэлийн” гэж, 40.4.2 дахь заалтын “байгуулалт,” гэсний дараа “засаглал, эрсдэлийн удирдлага” гэж нэмэх. Санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

48.Төслийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 40.5 дахь хэсэг нэмэх:

“40.5.Энэ хуулийн 40.3-т заасан нийтийн үйлчилгээний компанийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурт дараах асуудлыг хамааруулна:

40.5.1.компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшин болон нийтийн үйлчилгээний үүргийн биелэлт;

40.5.2.компанийн бүтэц, зохион байгуулалт, засаглал, эрсдэлийн удирдлага, хүний нөөцийн зохистой менежмент;

40.5.3.санхүүгийн менежмент, төсвийн хэмнэлт, хэтрэлт, төсөв, татаасын ашиглалт, нэгж үйлчилгээний өртөг, зардлын үр ашиг;

40.5.4.үйлчилгээний чанар, хүртээмж;

40.5.5.ашиглаж байгаа үндсэн хөрөнгө, дэд бүтцийн найдвартай ажиллагаа;

40.5.6.мэдээллийн ил тод байдал.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

49.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.9 дэх хэсгийн “3 жил” гэснийг “2 жил” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 40.10, 40.11 дэх хэсэг, Тайлбар хэсэг нэмэх:

“40.10.Эрх бүхий байгууллагын шийдвэрээр нийтийн ашиг сонирхлын зорилгоор үнэ, тарифыг өртгөөс доогуур тогтоосон, эсхүл нийтийн үйлчилгээний үүргийн хүрээнд компанид нэмэлт санхүүгийн үүрэг хүлээлгэснээс үүссэн орлогын зөрүү, алдагдлыг компанийн үйл ажиллагааны үр ашиггүй байдалд тооцохгүй бөгөөд гүйцэтгэлийн үнэлгээнд нотлох баримтад үндэслэн залруулж тусгана.

40.11.Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хуулийн 40.3-т заасан журамд нийцүүлэн компанийн тэнцвэржүүлсэн гүйцэтгэлийн үнэлгээний аргачлалыг баталж, хэрэгжилтэд хяналт тавина. Уг аргачлалд энэ хуулийн 40.4, 40.5-д заасан болон тухайн компанийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн бусад үзүүлэлтийг уялдуулан үнэлэх, тайлагнах, бизнес төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг тодорхойлох зохицуулалтыг тусгана.

Тайлбар: -Энэ хуулийн “Тэнцвэржүүлсэн гүйцэтгэлийн үнэлгээний аргачлал” гэж төрийн болон орон нутгийн өмчит компанийн стратеги, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг санхүүгийн үр дүн, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, хэрэглэгчийн сэтгэл ханамж, үйлчилгээний чанар, үйл ажиллагааны үр ашиг, байгууллагын чадавх, хүний нөөцийн хөгжлийн үзүүлэлтээр тэнцвэртэй хэмжиж, үнэлэх, тайлагнах арга зүйн зохицуулалтыг ойлгоно.”. Санал хураалт.

93-аас 57 буюу 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

50.Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: 50, 52 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү. 50, 52.

С.Бямбацогт: 50, 52 дугаар саналыг гүйцэн боловсруулах чиглэл өглөө.

51.Төслийн Наймдугаар бүлгийн гарчгийг “Нэмэлт хувьцаа гаргах, төрийн эзэмшлийн хувьцааг шилжүүлэх, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах” гэж өөрчлөх. Санал хураалт.

Санал хураалтад 93 гишүүнээс 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

53.Төслийн 45 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 45.3, 45.4 дэх хэсэг нэмэх:

“45.3.Төрийн өмчийн компанийн эд хөрөнгийн тооллого хийж, дуусгалтын тайлан, тэнцэл үйлдэн, эд хөрөнгийг хэсэгчлэн шилжүүлэх, эсхүл дуудлагаар худалдах ажлыг Засгийн газрын шийдвэрийг үндэслэн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

45.4.Орон нутгийн өмчийн компанийн эд хөрөнгийн тооллого хийж, дуусгалтын тайлан, тэнцэл үйлдэн, эд хөрөнгийг хэсэгчлэн шилжүүлэх, эсхүл дуудлагаар худалдах ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн орон нутгийн өмчийн газар эрхлэн гүйцэтгэнэ.”. Санал хураалт.

93-аас 57 буюу 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

54.Дээрх 53 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 46 дугаар зүйлийг хасах. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

55.Төслийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсгийг хасах. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

56.Төслийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн “байгуулахыг” гэснийг “байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг” гэж, “шийдвэрлэнэ” гэснийг “гаргана” гэж өөрчилж, 48.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.3.Энэ хуулийн 48.1-д заасан нөөц сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

48.3.1.компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх, технологийг шинэчлэх;

48.3.2.давагдашгүй хүчин зүйл, зах зээлийн гэнэтийн өөрчлөлт болон бусад урьдчилан таамаглах боломжгүй эрсдэлийн сөрөг нөлөөллийг бууруулах.”. Санал хураалт.

93-аас 55 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

57.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 49.1.7 дахь заалтын “компанийн эсрэг, эсхүл” гэснийг хасаж, 49.1.14 дэх заалтын “дэмжлэг,” гэсний дараа “татаас,” гэж нэмэх:

“49.1.1.компанийн төсөв, бизнес төлөвлөгөө;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 56 буюу 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

58.Төслийн 51 дүгээр зүйлд. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: 58 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү.

С.Бямбацогт: 58 дээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

59.Дагаж мөрдөх хугацааг “2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө” гэж өөрчлөх. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27 оны 01 сарын 01-нээс төрийн бус компаниуд цэгцрэх нь байна шүү дээ тийм ээ.

60.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа хоёр жилээс хэтрэхгүй байх бөгөөд нэг удаа хоёр жил хүртэл хугацаагаар улируулан томилох тухай зохицуулалт дэмжигдсэнтэй холбогдуулан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг хүчингүй болгох тухай хуулийн төслийг боловсруулах. Санал хураалт.

93-аас 55 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

61.Төрийн өмчийн компанийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр санхүүгийн аудит хийлгэх тохиолдолд тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх компанийн жагсаалтыг Засгийн газар батлах зохицуулалт дэмжигдсэнтэй холбогдуулан Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах. Санал хураалт.

93-аас 55 буюу 59 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

62.Төслийн 17 дугаар зүйлийн 17. 2 дахь хэсэгт. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Пунсалмаа гишүүний гаргасан энэ 62 дахь санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгөхийг хүсэж байна.

С.Бямбацогт: Пунсалмаа гишүүний хүсэлтээр Сайнзориг гишүүн гүйцээн болгох чиглэл авъя гэжээ. Өглөө.

63.Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.1.4 дэх заалт нэмэх:

“18.1.4.энэ хуулийн 8.1.2-т заасан үндэслэлээр үүсгэн байгуулсан төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг Улсын Их Хурлын зөвшөөрлийн үндсэн дээр бусдад шилжүүлэх, барьцаалуулах;”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг. Санал хураалт.

93-аас 57 буюу 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

64.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2.8 дахь заалтын “хувьцааны удирдлагын талаарх илтгэлийг” гэснийг, мөн төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн “төр болон орон нутгийн хувьцааны удирдлагын талаарх илтгэлийг” гэснийг “энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан өмчлөлийн бодлогын хэрэгжилтийн тайланг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Их Хурлын гишүүн Сайнзориг.

93-аас 56 буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

65.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн “03 дугаар сарын 01-ний” гэснийг “05 дугаар сарын 01-ний” гэж өөрчлөх. Санал гаргасан Их Хурлын гишүүн Сайнзориг.

93-аас 56 хувийн 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Найруулгын санал.

Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “байгуулах” гэсний өмнө, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “байгуулна” гэсний өмнө, “үүсгэн” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалтын “дүрэмд” гэсний өмнө “компанийн” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “зөвлөл” гэсний дараа “/байхгүй бол гүйцэтгэх удирдлага/”, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “комисс” гэсний өмнө “татан буулгах” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “шийдвэрлүүлэх үүрэгтэй” “шийдвэрлүүлнэ” гэж, 24 дүгээр зүйлийн гарчгийн “тавигдах” гэснийг “тавих” гэж, 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийн “хавсарган ирүүлнэ” гэснийг “хавсаргана” гэж өөрчлөх.

3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.4 дэх хэсгийн “зөвхөн” гэснийг, 8.5 дахь хэсгийн “Энэ” гэснийг, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “хурлаас” гэснийг, 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсгийн “төрийн өмчийн асуудал эрхэлсэн” гэснийг тус тус хасах.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал хураалт.

93-аас 57 буюу 61 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал. 1. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Эдийн засгийн байнгын хорооны хурал, бас намын бүлгүүдийн хүсэлтээр 5 хоног завсарлага авч, тэгээд хугацаанаасаа өмнө энэ завсарлагаа дуусгаж эхлүүлээд өчигдөр бас Эдийн засгийн байнгын хороо тулгаж зарлагдаад манай зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүд маань саналаа тайлбарлах боломж бас хагас, дутуу олгогдсон . Бүрэн олгогдоогүй.

Тийм учраас бид Эдийн засгийн байнгын хороон дээр дэмжигдээгүй саналууд дээрээ гүйцээн боловсруулах чиглэл аваад, эргээд бас ажлын хэсэг дээрээ гишүүдтэйгээ ярилцаад эргэж оруулж ирэх саналтай байна. Гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү. Бүх санал дээр. Байнгын хороо дэмжээгүй санал.

С.Бямбацогт: Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй бүх саналууд дээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Цэнгүүн, Сайнзориг нарын гишүүд л баахан санал гаргасан байна.

Хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.” Төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 56 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэсний өмнө “Төрийн байгууллага,” гэж нэмж, “албан газар, төрийн өмчийн компани” гэснийг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 5-д заасан төрийн өмчит хуулийн этгээд” гэж өөрчлөх.Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг.

93-аас 51 буюу 54 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.”. Санал хураалт.

93-аас 51 хувь 54 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын 9¹ дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “улсын ахлах” гэсний дараа “байцаагч” гэж нэмж, 7 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг хасах;

2.Мөн зүйлийн 2 дахь заалтын 13 дугаар зүйлийн 2 дахь заалтын “нийтийн үйлчилгээний” гэсний өмнө “төрийн өмчит” гэж нэмэх;

3.Мөн зүйлийн 3 дахь заалтын 15 дугаар зүйлийн гарчгийн, 6, 7 дахь хэсгийн “Нийтийн үйлчилгээний” гэсний өмнө “Төрийн болон орон нутгийн өмчит” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “холбоотой” гэсний дараа “асуудлыг” гэж, 7 дахь хэсгийн

“нээлттэй” гэсний өмнө “олон нийтэд ил тод,” гэж, тус тус нэмж, мөн хэсгийн 1 дэх заалтын “удирдлагын” гэснийг “удирдлага, түүний цалин, хөлс, урамшууллын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 55 буюу 59 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 14 дүгээр зүйлийн өмнө “мөн зүйлийн 3 дахь заалтын “өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн” гэснийг “өмчит компанийн” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 93 гишүүн ирсэн 49 гишүүн буюу 52 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн 21¹ дүгээр зүйлийн дараах “12” гэснийг “13” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг. Дэмжье гэсэн томъёолол санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хэд дээр? 5 хураачихсан шүү дээ. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол хэсэг дээр гүйцээн боловсруулах чиглэл авахыг хүсэж байна.

С.Бямбацогт: “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

21.12 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Гишүүд өнөөдрийнхөө асуудлыг бүгдээрээ сайхан дуусгачихна шүү. Энэ шөнөд орой байхгүй тийм ээ.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэсэн үү. Бүгд бэлэн үү? Санал хураалт явуулъя. Гишүүд ээ суудлаа эзлээрэй.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 93 гишүүн орсноос 54 гишүүн буюу 58 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн 3 хуулийн төсөл байгаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

93-аас 55 буюу 59 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийн анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Бизнесийн эрх чөлөөний тухай хуулиудыг нэгтгээд хамтад нь батлаад явахаар бас байгаа шүү. Тийм болохоор манай ажлын хэсэг, Энхтүвшин гишүүн, Жаргалан гишүүд бас анхаараад хамт үйл ажиллагааг бас уялдуулж ажиллаарай.

21.15 цаг

Одоо Хөдөө аж ахуйг дагасан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль энэ дээр өдөр нэлээн маргаантай болсныг буцаах санал хураалгая.

41.10 тийм ээ? Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн бол хуулийн төслийг Байнгын хороонд буцаана.

Үүний дагуу бас хууль хоорондын зөрчил, бас Улсын Их Хурал хууль зөрчсөн хууль батлах нь уу гэдгийг нягталж үзэх шаардлага байгаа учраас үүнийг буцаах томьёоллыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Уучлаарай санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалтдаа бэлтгэе. Тийм Байнгын хороо дахиж

хэлэлцэнэ гэсэн үг. Буцааж байгаад бид нар хууль зөрчсөн хууль батлах Их Хурал зохимжгүй учраас энийг дахиж нягталж харах гэж байгаа юм.

Тэгээд нягталж хараад зөрчихгүй бол оруулаад ирнэ. Зөрчихөөр бол энэ хууль цаашаа явахгүй. Тийм болохоор буцаая гэж байгаа юм.

Сая Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн тодорхой заалт өөрчлөх саналыг буцаах саналтай байгаа. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 93 гишүүн оролцсоноос 54 гишүүн буюу 58 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хороо, Байгаль орчны байнгын хороо энэ хуулийн хууль зөрчиж байна уу гэдгийг сайн нягталъя. Тамгын газар мэргэжил, аргал зүйн туслалцаа сайн үзүүлнэ шүү. Дараагийн асуудалдаа оръё.

21.18 цаг

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо Байнгын хорооноос хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай гишүүд үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй 41 санал байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд суудлаа эзлээд санал хураалтдаа бэлтгэе.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал.

1. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийн талаар.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “бодлого,” гэснийг, мөн хэсгийн “бүртгэл,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Батбаатар, Батсүмбэрэл, Ганбаатар, Наранбаяр, Одонтуяа, Сайнзориг, Ундрэм, Эрдэнэбат. Цаашид “Ажлын хэсэг гэх. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

93-аас 51 буюу 54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Гишүүд анхааралтай байж байгаарай.

Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Байгаль орчныг хамгаалах тухай хууль,” гэсний дараа “Агаарын тухай хууль,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 51 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “төр,” гэсний дараа “иргэн,” гэж нэмж, мөн хэсгийн “эрх, үүрэг, тэдгээрийн уялдаа холбоог хангахтай холбогдсон” гэснийг “эрх, үүргийг зохицуулсан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Болормаа гишүүн. 4 дүгээр санал дээр Энхбатын Болормаа гишүүн.

Э.Болормаа: Саналын томъёолол дээр 4 дэх санал дээр гүйцээн боловсруулалт чиглэл хүсье.

С.Бямбацогт: 4 дэх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

5.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “салбар,” гэсний дараа “хүн амын” гэж нэмж, 5.1.5 дахь заалтын “шинжлэх ухаанд үндэслэх” гэснийг “шинжлэх ухаан, инновацад суурилах” гэж, 5.1.9 дэх заалтын “мэдлэг, инновацад суурилсан дэвшилтэт технологийг” гэснийг “мэдлэгийг” гэж тус тус өөрчилж, 5.1.6 дахь заалтыг, 5.2 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5.1.1 дэх заалт нэмэх:

“5.1.1.эдийн засгийн үр ашигтай байх;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 51 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “олон улсын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд боловсруулах тайлан, илтгэлийг танилцах” гэснийг “тайлан, илтгэлийг сонсож, хэлэлцэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 6.1.4 дэх заалтын “бүрэн эрх” гэснийг хасах. Санал хураалт.

93-аас 51 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7 дугаар санал. Энхбатын Болормаа гишүүн.

Э.Болормаа: 7 дугаар санал дээр мөн гүйцээн боловсруулах чиглэл хүсье.

С.Бямбацогт: 7 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

8.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “ногоон хөрөнгө оруулалтын бодлого,” гэснийг, 8.1.5 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.1.Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах асуудлыг уялдуулан боловсруулах;

8.1.3.ногоон санхүүжилтийн стратегийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулах;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 52 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтын “төлөвлөгөө,” гэснийг хасаж, 8.2.2 дахь заалтын “удирдах” гэснийг “зохицуулах, хяналт тавих” гэж өөрчилж, 8.1.4 дэх заалтыг 8.2.1 дэх заалт болгон шилжүүлж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8.2 дахь хэсэг нэмэх:

“8.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”. Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.5, 8.2.6, 8.2.8 дахь заалтын “хөтөлбөрт” гэсний дараа “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн” гэж, 8.2.7 дахь заалтын “шилжүүлэгт” гэсний дараа “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн” гэж тус тус нэмж, 8.2.13 дахь заалтын “зарцуулалтыг хариуцан удирдаж,” гэснийг “зарцуулалтад” гэж, 8.2.15 дахь заалтын “, мэдээлэл цуглуулах, боловсруулах, тайлагнахтай холбоотой үйл ажиллагаа, аргачлал, зохицуулалтын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам” гэснийг “аргачлал, журам” гэж тус тус өөрчилж, 8.2.9 дэх заалтыг, 8.2.14 дэх заалтын “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн үр дүнг тооцох, мэдээлэл цуглуулах, нэгтгэх, тайлагнах, баталгаажуулах үйл ажиллагааны нэгдсэн аргачлал, зохион байгуулалтын” гэснийг, 8.2.18, 8.2.19 дэх заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 8.2.4, 8.2.16, 8.2.17, 8.3.1, 8.3.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.2.4.олон талт карбон зах зээлийн үйл ажиллагаанд зөвшөөрсөн тухай тодорхойлолт олгох, оролцогч этгээдийг бүртгэх, хяналт тавих;

8.2.16.энэ хуулийн 7.1.8-д заасан журмын төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, батлуулах;

8.2.17.энэ хуулийн 7.1.7, 7.1.9-д заасан журмын төслийг боловсруулж, батлуулах;

8.3.1.энэ хуулийн 6.1.1, 7.1.1-д заасны дагуу уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах арга хэмжээг салбарын хэмжээнд тодорхойлж, улсын төсөвт тусгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

8.3.5.салбарын хэмжээнд Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг хангах, хүлэмжийн хийн ялгарлын тооллоготой холбоотой өгөгдөл, мэдээллийг цуглуулах, тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 50 буюу 53 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.2.20 дахь заалт нэмэх:

“8.2.20.сааруулалтын үр дүнг тооцох аргачлал, стандарт, ялгарал болон шингээлтийн итгэлцүүрийг Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хорооны дэргэдэх техникийн хороогоор хэлэлцүүлж, түүний дүгнэлтэд үндэслэн батлах;”. Санал хураалт.

93-аас 51 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцсэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход чиглэсэн аймаг, нийслэлийн төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлан санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавина.”. Санал хураалт.

93-аас 54 буюу 58 хувийн санал санал дэмжигдлээ.

13.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “8.2-т заасан байгууллагаар” гэснийг “8.2.15-д заасан журмын дагуу” гэж өөрчилж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “6.1.1, 7.1.1, 10.1-д заасантай уялдуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөвлөгөөг” гэснийг “6.1.1, 7.1.1, 9.1-д заасантай уялдуулан тухайн нутаг дэвсгэрийн уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 52 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Энхбатын Болормаа гишүүн.

Э.Болормаа: 14 дүгээр санал дээр мөн гүйцээн боловсруулах чиглэл хүсье.

С.Бямбацогт: 14 дээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

15.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн төлөв байдлын үнэлгээг жил тутам, уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн чиг хандлага, нөлөөллийн үнэлгээг таван жил тутам боловсруулж, үнэлгээний дүнг нэгтгэн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

12.2.Энэ хуулийн 8.2.15-д заасан журмын дагуу уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх бодит болон болзошгүй сөрөг нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээг

нийгэм, эдийн засгийн салбар, бүс нутаг тус бүрээр холбогдох төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутгийн байгууллага нь Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасан үнэлгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, шинжлэх ухаанд суурилсан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох арга хэмжээний бодлого, төлөвлөлтийг тодорхойлно.

12.4.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний үр дүнг үндэсний, бүс нутгийн, салбарын болон орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, Үндэсний дасан зохицох төлөвлөгөө боловсруулахад ашиглана.

12.5.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний үр дүнг уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний платформоор дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.6 дахь хэсэг нэмэх:

“12.6.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэн гарах эдийн засгийн болон эдийн засгийн бус гарз хохирлын үнэлгээг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20.3-т заасан журмын дагуу холбогдох төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 49 буюу 52 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “баталгаажуулахаар” гэснийг “хянуулахаар” гэж, 13.3 дахь хэсгийн “коэффициентыг” гэснийг “итгэлцүүрийг” гэж, мөн зүйлийн 13.4 дэх хэсгийн “боловсруулж, тогтмол хугацаанд шинэчилнэ” гэснийг “боловсруулна” гэж, 13.5 дахь хэсгийн “аргачлалыг” гэснийг “аргачлал, ялгарал болон шингээлтийн итгэлцүүрийг” гэж, мөн хэсгийн “энэ хуулийн 8.2-т заасан байгууллага” гэснийг “байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран” гэж, 13.8 дахь хэсгийн “хүргүүлж” гэснийг “гаргаж” гэж тус тус өөрчилж, 13.4 дэх хэсгийн “бодлого,” гэснийг, 13.8 дахь хэсгийн “хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн ил тод байдлын тайлангийн хамтаар” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад. 93 гишүүнээс 53 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18. Энхбатын Болормаа гишүүн.

Э.Болормаа: 18 болон 19 дүгээр санал дээр гүйцээн боловсруулах чиглэл хүсье.

С.Бямбацогт: 18, 19 дүгээр санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

20.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “дээд шатны байгууллагад танилцуулна” гэснийг “энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ” гэж өөрчлөх. Санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх бодлого, төлөвлөлт

18.1.Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг таван жил тутам шинэчлэн батална.

18.2.Урт хугацааны хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн шилжилтийн стратегийг хүлэмжийн хийн үндэсний тооллого, хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн хэтийн төлөв, төсөөлөлд үндэслэн боловсруулна.

18.3.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх төлөвлөлтийг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн тодорхойлно.

18.4.Энэ хуулийн 18.2-т заасан стратеги, төлөвлөгөөнд хүлэмжийн хийг ялгаруулагч болон шингээгч салбар тус бүрээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээний хүрээ, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тусгана.

18.5.Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 8.4-т заасан чиг үүрэг, 10, 11 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт тусгаж хэрэгжүүлнэ.

18.6.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг харгалзан үзнэ.

18.7.Хувийн хэвшлийн байгууллага өөрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийг тооцох, бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийг дэмжинэ.

18.8.Үндэсний зохицуулагч байгууллага байгууллагын болон төслийн түвшний хүлэмжийн хийн ялгарлын тооцоо, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалттай холбоотой заавар, аргачлалыг баталж, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

18.9.Үндэсний зохицуулагч байгууллага уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээний гүйцэтгэлийг жил бүр үнэлж, хэрэгжилтийн тайланг боловсруулж, энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

18.10.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд институтын болон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг тусгана.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 93 гишүүн орсон 48 гишүүн буюу 51 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүд ээ, Сэдээ гишүүн ээ.

22.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.2.Үндэсний зохицуулагч байгууллага Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн ил тод байдлын тайланг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалын дагуу боловсруулж, энэ хуулийн 8.3-т заасан байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 93 гишүүн орсноос 50 гишүүн буюу 53 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

23.Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20 дугаар зүйл.Ногоон санхүүжилт

20.1.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх, нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг ногоон санхүүжилтээр дэмжинэ.

20.2.Ногоон санхүүжилтээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөв, мөнгөний бодлого, ногоон санхүүжилтийн стратегитай нийцсэн байна.

20.3.Энэ хуулийн 20.1-т заасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтөд зардал, үр ашгийн тооцоо, нийгэм, эдийн засгийн өгөөж, төсөвт үзүүлэх нөлөөлөлд үндэслэнэ.

20.4.Ногоон санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 20.4.1.улсын болон орон нутгийн төсөв;
- 20.4.2.төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилт;
- 20.4.3.гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүний санхүүжилт;
- 20.4.4.гадаадын зээл, буцалтгүй тусламж;
- 20.4.5.байгаль орчин, уур амьсгалын сан;
- 20.4.6.хууль тогтоомжид нийцсэн бусад эх үүсвэр.

20.5.Ногоон санхүүжилтийг дараах санхүүгийн хэрэгсэл, хөшүүргийг ашиглан хэрэгжүүлж болно:

20.5.1.улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт;
20.5.2.татварын хөнгөлөлт, чөлөөлөлт;
20.5.3.батлан даалт;
20.5.4.зорилтот бонд, зээл;
20.5.5.төр, хувийн хэвшлийн болон олон улсын эх үүсвэртэй холимог санхүүжилт;
20.5.6.хууль тогтоомжид заасан бусад.

20.6.Энэ хуулийн 20.5-д заасан ногоон санхүүжилтийн хөшүүрэг нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Өрийн удирдлагын тухай, Татварын ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

20.7.Ногоон санхүүжилтэд хамрагдах төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа нь ногоон санхүүжилтийн шалгуур, ногоон таксономи, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын шаардлагыг хангасан байна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 55 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.5 дахь хэсгийг хасаж, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.3.Ногоон санхүүжилтэд хамрагдах төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны үр дүн нь бодит, хэмжигдэхүйц, баталгаажихуйц байна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Төслийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3, 22.5, 22.6 дахь хэсгийг хасаж, 22.1, 22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, доор дурдсан агуулгатай тайлбар нэмэх:

“22.1.Ногоон санхүүжилтийн мэдээлэл нь ил тод, нээлттэй, нийтэд хүртээмжтэй байна.

22.4.Уур амьсгалын санхүүжилтийн мэдээллийг энэ хуулийн 19 дугаар зүйлд заасны дагуу Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн ил тод байдлын тайланд тусган тайлагнана”

Тайлбар: -Энэ хуулийн 4.1.24-т заасан уур амьсгалын санхүүжилт нь 4.1.9-д заасан ногоон санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд энэ хуульд "ногоон болон уур амьсгалын санхүүжилт" гэж дурдсан тохиолдолд уур амьсгалын санхүүжилтийг ногоон санхүүжилтэд хамааруулан ойлгоно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 50 гишүүн буюу 53 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “хэлбэртэй” гэснийг “төрөлтэй” гэж, 23.3.8 дахь заалтын “иргэдтэй урьдчилан зөвлөлдөж” гэснийг

“иргэдэд төсөл, хөтөлбөрийн танилцуулга хийж,” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 23.3.7, 23.5.11, 23.6 дахь хэсгийг хасаж, 23.5.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.5.5.сааруулалтын үр дүнг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод тооцох, олон улсад шилжүүлэх эсэхийг тодорхойлсон ашиглалтын зорилго;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 51 буюу 54 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

27.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “санхүүжилтээр шууд санхүүжээгүй төслөөс” гэснийг “санхүүжилтээс бусад эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төслөөс” гэж өөрчлөх. Санал хураалт.

93-аас 50 буюу 53 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Төслийн 25 дугаар зүйлийг хасах. Санал хураалт.

93-аас 50 буюу 53 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “баталгаажуулалтын журмыг энэ хуулийн 8.2-т заасан байгууллага батална” гэснийг “баталгаажуулалтыг энэ хуулийн 7.1.8-д заасан журмын дагуу хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Төслийн Наймдугаар бүлгийн гарчгийн “ИЛ ТОД БАЙДАЛ” гэснийг “ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ” гэж өөрчилж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “Үндэсний” гэсний өмнө “Уур амьсгалын өөрчлөлтийн” гэж нэмж, 27.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.2.Үндэсний зохицуулагч байгууллага уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, төсөл, хөтөлбөрийн үр дүн, хүлэмжийн хийн үндэсний тооллогын мэдээллийг энэ хуулийн 27.1-д заасан үндэсний мэдээллийн системд бүртгэж, түүний ашиглалт, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг ханган ажиллана.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

31.Төслийн 28 дугаар зүйлийн гарчгийн “, ил тод байдал” гэснийг хасаж, мөн зүйлийн 28.2 дахь хэсгийн “хуулийн” гэсний өмнө “хуулийн 28.1-д заасан байгууллага” гэж нэмж, 28.3 дахь хэсгийн “тогтоосон хугацаанд” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “зорилтыг хангах зохицуулалттай карбон кредитийг энэ хуулийн 8.2-т заасан” гэснийг “зорилтод

тооцогдох карбон кредитийг энэ хуулийн 8.3-т заасан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 52 буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 50 буюу 53 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Төсөлд доор дурдсан агуулгатай 32 дугаар зүйл нэмэх:

“32 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

“32.1.Энэ хуулийн 7.1-ийн. Ганбаатар гишүүн ээ. “32.1.Энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 7.1.9, 7.1.10-т заасан журмыг Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор баталж, мөрдүүлнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 51 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Төслийн 32 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. 36.

93-аас 49 буюу 52 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах. Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

1.Төслийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “8.3” гэсний дараа “заасан чиг үүрэг” гэж, 24.1 дэх хэсгийн “бүртгэгдсэнээр” гэсний дараа “түүнийг” гэж тус тус нэмж, 4 дүгээр зүйлийн 4.1.6, 4.1.15 дэх заалтын “зах зээлийн тогтолцоог” гэснийг “зах зээлийг” гэж, 4.1.20 дахь заалтын “мэдрэг байдал өндөр” гэснийг “эрсдэлтэй, мэдрэг байдалтай” гэж, мөн заалтын “өндөр” гэснийг “бүхий” гэж, 4.1.32 дахь заалтын “нүүрсхүчлийн хий” гэснийг “нүүрстөрөгчийн давхар исэл,” гэж, 4.1.33 дахь заалтын “экосистемийн,” гэснийг “экосистемийг ашиглах” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “санхүү, төсвийн” гэснийг “эдийн засаг, хөгжлийн” гэж, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “тогтоосон” гэснийг “хуульд заасан” гэж тус тус өөрчилж, төслийн хуулийн нэрийн “ХУУЛЬ” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.2.20, 8.3.6 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтын “бүрэн эрх” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “Салбарын болон бусад” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “өөрчлөлтийг даван туулах” гэснийг “өөрчлөлтийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 55 буюу 59 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 9 дэх хэсгийн “мэдээллийн нэгдсэн” гэснийг “уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн” гэж, 2 дугаар зүйлийн “өөрчлөлтийн мэдээллийн нэгдсэн сан” гэснийг “өөрчлөлт” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

93-аас 52 буюу 55 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41.12.Байнгын хороо энэ хуулийн 39.25-д заасан үндэслэлээр хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн санал, дүгнэлт гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүд олонх дэмжсэн бол хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцно. Саяын тогтоол батлагдлаа.

3.Найруулгын санал.

Дээрх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчилж, төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Энэ чухал хууль энэ намар бас COP17 Монгол Улсад болно. Үүнээс өмнө бас баталчих юм бол бас Монгол Улсад орж ирэх байгаль орчинтой ч хөрөнгө оруулалт хэрэгтэй.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

Манай Бейсен дарга их чухал хууль батлуулах гэж ажиллаж байгаа Сандаг-Очир гишүүн.

21.47 цаг

Одоо энэ ганцхан асуудал байгаа шүү нөхөд өө. Одоо асуулт билүү. Одоо ганцхан санал хураалт байгаа.

Одоо **Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.**

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. Хурууны хээгээ уншуулаагүй байна шүү. Зулпхар гишүүн хажууд нь суугаад сайхан уншуулчихгүй юу. Санал хураалт. Санал хураалт гишүүд ээ.

1.Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 93 гишүүнээс 56 гишүүн буюу 60 хувийн санал санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Ойн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

93-аас 53 буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ойн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

93-аас 51 буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.“Ойн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

93-аас 54 буюу 58 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

Манай Бейсен даргын ажил эхэлчихлээ шүү. Өнөөдрийн батлах хуулиуд дуусаж байна. Одоо гэхдээ хэлэлцэх хуулиуд байгаа. Сая санал хураалтад оролцсон гишүүддээ их баярлалаа. Одоо хэлэлцэх хуулиудаа хэлэлцье ээ. Дараагийн асуудалдаа оръё.

21.49 цаг

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

Хууль санаачлалын илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа гишүүн танилцуулна. Таныг индэрт урьж байна. Даваасамбуугийн Ганмаа гишүүн. Дахин дахин хэлэхгүй бол буруу хэлээд байгаа шүү.

Д.Ганмаа: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Өнөөдөр бид Монгол Улсын иргэн бүрийн Үндсэн хуулиар баталгаажуулсан эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хэрхэн бодитойгоор хангах вэ гэдэг асуудлыг хэлэлцэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд иргэн бүр эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй гэж заасан байдаг. Гэвч бодит байдал дээр иргэн эмнэлэг хооронд явж чирэгдэх, өвчний түүх, мэдээлэл нь тухайн нэг эмнэлэгт хэвтээд гарснаар тасалдах, хот, хөдөөгийн эмнэлгийн үйлчилгээ, ялгаа нь асар их, анхан шатлалын тусламж нь бэхжээгүй, эмчилгээний дараах хяналт орхигдох, хаягдах зэрэг асуудлууд өндөр хэвээрээ байна.

2016 онд баталсан Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай анхдагч хууль нь тухайн үед цаг үеэ олсон дэвшил байсан. Гэвч өнгөрсөн 10 жилийн хугацаанд эрүүл мэндийн тогтолцоо, санхүүжилт, технологи, хүн амын өвчлөлийн бүтэц, олон улсын чиг хандлага эрс өөрчлөгдсөн байна.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл хийгдэж, 1 худалдан авагчийн тогтолцоог бүрдүүлж, стратегийн худалдан авагч руу бид 2021 онд шилжсэн.

Одоогийн хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, бидний өөрсдийн хийсэн салбарын судалгаанууд олон улсын хүрээнд бидний зохион байгуулсан хэлэлцүүлгүүд, олон улсын байгууллагуудын зөвлөмжөөс харахад өнөөгийн тогтолцоонд хүн төвтэй биш эмнэлэг төвтэй хэвээр байгаа нь харагдаж байна.

Эрүүл мэндийн салбарын том нэг асуудал бол шийдвэр гаргалт, тогтолцоонд суурилагаасаа илүү хувь хүмүүсээс хамааралтай хэвээрээ байна.

Сайд солигдох бүрд бодлогын тэргүүлэх чиглэл өөрчлөгдөж байна. Удирдлага өөрчлөгдөх бүрд бүтэц өөрчлөгдөж байна. Улмаар эрүүл мэндийн салбарын урт хугацааны хөгжлийн бодлого, институцийн тогтвортой байдал алдагдаж байна.

Өнөөдөр хүн өвдөхөөрөө өөрөө эмнэлгийн тусламж, үйлчилгээнийхээ зохицуулагчаа хийх болжээ. Эрүүл мэндийн салбар бол 4 жилийн туршид сонгуулийн мөчлөгөөр хэмжигдэх салбар биш юм. Энэ бол олон арван жилийн нотолгоо, судалгаа, шинжлэх ухаанд суурилж хөгжих ёстой салбар юм.

Гэвч өнөөдөр тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, хөрөнгө оруулалт, санхүүжилттэй холбоотой олон шийдвэрүүд хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ, өвчлөлийн бүтэц, шинжлэх ухааны нотолгоонд эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэгт тулгуурлахаасаа илүү тухайн үеийн шийдвэр гаргагч нарын асуудалд хандах байдал, асуудлыг дагаж шийдэж байна.

Иймээс энэхүү хуулийн төсөл нь эрүүл мэндийн салбарын бодлого, төлөвлөлт, санхүүжилт, хүний нөөцийн шийдвэрийг хувь хүний үзэмжээс бус харин судалгаа, өгөгдөл, нотолгоонд суурилан гаргах эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаа юм.

Мөн эрүүл мэндийн салбарын санхүүжилт, нөөцийн хуваарилалт нь иргэдийн хэрэгцээг дагах ёстой болохоос байгууллага, хувь хүний нөлөөллийг дагах ёсгүй юм. Төрөөс зарцуулж байгаа 1 төгрөг, 1 мөнгө бүрийг хамгийн их хэрэгцээтэй байгаа иргэнд хүргэх ёстой. Тиймээс энэхүү хуулийн төсөлд гүйцэтгэл, чанар, үр дүн, хэрэглэгчийн үнэлгээнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бодитоор бий болгож, шийдвэр гаргалтыг илүү ил тод, хариуцлагатай болгох зохицуулалтыг тусгасан.

Эрүүл мэндийн салбар хүнээс хамаардаг биш тогтолцооноосоо хамаардаг байх ёстой юм. Сайд солигдоход бодлого солигддог биш сайд шүү уучлаарай. Нотолгоо өөрчлөхөд бодлого өөрчлөгддөг тогтолцоог бид бий болгох ёстой. Тиймээс энэхүү шинэчилсэн найруулгын гол үзэл санаа нь энгийн бөгөөд ойлгомжтойгоор эмнэлгийг биш хүнийг төвд тавья. Өвчнийг биш хүний хэрэгцээнд суурилсан зохицуулалтыг бий болгоё. Тасалдсан бус нэгдмэл, тасралтгүй тусламж, үйлчилгээний арга зүйг бүрдүүлье.

Энэхүү хуулийн төсөл тусламж, үйлчилгээг хүн төвтэй нэгдмэл, тасралтгүй, чанартай, аюулгүй, хүртээмжтэй хүргэх эрх зүйн шинэ орчны суурийг бүрдүүлж байна.

Тэгэхийн тулд нэгдүгээрт анхан шатны тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн тогтолцооны үндэс болгон бэхжүүлнэ. Анхан шатлалын тусламж, үйлчилгээ дэлхийн улс орнууд ялангуяа КОВИД-19 цар тахлаас хойш бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг хангах хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмын хүрээнд үндэс нь анхан шатлалын тусламж, үйлчилгээ эрүүл мэндийн тогтолцооны үндэс болгон бэхжүүлэхээр шийдвэрлэсэн билээ.

Өнөөдөр иргэдийн дийлэнх нь шууд лавлагаа шатлалын эмнэлэгт ханддаг болсон. Үүний улмаас улсын хэмжээний томоохон эмнэлгүүд ачаалалдаа дарагдаж, нөөцийн үр ашиг алдагдаж байна. Харин хуулийн шинэчилсэн

найруулгаар өрхийн болон сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эрүүл мэндийн төв, иргэдийн эрүүл мэндийн үндсэн хамгаалагч болж ажиллана. Өрхийн эмч өвчтөнийг үнэлж, зохицуулагчийг нь хийж, шаардлагатай үед дараагийн шатлал руу нь илгээдэг олон улсын жишигт хаалга барих тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлнэ.

Үүнд дараах урьдал нөхцөл байгаа нь манай улсын хувьд том давуу тал болж байна. Анхан шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг хаана ч байсан авах боломжтой дэд бүтцийг бүрдүүлж чадсан байна Монгол Улс. 307 сумын эрүүл мэндийн төв, 228 өрхийн эрүүл мэндийн төв, 20 тосгоны эрүүл мэндийн төв байна. Энэ нь иргэдийг чирэгдүүлэх бус харин хамгийн зөв тусламжийг хамгийн хэрэгтэй цаг үед тухайн газрын шатлал, төрөл бүр зохистой эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүгийн дарамтгүй авах боломжийг бүрдүүлнэ.

Эмчийн тоо, сувилагчийн тоо, орны тоо, эмийн сангийн тоогоор бид дэлхийд тэргүүлж байгаа. Хуучин төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос хөдөө орон нутагт эмнэлгийн дэд бүтэц одоо хүртэл хэвээрээ хадгалагдаж байгаа.

Хоёрдугаарт шатлал хоорондын тасалдсан холбоо, өвчтөн шатлал хооронд хаягддаг байдлыг шат дараатайгаар бүрмөсөн арилгана. Өнөөдөр харвалт, зүрхний шигдээс зэрэг хүнд өвчний дараах хяналт тасрах, өвчтөн, эмнэлэг хооронд хаягдах тохиолдол гарч байгаа. Хуулийн шинэчилсэн найруулгаар анхан, хоёрдогч, гуравдагч шатлалын эмнэлгүүдийг нэг зорилгын хүрээнд уялдаатай ажиллах, нэгдмэл байдлаар өвчтөн хаана эмчлүүлж байгаагаас үл хамааран эмнэлгийн мэдээлэл нь үргэлжилдэг, тусламж, үйлчилгээ нь тасралтгүй байдаг тогтолцоог бүрдүүлнэ.

Гуравдугаарт чанар ба хариуцлагын шинэ тогтолцоог бий болгоно. Өнөөдөр бид эмнэлгийн үйл ажиллагааг тоогоор нь хэмждэгээс чанар үр дүнгээр нь хэмждэг тогтолцоонд шилжиж чадаагүй байна. Хуулийн шинэчилсэн найруулгаар магадлан итгэмжлэл, эмнэл зүйн аудит, гүйцэтгэлийн үнэлгээ, хэрэглэгчийн үнэлгээ гэсэн 4 тулгуурт хөндлөнгийн үнэлгээний механизмыг бүрдүүлж байна.

Өөрөөр хэлбэл, зөвхөн хэдэн хүн үзсэнээр, хэдэн ор ашигласнаар, хэчнээн үйлчилгээ хийснээр бус хэдэн хүний эрүүл мэнд сайжирсан бэ гэдгээр эмнэлгийн үр дүнг хэмждэг болно.

Дөрөвдүгээрт санхүүжилтийн хөшүүргийг чанар, хүртээмж, аюулгүй байдлын үр дүнтэй уялдуулна. Эрүүл мэндийн даатгалын сан, Эрүүл мэндийн сайдын багцыг жилээс жилд өсгөж байгаа ч сангийн тэнцэл хасах руугаа орох тогтвортой байдалд дарамт учирч байгаа.

Иймд энэ хууль санхүүжилтийг зөвхөн үйлчилгээний тоонд бус чанар, үр дүн, аюулгүй байдалтай уялдуулах эрх зүйн үндсийг бий болгож байна.

Гэхдээ энэ нь бол төсөв нэмнэ гэсэн үг биш ээ. Харин байгаа хөрөнгөө, байгаа төсвөө бодлоготойгоор илүү үр ашигтай зарцуулах юм.

Тавдугаарт эрүүл мэндийн цахим шинэчлэлийг дараагийн үе шатад гаргаж байна. Хуулийн шинэчилсэн найруулгаар өвчний цахим түүхийг бүрдүүлж,

эмчлүүлэгчид зориулсан порталыг бий болгож, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.

Ингэснээр иргэн өөрийн эрүүл мэндийн мэдээлэлдээ шууд хандах, эмч нар шаардлагатай мэдээллийг шуурхай ашиглах, давхардсан оношилгоо буурах, чанартай эмийг хүртээмжтэйгээр хэрэглэх, эмчилгээний чанар дээшлэхээс гадна тоон мэдээлэл нэгтгэгдэж, эрүүл мэндийн нотолгоонд суурилсан, бодит, үнэн зөв, шинжлэх ухаанч шийдвэр гаргах боломжтой болно.

Тиймээс энэхүү хуулийн төсөлд санхүүжилтийг зөвхөн үзүүлсэн үйлчилгээний тоотой бус чанар, үр дүн, аюулгүй байдал, хэрэглэгчийн үнэлгээтэй уялдуулан зохицуулалтыг нь бий болгосон.

Ингэснээр мөнгө хамгийн их нөлөө бүхий байгууллагыг биш харин хамгийн сайн үр дүн үзүүлж байгаа тусламж, үйлчилгээг дагах нөхцөл нь бүрдэх юм. Өнгөрсөн зууны төвлөрсөн төлөвлөгөө тогтолцооноосоо уламжлан өвчнийг голчлон эмнэлэгт хэвтүүлэн эдгээхэд чиглэсэн эмнэлэгт суурилсан бүтэцтэй семешка загвараар тусламж үзүүлсэн хэвээр өнөөг хүрчээ.

Иймд тусламж, үйлчилгээний загварыг одоогийн нийгэм, эдийн засгийн байдал, өвчлөлийн бүтэц, эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон загварт шилжүүлэх нь тулгамдсан асуудал болоод байгаа. Энэ загварын өөрчлөлтийг энэхүү хуулийн шинэчилсэн найруулгаар зохицуулахаар зорьж байна. Энэ бол өвдсөн хойно нь эмчлэх бус урьдчилан сэргийлэх тогтолцооны тухай хууль юм. Энэ бол хот, хөдөөгийн ялгааг бууруулах тухай хууль юм. Энэ бол эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлж, иргэдийн итгэлийг сэргээх тухай хууль юм.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоо эмнэлэг төвтэй загвараас хүн төвтэй буюу үүнд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд ажиллах хамгийн таатай бүхий л орчин нөхцөлийг бүрдүүлэх нь ч мөн орж, нэгдмэл, тасралтгүй үйлчилгээний загварт шилжих эрх зүйн үндэс нь бүрэн бүрдэнэ.

Иймд Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа. Монгол хүн бүрийн төлөө бүх бодлогод эрүүл мэнд уриаг дэвшүүлье ээ.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Даваасамбуугийн Ганмаа гишүүнд баярлалаа. Төслүүдийн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал танилцуулна. Таныг индэрт урьж байна.

О.Батнайрамдал: Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганмаа нарын 46 гишүүнээс 2026 оны 05 сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн

бодлогын байнгын хороо 2026 оны 06 сарын 17-ны өдөр хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэдээ эрүүл мэндийн шалтгаант санхүүгийн эрсдэлээс хамгаалах, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн таатай орчныг бий болгох, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, хүн амын бодит хэрэгцээнд тулгуурласан тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн тогтолцооны зорилтуудыг хангах хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуулийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын хүрээнд хуулийн төслийг баталснаар улсын төсөвт 9 тэрбум төгрөгийн нэмэлт зардал үүснэ гэж хууль санаачлагч үзжээ.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулж, иргэд олон нийтийн санал авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Наранбаяр хуулийн төслийн хүрээнд иргэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах шатлалыг хэрхэн тодорхойлсон талаар, Өрхийн эрүүл мэндийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үйлчилгээг сайжруулах болон улсын эмнэлэгт ажиллаж буй эмч нарыг сэлгэн ажиллуулах зохицуулалт туссан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал хуулийн төслийг боловсруулахад суурь судалгаа хийгдсэн эсэх, судалгааны дүгнэлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсайхан эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрлийг хэрхэн тодорхойлсон, ангилсан талаар, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолоор баталдаг төлбөрийн аргуудыг хуулийн төсөлд шууд тусгасан нь оновчтой эсэх, эмнэлгийн тусгай зөвшөөрлийн зохицуулалтыг орхигдуулсан талаар, мөн эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн зохицуулалт болон хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр боловсруулж буй эрүүл мэндийн холбогдох бусад хуулийн төслүүдтэй хэрхэн уялдсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн тооцоолол, дэд бүтэц, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны стандарт, бүтцийн өөрчлөлтийн талаар тус тус асууж, хариулт авсан болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа эрүүл мэндийн салбарын тогтолцоог эмч, эмнэлэг төвтэй биш иргэний эрх ашигт нийцсэн байхаар хуулийн төслийг боловсруулсан талаар саналаа хэлсэн.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар оролцсон гишүүдийн олонх буюу 75 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 68.8 хувийн саналаар, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 81.3 хувийн саналаар, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 81.3 хувийн саналаар, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 81.3 хувийн саналаар, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний

тухай хуулийн хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг 81.3 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлэг явуулах талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

С.Бямбацогт: Батнайрамдал гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя. Бямбасүрэнгийн Туяа Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Мэндсайханы Наранпүрэв Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Сэмбэдоржийн Жаргалсайхан Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Лхамжавын Баярцэцэг Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, Гүрсэдийн Баатарсүрэн хуульч, өмгөөлөгч, Даваасамбуугийн Энхмаа Хүний их эмч, анагаах ухааны доктор, Цэдэв-Очирын Төмөр-Очир Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал, Монгол улсын гавьяат эмч, анагаах ухааны доктор, дэд профессор, Машбатын Одгэрэл Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал, хүний их эмч, Шагдархүүгийн Хажидмаа Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирал, Норовын Болормаа Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны ахлах мэргэжилтэн, хүний их эмч, Ганхуягийн Пүрэвсүрэн “Гурван гал” эмнэлгийн Ерөнхий захирал, хүний их эмч, Хишигдэлэгийн Ганцэцэг Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийн захирал, хүний их эмч, Чулуунбаатарын Адьяалхам эрх зүйч. Ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хуралд бас хүндэтгэлтэй хандах, Улсын Их Хурлын гишүүдийн асуултад үнэн зөв, бодитой мэдээлэл өгч, бүрэн гүйцэд хариулах, тодорхой хариулах ийм бас дэгтэй шүү гэдгийг сануулъя.

Одоо Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчдын илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу? Оройн мэнд. Энэ хуульд шинээр зохицуулж байгаа харилцааны хүрээнд ойлгохдоо нийгмийн эрүүл мэндийн бодлогоор бууруулах боломжтой оношны хамаарлын бүлгүүд болох жишээлбэл уушгины хатгаа, хүүхдийн амьсгалын замын өвчин гээд чихрийн шижин, эсвэл архины шалтгаант сэтгэцийн эмгэг энэ тэр гэсэн энэ өвчнүүд, эсвэл эрүүл мэндийг нь дэмжих бодлогоор бууруулах боломжтой оношны хамааралтай бүлэг болох цөсний чулуу, хамрын хөндийн эмгэг ч юм уу, гэдэсний өвчин гэх зэрэг өвчнүүд, эсвэл эрт илрүүлгээр бууруулах боломжтой оношны хамааралтай бүлгүүд болох жирэмсний хүндрэлүүд, бөөрний зарим архаг өвчин зэрэг иймэрхүү ингээд жагсаалтууд байгаа. Энэ бол өнөөдрийн байдлаар Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн хамаг мөнгө энд яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийг аймаг, дүүрэг дээр аймгийн эрүүл мэндийн зардлыг харахаар хүн амын тоо нь адилхан мөртөө зарцуулж байгаа эрүүл мэндийн үзүүлэлт нь өөр байгаа. Тэгэхээр манай улсын эрүүл мэндийн зардлын урсгал нь өвдсөн газраа илүү их мөнгө өгөөд байдаг, хүн ам нь өвдвөл мөнгө өгөөд байдаг, эдгээд эрүүл болохоор мөнгө өгдөггүй ийм нийгмийн эрүүл мэндийн ийм урвуу тогтолцоотой.

Тэгэхээр өнөөдрийн байгаа энэ байдлыг сайжруулахад энэхүү хуулийн ямар зохицуулалт нь яаж тусгасан байдал нь өөрчлөлтийг авчрах вэ гэдэг мэдээллийг өгнө үү.

С.Бямбацогт: Хууль санаачлагчид хариулъя. Ганмаа гишүүн.

Д.Ганмаа: Та бүхэн мэдэж байгаа Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хууль, нийгмийн эрүүл мэндийн хууль гэж байгаа манайд. Бусад улс оронд бол ер нь нийт эрүүл мэндийн асуудлуудыг нэгтгэсэн байдлаар шийдсэн асуудал байдаг л даа. Манай хуулийн хувьд нэгдүгээрт ерөөсөө эрүүл мэндийн гол зорилго болсон нийт иргэдээ эрүүл байлгах, урт удаан наслуулах, чанартай наслуулах, тэрүүнд ялангуяа эмнэлгийн тусламж, үйлчилгээгээ ямар байдлаар зохистой нэгдмэл, шатлал хооронд, шатлал тус бүрд зохистой тусламж, үйлчилгээг хүргэх вэ гэдэгт илүү тулгуурлаж байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт мэдээж насны бүтцээрээ ч юм уу, эсвэл өвчлөлийн бүтцээрээ байгаа, оршин сууж байгаа, амьдарч байгаа нутгийнхаа онцлогоос хамаараад жишээлбэл говийн бүсэд бол илүү уул уурхай ч гэдэг юм уу, эсвэл хангайн бүсэд бол илүү тариалантай, эсвэл зарим бүсүүдэд яг малчид ихтэй ч гэдэг юм уу хамаараад ерөөсөө бодит хэрэгцээгээ байнга судал, 5 жилийн тутамд гаргаж байя гэсэн ийм дүгнэлтүүдийг гаргаж байгаа.

Юу гэсэн үг вэ гэх вэ тухайн нөхцөл байдалд ямар ард иргэд амьдарч байна, ямар өвчлөлт нь илүү байна. Тэрнээсээ хамаараад хүндрэл, нас баралт нь хаа байна. Яг тэндээ тулгуурласан бодитой, төлөвлөгөөт тусламж, үйлчилгээг хүргэе. Тэр тусмаа бид нар хамгийн илүү бэхжүүлж байгаа анхан шатын тусламж, үйлчилгээ. Тэрийгээ өрхийн мэндийн төвд, сумын эрүүл мэнд, тэгээд мэдээж сум, тосгоны эрүүл мэндийн хувьд анхан шатынхаа тусламж, үйлчилгээг ч зайлшгүй шаардлагатай үед хоёрдогч шатлалынхаа тусламж, үйлчилгээг энд хүргэж явъя гэсэн ийм тооцоололтой байгаа.

Тэн дээр мэдээж зөвхөн эмч гэхээсээ илүү сувилагч, яг л эмч, эрүүл мэндийн байгууллагууд гол суурь хэдэн тусламжууд байгаа шүү дээ. Эмчлэх, урьдчилан сэргийлэх, туслах, дэмжих, боловсрол олгох, хөнгөвчлөх гэх мэтчилэн эдгээр нийт үйл ажиллагааг цогцоор нь харж хийх энэ тусламж, үйлчилгээг хүргэх юм.

Ингэснээрээ гол нь бид хэдийн асуудалд юу гэдэг юм дагаж шийддэг энэ асуудлаа илүү тодорхой, илүү бодитой, илүү төлөвлөгөөтэй, илүү үр дүнтэй хүргэх энэ тогтолцоонд байгаа. Түрүүний нэрлэсэн хэд хэдэн өвчлөлүүд байна тийм үү? Эдгээр өвчлөлүүдэд яг анхан шатдаа тухайн аймаг, орон нутгийнхаа ч юм уу, эсвэл тухайн дүүрэг, газрынхаа хүмүүсийг яг ямар хүмүүсийг нь ямар хугацаанд яаж хянах вэ. Жишээлбэл, даралт ихэсдэг өвчтэй хүмүүсийг гэвэл яг анхдагч

байдлаар байна уу, илүү хүндрэлийн шалтгаантай өөр даралт өвчлөлт байна уу, эсвэл улирлын үед томуу ихэслээ гэхэд энийг өвчлөлийг хүндрүүлэхгүй цааш нь хатгаа болчихгүй бүүр хүүхэд.../минут дуусав./

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Тодруулаад асуучихъя тэгээд хариулъя. Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Баярлалаа. Тэгэхлээр өнөөдрийн байгаа эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гардаг дата мэдээллүүдийн өгөгдлүүдийг дахиж ашиглах замаар, эсвэл илүү сайжруулах замаар эрүүл мэндийн нөөцийн хуваарилалтыг байршуулалт, тэр шийдвэр гаргалт хийнэ гэсэн үг үү? Энэ дээр та нэмж тодруулж өгөөч. Баярлалаа.

С.Бямбацогт: Ганмаа гишүүн хариулъя .

Д.Ганмаа: Ер нь судалгаанд суурилна гэдэг нь нэгдүгээрт эрүүл мэндийн бодит хэрэгцээг тодорхойлох асуудал яриад байгаа юм бид нар газар орон нутгийнхаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт мэдээж нэгтгэгдчихсэн цуглуулагдсан мэдээ, мэдээлэл байгаа бид нарт. Тэр нь эмнэлгийн эрүүл мэндийн хөгжлийн төв дээр ч бай, Эрүүл мэндийн яаман дээр ч бай мэдээж мэргэжлийн сургуулиуд, судалгааны төвүүд дээр ч байсан мэдээ, мэдээллийг нэгтгэж ашиглах энэ бүрэн боломж, энэний зохицуулалтуудыг гаргаж ирнэ.

Хоёрдугаарт мэдээж бид нар оношоо хамааралтай бүлгээсээ хамаараад зарим өвчлөлийг санхүүжүүлдэг, зарим нь санхүүжүүлэлт нь тийм сайн тавигддаггүйгээс болоод бас янз янзын өвчтөнийг эмчлэхийн тулд мэдээ, мэдээлэл нь яг үнэн зөв, бодитой гарахгүй байгаа асуудлууд бас бодит амьдрал дээр гараад байгаа юм. Одоо эдгээр асуудал нь бид нарын тэр нэгдмэл мэдээллийн сантай болсноор үнэн, зөв мэдээллийг нэгтгэгдэж.../минут дуусав./

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Ганмаа гишүүн .

Д.Ганмаа: Манай юунаас хариулчих, техникийн хэсгээс хариулчих.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон индрийн. Хэн хариулах вэ? Нэрээ хэлээд хариулаарай. 4.

Л.Баярцэцэг: Баярцэцэг. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бид нар нийт эрүүл мэндийн тухай асуудлыг ярихаар 3.5 сая хүн амын эрүүл мэндийн асуудал яривал бид нар нийтээрээ тогтолцооны асуудал яриад байгаа юм. Хэрвээ бид нар яг одоо өвдсөн хувь хүний асуудал яривал яг эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай асуудал ярьж байгаа. Тэгэхээр нийт хүн 3.5 сая хүн амынхаа эрүүл мэндийн яг бодит хэрэгцээг өнөөдөр бид нар яг тооцож чадаж байгаа юу? Яг 3.5 сая хүн амын нийт зонхилон тохиолдож байгаа өвчин ямар байгаа юм, тэрэнд тохирсон бид нар нөөцийг хуваарилж чадаж байгаа юу, тэр дэд бүтцийг бий болгож чадаж байгаа юу, тэгээд тэр тусламж, үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэж чадаж байгаа юу гэдэг эрх зүйн зохицуулалтыг энэ хуулийн хүрээнд цогцоор нь авч үзэж байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууя.

М.Нарантуяа-Нара: Оройн мэнд хүргэе. Ганмаа гишүүний энэ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний шинэчилсэн найруулгын хууль бол бас миний хувьд яг энэ өндөр хөгжилтэй орны эрүүл мэндийн тогтолцоог маш сайн судалж, практикт, онол хослуулж байсан хүний хувьд бол бас нэлээн шинэ соргогоор харсан байна гэж харж байна.

Тэгээд яг одоогийн эмнэлэг, эмнэлгийн тусламж, үйлчилгээний энэ тогтолцоог, хуулийн нөхцөл байдлыг харахаар яг өвчтөний талаас харахаас илүүтэйгээр эрүүл мэндийн байгууллагын удирдлага, удирдлагын түвшин, тэнд хэн ямар дарга нь байх вэ, тэр дарга нь хэнийг удирдах вэ, яах вэ, ийх вэ гэдэг ер нь энэ эмнэлгийн яг бүтэц, удирдлагын хэмжээний асуудал байгаад байдаг. Харин эсрэгээрээ өвчтөн өвдөнгүүтээ би хаана очих вэ, хэнд хандах вэ, энэ өвчнийг эхний оношийг тавиад дараагийн хэсэгт би хаашаа явах вэ гэдэг юм нь тодорхойгүй байдаг.

Дээрээс нь ямар нэгэн байдлаар онош тогтоогдоод дараагийн эмчилгээ болон хагалгааны ялангуяа энэ хүнд шатын түвшний юм болохоор цаг нь олддоггүй. Тэгээд цаг авахын тулд бараг тэнд өдөржин очерлоод суудаг, эс үгүй бол хэдэн сараар үргэлжилдэг ийм юмнууд байдгийг бас нэлээн шийдэж өгөх юм уу гэж харсан. Тэгээд яг энэ дундаа бас хот, хөдөөгийн алслагдсан бүс нутгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, энэ чанарын ялгаа арилаагүй, бүс нутгийн тэгш бус байдлыг бас энэ хуулийн төсөлд шигтгэж өгсөн чинь бол аягүй зөв санагдаж байгаа.

Би нэг зүйлд аягүй санаа зовдог юм. Ялангуяа манай Түнхэл тосгон засаг захиргааны нэгжийн хувьд Сэлэнгэ аймгийн Мандал сумд харьяалагддаг. Гэтэл Мандал сум руу 45км орчим ойролцоогоор маш ийм off road замтай байдаг. Би нэг зүйл боддог нь хүн ямар нэгэн гэмтэл, бэртэл аваад Улаанбаатар хүртэл 120 хэдэн километр. тэгэнгүүт гэмтэл, бэртэл авсан тохиолдолд тэр гэмтэл бэртэлтэйгээ шууд Гэмтлийн эмнэлгийг зорихоос өөр аргагүй болдог.

Өөрөөр хэлбэл, Улаанбаатарт гэмтэл осолд орсон хүний хүнтэй харьцуулах юм бол маш урт хугацааг туулж тэнд очдог. Жирэмсэн эх хэрвээ төрөх болох юм бол, гэнэтийн төрөх тохиолдол гарах юм бол төрөх харьяаллаараа Мандал сум руу явдаг нөгөө ийм аймаар замаар чинь. Тэгэхээр ийм ийм асуудлыг бас аягүй ингэж хөдөө орон нутаг, хот гэхгүй ихэвчлэн хот, хотын том том нэгдсэн улсын нэгдсэн эмнэлгүүд дээрх л асуудлыг бид нар яриад байдаг. Гэтэл хөдөө орон нутгийн алслагдсан бүсийн энэ үйлчилгээг тэр болгон ярьдаггүй асуудлыг бас шигтгэж өгсөн нь их таатай байна.

Тэгээд энд ингэж байгаа хүн төвтэй, тэгш хүртээмжтэй тэгээд эрүүл мэндийн цахим шилжилт, шатлал хоорондын залгамж холбоо, гүйцэтгэлийн үнэлгээ гэсэн ийм товчхондоо ийм 4 агуулгыг маш сайн оруулсан юм байна. Тэгээд энэ дээр жишээлбэл хүмүүс өөрсдийнхөө өвчний асуудлыг шууд цахимаар буюу өөрийнхөө гар утсаар оруулаад тэрийгээ хянаж байх боломжтой, эмнэлгийн цагийг бас тэрүүгээрээ хянаж байх боломжтой болно гэж ойлгож болох уу энэ хуулиар?

С.Бямбацогт: Ганмаа гишүүн хариулъя.

Д.Ганмаа: Тийм яг зөв. Эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсэг 6 бүрэлдэхүүн хэсэг байдаг тэр тогтолцооны хүрээн дээр. Энэ 6 тогтолцооны бүрэлдэхүүн хэсгийн чинь нэг том багана яг мэдээллийн сан байхгүй юу. Тэр мэдээллийн сан нь өөрөө яг эрүүл мэндийн энэ нэгдмэл тусламж, үйлчилгээг хүргэх, мэдээллийг солилцох, мэдээллийг хадгалах, өвчтөний буюу эмчлүүлэгчийн цахим мэдээлэл түүхийг тэнд хадгалах. Тэгснээрээ өвчтөн 6 жилийн өмнө жишээлбэл үзүүлж харууллаа гэхэд тухайн үед тэр хүний цусны шинжилгээ, цусан дахь сахар нь хэд байсан юм, даралт нь хэд байсан юм, ямар ямар шинжилгээ өгсөн юм, ямар эм уусан чинь тэр нь таарсан уу, таараагүй юу, ямар эмч дээр очсон, тухайн үед авхуулсан зураг ч юм уу, цээжний зураг нь ямар байсан гэх мэтчилэн энэ мэдээллийг жил, хэдэн жилийн дараа ч гэсэн энэ мэдээллээ сайжирсан уу, муужирсан уу, аль эм нь илүү зохисон гэх мэтийн бүх мэдээлэл нь тэр чигээрээ тэр хүнд хадгалагдана гэсэн үг. Та мэдээж гадаадад үзүүлж харуулж байсан тийм туршлага байгаа манай гишүүдэд. Эдгээр хүмүүс бас гадагшаа энэ тусламж, үйлчилгээ авахад яг ийм эмчлүүлэгчдийн портал бэлэн бий болдог. Тэгснээрээ үүх түүхээ хадгалах энэ бүрэн боломж.

Дээрээс нь тэр мэдээллээ ашиглах, цаг цааш нь аль эмчид, аль эрүүл мэндийн байгууллагад өгөх вэ? Тэгснээрээ эрүүл мэндийн байгууллагууд нь энэ мэдээллийг нэгтгэж, хадгалж, мэдээлэл солилцож, шатлал хооронд, шатлал дунд энэ зохицуулалтуудыг хийж, тэгснээрээ дараа дараагийн шинжилгээ давтахгүй байх, эмчилгээг зөв зохистойгоор хэрэглэх. Тэрийг нь яваандаа бүр том байдлаараа дата нэгтгэгдэж яг бодлогод суурилсан шийдвэр гаргах энэ том нөхцөлийг нь бүрдүүлэх.

Тэгснээрээ бид нар ерөөсөө мэдээллийн маш том нэгдмэл системийг бий болгож, иргэддээ ч, хүндээ ч, эрүүл мэндийн байгууллагадаа ч, тогтолцоондоо ч, тэр байтугай улсдаа ч хэрэгтэй үр ашигтай ийм л зам руу явж байгаа гэсэн үг.

Таны ярьсан тэр Мандал сумын эмнэлэг бас алсын эх барих эмэгтэйчүүд дээр та бас маш зөв зүйтэй л юм хэлж байна л даа. Хөдөө орон нутагт явахад яг энийг ярьдаг. Манайх багийн эмчийн сургалт байж байгаад болиулчихсан байсныг буцаж энэ хууль талаараа сэргээж байгаа.

Дээрээс нь анхдагч, хоёрдогч, гуравдагч шатлал дээрээ сум дундын эмнэлгээ нэмж оруулж ирж байгаа. Тэгснээрээ энэ ээж нарыг, төрөх гэж байгаа ээж нарыг ч бай эсвэл ойр зуурын бэртэл, гэмтэл авсан хүмүүсийг хаа хамаагүй хол тээвэрлэж явах энэ асуудлуудыг бас шийдэгдэх энэ боломжийн зохицуулалтуудыг нь гаргаж өгч байгаа юм.

С.Бямбацогт: Баярлалаа. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Оройн мэндийг хүргэе. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дэмжиж байна. Манай бас Ганмаа гишүүний хувьд бас энэ чиглэлээр нэлээн бас олон улсын туршлагыг бас нэвтрүүлж байгаа гэж бас ойлгож байгаа. Тэгээд тодруулах ерөнхий яах вэ хуулийн бид нарын энэ эрүүл мэндийн салбарын хөгжил бол харьцуулшгүй түвшинд л байна л даа. Бусад улсуудын явж байгаа энэ загвар юмнуудыг ингээд

харахад бол их тийм өөр түвшинд орчихсон. Ал тэр цахим шилжилт өөрийн тань яриад байгаа энэ тодорхой бас тухайн өвчтөний тэр түүхийг өвчний түүхийг бол бүрэн судлаад өөрт нь зориулж, бүүр зөвлөгөө гаргаад өгдөг юм нь бүүр шал өөр түвшинд оччихсон.

Бидний хувьд бол бас яг бодит байдал бас их тийм өөр ийм түвшинд бас байна л даа. Тэгэхээр ирээдүйгээ харсан 1 асуулт, яг одоо байгаа нөхцөлтэйгөө холбосон 1 асуултыг асууя гэж бодож байна.

Энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийн асуудлыг яг яг бүр тодорхой та хэлээд өгөөч ээ. Гэрээсээ гараад 3 алхаад орж байгаа эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа хүн, бараг багадаа 30, 40км тэгээд бараг 100-аад километр явж байж, бүүр бүүр хүндрэх юм бол 2, 300км явж байж эмчилгээ авч байгаа хүмүүсийн хоорондын энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч байгаа ийм хүртээмжийн асуудлыг бол бүүр тэнгэр, газар шиг байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг энэ малчдын асуудал дээр, алс хязгаар нутагт байгаа хүмүүс дээр үндсэндээ бол бид нар бол уул нь бол нөгөө эрүүл мэндийн үйлчилгээгээ тухайн багт нь, тухайн сумд нь, аймагт нь бий болгох ийм концепц руу яваад байгаа юм шиг боловчиг буцаагаад архаг хууч өвчнөөсөө авхуулаад тэр орон нутагтаа үздэг байсан өвчнүүдийг нь нааш нь татах зарчмаар төвлөрүүлэх ийм бодлого руугаа явуулаад л ингээд л ухраад байгаа юм.

Тэгээд яг орон нутгийн нөхцөл байдал дээр ингээд очоод харахаар сум дундын эмнэлэг, сумын эмнэлгүүд бол өөрсдөө бүрэн хүчин чадлаараа ажиллах бол бололцоонууд байгаад байгаа юм. Тэгэхээр иймэрхүү яг энэ бодит байдлыг харсан тодорхой ийм өөрчлөлтүүд энэ хуулийн хүрээнд яаж орж ирэх вэ? Ийм зөрүүтэй байгаа эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа хүмүүсийн хувьд бол бас яаж бид нар үйлчилгээг нь сайжруулж болох вэ? Зөвхөн малчдаас гадна оюутан, залуучуудын асуудал, нийгмийн бүлгийн асуудлууд гээд ингээд энэ бүлгүүд дээр нь та тодорхой хэлээч гэдгийг. Энэ бол илүү ирээдүйг бол бид нар яах ёстой юм бэ гэдгийг би бас Солонгосын энэ ... гэж ийм байгууллага байна. Дахиад дээрээс нь энэ тодорхой энэ эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаагаа энэ хиймэл оюун ухаанд суурилж шийдвэр гаргах байдлаар оновчилж байгаа ийм бас загвар системүүд байна.

Тэгэхээр хэрвээ бид нар энэ рүү шилжих гэж байгаа бол шинэ системийг бид нар бий болгох тухай ярьж байна уу, эс үгүй бол олон улсын энэ загваруудыг бид нар авчирч нутагшуулах тухай ярьж байна уу? Яг хэрэгжүүлэх хүний нөөц, бүтэц зохион байгуулалт энэ рүү хийх зүйл дээр бас үнэхээрийн бэлэн зүйлүүд бас байна уу? Хийх ёстой юу гэвэл хийх ёстой. Төсөв, санхүү болон түүнтэй холбогдолтой юмнуудыг нь нарийн тооцсон зүйлүүд бол байна уу гээд. Ингээд нэлээн нарийн зүйлүүдийг бас асуумаар байна аа. Тэгээд харьцуулшгүй ийм хөгжлийн хувьд зөрүүтэй байгаа энэ нөхцөл байдал маань ойртоосой. Энэ хуулийн хэрэгжилтийн хүрээнд бас яг өнөөдөр тулгамдаж байгаа асуудлуудаа бас шийдээсэй, мөн ирээдүйд бас сууриар нь энэ асуудлыг шийдэж болох энэ өөрчлөлтүүдийг бас агуулаасай гэсэн үүднээс ийм 2 асуултыг асууя.

С.Бямбацогт: Ганмаа гишүүн хариулах уу? Даваасамбуугийн Ганмаа .

Д.Ганмаа: Үнэн манай Монгол Улс өөрөө их онцлог орон юм л даа. Бусад улс оронтой харьцуулахад алслагдмал орон нутагтай, малчидтай, ихэнх нь Улаанбаатартаа буюу нийслэлдээ амьдардаг. Энэнээс хамаараад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, тэр тусмаа эмнэлгийн тусламж, үйлчилгээг манай хууль чинь эмнэлгийн тусламж, үйлчилгээ шүү дээ. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүргэх загвар нь үнэхээр өөрийн онцлогтой тохирсон байх ёстой юм.

Наад захын жишээ гэхэд л бид нар анх анхан шат, хоёрдогч, гуравдагч шатлалынхаа тогтолцоог юу 2 шатлал болгоод тухайн үедээ тийм олон улсын загвар урт ерөнхийдөө тааруулж бас хийсэн юм байна лээ л дээ. Яагаад гэхээр анхдагч буюу primary care, тэгээд лавлагаа, шатлал буюу specialized Care гэдэг ийм 2 л юм олон улсад явдаг. Тэрүүгээр нь хэрэгжүүлэх, тэрийг өөрчилж хийх гэж бас хийх гэж оролдсон. Оролдсон юу яах вэ хийж хэрэгжүүлж явсан. Яг үнэндээ манай Монгол шиг ийм онцлогтой улс оронд бол бид нарт илүү тэр нөгөө 3 шатлалаараа тусламж, үйлчилгээ үзүүлэх нь илүү зохимжтой байгаад байгаа юм.

Ялангуяа таны асуугаад байгаа тэр хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим гэдэг зарчим байж байх байхгүй юу. Universal health бүх нийтийг эрүүл мэндэд хамруулах гэдэг зарчим. Энэ нь 2022 онд ялангуяа тэр КОВИД-ын цар тахлаас хойш нөгөө хөгжингүй орон ч бас юу гэдэг юм харьцангуй эдийн засгийн чадалтай орон ч гэсэн бүгд маш том хохирол амсаж ер нь хиарсан гэж хэлэхэд болно.

Тийм учраас бодлого зохицуулалтуудын маш том шийдвэр гаргагч нарыг дэлхийн эрүүл мэндийн байгууллагуудын судлаачид төлөөлөгч нар 2022-т хамтарсан хуралдаан хийж, ерөөсөө эдгээр тусламж, үйлчилгээг хүргэхэд бид нар зайлшгүй анхан шатлалын тусламж, үйлчилгээг л бэхжүүлэх ёстой юм байна. Анхан шатын тусламж, үйлчилгээгээ бэхжүүлээд тэрэнд нь тусламж, үйлчилгээг хүргэх санхүүжилтийн хөшүүргийг нь сайн тавиад өгсөн тохиолдолд бид нар ерөөсөө энэ таны саяын ярьсан шиг алслагдмал ч юм уу, эсвэл хол амьдардаг, эсвэл ямар нэгэн байдлаар тэгш бус хүмүүст хамгийн сайн, хамгийн найдвартай, хамгийн боломжийн тусламж, үйлчилгээг хүргэж хамгийн гол нь хүндрүүлэхгүй, өвчлөлийг даамжруулахгүйгээр аль болохоор боломжийн буюу харьцангуй эрүүл түвшинд нь барих энэ бололцоо нь тохирох юм байна аа гэсэн үндсэн дээр. Тэгээд яг тэр загварын үндсэн дээр манай хуулийн энэ зохицуулалт орж ирж байгаа юм.

Тэгээд Монгол улс энэ загварт бас тохирсон өөрийн гэсэн дэд бүтэц нь харьцангуй сайн хөгжихсөн байгаа байхгүй юу. Бид нарт бараг сум болгонд эмнэлэгтэй, багийн эмч нартай. Багийн эмч нарыг бэлддэг байсан энэ тогтолцоо байхгүй болсныг буцаж энэ сууриараа бид нар сэргээн гаргаж ирж байгаа юм.

Тэгснээрээ 2 жилийн өмнө бид нар маш багийн эмч нарын бүх юу гэдэг юм улс.../минут дуусав./

С.Бямбацогт: Ажлын хэсгээс нэмээд. Ганхүлэг гишүүн тодруулж асууя. Тэгээд нэмээд хариулчихъя. Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Орын тоогоороо, яг үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлгийн тоогоороо энэ тэр бол бас бусад улстай харьцуулахад бол нэлээн өндөр гэж би бас ойлгосон. Хангалттай бас дэд бүтэц юмнууд бас байгаа гэж ойлгосон. Гол асуудал нь бас энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тодорхой бас хэсгийг

илүү бас эдийн засагжуулах, төлбөрийн тэр бас уян хатан зохицуулалтуудыг оруулж ирэх асуудлууд бас байх шиг байна. Иргэдийн хувьд бол бүх үйлчилгээгээ заавал үнэ төлбөргүй авна гэхээсээ илүүтэй илүү ийм чанартай, хариуцлагатайгаар үндсэндээ эрүүл мэндийн үйлчилгээ авдаг ийм бай тал руу, зардлаа хуваах тал руу бас зохицуулалтууд бол бусад улсууд бол хийж энэ асуудлаа бол шийдсэн байгаа юм.

Ялангуяа Эрүүл мэндийн даатгалын заавал үндсэндээ үзүүлэх, үйлчилгээ үнэгүй үзүүлэх үйлчилгээнүүдээс гадна өөрөө нэмэлт сонголтоор тодорхой үйлчилгээнүүдээ, өвдөх магадлалтай бас үйлчилгээнүүдээ бас сонголтоор урьдчилж даатгал.../минут дуусав./

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Хэн хариулах вэ? Баярцэцэг Улсын Их Хурлын гишүүний зөвлөх. 4 дүгээр микрофон.

Л.Баярцэцэг: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр эрүүл мэндийн бодлогын хүрээнд тусламж, үйлчилгээний хүртээмжийг ер нь үндсэндээ 4 хэмжээсний хүрээнд авч үзэж байгаа.

Нэгдүгээрт тэр эмнэлгийн тусламжийг газар зүйн байршлын хувьд тухайн иргэн авах боломж нь ямар байна.

Хоёрдугаарт хувь хүний өөрийнх нь онцлог хэрэгцээ, шаардлага нь яг нийцсэн тэр хүртээмж нь бий байна уу.

Гуравдугаарт өөрийнх нь яг тэр сонголтод тохирсон тэр тусламж, үйлчилгээ бэлэн байна уу.

Дөрөвдүгээрт тэр хүний хувьд санхүүгийн хувьд тэр нь боломжтой байна уу гэсэн энэ 4 хэмжээсний хүрээнд хүртээмжийг авч үзэж байгаа. Тэгэхээр бид нар хэрвээ эрүүл мэндийн бодлогын хүрээнд өнөөдрийн одоо байгаа эрх зүйн зохицуулалтын хүрээнд бид ер нь энэ хүртээмжийн асуудлыг энэ 4 хэмжээсний хүрээнд эрх зүйн хувьд зохицуулж байгаагүй.

Тэгэхээр энэ эмнэлгийн тусламж, үйлчилгээний шинэчилсэн найруулгад бол анх удаа бол энэ эрүүл мэндийн бодлогын хүрээнд яг хүртээмж гэж яг юу хэлэх юм? Тэр нь ялангуяа Монгол улсын онцлогийн хувьд өнөөдөр тархай бутархай, хүн ам нь нэлээн тарч бутарч байрладаг, дээрээс нь нүүдэл нүүдэлчин ахуй соёлтой.../минут дуусав./

С.Бямбацогт: Хариултаа жоохон тодорхой болгож. Дахиад тодруулчихъя Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Одоо бүүр ингээд танин мэдэхүйн юм руу хэдүүлээ орж болохгүй ээ. Миний асуугаад байгаа асуулт нь бол яг яаж тодорхой шийдэх гээд байгаа юм бэ гэдэг ийм жишээ хүсээд байна л даа . Олгож байгаа угаасаа ингээд үйлчилгээ авахад хол, хэцүү байгаа, дэд бүтэц сайн байгаа юм байна.

Тэгэхээр яг энэ дээр яг нөгөө энэ хууль батлагдсанаараа хотын иргэд болон малчдын хувьд бол яаж хүртээмжийн асуудал нь илүү ижил түвшинд очно гэж та бүхэн маань хараад байгаа юм бэ гэдэг.

Хоёр дахь нь болохоор тэр төлбөр мөнгөтэй холбогдолтой, энэ үйлчилгээг үзүүлэхтэй холбогдолтой асуудлыг бүгдийг нь үнэгүй гэдэг ийм концепцоос илүү зардлаа хуваах ийм агуулга байна уу? Байвал яаж үндсэндээ зохицуулж байгаа вэ гэдэг ийм яг тодорхой асуулт асуугаад байгаа юм. Тэгэхээр танин мэдэхүйн биш энэ хууль дээр иймд ингэж заагаад ингэж шийднэ гэдэг ийм хариулт хэлээч ээ.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Ганмаа гишүүн хариулъя.

Д.Ганмаа: Эрүүл мэндийн даатгалын тухай хууль гээд эрүүл мэндийн санхүүжилтийг зохицуулж байгаа хууль байгаа юм. Тэр хууль дээр бол яг санхүүжилтийн хэлбэрийг хамтын төлбөрөө нэмэх үү, хасах уу, ямар байдлаар зохицуулах вэ, орлогоо яаж нэмэгдүүлэх вэ, зарлагаа яах вэ гээд бүүр тодорхойлон тусгайлсан заасан. Энийг бол Отгонбаяр гишүүний ахалсан ажлын хэсэг санал, дүгнэлтээ гаргаад явж байгаа.

Манай хуулийн хүрээнд бол санхүүжилт рүү орох боломжгүй, хүрээ давхардуулж болохгүй. Бид нар эхнээсээ тэгэхгүйн тулд энэ хуулийнхаа хүрээг маш тодорхой зааж Веннийн диаграммаар тусгаарласан юм. Тэгэхдээ бид нар энэ хуулийнхаа яг амь оруулахын тулд ялангуяа тэр таны асуугаад байгаа алслагдмал хөдөө орон нутагт тусламж, үйлчилгээг анхан шатлалын зайлшгүй шаардлагатай тусламж, үйлчилгээг хүргэхийн тулд яах вэ гэдгийг төлбөрийн аргуудыг тодорхойлж оруулж өгсөн.

Ер нь бол 2016 оны хуульд ч гэсэн төлбөрийн аргууд орсон байсан юм байна лээ. Тэр дээр бид нар бүр яг.../минут дуусав./

С.Бямбацогт: Хосбаяр гишүүн асуултаа асууя.

Г.Хосбаяр: Энэ хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг бол дэмжиж байгаа. Өнөөдөр Монгол бол онцлогтой орон. Өргөн уудам газар нутагтай, хүн ам бас тархуу суурьшсан, бас энэ өвөл, зун болдог гээд энэ улирлын хамааралтай зэрэг ийм маш онцлог ийм бүс нутаг. Тийм учраас энэ аливаа асуудлыг бас нэлээн энэ улс орныхоо нөхцөл байдал, хөдөө орон нутгийн нөхцөл байдлыг маш сайн судалж хийх ёстой гэж ингэж боддог.

Тэгээд энэ хуулийн төслөөр анхдагч болон хоёрдогч, гуравдагч энэ шатлалын эмнэлэг энэ үүргийг тодорхой болгож байгаа, мөн шатлал хоорондын уялдаа холбоог сайжруулж байгаа гэж үзэж байгаа. Тэгэхээр зэрэг энэ ер нь бид нар чинь бас бүсчилсэн хөгжлийн тухай ярьж байгаа. Тэгэхээр бүсийн төвүүд дээр бас 3 дугаар шатлалын эмнэлэг байх тухай ярьж байгаа. Тэгээд яг бас энэ хуульд ер нь энэ бодлогын түвшинд энэ 3 дугаар шатлалын эмнэлгүүд энэ бүсийн төвүүд дээр байх боломжтой гэж харж байгаа юу?

Мөн хөдөө орон нутагт жишээлбэл, сумын төв дээр хүмүүс ер нь төрөхөө больсон гэж байна л даа. Дандаа аймгийн төв рүү яваад төрдөг болчихсон. Бараг хөдөө сумуудын бараг төрж байгаа хүмүүсийн 99 хувь нь аймгийн төв дээрээ очиж

төрж байна. Тэгээд уг нь бол хуулийн төсөл санаачлагчийн ч тэр манай Эрүүл мэндийн яамныхны хэлж байгаагаар хөдөө орон нутагт бол энэ материаллаг бааз, тоног төхөөрөмж боловсон хүчин бүх зүйлээр хангагдсан гэж үзэж байгаа. Хангагдсан гэдэг мэдээллийг өгч байгаа.

Тэгэхээр ер нь энэ хууль шинэчилсэн найруулга гарснаар энэ хөдөө орон нутагт яг иргэд нь тэр анхан шатдаа 1, 2 дугаар шатлал дээрээ эмнэлгийн тусламж, үйлчилгээгээ бүрэн авах тийм боломж нөхцөлийг илүү сайжруулж өгөх үү?

Мөн энэ хуулийн төсөл 27 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлнэ гэж байна. Тэгэхээр 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлснээр удахгүй бид нар чинь бас улсын төсвөө ярьж эхэлнэ. 27 оны төсөв батална. Тэгэхээр энэ хууль 27 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлснээр улсын төсөв дээр зардал нэмэгдэх үү, эсвэл хасагдах уу, эдийн засгийн ер нь үр ашиг гарах уу, ер нь яг эдийн засгийн тооцоо судалгаа юмыг бас энэ бодит нөхцөл байдалд тааруулж хийсэн үү гэдэг ийм 2 зүйлийг асууя.

Ер нь Эрүүл мэндийн яамныхан ч гэсэндээ тэр суман дээр анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхцөл байдал одоо ямар байгаа юм? Тэр ер нь хөдөө орон нутагт нэлэнхийдээ тийм төрөлт дандаа аймгийн төв суурин руу шилжээд байгаа дээр ямар бас бодлого баримталж байгаа юм? Энэ талаар бас хэлбэл сайн байна. Тэгэхгүй бол эх аймагт очиж төрснөөр тэр эхийг дагаад л хүмүүс явж байна. Нөхөр нь ч юм уу, гэр бүлийнхэн нь. Дахиад л сумаасаа аймаг хүртэлх ирж очих зардал, аймаг дээр очоод байрлах зэргээр ингээд бас олон зүйлүүд гарч байна. Тэгэхээр энэ маань үнэхээр хүмүүс өөрсдөө хүсээд яваад аймаг, төв суурин газарт төрж байна уу, эсвэл сумын эмнэлэг, эсвэл тэр үнэхээр сумын эмнэлэг нь явуулаад байна уу, эсвэл үнэхээр тэр сумд тийм хүн төрүүлэх боломж байхгүй байгаа юм уу? Энэ тал дээр бас хариулт өгөөч гэж.

С.Бямбацогт: Ганмаа гишүүн хариулъя. Ажлын хэсгээс нэмж хариулт.

Д.Ганмаа: Би хуулийнхаа талаас тайлбарлая. Одоо байгаа бодит нөхцөл байдлыг бас асуугаад байна. Тэгэхлээр яамнаас тэрийгээ асуугаад байна тээ? Бид нар, тийм таны асууж байгаа зөв л дөө. Бүсчилсэн хөгжил гэж хэсэг ярьсан бид хэд их нэлээн. Тэгэнгүүтээ төвлөрлийг сааруулъя гээд эргүүлээд бас буцаасан ч байдлаар гэх үү дээ тэрийг чинь хийж үзсэн. Төрөлтийг ерөөсөө сумуудад түрүүлэхээ больё гэж ярьсан. Тэгээд бүгдийг нь аймаг руу татсан. Тэгснээ хот руу бас мэдээж эрсдэлтэй, хүндрэлтэй төрөлтүүдийг бол мэдээж хот руугаа татаж байгаа юм.

Тэгэхдээ яг ингээд малчидтай уулзаад хөдөө орон нутгаар явахаар зэрэг ер нь аймаг руугаа яваад л, эсвэл хот руу очиж төрөөд байхад өөрсдийнх нь эдийн засгийн хувьд ч гэр оронтой ойрхон баймаар байдаг, эргэлтээ авмаар байдаг. Тэгээд хотод очихоороо айлд юм уу, зочид буудалд байрлаад л гээд л асуудлууд зөндөө байдаг юм байна лээ.

Тэгэхлээр бид нарын энэ хуульд зохицуулах гол зүйлд маань хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ гэдэг эмийг л ерөөсөө өвчлөл, нас баралт, архаг өвчний тархалт, нийгэм эдийн засгийн нөхцөл, газар зүйн байршил, тэгээд тусламж,

үйлчилгээний хүний нөөцийн чадавхтайгаа уялдуулж байнга хийж байна. Тэрэндээ тодорхойлсон тусламж, үйлчилгээг хийнэ л гэж заагаад байгаа зохицуулалт юм.

Мэдээж эрсдэлгүй, аюулгүй, боломжийн төрөлтүүдийг бол аль болохоор гэрт нь ойрхон үзүүлэх, боломжийн өвчлөлүүдийг ерөөсөө анхан шатад нь буюу түрүүний ярьсан сум, тосгоны эрүүл мэндийн төвд нь. Бүүр болохгүй бол сум дундын эмнэлэгт нь. Аль болохоор боломжтой тусламж, үйлчилгээг авахаар л ингэж зааж зохицуулалтыг нь оруулж байгаа юм.

Мэдээж эдийн засгийн тооцооллуудыг хийсэн. Эдийн засгийн тооцооллын хувьд бид нарт ерөөсөө шинээр ямар нэгэн юу гэдэг юм байгууллага байгуулах, хүмүүсийг бий болгох, илүү зардал огт гаргахгүйгээр харин ч одоо байгаа зардлаа үр ашигтай, үр дүнтэй хэрэглэх бүх зүйл, заалтууд тэр техникийн үнэлгээнүүдийг нь оруулж өгч байгаа юм. Тэгж байж бид нар энэ сангийн тэнцлийн асуудлуудаа аятайхан сэргээх, эргээд хүндээ ч гэсэн манайх нөгөө out-of-pocket гэж ярьдаг. Халааснаас нь гарч байгаа зардал 40 гаруй хувь руугаа явчхаад байгаа юм. Уул нь 25 хувь дээр барьж байж эмнэлгийн тусламж, үйлчилгээ иргэддээ ээлтэй байна гэж үздэг байхгүй юу.

Тийм болохоор энэ давхардсан шинжилгээ, үзлэг, эмчилгээ эдгээрийг бүгдийг нь байхгүй болгож байж энэ асуудал шийдэгдэх юм. Бид нар яах вэ 9 тэрбум тэр төгрөг нэмэгдэж байгаа яг энэ тусламж, үйлчилгээний шинэ хууль маань батлагдаад хэрэгжингүүт. Энэ нь гол нь нөгөө эмнэлэг, тусламжийн нэгдмэл хүн төвтэй тогтолцоог бий болгох. Энийг зохицуулалтыг хэрэгжүүлэх байгууллага дээр 3 хүний ажлын буюу цалингийн байр нэмэгдэж байгаа. Тэгэхдээ энэ байгууллагын шинэ байгууллага биш, одоо ч гэсэн яг энэ үйл ажиллагааг ерөнхийдөө зохицуулалтуудыг хийдэг манай эрүүл мэндийн төв юм байгаа юм. Тэн дээрх үйл ажиллагаа.

Яамнаас саяын тэр бодит байдалтай асуудаг Наранпүрэв дарга.

С.Бямбацогт: Эрүүл мэндийн яам 4 дүгээр микрофон. Ажлын хэсэг.

М.Наранпүрэв: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яам Эмнэлгийн тусламжийн бодлогын эрсдэлийн газар Наранпүрэв байна. Сумын эрүүл мэндийн төв нийт 307 сумын эмнэлгүүд байгаа. 6 сум дундын эмнэлэг. Сум дундын эмнэлгүүд дээр бол төрөх, эх барихын тусламжийг үзүүлж байгаа. Сумын эмнэлэг дээр үзүүлж өгөхгүй байгаа бас шалтгаан байгаа нэгдүгээрт манайд нийт төрөлтийн тоо буурсан. Анхан шатын эрүүл мэндийн байгууллагууд дээр бол төрөх эх барихын хяналтыг нэгдүгээрт нь хийж байгаа. Төрсний дараах хяналтууд хийгдэж байгаа. Гол шалтгаан нь бол хүний нөөцийн асуудал.

Өөрөөр хэлбэл, төрөх, эх барихтай холбоотой эх барихын тусламж асуудал байна. Эх баригч эмч. Анхан шатын эрүүл мэндийн байгууллагууд дээр ажиллаж байгаа анхан шатын эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийн тоо болон чадавх ялангуяа эх барихын өмчийн хүрэлцээ бас хангалтгүй байгаатай холбоотой. Эхийн эндэгдэл гарах магадлалтай учраас нэгдүгээрт цөөрч байгаа эхийн төрөлтүүдийг төвийн бүсүүд дээр бол төрүүлэх, хяналтуудыг бол.../минут дуусав./

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя 4 дүгээр микрофон.

М.Наранпүрэв: Төрөлтийг бол анхан, төрөлтийн хяналт болон төрөх хүртэлх жирэмсний хяналт, төрсний дараах нярайн болон эхийн хяналтыг бол анхан шатын эрүүл мэндийн байгууллага дээр хийх, төрөх процесс хэвийн төрөлтүүд болон сум дундын эмнэлэг дээр хэвийн төрөлтүүдийг хийхээр ингээд байгаа.

Өнөөдрийн нөхцөл байдал ялангуяа алслагдсан сумууд дээр бол хэвийн төрөлтүүд зарим аймгууд дээр эх баригчтай болон эх барихын эмчтэй газрууд дээр бол төрөлтүүд бол бас их мөн хийгдэж байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Бадарчийн Хэрлэн гишүүн асуултаа асууя. Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, дэмжээгүй байр суурьтай гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үгээ хэлнэ үү. Таныг оруулахгүй гэнэ ээ. Отгоны Саранчулуун гишүүн. Дараад нь хийчихнэ. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Баярлалаа. Юуны өмнө энэхүү хуулийг дэмжиж байна. Яагаад гэхлээр өнөөдөр Монголд эрүүл мэндийн салбарт хийгдэх ёстой зайлшгүй олон алхамтай өөрчлөлтүүдийн хамгийн эхний хэсэг бол эрүүл мэндийн статистик, дата мэдээллүүд байдаг. Хэрвээ бид нар яг хэмжиж чадвал нөгөө удирдаж чадна гэдэг шиг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахыг бид нар орны тоо, эмнэлгийн барилгаар хэмжихээсээ илүү яг хүний хэрэгцээнд нь тулгуурласан мэдээллийг цуглуулж байж эрүүл мэндийн үйлчилгээг дахин төлүүлэх боломжтой болох юм байгаа юм.

Энийг жишээ аваад үзвэл юу вэ гэхлээр бид нар өмнө жилүүдэд бас ярьж байсан хүнд өвчин эмгэг туссаны дараа, хагалгааны дараах хаачих вэ гэдэг асуудал байгаа. Бид нар фэйсбүүк дээр харах юм бол маш олон мэс заслын дараах яах вэ, хаачих вэ гэдэг ийм асуултуудаар дүүрэн ийм фэйсбүүкийн группүүд байгаа. Хамгийн энгийн жишээ сахартай хүмүүсийн групп, бөөрний өвчтэй хүмүүсийн групп, зүрх судасны өвчтэй хүмүүсийн групп, харвалтын дараа хаачих вэ гээд ийм группүүд байгаа. Тэр группүүд бие биеэсээ маш олон зүйлүүдийг асуудаг. Ямар эм уух юм, ямар дэглэм барих юм, ямар эмчилгээ хийлгэх вэ, хаана очих вэ, ямар сувилал нь сайн байх вэ гэх мэтчилэн.

Тэгэхээр энэ болгонд яагаад ийм олон асуултууд үүсгээд тэн дээр нь мэргэжлийн бус зарим хүмүүс орж ирж зөвлөгөө өгдөг. Заримдаа бүр буруу эм ууж ингэж улам эрүүл мэндээ дордуулаад эргээд эцсийн дүнд нь өвчин нь хүндрээд эмнэлэг дээр ирдэг ийм тохиолдол зөндөө байгаа. Тэгэхээр энэхүү хуулийн төслийн шинэчлэл, энэхүү өөрчлөлтүүдийг хийгдсэнээрээ нэг шинэ зохицуулалтыг оруулах боломжтой гэж ярьж байгаа нь бол юу вэ гэхээр эмнэлэг дээр буюу лавлагаа шатын эмнэлгийн дараа ч юм уу тэр сэргээн засалтын асуудлуудыг хөндөж өгч байгаа.

1 хүн өвдөөд эмнэлэгт үйлчилгээ авсан бол эргээд хөл дээрээ босох хүртэл тогтолцоог энэ дээр тусгаж өгсөн байгаа. Энэ нь яаж тусгасан бэ гэхлээр нөгөө судалгааны хэсэгт нь оруулсан гэдэг утгаараа өвчилсний дараа хаачих вэ гэдэг асуудлуудыг эмнэлгийн зүгээс өгөх заавар, тэнд нь зөвхөн эмчийн оролцоо биш, сувилагч биш давхар сэргээн засахын мэргэжилтэн, нөгөө сэтгэл зүй, нөгөө хөдөлгөөн засал зэрэг бусад дэмжих мэргэжилтнүүдийн оролцоог судалгаагаараа, хэрэгцээгээрээ гараад ирэх учраас дэмжиж байгаа гэж ингэж үзэж байгаа.

Тийм учраас энэ нь өөрөө эмнэлэгт дахин хэвтэх, дахиж хүндрэх асуудлууд буурна. Дээрээс нь ер нь хувь хүний өөрийн бас өвчний дараа эргэж өөрийгөө хөл дээрээ босгох тэр хариуцлага бас нэмэгдэх ийм боломжуудыг бий болгож байгаа гэдэг утгаараа маш ач холбогдолтой маш шинэлэг ийм хууль болно гэж бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуултаа асууя.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Ганмаа гишүүний ахлан өргөн барьсан Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дэмжиж байна. Засгийн газар, яам, агентлаг, төрийн байгууллагууд тэр дундаа эрүүл мэндийн байгууллагууд маань иргэдийн, аж ахуйн нэгжийн, татвар төлөгчдийн төлсөн мөнгийг үр дүнтэй зарцуулах үүрэгтэй.

Үүний тулд бид нар зарцуулсан төгрөг бүрийн үр дүнг зөв хэмжиж, дүгнэж, алдаа байвал засаад сайжруулаад явах ёстой. Эрүүл мэндийн салбарын хувьд төсөв хэлэлцэх, хөгжлийн төлөвлөгөө батлах үеэр Ганмаа гишүүн мэргэжлийн хүний хувьд, салбарын төлөөллийн хувьд салбарын үр дүнг оновчтой хэмжих шалгуур үзүүлэлтүүдээр Засгийн газар болон яамны ажлыг сайжруулах тал дээр нэлээн манлайлалтай ажилласан гэдгийг дурдах нь зүйтэй болов уу.

Салбаруудын хуулиудын дундаас эрүүл мэндийн салбарын байгууллагуудын үр дүнг тодорхой хэмждэг болох, хамгийн гол нь гүйцэтгэлийг, хүрсэн үр дүнг хариуцлагатай уялдуулах тогтолцооны том өөрчлөлтийг оруулахыг зорьсон хууль байна гэж харж байна. Өнөөдөр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, чанартай болгохын тулд энэ ажлын үр дүнг үргэлжилсэн үгээр тайлагнадаг бус бодитой, хэмжигдэхүйц, шинжлэх ухаанд үндэслэсэн тоон утгаа л илэрхийлдэг болох хэрэгтэй байгаа.

Энэ хуулийн төслөөр эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг анх удаагаа оновчтой тодорхойлж, хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох үндэс суурийг нь тавьж байна гэж ойлгож байна. Энэхүү бодлогын том өөрчлөлтийг дэмжиж байгаа бөгөөд бусад гишүүдийгээ ч бас дэмжихийг уриалж байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Буланы Бейсен гишүүн үгээ хэлье. 2 дугаар микрофон.

Б.Бейсен: Гишүүддээ болон ажлын хэсгийнхний эмнэлгийн салбарын удирдлагууддаа оройн мэнд хүргэе. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай

хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг дэмжиж байгаа. Яагаад гэвэл маш чухал хууль.

Тэгэхдээ бас учир дутагдалтай юм бас байна. Энийг бас Ганмаа гишүүн энийг бас цаашдаа, эцсийн юун дээр нь сайн яахгүй бол бас болохгүй асуудлууд байж байна. Хамгийн гол нь анхан шатны тусламж үйлчилгээ, сум, баг, өрхийн эмнэлгүүдийн. Тэгээд 2 дугаар шатлалын нэгдсэн эмнэлгүүдийн тусламж, үйлчилгээ. 3 дахь нь хотын дунд нь бүсийн эмнэлгийн оношилгоо, эмчилгээний төв гээд байгаа. Хотын клиникийн эмнэлгүүдийн тусламж, үйлчилгээний бас нарийн мэргэжлийн эмнэлгүүд байж байгаа.

Одоогийн нөхцөл байдал дээр эмнэлгийн тусламж, үйлчилгээ үнэхээр хүнд байдалд байгаа. Ард иргэд тусламж, үйлчилгээ авч чадахгүй байгаа, ширгэж байгаа. 1-6 сар хүртэл очер дараалал хүлээж байгаа, эм нь байхгүй, гадагшаа явж байгаа. Энийг нуухын аргагүй үнэхээр. Тийм учраас энэ дээр бас эмнэлгийн удирдлагууд, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв бас дүгнэлт хийх хэрэгтэй. Заримынх нь нарийн мэргэжлийн эмч нар нь байхгүй. Хөдөө төгсөж очсон эмч нар нь нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлж чадахгүй, ард иргэдийг эрүүл мэндээр хохироодог асуудлууд байж байгаа.

Тийм учраас энэ сургалтын асуудал дээр онцгой анхаарахгүй бол болохгүй. Ялангуяа хөгжлийн төв шууд АШУИС-ийн манай энэ дээд сургуулийг төгсчхөөд шууд элсүүлэхийг болиод 1-2 жил клиник эмнэлэгт ажиллуулж байж нарийн мэргэжлийн эмчид сургах хэрэгтэй.

Нөгөө талаар сумууд дээр гэрээлсэн газарт нь очихоор юм хийхгүй бол төгсчхөөд очихгүй байгаа асуудлууд байж байгаа. Сумууд дээр хамгийн гол нь оношилгоо, эмчилгээ дээр анхаарах юм бол цусны ерөнхий шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ, хавдрын маркерууд, биохимийн шинжилгээ, зүрхний бичлэг, эхо рентген, нарийн мэргэжлийн аппарат тоног төхөөрөмж тавьсан мөртөө мэргэжилтэн байхгүй. Дагалдан сургахгүй. Орон тоон дээр ажилладаг мөртөө аппарат ажиллуулж чадахгүй асуудлууд байж байгаа. Эрүүл мэндийн яам энэ дээр дүгнэлт хийгээд ер нь шалгаад зарим хий хоосон аппаратаа бүтээж тавьчихаад цалин авч байгаа улсууд байж байгаа.

Би яг хөдөө сумуудаар явж байхад энэ хангасан мөртөө ажиллуулдаггүй, аймаг руугаа явуулдаг, аймгийн ачааллыг нэмэгдүүлдэг, аймгаасаа хот руу ирээд хотын клиник эмнэлгүүдийн ачааллыг хүндрүүлдэг асуудлууд байж байна. Одоо энэ хотын клиникийн эмнэлгүүдээр ирж байгаа улсуудын бараг 60 хувь нь хөдөөгийнхөн ирсэн. Хотын өвчтөнүүд үзүүлж чадахгүй ийм асуудлууд байж байна. Үйлчлүүлэгчид.

Ялангуяа энэ хотод ирж байгаа би эмч хүн учраас байнга яадаг хотын I, II, III дугаар эмнэлгийн удирдлагууддаа баярлалаа гэж хэлмээр байна. Хавдар судлал байна, гэмтлийнх байна, Эх, хүүхдийн эрүүл мэндийн төвийнхөн. Байнга шөнө залгасан ч утас авдаг, чирэгдүүлэхгүй шууд хэвтүүлдэг ийм асуудлууд байж байгаа. Энэ дотроос Төмөр-Очир даргыг бүр баярлалаа гэж хэлмээр байх юм. Харвалт ирнэ, зүрхний шигдээс ирнэ, шөнө ч гэсэн утсаа аваад хариулж байдаг.

Дараагийн нэг асуудал байж байна. Эмнэлгүүдийн өр зээлийн асуудал байж байна. Өглөг, авлагын асуудал. Сайд түрүүн өр, зээлээс саллаа гээд байх юм. Ер нь эмнэлгүүд чинь төсөвгүйгээр, байлдаанд ороход сумгүйгээр байлдаж чадахгүй биз дээ? Тэрэнтэй адилхан шүү дээ. Ийм компаниудын өр гээд ийм юм яриад байх юм. Тэгэхдээ эмнэлгийн удирдлага, төсвийн ерөнхий захирагч нарын алдаатай асуудал бас байж байгаа. Эмчилгээ эрхэлсэн орлогч нар тасгийн .../минут дуусав./

С.Бямбацогт: Үгээ дуусгачихъя даа.

Б.Бейсен: Тэгэхээр энэ эмнэлгийн бүтэц, орон тоог шинэчлэн тогтоох шаардлагатай байгаа. Энэ дээр ажлын хэсэг гаргахад би санал гаргачихсан байгаа. Тэгэхгүй бол илүү орон тоон дээр төсөв, илүү цалин, нийгмийн даатгалын шимтгэл явчхаад байна.

Хяналт шалгалтыг сайжруулаад бүсийн оношилгоо, энэ эмчилгээний төв гэдгийг болиод аймаг болгон оношилгооны төвтэй, ангиографийн аппараттай. Тэгээд MRI-тай болгохгүй бол бүсийн оношилгоонд Хэнтийнхэн цаашаагаа 400км Дорнод явахгүй шүү дээ. Цаашдаа хөгжихийн тулд аймаг болгон оношилгооны төвтэй. Байр нь бэлэн байж байдаг. Зарим тоног төхөөрөмжөө тавьсан тохиолдолд болно. Тэгээд хотын эмч нар тэнд очоод ажлын байрны сургалт хийх шаардлагатай юм байна. Тэгж байж энэ тусламж, үйлчилгээг сайжруулахгүй бол болохгүй. Бусад асуудлыг би бас Гамаа гишүүнд энэ бичгээр бас өгье. Энэ цаг нь багтахгүй байгаа юм шиг байна. Та бүхэнд баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн үгээ хэлнэ.

М.Нарантуяа-Нара: Дахин оройн мэнд хүргэе ээ. Тэгэхээр Гамаа гишүүний энэ хуулийн төсөлд маш чухал чухал зүйл дурдагдсан байгаа нь ялангуяа одоо бид нар энэ гар утсыг бол байнга атгаад явдаг. Тэгсэн мөртөө бид нар энэ өвчний түүх гээд баахан ийм цаастай ингээд л тийм ягаан дэвтэр, тийм ногоон дэвтэр гээд яг үнэнийг хэлэхэд тэд нарыг байнга авч явж чаддаггүй. Тэгээд гэнэтийн өвчин хууч, эс үгүй бол эмнэлэг орлоо гэхэд тэр болгоныг чирээд явахад сүүлдээ нөгөөдөх нь бүүр он удаан жил болсоор байгаад л навсайсан гээд л ийм цаас болчихдог. Тэгэхээр энийг хөнгөвчилнө гэдэг бол хамгийн чухал.

Дээрээс нь энэ цаасыг яагаад авч яваад байна гэхээр ихэнхдээ өвчний түүхүүд байдаг ч гэсэн яг хувийн болон улсын эмнэлэгт үзүүлсэн, ялангуяа тэр энэ компьютер юм хумаар харсан тэр юмнууд нь тэр болгон хавсрагдсан байдаггүй.

Жишээлбэл, яг миний өөрийн амьдрал дээр тулгамдсан юман дээр 21 онд үзүүлсэн элгийг 26 онд үзүүлэхэд ийм байна гэхэд 21 онд яг ямар хэмжээтэй ямар байсныг нь мэдэхгүй байх жишээний. Хэрвээ энэ үүсчихсэн байсан бол 21 онд ийм хэмжээтэй байсан. 26 онд ийм болсон байна. Харьцангуй өсөлт бага байна, гайгүй байна, эс үгүй бол томорсон байна гэдэг энэ эрсдэлийг хэмжих маш том боломжтой ийм давуу талтай хууль болж ингэж харж байна.

Нөгөө талаар сум орон нутгийн энэ багийн эмч нарыг энэ хуулиар дахин сэргээнэ гэдэг бол хамгийн зөв. Яг үнэнийг хэлэхэд тулгамдсан үед эмч давхиж ирэх нь төрөх дөхсөн эмэгтэй хүн тэр том бартаат замаар хэдэн 10, 20, 30, 40, 50км явснаас илүү эмч хурдан давхиж ирэх нь илүү найдвартай арга хэрэгсэл

байдаг. Тэгэхээр энийг бол эргэж дахиж сэргээнэ гэж оруулж байгаад нь үнэхээр баяртай байна.

Хамгийн гол нь одоо бид нар эрүүл мэндийн асуудлыг, эмнэлэг, үйлчилгээний бүтцийн, тогтолцооны асуудлаас маш олон жил харж ирсэн ч энэ өөрөө эсрэгээрээ өвчтөний зүгээс харсан байдал ерөөсөө байдлыг чухалчилж байгаагүй учраас энд дандаа баланс алдагдаж өвчтөний талын ашиг сонирхол, хэрэгцээ хангамжийг хангах асуудал үргэлж хаягдсаар ирсэн.

Тийм учраас энийг өвчтөний талд илүү их фокусалж өгснөөрөө энэ хууль бол маш давуу талтай санагдаж байна. Тийм учраас Ганмаа гишүүндээ баярлалаа. Нийт ер нь бол өвдөхгүй амьдардаг хүн гэж байхгүй маш ховор байдаг. Тийм учраас энэ бүх эрсдэлд хамгийн гол нь маш дөт замаар, маш боломжтой замаар эмнэлгээ ингээд өвчнийхөө түүхийг хянаад, эмнэлгийнхээ цагийг гар утсаараа хянаад, цахимаар хянаад байж байх энэ боломжийг хангаж өгсөн энэ хуулийн төслийг бол дэмжээд явна. Баярлалаа.

С.Бямбацогт: Саналаа хураачих уу? Гишүүд үг хэлж дууслаа. Одоо Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулах ёстой. Батжаргал дарга хааччихав?

Дэгийн хуулийн 13.1.6-д заасны дагуу санал хураалтыг ирэх долоо хоногийн Пүрэв гаргийн 10 цагаас хуралдуулахаар, хураалгахаар хойшлууллаа.

Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсгийн гишүүддээ их баярлалаа. Өдөржин хүлээсэн байх. Орой болтол суулгалаа уучлаарай тэгээд та бүхэн. Сайн хууль бас батлагдаж байвал та хэд маань баярлах байх. Өнөөдөр жоохон чилээсэнд уучлаарай. Дараагийн асуудалдаа оръё.

22.56 цаг.

Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 17-д төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууц хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсын батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална гэж заасан. Үндсэн хуульд заасны дагуу төрийн нууц дахь мэдээллийг зөвхөн хуулиар тогтоох зорилгоор 1995 онд Төрийн нууцын тухай хууль, Төрийн

нууцын жагсаалт батлах тухай хуулийг тус тус баталснаар төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон харилцааг анх удаа хуулиар зохицуулж, төрийн нууцыг хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тавьсан.

Үүнээс хойш Төрийн болон албаны нууцын тухай хууль 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, албаны нууц хэмээх шинэ нэр томьёо тодорхойлогдон практикт одоо хэрэглэж байна.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.3.2-т төрийн мэдээллийн ангилал, нууцын зэрэглэлийг оновчтой болгож, нууц хамгаалалтыг шинэ түвшинд гаргах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно гэж, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.4.1-д төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно гэж тус тус заасан.

Дээрх бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилтын хүрээнд төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах, авлига, хүнд суртлыг бууруулах, төрийн байгууллагын нууцын хадгалалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн болон албаны нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг 7 бүлэг, 39 зүйлтэй боловсрууллаа.

Төрийн болон албаны нууцын тухай хуульд салбарын болон төрийн байгууллага бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах мэдээллийг албаны нууцад хамааруулахаар томьёолсон нь төрийн байгууллагаас нууцлах мэдээллийн төрөл, хэмжээ, агуулгыг хэт өргөжүүлж, мэдээллийг явцуу ашиг сонирхлоор нууцад авах нөхцөлийг бүрдүүлж, улмаар төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс мэдээллийг хууль зөрчиж, үндэслэлгүйгээр албаны нууцад хамааруулах зөрчил түгээмэл байгаа нь төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд сөргөөр нөлөөлөх, иргэдийн мэдэх эрх хангагдахгүй байх, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэгдэх суурь нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Төрийн болон албаны нууцын тухай хуульд байгаа албаны нууцтай холбоотой зохицуулалтыг бүхэлд нь халж, хуулийн нэрийг Төрийн нууцын тухай хууль болгон өөрчилж, зөвхөн төрийн нууцтай холбогдсон харилцааг зохицуулна.

Төрийн нууцын тухай хууль батлагдсанаар дараах үр дүнд хүрэх ач холбогдолтой гэж үзэж байна. Төрийн нууцын жагсаалтыг Засгийн газраас баталж байгаа одоогийн эрх зүйн зохицуулалтыг ард түмнээс сонгон байгуулсан төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурал батлах үндэс бүрдэнэ.

Төрийн байгууллага, албан тушаалтан, дэд бүтцийн томоохон төслүүд болон бусад мэдээллийг үндэслэлгүйгээр нууцад хамааруулах явдлыг таслан зогсоож, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэх нөхцөлийг арилгах, гэмт

үйлдэл гарахаас сэргийлэх, төрд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Албан нууцад хамаарах 882 мэдээлэл ил болж, улмаар төрийн нууцад хамаарахаас бусад төрийн байгууллагын мэдээлэл ил тод, нээлттэй байх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан төр, түүний байгууллагаас хууль, ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах иргэний эрх хангагдана.

Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан салбар байгууллагын хэмжээнд төрийн нууцад хамаарах 574 мэдээлэл 200 болж буурна.

Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Энхбаяр сайд баярлалаа. Төслүүдийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн танилцуулна.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд 2026 оны 06 сарын 09-ний өдрийн хуралдаанаар явууллаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 17-д төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална гэж, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.3.2-т төрийн мэдээллийн ангилалд нууцын зэрэглэлийг оновчтой болгож, нууц хамгаалалтыг шинэ түвшинд гаргах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно гэж, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.4.1-д төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамааруулахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно гэж заасны дагуу төрийн нууцыг зөвхөн хуулиар тогтоон хамгаалах, төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдал, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах, авлигал, хүнд суртлыг бууруулах, төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.parliament цахим сайтад байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат хуулийн төслийн дэмжиж байгаагаа илэрхийлж, авлига, албан тушаалын хэргүүд нэмэгдсэн үед уг хуулийг баталснаар нөхцөл байдал хэрхэн сайжрах, эдгээр гэмт хэрэгт холбогдсон албан тушаалтанд ямар хариуцлага ногдуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр манай улсын хувьд аюулгүй байдал болон гадаад бодлогоо баримталж, нууцын асуудалд болгоомжтой хандах, технологи, хиймэл оюун ухаанд суурилсан энэ үеийн нууцлалын бодлогын асуудал, олон улсын жишиг, улс төр, дипломатын аргаар улс орныхоо аюулгүй байдлыг хамгаалах, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал бүхий улсын хувьд нууцын жагсаалтыг хуулиар батлах нь оновчтой эсэх, цаашдаа нууцын асуудлууд Улсын Их Хурлаар батлах, ил тод болгох, нууцлалын чадвар, шаардлагаа алдах эрсдэлтэй эсэх, жагсаалтад ороогүй боловч асуудлаас тодорхой болгох явцад нууц хамааруулах асуудлыг хэрхэн зохицуулах, Улсын Их Хурлын гишүүн Анар Төрийн болон албаны нууцын тухай хуулийг зайлшгүй шинэчлэх шаардлагатай тухай, нууцад авах шаардлагагүй мэдээллийг нууцалдаг талаар, Улсын Их Хурлаас хяналт тавих боломжгүй албаны нууцад авч байгаа процесс нь ойлгомжгүй, тодорхойгүй, зайлшгүй шаардлагатай зүйлсийг нууцад оруулах тухай, хэтэрхий нээлттэй болгосон тохиолдолд нууцаа хамгаалж чадах эсэх, заруулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн Төрийн нууцын нэр дор нууцалдаг төсөв, төсвийн зардлуудад хяналт тавих тогтолцоо, нууцлах хугацаа урт байгааг богиносгох эсэх, тендер, худалдан авах ажиллагаа, гэрээ, хэлэлцээрүүдийг нууцалдаг асуудал хууль бусаар нууцалсан болон нууцад авсан албан тушаалтанд ямар хариуцлага хүлээлгэх тухай зохицуулалтын хуулийн төсөлд тусгасан эсэх тухай асуулт асууж, үг хэлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Анар хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаагаа илэрхийлээд цаашид Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар зарим асуудлыг хаалттай горимоор хэлэлцэх шаардлагатай, нууцад авсан бүртгэлгүй, хууль бусаар нууцад авсан албан тушаалтанд хариуцлага тооцох, хуулийн төслийн үг хэллэг, найруулгын зөрчилтэй байгаад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд хуулийн төслийг хэлэлцэхдээ зөвхөн нууцлах ёстой асуудлыг хаалттай хэлэлцэх, Улсын Их Хурлын гишүүн Ганбат хуулийн төслийг дэмжиж, авлига, албан тушаалын гэмт хэргийг зогсоох, илүү эерэг үр дүнд хүрэх талаар үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11 дэх хэсэг заасныг үндэслэн Байнгын хорооны хуралдаанаар Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Патентын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Үй олноор хөнөөх, зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүх шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар нэг бүрчлэн ил санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Баттөмөрийн Энхбаяр, Ядамдоржийн Жавхлан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Чойжилжавын Эрдэнэчимэг Хууль, эрх зүйн газрын ахлах референт, Бат-Эрдэмийн Төрбат Хууль, эрх зүйн газрын ахлах референт, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ дэд сайд, Гадаад харилцааны яамнаас Төрийн нарийн бичгийн дарга, Батсуурийн Мөнхбаяр Бодлогын газрын дэд захирал, Батлан хамгаалах яамнаас Эрхэмбаярын Гансүх Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга, хурандаа, Гомбосүрэнгийн Энхболд Төрийн захиргаа,

удирдлагын газрын ахлах шинжээч, хуулийн зөвлөх. Тагнуулын ерөнхий газраас Аюушжавын Бат-Эрдэнэ Тэргүүн дэд дарга, бригадын генерал, Баасанбүрэнгийн Батмөнх хэлтсийн дарга, Чулуунбаатарын Хүдэрбаяр хэлтсийн дарга. Ажлын хэсгийн гишүүд. Баярлалаа. Жаргалан гишүүн байна биз дээ?

Одоо Улсын Их Хурлын гишүүдээс Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төсөлтэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Отгоншарын Батнайрамдал гишүүн алга байна. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна уу.

Ө.Шижир: Шөнийн мэнд. Бид нар нөгөө өдөр алдаж, шөнө гэдэг шиг ийм сая Ганмаа гишүүний өргөн барьсан тэр Эмнэлгийн тусламжийн тухай хууль, Нууцын тухай хуулиуд ингээд шөнө тулгаж орж ирдэг. Энэ хууль маань өөрөө бас шинэ жилийн үеэр бас шахуу батлагдсан юм байна лээ шүү дээ. Шинэ жилийн үеэр батлагдахдаа Албаны нууц гэж оруулж ирээд түүнээс хойш албаны нууц гэсэн нэртэй бүх юм болгон нууц болоод өнөөдөр Монгол Улсын өөрөө нэг их нууцтай, эсвэл нууцлаг хууль ч юм шиг тийм болчихсон. Засгийн газар нь одоо өргөн барьсан төсөл дээрээ 880 орчим шахам нууц гэж байгаа.

Ардчилсан намын бүлгээс Цогтгэрэл дарга, бидний өргөн барьсан хуулийн төсөл дээр холбогдох байгууллагуудаас хэчнээн нууц байгаа юм бэ гээд мэдээлэл авахаар 600 орчим байна. Ингээд нэгдсэн тоо, яг хэдэн бичиг баримт, хэчнээн нууц юм байгаа юм, нэгдсэн тоо баримт байдаггүй. Хоёр өөр тоонууд ингээд өгөөд яваад байдаг.

Бүх юм нууц болсон. Бид нарын одоо энэ хэлж байгаа, ярьж байгаа микрофон хүртэл нууц болсон. Хаанах нийлүүлсэн нь нууц болсон. Хэдэн төгрөгийн төсөв нь нууц болсон. Ингээд нууцлаагүй үлдсэн юм бид нар байна уу гэхээр бараг байхгүй боллоо.

Ер нь Байнгын хороон дээр ч хэлж байсан үндэсний аюулгүй байдалтай холбоотой цэрэг, цагдаа, хил хамгаалах, тагнуул ч гэдэг юм уу иймэрхүү тусгай чиг үүргийн байгууллагын асуудал нууцлахыг ойлгож байна. Бизнесийн байгууллагуудын гэрээнүүдийг нууцалж байгааг ойлгохгүй байна. “Эрдэнэс Тавантолгой” компанийн оффтейк нүүрсний гэрээнүүдийг нууцалж байгааг ойлгохгүй байна. Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжмалын гэрээнүүд нууц байгааг ойлгохгүй байна. Албаны нууц гээд энгийн бичиг хэргийн захидал харилцааг хүртэл нууцалж байгааг ойлгохгүй байна. Төрийн байгууллагаас гарсан шийдвэрийг төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид буцааж Их Хуралд явуулахдаа нууцын тамга дараад явуулж байгааг бас ойлгохгүй байгаа. Энэ чинь ил байгаад байгаа шүү дээ.

Жишээ нь, Ашигт малтмалын ерөнхийн газрын даргын тушаалыг “Оюу толгой” компани сонсголын үеэр хяналт шалгалтын ажлын хэсэг рүү явуулахдаа нууцлаад явуулчихаж байгаа юм. Уг нь бол энэ илээр гарсан тушаал байгаа юм гэх мэтчилэн ингээд нууцаар явуулчихаар нууцаар ярих болчихдог. Ил ярих боломжгүй болгодог. Энэ өөрөө ажил явуулахад маш их хүндрэлүүд үүсгэдэг гэх мэт ийм асуудал байгаад байгаа юм.

Ер нь Засгийн газраас өргөн барьсан Нууцын тухай хууль, мөн Ардчилсан намын бүлгийн гишүүдээс, Цогтгэрэл дарга тэргүүтэй бидний өргөн барьсан Нууцын тухай хуультай нэгтгээд хэлэлцээд явах нь зөв өө. Бид нар ер нь энэ албаны нууц гэдэг ойлголтыг буцааж энэ хуулиасаа авч хаяхад энэ олон нууцуудыг бүгдийг нь ил болгохгүй бол сүүлдээ энэ чинь улс төрийн хэрэгсэл болоод байна. Тэр тэрийг нууцаас гаргалаа гээд, гаргаж ирээд мэдэгдэл хийгээд байдаг. Тэрүүнд нуух юм юу байгаа юм, бүгдийг нь ил болгочихъё. Нууц бүхний ард хардлага л бий. Нууц бүхний хувьд үл итгэл бий. Нууц бүхний хувьд үл ойлголцол бий. Нууц бүхний хувьд хуваагдал бий.

Тэгэхээр энэ нууцтай холбоотой бүх юмнуудыг бүгдийг нь ил болгоё. Зөвхөн цэрэг, цагдаа, онцгой, хил хамгаалах ч гэдэг юм уу, төрийн тусгай чиг үүргийн байгууллагын юмнуудыг нууцалъя. Энэ хуулийн төслүүдийг аль алныг нь дэмжиж байгаа. Бодвол хамтраад хэлэлцээд нэг хуулийн төсөл болгоод нэгтгээд хамтарсан ажлын хэсэг гараад явах байх гэж итгэж байна.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ тийм үү. Ер нь энэ Засгийн газрын өргөн барьсан хууль, Цогтгэрэл гишүүд нарын өргөн барьсан хуулийг хамтатгаад хэлэлцээд явах ийм бодлого барина. Үзэл баримтлалын хувьд хууль санаачлагч өөрсдөө зөвшөөрвөл, үзэл баримтлал нийцэж байвал энэ хэлэлцэх эсэх нь шийдэгдсэний дараа ярих боломжтой асуудал.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Энэ хуулийн үзэл баримтлалыг дэмжиж байгаа. Үндсэн хуулиар 16.17-д Монгол Улсын иргэдийн мэдэх эрхийг энэ хуулиар л хязгаарлаж байгаа. Тэгэхээр энэ хууль дээр болохоор төр, байгууллагын нууц, хувь хүний нууц гэсэн ийм гурван төрлийн хуулиар энэ эрхийг хязгаарласнаас бусад мэдээллийг олж авах, хайх ийм эрхтэй байгаа. Тэгэхээр энэ Үндсэн хууль дээр байхгүй, албаны нууц гэдэг зүйлийг оруулж ирээд энэ албаны нууц гэж хууль, Төрийн болон албаны нууц гэж батлагдталаа жишээлбэл 2017 оны 61 л нууцад хамаарах мэдээлэл ийм тоо байсан бол хүний эрхийн тайлан дээр бичсэнээр бол энэ тоо албаны нууц гэж тэлэнгүүт 7 дахин нэмэгдэж, 570 хэд болж нэмэгдсэн байгаа юм. Тэгэхээр энэ хэмжээгээрээ иргэдийн мэдэх эрх хумигдаж, агшиж байсан. Тэгэхээр энийг буцааж залхуулж, өөрөөр хэлбэл төр, төрийн хуулиар хязгаарласнаас бусад мэдээллийг нийтийн төрийн мэдээллийг Монгол Улсын иргэд хайх, олж авах энэ эрхийг нээж байгааг өөрөөр хэлбэр хүний эрхийг тэлж байгаа ийм хууль байгаа учраас энэ хуулийн дэмжиж байгаа юм.

Энэтэй холбогдуулж 1 асуулт байгаа юм. Бид нар Үндсэн хуулиар тодорхой хэмжээний бололцоо, өмчлөх эрхтэй холбоотой зүйл, заалтууд байна. Гэхдээ энийг бас төрийн болон энэ албаны нууцаас, энэ хуулиас гадна өөр бас олон улсын гэрээгээр хязгаарлаад байгаа юм. Энэ хуулийн төсөл дээр олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гээд заачихсан байгаа юм. Энэ хязгаарлалтуудыг би нэг жишээ хэлье л дээ Үндсэн хууль дээр газрын баялаг бол ард түмний мэдэлд байна гээд заачихсан байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл мэдэлд байна гэдэг чинь мэдэх эрх нь, тодорхой хэмжээний мэдэх эрх нь байж байж тэр өөрийнхөө өмчлөл мэдэлд байгаагаа бүрэн бүтэн болно.

Гэтэл жишээлбэл, олон улсын гэрээ ч гэдэг юм уу, Харбины гэрээ гэдэг ч юм уу хамгийн том уул уурхайн баялгийнхаа ямар үнээр зарж байгаа гэдэг мэдээллийг иргэд битгий хэл төрийн байгууллагууд мэдээлэл авахгүй, хэрвээ авах боломжгүй, хэрвээ авахаар бол тэр мэдээллийг олж авахаар бол өөр Хятад компаниас Хятадаас олж зөвшөөрөл авч байж энэ эрхээ хэрэгжүүлэхээр ийм зүйл, заалтууд ингээд яваад байна. Үндсэн хуулиар болохоор Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж, олон улсын гэрээг дагаж мөрдөхгүй байх ийм эрхтэй.

Тэгэхээр олон улсын гэрээ гэдэг ийм нэг суваг үүсээд тэгээд төрийн болон албаны нууц гэж байснаа энд албаныхыг нь хумьчихаар дахид олон улсын гэрээ гэдэг энэ зүйл, заалт дээр Монгол Улсын иргэдийн энэ мэдэх эрхийг, мэдээлэл хайх эрхийг, өөрийнхөө өмчлөх эрхээ хэрэгжүүлэх энэ Үндсэн хуулийн энэ эрхээ хэрэгжүүлэх энэ бололцоо, боломжуудыг хязгаарлаад байгаа. Тэгэхээр энэтэй холбоотойгоор энэ хууль дээр ямар нэгэн, миний харснаар бол ийм зүйл, заалт харагдаагүй. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гэсэн л заалт байгаад байгаа. Тэгэхээр ийм Үндсэн хуулийн яг хуулийн үзэл баримтлалтай уялдуулаад энэ иргэний энэ эрхийг тэлэхэд өөр нэг хязгаарлаж байгаа хүчин зүйлийг олон улсын гэрээгээр хязгаарлах энэ бололцоо, боломжууд энэ хууль дээр ямаршуу байдлаар зохицуулах ийм зүйл, заалт байгаа юу, эсвэл энэ талаар юу гэж бодож байгаа бэ гэсэн асуулт байна.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Мөнх-Эрдэнэ. Таны хуулийн төсөл дээр дурдсан 3.3 дахь зохицуулалт бол өнөөдөр бас хүчин төгөлдөр мөрдөж байгаа Төрийн болон албаны нууцын тухай хуульд байдаг заалт. Тэгэхээр энэ олон улсын гэрээ гэдэг бол үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, энэ чиглэлээр гадаад улсуудтай байгуулсан тодорхой төрлийн гэрээнүүд байдаг. Энэ жишээ хэлэхэд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Польш Улс гэх мэт улсуудтай, дээр нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улстай байгуулсан ийм олон улсын гэрээнд тусгайлан заасан саяын миний хэлдэг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдалтай холбоотой чиглэлээр байгуулсан энэ гэрээнүүдэд тусгайлан заасан тохиолдолд энэ олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу бид мэдээллийг хамгаалах, хадгалах ийм үүрэг хүлээдэг.

Аж ахуйн шинжтэй таны саяын жишээ дурддаг Харбины гэрээ гэж ярьж байгаа энэ гэрээ бол жишээ нь төрийн нууцад ямар ч хамаагүй. Энэ төрийн нууцад авсан зүйл байхгүй. Төрийн нууцтай холбоотой харилцааг зохицуулаагүй ийм асуудал байгаа. Энэ талаар тагнуулын байгууллага ч гэсэн тодорхой дүгнэлт гаргаад ирүүлчихсэн байгаа.

Харбины гэрээг байгуулах хэлэлцээний шат, хэрэгжилтийн шатад, дүгнэх үе шатад харилцан солилцсон мэдээллийг энэ гэрээнд оролцогч бус гуравдагч талуудад мэдээлэл хүссэн задруулах тохиолдолд нөгөө талаасаа зөвшөөрөл авах ийм зохицуулалт байгаа. Энэ олон улсын гэрээг байгуулахад Улсын Их Хурал соёрхон баталсан тул Улсын Их Хурал жишээ нь гишүүд энэ гэрээтэй холбоотой мэдээлэл хүсэхэд ямар нэгэн зөвшөөрөл авах шаардлага байхгүй ээ гэж ойлгож болно. Баярлалаа.

С.Бямбацогт: Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тэгэхээр яах вэ бид нар сонсгол хийх гээд сонсгол хийж чадаагүй шүү дээ. Хуулиар бол жишээ нь сонсгол хийх хүсэлт гаргаад хийх ёстой болохоос биш тэрийг нь чуулганаар хэлэлцэх эсэхийг нь шийднэ гэсэн тийм заалт байхгүй. Тэгэхээр энэтэй холбоотой эрхүүд хязгаарлагдаад байгаа байхгүй юу. Ямар сайндаа л гэрээгээр чинь одоо тэр гэрээгээр чинь мэдээлэл авъя гэхээр өгөхгүй байгаа байхгүй юу. Тэгээд аргаа бараад сонсгол хийе гэхээр сонсголыг нь жишээлбэл, Улсын Их Хурал дээр энийг хийх бололцоогүй ингээд хязгаарлаж байгаа. Уул нь хуулиараа бол сонсголыг ч гэсэн хийсэн бол тодорхой хэмжээний сонсгол хийж мэдэх эрхээ хангах ёстой юм уг нь.

Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ хууль чинь өөрөө 16.17 буюу үндсэн иргэдийн мэдэх эрхийг хангах гэж байгаа. Тэгэхээр энэ мэдэх эрхийг хязгаарлаж байгаа өөр жишээ нь яг төрийн нууц гэж ойлгогдохоор байдлаар жишээлбэл олон улсын гэрээнүүд хийгээд энийг хязгаарлаж байгаа зүйлүүд байгаа учраас ер нь цаашдаа бас энэ чиглэлийн зохицуулалтуудыг хэрвээ болохгүй бол.../минут дуусав./

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Энхтүвшин гишүүний асууж байгаа Харбины гэх гэрээ бол төрийн нууцад ч хамаарахгүй, албаны нууцад ч хамаарахгүй. Энэ талаар тагнуулын байгууллагын дүгнэлт гарчихсан байгаа. Энхтүвшин гишүүн та надад бичгээр энэ гэрээний хувийг үзэж танилцъя гэдэг, хувилаад өг өө гэдэг хүсэлтээ өгчих. Би танд бичгээр хувилаад өгье. Энэ нууц биш асуудал байгаа.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тэгэхээр яах вэ энэ би танилцах нь гол нь биш л дээ. Яг энэ жишээлбэл газрын баялаг ард түмний мэдэлд байна аа гээд. Тэгэхээр ард түмэн нь өөрийнхөө байгаа зүйлээ ямар үнээр зарж байгаа, яаж байгаа, ийж байгаа мэдээллээ, тэгээд жишээлбэл энэ төмөр замын гэрээ ч гэсэн энэ бол тэр нь өмнө хийчихсэн байгууллагын албаны нууцтай холбоотой явж байгаа. Энэ нь болохоор олон улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр гээд иймэрхүү агуулгаар эхнээсээ тийм хуулийн хувьд тийм биш ч гэсэн төрүүлсэн сэтгэгдэл нь, байгаа байдал нь бол ингээд яг л нууцад оруулчихаад байгаа. Тэгэхээр энийг ард түмэн мэдэх энэ бололцоо, боломжийг нь хангаач ээ л гэж хэлмээр байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Энхбаяр сайд. Жадамбын Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Нууцын тухай болон бид бас их нухацтай хандах ёстой. Бид нар чинь их гүрний дунд оршдог. Евроазийг дамжин оршдог. Их гүрнүүдийн ашиг сонирхлын зөрчил дээр байдаг ийм орон. Юу юунаас илүү нууцлах асуудлууд олон байх ёстой. Ард түмний мэдэх эрх гэдгээр, Их Хурлын гишүүний бүрэн эрх гэдгээр энэ нууцын асуудлыг хэт задгайлах нь бас улс оронд сөрөг тусна. Зарим гишүүд энэ микрофоны асуудлыг бол тэр хөндөж байна шүү дээ. Энэ микрофоныг хаанаас авсан, хаана нь нийлүүлсэн энэ бас нууц байх ёстой. Энэ чинь Их Хурал бодлого ярина, нууц асуудал хэлэлцэнэ. Гэтэл энийг нийлүүлэх асуудлыг нууц байж

болохгүй гээд ил тендерээр зарлахад энэ өөрөө улс орны аюулгүй байдал алдагдах л ийм эх үүсвэр болж хувирдаг. Их Хурлын дарга аа цагаа сунгаадах уу.

С.Бямбацогт: Энхбаяр сайд 1 минут сунгая.

Ж.Энхбаяр: Нөгөө талаар хэн ч Их Хурлын гишүүн болох бололцоотой. Бид нар ийм л ардчилсан парламентын тогтолцоотой. Тэгэхээр нууцаа жагсаалтаар Их Хурал нь баталчихдаг. Энэ өөрөө бусад тусгай байгууллагууд үйл ажиллагаа явуулахад олон зүйлээр хязгаарлалт болж эхэлнэ. Ялангуяа чухал ашигт малтмал, чухал технологи, бодлогын, эдийн засгийн бас нууцалбал зохих олон асуудал гарч ирдэг. Тухайн гэрээ хүчин төгөлдөр болтол харилцан нууцлах шаардлагыг улс орнууд тавьдаг. Тэгэхээр нууцыг жагсаалт гаргаж Их Хурал нь батлаад одоо бид дараа нь энэ асуудлыг нууцлах ёстой гээд Их Хуралд өргөн бариад шийдүүлэх болоод байна л даа. Тэгэхээр энэ маань өөрөө нууц алдагдах гол байдлыг өөрөө бид нар бүрдүүлэх юм руу бас хэт явах юм.

Тэгэхээр энэ тусгай байгууллагуудын нууцлал зохих зарим асуудлуудыг жоохон нээлттэй үлдээж.../минут дуусав./

С.Бямбацогт: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. Та үг хэлэх юун дээр бас хэлж болох боломж байгаа. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Тэгэхээр Их Хуралд чинь бид нар яг энийг чинь тооцоолоод Тусгай хяналтын байнгын хороо гээд байгуулчихсан шүү дээ. Тэнд төрд зүтгэсэн, тусгай албадаар дамжсан, тусгай албаны шалгалтад орсон бас итгэл хүлээсэн гэж үздэг гишүүд орж ажиллаж байгаа. Тэгэхээр энэ түвшиндээ бас энэ асуудлаа жоохон хязгаарлах ийм шаардлага байна шүү гэдгийг цаашдаа ажлын хэсэг дээр анхаараад явна биз. Ахиад хэлье юм нарийсаж байгаа үед нууцлах юм бол байна. Ялангуяа манайх шиг жижиг улс бол нууцын бодлоготой, нууцлах зүйл ихтэй байх ёстой шүү. Ард түмэнд мэдэх эрх, парламентын ардчилал ийм зүйлийг барьж энэ нууцын асуудалд их дэлгэж хандах нь тийм сайн үр дагавар хүрэхгүй гэсэн ийм бодолтой байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Одоо болсон. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хариулчихсан. Дараагийн хууль дээр ярьж болно бас. Та бүхэнд боломж байгаа.

Дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж гишүүд үг хэлнэ. Урьдчилан ирүүлснээс нь дагуу. Нэрс алга байна.

Энэ асуудлыг бас чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.1.9-д заасны дагуу санал хураах боломжгүй учраас хойшлууллаа. Пүрэв гаргийн чуулганаар 10 цагаас чуулганы хуралдаанаар хураана.

23.25 цаг.

Дараагийн асуудалдаа орёе. Энэ чинь дагасан олон хуультай юм байна тээ? Дараагийн асуудалд орёе.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 17-д төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл авах, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална гэж заасан. Үндсэн хуульд заасны дагуу төрийн нууцлах мэдээллийг зөвхөн хуулиар тогтоох зорилгоор Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг Улсын Их Хурлаас 1995, 2004 онуудад баталж байсан Төрийн нууцын тухай хуулийн бүтцийн жишгийг баримтлан төрийн бодлогын хүрээд 20, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, технологийн хүрээнд 5, батлан хамгаалах хүрээд 70, тагнуул, сөрөн тагнуул, хууль сахиулах ажлын хүрээнд 62, мэдээллийн аюулгүй байдал болон бусад хүрээнд 43, нийт 200 мэдээллийн жагсаалтын боловсруулсан.

Хуулийн төслийн боловсруулахдаа төрийн нууцаар үзсэн 45 байгууллагаас санал авч, ирүүлсэн 762 мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мэдээллийн үндэслэлгүйгээр нууцлах, салбар байгууллагын хэмжээнд хэт өргөжүүлэх эрсдэлийг унах, үндэсний аюулгүй байдлын шинэ болон бодит аюул заналыг харгалзан үзсэн болно.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль батлагдсанаар дараах үр дүнд хүрэх ач холбогдолтой.

Нэгдүгээрт, Төрийн нууцын жагсаалтыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар батлах эрх зүйн үндэс бүрдэнэ.

Хоёрдугаарт, Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан салбар байгууллагын хэмжээнд төрийн нууцад хамаарах 574 мэдээллийн 200 болж буурна.

Гуравдугаарт, Үндэсний нууц хамгаалах тогтолцоо бэхжиж, мэдээллийн аюулгүй байдлыг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, хууль хэрэгжилтийн нэгдмэл байдлыг хангах үндэс, суурь бүрдэнэ.

Хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танилцуулна.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 06 сарын 09-ний өдрийн хуралдаанаар явууллаа.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2017 оны 09 сарын 13-ны өдрийн 247 дугаар тогтоолоор салбар байгууллагын хэмжээнд төрийн нууцад хамаарах 574 мэдээллийн жагсаалтыг баталсан бөгөөд уг жагсаалт нь 2019-өөс 24 онд нийт 8-н удаа нэмэлт, өөрчлөлт, 2 удаа мэдээллийн жагсаалтаас хассан, 3-н удаа өөрчлөлт оруулсан. 14-н удаа нэмсэн тохиолдол байна.

Төрийн нууцын жагсаалтыг Засгийн газрын шийдвэрээр баталснаар ард түмнээс сонгон байгуулсан төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын хяналт суларч, уг жагсаалтыг үндэслэлгүйгээр өргөжүүлэх нөхцөл бүрдэж байгаа тул төрийн нууцыг хуулиар тогтоон хамгаалах олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн төрийн нууцын жагсаалтыг хуулиар тусгайлан батлахаар боловсруулсан байна.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын хуулийн d.parliament цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулахад Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хэвээрээ түрүүний ажлын хэсэг. Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж асуулт асуух гишүүд нэрээ өгөөрэй. Урьдчилан ирүүлсэн нэрс байгаа.

Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн алга байна Отгоншарын Батнайрамдал гишүүн алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн алга байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Хууль санаачлагчаас 2 асуулт асуух гэсэн юм.

Нэгдүгээрт, Эрүүгийн хуулийн 19.11 буюу төрийн нууц мэдээллийн хууль бусаар олж авч хадгалсан гээд сэтгүүлчийг ялласан. Гэтэл энэ нууц хадгалах үүрэг ер нь сэтгүүлчид байдаг юм уу нэгдүгээрт?

Нууцыг хадгалах үүрэгтэй, нууцыг хадгалахаар гарын үсэг зурсан албан тушаалтанд ямар хариуцлага ногдуулсан бэ? Ямар хариуцлага энэ хүн хуулиар үүрэх ёстой юм бэ? Мэдээж төрийн нууц гэдэг хаа нэг газар хэвтэж байдаг ийм асуудал бол биш. Тэгэхээр сэтгүүлчийг хадгалсан гэж яллагчаад сэтгүүлчид хэн тэр нууцыг өгсөн юм бэ гэдэг ч юм уу, ер нь энэ төрийн нууцыг хадгалах энэ чиг үүрэгтэй байгууллагууд, дээрээс нь төрийн нууц алдагдсан бол яаж энэ төрийн нууц алдагдав аа гэдэг дээр байгууллагууд, холбогдох байгууллагууд ямар арга хэмжээ авдаг юм бэ? Энэ хуулийн хэрэгжилтийг нэгдүгээрт эргэж харан юм уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт дэлхий даяар хиймэл оюун ухааны хөгжил гэдэг бол ерөөсөө өгөгдөл дээр, дата мэдээлэл дээр хэн процессын анализ хийж байгаа дээр л хөгжиж байна. Мэдээж эмзэг мэдээлэл, хувь хүний мэдээлэл бол төрийн нууцад байх нь бол ойлгомжтой.

Гэхдээ бусдыг нь нээлттэй болгоод смарт, илүү оновчтой мэдээлэл дээр тулгуурлаж шийдвэр гаргах энэ алхам дээр Засгийн газрын зүгээс ямар ажил хийх гэж байна бэ? Нэг үеэ бодох юм бол Монгол Улсыг дэлхийн банкны судалгаагаар мэдээлэл бол сайн цуглуулж чадаж байгаа.

Дээрээс нь нэмээд энэ нөгөө тал дээрээ, энэ их мэдээлэл дээрээ анализ хийж чадахгүй байгаа гэж дүгнэсэн байсан. Тэгэхээр их өгөгдлийн сантай яагаад болохгүй байгаа юм бэ? Бусад улс орны хувьд жишээлбэл үүн дээрээ маш сайн анализ хийж чадаж байгаа нь хиймэл оюун ухаан, AI-г илүү хөгжүүлж чадаж байгаа улс орны тоонд орж байгаа. Эрх мэдэл гэдэг бол сүүлийн үед мэдээлэл, хэн мэдээлэлд ойрхон байна гэдгээс нь шалтгаалж байна.

Тэгэхээр мэдээлэл хаалттай байна гэдэг бол авлига, хээл хахуул цэцэглэх, авлига, хээл хахуул, дээрээс нь нэмээд иргэд, олон нийтийн төрд итгэх итгэлийг бас бууруулж байгаа. Ерөнхий сайдын “чөлөөлье” гэдэн аяны нэг том зүйл бол мэдээллийг илүү нээлттэй болгоё, нууцлал, энэ хаалттай байдлыг чөлөөлье гэж би бол ойлгож байгаа. Өөрөө Цахим хөгжил, харилцаа холбооны сайдаар ажиллаж байхдаа маш олон мэдээллийг ил тод, нээлттэй болгосон. Одоо Оюу толгой байгууллагын, энэ Оюу толгойн сонсголын үеэр ч гэсэн маш олон мэдээллийг байгууллагын нууц мэдээлэл гээд ил тод болгож чадахгүй байгаа. Манай Төсвийн байнгын хороон дээр Оюу толгой дээр хийсэн аудитын зарим дүгнэлтийг сонсох гэхээр мэдээллүүд нь нууцаа гээд энэ бол нууцаар явагдаж байгаа.

Тэгэхээр хувь байгууллага хүртэл маш олон мэдүүлүүдийг нууцалж байгаа. Гэтэл үүнтэй холбоотойгоор Монголын төр мэдээж энэ иргэдийн хувь мэдээлэлтэй холбоотой асуудлуудыг бид нар нууцлахыг бол ойлгож байна. Гэхдээ та бүхэн энэ мэдээллийг ил тод байлгах дээр хиймэл оюун ухаан, их өгөгдлийг хөгжүүлэх дээр юу хийх гэж байгаа бэ гэдэг ийм 2 асуултыг асуух гэсэн юм.

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя. Баттөмөрийн Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Төрийн нууцын жагсалт батлах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг ярьж байна. Ер нь бол хууль санаачлагч энэ хуулийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хаалттай горимоор хэлэлцүүлэх саналтай байсан. Тодорхой төрийн нууцыг хадгалж байсан гэх хэрэг, учралтай холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргаан одоо ч нууцад байгаа. Энэ талаар Улсын Их Хурлын гишүүн, хууль санаачлагч, Засгийн газрын гишүүн, тэр хэргийг шүүсэн шүүгч одоо мэдээллийг ил тод хэлэх боломжгүй. Өөрөөр хэлбэл энэ төрийн нууцын тамгатай байгаа учраас энэ тухай яривал өөрөө 5-8 жилийн хорих ял авна.

Тийм учраас тодорхой хэрэг учрал дээр бол ... шүүх боломж байхгүй. Харин энэ хэрэг учралтай холбоотойгоор Цогтгэрэл даргын санаачилсан хууль дээр бол төрийн нууцыг хадгалж байсан этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх ийм агуулга орж ирсэн байна лээ. Би энийг бол хаалттай горим дээр нюансуудыг нь хэлэх ёстой гэж бодож байгаа. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын төрийн нууцыг задруулсан, дамжуулсан, магадгүй тусгай албадын үйл ажиллагааг хадгалсан ч байсан гэдгээр хуулийн хариуцлагаас мултрах сиймхий боломжийг гадаадын агентуудад олгож болохгүй. Энэ бол өөрөө тийм цогц үйл ажиллагаа байгаа.

Тийм учраас задруулсан ч тэр, хадгалж байсан ч тэр энэ бол гэмт хэрэг. Төрийн нууцыг хэн ч хадгалах ёсгүй. Хэн ч. Хэн ч хадгалж байх ёсгүй төрийн нууцыг. Тийм учраас энэ дээр энийг зөвтгөсөн ийм үзэл баримтлалыг бол Засгийн газар бол дэмжихгүй. Тусгай албад ч бас дэмжихгүй байх гэж бодож байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын эрх ашиг ч энийг дэмжихгүй гэж би ойлгож байгаа.

С.Бямбацогт: Булгантуяа гишүүн тодруулъя.

Х.Булгантуяа: Энхбаяр сайд аа төрийн нууцыг хэн нэгэн задруулах нь зөв өө гэж ерөөсөө яриагүй. Төрийн нууцыг жирийн иргэн ч байдаг юм уу, хувь сэтгүүлч байдаг юм уу олж авах ёсгүй л байхгүй юу. Төрийн нууцыг төрийн нууцтай харьцах ёстой хэдхэн албан тушаалтан байдаг. Байгууллага дээр тэр битгий хэл бүхэл бүтэн яам дээр, агентлаг дээр төрийн нууцтай харьцах албан тушаалтан гэж тусдаа байдаг. Тэр хүн төрийн нууцтай харьцсаныхаа төлөө арай илүү өндөр цалингийн нэмэгдэл битгий хэл авдаг. Түүнтэй холбоотой холбогдох бичгүүд дээр гарын үсэг зурдаг. Та үүний хүлээж авлаа шүү. Та үүнийг буцааж өгнө шүү. Та үүнтэй танилцана шүү гэж. Тэгэхээр тийм биш хүн, жирийн иргэн үүнийг олоод авбал яах юм? Тэрийг нь төрийн нууц гэж мэдэхгүй задруулбал яах юм гэдэг асуултыг асуугаад байгаа байхгүй юу. Одоо сая сэтгүүлч түүнээс болоод ял эдэллээ шүү дээ. Тэгэхээр тэр хүн тийм үүрэг хүлээж байгаа юм уу хуулиараа? Тэр.../минут дуусав./

С.Бямбацогт: Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Ямар ч хүн Улсын Их Хурлын гишүү, Засгийн газрын гишүүн, хэвлэл мэдээллийн ажилтан, бизнесийн хүн ч бай тэр хүн гаднын агент мөн эсэх асуудлыг бид мэдэхгүй. Би түрүүн сая хэлээд байна шүү дээ хаалттай горимоор хэлэлцье гэдэг нь тодорхой хэрэг учралууд гарч байсан асуудлууд байна.

Жишээлбэл, нэг Улсын Их Хурлын гишүүн өөрийнх нь төрийн нууцтай холбоотой асуудал энэ гадаа хүн авчраад өгсөн тэгээд задлаад үзсэн чинь төрийн нууцын тамгатай байсан гээд нэг Их Хурлын гишүүн 20-иод жилийн өмнө бөөн скандал үүсгэж байсан асуудал бий. Тэр хүнд одоо хэн өгсөн асуудал байна уу, энэ нь өөрөө ямар оролцоотой схем болсон байна вэ гэдэг чинь зүгээр тийм иргэн хоорондын бас асуудал биш ээ гэж би хэлээд байна шүү дээ. Тусгай албад.../минут дуусав./

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя 4 дүгээр микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Мөнх-Эрдэнэ. Та Эрүүгийн хуулийн 9.11, 9, 11 дүгээр зүйл төрийн нууцыг хууль бусаар олж авах гэсэн гэмт хэргийн талаар асууж байна. Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд субъект нь бол хэн ч байж болно. Монгол Улсын иргэн. Энд ажил, мэргэжлээр нь онцгойлсон энэ хүнд хамаарахгүй гэсэн ийм зохицуулалт байхгүй.

Өөрөөр хэлбэл, төрийн нууцыг хуулийн дагуу биш хууль бусаар олж авсан. Та хуулийн дагуу олж авах гэдэг бол түрүүний дурдсан төрийн нууцыг хадгалах, хамгаалах, төрийн нууцтай харилцдаг баталгаа гаргасан албан тушаалтан, байгууллагын албан хаагчид бид энэ хүмүүсийн хувьд яригддаг асуудал.

Хууль бусаар олж авч байгаа энэ гэмт хэргийн шинж, гэмт хэргийн үйлдсэн сэдэл, субъектив нөхцөл байдал эд нарыг энэ мэдээж хуулийн гэмт хэрэгтэй тэмцдэг байгуу.../минут дуусав./

С.Бямбацогт: Булгантуяа гишүүн тодруулъя.

Х.Булгантуяа: Үгүй ээ төрийн, бид нар бас Улсын Их Хурлын гишүүд бас мэднэ шүү дээ төрийн нууц, харин Цогтгэрэл гишүүн хүртэл тэндээс Цогтгэрэл дарга хүртэл яриад байна л даа. Төрийн нууц гэдгийг бид нарт өгөх юм бол эндээ төрийн нууц гэсэн тамгатай байдаг. Нууц гэсэн тамгатай байдаг. Энэ тамгыг бол үнэнийг хэлэхэд өөр хүмүүст дамжуулахад үүнийг фотошопдоод янзлаад өөр хүнд өгөхөд маш амархан. Аймар байгаа биз? Маш амархан үүнийг.

Ингээд авсан хүн үүнийг нууц гэж мэдэх боломж байхгүй. Боломж байхгүй шүү дээ. Тэгээд үүнийг нь мэдэхгүй зүгээр л нэг Улсын Их Хурлын байдаг юм уу, төрийн байгууллагын хэн нэгний цаас гэж ойлгох амар байхгүй юу. Тэгэхээр үүнийг зохион байгуулалттай авсан юм уу, зорилготойгоор авсан юм уу, гаднын агент гээд аймар томоор биш зүгээр энэ төрийн нууц жирийн иргэн, хэн нэгний гар дээр оччих.../минут дуусав./

С.Бямбацогт: Асуултаа гүйцээчихье.

Х.Булгантуяа: Тийм. Тэгэхээр би тэгж л хэлэх гээд байна л даа. Мэдээж хадгалах ёстой албан тушаалтныг бол бид нар ойлгож байна. Бид нар хуулиараа тийм үүрэгтэй учраас тэрний төрийн нууцыг хадгалах ёстой. Төрийн нууцыг бид нар задруулах гээд байгаа юм ерөөсөө байхгүй. Энд өнөөдөр олон удаа хаалттай хурал болдог. Хадгалах үүрэггүй хүнд ямар нэгэн байдлаар энэ мэдээлэл хүрэх юм бол, нууц гэдгийг нь ойлгохгүй олж авах юм бол, зөв, буруу зорилгоор биш энэ жирийн нэг мэдээлэл гэж ойлгох юм бол яах юм бэ? Тэр хүн хуулиараа тийм үүрэг хүлээсэн хүн, албан тушаалтан юм уу? Харин энэ нууцын мэдээллийг олж авсан албан тушаалтан задруулсан бол тэр хүнд нь хариуцлага тооцох ёстой биз дээ? Тэгэхээр тэр сэтгүүлчид хэн тэр мэдээллийг задруулав? Тэр хүнтэй нь хариуцлага тооцох ёстой биз дээ уг нь бол? Би тэр асуултыг л асуугаад байгаа юм л даа. Яагаад гэвэл.../минут дуусав./

С.Бямбацогт: Тэр нууцыг задруулсан албан тушаалтанд хариуцлага бас хүлээлгэх ёстой биз дээ, үгүй юм уу л гээд асуугаад байна. Хариулах хүн байна уу? Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Нууц задруулсан этгээд энд хариуцлага хүлээх нь ойлгомжтой шүү дээ. Нууцыг хадгалах үүрэг хүлээгээгүй этгээдийг хариуцлагаас чөлөөлөх тухай яриад байгаа байхгүй юу гол нь Булгаа гишүүн, Цогтгэрэл гишүүн нар. Тэгэхээр ийм хэрэг учрал, тохиолдлууд бол байна шүү дээ. Нууцыг хадгалах үүрэг хүлээгээгүй этгээдээр дамжуулж нууцыг санаа зорилготой гаргах ажиллагаа явагдаж байсан ийм учралууд, асуудлууд байна шүү дээ. Хэрвээ бид нар тодорхой хүмүүст нууц хадгалах үүрэг, хариуцлагаас чөлөөлөө гэж үзэх юм бол тийм хүмүүсээр дамжуулж, тийм хүмүүсээр дамжуулж төрийн нууцыг задлах ийм үүд хаалгыг нээх гээд байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл тэр.../минут дуусав./

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Нууцыг хадгалж байгаа этгээд чинь тодорхой нэг “А” гэж иргэнээр дамжуулаад тэр нууцыг олсон юм аа гэрийнхээ хогийн савнаас олж байсан гэж ярьж байсан шүү тэр үед. Хогийн савнаас. Тэгээд тийм байдлаар төрийн нууцыг гаргах, ил болгох ийм ажиллагааг, үүд хаалгыг нээж болохгүй. Тухайн үед бол тийм ажиллагааг гаргасан этгээдийг илрүүлээд олоод хариуцлага шийтгэл ногдуулж байсан асуудлууд бий шүү дээ. Ийм арга ажиллагааг дэвэргээд байгаа байхгүй юу. Харин тийм хаалттай ярих ёстой гэж яриад байгааг энийг л хэлээд байгаа юм л даа.

С.Бямбацогт: Төрийн нууц задарсан байх юм бол түүнийг хадгалсан, дамжуулсан, задалсан этгээд бүгдээрээ хариуцлага хүлээх нь байна гэдгийг ойлгож авлаа шүү дээ.

Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя. Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Үг алга байна. Гишүүд үг хэлж дууслаа.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.1.9-д заасны дагуу санал хураалт явуулах боломжгүй байгаа тул Пүрэв гарагийн нэгдсэн чуулганаар санал хураалтыг явуулна. Хойшлууллаа. Дараагийн асуудалдаа орёе.

23.45 цаг.

Төрийн нууцын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийн Одонгийн Цогтгэрэл гишүүн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрхэд төр, түүний байгууллагаас хууль бусаар тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсын батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална гэж оруулснаар хүний мэдээлэл хайх, хүлээн авах, ашиглах эрхийг гагцхүү хууль батлах замаар хязгаарлах, аливаа нууцыг хуулиар тогтоох, хамгаалах эрх зүйн үндсийг тодорхойлсон.

Монгол Улсад төрийн нууцтай холбоотой эрх зүйн зохицуулалтын үндсийг 1995 онд баталсан Төрийн нууцын тухай болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар бүрдүүлсэн. Улмаар 2016 онд Төрийн болон албаны нууцын тухай хуулийг, шинэчилсэн найруулгыг баталж, төрийн нууцын жагсаалтыг Засгийн газар баталдаг шинэ эрх зүйн зохицуулалт хэрэгжиж эхэлсэн.

Ингэснээр өмнө нь Улсын Их Хурлаар, зөвхөн Улсын Их Хурал хуулиар тогтоож байсан төрийн нууцын жагсаалтыг Засгийн газар дэлгэрүүлэн батлахаас гадна нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах, төрийн болон албаны нууцтай холбоотой журам, заавар батлах зэрэг эрхтэй болжээ.

Гэвч Төрийн болон албаны нууцын тухай хууль нь мэдээллийг төрийн нууцад хамааруулах шалгуур үзүүлэлт тодорхойгүй, төрийн нууцад хамаарах мэдээллийн хүрээ хэт их тэлсэн, төрийн нууцад хамааруулж болохгүй мэдээллийг тогтоогоогүй зэрэг зохицуулалтын алдаатай байна.

Мөн Эрүүгийн хуульд төрийн нууцыг олж авах, гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоохтой иргэд, сэтгүүлчдийн хүний эрх хамгаалах хууль ёсны үйл ажиллагааны онцлогийг тооцохгүйгээр тогтоосон. Энэхүү зохицуулалтын алдаанаас болж төрийн нууцад хамаарах мэдээлэл 1995 оноос 2004 оны хооронд 22, 24-өөс 17 оны хооронд 61 байсан бол Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль хүчингүй болж, Засгийн газраас төрийн нууцын жагсаалтыг баталдаг болсноос хойш төрийн нууцад хамаарах мэдээллийн тоо 9 дахин нэмэгдэж 575-д хүрсэн. Албаны нууцад 59 байгууллагын 882 мэдээллийг оруулж, иргэдийн мэдэх эрх зөрчигдөж байна.

Мөн төрийн өмчит компаниудын өндөр үнийн дүнтэй худалдан авалт, оффтэйк гэрээ зэрэг олон нийтэд ил тод байх ёстой үйл ажиллагааг төрийн болон албаны нууцын ангилалд оруул ирсэн нь мэдээллийн ил тод байдал, хэвлэл мэдээллийн хяналт, нээлттэй өрсөлдөөнд сонгон шалгаруулалтын зарчмыг бодиттойгоор хязгаарлах нөхцөл бүрдүүлсэн. Үүний улмаас төрийн өмчит компаниудтай холбоотой олон тэрбум төгрөгийн авлига, албан тушаалын гэмт хэрэг ихсэж, төрийн өндөр албан тушаалтнууд болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүд холбогдох тохиолдол хэвийн явдал боллоо.

Монгол Улс сүүлийн жилүүдэд авлигын төсөөллийн индекс, ардчиллын индекс, хэвлэлийн эрх чөлөөний индекс зэрэг олон улсын үнэлгээнүүдээр тогтмол ухарч байгаа бөгөөд төрийн үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Тухайлбал, 2025 онд хуулийн засаглалын олон улсын индексээр Монгол Улс 142 орноос 67 дугаар байрт эрэмбэлэгдсэн нь төрийн байгууллагын ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлага хэвээр байгааг харуулж байна.

Энэхүү Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн зорилт нь Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлж, мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Тус хуулийн төсөлд Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтын хуулиар баталж, төрийн нууц тогтоох, ил болгох эрхийг гагцхүү Улсын Их Хуралд хадгалуулж, хууль гаргах өөр аливаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг төрийн нууцад хамааруулахыг хориглох, төрийн нууцад хууль зөрчсөн үйлдэл, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн баримтыг оруулахыг хориглох, төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн мэдээллийг албаны нууцад авах зохицуулалтыг хасаж, тус мэдээллийг ил болгох зохицуулалтыг тусгалаа.

Иймд Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл түүнтэй хамт өргөн мэдүүлж буй бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлал болон хуулийн төслүүдийг хэлэлцэн дэмжиж, хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг Улсын Их Хурлын эрхэм гишүүдээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Цогтгэрэл гишүүнд баярлалаа. Төслүүдийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Очирбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын 18 гишүүнээс 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар явууллаа.

Монгол Улсын Төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хуулиар бус Засгийн газрын тогтоолоор баталдаг болсон нь хэлбэрийн хувьд Үндсэн хуульд нийцээгүй байгаагаас гадна мэдээллийг төрийн нууцад хамааруулах шалгуур босго намсаж, үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын хяналт байхгүй болсонтой холбогдуулан Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг Засгийн газар бус Улсын Их Хурал баталдаг байх, албаны нууц гэсэн ойлголтыг халахаар хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Хуулийн төслүүдэд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.parliament.mn цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон дээрх хуулийн төслийн гол ялгаа, Үндсэн хуулиар олгосон иргэдийн мэдэх эрхийг төрийн болон албаны нууцаар хязгаарлахаас гадна зарим олон улсын гэрээ хэлэлцээрийг нууцад оруулсан асуудлын талаар, төрийн нууцыг хамгаалах үүрэг хүлээгээгүй хүн нууц мэдээлэл санамсаргүй олж авсантай холбогдуулан хариуцлага хүлээх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир бүх асуудлыг албаны нууц гэж халхавчлан нууцлах нь иргэдийн төрд итгэх итгэлийг алдагдуулж байгаа бөгөөд үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлыг нууцлах шаардлагатай талаар асуулт асууж, хариулт авсан болно. Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны хуралдаанаар Нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүх хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хүний эрхийн Үндэсний Комиссын

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Патентын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүх шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар нэг бүрчлэн ил санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Очирбат гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн танилцуулъя. Намсрайн Ариунболд Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх, Баттулгын Солонго Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх.

Одоо хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлт, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна гишүүд.

Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн алга байна. Отгоншарын Батнайрамдал гишүүн алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Энэ Засгийн газрын өргөн барьсан хууль болон Цогтгэрэл нарын гишүүдийн өргөн барьсан хууль ер нь бол яг адилхан бүтэцтэй, үзэл баримтлалын хувьд ч гэсэн ижилхэн. 7 бүлэг, 39 зүйлтэй. Бүлэг, зүйлүүдийн нэр нь бараг 99 хувь адилхан ийм хууль байлаа. Тэгээд нэгтгэж хэлэлцэхэд бол ямар ч асуудалгүй бүтцийн хувьд бол ийм хууль байна лээ.

Тэгээд энэ дээр миний харснаар бол 2 зарчмын зөрүүтэй өөр юмнууд гараад байгаа юм. Цогтгэрэл нарын гишүүдийн өргөн барьсан хууль дээр болохоор 4.4 дээр нь хууль гаргахгүйгээр аливаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект үйл ажиллагааг төрийн нууцад хамруулахыг хориглоно гээд заачихсан. Энэтэйгээ зөрчилдсөн заалт нь 14.4 дээр байгаад байгаа байхгүй юу. Энэ болохоор ийм цоорхой юмны чинь болохоор байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсвэл хүлээн авсан мэдээлэл төрийн нууцын жагсаалтад багтаагүй боловч нууцлах шаардлагатай тохиолдолд тухайн байгууллага, албан тушаалтан нууцлах арга хэмжээ авна аа гэсэн.

Тэгэхээр энэ Засгийн газрын өргөн барьсан хууль дээр болохоор яг энэ нууцлах арга хэмжээ авна гэсэн заалт нь байхгүй. Энэ саналаа төрийн нууцад хамруулах саналаа даруй тагнуулын байгууллагад хүргүүлнэ гэсэн заалт байгаад байгаа.

Цогтгэрэл нарын гишүүнийх дээр болохоор хуульд нь заахгүйгээр тухайн байгууллага, албан тушаалтан даруй нууцлах арга хэмжээ авахаар ийм заалт яваад байна. Тэгэхээр энийг яагаад ийм ялгаатай байдлаар өөрөөр хэлбэл хуулиар зөвхөн нууцлах арга хэмжээ авна гэххэд энэ тухайн тохиолдол үүсэхэд шаардлагатай гэж албан тушаалтан, байгууллага үзээд нууцлах арга хэмжээ авах энэ 14.4 дэх заалтыг тайлбарлаж өгөөч. Нэгд.

Хоёрдугаарт өөр нэг ялгаатай зүйл нь гэхээр жагсаалтыг Засгийн газрын өргөн барьсан бол цуг батлаад явж байгаа юм. Цогтгэрэл нарын гишүүдийнх болохоор 6 сарын дараа батлахаар энэ жагсаалтыг батлахаар, хүрэн дотроо багтааж жагсаалтыг батлахаар заасан байна. Тэгэхээр энийг яагаад 6 сар гэж заасан бэ гэсэн энэ 2 асуулт байна.

С.Бямбацогт: Ариунболд зөвлөх хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон индрийн.

Н.Ариунболд: Баярлалаа. Тэр эхний асуултын хариултын тухайд болохоор мэдээж төрийн нууцын жагсаалтыг Улсын Их Хурлаас батална. Тэр хөдөлгөөнгүй байдлаар батлагдсан явж байна. Тэгээд нөгөө яг практик, хэрэглээн дээр тодорхой нууцыг авах шаардлага бол аль аль ямар ч байгууллага дээр үүсэж болно. Тэр тохиолдолд тухайн нууцыг нууцтай адилхан нууцлах арга хэмжээ авахаар нь зохицуулсан нь мэдээж хэрэг Улсын Их Хурлаар тэр нууц болох хүртлээ ил болох, ийм ил байх тэгээд хэдэн тодорхой хугацаа шаардагдана. Энэ хугацаанд ил байлгах, ил болчих ийм боломж байгаад байгаа учраас тэрийг үнэхээрийн нууцлах шаардлагатай мэдээлэл байгаа бол тэрийг нууцална аа гэсэн ийм агуулгаар хуулийн зохицуулалтыг оруулж өгсөн байж байгаа.

Өөрөөр хэлбэл, тэр нэгэнт л тухайн эрх бүхий байгууллагаас энэ бол төрийн нууцад зайлшгүй орох жагсаалт хамрах мэдээлэл мөн гэж юм үзсэн энэ тохиолдлыг бол хэлж байгаа.

Дараачийн асуудал нь болохоор яагаад Улсын Их Хурлын гишүүдээс тэр нууцын жагсаалтыг давхар дагалдуулж ийм хуулийн зохицуулалтыг оруулж ирээгүй вэ гэхээр энэ Засгийн газар бол өөрөө яг эрх мэдлийнхээ хүрээнд Засгийн газрын бүтцийн байгууллагад бол Тагнуулын ерөнхий газар ч гэдэг юм уу энэ

томоохон байгууллагууд байдаг учраас энийг бол Улсын Их Хурлын гишүүн бие даагаад төрийн нууцын жагсаалтыг өөрөө боловсруулаад ингээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ийм хараахан боломж байхгүй учраас энийг бол Засгийн газарт нь өөрт нь үүрэг болгоод дагаж мөрдөх журмын хуулиар энийг 6 сарын дотор боловсруулаад оруулж ирье гэсэн ийм дагаж мөрдөх журмын тухай хуулиар оруулж ирсэн. Засгийн газраас одоо бол жагсаалтаа бас хамтатгаад өргөн мэдүүлчихсэн ийм нөхцөл байдалтай байгаа юм билээ. Баярлалаа.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүнд тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Тийм хоёр дахь асуудлын хувьд бол ойлголоо. Тэгээд энэ нөгөө Засгийн газрын өргөн барьсан төсөл дээр болохоор яг танайх шиг өргөн барьсан энэ байгууллага, албан тушаалтан нууцлах арга хэмжээ авахтай холбоотой зохицуулалт байхгүй. Нэн даруй энэ ажлын 5 өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, асуудлыг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд оруулна аа гээд.

Өөрөөр хэлбэл, Засгийн газрын өргөн барьсан төсөлд болохоор яг энэ хуулиар л энэ нууцлалыг, нууцад хамаарах зүйлүүдийг зөвхөн хуулиар л тогтооно гэдэг зарчимдаа явж байна. Тэгээд танай үзэл баримтлал дээр ч гэсэн бас яг ийм байгаа мөртөө энэ зүйл, заалт чинь өөрөө хэдийгээр завсрын шилжилт боловч яг энэ зарчимтайгаа, үзэл баримтлалтайгаа энэ 14.4-ийн энэ нууцлах арга хэмжээ авах заалт чинь зөрчилдөөд байгаа юм биш үү?

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Н.Ариунболд: Юу яая яах вэ дээ энэ дунд ийм хуулийн хийдэл гараад яг нууцлах шаардлагатай мэдээлэл маань Засгийн газрын хуралдаанаар 5 хоногийн хугацаанд ч юм уу, 2 хоногийн хугацаанд ч юм уу ингээд орохлоор тэр дунд завсар үлдээд нөгөө нууцалъя гэж бодоод байгаа юм маань ил болчих вий гэдэг ийм сэргийлэх үүднээс л энэ хуулийн зохицуулалт орсон.

Өөрөөр хэлбэл, энэ төсөл, энэ хууль чинь өөрөө хууль байгаад байгаа учраас тэр мэдээлэх шаардлагатай мэдээллүүдийг тодорхой хугацаанд Засгийн газар дэмжих, дэмжихгүй хүртэл хугацаанд тагнуулын байгууллага, ялангуяа Улсын Их Хурлаас батлах хүртэлх хугацаанд үнэхээрийн шаардлагатай гэж үзвэл нууц байлгая аа гэсэн ийм л үзэл баримтлалтай хийгдсэн юм.

Тэгэхгүй бол тэрүүхэн хугацаанд чинь нөгөө нууц чинь биш болоод задарсан байсан ч тэгээд л ач холбогдлоо алдчихна аа л гэж үзсэн юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Ойлгож байна аа энийг. Гэхдээ энэ 4.4 дээр чинь болохоор хууль гаргахгүйгээр төрийн нууцад хамруулахыг хориглоно гээд. Өөрөөр хэлбэл, нууцалчхаж байгаа байхгүй юу. Хууль гаргахгүй л бол нууцалж болохгүй гээд ийм заалт байгаад байгаа. Энэ нь зөрчилдөөд байгаа юм шиг л харагдаад байна л даа. Тэгэхээр нэгдэхийн хувьд бол ямар ч асуудалгүй, бүтцийн хувьд ч гэсэн ийм байгаа учраас зүгээр энэ нь аль нь зөв гэдгийг бас Засгийн газрын оруулж ирсэн

өөр байгаа учраас та хэд нэгдэх, хэлэлцэх үедээ энийгээ бас анхаарна биз дээ. Баярлалаа.

С.Бямбацогт: Цогтгэрэл гишүүн нэмж хариулья.

О.Цогтгэрэл: Тийм, манай өргөн барьж байгаа хуулийн үзэл баримтлал ерөөсөө л төрийн нууцыг хуулийн хүрээнд хуулиар жагсаалт баталж, хуулийн хүрээнд авна. Одоо байгаа 16 оны 12 дугаар сард батлагдсан нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн хүрээнд биш Засгийн газар нууцаар авдаг болсон нь өнгөрсөн хугацаанд гарсан энэ авлига, хулгай, оффтэйк гэрээ, энэ олон асуудлын үндэс болжээ гэдэг хүрээнд энэ хуулийн үзэл баримтлал суурилж бичигдсэн.

Тэгээд яагаад энэ 2 хууль Засгийн газрын хууль, гишүүдийн өргөн барьсан хууль яагаад ийм адилхан болчхов оо гэдэг зүйл бас асуултын эхэнд гарч байна лээ. Бид бүгдийн хувьд энэ хуулийг үндсэндээ жилийн өмнө Засгийн газраас санал авах гэж явуулсан. Тэрний дараа Засгийн газар Нууцын тухай хуулийг хөндөж өргөн барихдаа агуулгын хувьд Төрийн болоод албаны нууцын тухай хуулийг зөвхөн Төрийн нууцын тухай хууль энэ бол Үндсэн хуульд заасан үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар л нууцад авна аа гэдэг үзэл баримтлалын хүрээнд бол яг зөвхөн хуулиар нууцад ав.../минут дуусав./

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжсэн, дэмжээгүй, урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд үг хэлнэ.

Алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан.

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулах ёстой. Санал хураалт явуулах боломж, ирц боломжгүй байгаа учраас чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.1.9-д заасны дагуу санал хураалтыг Пүрэв гаргийн үдээс өмнөх хуралдаанаар хураана. Тэр болтол хойшлуулж байна.

00.05 цаг.

Дараагийн асуудал. Дахиад нэг асуудал байна. Дараагийн асуудалд орёе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль, тогтоолын эцсийн найруулга холбогдох Байнгын хороо бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Дагалдан гарсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Холбогдон боловсруулсан Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Очирбат гишүүн, Шижир гишүүн, Ганбаатар гишүүн?

Алга байна.

06 сарын 19-ний өдрийн 10 цагт эхэлсэн чуулганы нэгдсэн хуралдаан 06 сарын 20-ны өдрийн 00:06 минутад, 07 минутад дуусаж байна.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ их баярлалаа. Ялангуяа бас орой санал хураалтад оролцсон 50 гаруй гишүүддээ бүүр их баярлалаа. Тэгээд чуулганы нэгдсэн хуралдаан, Тамгын газрынхаа ажилтнууддаа өдий болтол бидэнтэй хамт бас.

00.07 цаг.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Д.ОТГОНДЭЛГЭР

